



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ XVIII БОТЬ

(2023 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2024 он

ННА 67.408

ДАА 345

Н-615

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

*Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ, сургалт мэдээллийн
үндэсний хүрээлэн болон хөгжинө.*

© Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Зохиогч болон нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр тус номын агуулгыг хэсэгчлэн болон бүтнээр хэвлэх, электрон аливаа хэлбэрээр хувилах, бичлэг хийх, хайлтын системд оруулах, хэвлэн олшруулахыг хориглоно. Хууль зүйн үндэсний хүрээлэн.

Хянан тохиолдуулсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.) Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Хууль зүйн сургалт, судалгааны төв

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч,
дизайнер Б.Заяа

Цаасны хэмжээ: 176/250

Хэвлэлийн хуудас: 34 х.х

“Тоонот принт” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9142-4-0

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигч та бүхний түмэн амгаланг айлтган мэндчилье. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд заасан судалгааны ажлыг хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төрөлжүүлэх, эрх зүйн гол салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтын хүрээнд бид 2023 онд хийж гүйцэтгэсэн судалгаануудаа “Үндсэн хуулийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XVI боть”, “Нийтийн

эрх зүй болон хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XVII боть”, “Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XVIII боть” хэмээх гурван ботиор ийнхүү уншигч олноо толилуулж байна.

Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгааны тайланг эмхэтгэсэн энэхүү XVIII ботид тус хүрээлэнгээс гүйцэтгэсэн Эрүүгийн эрх зүйд холбогдох төлөвлөгөөт болон захиалгат нийт 9 судалгааны тайлан, лавлагааг эмхэтгэв. Үүнд, эрүүгийн процессын эрх зүйн гол хэрэгжүүлэгч болох прокурорын байгууллага болон цагдаагийн албаны тухай, онолын хувьд маргаантай буй зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай, галт зэвсгийн эрх зүйн зохицуулалтын тухай болон өмнө нь төдий л хөндөгдөж судлагдаж байгаагүй ч өдгөө эрх зүйн хувьд боломжтой болоод буй гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтын тухай судалгаанууд мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн педофил өвчтэй хүмүүст авах арга хэмжээ, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах тухай гэх мэт нийгэмд шинэ тутам үүссэн, тулгамдсан асуудлуудад шийдэл санал болгох үүднээс хийж гүйцэтгэсэн харьцуулсан лавлагаанууд багтаж байна.

Тус хүрээлэнгээс 2022 онд гүйцэтгэсэн “Прокурорын хараат бус байдал: Прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага” харьцуулсан судалгааны үр дүнд үндэслэн 2023 онд Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн үнэлгээ хийсэн бөгөөд уг судалгаагаар прокурорын байгууллагын бие даасан байдал, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, прокурорын өөрөө удирдах байгууллага, прокурорын туслах ажилтантай холбоотой зохицуулалтыг судалж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх тухайд тодорхой санал, зөвлөмж дэвшүүлсэн юм.


Гүйцэтгэх ажлын цар хүрээ хийгээд арга, аргачлал нь тодорхой үндэслэл бүхий шалтгааны улмаас хүний эрх, эрх чөлөөнд халдах шаардлагатай тулгардаг билээ. Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тандан судалгаагаар гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг шинээр бий болгох замаар өргөжүүлэх, ингэхдээ Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай эсэхийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу харьцуулсан судалгаагаар баяжуулан гүйцэтгэв.

Галт зэвсгийн тухай бусад улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанд Оросын Холбооны Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын галт зэвсэгтэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалт, галт зэвсгийн тухай ойлголт, ангилал, төрөл, зориулалт, галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах, өвлөх, бэлэглэх, галт зэвсгийн худалдаа ба импорт гэх мэт олон зохицуулалтыг судалсан бөгөөд сум болон сумыг дахин цэнэглэхтэй холбогдох харилцааг илүү өргөн хүрээнд буюу АНУ, ОХУ, ХБНГУ, Канад, Филиппин улсад хэрхэн зохицуулдаг болохыг тус тус судалсан.

Цагдаагийн албанд тулгамдаж буй эрх зүйн зарим асуудлын хүрээнд бид цагдаагийн алба хаагчийн сургалт, дотоод хяналт шалгалт, мөрдөгчид тавигдаж буй шалгуур, сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг нарийвчлан, гадаадын зарим орны сайн туршлагыг авч үзэж судалсан болно.

Уг ботид эмхэтгэгдсэн бидний судалгаа Монгол Улсын эрүүгийн эрх зүйн салбарт тулгамдаж буй олон асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэгдэхэд зохих ёсны хувь нэмрийг оруулахын зэрэгцээ хууль зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж буй эрдэмтэн, судлаач, тус салбарт ажиллаж буй албан хаагчид, оюутнуудын судалгааны чухал эх сурвалж болно гэдэгт итгэж байна.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

ГАРЧИГ

Өмнөх үг	III
Товчилсон үгийн жагсаалт	VI
Хүснэгтийн жагсаалт	VIII
Графикийн жагсаалт	X
Схемийн жагсаалт	XI
Нэг. Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ	1
Хоёр. Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тандан судалгаа	63
Гурав. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ	139
Дөрөв. Цагдаагийн албанд тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал	177
Тав. Гүтгэх болон худал мэдээлэл тараах гэмт хэргийн лавлагаа	261
Зургаа. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг болон педофил өвчтэй хүмүүст авах арга хэмжээний талаарх лавлагаа	273
Долоо. Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл “Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах” гэмт хэргийн лавлагаа	287
Найм. Согтуурсан болон мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэрэг	299
Ес. Галт зэвсгийн тухай бусад улс орны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа	313

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

DCAF	Democratic Control of Armed Forces
АИХЭГ	Ардчилсан институт, хүний эрхийн газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНАУ	Бүгд Найрамдах Австри Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Эстони Улс
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЖЦХЖТХ	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
ЗХАБтХ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
ЗХАХТЖТ	Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв
ЗХтХ	Захиргааны хариуцлагын тухай хууль
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ННФ	Нээлттэй нийгэм форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОУПХ	Олон Улсын Парламентын Холбоо
ОХУ	Оросын Холбооны Улс
СГАСХ	Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УДШ	Улсын Дээд Шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАБ	Үндэсний аюулгүй байдал
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗС	Хууль зүйн сургууль
ХЗСТ	Хууль зүйн судалгааны төв
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦАтХ	Цагдаагийн албаны тухай хууль
ЦБҮАЖ	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
ЦДЦСНТ	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭЗХАХБ	Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХ	Эрүүгийн хууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	6
Хүснэгт 1.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	7
Хүснэгт 1.3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	8
Хүснэгт 1.4. Гадаад улсуудын зохицуулалт: Эрх мэдлийн хуваарилалтад прокурорын байгууллагын эзлэх байр суурь	14
Хүснэгт 1.5. Гадаад улсуудын зохицуулалт: Улсын Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг тодорхойлсон байдал	20
Хүснэгт 1.6. Гадаад улсуудын зохицуулалт: Ерөнхий прокурорын томилгоо, үйл явцын талаар тодорхойлсон байдал	23
Хүснэгт 1.7. Гадаад улсуудын зохицуулалт: Улсын Ерөнхий прокурорыг огцруулах үндэслэлийг тодорхойлсон байдал	27
Хүснэгт 1.8. Прокурорын өөрөө удирдах байгууллагыг тодорхойлсон байдал	30
Хүснэгт 1.9. Монгол Улсын зохицуулалт: Прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг тодорхойлсон байдал	31
Хүснэгт 1.10. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг тодорхойлсон байдал	33
Хүснэгт 1.11. Монгол Улсад прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүн, томилгоог тодорхойлсон байдал	36
Хүснэгт 1.12. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын өөрөө удирдах байгууллагын томилгоо, бүрэлдэхүүнийг тодорхойлсон байдал	38
Хүснэгт 1.13. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтны гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлсон байдал	42
Хүснэгт 1.14. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлсон байдал	45
Хүснэгт 1.15. Монгол Улсын зохицуулалт: Прокурорын туслах ажилтныг томилох процессыг тодорхойлсон байдал	47
Хүснэгт 1.16. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтныг томилох үйл явцыг тодорхойлсон байдал	47
Хүснэгт 1.17. Монгол Улсын зохицуулалт: Прокурорын туслах ажилтны цалинг тодорхойлсон байдал	50
Хүснэгт 1.18. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтны цалинг тодорхойлсон байдал	51
Хүснэгт 2.1. Гүйцэтгэх ажил явуулж буй байгууллагууд	69
Хүснэгт 2.2. Эрх ашиг нь хөндөгдөж буй бүлэг /Нөлөөллийн хэлбэр/	74
Хүснэгт 2.3. Ил болон нууц арга, хэрэгсэл	76
Хүснэгт 2.4. Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо	83
Хүснэгт 2.5. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал	86
Хүснэгт 2.6. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	91

Хүснэгт 2.7. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	97
Хүснэгт 2.8. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	102
Хүснэгт 2.9. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	110
Хүснэгт 2.10. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт	115
Хүснэгт 2.11. БНАУ-ын гүйцэтгэх ажилд хяналт тавих байгууллага болон механизм	127
Хүснэгт 3.1. Үнэлэх зүйл, заалт	144
Хүснэгт 3.2. Захиргааны зөрчлийн төрөл.	157
Хүснэгт 4.1. 2022 болон 2023 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр	183
Хүснэгт 4.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх систем	210
Хүснэгт 4.3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх өргөдөл, гомдол ба шийдвэрлэлтийн мэдээлэл (2017-2023 он).	213
Хүснэгт 4.4. Давуу болон сул тал /Их Британи/.	217
Хүснэгт 4.5. Давуу болон сул тал /Канад/	219
Хүснэгт 4.6. Давуу болон сул тал /Өмнөд Австрали/	220
Хүснэгт 4.7. Гадаадын зарим орны цагдаагийн албанд хяналт тавих чиг үүрэг бүхий хараат бус байгууллагын жагсаалт	221
Хүснэгт 4.8. ЦАТХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх хэсэг хэрэгжих нөхцөлийн дэлгэрэнгүй тодруулга	233
Хүснэгт 4.9. Гадаад орнуудын Цагдаагийн албаны тухай хууль дахь сонсогчийн эрх зүйн байдлын зохицуулалт.	235
Хүснэгт 4.10. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны мэдээлэл	241
Хүснэгт 4.11. Гадаад орнуудын жагсаал, цуглааны үе дэх цагдаагийн албаны оролцоог хуульчилсан байдал	246
Хүснэгт 4.12. Хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжтой зөрчилдсөн журмууд /хэсэгчлэн авав/	249
Хүснэгт 5.1. Бүртгэгдсэн хэргийн тоо /2013-2023 он/	269
Хүснэгт 5.2. Бүртгэгдсэн зөрчлийн тоо /2017-2021 он/	269
Хүснэгт 9.1. ХБНГУ-ын нийт гэмт хэргийн тоог галт зэвсэг ашиглахаар завдсан, галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэгтэй харьцуулсан байдал	316
Хүснэгт 9.2. ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн бүтэц	320
Хүснэгт 9.3. ОХУ-ын Галт зэвсгийн тухай хуулийн бүтэц	321
Хүснэгт 9.4. Торгуулийн хүснэгт: Хууль бус зэвсэг эзэмшсэн тохиолдолд оногдуулах шийтгэл	351
Хүснэгт 9.5. Сумны хонгиог дахин цэнэглэх	358

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 3.1. Хүнийг саатуулах арга хэмжээний тоон үзүүлэлт	163
График 3.2. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээ авсан тоон үзүүлэлт	167
График 4.1. 2017-2023 оны Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол	215
График 9.1. ХБНГУ-ын нийт гэмт хэргийн тоо	316
График 9.2. ХБНГУ-д 2012-2022 онд галт зэвсэг ашиглахыг завдсан болон галт зэвсэг ашигласан хэргийн тоон харьцуулалт	317
График 9.3. ОХУ-ын 100,000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин (1995-2021 он)	318
График 9.4. ОХУ-ын Галт зэвсэг, хийн зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэх төхөөрөмж ашиглаж үйлдсэн гэмт хэргийн тоо (2015- 2021 он)	318

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 3.1. Замын хөдөлгөөний тухай хуулийн зөрчлийг шалгах ажиллагаа	158
Схем 3.2. Гаалийн тухай хуулийн зөрчлийг шалгах ажиллагаа	159
Схем 4.1. Монгол Улсын ЦЕГ-ын дотоод хяналт-аюулгүй байдлын газрын бүтэц	213
Схем 9.1. Зэвсэг эзэмших, ашиглах тусгай зөвшөөрлийн төрөл	326
Схем 9.2. Галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл.	331
Схем 9.3. Тусгай мэдлэгээ нотлох шаардлага	348

НЭГ. ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Г.Давааням	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (LL.D)
------------	--

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Энх-Амгалан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Х.Буянбат	Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.05.05.

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	4
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	5
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	6
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	9
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	9
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	9
II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	10
III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	11
3.1. Прокурорын байгууллагын бие даасан байдал	11
3.2. Ерөнхий прокурор, түүний орлогч	19
3.3. Прокурорын өөрөө удирдах байгууллага	29
3.4. Прокурорын туслах ажилтан	39
IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	53
НОМ ЗҮЙ	57

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин Зургадугаар зүйлийн 1-д заасны дагуу прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү чиг үүргийг хараат бусаар, хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй гүйцэтгэх нь эрх зүйт ёс, хуулийн засаглалыг бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Прокурорын хараат бус байдлыг 2017 онд батлагдсан Прокурорын тухай хуулиар зохицуулж байна. Прокурорын тухай хуульд прокурорын хараат бус байдлын баталгаа, нөлөөллийн мэдүүлэг гаргах, хууль зүйн баталгаа, эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаа, улс төрийн баталгаа, дэмжих, хориглох зэрэг зохицуулалтыг тусгажээ.

2022 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага/” сэдэвт харьцуулсан судалгааг гүйцэтгэсэн. Харин тус хууль батлагдсанаас хойш 5 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийгээгүй байна.

Түүнчлэн, 2021 оны Шүүхийн шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн хэрэгжилттэй уялдуулан, Прокурорын тухай хуулийг шинэчлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болох шаардлага зүй ёсоор үүссэн. Улмаар хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлага бүхий зүйлсийг тодорхойлох үүднээс Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийх хэрэгцээ шаардлага тавигдаж байна.

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Хууль зүйн үндэсний хүрээлэн 2022 онд “Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага/” сэдэвт судалгааг гүйцэтгэсэн. Энэхүү судалгаанд Монгол Улсын прокурорын байгууллагын эрх зүйн үндэс, прокурорын байгууллагын эрх мэдлийн хамаарал, прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлага, түүнд тавигдах шаардлага, томилгоо, түүний үйл явц, бүрэн эрхийн хугацаа, огцруулах, ажлаа тайлагнах үйл явц, прокурорын өөрөө удирдах тогтолцоо, түүнд хамаарах прокурорын холбоо, бусад өөрөө удирдах байгууллагууд болон түүний томилгоо бүрэлдэхүүний талаар судалсан бөгөөд засаж сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг өгсөн.

Мөн Шүүхийн шинэчлэлийн хүрээнд 2021 онд Шүүхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Прокурорын тухай хууль, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлага зүй ёсоор үүсээд байгаа тул дараах асуудлын хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг хийх хэрэгцээ шаардлага бий болсон. Тус өөрчлөлтийн хүрээнд шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, шүүх иргэдэд хүртээмжтэй байхад чиглэсэн шүүх эрх мэдлийн шинэчлэлийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

Тус судалгааны хүрээнд дээрх асуудлыг гүнзгийрүүлэн хэрэгжилтийн үр дагаврыг дараах байдлаар судалсан.

1. Прокурорын байгууллага нь Ерөнхийлөгчөөс хамааралтай байгаа тул түүний бие даасан байдлыг сайжруулах үүднээс зарим зохицуулалтыг эргэн харах нь зүйтэй. Тухайлбал, Улсын Ерөнхий прокурорыг томилох, мэргэжлийн болон ёс зүйн дүрэм зэргийг Ерөнхийлөгч баталж байна. Иймд Шүүхийн шинэчлэлийн хүрээнд шүүхийн байгууллагын эрх мэдлийг болон бие даасан байдлыг баталгаажуулсантай адилаар прокурорын байгууллагын бие даасан байдлыг баталгаажуулах талаар авч үзсэн;

2. Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлага болон томилох, огцруулах үйл явцыг сайжруулах талаар судалсан;

3. Прокурорын байгууллагын Мэргэжлийн зөвлөл, Ёс зүйн зөвлөл гэх мэт прокурорын байгууллагын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, түүний томилох үйл явцыг судлан сайжруулах арга замыг санал болгосон;

4. Прокурорын туслах ажилтны талаар эрх зүйн зохицуулалтыг судалж, тавигдах шаардлага болон томилох процесс, чиг үүргийн талаар судалсан.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаан (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ.

Үнэлгээний хүрээг тогтооходоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх хэрэгтэй. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Дээр дурдагдсан үнэлгээ хийх шалтгаанд тулгуурлан 2017 онд батлагдсан Прокурорын тухай хуулийн дараах агуулга бүхий зохицуулалтуудад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр тогтлоо.

Үнэлгээний хүрээ

Прокурорын байгууллагын бие даасан байдал

- А. Төрийн эрх мэдлийн хуваарилалтад прокурорын байгууллагын эзлэх байр суурь
- Б. Прокурорын байгууллага дахь Ерөнхийлөгчийн нөлөө

Ерөнхий прокурор, түүний орлогч

- А. Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлага
- Б. Ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох үйл явц
- В. Ерөнхий прокурор, түүний орлогчийг огцруулах үйл явц

Прокурорын өөрөө удирдах байгууллага

- А. Прокурорын өөрөө удирдах байгууллагын зохион байгуулалт
- Б. Прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа
- В. Прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүн, томилгооны үйл явц

Прокурорын туслах ажилтан

- А. Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага
- Б. Прокурорын туслах ажилтныг томилох үйл явц
- В. Прокурорын туслах ажилтны цалин

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно. 2017 оны Прокурорын тухай хуулийн 1.1-д “...прокурорын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтооход оршино...” гэж тус хуулийн зорилгыг тодорхойлжээ. Прокурорын тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 1.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

2017 оны Прокурорын тухай хуулийн зохицуулалт	Сонгосон үндэслэл
45.4.Хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, гучин таван насанд хүрсэн прокурорыг Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор томилно.	Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлага, томилох, огцруулах үйл явцын талаар асуудал нь прокурорын хараат бус, бие даасан байдлыг хангах болон бусад зорилгод хүрэхэд асуудал үүсгэж байна.
46.1.Прокурорын байгууллагыг Улсын ерөнхий прокурор тэргүүлнэ. Улсын ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно.	
46.2.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогчийг Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно.	
46.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон хүнийг Улсын Их Хурал дэмжихгүй бол нэг удаа өөр хүний нэрийг дэвшүүлнэ.	
46.4.Улсын ерөнхий прокурорын эзгүйд түүний шийдвэрээр Улсын ерөнхий прокурорын аль нэг орлогч бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ. Улсын ерөнхий прокурорын орлогч Улсын ерөнхий прокурорын өмнө ажлаа хариуцна.	
46.5.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.	
46.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрх дараахь тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэр гарснаар хугацаанаас өмнө дуусгавар болно:	
46.6.1.өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон, хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог албан тушаалд нэр дэвшсэн;	

<p>46.6.2.гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;</p> <p>46.6.3.эрүүл мэндийн байдлын улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;</p> <p>46.6.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан.</p>	
<p>45.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, хуульчийн мэргэжлээр 3-аас доошгүй жил, эсхүл прокурорын туслах ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан, гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй, мэргэжлийн шаардлага хангасан, хорин таван насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророор томилно.</p> <p>45.2.Прокурорыг мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг Улсын ерөнхий прокурор батална.</p> <p>45.3.Прокуророор 5-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг дээд шатны прокуророор томилно.</p> <p>45.4.Хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, гучин таван насанд хүрсэн прокурорыг Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор томилно.</p>	<p>Прокурорт тавигдах ерөнхий шаардлага болон зарим албан тушаалын прокуроруудад тавигдах тусгай шаардлагын асуудал нь тус хуулийн зорилгод нийцэж буй эсэхийг судлах шаардлагатай.</p>

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Прокурорын тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Энэ шалгуур үзүүлэлтээр ихэвчлэн тухайн хуулийг хэрэгжүүлэгч этгээдээс болон байгууллагаас уг зохицуулалт практикт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг тогтооход түлхүү ашигладаг. Мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон амьдралд гарч байгаа эерэг болон сөрөг ямар үр дагаврууд байгааг тодорхойлох бөгөөд хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тооцох нь чухал юм.

Прокурорын тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 1.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

2017 оны Прокурорын тухай хуулийн зохицуулалт	Сонгосон үндэслэл
<p>64.1.Прокурорын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгах, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байна.</p>	<p>Прокурорын байгууллагын өөрөө удирдах байгууллагууд болох Прокурорын мэргэжлийн зөвлөл, Прокурорын ёс зүйн зөвлөл гэх мэт байгууллагуудын практикт ажиллаж буй эерэг болон сөрөг талыг судлан үзэх нь зүйтэй гэж үзсэн.</p>
<p>64.2.Прокурорын мэргэжлийн дүрэм, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.</p>	
<p>64.3.Прокурорын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улсын ерөнхий прокурор томилно.</p>	

<p>65.1.Прокурор ёс зүйн дүрэм зөрчсөнтэй холбоотой асуудлыг шалгах, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус ёс зүйн зөвлөлтэй байна.</p> <p>65.2.Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.</p> <p>65.3.Прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улсын ерөнхий прокурор томилно.</p>	
<p>55.1.Прокурорын байгууллагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах ажилтан ажиллана.</p>	<p>Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага, томилгоо, баталгааны талаар асуудал нь практикт эерэг болон сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй тул тухайн шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.</p>

III. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрхэн хүлээн авч буй байдал болон хуулийг хэрэгжүүлж байна уу? гэдгийг тодорхойлно. Хуулийн үр нөлөөг шууд хүртэж байгаа этгээдээс авах нь зохимжтой. Прокурорын тухай хуулийн дараах зохицуулалтуудыг тухайн шалгуур үзүүлэлтийн түвшинд судлахаар болов.

Хүснэгт 1.3. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

2017 оны Прокурорын тухай хуулийн зохицуулалт	Сонгосон үндэслэл
<p>46.1.Прокурорын байгууллагыг Улсын ерөнхий прокурор тэргүүлнэ. Улсын ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно.</p>	<p>Прокурорын байгууллагын Ерөнхийлөгчөөс хэт хамаарч буй байдал нь тухайн хуулийн үйлчлэлд шууд хамаарч буй прокурорудад ихээхэн хамааралтай байх тул тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.</p>
<p>46.2.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогчийг Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно.</p>	
<p>46.5.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.</p>	
<p>46.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрх дараахь тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэр гарснаар хугацаанаас өмнө дуусгавар болно.</p>	
<p>47.2.Прокурорын тангараг өргөх ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.</p>	
<p>50.1.Ял шийтгүүлсэн этгээдэд үзүүлэх уучлалын асуудлаар дүгнэлт гаргана.</p>	
<p>50.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар дүгнэлт гаргаж болно.</p>	
<p>54.3.Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.</p>	
<p>64.2.Прокурорын мэргэжлийн дүрэм, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.</p>	

65.2.Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.	
67.3.Прокурорын сахилгын дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.	
69.2.Прокурорын бэлгэдэл, далбаа, дүрэмт хувцас, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.	

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Прокурорын тухай хуулийн дээрх зүйл, заалтад хамаарах агуулга тус бүр дээр байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг аль тохирохыг ашиглана. Мөн гадаад улсуудын зохицуулалт болон туршлагыг харьцуулан судална.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилгод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?”, “хүлээн зөвшөөрөгдөх үү?” гэсэн асуултын хүрээнд гүйцэтгэв.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор тухайн сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

- Мэдээлэл цуглуулах арга;
- Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;

Холбогдох субъектээс судалгаа авах аргыг сонгосон болно.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд Прокурорын тухай хууль, холбогдох сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Прокурорын тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, судалгааны тайланг ашигласан болно.

Монгол Улсад Прокурорын байгууллага үүссэнээс хойших 90 гаруй жилийн хугацаанд прокурорын байгууллагатай холбоотой эрх зүйн зохицуулалт шинэчлэгдэн хөгжиж ирсэн билээ. Тиймээс ч салбар эрх зүйн онолын тайлбар, хамтын бүтээл, гарын авлага, өгүүлэл, нийтлэл зэрэг эрдэм шинжилгээний олон бүтээл хэвлэгдсэн байна. Судалгаанд ашигласан эх сурвалжийг жагсаавал:

Сурах бичиг, гарын авлага:

- Прокурорын ном: прокурорын гарын авлага, Хян. Б.Чимид, Улсын Ерөнхий прокурорын газар, (Уб, 2000);
- Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт, (Уб, 2009);
- Г.Баясгалан, Н.Туяа, Б.Цэрэнбалтав, Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, (Уб, 2003) гэх мэт.

Хууль, эрх зүйн акт:

- Монгол Улсын Үндсэн хууль, (1992);
- Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, (2015);
- Прокурорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2017);
- Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, (2021) гэх мэт.

Судалгааны тайлан эмхэтгэл:

- The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific, OECD, (2020);
- “Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага/” судалгааны тайлан, ХЗҮХ, (2022) гэх мэт.

Олон улсын гэрээ, конвенц:

- Rome Charter, XIV;
- Venice Commission (2010), Report on European Standards as regards the Independence of the Judicial System: Part II – The Prosecution Service (hereinafter – Venice Commission Report) гэх мэт.

III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Прокурорын тухай хуулийн зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэллээ.

3.1. Прокурорын байгууллагын бие даасан байдал

2017 оны “Прокурорын тухай хууль”-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.” гэж тодорхойлжээ.

Гэвч Монгол Улсад прокурорын байгууллага нь Прокурорын тухай хуульд зааснаар Ерөнхийлөгчөөс хамааралтай байх явдал ажиглагдаж байгаа. Тухайлбал, Улсын Ерөнхий прокурорыг томилох, огцруулах, Прокурорын тангараг өргөх ёслолын журмыг батлах, Улсын Ерөнхий прокурор Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу дүгнэлт гаргах, Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журмыг тогтоох, олгох, прокурорыг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгох, Прокурорын мэргэжлийн дүрэм, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг батлах, Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг батлах, Прокурорын сахилгын дүрмийг батлах, Прокурорын бэлгэдэл, далбаа, дүрэмт хувцас, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг батлах бүрэн эрхийг Ерөнхийлөгч хэрэгжүүлдэг байна.

Энэ нь прокурорын байгууллагын бие даасан байдал, прокурорын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бий болгож байгаа бөгөөд иргэдийн прокурорын байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж байна. Үүнтэй холбогдуулан прокурорын байгууллагыг төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн аль эрх мэдэлд хамаарахыг тодорхойлох шаардлага зайлшгүй үүсээд байна.

А. Төрийн эрх мэдлийн хуваарилалтад прокурорын байгууллагын эзлэх байр суурь

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэг буюу шүүх эрх мэдлийн хэсгийн Тавин зургадугаар зүйлд прокурорын байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг.

Мөн Прокурорын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “...шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.” гэж заасан. Үүнээс дүгнэвэл прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болох нь харагдаж байна.

Өмнөх 2002 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуульд ч прокурорын байгууллагыг ийнхүү тодорхойлсон байжээ. Тодруулбал, “Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.” гэж тодорхойлжээ.

Мөн Үндсэн хуулийн үзэл баримтлал, прокурорын үүрэг, зорилт, тогтолцоо зэрэг шалгуурыг үндэс болгон дараах шинжүүдийг гаргаж болох юм.

- Прокурорын байгууллага нь төрийн байгууллагын ерөнхий системд багтаж, төрийн механизмын салшгүй хэсэг болдог.
- Прокурорын байгууллага нь төрийн хяналтын нэг чиглэл болох хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих үйл ажиллагааг өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байдаг.
- Прокурорын үйл ажиллагаа, зохион байгуулалтын үндсийг Үндсэн хуулиар хуульчлан бататгаж, холбогдох бусад хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулдаг. Прокурорын байгууллага бол Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн байгууллага мөн. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж зааснаар нотлогдоно. Түүнчлэн, “Монгол Улсын прокурорын байгууллагын зохион байгуулалт, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”, Прокурорын байгууллагын тухай хуульд “Прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шууд оролцдог байгууллага мөн” гэж тодорхойлоод Монгол Улсын хуулиар прокурорын байгууллагын статусыг “шүүх эрх мэдэл” гэсэн бүлэгт оруулан тодорхойлсон.
- Прокурорын байгууллага бол шүүхийн тогтолцоонд түшиглэсэн байгууллага юм. Түүний үндсэн тогтолцоо ямар байх нь шүүхийн тогтолцооноос шууд хамааралтай байна.¹

Энэ талаар судлаач Бяраагийн Чимид “Прокурор аль зүгт явна вэ?” гэх өгүүлэлдээ прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийн байгууллага гэдгийг дараах байдлаар тодорхойлсон.

...1933-1934 онд хөдөө, хотод анги нутгийн /хэсгийн/ шүүхүүдийг татан буулгаж үүргийг нь сум, хорооны захиргаанд шилжүүлсэнтэй холбогдуулан шүүх, прокурор хоёрыг бүх тогтолцоогоор нь Шүүх яаманд харьяалуулжээ. Сайд нарын зөвлөлийн 1934 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар хурлаас баталсан “Шүүх таслах ба прокурорын газруудын дүрэм”-ээр уул өөрчлөлтийг бататгасан байдаг. Энэ дүрмийн 4-т “Шүүх явдлын яам бол бүхий л улсын дотор шүүх ба прокурорын газруудыг ерөнхийлөн удирдах явдлыг” биелүүлнэ гэсний дээр 1 дүгээр зүйлд нь “шүүх прокурорын газруудын үндсэн зорилтууд”-ыг нэгтгэн тодорхойлсон. Ингэснээр прокурорыг шүүх эрх мэдэлд хамаатай, эцсийн нэг зорилготой, ерөнхий удирдлагын хувьд Хууль зүйн яамны харьяалалтай болгосон ажгуу. Энэ бүхэн прокурорыг төрийн байгууллагын тогтолцоонд хэрхэн байршуулах вэ? гэсэн эрэл хайгуул байсан болов уу. Түүнчлэн, прокурорын үүрэгт ерөнхий хяналтыг нэн тэргүүний болгож тодруулсан нь Зөвлөлтийн прокурорын жишгийг дагнан харгалзсан болов уу гэлтэй.

Шинэ Үндсэн хуульд нэгэнт тунхаглаж, бусад хуулиар тодруулсан Монгол Улсын Прокурорын байгууллагын статусыг өнөө хэрхэн тайлбарлаж болох вэ? Монголын төрийн байгууллагын шинэ тогтолцоонд прокурор чухам хаана юунд хамаарч, ямар байр суурь эзэлж байна? Түүний цаашдын хандлага хаашаа чиглэнэ вэ? гэсэн цөвнөгү асуудал сонирхол татсаар байна. Гэтэл одоо хэр олигтой судлаагүй л байна. Ургалч үзэл нэвтэрч, хэн хүнгүй үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсон цагт хүн бүр л өөр өөрийнхөөрөө өгүүлэх буй заа. Гэлээ ч Үндсэн хуулийн үзэл баримтлал, прокурорын үүрэг зорилт, тогтолцоо зэрэг шалгуурыг үндэс болговоос дараах хэдэн шинжийг илэрхийлж болох буй.

1 Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, *Прокурорын хяналт*, (УБ, 2009), 67-68 дахь тал.

1. Прокурорын байгууллага бол Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн байгууллага мөн. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж зааснаар нотлогдоно. Түүнчлэн, “Монгол Улсын Прокурорын байгууллагын зохион байгуулалт, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн нь ердийн биш “Үндсэн хуульчилсан хууль”-аар тодорхойлон зохицуулна гэсэн утгатай болно /Органик буюу “конституционный закон” гэдгээр ойлгож болно/.

2. Прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шууд оролцдог гол байгууллага мөн. Ийн ангилахдаа Монгол Улсын Үндсэн хуулиар прокурорын статусыг “шүүх эрх мэдэл” гэсэн хэсэгт оруулан тодорхойлсныг иш үндэс болгож байна. Нөгөөтээгөөр хөгжилтэй бусад орны эрдэмтдийн ангиллыг харгалзсан хэрэг л дээ. Бусад орныхтой жишиж “хөлөө олохгүйгээр” “Монголоороо байна” хэмээн мугуйдаж болохгүй. Бас учир утгыг нь сайтар олохгүйгээр даган баясаж ч болохгүй. Харин зөв ойлгож зохих байранд нь тавих хэрэгтэй. Тэгвэл илүү үр дүнд хүрэх нь лавтай билээ.

Барууны орнуудад прокурор ихэвчлэн Үндсэн хуулийн статусгүй байдаг. Өөрөөр хэлбэл, тэнд прокурорын статусыг Үндсэн хуульдаа тусгайлан тодорхойлдоггүй, харин ердийн хуулиар журамлан зохицуулдаг байна. Харин хүний эрх, төрийн бусад байгууллагын үйл ажиллагаанд холбогдох төдийд дурдсан зүйл зарим орны Үндсэн хуульд тохиолддог. Ийм хандлагын учир шалтгаан нь Үндсэн хуулийн төрийн эрх мэдлийг “Засгийн гурван салаа”-нд хуваарилсан байдагтай шууд холбоотой. Бас прокурор хэмээх албан тушаал хэрэглэдэггүй улс орон ч бий.

Сая дурдсан зарчим ямар агуулга, учир холбогдолтойг энд нотлон тайлбарлахыг зориогүй. Зөвхөн прокурорын шинэ статуст ямар холбогдолтой, яагаад Үндсэн хуулиар “шүүх эрх мэдэл”-д хамааруулсныг цухас тодруулах гэсэн юм.

Эрх мэдэл хуваарилах зарчмыг онолын талаар үндэслэгчдийн нэг Шарль Луи Монтескье /1689-1755/ “...гэмт хэргийн учир гэсгээн цээрлүүлэх, хувь этгээдийн сөргөлдөөнийг таслан шийдвэрлэх”-ийг шүүх эрх мэдэл хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь “Шүүх эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан шийднэ” гэсэн утгатай бөгөөд одоо ч “амьдарсаар буй” ойлголт шүү дээ. Үүнтэй прокурор ямар холбоо хамааралтай юм бэ гэдэг нь хуульчдад ойлгомжтой мэт боловч социал улс төр талаасаа бас л ээдрээтэй, будлиулсан асуудлын нэг.

Шүүн таслах ажил буюу шүүх эрх мэдэл бол явж явж гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлон тогтоож ял шийтгэх /гэм буруугүй бол цагаатгах/, засаг төр, хуулийн этгээд, хувь хүний хооронд үүссэн элдэв эрх зүйн маргаан, сөргөлдөөнийг эцэслэн шийдвэрлэж зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн хангах явдал мөн. Сөргөлдөөнт байдалд хуулийг зөв тайлбарлаж, шударгаар хэрэглэх нь шүүхийн социал үүрэг юм. Энэ ажлыг бүх төрлийн, бүх шатны шүүх зөвхөн хуульд захирагдан эцэслэн шийдвэрлэдэг.

Хэрэг маргааны тухайд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээс дээгүүр хүчинтэй нь үгүй билээ. Дээр нь хууль л бий. Иймээс “хууль бол ярьдаггүй шүүгч, шүүгч бол ярьдаг хууль” гэж их Цицероны хэлсэн нь үнэнтэй. Харин шүүгч нь энэ хэмжээнд байгаа бол шүү.

Чухамхүү эцэслэн шийдвэрлэдэг тэр чанараар нь шүүх эрх мэдлийг шүүхүүд хэрэгжүүлнэ гэж Үндсэн хуульд заасан байдаг. Түүнээс биш бүгдийг шүүх ганцаар хийдэг гэсэн үг биш. Элдэв хэрэг, маргааныг үүсэхээс нь өмнө эцэслэн шийдвэрлэх хүртэл, бас шийдсэний нь дараа ч их ажил ундардаг. “Гурил хийхийн тулд буудай тарьдаг, буудай ургуулахын тул газар боловсруулдаг.” гэхчлэн яриад байвал нэг ажлын нэг гинжин холбоо цааш үргэлжилнэ. Тэр лугаа адил шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхийн өмнө хэрэг бүртгэх, мөрдөн байцаах /энэ хоёрыг нэгтгээд мөрдөн шалгах/ тэр бүхэнд хууль ёсыг сахин биелүүлж байгаа эсэхийг хянаж, гажуудлыг арилгуулах зэргийн нарийн төвөгтэй их ажил ундардгийг бид мэднэ.

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсний дараа түүнийг биелүүлэх /эрүүгийн хэргийн хувьд ял эдлүүлэх/ ажиллагааг залгаж, түүнд бас хуулийг сахиж байна уу гэж хяналт тавих шаардлага гарна. Тэр бүхийг прокурор хянаж зөвшөөрөл олгож, татгалзаж, гажуудлыг арилгуулж, бас шүүхэд яллаж буюу яллагааг дэмжиж байгаагаараа шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд амин чухал бөгөөд үлэмжхэн үүрэг гүйцэтгэж буй хэрэг. Гэхдээ эцсийн шийдвэр гаргадаггүй. Тиймээс л “оролцогчийн” статустай гэсэн үг. Бас прокурорын үйл ажиллагаа өөрөө шүүхийн хяналтад байдаг.

Чухам ийм учраас л шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч гээд байгаа бөгөөд яллагчийн хувьд энэ нь шүүх хуралдаанд мэтгэлцэгч тал болон оролцоно гэдгээс хавьгүй өргөн ойлголт билээ.

3. Прокурор бол харьцангуй бие даасан тогтолцоо мөн боловч эцсийн дүнгээ шүүхийн тогтолцоонд түшиглэсэн байгууллагууд юм. Түүний үндсэн тогтолцоо ямар байх нь шүүхийн тогтолцоо ямар байхаас хамаарч байна. Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо нь Улсын Ерөнхий прокурорын газар, аймаг нийслэлийн прокурорын газар, сум, сум дундын болон дүүргийн прокурорын газруудаас бүрэлдэж буй нь шүүхийн үндсэн тогтолцоог санагдуулж байгаа биз дээ.

Мөн хуульд дагнасан прокурор байж болно гэсэн нь шүүхийн тухай Үндсэн хуулийн заалттай холбоотой юм. Гагцхүү тэр тогтолцооны зарчмын үндэс нь шүүх шиг тус тусдаа бие даасан бус, доод шатных нь дээд шатныхаа прокурорт шатлан захирах төвлөрсөн удирдлагатайд оршино. Бас бус ялгаа бий ч энэ бол зохион байгуулалтын зарчмын нэг гол онцлог.

Төвлөрөл, хууль ёс, гадны нөлөөнд үл автах энэ гурав бол прокурорын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим мөн.

Товчхон тэмдэглэхэд Монгол Улсын прокурорын байгууллага цаашид шүүхтэй, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй ихээхэн уялдаатай шинэчлэгдэх нь түүний гол хандлага байх болов уу. Юутай ч одоо зарим хүний мөрөөдөөд байгаа шиг “Ерөнхий хяналт нь бүрэн сэргээд” дөрөв дэх эрх мэдлийн байгууллага болж эргэн тогтохгүй буй заа. Тэгэхдээ өөр нэг чухал хандлагыг тэмдэглэх хэрэгтэй.²

Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын прокурорын байгууллага нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын үүднээс авч үзвэл шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарах байгууллага болох нь харагдаж байна.

Гадаад улс, орнуудад прокурорын байгууллага нь төрийн аль эрх мэдэлд хамаарахыг янз бүрээр зохицуулсан байдаг. Энэ нь тухайн улс орны эрх зүйн зохицуулалтын онцлог, төрийн дэглэм, засаглалын хэлбэр, туршлага гэх мэт олон хүчин зүйлсээс хамаардаг.

Хүснэгт 1.4. Гадаад улсуудын зохицуулалт: Эрх мэдлийн хуваарилалтад прокурорын байгууллагын эзлэх байр суурь

	Хамаарах улсууд	Эрх зүйн зохицуулалтууд
Шүүх засаглалын хүрээнд	Бүгд Найрамдах Финлянд Улс	Үндсэн хуульд зааснаар Прокурорын байгууллага нь шүүх эрх мэдэлд хамаарч байна. ³

2 Прокурорын ном: прокурорын гарын авлага, Хян. Б.Чимид, (Уб, 2000), 5-10 дахь тал.

3 Finland's Constitution of 1999 with Amendments through 2011, Chapter 9, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Finland_2011.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

	Бүгд Найрамдах Австри Улс	Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн В хэсэг буюу Шүүх эрх мэдлийн хэсэгт прокурорын байгууллага хамаарч байна. ⁴
	Шведийн Хант Улс	Ерөнхий прокурор нь хууль эрх зүйн хөгжил, Дээд шүүхийн үйл ажиллагаа, захиргааны чиг үүргийг хариуцдаг. ⁵
	Нидерланд Улс	Үндсэн хуульд прокурорыг 6 дугаар бүлэг буюу шүүх эрх мэдлийн хэсэгт оруулан хуульчилсан байна. ⁶
Гүйцэтгэх засаглалын хүрээнд	Норвегийн Хант Улс	Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдэлд хамаардаг Хууль зүйн яамны харьяа байгууллага юм. ⁷
	Сингапур Улс	Үндсэн хуулийн 4 дүгээр хэсгийн 2 дугаар бүлэг буюу гүйцэтгэх засаглалын хэсэгт прокурорын байгууллагын талаар хуульчилсан учраас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага байна. ⁸
	Япон Улс	Прокурорын байгууллагын эрх мэдэл нь гүйцэтгэх засаглалд хамаардаг байна. ⁹
	Шинэ Зеланд Улс	Прокурорын байгууллага нь гүйцэтгэх засаглалын бүрэлдэхүүнд хамаардаг байна. ¹⁰
Хосолсон байдлаар	Румын Улс	Үндсэн хуулийн 132-т прокурорын үйл ажиллагаа “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд” хамаардаг хэдий ч түүний бүрэн эрх хязгаарлагдмал, прокурортой хамаарах шүүх эрх мэдлийн хүрээнээс хэтэрч болохгүй.” ¹¹
	Словени Улс	Прокурорын газар нь албан ёсоор гүйцэтгэх засаглалын нэг хэсэг юм. Харин Үндсэн хуулийн шүүхийн 2013 оны шийдвэрт прокурорын байгууллагыг засгийн газрын бүтцэд оруулж болохгүй талаар тодорхойлсон. Энэ нь төрийн бусад байгууллагаас хянах тогтолцоог хязгаарлахад хүргэнэ гэж үзсэн. ¹²
Тусад нь зохицуулах байдлаар	Бүгд найрамдах Эстони Улс	Прокурорын тухай хуулийн 1-д “Прокурорын байгууллага нь хуулиас үүдэлтэй чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус бөгөөд энэ хууль, бусад хууль тогтоомж, тэдгээрийн үндсэн дээр гаргасан хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулна.” ¹³ гэж зохицуулсан байдаг.

Прокурорын байгууллагын төрийн аль эрх мэдлээс хамаарахыг бусад улс, орнуудын хувьд авч үзвэл харилцан адилгүй байдлаар тогтоосон байна. Өөрөөр

- 4 Austria's Constitution of 1920, Reinstated in 1945, with Amendments through 2009, Chapter III, Section B, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Austria_2009.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 5 Legal professions – introduction, Холбоос: https://e-justice.europa.eu/content_legal_professions-29-se-en.do?member=1, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 6 Constitution of The Netherlands 1814 (rev. 2008), chapter 6, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Netherlands_2008?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 7 Welcome to The Higher Prosecuting Authorities - The Director of Public Prosecutions and the Regional Public Prosecution Offices, Холбоос: <https://www.riksadvokaten.no/english/>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 8 Singapore's Constitution of 1963 with Amendments through 2016, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Singapore_2016.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 9 Masato Shimizu, Nikkei senior staff writer, “Japanese prosecutors and politicians keep up a delicate dance”, May 30, 2020, Холбоос: <https://asia.nikkei.com/Politics/Japanese-prosecutors-and-politicians-keep-up-a-delicate-dance#:~:text=The%20right%20of%20prosecution%2C%20however,right%20to%20investigate%20the%20government>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 10 “How is a judge appointed?”, Courts of New Zealand website, Холбоос: <https://www.courtsofnz.govt.nz/learn-about-our-courts/how-is-a-judge-appointed/#:~:text=The%20Attorney%2DGeneral%20is%20a.not%20influenced%20by%20party%20politics>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.
- 11 Art. 132 (1) of Romania's Constitution, 1991, The prosecutors carry out their activity according to the principles of legality, impartiality and hierarchical control, under the authority of the minister of justice.
- 12 See Section 21-25 of Decision U-I-42/12-15 of Slovenia's Constitutional Court, dated 7th February 2013.
- 13 Article 13 of Estonia's Prosecutor's Office Act, 1998.

хэлбэл, 1) шүүх эрх мэдлийн хүрээнд, 2) гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд, 3) аль аль нь хосолсон байдлаар, 4) бие даасан байдлаар зохицуулах гэсэн 4 ангилалд хувааж болохоор байна.

Энэ талаар ХБНГУ-ын Аугсбургийн Их Сургуулийн профессор Петер Казиске хэлэхдээ "...ХБНГУ-ын хувьд прокурорын байгууллага нь гүйцэтгэх засаглал буюу Засгийн газар, цаашлаад хууль зүйн яамны харьяанд ажилладаг байгууллага юм. Улс, орон бүр прокурорын байгууллагыг төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хамааруулахдаа өөр өөрөөр тодорхойлсон байдаг. Хамгийн дэвшилтэт бөгөөд прокурорын байгууллагын бие даасан байдал, прокурорын хараат бус байдлыг баталгаажуулж өгөх арга нь прокурорын байгууллагыг шүүх эрх мэдлийн хүрээнд хамааруулах юм. ХБНГУ-д прокурорын байгууллагыг гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хамааруулах ямар нэг асуудал гарахгүй байгаа нь тус улсын эрх зүйн хөгжил, ухамсар, соёлтой холбоотой..."¹⁴ гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллагаас (OECD) хийсэн "Зүүн Европ, Төв Ази, Ази Номхон далайн улсуудын прокурорын хараат бус байдал" судалгааны тайланд мөн энэ талаар дараах зөвлөмжийг өгсөн байна.

Прокурорын хараат бус байдал нь шүүхийн хараат бус байдлын салшгүй үр дагавар болох бөгөөд үйл ажиллагааны чухал зарчим байх ёстой. Нөгөөтэйгөөр, прокурорууд шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэж, хамгаалах ёстой.

-Прокурорын байгууллагын эрх мэдлээс хараат бус байх мөн чанар, хамрах хүрээг хуулиар тогтоох;

-Прокурор нь Шүүхийн байгууллагад харьяалагддаг бол хууль нь прокурор, шүүгчийн үүргийг тус тусад нь хангах ёстой бөгөөд хэрэв энэ нь боломжтой бол хоёр чиг үүргийг хэрхэн дараалан гүйцэтгэхийг зохицуулах ёстой.¹⁵

ХЗҮХ-ийн ХЗСТ-өөс 2022 онд хийсэн "Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага/" судалгааны тайланд энэ талаар "...Монгол Улсын хувьд Үндсэн хуульд заасан болон судлаачдын үзэж буйгаар прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарч байна. Тийнхүү прокурорын байгууллага нь аль ч эрх мэдлээс хамаарсан прокурорын байгууллага нь хараат бус байх мөн чанар, хүрээг хуулиар тогтоож өгөх нь зүйтэй..."¹⁶ гэх дүгнэлтийг өгчээ.

Дүгнэвэл, Монгол Улсын хувьд прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарна. Харин бусад улс, орнуудын хувьд шүүх эрх мэдлийн хүрээнд хамааруулахаас гадна гүйцэтгэх засаглалын хүрээнд хамааруулах эсвэл хосолсон болон тусад нь зохицуулах байдлаар зохицуулсан байна.

Гэсэн хэдий ч шүүх эрх мэдлийн хүрээнд хамааруулах нь олон улсын сайн туршлагад тооцогдох бөгөөд зарим тохиолдолд эрх зүйн зохицуулалт, соёл, ухамсрын түвшнээс шалтгаалан мөн өөр байж болохоор байна. Прокурорын

14 ХБНГУ-ын профессор П.Казискегийн залуу судлаачтай уулзах уулзалт, хэлэлцүүлгийн үеэр хийсэн ярилцлагын хэсгээс...(2022.10.05).

15 The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific, OECD, (2020), pp.23-27.

16 "Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага/" судалгааны тайлан, ХЗҮХ, (УБ, 2022), 11 дэх тал.

байгууллага нь аль эрх мэдэлд хамаарахаас үл хамааран түүний бие даасан байдал, прокурорын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж өгөх нь нийтлэг байдлаар чухлаар тавигдаж байгааг дурдах нь зүйтэй.

Б. Прокурорын байгууллага дахь Ерөнхийлөгчийн оролцоо

Монгол Улсын хувьд прокурорын байгууллага нь төрийн эрх мэдлийн хуваарилалтын хувьд шүүх эрх мэдэлд хамаардаг хэдий ч түүний үйл ажиллагаанд Ерөнхийлөгч оролцоо өндөр байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа Ерөнхийлөгч нь чиг үүргийн хувьд гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах тул шүүх эрх мэдэл болон гүйцэтгэх эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийн асуудал яригдаж болохоор байна.

Мөн шүүхийн шинэтгэлийн хүрээнд батлагдсан Шүүхийн тухай хуулийн үзэл санааны үүднээс авч үзсэн ч шүүх эрх мэдлийн байгууллага болох прокурорын байгууллага дахь Ерөнхийлөгчийн оролцоог эргэн харах нь зүйтэй.

Прокурорын тухай хуульд зааснаар Ерөнхийлөгч нь прокурорын байгууллагад дараах оролцоог хэрэгжүүлж байна. Үүнийг дотор нь ангилбал бодит болон хэлбэрийн оролцоо гэж авч үзэх боломжтой байна.

Бодит оролцоо:

- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно. /46.1, 2/
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ. /46.5/
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрхийг тодорхой тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэр гаргаж дуусгавар болгоно. /46.6/
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар дүгнэлт гаргах. /50.2/
- Прокурорын мэргэжлийн дүрэм, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /64.2/
- Прокурорын ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /65.2/
- Прокурорын сахилгын дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /67.3/

Хэлбэрийн оролцоо:

- Прокурорын тангараг өргөх ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /47.2/
- Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /54.2, 54.3/
- Прокурорын бэлгэдэл, далбаа, дүрэмт хувцас, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. /69.2/

Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын Ерөнхийлөгч нь прокурорын байгууллагын үйл ажиллагаанд их оролцдог болох нь харагдаж байна. Мөн хэлбэрийн гэхээсээ илүү бодит оролцоо их байна. Иймд Ерөнхийлөгчийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, Ерөнхийлөгч болон прокурорын байгууллагын хоорондын харилцааг тодорхойлох нь зүйтэй.

Ерөнхийлөгч нь төрийн засаглалын аль хэлбэр, дэглэм байгаагаас хамааран гүйцэтгэх засаглалд ялгаатай чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ талаар Академич С.Нарангэрэл дараах байдлаар тодорхойлжээ.

“Бүгд найрамдах улсын хэлбэрт Ерөнхийлөгч гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн байна. Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн статус ба бүрэн эрх бүгд найрамдах улсын хэв шинжээс шалтгаалж, эрс ялгагдана. Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсын сонгодог хэлбэр нь АНУ бөгөөд төрийн тэргүүн төдийгүй гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн, өөрөөр хэлбэл, засаг захиргааны буюу Засгийн газрын тэргүүн байдаг. Энэ нөхцөлд Ерөнхий сайдын албан тушаал байдаггүй. Ерөнхийлөгч нь парламентаас ангид замаар өөрөөр хэлбэл, ард түмнээс шууд ба шууд бусаар сонгогдоно. Парламентын бүгд найрамдах улсад Ерөнхийлөгч нь зөвхөн төрийн тэргүүн байх бөгөөд Засгийн газрын тэргүүн биш байна. Гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхий сайдаар тэргүүлсэн Засгийн газар хэрэг дээр барих бөгөөд ялангуяа энэ нь Ерөнхийлөгчийн дийлэнх акт Ерөнхий сайд буюу холбогдох сайд баталгаажуулснаар илэрлээ олддог. Ерөнхийлөгчийг гол төлөв парламент буюу түүний оролцоотойгоор сонгоно. Холимог буюу хагас ерөнхийлөгчийн хэв шинжийн бүгд найрамдах улс байдаг бөгөөд Ерөнхийлөгч зөвхөн төрийн тэргүүн байх хийгээд тэгэхдээ парламентын өмнө Засгийн газрыг хариуцах эрх мэдлийн бүрэн эрхийг бодитой эдэлдэг. Ийм тогтолцоонд Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгоно. Ерөнхийлөгчийн загвараас үл хамааран Ерөнхийлөгч Үндсэн хуулиар дараах бүрэн эрхийг эдэлнэ: олон улсын харилцаанд улс орноо төлөөлөх, олон улсын гэрээ байгуулах, Засгийн газрын гишүүн ба шүүгчийг томилоход оролцох, хуулийг батлах ба ёсчлох, зарлиг гаргах, хууль санаачлах, хуульд хориг тавих эрх, одон медалиар шагнах, цэргийн дээд цол хүртээх, уучлал үзүүлэх эрхийг хэрэгжүүлж, харьяатын асуудлыг шийдвэрлэж, дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилж, эгүүлэн татна. Парламентын ба холимог хэв шинжийн бүгд найрамдах улсын хэлбэрт Ерөнхийлөгч нь тодорхой нөхцөлд парламентыг тараах, сонгуулийг хугацаанаас өмнө зарлах эрх эдэлнэ.”¹⁷

Монгол Улсын прокурорын байгууллага нь өмнө нь дурдсанчлан шүүх эрх мэдлийн байгууллага хэдий ч Ерөнхийлөгч буюу гүйцэтгэх засаглалын институтийн прокурорын байгууллага дахь оролцоо өндөр байна.

Гадаадын улс, орнуудын хувьд прокурорын байгууллага дахь Ерөнхийлөгчийн оролцоог олон янзаар тодорхойлдог ба Монгол Улсынхтай адил өргөн оролцоогүй болохыг ХЗҮХ-ийн 2021 оны “Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага/” судалгааны тайланд авч үзсэн байна.

Мөн ЭЗХАХБ-аас хийсэн “Зүүн Европ, Төв Ази, Ази Номхон далайн улсуудын прокурорын хараат бус байдал” судалгаанд Ерөнхий прокурорыг улс төрийн институциас тусгаарлах нь Прокурорын байгууллагын хараат бус байдалд чухал гэж мөн тодорхойлсон байдаг.¹⁸

Өмнөх туршлагаас үзвэл ийнхүү зохицуулах нь хараат бус байдалд нөлөөлдөг болох нь нотлогдож байсан. Тухайлбал, 2012 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 2021 онд шинэчилж баталсан. Тухайн шинэчлэлийн хүрээнд Ерөнхийлөгчөөс шүүгчийн томилгоо хараат байгаатай холбогдуулан Шүүхийн Ерөнхий зөвлөл

¹⁷ С.Нарангэрэл, *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг*, (УБ, 2021), 139 дэх тал.

¹⁸ *The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific*, OECD, (2020), pp.39-45.

эрэмбийн дагуу нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлэхээр зохицуулсан.

Энэ талаар 2021 оны Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын үзэл баримтлалд дурдахдаа "...Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгч бүх шатны шүүхийн шүүгч нарыг томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд 3 хүнийг нэр дэвшүүлэн илгээж байгаа нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлын Үндсэн хуулийн баталгаа болоход оршиж байгаагаас бус шүүхийг харьяалах зорилго агуулгагүй. Ийнхүү харьяалан захирах боломж олгохгүй тул шүүгчийг томилох, чөлөөлөх, огцруулах, шүүгчийг өөр шүүхэд шилжүүлэн томилохыг Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар бус Шүүхийн ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснийг үндэслэж шийдвэрлэдэг Үндсэн хуулийн зохицуулалттай..."¹⁹ гэж ач холбогдлыг нь тайлбарласан байна.

Иймээс Монгол Улсын прокурорын байгууллага нь шүүх эрх мэдэлд хамаарч байгааг харгалзан, мөн прокурорын байгууллагын бие даасан байдал, прокурорын хараат бус байдлын үүднээс Ерөнхийлөгчийн прокурорын байгууллага дахь оролцоог хязгаарлах нь зохимжтой. Ерөнхийлөгчийн оролцоог ийнхүү хязгаарлахдаа хэлбэрийн оролцоо болон агуулгын оролцоог аль алийг нь хязгаарлах хэрэгтэй байна. Гадаад улсуудад прокурорын зөвлөл нь прокурорыг томилох, огцруулах, дэвшүүлэх, сахилгын шийдвэр ногдуулах, урамшуулал олгох, прокурорын орон тоог тогтоох, Ерөнхий прокурорыг огцруулах санал гаргах гэх мэт чиг үүргүүдийг зөвлөлдөж шийдвэрлэдэг. Үүнтэй адилаар прокурорын зөвлөл болон бусад өөрөө удирдах байгууллага, албан тушаалтнуудад тухайн чиг үүргийг өгч Ерөнхийлөгчийн оролцоог хязгаарлах нь зүйтэй.

3.2. Ерөнхий прокурор, түүний орлогч

Судалгааны энэхүү хэсгээр Прокурорын тухай хуульд заасан Монгол Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлага, томилох үйл явц, огцруулах үйл явцын талаар зохицуулалтыг судлах юм.

А. Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлага

Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, гучин таван насанд хүрсэн прокурорыг Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор томилохоор тусгажээ. Өөрөөр хэлбэл Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор зөвхөн прокуророор ажиллаж байсан хүн томилогдож болохоор байна.

2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачилсан ба үүнд Прокурорын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд "Прокурорын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн "прокурорын" гэснийг "Монгол Улсын "иргэнийг" гэж өөрчилсүгэй" гэжээ. Энэхүү өөрчлөлт нь прокурор бус энгийн иргэн, тэр дундаа улс төрчдийг Улсын Ерөнхий прокуророор томилох эрх зүйн орчин бүрдэнэ гэж

¹⁹ 2021 оны Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын үзэл баримтлал.

иргэдийн шүүмжлэлийг ихээхэн авсан.²⁰ Тиймээс тухайн хуулийн төслөө УИХ эргүүлэн татсан байна.

Энэ талаар хуульчид болон иргэдийн дунд ихээхэн шүүмжлэл гарч байсан. Тухайлбал, Улсын ерөнхий прокуророор мэргэжлийн бус хүн, тохиромжгүй улс төрч хүн томилогдох магадлалтайг “...Шүүгчийн туслахад гэхэд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй эрх зүйчийг ажиллуулах шаардлага тавьдаг. Гэтэл бүхэл бүтэн Прокурорын байгууллагын удирдлагыг “Монгол Улсын иргэн” буюу ямар ч хуульчийн мэргэжлийн болон бусад шаардлага тавихгүй байгаа нь гэмт хэрэг, гэмт явдалтай тэмцэх төрийн хүчийг сулруулах аюултай нөхцөл байдал үүсэхэд хүрнэ. Хуульчид ялангуяа прокурорууд мэргэжлийн бус хүнээр удирдуулахыг дотоод итгэл үнэмшлийн хувьд хүлээн зөвшөөрөхгүй. Нөгөө талаар прокурорын байгууллагад ажиллаж байгаа хуульчдын хувьд мэргэжлийн карьер хийх сонирхол, хүсэл эрмэлзлэлгүй болгоход хүрнэ. Одоо прокурорын байгууллага хүний нөөцийн хувьд маш хомсдолтой байгаа. Энэ байдал улам ихэснэ. Прокурорын байгууллага хуульд заасан чиг үүргээ мэргэжлийн хэмжээнд гүйцэтгэхэд улам их хүндрэл үүсэж болзошгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2-т “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно” гэж заасан буюу Прокурорын тухай хуульд заасан хуульчийн мэргэжлийн болон бусад шаардлагыг хангасан хуульчийг Ерөнхийлөгч томилох бүрэн эрхтэй. Тэгэхээр Ерөнхий прокурорт тавих Хуульчийн мэргэжлийн болон бусад шаардлага байхгүй болсон тохиолдолд хэн ч Ерөнхий прокурорын албан тушаалд томилогдох боломж нээгдэнэ. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчтэй ойр улстөрчид л томилогдох нөхцөл байдал үүсэх нь ойлгомжтой. Гэхдээ дагаж гарах хуулийн төсөлтэй холбогдуулан Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Прокурорын тухай хуульд оруулах өөрчлөлтийг дэмжихгүй талаар байр сууриа олон нийтэд илэрхийлснийг харсан...”²¹ гэх байдлаар шүүмжилж байсан.

Бусад улс, орнуудад Ерөнхий прокурор болон түүний орлогчид тавигдах шаардлагыг олон янзаар зохицуулсан байна.

Хүснэгт 1.5. Гадаад улсуудын зохицуулалт: Улсын Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг тодорхойлсон байдал

Улс	Улсын Ерөнхий прокурорт тавигдах шаардлага
Норвегийн Хант Улс	Эрүүгийн процессын хуулийн 56 дугаар зүйлд зааснаар Улсын Ерөнхий прокурор болон орлогч нь хуульчийн албан ёсны шалгалтад тэнцсэн эсвэл эрх зүйн магистраас дээш зэрэгтэй байхыг шаарддаг. ²²

20 Х.Нямбаатар, “Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслөө татна”, (сурв. Г.Батжаргал), 2022.05.31, Холбоос: <http://itoim.mn/article/YQWxl/33377>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

21 Ч.Өнөржаргал, “Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг хасна гэдэг гэмт хэрэгтэй тэмцэх төрийн хүчийг сулруулна dnn.mn”, (сурв. Б.Энхзаяа), Холбоос: <https://dnn.mn/ч-өнөржаргал-ерөнхий-прокурорт-тавигдах-шаардлагыг-хасна-гэдэг-гэмт-хэрэгтэй-тэмцэх-төрийн-хүчийг-сулруулна-dnn-mn/>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

22 Ч.Өнөржаргал, “Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг хасна гэдэг гэмт хэрэгтэй тэмцэх төрийн хүчийг сулруулна dnn.mn”, (сурв. Б.Энхзаяа), Холбоос: <https://dnn.mn/ч-өнөржаргал-ерөнхий-прокурорт-тавигдах-шаардлагыг-хасна-гэдэг-гэмт-хэрэгтэй-тэмцэх-төрийн-хүчийг-сулруулна-dnn-mn/>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Ерөнхий прокурор нь хуульч мэргэжилтэй байх ёстой бөгөөд ХБНГУ-аас авдаг хуулийн 1, 2-р шалгалтад тэнцсэн байх ёстой. Мөн прокурорын байгууллага болон шүүхийн байгууллагад өмнө нь ажиллаж дадлагажсан байхыг шаарддаг байна. ²³
Бүгд Найрамдах Солонгос Улс	2017 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар Ерөнхий прокурорыг дор дурдсан зүйлийн албан тушаалтнаар 15-аас доошгүй жил ажилласан хүмүүсээс томилно. 1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч; 2.Төрийн байгууллага, бусад аж ахуйн нэгжийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа, төрийн болон төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн байгууллагад хуульчийн мэргэшсэн, хууль зүйн ажил эрхэлж байсан хүн; 3.Хуульчийн мэргэжлээр мэргэшсэн, коллеж, их дээд сургуульд хуулийн тэнхимийн туслах профессор болон түүнээс дээш албан тушаалд ажиллаж байсан хүн. ²⁴
Америкийн Нэгдсэн Улс	АНУ нь муж улс бүрд өөрөөр Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг хуульчилжээ. Тухайлбал, Алабама мужид 25-аас дээш настай, АНУ-д 7 жил, тухайн мужид 5 жил суурьшсан хүнийг, Аризона мужид 25-аас дээш настай, АНУ-д 10 жил, тухайн мужид 5 жил суурьшсан, дор хаяж таван жилийн хугацаанд улсын дээд шүүхийн өмнө өмгөөлөгчөөр ажилласан хүнийг, Калифорни мужид 18-аас дээш настай АНУ болон тухайн мужид суурьшиж буй Дээд шүүхэд 5-аас дээш жил дадлага хийсэн хүнийг, Колорадо мужид 25-аас дээш настай АНУ болон тухайн мужид суурьшиж буй нэр хүндтэй Дээд шүүхийн өмгөөлөгч хүнийг, Жоржиа мужид 25-аас дээш настай, АНУ-д 10 жил, тухайн мужид 4 жил суурьшсан, Жоржиа мужийн Хуульчдын холбоонд долоон жилийн хугацаанд идэвхтэй гишүүн байсан хүнийг, Кентаки мужид 30-аас дээш настай тухайн мужид 2 жил суурьшиж буй, сүүлийн 8 жил хуульчаар ажилласан хүнийг ²⁵ гэх мэтээр Улсын Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг тодорхойлжээ.
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Энэтхэгийн Ерөнхий прокуророор томилогдохын тулд тухайн хүн Дээд шүүхийн шүүгчийн шаардлага хангасан байх ёстой. Өөрөөр хэлбэл, дээд шүүхийн шүүгч 5 жил, эсвэл дээд шүүхэд 10 жил өмгөөлөгч, эсвэл нэр хүндтэй хуульч байх ёстой. ²⁶
Их Британи	Наад зах нь хоёрдугаар зэрэглэлийн (2:2) зэрэгтэй, хуульч, өмгөөлөгчөөр бэлтгэгдсэн, хуулийн практикийн курс эсвэл хуульчийн мэргэжлийн сургалтын курсээ дүүргэсэн, 2 жилийн сургалтын гэрээг төгссөн хүн Улсын Ерөнхий прокурорын шаардлагад нийцдэг байна. ²⁷
Бүгд Найрамдах Латви Улс	Бүгд Найрамдах Латви Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 35 дугаар зүйлд "10-аас доошгүй жил прокуророор ажилласан эсхүл 5-аас доошгүй жил Улсын Дээд шүүхийн шүүгчээр ажилласан хүнийг Улсын Ерөнхий прокурор болон түүний орлогчоор томилно" ²⁸ гэж заасан байна.
Бүгд Найрамдах Эстони Улс	Бүгд Найрамдах Эстони Улсын 1998 оны Прокурорын байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 8-д зааснаар Ерөнхий прокуророор туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн хуульч хүнийг томилохоор байна. ²⁹

23 ХБНГУ-ын Аугсбургийн Их Сургуулийн профессор Петер Казискетэй хийсэн ярилцлагын хэсгээс.
24 Prosecutors' Office Act of Korea, Expand Act No. 14582, Mar. 14, 2017, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42630&lang=ENG, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30
25 States' Qualifications for Attorney General, Холбоос: <https://www.cga.ct.gov/2010/rpt/2010-R-0253.htm>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30
26 Attorney General of India: Appointment, duties and special rights, Холбоос: <https://www.indiatoday.in/education-today/gk-current-affairs/story/attorney-general-of-india-appointment-duties-and-special-rights-1895843-2022-01-04>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.
27 Crown prosecutor, Холбоос: <https://nationalcareers.service.gov.uk/job-profiles/crown-prosecutor>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.
28 Prokuratūras likums, 35, Холбоос: <https://likumi.lv/ta/id/57276-prokuraturas-likums>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.
29 Prosecutor's Office Act of Estonia, 1998, Article 15, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/515092021001/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

Украин улс	Украины өмнөх Ерөнхий прокуроруудын нэгийг эрх зүйч мэргэжил эзэмшээгүй хүнээр томилсон. Украины Дөрөв дэх удаагийн мониторингийн тайланд энэхүү шинэчлэл нь “прокурорын ерөнхий тогтолцоонд хууль дээдлэх ёсыг сайн төлөвшүүлэхгүй байна”, мөн “Ерөнхий прокурорын албанд итгэх, хараат бус олон нийтийн итгэлийг бий болгоход сөргөөр нөлөөлөх” зэрэгт санаа зовж буйгаа илэрхийлжээ. 2019 онд Улсын ерөнхий прокурор ажлаа хүлээлгэн өгсний дараагаар Ерөнхий прокурорын хуульч мэргэжилтэй байх шаардлагыг сэргээсэн. ³⁰
------------	---

Гадаад улс, орнуудад Улсын ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг Монгол Улсынхтай адил зөвхөн прокурор байхаар томьёолоогүй байна. Үүнээс гадна бусад чиглэлээр хуульчийн үйл ажиллагаа эрхэлж байсан буюу шүүгч, өмгөөлөгч, хуулийн мэргэжилтэн, их сургуулийн багшаар ажиллаж байсан хүмүүсийг томилж болохоор тусгажээ. Түүнчлэн, хуулийн чиглэлээр сургууль төгссөн байх тусгайлсан шалгалтад тэнцсэн байх шаардлагыг тавьснаас гадна ажилласан жилийн туршлагыг мөн харгалзаж үзэхээр тусгажээ. Өөрөөр хэлбэл, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг Улсын Ерөнхий прокуророор томилдог, улмаар прокурорын байгууллагад олон ургалч үзлийг бий болгох нь гадаад улсуудын жишиг болж байна.

Тиймээс Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлагыг одоо байгаагаар буюу зөвхөн прокурор байхаар зохицуулахаас илүү гадаад улс, орнуудын зохицуулж буй сайн туршлагыг даган шүүгч, өмгөөлөгч, хуулийн мэргэжилтэн, их сургуулийн багш гэх мэтээр тохиромжтойгоор тусгах нь зүйтэй.

Б. Ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох үйл явц

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2-т Улсын ерөнхий прокурорыг томилох үйл явцыг “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно” гэж заасан байна. Үүнийг органик хууль буюу Прокурорын тухай хуульд илүү нарийвчлан зохицуулжээ. Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлд энэхүү томилгооны талаар тусгасан бөгөөд Улсын ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилдог. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон хүнийг Улсын Их Хурал дэмжихгүй бол нэг удаа өөр хүний нэрийг дэвшүүлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогчийг Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно. Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн гэдэг нь Улсын Их Хурал тухайн нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан тохиолдолд сонгоно гэсэн үг.³¹ Мөн Прокурорын тухай хуулийн 46.8-д Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигчийн сонголыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо зохион байгуулахаар зохицуулсан. Түүнчлэн тус хуулийн 46.7-д Улсын Ерөнхий прокурорын бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуульд заасан журмын дагуу дараагийн Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилохоор байна.

Бусад улс, орнууд эрх зүйн тогтолцоо, төрийн засаглалын хэлбэр, дэглэм, уламжлалаас хамаарч, Ерөнхий прокурорыг томилох үйл явцыг ялгаатай байдлаар тодорхойлсон байна.

30 The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific, OECD, (2020), p.40.

31 Г.Баясгалан, Н.Туяа нар, *Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар*, (УБ, 2003), 14 дэх тал.

Хүснэгт 1.6. Гадаад улсуудын зохицуулалт: Ерөнхий прокурорын томилгоо, үйл явцын талаар тодорхойлсон байдал

Улс	Ерөнхий прокурорын томилгоо, үйл явцын талаар эрх зүйн зохицуулалтууд	Томилох субъект
Норвегийн Хант Улс	Эрүүгийн процессын хуулийн 56 дугаар зүйлд зааснаар Улсын Ерөнхий прокурорыг Хаан, түүний орлогчийг Яам томилдог. ³²	Хаан
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	“Шүүхийн тухай хууль”(Gerichtsverfassungsgesetz – GVG)-ийн 149 дүгээр зүйлд “Холбооны Ерөнхий прокурор, холбооны прокуроруудыг Холбооны Хууль зүйн сайдын санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилдог бөгөөд үүнд Бундесратаас зөвшөөрөл авах шаардлагатай.” ³³ гэж зохицуулсан байна.	Ерөнхийлөгч
Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын Ерөнхий прокурорын газрын Ерөнхий прокурор, Улсын Ерөнхий прокурорын орлогч зэрэг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоогдсон Улсын Ерөнхий Прокурорын газрын прокуророос дээш зэрэглэлийн прокуроруудыг шаардлага хангасан хүмүүсээс томилно. Улсын Ерөнхий прокурорыг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх нэр дэвшигчдийн Зөвлөлийн хорооноос санал болгож, Хууль зүйн сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилдог. Үндэсний ассамблей томилгооны талаар боловсон хүчний сонголт хийдэг. Бүрэн эрхийн хугацаа нь хоёр жил боловч заавал байх албагүй. ³⁴	Ерөнхийлөгч
Бүгд Найрамдах Эстони Улс	Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-т “Бүгд Найрамдах Улсын Засгийн газар Рийгикогу хотын Хууль зүйн хорооны санал, дүгнэлтийг хэлэлцээд тухайн бүсийг хариуцсан сайдын санал болгосноор Ерөнхий прокурорыг албан тушаалд томилно.” ³⁵ гэж тодорхойлсон байна.	Засгийн газар
Америкийн Нэгдсэн Улс	Ерөнхийлөгч АНУ-ын Ерөнхий прокурорыг Сенатын зөвлөгөө, зөвшөөрлөөр томилдог. ³⁶	Ерөнхийлөгч
Оросын холбооны Улс	1992 онд батлагдсан “Оросын холбооны прокурорын байгууллагын тухай хууль”-иар зохицуулдаг. ОХУ-ын Ерөнхий прокурорыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн санал болгосноор ОХУ-ын Холбооны Зөвлөл томилж, чөлөөлнө. ОХУ-ын Ерөнхийлөгчөөс ОХУ-ын Ерөнхий прокурорын албан тушаалд томилуулахаар санал болгосон хүн Холбооны Зөвлөлийн хуралдаанд хангалттай тооны санал аваагүй бол ОХУ-ын Ерөнхийлөгч өөр нэр дэвшигчийг 30 хоногийн дотор Холбооны хуралд танилцуулна. ОХУ-ын Холбооны Зөвлөлийн дарга нь ОХУ-ын Ерөнхий прокуророор томилогдсон хүнийг Холбооны Зөвлөлөөс тогтоосон журмын дагуу тангараг өргүүлэх ёстой. ОХУ-ын Ерөнхий прокурорыг томилох, чөлөөлөх тухай хэвлэлд зарлана. ³⁷	Холбооны зөвлөл

32 The Criminal Procedure Act of Norway, Act of 22 May 1981 No. 25, Article 56, Холбоос: <https://app.uio.no/ub/ujur/oversatte-lover/data/lov-19810522-025-eng.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

33 Courts Constitution Act in the revised version published on 9 May 1975 (Federal Law Gazette I p. 1077), as last amended by Article 4 of the Act of 25 June 2021 (Federal Law Gazette I, p. 2099)

34 Prosecutor General of the Republic of Korea, Холбоос: https://ko.wikipedia.org/wiki/%EB%8C%80%ED%95%9C%EB%AF%BC%EA%B5%AD%EC%9D%98_%EA%B2%80%EC%B0%B0%EC%B4%9D%EC%9E%A5, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

35 Prosecutor’s Office Act of Estonia, 1998, Chapter 4, Article 16, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/515092021001/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

36 28 U.S. Code § 503 - Attorney General, Холбоос: <https://www.law.cornell.edu/uscode/text/28/503#:~:text=The%20President%20shall%20appoint%2C%20by,of%20the%20Department%20of%20Justice>, Сүүлд үзсэн огноо: 2022.09.30.

37 Federal Law No. 2202-I of January 17, 1992 on The Prosecutor’s Office of The Russian Federation (in the Wording of Federal Law No. 168-FZ of November 17, 1995).

Албани Улс	Ерөнхий прокурорыг Парламентын гишүүдийн тавны гурвын саналаар сонгодог бөгөөд тэд Албанийн Прокурорын дээд зөвлөлөөс санал болгосон гурван нэр дэвшигчийн дундаас сонгогдоно. Нэр дэвшигч нь өмнөх арван жилд төрийн захиргааны болон улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байсан байж болохгүй. Санал ирүүлснээс хойш 30 хоногийн дотор Парламент Ерөнхий прокурорыг сонгоогүй тохиолдолд Прокурорын дээд зөвлөлөөс нэгдүгээрт жагсаасан нэр дэвшигчийг томилно. ³⁸	Парламент
Армен Улс	Парламентын байнгын хорооны санал болгосноор Үндэсний ассамблей (парламент) Ерөнхий прокурорыг нийт депутатуудын тавны гурваас доошгүй саналаар сонгодог. ³⁹ Истанбулын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд АСН-аас баталсан Армени дахь мониторингийн дөрөв дэх удаагийн тайланд одоо байгаа загвар нь Прокурорын албыг болзошгүй улс төрийн дарамт, нөлөөллөөс хангалттай тусгаарлаж чадахгүй байгаа тул байнгын хорооноос Улсын ерөнхий прокурорт нэр дэвшигчийг тодруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн шинжээчдийг заавал оролцуулахыг зөвлөж байна.	Үндэсний ассамблей
Азербайжан Улс	Ерөнхий прокурорыг Ерөнхийлөгч Парламентын зөвшөөрлөөр томилдог.	Ерөнхийлөгч
Украин Улс	Ерөнхийлөгч түүнийг Парламентад нэр дэвшүүлж, улмаар Ерөнхийлөгч Ерөнхий прокурорыг томилдог.	Ерөнхийлөгч
Вьетнам Улс	Ерөнхийлөгчийн санал болгосноор парламентаас сонгодог.	Парламент
Босни-Герцеговина Улс	Прокурорын албаны удирдлагыг томилохдоо бусад прокурорыг ажилд авахтай адил тогтолцоог ашигладаг: Шүүх, Прокурорын Дээд Зөвлөлийн (НЈРС) шийдвэрээр томилдог. ⁴⁰	Шүүх, прокурорын дээд зөвлөл
Гүрж Улс	Гүржийн систем дөрвөн үе шаттайгаар хэрэгждэг. Хууль зүйн сайд эхлээд эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл, хуулийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөнө. Хэлэлцүүлгийн үндсэн дээр гурваас доошгүй нэр дэвшигчийг үндэслэл бүхий шийдвэртэйгээр Прокурорын зөвлөлд санал болгоно. Дараа нь Прокурорын зөвлөл гурван нэр дэвшигчийн нэрийн өмнөөс нууц санал хураалт явуулна. Нийт гишүүдийн 2/3-аас багагүй санал авсан нэр дэвшигчийг нэр дэвшүүлнэ. Хууль зүйн сайд Прокурорын зөвлөлийн нэрийн өмнөөс нэр дэвшигчийг Гүржийн Засгийн газарт танилцуулж зөвшөөрөл авна. Засгийн газраас зөвшөөрөл авсан нэр дэвшигчийг парламентад өргөн мэдүүлнэ. Парламентын гишүүдийн олонхын саналаар нууц санал хураалт явуулан томилно. ⁴¹	Парламент
Латви Улс	Прокурорын тухай хуулийн 38 дугаар зүйлд Ерөнхий прокурорыг Шүүхийн зөвлөлийн зөвшөөрлөөр Дээд шүүхийн Ерөнхий шүүгч санал болгодог гэж заасан байдаг. Ерөнхий прокурорыг парламентаас томилдог.	Парламент
Молдав Улс	Молдавын Ерөнхий прокурорыг Прокурорын дээд зөвлөл нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, Ерөнхийлөгч томилдог.	Ерөнхийлөгч

38 The procedure is further detailed in Articles 22-37 of the Law 97/2016 of Albania.

39 See Art. 177 of Armenia's Constitution, July 5, 1995.

40 See Art. 3 of the Law on the Prosecutor's Office of Bosnia and Herzegovina, 24/02, 3/03, 37/03, 42/03, 9/04, 35/04, 61/04.

41 The new Organic Law of Georgia on the Prosecutor's Office, enacted on 30 November 2018, establishes and appointment procedure in three phases without any participation of the Executive. Consultations and the selection of the candidate are now a competence of the sole Prosecutorial Council. The final approval is given by Parliament with the majority of its members, without a secret ballot.

Монтенегро Улс	Прокурорын албаны удирдлага (Улсын дээд прокурор) олон нийтийн санаачилгаар сонгогддог. Прокурорын зөвлөлөөс сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчид парламентын эрх бүхий ажлын хэсгийн хуралдаанд оролцдог. Улмаар Ерөнхий прокурорыг парламентаас томилдог. ⁴²	Парламент
Румын Улс	Хууль зүйн сайдын санал болгосноор Шүүхийн дээд зөвлөлийн прокурорын хэлтсийн зөвлөх саналын дагуу Ерөнхийлөгч томилдог. ⁴³	Ерөнхийлөгч
Серби Улс	Парламент Улсын прокурорын зөвлөлөөс ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалтыг үндэслэн засгийн газрын санал болгосноор сонгодог. Уг процедур нь сул орон тоог олон нийтэд зарлахаас эхэлдэг. ⁴⁴	Парламент
Словени Улс	Засгийн газрын саналыг урьдчилсан байдлаар авсны дараа Улсын Прокурорын зөвлөлийн үндэслэл бүхий саналын дагуу парламент томилдог. ⁴⁵	Парламент
Япон Улс	Засгийн газар томилж, Эзэн хаан баталдаг.	Эзэн хаан
Малайз Улс	Ерөнхий сайдын зөвлөснөөр Эрхэмсэг ноён Ян ди-Пертуан Агонг томилдог. Күүкийн арлуудын ерөнхий хуульч, албаны тэргүүнийг Ерөнхий прокурорын үүрэг гүйцэтгэдэг Ерөнхий сайдын санал болгосноор Хатан хааны төлөөлөгч томилдог.	Эзэн хаан

Гадаад улс, орнуудад Ерөнхий прокурор болон түүний орлогчийг Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газар, Шүүх, Прокурорын дээд зөвлөл, Эзэн хаан зэрэг субъектүүд томилж байна. Томилгоонд дараах процесс ажиглагдсан. Үүнд:

- Ерөнхий прокурор болон түүний орлогчийг өөр өөр субъект томилох;
- Засгийн газар, Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Парламентаас зөвшөөрөл авах, санал авах, танилцуулах;
- Нэр дэвшигчдийн зөвлөлөөс санал болгох;
 - Сонсгол хийх;
 - Прокурорын, Шүүхийн дээд зөвлөлөөс нэр дэвшигчдийн жагсаалт гаргах;
 - Байнгын хорооноос нэр дэвшигчдийг тодруулах;
 - Шинжээчдийг оролцуулах;
 - Бусад прокурорыг томилохтой адил байдлаар томилох;
 - Парламент нууц санал хураалт явуулах;
 - Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах гэх мэт.

Монгол Улсын хувьд Ерөнхий прокурорыг томилох процессыг шинэчлэх тохиолдолд дээр дурдсан процессын туршлагаудыг харгалзан өөрийн эрх зүйн тогтолцоо, туршлагад тохирсон процессыг сонгон авах нь зүйтэй юм.

ЭЗХАХБ-аас мөн хийсэн “Зүүн Европ, Төв Ази, Ази Номхон далайн улсуудын прокурорын хараат бус байдал” судалгаанд дараах зөвлөмжийг өгсөн нь дээрх агуулгатай нийцэж байна.

42 Мөн тэнд.

43 Art. 54 of the Law 303/2004 of Romania.

44 Art 74 of the Law on Public Prosecution, No. 116/08, 104/2009 and Art. 13 of the Law on State Prosecutorial Council of Serbia, No. 101/2010 and 88/2011.

45 Article 111 Par. 1 of the State Prosecutor's Office Act of Slovenia (SPOA), 2011.

- Ерөнхий прокурорыг улс төрийн институцээс тусгаарлах нь Прокурорын байгууллагын хараат бус байдлын чухал шинж чанар гэж үздэг. Байгууллагын удирдлагын томилгооны тогтолцоо нь энэхүү тусгаарлалтыг хангах гол элемент юм. Тогтоосон стандартын дагуу нэр дэвшигчдийн мэргэжлийн үр чадварыг хуулийн байгууллага, прокурор, иргэний нийгмийнхэн ч үнэлдэг байх ёстой.

- Прокурорын албаны удирдлагыг томилоход гүйцэтгэх эсвэл хууль тогтоох байгууллагын гүйцэтгэх үүрэг олон оронд нийтлэг байдаг. Тухайн улс ямар загвар сонгохоос үл хамааран прокурор, ялангуяа Ерөнхий прокурорыг томилох тогтолцоо нь улс төрийн зохисгүй нөлөөлөл, дарамт шахалт үзүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь нэгэн адил чухал юм. Ерөнхий прокурорыг эцсийн бөгөөд албан ёсоор томилох нь Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газрын мэдэлд байгаа ч нэр дэвшигчдийг хэрхэн сонгох нь чухал. Сонгон шалгаруулалт нь үр чадвар, түүнчлэн бодитой шалгууртай ил тод журмаар явагдах ёстой. Ингэснээр бүх үйл ажиллагаа нь олон нийтийн итгэлийг олж, шүүгчийн хүндэтгэлийг бүхэлд нь олж авдаг.

- Энэ зорилгодоо хүрэхийн тулд олон улсын зөөлөн эрх зүйн баримт бичгүүдийн (Soft law instrument) ихэнхэд зааснаар сонгон шалгаруулалтад мэргэжлийн, улс төрийн бус шинжээчдийг оролцуулахыг зөвлөдөг. Олон улс орон хуулийн мэргэжилтнүүдээс (шүүгч, прокурор, өмгөөлөгч гэх мэт) бүрдсэн Шүүх/Прокурорын зөвлөл, сонгон шалгаруулах хороодод ийм үүрэг оногддог. Улс төрийн байгууллагаас томилогдсон эдгээр хорооны гишүүд ч гэсэн ил тод байдлаар сонгогдсон, нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах бүх үйл явц ил тод, бодитой шалгуурт тулгуурласан байвал олон нийтийн итгэлийг хүлээнэ. Иргэний нийгмийн мэргэжилтнүүдийг татан оролцуулах нь нийт сонгон шалгаруулалтын үйл явцыг ил тод болгоход хувь нэмэр оруулах боломжтой.

- Ерөнхий прокурорыг парламентаас сонгодог бол эцсийн сонгох процесст мэргэшсэн олонхын саналыг ашиглах нь өргөн хүрээний зөвшилцлийг бий болгоно. Парламент шаардлагатай олонх болж чадаагүй тохиолдолд томилгоо хийх боломж олгох зохих заалтуудыг бий болгох шаардлагатай.

- Прокурорын байгууллагын удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх тодорхой, ил тод, найдвартай журмыг хуулиар тогтоох ёстой.

- Прокурорын байгууллагын удирдлагыг сонгоход хуулийн байгууллага (прокурорыг оролцуулан) болон шаардлагатай бол иргэний нийгмийн байгууллагууд оролцох ёстой.

- Сонгон шалгаруулалтын үйл явцад гол үүргийг прокурорын өөрийн удирдлагын байгууллагууд эсвэл бие даасан шинжээчийн сонгон шалгаруулах хороо (үр чадварт үндэслэн ил тод журмаар шалгаруулдаг мэргэжлийн хүмүүс) гүйцэтгэх ёстой.⁴⁶

В. Ерөнхий прокурор, түүний орлогчийг огцруулах үйл явц

Монгол Улсын хувьд Ерөнхий прокурор болон түүний орлогчийг огцруулах болон түдгэлзүүлэх асуудлыг Монгол Улсын Прокурорын тухай хуулиар зохицуулдаг. Монгол Улсын Ерөнхий прокурор болон түүний орлогчийг Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэдэг.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий прокурор болон түүний орлогчийг дараах тохиолдолд Ерөнхийлөгчийн шийдвэрээр огцруулах тухай тус хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д тусгажээ. Үүнд:

- Өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон, хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог албан тушаалд нэр дэвшсэн;
- Гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

⁴⁶ *The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific*, OECD, (2020), pp.39-45.

- Эрүүл мэндийн байдлын улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан.

Бусад улс, орнуудад мөн Ерөнхий прокурор болон түүний орлогчийг огцруулах үндэслэлийг Прокурорын тухай хууль болон бусад хууль, тогтоомжоор хуульчилсан байна.

Хүснэгт 1.7. Гадаад улсуудын зохицуулалт: Улсын Ерөнхий прокурорыг огцруулах үндэслэлийг тодорхойлсон байдал

Улс	Улсын Ерөнхий прокурорыг огцруулах үндэслэлүүд
Албани Улс	<p>Үндсэн хуулийн 149/с-д сахилгын болон эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд Үндсэн хуулийн шүүх Ерөнхий прокурорыг огцруулах үндэслэлийг заажээ.</p> <p>1.Улсын ерөнхий прокурор, Прокурорын дээд зөвлөлийн гишүүнд хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>2.Улсын ерөнхий прокурор, гишүүнийг дараах тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр огцруулна.</p> <p style="padding-left: 20px;">а. мэргэжлийн болон ёс зүйн ноцтой зөрчил гаргасан;</p> <p style="padding-left: 20px;">б. ял эдэлж байгаа</p> <p>3.Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр Ерөнхий прокурор, гишүүнийг дараах тохиолдолд бүрэн эрхээс нь түдгэлзүүлнэ.</p> <p style="padding-left: 20px;">а.түүний эсрэг гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө цагдан хорих, гэрээр баривчлах хувийн баталгаа гаргах; эсвэл</p> <p style="padding-left: 20px;">б. түүнийг санаатайгаар үйлдсэн хүнд гэмт хэрэгт буруутгаж байгаа.</p> <p style="padding-left: 20px;">в. хуульд заасны дагуу сахилгын хэрэг үүсгэснээр.⁴⁷</p>
Армени Улс	<p>Прокурорын албаны тухай хуулийн 63 дугаар зүйлд Ерөнхий прокурорын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шалгуурыг тодорхойлсон. Эдгээр үндэслэл нь эрүүгийн шийтгэл оногдуулсан, цагаатгаагүй үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн хэрэгсэхгүй болгосон, хууль тогтоомж, прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, прокурорын нэр хүндэд халдсантай холбоотой байна.⁴⁸</p> <p>Босни-Герцеговина, Эстони, Гүрж, Литва, Вьетнам зэрэг улсуудад мөн ийм үндэслэлээр ерөнхий прокурорыг огцруулдаг байна.</p>

47 Albania's Constitution of 1998 with Amendments through 2016, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Albania_2016.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

48 Law of The Republic of Armenia of December 1, 2017 No. ZR-198 About prosecutor's office, Холбоос: <https://cis-legislation.com/document.fwx?rgn=113216>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

<p>Бүгд Найрамдах Литва Улс</p>	<p>Прокурорын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т зааснаар тус улсын ерөнхий прокурорыг Бүгд Найрамдах Литва Улсын Ерөнхийлөгч огцруулдаг бөгөөд дараах дараах үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлдөг. Энэ нь:</p> <p>өөрийн хүсэлтээр;</p> <p>бүрэн эрхийн хугацаа дууссан;</p> <p>эрүүл мэндийн шалтгаанаар;</p> <p>65 нас хүрсэн буюу тэтгэвэрт гарах шалтгаанаар;</p> <p>өөр албан тушаалд сонгогдсон, эсхүл өөр албан тушаалд сайн дураараа шилжсэн тохиолдолд;</p> <p>үйлдлээрээ прокурорын нэрийг гутаасан бол;</p> <p>шүүхийн түүнд оноосон шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол.⁴⁹</p>
---	--

Дээрх улс, орнуудын хувьд ихэвчлэн өөрийн хүсэлтээр, эрүүгийн гэмт хэрэг хийсэн, мэргэжлийн болон ёс зүйн зөрчил үйлдсэн, эрүүл мэндийн шалтгаанаар гэх нийтлэг үндэслэлүүдээр Улсын Ерөнхий Прокурорыг огцруулдаг байна.

Монгол Улсын хувьд Прокурорын тухай хуулиар “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлийг тусгаж өгсөн нь бусад улсуудаас өөр бөгөөд өөрийн орны онцлог зохицуулалт болсон байна.

Тус зохицуулалт нь 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6.4 дэх заалт болон нэмэгдсэн юм.

Энэхүү зохицуулалт батлагдан гарахтай зэрэгцэн буюу 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр мөн тухайн үед хэрэгжиж байсан 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан” тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх цаашлаад шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэлд “Түүнчлэн энэ тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан бол заавал хэлэлцэнэ” гэх зохицуулалтыг оруулж ирсэн байна.

Тус нэмэлт, өөрчлөлт нь төслийн үзэл баримтлалд дурдагдсанаар “...Хууль хяналт, шүүхийн байгууллагын удирдах албан тушаалтнууд өөрийг нь санал болгосон, томилсон албан тушаалтандаа үйлчилдэг улс төрийн захиалгаар эрүүгийн хэрэг үүсгэдэг, улс төрчдөд үйлчилдэг бол уг байгууллагын гүйцэтгэх албан тушаалтнууд нь мэргэжлийн чадавхгүй, хууль дээдлэх биш “дээрээс ирсэн” зааврыг биелүүлдэг, илэрхий гэмт хэргийг шийдвэрлэхгүй удаашруулж, саармагжуулдаг үйл ажиллагааг биелүүлэгч болжээ. Шүүх прокуроруудын байгууллагын ажилтнуудын ёс зүйгүй байдал, гэмт хэргийг хаацайлдаг жишээ илэрч байна..., ...Иймд Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг хамгаалж ажиллаж чадахгүй байгаа шүүх, хууль хяналтын байгууллагын удирдлагын үйл ажиллагааг үндэсний язгуур ашиг сонирхолд нийцүүлж, үндэсний аюулгүй байдалд учирч байгаа ноцтой эрсдэлийг арилгах талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилсан болно.”⁵⁰ гэх үзэл баримтлалыг агуулсан байна.

49 Мөн тэнд.

50 Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Энэ талаар судлаач, хуульч, иргэд болон улс төрчдийн дунд маргаан, мэтгэлцээн өрнөсөн. Тодруулбал, “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлдэг, цаашлаад дуусгавар болгодог үйл явц нь шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бий болгосон.

Энэ талаар судлаач, хууль зүйн доктор А.Бямбажаргал дараах санааг илэрхийлсэн байна.

“...Хэдийгээр ганцхан заалт боловч түүнээс үүдэн бүхэл бүтэн шүүх эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлж буй 512 шүүгчийг хянан шийдвэрлэсэн хэрэгтэй нь холбоотойгоор, тэр дундаа ямар нэг хууль зүйн үндэслэлгүйгээр Үндэсний аюулгүй байдлыг зөвлөл шийдсэн гэдгээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлж болох нь өөрөө шүүгчийн бүрэн эрхийг баталгааг үгүйсгэж буй юм...”

...Шүүгчийг хэрэг, маргаан шийдвэрлэхэд шууд нөлөөлнө шүү дээ. Уг нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2-т “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэх шууд нэр зааж хязгаарласан заалт бий. Гэтэл шүүгчийн эрх зүйн байдлыг тухай хуулийн 17.1.8, 18.5 дах хэсэгт оруулсан нэмэлтээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан бол заавал хэлэлцэх, улмаар бүхэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх нөхцөл бүрдүүлэхээр заасан нь цаашид хэргийг хувь заяаг шүүх бус Ерөнхийлөгч, үндэсний аюулгүй байдлын зөвлөл нэрийг дор өөртөө төвлөрүүлсэн хэрэг л дээ...”⁵¹ гэж гол үүсэж болох сөрөг үр дааврыг тайлбарласан байна.

Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд энэхүү заалтыг хасаж “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлдэг, цаашлаад дуусгавар болгодог байдлыг зогсоосон.

Үүний адилаар “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлээр Улсын Ерөнхий Прокурор болон түүний орлогчийг огцруулдаг үндэслэл байсаар байгаа нь тухайн субъектийн хэрэг, маргаан шийдвэрлэх болон бусад үйл ажиллагаатай нь холбогдсон хараат бус байдал, прокурорын байгууллагын бие даасан байдлыг алдагдуулах боломжтой байна.

Энэ нь хууль тогтоох замаар Үндсэн хууль, түүнд тогтоосон хууль дээдлэх зарчмыг зөрчсөн бодит жишээ юм. Тухайлбал, Прокурорын тухай хуулийн 46.6.4-нэмэлтээр оруулсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарснаар Улсын ерөнхий прокурор, орлогчийн бүрэн эрхийг дуусгавар болгохоор заасан нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл чиг үүрэгтэй зөрчилдөөд зогсохгүй, цаашид хэрхэн хэрэгжүүлэх тухай огт тооцоогүй болох нь харагдана. Нэг үгээр бол шударга бусын хонгилыг илүү хялбарчлаад, нэмээд прокурор буюу хяналт тавих, мөрдөх буюу АТГ-тай хамтад нь өөрийн гарт оруулсан л асуудал буй юм...”⁵² гэжээ.

Тиймээс Прокурорын тухай хуулийн 46.6.4-т заасан дээрх зохицуулалт буюу Улсын Ерөнхий Прокурор болон түүний орлогчийг “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлээр огцруулах үндэслэлийг хасаж хуульчлах нь зүйтэй.

3.3. Прокурорын өөрөө удирдах байгууллага

Прокурорын тухай хууль болон бусад хууль, тогтоомжид зааснаар Монгол Улсын прокурорын өөрөө удирдах байгууллагын тогтолцоонд Монголын прокуроруудын холбоо, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, Прокурорын ёс зүйн зөвлөл, Прокурорын мэргэжлийн зөвлөл, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Монголын Хуульчдын

51 А.Бямбажаргал: “Шүүхийн тухай хуулийг батлах асуудал том сорилттой ямагт тулж байна”, 2021, Холбоос: <https://ikon.mn/n/237p>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

52 Мөн тэнд.

холбооны Прокурорын хороо гэх байгууллагууд байдаг. Эдгээр байгууллагуудын талаар товч авч үзье.

Хүснэгт 1.8. Прокурорын өөрөө удирдах байгууллагыг тодорхойлсон байдал

Прокурорын өөрөө удирдах байгууллага	Ерөнхий мэдээлэл
Монголын Прокуроруудын холбоо	<p>Монголын Прокуроруудын холбоо нь 1994 онд прокуроруудын санаачилгаар “Монголын Прокуроруудын Үндэсний Холбоо” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан, орон нутагт салбар зөвлөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Монголын Прокуроруудын Холбооны анхны дүрэм 2011 оны 8 сарын 26-ны өдөр батлагдаж байсан бол 2017, 2019 онд тус тус шинэчлэн баталсан.</p> <p>Монголын Прокуроруудын Холбоо нь прокурор, прокурорын байгууллагын ажилтан, албан хаагч, прокурорын байгууллагын үйл ажиллагааг дэмжих хүсэлтэй иргэдийг эгнээндээ нэгтгэсэн, гишүүдэд үйлчилдэг, прокурорын нэр хүнд, үйл ажиллагаа, эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий ашгийн төлөө бус, төрийн бус байгууллага юм.</p>
Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл	<p>Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хуульд заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор прокурорын байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдахтай холбогдсон үндсэн асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын Ерөнхий прокурорт зөвлөх чиг үүрэгтэй. Энэхүү зөвлөл нь Прокурорын тухай хуулийн 43.7-д заасан төрийн байгууллага юм.⁵³</p>
Прокурорын ёс зүйн зөвлөл	<p>Прокурорын ёс зүйн зөвлөл нь Прокурорын тухай хуулийн 65.1-д зааснаар орон тооны бус байгууллага юм.</p>
Прокурорын мэргэжлийн зөвлөл	<p>Прокурорын мэргэжлийн зөвлөл нь Прокурорын тухай хуулийн 64.1-д зааснаар орон тооны бус байгууллага юм.</p>
Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл	<p>Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар үйл ажиллагааг явуулдаг байна.</p>
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл	
Монголын Хуульчдын холбооны Прокурорын хороо	<p>Хуульчдын холбооны дүрмийн 9.10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар Прокурорын хороог 2013 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын холбооны анхдугаар хурлын 10 дугаар тогтоолоор батламжилсан. Прокурорын хороо нь Хуульчдын холбооны холбогдох хууль, дүрэмд заасан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Хуульчдын холбооны зүгээс явуулж буй прокурор-гишүүдэд чиглэсэн, тэдэнд хамааралтай үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий хуульд нэрлэн заасан, мэргэшлийн чиглэлээр байгуулагдсан, прокуроруудын заавал гишүүнчлэлтэй, сайн дурын хороо юм.⁵⁴</p>

Прокурорын өөрөө удирдах байгууллагууд нь прокурорын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл болдог. Улсын Прокурорын зөвлөл болон холбогдох бусад өөрөө удирдах байгууллагууд прокурорыг томилох, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг асуудлаар чухал эрх мэдлийн

53 Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, Холбоос: <https://prokuror.mn/prosecutor-s-council>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

54 Прокурорын хорооны танилцуулга, Холбоос: <https://www.mglbar.mn/committee/9?page=intro>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

хэрэгжүүлдэг. Үүнийг бий болгох нь Ерөнхий прокурорын эрх мэдлийг сулруулж, хэт эрх мэдэлтэй этгээд эрх мэдлээ урвуулан ашиглах эрсдэлийг бууруулахад чиглэнэ. Улс орнууд өөрсдийн үйл ажиллагааг явуулахад улс төрийн аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийхийн тулд бүрэлдэхүүн, гишүүдийнхээ томилгоог зохицуулах ёстой. Прокурорын үндэсний холбоод байгууллагын зохисгүй хөндлөнгийн оролцоог эсэргүүцэх чадавхыг бэхжүүлж чадна.⁵⁵ Тиймээс прокурорын өөрөө удирдах тогтолцоо буюу прокурорын өөрөө удирдах байгууллагыг судлах зайлшгүй шаардлагатай юм.

Венецийн комиссын тайланд прокурорын өөрөө удирдах байгууллагын талаар дараах санал, зөвлөмжийг өгсөн. Прокурорын зөвлөлийн бүрэлдэхүүнд бүх шатны прокурорууд байхаас гадна хуульч, хуульч эрдэмтэн зэрэг бусад оролцогч байх ёстой. Хэрэв ийм зөвлөлийн гишүүдийг УИХ-аас сонгосон бол олонхын саналаар сонгох нь зүйтэй. Прокурор, шүүхийн зөвлөл нь нэг байгууллага бол шүүгч, прокурорууд бие биеэ томилох, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангана. Үүний зэрэгцээ, ийм холбоод нь прокурорын эрхийг хамгаалах эсвэл өөр бусад асуудлаар санал бодлоо илэрхийлэх замаар чухал дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэдэг.⁵⁶

А. Прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа

Монголын Прокуроруудын холбоо, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, Прокурорын ёс зүйн зөвлөл, Прокурорын мэргэжлийн зөвлөл, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл болон Монголын Хуульчдын холбооны Прокурорын хорооны үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 1.9. Монгол Улсын зохицуулалт: Прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг тодорхойлсон байдал

Прокурорын өөрөө удирдах байгууллага	Үйл ажиллагаа
Монголын Прокуроруудын холбоо	<p>Холбоо нь зорилгоо биелүүлэхийн тулд дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Холбооны гишүүдийн саналыг үндэслэн Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, тогтолцоог өөрийн орны онцлог, олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоход анхаарч ажиллах; - Прокурор, гишүүдийн нэр төрд халдсан илт худал гүтгэлэг, мэдээ, мэдээллийг няцаах, холбогдох арга хэмжээ авах; - Гадаад орнуудын прокурорын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа, ажлын арга барил, эрх зүйн зохицуулалтыг судлах, мэдээлэх; - Олон Улсын Прокурорын холбооноос зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхтэй оролцож, үйл ажиллагааг нь дэмжих;

55 *The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific*, OECD, (2020), pp.28-29.

56 *Report on European Standards as regards the Independence of the Judicial System: Part II – The Prosecution Service*, Venice Commission, (2010), Холбоос: <https://rm.coe.int/1680700a60>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

	<ul style="list-style-type: none"> - Прокурор, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиж мөрдүүлэх, прокурорын нэр хүндийг өндөрт өргөж явахад үйл ажиллагаагаа чиглүүлэх; - Гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх аливаа ажил, сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах; - Гишүүдийг гадаадад болон дотоодод сургах, дадлагажуулах, туршлага судлахад дэмжлэг туслалцаа үзүүлэх; - Прокурор, ажилтнуудын ажиллах нөхцөл, хууль, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулах, хамгаалах талаар дүгнэлт гаргах, төр засгийн байгууллагуудад асуудал тавьж шийдвэрлүүлэх; - Ажил мэргэжлээрээ өндөр ур чадвар гаргаж, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт үзүүлсэн, мөн прокурор, ажилтныг сургах, дадлагажуулах, боловсон хүчин бэлтгэх талаар идэвх санаачилга гаргасан гишүүдийг дэмжих, урамшуулах; - Шаардлагатай гэж үзвэл Удирдах зөвлөлөөр хэлэлцэж гишүүддээ мөнгөн болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл	<p>Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Прокурорын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, бүтэц, орон тоо, хүний нөөцтэй холбоотой асуудал; - Прокурорын байгууллагын хөрөнгө санхүү, төсөв, жилийн ажлын тайлан, төлөвлөгөө, түүний биелэлт, төсөл, хөтөлбөр; - Хууль тогтоомжийн төсөлд өгөх санал, Улсын Ерөнхий прокурорт хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд батлах нийтээр дагаж мөрдөх болон прокурорын байгууллагад хэрэгжих хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийн төсөл; - Прокурорын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн байдал; - Улсын Ерөнхий прокурорын удирдамжаар хийгдсэн шалгалт, судалгааны дүн; - Шагнал урамшуулал, прокурор, ажилтнуудын нийгмийн асуудал; - Бусад⁵⁷
Прокурорын ёс зүйн зөвлөл	Прокурорын тухай хуулийн 65.1-д зааснаар прокурор ёс зүйн дүрэм зөрчсөнтэй холбоотой асуудлыг шалгах, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
Прокурорын мэргэжлийн зөвлөл	Прокурорын тухай хуулийн 64.1-д зааснаар прокурорын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгах, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар үйл ажиллагааг явуулдаг байна.
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл	
Монголын Хуульчдын холбооны Прокурорын хороо	Хуульчдын холбооны холбогдох хууль, дүрэмд заасан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Хуульчдын холбооны зүгээс явуулж буй прокурор-гишүүдэд чиглэсэн, тэдэнд хамааралтай үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

Дээрхээс дүгнэвэл, Монгол Улс дахь прокурорын өөрөө удирдах байгууллагууд нь ерөнхийдөө хүний нөөц, сургалт, судалгаа шинжилгээ, гадаад харилцаа болон

57 Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, Холбоос: <https://prokuror.mn/prosecutor-s-council>. Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

прокуроруудын эрх ашгийг хамгаалах, ёс зүй зөрчил, мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг шийдвэрлэх, ЭХХША-тай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон зохион байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байна.

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын өөрөө удирдах байгууллагууд нь дээрх үйл ажиллагааг нийтлэг байдлаар хэрэгжүүлдэг хэдий ч өөрийн улсын онцлогтой холбоотойгоор бас өөр чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг.

Хүснэгт 1.10. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг тодорхойлсон байдал

Улс	Прокурорын өөрөө удирдах байгууллагууд, түүний хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Бүгд Найрамдах Солонгос Улс	<p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Прокуроруудын холбоо (Korean Prosecutors Association) нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг:</p> <p>Сүлжээ - Дэлхийн өнцөг булан бүрд буй гишүүдтэй мэргэжлийн болон хувийн харилцааг хөгжүүлэх, дэмжих.</p> <p>Боловсрол - Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэ дэвшлийн талаар цаг үеийн мэдээллээр хангах. Хууль зүйн тасралтгүй боловсролын кредит олгох.</p> <p>Ментор - Хууль зүйн чиглэлээр суралцаж буй оюутнууд болон хуулийн сургуулийн төгсөгчдөөс бүрдсэн сайн дурын гишүүнчлэлээр дамжуулан дараагийн үеийн прокуроруудад зөвлөгөө өгөх.</p> <p>Нийгэмд үйлчлэх - Гэр бүлийн хүчирхийлэл, ахмад настнуудын хүчирхийлэл (биеийн болон санхүүгийн), санхүүгийн луйвар, сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлт гэх мэт олон нийтийн аюулгүй байдалтай холбогдох асуудлын талаар олон нийтийг мэдээ мэдээллээр хангах.</p>
Албани Улс	<p>Прокурорын дээд зөвлөлийг байгуулж, хороодтойгоо хамт тус улсын прокурорын өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлдэг. 2016 оны Хууль зүйн тогтолцооны удирдлагын байгууллагын тухай хуулийн 159 дүгээр зүйлд Прокурорын дээд зөвлөлийн чуулганы нэгдсэн хуралдааны бүрэн эрхийг тодорхойлсон бөгөөд үүнд прокурорыг томилох, дэвшүүлэх, түүнчлэн огцруулах сахилгын шийтгэл ногдуулах тухай заасан байдаг. Мөн хуулийн 160 дугаар зүйлд Прокурорын дээд зөвлөл нь Стратегийн төлөвлөлт, төсвийн хороо, Сахилгын хороо, Ёс зүй, мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний хороо, Ажил мэргэжлийн хөгжлийн хороо гэсэн дөрвөн байнгын хорооноос бүрдэнэ гэж заасан.</p>
Босни Герцеговина Улс	<p>Улсын Шүүх, Прокурорын Дээд Зөвлөлийн тухай хуулиар тус зөвлөлийн зохион байгуулалт, эрх мэдлийг тогтоодог. Тус зөвлөл нь шүүгч, прокурорыг томилох, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх, шүүгч, прокурорын бүрэн эрхийг түр түдгэлзүүлэх, бүрэн эрхийг нь дуусгавар болгох болон бусад асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй. Зөвлөл нь хуулийн этгээдийн бие даасан байгууллага юм.</p>
Бүгд Найрамдах Эстони Улс	<p>Прокурорын өөрөө удирдах ёсны байгууллага нь Прокурорын чуулган, Прокурорын өрсөлдөөний хороо, Сахилгын хороо юм. Прокурорыг сонгон шалгаруулах, сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий хоёр хорооны гишүүдийг Прокурорын чуулганаас томилдог. Прокурорын чуулган бол жилд нэгээс доошгүй удаа хуралддаг бүх прокурорын хурал юм. Чуулганаар Прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаарх Хууль зүйн сайд, Улсын ерөнхий прокурорын тайланг сонсож, прокурорын байгууллагын холбогдох асуудлыг хэлэлцдэг. Ерөнхий прокурор Прокурорын хурлыг хуралдуулж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлдэг.⁵⁸</p>

58 Article 13 of Estonia's Prosecutor's Office Act, 1998.

Гүрж Улс	Прокуроруудын бага хурал, Прокурорын зөвлөл, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулсан. Бага хурал нь Прокурорын байгууллагын нийт прокурор, мөрдөн байцаагч нараас бүрдсэн бөгөөд тэдний үндсэн үүрэг нь Прокурорын зөвлөлийн найман гишүүнийг сонгох явдал юм. Прокурорын зөвлөлийн бүрэн эрхийг Прокурорын албаны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан бөгөөд Улсын ерөнхий прокурорт сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах тухай заасан байдаг. Прокурорын зөвлөл нь Хууль зүйн сайдын зарласнаар, эсхүл нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн хүсэлтээр хуралддаг бөгөөд мөрдөн байцаах, прокурорын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох эрхгүй. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар 2016 онд байгуулагдсан Зөвлөлдөх зөвлөл нь прокурорын урамшуулал, албан тушаал ахих, сахилгын хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд Улсын Ерөнхий прокурорт туслалцаа үзүүлэх үүрэгтэй байв. ⁵⁹
Молдав Улс	Молдавын бүх прокурорууд Ерөнхий хурлаар үе үе хуралдаж, Ерөнхий прокурорын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, Ёс зүйн дүрмийг баталж, прокурорын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг авч үздэг. Прокурорын дээд зөвлөл нь прокурорыг сонгон шалгаруулах, Ерөнхий прокурорт нэр дэвшигчийг шалгаруулах сонгон шалгаруулалт зохион байгуулах, хүний нөөцийн бүхий л чухал асуудлаар Ерөнхий прокурорт санал оруулах (томилгоо, бүрэн эрхийг дуусгавар болгох, томилголт, албан тушаал ахих), прокурорын орон тоог тогтоох болон бусад үүргийг гүйцэтгэдэг байна. ⁶⁰
Монтенегро Улс	Прокуроруудын өөрөө удирдах байгууллага нь Улсын прокуроруудын бага хурал, прокурорын ёс зүйн хороо, прокурорын зөвлөл юм. Прокурорын бага хурлаар Прокурорын зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг прокуроруудыг сонгож, прокурорын ёс зүйн дүрмийг баталдаг. Прокурорууд уг дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэх талаар ямар ч хүн Прокурорын Ёс зүйн хороонд хандаж санал бодлоо илэрхийлж болно. Тус хороо нь жил бүр Прокурорын зөвлөлд ажлаа тайлагнадаг. Прокурорын бага хурлаас хорооны даргыг сонгодог. Прокурорын зөвлөлийн чиг үүргийг Прокурорын байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан байдаг. Зөвлөл нь прокурорын тоог тогтоох, Ерөнхий прокурорыг (Улсын дээд прокурорыг) албан тушаалаас нь огцруулах санал гаргах, сахилгын хариуцлагын асуудлыг шийдвэрлэх, тэдний хараат бус байдалд заналхийлсэн асуудлаар прокуророос ирүүлсэн гомдлыг шалгах зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг. ⁶¹
Румын Улс	Дээд шүүхийн зөвлөл нь Румын улсын шүүх болон прокурорын албаны бие даасан байдлын баталгаа юм. Шүүгч, прокурор гэсэн хоёр тусдаа хэсэгтэй. Прокурорын ажил мэргэжлийн талаарх шийдвэрийг прокурорын хэлтэс гаргадаг. ⁶²
Серби Улс	Прокурорын зөвлөл болон Сахилгын комисс нь прокурорын өөрөө удирдах байгууллага юм. Прокурорын зөвлөл нь прокурорын албан тушаалд нэр дэвшигчдийг Парламентад санал болгож, албан тушаал ахих асуудлыг шийдэж, прокурорын байгууллагын даргад нэр дэвшүүлэх жагсаалтыг Засгийн газарт хүргүүлдэг. Жил бүр төсвийн хүсэлт гаргах, түүний гүйцэтгэлд хяналт тавих нь Зөвлөлийн бүрэн эрх юм. Прокурорын зөвлөл Сахилгын комиссын гишүүдийг томилж, түүний шийдвэрийг эсэргүүцсэн гомдлыг шийдвэрлэдэг. ⁶³
Словени Улс	Прокурорын зөвлөлийн эрх мэдлийг Улсын Прокурорын тухай хуулийн 102 дугаар зүйлд заасан. Зөвлөл бусад үүрэг даалгаврын дотор шинэ ерөнхий заавар батлах журмыг санаачлах, улсын яллагчийг томилох саналд санал дүгнэлт өгөх, тэднийг дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэх, Улсын ерөнхий прокурорыг томилох тухай санал оруулах, шилжүүлэх, томилох, сахилгын байгууламжийг томилж, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэдэг.

59 The new Organic Law of Georgia on the Prosecutor's Office, enacted on 30 November 2018, has replaced the Consultative Council with consultative bodies (the Career management, Ethics and Incentives Council and the Strategic Development and Criminal Policy Council). According to the new legislation, the Prosecutorial Council meets every six months, with no need to be convened by the Minister of Justice.

60 *The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific*, OECD, (2020), p.32.

61 *The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific*, OECD, (2020), p.32.

62 Art. 1 para. (1) of Law on the on the Superior Council of Magistracy of Romania, no. 317/2004.

63 Art. 165 of the Constitution of Serbia, 2006.

Украин Улс	Прокуроруудын бага хурал, Прокурорын зөвлөл, Мэргэшсэн болон сахилгын комисс юм. Украины бүх прокуроруудыг төлөөлдөг Прокуроруудын бага хурал нь өөрөө удирдах дээд байгууллага боловч байнгын ажиллагаатай байдаггүй. Прокурорын өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийн биелэлт, прокурорын байгууллагын санхүүжилт, зохион байгуулалтын талаар прокурорын зөвлөлийн тайланг сонсдог. Бага хурлаас Мэргэшлийн болон сахилгын комисс болон Зөвлөлийн зарим гишүүд, прокуроруудыг томилдог. Прокурорын ёс зүйн дүрэм, үйл ажиллагааг баталдаг. Прокурорын зөвлөл нь Бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, хуралдуулах ажлыг зохион байгуулдаг. Зөвлөл нь бусад эрх мэдлийн хүрээнд прокурорыг томилох, чөлөөлөх тухай зөвлөмж гаргах, тэдний хараат бус байдалд заналхийлсэн талаарх прокурорын дүгнэлтийг шалгаж, холбогдох арга хэмжээг авах, прокурорын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах хүсэлт гаргах, удирдах албан тушаал эрхэлж байгаа прокурорын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг эрх мэдлийн хүрээнд тус зөвлөл үйл ажиллагаа явуулдаг ба прокурорын мэргэшил, сахилгын хороо нь прокурорын албан тушаалд нэр дэвшигчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлж, прокурорын сахилгын хариуцлага хүлээлгэх, огцруулах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэдэг хамтын байгууллага юм.
Камбож Улс	Дээд Зөвлөл нь Хууль зүйн сайдын хүсэлтээр прокуроруудыг томилох, шилжүүлэх, огцруулах, түдгэлзүүлэх, огцруулах тухай хүсэлтийг Эрхэмсэг Хаанд хүргүүлдэг. Дээд зөвлөлөөс прокуроруудыг дэвшүүлэх талаар зөвлөгөө өгдөг. ⁶⁴
Япон Улс	Шалгалтын хороо нь гурван жил тутамд бүх прокуроруудын үнэлгээг тогтмол хийдэг өөрөө удирдах ёсны байгууллага бөгөөд Хууль зүйн сайдын хүсэлтээр прокуроруудыг шалгадаг. Хороо мөн өөрийн санаачилгаар шалгалтыг эхлүүлж болно. Шалгалтын хороо биеийн/сэтгэцийн хомсдол, ажил үүргээ гүйцэтгэх явцад гарсан үр ашиггүй байдал болон прокурорыг албан үүргээ гүйцэтгэх чадваргүй болгох бусад шалтгааныг үнэлдэг. Хороо нь Хууль зүйн сайдад ажлаа тайлагнадаг. ⁶⁵
Зүүн Тимор Улс	Ерөнхий прокурорын газар болон Улсын яллах зөвлөл нь Прокурорын албаны дотоод эрх мэдэл бүхий байгууллага юм. Прокурорыг шилжүүлэх, огцруулах асуудлыг Улсын яллах зөвлөл шийдвэрлэдэг.
Азербайжан Улс	Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг нь Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч баталдаг. Ерөнхий прокурор энэ зөвлөлийг тэргүүлдэг бөгөөд эрхэлж буй албан тушаалын дагуу түүний орлогч болон бусад ахлах прокуроруудаас бүрддэг. Удирдах зөвлөл нь Прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг хандлага, гэмт хэрэгтэй тэмцэх нөхцөл, гүйцэтгэх сахилга бат, боловсон хүчний менежментийн талаар хэлэлцдэг. Мөн тушаал, актуудыг боловсруулдаг. Удирдах зөвлөлийн шийдвэрийг олонхын саналаар батална. Санал зөрж байгаа тохиолдолд Ерөнхий прокурор ганцаарчилсан үндэслэлтэй шийдвэр гаргадаг. Удирдах зөвлөлийн шийдвэр нь прокурорын байгууллагын бүх ажилтнуудад заавал байх ёстой бөгөөд Ерөнхий прокурорын тушаалын үндэслэл болно.
Латви Улс	Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, гэрчилгээжүүлэх комисс, мэргэшлийн комисс нь Ерөнхий прокурорын газрын нэг хэсэг юм. Тэдний бүрэн эрх, чадамжийг Прокурорын байгууллагын тухай хуульд заасан байдаг. Латви улсын Ерөнхий прокурорын зөвлөлийг Ерөнхий прокурор томилдог бөгөөд Прокурорын газрын хэлтсийн дарга нар, Прокурорын газрын захиргааны дарга болон бусад улсын прокурорууд, прокурорын газрын дотоод байгууллагуудын дарга нараас бүрддэг. ⁶⁶ Латви улсад коллежийн зөвлөл мөн байдаг. Дарга нь Ерөнхий прокурор бөгөөд гишүүдэд Ерөнхий прокурорын орлогч, бүс нутгийн прокурорын газрын ахлах прокурорууд багтдаг. Улсын Ерөнхий прокурор бусад прокуроруудыг Коллежийн зөвлөлийн гишүүнд оруулах шийдвэр гаргаж болно. Коллежийн зөвлөл нь прокурорын байгууллагын ажил, зохион байгуулалттай холбоотой хамгийн чухал асуудлаар Ерөнхий прокурорт зөвлөгөө өгдөг зөвлөх байгууллага юм. Тэргүүлэх чиглэл, стратеги төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн байгууллагуудын төсвийг мөн зөвлөл боловсруулдаг. Коллежийн зөвлөлийн олон гишүүнийг албан тушаалын дагуу томилдог бол бусад гишүүдийг Ерөнхий прокурор сонгодог.

64 Art. 18 of the Law on the Organization and Functioning of the Supreme Council of Magistracy of Cambodia, 2014.

65 Public Prosecutor's Qualifications Examination Committee.

66 Section 29 of Latvia's Prosecution Office Law, 1994.

Польш Улс	Прокурорын бие даасан удирдлагын тогтолцоо нь үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулагдсан байгууллагуудаас бүрддэг. Прокурорын үндэсний зөвлөл нь янз бүрийн зэрэглэлийн прокуроруудаас бүрддэг бөгөөд Улсын ерөнхий прокурорын дэргэд байгуулагддаг. Үндэсний зөвлөл нь зөвлөх чиг үүрэгтэй бөгөөд прокурорын хараат бус байдлыг хамгаалах ерөнхий үүрэгтэй. Мөн прокурорын ёс зүйн дүрмийг баталж, хэрэглэхэд хяналт тавьдаг. Зөвлөлөөс гадна төв болон орон нутгийн түвшинд прокурорын ерөнхий чуулган, нутаг дэвсгэрийн зөвлөлийг байгуулдаг. Эдгээр байгууллагууд нь прокурорын үйл ажиллагаанд санал дүгнэлт гаргах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, өөрөө удирдах ёсны тогтолцооны хүрээнд прокурорын төлөөлөгчдийг сонгох, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сахилгын шүүхийн гишүүдийг сонгох зэрэг чиг үүрэгтэй.
-----------	--

Гадаад улс, орнуудад прокурорын өөрөө удирдах байгууллага нь прокурорын зөвлөл, прокурорын чуулган, прокурорын хороо, сахилгын хороо, ёс зүйн хороо, прокуроруудын бага хурал, шалгалтын хороо, мэргэшлийн комисс гэх мэт хэлбэрээр байгуулагддаг байна.

Эдгээр байгууллага дотроос прокурорын зөвлөл нь нийтлэг ач холбогдолтой үйл ажиллагааг гүйцэтгэдэг байгууллага юм. Тухайлбал, прокурорын зөвлөлүүд нь прокурорыг томилох, огцруулах, дэвшүүлэх, сахилгын шийдвэр ногдуулах, урамшуулал олгох, тэдгээртэй холбоотой санал гаргах, прокурорын орон тоог тогтоох, Ерөнхий прокурорыг огцруулах санал гаргах, прокурорын хараат бус байдалд сөргөөр нөлөөлсөн гомдлыг шийдвэрлэх, Ерөнхий прокурорт зөвлөгөө өгөх гэх мэт чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнээс прокурорыг томилох, огцруулах, дэвшүүлэх, сахилгын шийдвэр оногдуулах, урамшуулал олгох, тэдгээртэй холбоотой санал гаргах, прокурорын орон тоог тогтоох чиг үүргийн зохицуулалт улс орон бүрд харьцангуй нийтлэг байна. Зарим улсад тус чиг үүргийг прокурорын өөрөө удирдах байгууллагын өөр хэлбэр бүхий байгууллагууд гүйцэтгэх ч тохиолдол байна.

Монгол Улсын прокурорын өөрөө удирдах байгууллагын хувьд гадаад орнуудын дээр дурдсан зарим дэвшилтэт зохион байгуулалт болон үйл ажиллагааг өөрийн эрх зүйн зохицуулалтад нутагшуулах нь зүйтэй юм.

Б. Прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүн, томилгооны үйл явц

Монголын Прокуроруудын холбоо, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, Прокурорын ёс зүйн зөвлөл, Прокурорын мэргэжлийн зөвлөл, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Монголын Хуульчдын холбооны Прокурорын хорооны бүрэлдэхүүн, томилгооны үйл явцыг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 1.11. Монгол Улсад прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүн, томилгоог тодорхойлсон байдал

Прокурорын өөрөө удирдах байгууллага	Бүрэлдэхүүн, томилгооны үйл явц
Монголын прокуроруудын холбоо	Холбооны эрх барих дээд байгууллага нь гишүүдийн төлөөллөөс бүрдсэн Бага хурал байх бөгөөд Бага хурлын чөлөөт цагт Удирдах зөвлөл нь өдөр тутмын үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлдэг. Удирдах зөвлөл нь Холбооны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл	Улсын Ерөнхий прокурорын 2019 оны А/35 дугаар тушаалаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсон. Улсын Ерөнхий прокурорын хоёр орлогч, Хэрэг эрхлэх газрын дарга, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор буюу хэлтсийн дарга нар, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор нь зөвлөлийн гишүүд байна.
Прокурорын ёс зүйн зөвлөл	Бүрэлдэхүүнийг Улсын Ерөнхий прокурор баталдаг байна.
Прокурорын мэргэжлийн зөвлөл	Бүрэлдэхүүнийг Улсын Ерөнхий прокурор баталдаг байна.
Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл	Улсын Ерөнхий прокурорын газрын бүтцэд анх удаа Эрүүдэн шүүхээс урьдчилсан сэргийлэх зөвлөл ажиллуулахаар Улсын Ерөнхий прокурорын 2019 А/28 дугаартай тушаалаар баталж, Зөвлөлийг байгуулснаар дарга, 8 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. ⁶⁷
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл	Зөвлөл нь Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Улсын Ерөнхий Прокурорын туслах прокурор болон дадлага туршлага, мэргэжлийн ур чадвар бүхий прокуроруудаас бүрдсэн 10 гишүүнтэй байна. Зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Ерөнхий прокурор томилдог. ⁶⁸
Монголын Хуульчдын холбооны Прокурорын хороо	Прокурорын хорооны хувьд Хуульчдын холбооны дүрмийн 9.10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар Прокурорын хороог 2013 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын холбооны анхдугаар хурлын 10 дугаар тогтоолоор батламжилсан. Прокурорын хороонд 506 хуульч гишүүнчлэлтэй байна. ⁶⁹

Дээрхээс дүгнэвэл, прокурорын өөрөө удирдах байгууллагуудаас Монголын Прокуроруудын холбоо, Монголын Хуульчдын холбооны Прокурорын хорооны гишүүдээс бусад байгууллагын гишүүдийг Улсын Ерөнхий прокурор томилдог байна. Өөрөөр хэлбэл, прокурорын өөрөө удирдах байгууллага нь Улсын Ерөнхий прокурор гэх нэг субьектээс хэт хамааралтай байна.

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын өөрөө удирдах байгууллагын гишүүдийн бүрэлдэхүүнийг болон томилох процессыг дараах байдлаар тогтоож байна.

67 УЕПГ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Холбоос: <https://prokuror.mn/prevention-of-torture>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

68 УЕПГ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Холбоос: <https://prokuror.mn/crime-prevention-council>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

69 Прокурорын хорооны танилцуулга, Холбоос: <https://www.mglbar.mn/committee/9?page=intro>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

Хүснэгт 1.12. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын өөрөө удирдах байгууллагын томилгоо, бүрэлдэхүүнийг тодорхойлсон байдал

Улс	Прокурорын өөрөө удирдах байгууллагын томилгоо, бүрэлдэхүүн
Албани Улс	Үндсэн хуулийн 149 дүгээр зүйлд Прокурорын дээд зөвлөл нь 11 гишүүнээс бүрдэх ба зургаан гишүүнийг бүх шатны прокурор, таван гишүүнийг парламентаас прокурорын бус хуульчдаас сонгохоор заасан. Прокурорын байгууллагын бүх шатны төлөөллийг шударгаар хангасан журмын дагуу прокуроруудыг сонгодог. Прокурорын бус гишүүдийг хууль зүйн болон багшлах чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, ёс суртахуун, мэргэжлийн өндөр боловсролтой, нэр хүндтэй хуульчдаас сонгодог. Иргэний нийгмээс нэг гишүүнийг томилдог. Бүх гишүүд томилогдохоос өмнөх арван жилийн хугацаанд төрийн захиргааны байгууллагад улс төрийн ажил, улс төрийн намын удирдах албан тушаал хашсан байхыг хориглоно. Нэр дэвшигчдийг сонгох бусад шалгуур, журмыг хуулиар зохицуулдаг. Прокурорын дээд зөвлөлийн даргыг хуулийн дагуу тус зөвлөлийн анхдугаар хурлаар прокурорын бус гишүүдээс сонгодог. Прокурорын дээд зөвлөлийн гишүүд дахин сонгогдох эрхгүйгээр таван жилийн хугацаанд орон тооны албан тушаалыг хэрэгжүүлдэг. Бүрэн эрхийнхээ хугацаа дууссаны дараа прокурорын гишүүд өмнөх албан тушаалдаа, томилогдохоосоо өмнө төрийн албанд бүтэн цагаар ажиллаж байсан прокурорын бус гишүүд өмнөх албан тушаалдаа буцаж ирдэг.
Босни Герцеговина Улс	Шүүх, Прокурорын Дээд Зөвлөлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд түүний 15 гишүүн тус бүрийг өөр эрх бүхий байгууллагаас томилно гэж заасан байдаг. Эдгээрийг бүс нутгийн шүүх, Холбооны Дээд шүүх, орон нутгийн шүүх, бүс нутгийн болон холбооны прокурорын газар, орон нутгийн прокурорын газар, парламент, засгийн газраас сонгодог. Тиймээс тус зөвлөлийг таван прокурор, зургаан шүүгч, хоёр өмгөөлөгч, хоёр гишүүний бүрэлдэхүүнтэйгээр УИХ, Засгийн газар бүрдүүлдэг.
Бүгд Найрамдах Эстони Улс	Прокурорын Ассамблей нь Эстонийн бүх прокуроруудын хурал бөгөөд Прокуроруудын Өрсөлдөөний хороо болон Сахилгын хорооны гишүүдийг томилдог. Өрсөлдөөний хорооны долоон гишүүн нь Ерөнхий прокурор, улсын прокурор, хоёр дүүргийн прокурор, нэг шүүгч, Тарту их сургуулийн профессор, Хууль зүйн яамны төлөөлөгч юм. Сахилгын хороо нь улсын хоёр прокурор, дүүргийн хоёр прокурор, нэг шүүгч бүрддэг.
Гүрж Улс	Прокурорын албаны бүх прокурор, мөрдөн байцаагчдын нэгдсэн хурал юм. Прокурорын зөвлөл нь Хууль зүйн сайд, даргаар нь Хууль зүйн сайд, нийт прокурорын Бага хурлаас сонгогддог прокурорын олонх, УИХ-ын олонх, парламентын цөөнхөөс нэг УИХ-ын гишүүн, Хууль зүйн дээд зөвлөлөөс сонгогддог хоёр шүүгч, Дээд боловсролын байгууллага, иргэний нийгмийн байгууллагаас санал болгосон нэр дэвшигчид, парламентаас томилогдсон хоёр гишүүнээс бүрддэг.
Молдав Улс	Прокурорын дээд зөвлөл нь 12 гишүүнээс бүрддэг. Ерөнхий прокурор, Хууль зүйн сайд, Гагаузын өөртөө засах орны прокурор, Дээд шүүхийн дарга нарыг албан тушаалын дагуу томилдог. Таван прокурорыг Прокуроруудын нэгдсэн хурлаас иргэний нийгмийн гурван төлөөлөгчийг Ерөнхийлөгч, УИХ, Шинжлэх ухааны академи нээлттэй сонгон шалгаруулалтаар томилдог.
Монтенегро Улс	Прокуроруудын бага хуралд Прокурорын газрын бүх дарга, прокурорууд багтдаг. Прокурорын зөвлөлийг Бага хурлаас томилогдсон таван прокурор, парламентаас томилогдсон, чөлөөлөгдсөн дөрвөн нэр бүхий хуульч, Хууль зүйн сайдын нэг төлөөлөгч бүрдүүлдэг. Зөвлөлийг Ерөнхий прокурор тэргүүлдэг. Прокурорын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монтенегрогийн Ерөнхийлөгч зарладаг. Прокурорын Ёс зүйн хороо нь ерөнхийлөгч, хоёр гишүүнтэй. Ерөнхийлөгчийг прокурорын бус прокурорын зөвлөлийн гишүүдээс, нэг гишүүнийг Улсын дээд прокурорын газрын өргөтгөсөн хурлаар улсын яллагчдаас, нөгөө гишүүнийг Улсын прокурорын холбооны ерөнхийлөгчөөр сонгоно.
Румын Улс	Магистрын дээд зөвлөл нь 19 гишүүнтэй: Зөвлөлийн хоёр хэсгийг шүүгч, прокурорын ерөнхий чуулганаар сонгогдсон есөн шүүгч, таван прокурор, Сенатаас сонгогдсон хуулийн чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн хоёр төлөөлөгч, Давж заалдах шатны болон Шүүхийн дээд шүүхийн дарга, Хууль зүйн сайд, Улсын ерөнхий прокуророос бүрддэг.

Серби Улс	Прокурорын зөвлөлийг прокурорын байгууллагын ерөнхий сонгуулиар сонгогдсон зургаан прокурор, бүх хуулийн сургуулийн нэгдсэн чуулганаар сонгогдсон хуулийн сургуулийн нэг профессор, Өмгөөлөгчдийн холбооноос томилогдсон нэг өмгөөлөгч, Ерөнхий прокурор, Хууль зүйн сайд, УИХ-ын Хууль тогтоох хорооны дарга бүрдүүлдэг. Сербийн Улсын Прокурорын зөвлөлийн ажилд улс төрийн албан тушаалтнуудыг татан оролцуулж байгааг иргэний нийгмийн зарим төлөөлөгчид тус байгууллага нь прокуроруудыг улс төрийн дарамт шахалтаас хамгаалахгүй байна гэж шүүмжилсэн байдаг. ⁷⁰
Словени Улс	Прокурорын зөвлөл нь улсын прокуророос сонгогддог дөрвөн гишүүн, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор хууль зүйн мэргэжилтнүүдийн дундаас парламентаас сонгогддог дөрвөн гишүүн, дүүргийн дарга нарын дундаас Хууль зүйн сайд томилдог нэг гишүүнээс бүрдэнэ.
Украин Улс	Прокурорын зөвлөл нь Хууль зүйн дээд сургуулиудын хурлаас сонгогдсон хоёр хуульч эрдэмтэн, Ерөнхий прокурорын газар, бүс нутгийн болон орон нутгийн байгууллагуудын 11 прокуророос бүрддэг. Прокурорын мэргэшил, сахилгын комиссын гишүүн, удирдах албан тушаал эрхэлж буй прокурорууд Прокурорын зөвлөлийн гишүүн байж болохгүй. Прокурорын мэргэшлийн болон сахилгын комисс нь Украйны Прокуроруудын бага хурлаас томилогдсон таван прокурор, Хууль зүйн дээд сургуулиудын хурлаас сонгогдсон хоёр хуульч эрдэмтэн, Украины Өмгөөлөгчдийн хурлаас томилогдсон нэг өмгөөлөгч, Украйны өмгөөлөгчдийн хурлаас томилогдсон нэг өмгөөлөгч, УИХ-ын Хууль сахиулах асуудлын хорооны зөвшөөрлөөр иргэдийн төлөөлөгч гурван гишүүнээс бүрддэг.
Камбож Улс	Дээд шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоосон. Хууль зүйн сайд, Улсын дээд шүүхийн дарга, Улсын дээд шүүхийн дэргэдэх Улсын ерөнхий прокурор де юре гишүүн юм. 8 гишүүнийг хууль зүйн туршлагатай мэргэжилтэн, дээд шатны шүүхийн шүүгч, ахлах прокурор, шүүгч, анхан шатны шүүхийн харьяа прокуророос томилдог. Сенат, УИХ, Үндсэн хуулийн зөвлөл, Хууль зүйн сайд, анхан шатны шүүхийн шүүгч, дээд шатны шүүхийн шүүгч, ахлах прокурор, анхан шатны шүүхийн дэргэдэх прокурорууд тус бүр нэг гишүүнийг сонгодог. Магистрын дээд зөвлөлийн бүх гишүүдийг эцэст нь Эрхэмсэг хаан томилдог.

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүнийг шүүгч, өмгөөлөгч, прокурорын төлөөлөл, парламентын гишүүн, хууль зүйн сайд, хууль зүйн сургуулийн багш, нэр хүндтэй хуульч, иргэний нийгмийн төлөөлөл байх зэргээр янз бүрээр тодорхойлдог байна. Эдгээр бүрэлдэхүүнийг томилохдоо парламент, шүүх, засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг субъектүүд сонгон шалгаруулалт, томилгоо зэрэг олон төрлийн процессоор сонгодог байна.

Монгол Улсын хувьд ихэнх тохиолдолд прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүнийг Улсын ерөнхий прокурор томилж байгаа бөгөөд гадаад улсуудын хэрэгжүүлж буй тал бүрийн оролцоог хангасан сайн туршлага болох прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүнийг шүүгч, өмгөөлөгч, прокурорын төлөөлөл, парламентын гишүүн, хууль зүйн сайд, хууль зүйн сургуулийн багш, нэр хүндтэй хуульч, иргэний нийгмийн төлөөллийг хамруулж томилдог, сонгон шалгаруулалт явуулдаг байх зэрэг аргыг нэвтрүүлэх нь зүйтэй юм.

3.4. Прокурорын туслах ажилтан

Прокурорын тухай хуулийн 55 дугаар зүйлд зааснаар прокурорын байгууллагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах ажилтан ажиллана. Энэхүү туслах ажилтан нь тус хуулийн 45 дугаар зүйлд зааснаар прокурорын

⁷⁰ The study “When the Law Doesn’t Rule”, by the Open Society European Policy Institute, Transparency Serbia, and the Centre of Investigative Journalism of Serbia, pp.19, 27.

туслах ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан бөгөөд бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд прокуророор томилогдох боломж бүрдэнэ. Өмнөх 2002 оны Прокурорын байгууллагын тухай хуульд ч мөн ийнхүү тодорхойлж байжээ. Монгол Улсад одоогийн байдлаар 197 прокурорын туслах ажилтан ажиллаж байна.⁷¹

Тус бүлгийн хүрээнд прокурорын туслах ажилтны чиг үүрэг, тавигдах шаардлага, томилох явц, цалингийн талаар судлах бөгөөд харьцуулсан судалгаанд үндэслэн хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх юм.

2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн дагуу шүүгчийн туслахад тавигдах шаардлага болон томилогдох процесс зэргийг өөрчлөн зохицуулсантай холбогдуулан прокурорын туслах ажилтантай холбоотой эрх зүйн зохицуулалтад шинэчлэл хийх эсэхийг судлах шаардлага үүсэж байна.

Тус хуулийн үзэл баримтлалд "...Шүүхийн хүний нөөцийн хүрэлцээгүй байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацаа хэтрэх, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийг чирэгдүүлэх, улмаар шүүхийн шүүн таслах ажиллагааны чанарт нөлөөлөх нөхцөл байдалд хүргэж байна. Иймд шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргаан, ачааллыг өсөлттэй нь уялдуулан шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын цалингийн санг нэмэгдүүлэх, орон тоог үе шаттайгаар нэмэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Шүүхийн хүний нөөцийн тогтвортой, мэргэшсэн байх нөхцөлийг хангахын тулд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээд шүүгчийн туслахаар ажилласан жилийг мэргэжлээрээ ажилласанд тооцох.." гэж тусгажээ.

Үүний дагуу 2021 оны Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт зааснаар "...шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна..." гэж тавигдах шаардлагыг нэмэгдүүлсэн байна. Түүнчлэн, Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 89.1-д зааснаас гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэл судлаач туслахтай байх бөгөөд судлаач туслах нь хууль зүйн магистраас дээш зэрэгтэй, харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай байхаар зохицуулжээ.

Мөн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалинг хоёр дахин нэмэгдүүлэх тухай УИХ-ын 2021 оны 03 дугаар тогтоолын 1.2-т заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газар хуралдаанаараа авч хэлэлцсэн. Тус УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэн тогтоохоор шийдвэрлэсэн. Үүнд, төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6, ТЗ-5 зэрэглэлд хамаарах албан тушаалын цалинг 2 дахин, төрийн захиргааны албан тушаалын АА-9, АА-10 зэрэглэлд хамаарах албан тушаалын цалинг 1,7 дахин нэмэгдүүлэхээр тус тус тогтоожээ.⁷²

Шүүгчийн туслах болон прокурорын туслах ажилтны гүйцэтгэх чиг үүрэг нь төстэй бөгөөд процесс ажиллагааны хэвийн байдлыг хангахад чиглэгдсэн байдаг.

71 Улсын Ерөнхий прокурорын тайлан мэдээ, 2023.04.12-ны өдрийн байдлаар.

72 "Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын цалинг шинэчлэн тогтоолоо 2022.05.11", Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэвлэл мэдээллийн хэлтэс, Холбоос: https://www.judcouncil.mn/site/news_full/12122. Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

Мөн ачааллын хувьд ч хүний нөөц болон хэрэг, маргааны хуваарилалтаас хамааран ихээхэн ачаалалтай ажилладаг төрийн албан хаагчид юм. Иймд Шүүхийн тухай хуулийн дагуу шүүгчийн туслахын эрх зүйн байдлын зохицуулалтыг шинэчилсэнтэй адил прокурорын туслах ажилтны эрх зүйн байдлыг судалж сайжруулах хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тодруулах нь зүйтэй.

А. Прокурорын туслах ажилтны чиг үүрэг

Прокурорын туслах ажилтан нь прокурорын чиг үүрэг гүйцэтгэх туслах ажилтан болон захиргааны чиг үүрэг гүйцэтгэх туслах ажилтан гэсэн 2 чиглэлээр ажилладаг.

Прокурорын захиргааны чиг үүрэг гүйцэтгэх туслах ажилтан нь “Мэдээлэл лавлагааны цэг”-ийг хариуцаж, иргэд, олон нийтэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр дараах чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- Иргэдийн амаар буюу бичгээр гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хяналтын карт хөтлөн дээд шатны прокурорт танилцуулж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэх;
- Иргэдээс шуудан болон мэдээллийн бусад хэрэгслээр ирсэн өргөдөл, гомдол, мэдээллийг бичиг хэргийн эрхлэгчээс хүлээн авч зохих журмын дагуу бүртгэлд оруулж, шийдвэрлүүлэх;
- Бүртгэлийг үндэслэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаанд байнга хяналт тавьж, хугацааны талаар Улсын ерөнхий прокурорын газар, хэлтсийн дарга нарт, бусад прокурорын газарт тухайн байгууллагын удирдлагад тухай бүр танилцуулж, шийдвэрлүүлэх;
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлыг архивын нэгж болгуулан хүлээн авч, архивд шилжүүлэх;
- Тогтоосон журам, үүргийн дагуу “Прокурорын байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх заавар”-т заасан хугацаанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн гаргаж танилцуулах;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар өргөдөл, гомдол гаргагч болон бусад сонирхогч этгээдэд холбогдох мэдээллийг тухай бүр гарган өгч, шаардлагатай бол тухайн өргөдөл, гомдлыг шалгаж шийдвэрлэсэн прокурор, албан тушаалтантай биечлэн уулзуулах арга хэмжээ авах;
- Иргэд, олон нийтэд эрх зүйн бусад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шаардлагатай зөвлөгөө өгөх, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын заалтыг тайлбарлан ойлгуулах, иргэдээс хүсэлт тавьсан тохиолдолд нууцад хамааралгүй хууль, эрх зүйн бусад баримт бичгийг хүсэлт гаргагчийн зардлаар хуулбарлах буюу хэвлэж өгөх зэрэг болно.⁷³

Прокурорын чиг үүрэг гүйцэтгэх туслах ажилтан нь прокурорын хяналт тавих ажилд суралцаж, прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй. Үүнд дараах ажил, үүрэг хамаарна:

- Прокурорын хяналтын болон дотоод ажлын чиглэлээр прокурорын байгууллагад мөрдөгдөж буй удирдамжийн баримт бичгүүдийг бүрэн судалж танилцах;

73 Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, *Прокурорын хяналт*, (УБ, 2009), 92 дахь тал.

- Прокурорын хяналтын ажлын чиглэл тус бүрээр прокуророос гарах эрх зүйн баримт бичгүүдийн төслийг боловсруулах;
- Хэргийн газрын үзлэг, нэгжлэг, туршилт хийх, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах зэрэг зарим байцаан шийтгэх ажиллагаанд прокурорын хамт оролцож, ажлын дадлага туршлага эзэмших;
- Эрүүгийн хавтаст хэрэг уншин түүвэр хийх, яллах дүгнэлт бичих, прокурорын байгууллагад ирж буй өргөдөл, гомдлыг шалгаж шийдвэрлэх ажиллагаанд оролцох зэргээр хяналтын ажилд суралцах;
- Эрх зүйн онолын мэдлэг, хууль хэрэглэх, бичиг баримт боловсруулах ур чадвараа байнга дээшлүүлж, прокуророос өгсөн удирдамж, даалгаврыг чанд сахин биелүүлэх;
- Прокурорын хяналтын ажлын бүртгэлийн программыг бүрэн эзэмшиж, прокурорын хяналтуудын чиглэлээр уг программыг ашиглан бүртгэл хийхэд туслах, бүртгэлийн программ, компьютерын дотоод сүлжээг ашиглахтай холбогдсон сургалт зохион байгуулах;
- Прокурорын хяналтын ажлын мэдээ, тайлан, судалгааны тоо баримтыг компьютерт архивын нэгж болгон хадгалах.⁷⁴

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын туслах ажилтан нь ихэвчлэн “туслах прокурор”, “прокурорын туслах” гэсэн албан тушаалын нэршилтэй байдаг ба дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Хүснэгт 1.13. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтны гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлсон байдал

Улс	Прокурорын туслах ажилтны гүйцэтгэх чиг үүрэг
Бүгд найрамдах Солонгос Улс	<p>БНСУ-ын 2017 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар прокурорын мөрдөн шалгах албаны IV, V зэрэглэлийн ажилтан, VI зэрэглэлийн ажилтан, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг мөрдөх VI, VII, VII, VIII, VIII зэргийн ажилтан нь прокурорын үйл ажиллагаанд дараах байдлаар туслалцаа үзүүлж ажиллана:</p> <ul style="list-style-type: none"> - Прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах; - Эрүүгийн хэргийг бүртгэх, хадгалах; - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар томилогдсон прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туслалцаа үзүүлэх, тэдгээрт холбогдох тэмдэглэл хөтлөх, бусад баримт бичгийг бүрдүүлэх, хадгалах; - Прокурорын байгууллагын захиргааны бусад асуудал;⁷⁵
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	<p>ХБНГУ-ын туслах прокурор нь дараах чиг үүргийг гүйцэтгэдэг.</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын зарим хэсгийг нийтэд танилцуулах; - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч болон зохион байгуулагчтай ойр ажиллах; <p>Үндсэн болон давж заалдах шатны шүүх хуралдаанд урьдчилсан ажиллагаа дуустал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх, дагалдан явах;</p>

74 Мөн тэнд, 93 дахь тал.

75 Prosecutors' office act of Korea republic, Mar. 14, 2017, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42630&lang=ENG. Сүүлд үзсэн огноо:2023.05.01.

	- Нотлох баримт бүрдүүлэх, албадлагын арга хэмжээ авах эрх зүйн баримт бичгийг бие даан бичих; ⁷⁶
Бүгд Найрамдах Эстони Улс	Туслах прокурор нь Улсын ерөнхий прокурор, улсын тэргүүлэгч прокурор, тэргүүлэгч прокурор, улсын прокурор, ахлах прокурор, мэргэжлийн прокурор, дүүргийн прокурорын хяналт дор ажиллана. Туслах прокурор нь ердийн журмаар шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны явцад прокурорт оногдуулсан үүргийг дээд шатны прокуророос тодорхой зөвшөөрөл олгосон хэмжээгээр гүйцэтгэж болно. ⁷⁷
Япон Улс	Прокурорын удирдлага дор прокурорын туслах ажилтнууд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, хувийн баталгаа авах, баривчлах, торгуулийг цуглуулах гэх мэт үйл ажиллагааг явуулж байна. Прокурорын туслах ажилтан нь дараах үүргийг гүйцэтгэдэг. - Сэжигтнээс мэдүүлэг авах; - Шүүхийн захирамжаар баривчлах; - Зарим тохиолдолд шүүхийн захирамжгүй баривчлах; - Хураан авах, нэгжлэг хийх, магадлах, үзлэг хийх зөвшөөрөл хүсэх, эсхүл гүйцэтгэх; - Гуравдагч этгээдээс мэдүүлэг авах, шинжилгээ хийлгэх; - Сэжигтнийг цагдан хорих, сэтгэцийн болон бие бялдрын байдлыг шалгах, шинжээчийг гэрчээр асуух хүсэлт гаргах; - Прокурорын зөвшөөрлөөр цогцост үзлэг хийх; ⁷⁸
Америкийн Нэгдсэн Улс	Америкийн Нэгдсэн Улсын хувьд муж бүрээр өөрөөр зохицуулдаг. Тухайлбал, Пенсильвани мужийн Филадельп хотын захиргаанаас тодорхойлсноор туслах прокурорыг шүүх, мөрдөгч, прокуроруудад туслалцаа үзүүлэх хязгаарлагдмал цар хүрээтэй техникийн ажил эрхэлдэг хүнийг ойлгохоор тусгажээ. Нийтлэг байдлаар дараах чиг үүргийг гүйцэтгэдэг байна. - Хууль зүйн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх; - Шүүн таслах ажиллагаа, шүүх хуралдааны тов, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны байдал, холбогдох аливаа асуудлын талаар мэдээлэл өгөх; - Хэргийн материал, албан ёсны баримт бичиг, компьютержуулсан бүртгэлийг хянан үзэх; - Хэргийн бүртгэл хөтлөх; - Гэрчүүдтэй шүүх хуралдааны товлогдсон өдөр ирэх боломжтой эсэх, хууль ёсны журам, шүүх хуралдааныг үргэлжлүүлэх шалтгаан, хэргийн баримтын талаар ярилцах; - Прокурорын газрын томилогдсон хэлтсийн төрөл бүрийн тайлан, статистик мэдээллийг хөтлөх; - Хууль бус барааг хураан авсантай холбоотой мэдээ, тэмдэглэл, танилцуулгыг бэлтгэх; - Шаардлагатай бусад ажил; ⁷⁹

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын туслах ажилтан (туслах прокурор) нь прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эрүүгийн хэргийг танилцуулах, сэжигтнээс мэдүүлэг авах, баривчлах, нэгжлэг хийх, шинжилгээ

76 Assistenz-Staatsanwältin/Staatsanwalt des Bundes (WiKri Zürich), Холбоос: <https://jobs.admin.ch/offene-stellen/Assistenz-Staatsanw-Itin-Staatsanwalt-des-Bundes-WiKri-Z-rich-ffbdc28e-d9bc-4088-8c04-bb645e8f5d95>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

77 Prosecutor's Office Act of Estonia, 1998, Холбоос: [https://www.riigiteataja.ee/en/eli/510072018002/consolide#:~:text=\(1\)%20The%20prosecutors%20of%20a,imposed%20on%20them%20by%20law,](https://www.riigiteataja.ee/en/eli/510072018002/consolide#:~:text=(1)%20The%20prosecutors%20of%20a,imposed%20on%20them%20by%20law,) Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

78 Duties of Public Prosecutors' Assistant Officers, Холбоос: https://www.moj.go.jp/EN/keiji1/keiji_keiji05.html, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

79 2M88 Pay Range: Ep10 Prosecution Assistant 1, Холбоос: <https://www.phila.gov/departments/office-of-human-resources/job-specs/2m88.htm>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

хийлгэх, хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх гэх мэт чиг үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь тухайн мөрдөн шалгах ажиллагааны үйл ажиллагааг сайжруулах эерэг үр дагавартай бөгөөд нөгөө талдаа прокурорын туслах ажилтныг дадлагажуулахад сайнаар нөлөөлдөг. Эдгээрээс нийтлэг чиг үүргийг тодорхойлбол, прокурорын туслах ажилтан (туслах прокурор) нь эрүүгийн хэргийн бүртгэл хөтлөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл өгөх, тэмдэглэл хөтлөх, баримт бичиг боловсруулах болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцлийг бүрдүүлэх захиргааны ажлыг гүйцэтгэдэг болох нь ажиглагдлаа. Монгол Улсын хувьд дээрхтэй адил, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд хамаарах чиг үүргийг прокурорын туслах ажилтан гүйцэтгэдэг хэдий ч мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын процесст төдийлэн оролцдоггүй бөгөөд суралцах, дадлагажих чиг үүргийг илүүтэй гүйцэтгэдэг байна. Энэ нь тухайн прокурорын туслахыг прокурор болохтой холбоотой Иймд мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын процесст оролцуулах талаар авч үзэх нь зүйтэй юм.

Б. Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага

Прокурорын тухай хуулийн 55 дугаар зүйлд зааснаар прокурорын байгууллагын ажилтанд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, ажиллах журмыг Улсын ерөнхий прокурор баталдаг. Үүний дагуу Улсын ерөнхий прокурорын 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалын хавсралтаар “Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт явуулах журам” батлагдсан бөгөөд Тус журамд зааснаар прокурорын туслах ажилтнаар ажиллахаар хүсэлт гаргасан иргэнд дараах шаардлагыг тавьдаг байсан. Үүнд:

- Хууль, эрх зүйн чиглэлээр их, дээд сургууль төгсөж бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Компьютерын хэрэглээний программыг ашиглах чадвартай байх;
- Төрийн албаны тухай хуулийн хүрээнд эрх бүхий байгууллагаас тогтоосон төрийн захиргааны албан тушаалд тавих шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хангасан байх;
- Төрийн албан хэрэг хөтлөлтийг явуулах чадвартай байх;
- Гэмт хэрэг үйлдэж, шүүхээр гэм буруутайд тооцогдож байгаагүй байх;
- Зөрчлийн хэрэгт удаа дараа шийтгүүлээгүй байх;
- Төрийн албаны шалгалтад тэнцсэн байх;
- Цэргийн алба хаасан байх шаардлага тавьж байсан бөгөөд 2022 онд Улсын ерөнхий прокурорын А/19 дугаар тушаалаар “Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам”-ыг батлагдснаар дээрх журам хүчингүй болсон билээ.

Шинэчлэн баталсан журмаар прокурорын туслахад дараах шаардлагыг тавих болсон. Үүнд:

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй;

- Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх;
- Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилал хооронд шилжихээр хүсэлт гаргасан байх;
- Иргэний хувьд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй байх гэсэн шаардлагыг тавьжээ.

Харин гадаад улс, орнуудын хувьд прокурорын туслах ажилтанд тавигддаг шаардлага нь өөр өөр байна.

Хүснэгт 1.14. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлсон байдал

Улс	Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага
Бүгд Найрамдах Солонгос Улс	БНСУ-д прокурорын туслах ажилтнууд төрийн албан хаагчийн 7-р зэрэглэлд хамаардаг. ⁸⁰ Тиймээс 7-р зэрэглэлд тавигдах шаардлага хамаарагдана.
Бүгд Найрамдах Герман Улс	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хууль, эрүүгийн процессын эрх зүйн мэдлэгтэй, эрх зүйн чиглэлээр их дээд сургууль төгссөн; - Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй, бусад нэмэлт мэргэжилтэй байх; - Прокурорын байгууллага, шүүх, хуулийн болон холбогдох чиглэлээр мэргэжлээрээ ажилласан туршлагатай; - Хүнд хэцүү нөхцөлд ч үр дүнд чиглэсэн ажлын арга барилтай байх, асуудлыг шийдвэрлэх чадвартай байх; - Дор хаяж хоёр дахь албан ёсны хэл, англи хэлний мэдлэгтэй байх, албан ёсны гуравдагч хэлтэй бол давуу тал болно;⁸¹
Бүгд Найрамдах Эстони Улс	<ul style="list-style-type: none"> - 21-ээс доошгүй настай Бүгд найрамдах Эстони Улсын эрх зүйн чадамжтай иргэн байх; - Хууль зүйн их сургуулийн магистр зэрэгтэй эсвэл түүнтэй адилтгах мэргэжилтэй байх; - Эстони хэлийг C1 түвшинд мэддэг байх; - Ёс суртахууны өндөр төлөвшилтэй, наад захын ур чадвар, хувийн зан араншинтай байх; - Мэргэжлийн шийдвэрийг хүнд хэцүү нөхцөлд гаргах чадвартай;⁸² - Прокурорын уралдааныг зохион байгуулах, уралдаанд оролцогчид болон томилогдох прокурорт тавигдах шаардлагын тухай хуульд заасан бусад шаардлага;⁸³

80 공무원 직급표, Холбоос: https://m.blog.naver.com/sampoet/221734685493?fbclid=IwAR04k_2um6hoQNdHe6uV_pJD56dU9RftuP6MHiCRRkSPd8OaonsKPWnQHPGE, Сүүлд үзсэн огноо:2023.05.01.

81 Assistenz-Staatsanwältin/Staatsanwalt des Bundes (WiKri Zürich), Холбоос: <https://jobs.admin.ch/offene-stellen/Assistenz-Staatsanw-Itin-Staatsanwalt-des-Bundes-WiKri-Z-rich-/ffbdc28e-d9bc-4088-8c04-bb645e8f5d95>, Сүүлд үзсэн огноо:2023.05.01.

82 Abiprokurör Prokuratuur, Холбоос: <https://cv.ee/et/vacancy/526481/prokuratuur/services>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

83 Prokuröride konkursi korraldamise ning konkursil osalejatele ja ametisse nimetatavatele prokuröridele esitatavad nõuded [RT I, 07.10.2014, 1 - jõust. 10.10.2014], Холбоос: <https://www.riigiteataja.ee/akt/101042015005>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

Япон Улс	Прокурорын туслах ажилтан болохын тулд Үндэсний төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн байх; ⁸⁴
Америкийн Нэгдсэн Улс	Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон мужийн Сиэтл хотын прокурорын туслах ажилтны хувьд Вашингтон мужийн хуульчдын холбооны нэр хүндтэй гишүүн байх эсвэл ажилд орохыг санал болгосноос хойш 30 хоногийн дотор гишүүнчлэл авах чадвартай байхыг шаарддаг. Түүнчлэн, дараах ур чадваруудыг шаарддаг байна. - Нотлох баримт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар бүрэн мэдлэгтэй байх; - Хуулийн судалгаа хийх чадвартай байх; - Прокурорын хэргийг танилцуулах арга техникийг багтаасан мэтгэлцэх ур чадвартай байх; - Олон төрлийн хууль эрх зүйн асуудлыг хурдан шийдвэрлэх чадвартай байх; - Асуудлын шийдлийг бүтээлч байдлаар боловсруулах; - Бусад шаардлага; ⁸⁵

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын туслах ажилтан (туслах прокурор)-д тавигдах шаардлагыг төрийн албаны шалгалтад тэнцэж төрийн албан хаагч болсон байх, хууль зүйн их сургууль төгссөн байх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байх, тухайн ажлыг хийхэд шаардагдах ур чадвар, ёс зүйтэй байх, туршлагатай байх гэх мэтээр олон янзаар тодорхойлжээ.

Монгол Улсын хувьд “Цэргийн алба хаасан байх” шаардлага нь бусад улсынхаас ялгаатай байна. Прокурорын туслахын албан тушаал нь Улсын ерөнхий прокурорын газрын ажлын албанд хамаарагддаг бөгөөд төрийн тусгай албан хаагчийн ангилалд хамаардаггүй. Иймд “Цэргийн алба хаасан байх” шаардлагыг эргэн харах нь зохистой байж болох юм. Түүнчлэн прокурорын туслах ажилтны ур чадварыг дээшлүүлэхийн тулд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй болон хууль зүйн магистр зэрэгтэй байх зэрэг шаардлагыг бий болгохыг үгүйсгэхгүй.

В. Прокурорын туслах ажилтныг томилох процесс

Улсын ерөнхий прокурорын 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт явуулах журам”-д прокурорын туслах ажилтныг томилох үйл явцыг тодорхойлсон. Прокурорын туслахыг дараах үе шаттайгаар томилдог байна.

84 検察事務官になるための資格について教えてください, Холбоос: <https://www.kensatsu.go.jp/qa/qa1.htm>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

85 Assistant City Prosecutor- job post: City of Seattle, Холбоос: https://www.indeed.com/jobs?q=Prosecutor+Assistant&aceid=&gclid=CjwKCAjwo7iiBhAEIwAsIxQEeuThD-DMxGAWoVhCctHj-HjdCzVw4DfywUu1pPNVDO-ygaXc0lmsxoC_bgQAvD_BwE&gclsrc=aw.ds&from=mobRdr&utm_source=%2Fm%2F&utm_medium=redir&utm_campaign=dt&vjk=936747f7ecde0fc3a, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

Хүснэгт 1.15. Монгол Улсын зохицуулалт: Прокурорын туслах ажилтныг томилох процессыг тодорхойлсон байдал

Прокурорын туслахыг томилох үйл явц	Үйл ажиллагаа
Прокурорын туслах ажилтны сонгон шалгаруулалт	<ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг сонгон шалгаруулалт эхлэх өдрөөс гучаас доошгүй хоногийн өмнө байгууллагын цахим хуудас /www.prokuror.mn/ болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана. - Сонгон шалгаруулалтыг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар томилсон ажлын хэсэг зохион байгуулна. - Ажлын хэсэг нь дарга, гишүүд гэсэн 5 хүнээс бүрдэх бөгөөд ажлын хэсгийн ахлагч нь Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга байна. - Тамгын газар нь сонгон шалгаруулалтад оролцох иргэнээс бүрдүүлж өгсөн материалыг нягтлан үзэж, бүрдлийг хангуулан, бүртгэл дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан ажлын хэсэгт хүлээлгэн өгөх бөгөөд материалын хамт тухайн иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэхийг тодруулах зорилгоор цагдаагийн байгууллагаас авсан тодорхойлолтыг хүлээлгэн өгнө. - Сонгон шалгаруулалтын хүрээнд авах шалгалт нь дараах хэлбэртэй: эрх зүйн ерөнхий мэдлэгийн сорилгын шалгалт; найруулан бичиг /Цаашид “Эссэ” гэх/-ийн шалгалт; ярилцлагын шалгалт; компьютерын хэрэглээний программыг ашиглах чадварын шалгалт. - Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцогчдыг эрх зүйн ерөнхий мэдлэгийн сорилгын шалгалтаас бусад 3 шалгалтад авсан онооны дүнгээр эрэмбэлнэ.
Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчийг хүний нөөцөд бүртгэх, сул ажлын байранд томилох	<ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтыг зохион явуулсан ажлын хэсэг нь шалгаруулалт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан дүнг Улсын Ерөнхий прокурорт танилцуулна. - Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг тухайн сонгон шалгаруулалт явагдсан албан тушаалд хамааралтай прокурорын байгууллагын хүний нөөцийн бүртгэлд авах талаар Улсын Ерөнхий прокурор тушаал гаргах бөгөөд хүний нөөцөд авсан хүмүүсийг Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвд батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтад хамруулна. - Прокурорын байгууллагын хүний нөөцөд авсан иргэдийг прокурорын туслах ажилтны сул ажлын байранд томилуулах асуудлыг Тамгын газар судалж, шийдвэрлүүлнэ. - Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн 2 жилийн хугацаанд хүний нөөцөд бүртгэлтэй байх ба дээрх хугацаа дууссан, нөөцөөс хасагдсан тохиолдолд тухайн иргэн дахин сонгон шалгаруулалтад оролцоно. - Шалгаруулалтад тэнцсэн оролцогч өөрөө хүсвэл прокурорын туслах ажилтны бус, бусад сул ажлын байранд томилуулах асуудлыг шийдвэрлүүлж болно.

Гадаад улс, орнуудын хувьд прокурорын туслах ажилтныг томилох хэлбэр олон янз бөгөөд зарим улсын жишээг авч үзье.

Хүснэгт 1.16. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтныг томилох үйл явцыг тодорхойлсон байдал

Улс	Прокурорын туслах ажилтныг томилох үйл явц
Бүгд Найрамдах Солонгос Улс	<p>Төрийн албан хаагчийн 7 дугаар зэргийн нээлттэй сонгон шалгаруулалтад орсон байна.</p> <p>Тус сонгон шалгаруулалтууд нь дараах журмаар явагддаг:</p> <p>1. Бичгийн болон ярилцлагын шалгалтад тэнцсэн байх ёстой;</p>

	<p>2. 20 ба түүнээс дээш настай байна;</p> <p>3. Бичгийн шалгалт: PSAT (Хэлний логик, өгөгдөл тайлбарлах, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх), англи хэл (Англи хэлний түвшин тогтоох шалгалт), Солонгосын түүх (Солонгосын түүхийн түвшин тогтоох шалгалт);⁸⁶</p> <p>4. Ярилцлагын шалгалт: Бүлгийн хэлэлцүүлэг, ганцаарчилсан илтгэл, ганцаарчилсан ярилцлага;⁸⁷</p>
Бүгд Найрамдах Герман Улс	<p>1. Хууль зүйн чиглэлээр Хууль зүйн сургуульд мэргэжил эзэмших;</p> <p>2. Хуульчийн анхдугаар шалгалтад тэнцэх: Хуульч мэргэжлээр суралцаж төгссөний дараа хуульчийн анхны шалгалтыг өгөх ёстой бөгөөд энэ нь хуулийн мэдлэгийг шалгах бичгийн шалгалт байна;</p> <p>3. Хуульчаар дадлагажих: Хуульчийн анхны шалгалтад тэнцсэний дараа хуулийн чиглэлээр 2 жил ажиллаж дадлагажих;</p> <p>4. Хуульчийн хоёр дахь шалгалтад тэнцэх: Бичгийн болон аман шалгалтыг багтаасан улсын хоёр дахь шалгалтыг өгөх ёстой;</p> <p>5. Прокурорын туслахаар ажилд орох хүсэлт гаргах: Хуульчийн хоёр дахь шалгалтад тэнцсэн бол прокурорын байгууллагад ажилд орох боломжтой.</p> <p>6. Сонгон шалгаруулалтад тэнцэх: Сонгон шалгаруулалтад ихэвчлэн ярилцлага, таны ур чадвар, туршлагыг үнэлдэг.⁸⁸</p>
Бүгд Найрамдах Эстони Улс	<p>Прокурорын туслах ажилтныг шалгалт авч нээлттэй сонгон шалгаруулдаг бөгөөд Прокурорын өрсөлдөөний хороо нь сонгон шалгаруулалтад оролцогчид болон томилогдох прокурорт тавигдах шаардлагын тухай хуульд заасныг хэрэгжүүлж зохион байгуулдаг.</p> <p>1. Сонгон шалгаруулалтын зард зарласан комиссын хурлаар шалгалтын аргачлал, шалгалтын үр дүнг үнэлэх үндэслэлийг тогтоож, хүлээгдэж буй үнэлгээний тойргийн тоог тогтоож, баримт бичгийн шатыг явуулна;</p> <p>2. Комиссын нарийн бичгийн дарга хоёр дахь шатны шалгаруулалт болохоос дор хаяж хоёр долоо хоногийн өмнө хоёр дахь шатны шалгаруулалтыг зарлах хугацаа, газар, аргачлалын талаар нэр дэвшигчид бичгээр мэдэгдэнэ.</p> <p>3. Комиссын нарийн бичгийн дарга гурав дахь шатны үнэлгээнд хамрагдсан нэр дэвшигчид шийдвэр гаргаснаас хойших ажлын өдөр, дараагийн шатны шалгаруулалтад урьсан яг цаг, газар, нэр дэвшигчийг үнэлэх аргачлалыг мэдэгдэнэ.</p> <p>4. Нэр дэвшигчийг тухайн чиглэлээр болон бусад нэмэлт, заасан шаардлагын үндсэн дээр шалгаж, үнэлнэ.</p> <p>5. Үнэлгээний бүх шатны үр дүн эерэг гарсан тохиолдолд шалгалтад тэнцэнэ.</p> <p>6. Уралдаанаар нөхөх ажлын байрны тооноос олон нэр дэвшигч эерэг дүнтэй шалгалтад тэнцсэн бол шалгалтын дүнг үндэслэн нэр дэвшигчдийн зэрэглэлийг тогтоож, түүний үндсэн дээр удирдах албан тушаалд томилох саналыг гаргадаг.⁸⁹</p>

86 Үүнээс гадна тусгай шалгалт болох Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн, нийтийн удирдлагын, эдийн засгийн гэх мэт шалгалтыг өгдөг.

87 7급 공개경쟁채용시험, Холбоос: https://www.mpm.go.kr/mpm/info/fair/recruit/recruit01/recruit01_03/recruit01_03_01/, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

88 German Federal Ministry of Justice and Consumer Protection website, Холбоос: https://www.bmjv.de/EN/Jobs_Careers/HowToBecomeAPublicProsecutor/HowToBecomeAPublicProsecutor_node.html, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

89 Prokuröride konkursi korraldamise ning konkursil osalejatele ja ametisse nimetatavatele prokuröridele esitatavad nõuded [RT I, 07.10.2014, 1 - jõust. 10.10.2014], Холбоос: <https://www.riigiteataja.ee/akt/101042015005>, Сүүлд үзсэн: 2023.05.01.

Япон Улс	<p>Шалгалтад үндэслэсэн сонгон шалгаруулалтаар томилдог бөгөөд дараах үе шатыг дамждаг байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндэсний төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн бөгөөд прокурорын байгууллагад ажилд орсон байх ёстой; 2. Жилд 5 удаа авдаг бичгийн шалгалтыг авдаг; 3. Их сургуулийн төгсөлтийн шалгалтын захиргааны шалгалт эсвэл ахлах сургуулийн бичиг хэргийн шалгалтын үндсэн дээр тухайн ажилд томилогддог.
Америкийн Нэгдсэн Улс	<p>Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон мужийн Сиэтл хотын прокурорын туслах ажилтны хувьд хотын онлайн өргөдөл, анкет , тухайн албан тушаалыг сонирхож байгаа болон дээр дурдсан шаардлагыг хэрхэн хангаж байгааг тодорхойлсон захидлыг хүргүүлдэг.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сар бүр өргөдөл гаргагчдын үр чадварыг шалгадаг. Бүх өргөдөл гаргагчид ажлын зар дээр заасан хаалтын өдөр эсвэл түүнээс өмнө өргөдөл гаргах шаардлагатай. 2. Үндсэн шалгалтын хувьд бүх албан тушаал нь аюулгүй байдлын мэдрэмжтэй байхыг шаарддаг. Өргөдөл гаргагчид эрүүгийн процессын мөрдөн шалгах ажиллагааны шалгалтад хамрагддаг. Мөн өргөдөл гаргагчдад суурь мэдээллийг тайлбарлах, биеэ зөв авч явах, нийгэмшүүлэх талаар боломжтой мэдээллээр хангана.⁹⁰

Монгол Улсын прокурорын туслах ажилтны томилгоо нь сонгон шалгаруулалт хэлбэрээр зохион байгуулагддаг байна. Түүнчлэн шалгаруулалтад тэнцсэн иргэн 2 жилийн хугацаанд хүний нөөцөд бүртгэлтэй байх ба дээрх хугацаа дууссан, нөөцөөс хасагдсан тохиолдолд дахин сонгон шалгаруулалтад орох ёстой. Энэхүү процесс нь тухайн иргэн нөөцөд бүртгэгдсэн ч прокурорын туслахаар томилогдох хүртэл хугацаа алдах, дахин сонгон шалгаруулалтад оролцох зэргээр сөрөг үр дагаврыг бий болгож байна. Гадаад улс, орнуудын зохицуулалтыг авч үзвэл шалгаруулалтад тэнцсэний дараа тухайн байгууллагад өөрөө хүсэлт гаргах, хүний нөөцийн илүүдэл бий болохоос сэргийлж хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн хүнийг томилох гэх мэт туршлагыг бий болгосон байна. Иймд тухайн туршлагаудыг нэвтрүүлэн сөрөг үр дагавруудыг даван туулах боломжтой юм.

Г. Прокурорын туслах ажилтны цалин

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан “Прокурорын байгууллагын ажилтнуудын цалингийн зэрэглэл, шатлалыг шинэчлэн батлах тухай” тушаалаар прокурорын туслах ажилтны цалинг дараах шатлалын дагуу баталжээ.

90 Assistant City Prosecutor- job post: City of Seattle, Холбоос: https://www.indeed.com/jobs?q=Prosecutor+Assistant&=&aceid=&gclid=CjwKCAjwo7iiBhAEIiwAslxQEeuThD-DMxGAWoVhCctHj-HjdCzVw4DfywUu1pPNVDO-ygaXc0lmsxoC_bgQAvD_BwE&gclsrc=aw.ds&from=mobRdr&utm_source=%2Fm%2F&utm_medium=redir&utm_campaign=dt&vjk=93674f7ecde0fc3a. Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

Хүснэгт 1.17. Монгол Улсын зохицуулалт: Прокурорын туслах ажилтны цалинг тодорхойлсон байдал

Хамрагдах прокурорын газар	Албан тушаал	Цалингийн зэрэглэл, шатлал, түүнийг тогтооход баримтлах хугацаа (Төрийн албанд ажилласан хугацааг сараар тооцно.)					Дундаж цалин
		30 сар хүртэл	31-54 сар	55-80 сар	81-114 сар	115 сараас дээш	
Улсын Ерөнхий прокурорын газар	Улсын Ерөнхий прокурорын орлогчийн туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
	Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
	Захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
Нийслэлийн прокурорын газар	Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
	Захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
Тээврийн прокурорын газар	Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
	Захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
Дүүргийн прокурорын газар	Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
	Захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-8-1	AA-8-2	AA-8-3	AA-8-4	AA-8-5	1160000
Аймаг, сум дундын прокурорын газар	Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-10-1	AA-10-2	AA-10-3	AA-10-4	AA-10-5	996462
	Захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан	AA-10-1	AA-10-2	AA-10-3	AA-10-4	AA-10-5	996462

Үүнийг мөнгөн дүнгээр тооцвол, прокурорын туслах ажилтан нь нийслэлд буюу Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Дүүргийн прокурорын газарт дунджаар 1.160.000 төгрөгийн цалин авдаг бол орон нутагт буюу аймаг, сум дундын прокурорын газарт дунджаар 996.462 төгрөгийн цалин авдаг байна. Энэ нь дунджаар 1.078.231 төгрөг юм.

Харин прокурорын цалинг тооцвол Монгол Улсын Их Хурлын 2016 оны 65 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ”-нд заасны дагуу дунджаар 1.860.000 төгрөгийн цалин авдаг байна. Прокурорын туслах ажилтны

дундаж цалинтай тэнцэх 1078231 төгрөгийг прокурорын дундаж цалинтай тэнцэх 1860000 төгрөгтэй харьцуулбал 58%-тай тэнцүү байна.

Хүснэгт 1.18. Гадаад улсуудын зохицуулалт: Прокурорын туслах ажилтны цалинг тодорхойлсон байдал

Улс	Прокурорын туслахын цалин	Прокурорын цалинтай харьцуулсан байдал
Бүгд Найрамдах Солонгос Улс	Прокурорын туслах ажилтан нь төрийн албан хаагчийн 7 дугаар зэрэглэлд хамаардаг. 7 дугаар зэрэглэлийн цалин нь сард 1.962.300 воноос 4.115.000 вон хүртэл байдаг. Энэ нь тухайн төрийн албан хаагчийн шатлалаас хамаардаг бөгөөд 31 шатлал байдаг. Дунджаар 3.239.051 воныг авдаг байна. ⁹¹	Прокурорын хувьд Улсын Ерөнхий прокурор болон бусад прокурорууд гэж ангилагддаг. Улсын Ерөнхий прокурор нь сард 8.431.600 вон авдаг бол бусад прокурорууд нь 17 шатлалаас хамаарч 3.208.600 воноос 8.419.300 воны цалин авдаг байна. Үүнийг дунджилбал 5.868.347 вон болж байна. ⁹² Энэ нь прокурорын туслах ажилтны цалин прокурорын цалингийн 55.19%-тай тэнцүү.
Бүгд Найрамдах Герман Улс	ХБНГУ-ын прокурорын туслахын 2021 оны цалингийн судалгаагаар Германы прокурорын туслах сард дунджаар сард 3322 еврогийн цалин авдаг байна. Энэ нь бус нутаг, туршлагаас хамааран сард 3015-аас 3629 еврогийн хооронд хэлбэлздэг. Гэхдээ энэ нь дундаж үзүүлэлт бөгөөд ажлын туршлага, газарзүйн байршил зэрэг янз бүрийн хүчин зүйлээс хамаарч цалин өөр өөр байж болдог. Холбооны янз бүрийн мужуудад ч ялгаа байж болно. ⁹³	ХБНГУ-ын прокурорын цалингийн хувьд ажилласан жилээс хамаарч сард дунджаар 4907 еврогоос 7557 еврог авдаг байна. ⁹⁴ Энэ нь дунджаар 6232 евро гэсэн үг бөгөөд прокурорын туслахын цалинг тухайн дүнтэй харьцуулбал 53%-тай тэнцэж байна.
Бүгд Найрамдах Эстони Улс	Бүгд Найрамдах Эстони Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 22 дугаар зүйлд “Прокурорын туслахын цалин нь дүүргийн прокурорын цалингаас хэтрэхгүй байх ба туршилтын хугацаа дууссаны дараа дүүргийн прокурорын цалингийн 60 хувиас бага байж болохгүй.” ⁹⁵ гэж заасан байна. Одоогийн байдлаар прокурорын туслахын цалин нь туршилтын хугацаанд 2722 евро, үндсэн хугацаанд 2969 евро байна. ⁹⁶	Бүгд Найрамдах Эстони Улсын прокурорын цалин нь 3680 евро байна. ⁹⁷ Энэ нь прокурорын туслахын цалин прокурорын цалингийн 80%-тай тэнцэх үзүүлэлт юм.

91 2023년 공무원 봉급표, Холбоос: https://0muwon.com/entry/%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90-%EB%B4%89%EA%B8%89%ED%91%9C?fbclid=IwAR13AdlUpVRYDR8-Lyx6RxWXtVVAHZh0gTfsvbKLp_gyz2XRg-8lzfuo06Lc, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

92 검사 연봉 월급 얼마? (초임 초봉부터 검찰총장까지), Холбоос: https://m.blog.naver.com/for_my_blog/221902522005, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

93 Assistenz-staatsanwalt gehalt, 2021, Холбоос: <https://www.gehalt.de/einkommen/suche/assistenz-staatsanwalt>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

94 Gehalt Staatsanwalt, Gehaltsreporter, Холбоос: <https://gehaltsreporter.de/gehaelter-von-a-bis-z/recht/staat-sanwalt/>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

95 Prosecutor's Office Act of Esstonia, 1998, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/510072018002/consolide>, Сүүлд үзсэн огноо:2023.05.01.

96 Prokuröriks kandideerijale, Холбоос: <https://www.prokuratuur.ee/et/too-ja-praktika/prokuroriks-kandideerijale>, Сүүлд үзсэн огноо:2023.05.01.

97 Prokuröre ootab ees palgatõus, Холбоос: <https://www.err.ee/616456/prokurore-ootab-ees-palgatõus>, Сүүлд үзсэн огноо:2023.05.01.

Япон Улс	Япон Улсын прокурорын туслах ажилтны цалин нь Прокурорын цалингийн тухай хуульд зааснаар сард 218.800 иенээс 574.000 иен хүртэл байдаг. Нийтдээ 17 шатлалтай бөгөөд дунджаар 333.429 иений цалин авдаг байна. ⁹⁸	Япон Улсын прокурорын цалин нь Прокурорын цалингийн тухай хуульд зааснаар 237.700 иенээс 1.175.000 иен байдаг. Нийтдээ 20 шатлалтай бөгөөд дунджаар 505.855 иений цалин авдаг байна. ⁹⁹ Прокурорын туслах ажилтны цалин прокурорын цалингийн 65%-тай тэнцүү байна.
Америкийн Нэгдсэн Улс	Америкийн Нэгдсэн Улсад муж улс болон хотуудаас хамаарч прокурорын туслах нь сард 5249 доллароос 6131 долларын цалин авдаг. Энэ нь дунджаар 5690 доллар байна. ¹⁰⁰	Америкийн Нэгдсэн Улсад муж улс болон хотуудаас хамаарч прокурор нь сард 7845 доллароос 8809 долларын цалин авдаг. Энэ нь дунджаар 8327 доллар байна. ¹⁰¹ Прокурорын туслах ажилтны цалин прокурорын цалингийн 68%-тай тэнцүү байна.

Прокурорын туслах ажилтны дундаж цалин 1.078.231 төгрөг байгаа нь гадаад улсуудын туслах прокурор(прокурорын туслах ажилтан)-ын цалинтай харьцуулбал 7-15 дахин бага хэмжээтэй байна. Иймд прокурорын туслах ажилтны цалинг нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн прокурорын туслах ажилтны дундаж цалинг прокурорын дундаж цалинтай харьцуулбал ойролцоогоор 58%-тай тэнцүү байна. Гадаад улс, орнуудын прокурорын туслах(прокурорын туслах ажилтан)-ын цалинг прокурорын цалинтай харьцуулбал Бүгд Найрамдах Солонгос Улсад 55.19%, Бүгд Найрамдах Герман Улсад 53%, Бүгд Найрамдах Эстони Улсад 80% , Япон Улсад 65%, Америкийн Нэгдсэн Улсад 68%-тай тус тус тэнцэж байна. Үүний дундаж нь 64% байх бөгөөд Монгол Улсын хувьд 58% байгаа нь нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

98 Act on the Salaries of Public Prosecutors of Japan, Act No. 76 of July 1, 1948, Холбоос: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4263>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

99 Мөн тэнд.

100 Assistant Public Prosecutor Salary, Холбоос: <https://www.ziprecruiter.com/Salaries/Assistant-Public-Prosecutor-Salary#:~:text=As%20of%20Apr%2021%2C%202023.%2Fweek%20or%20%244%2C778%2Fmonth>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

101 “How Much Do Prosecutor Jobs Pay per Month?”, Холбоос: <https://www.ziprecruiter.com/Salaries/Prosecutor-Salary-per-Month>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.01.

IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгааны хүрээнд 2017 онд батлагдсан Прокурорын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг судаллаа. Ийнхүү судлахдаа прокурорын байгууллагын төрийн эрх мэдлийн хуваарилалтад эзлэх байр суурь, түүнд үзүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн нөлөө, Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчид тавигдах шаардлага, томилох, огцруулах үйл явц, прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, бүрэлдэхүүн, томилгооны үйл явц, прокурорын туслах ажилтны чиг үүрэг, тавигдах шаардлага, томилох үйл явц, цалингийн асуудлыг судлан үзэж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Прокурорын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх талаар:

Монгол Улсын прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийн хүрээнд хамаардаг бөгөөд энэ нь олон улсад сайн туршлагад тооцогддог. Бусад улс, орнуудын хувьд прокурорын байгууллагын харьяаллыг 1) шүүх эрх мэдлийн хүрээнд, 2) гүйцэтгэх засаглалын хүрээнд, 3) хосолсон 4) тусдаа гэх байдлаар янз бүрээр тодорхойлжээ. Гэхдээ прокурорын байгууллага аль эрх мэдэлд харьяалагдахаас үл хамааран түүний бие даасан байдал, хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж өгөх нь нийтлэг байдлаар чухлаар тавигдаж байна.

Мөн Монгол Улсын прокурорын байгууллага нь өмнө нь дурдсанчлан шүүх эрх мэдлийн байгууллага хэдий ч түүний үйл ажиллагаанд Ерөнхийлөгч буюу гүйцэтгэх засаглалын оролцоо өндөр байгааг дурдах нь зүйтэй.

Зөвлөмж: Гадаад улсуудын туршлагаас үзэхэд прокурорын байгууллагын үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн оролцоо нь харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс дахь прокурорын байгууллагын үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн оролцоо нь өндөр хэмээн дүгнэж болохоор байна. Мөн олон улсын байгууллагын дүгнэлт, зөвлөмжид ч прокурорын байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн институтийн оролцоог багасгах, тусгаарлах талаар тусжээ. Тийм учраас 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчлэлд шүүхийн байгууллага дахь Ерөнхийлөгчийн оролцоог хязгаарласны нэгэн адилаар прокурорын байгууллага дахь Ерөнхийлөгчийн оролцоог хязгаарлах шаардлага үүсэж байна. Тухайлбал, гадаад улсуудад прокурорын зөвлөл нь прокурорыг томилох, огцруулах, дэвшүүлэх, сахилгын шийдвэр ногдуулах, урамшуулал олгох, Ерөнхий прокурорыг огцруулах санал гаргах гэх мэт байдлаар хэлбэрийн болон агуулгын оролцоог хэрэгжүүлдэг. Иймд прокурорын зөвлөл болон бусад өөрөө удирдах байгууллага, албан тушаалтанд холбогдох чиг үүргийг шилжүүлж Ерөнхийлөгчийн оролцоог багасгах нь зохистой.

Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчийн талаар:

Тавигдах шаардлага: Монгол Улсын Прокурорын тухай хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчоор зөвхөн прокурор томилогдохоор байгаа нь сүүлийн үед маргаан дагуулж байна.

Зөвлөмж: Монгол Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчоор зөвхөн прокурорыг томилохоос илүүтэйгээр гадаад улсуудын туршлагыг харгалзан шүүгч, өмгөөлөгч, хуулийн мэргэжилтэн, их сургуулийн багш гэх мэт хуулийн чиглэлийн мэргэжилтнүүдийг томилдог болох нь зүйтэй байна. Учир нь хууль зүйн чиглэлээр

мэргэшсэн боловсон хүчнийг Улсын Ерөнхий прокуророор томилох замаар прокурорын байгууллага дахь олон ургалч үзлийг төлөвшүүлэх нь гадаад улсуудын жишиг болж буйг харгалзвал зохино.

Томилох үйл явц: Монгол Улсын Үндсэн хуульд Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилохоор зохицуулсан байна. Ийнхүү Үндсэн хуульд ерөнхий зохицуулснаас гадна Прокурорын тухай хуульд ч мөн ерөнхий байдлаар зохицуулжээ.

Зөвлөмж: Гадаад улсуудад Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилох явцыг нарийн зохицуулдаг бөгөөд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах, шинжээчдийг томилох, жагсаалт гаргах гэх зэргээр тус үйл ажиллагааг шударга явуулахад түлхэц үзүүлэхүйц зохицуулалтыг тусгасан байна. Иймд тус процессуудаас өөрт тохирохыг нутагшуулж томилох үйл явцыг сайжруулах хэрэгтэй. Энэ нь одоогийн процесс болох санал болгож, зөвшилцөж томилдог тогтолцооноос илүү тал бүрийн оролцоог хангасан, ил тод нээлттэй томилгоо болохоор байна.

Огцруулах үйл явц: Монгол Улс болон гадаад улсуудад өөрийн хүслээр, эрүүгийн гэмт хэрэг хийсэн, мэргэжлийн болон ёс зүйн зөрчил үйлдсэн, эрүүл мэндийн шалтгаанаар гэх нийтлэг үндэслэлүүдээр Улсын Ерөнхий Прокурорыг огцруулдаг байна. Харин Монгол Улсад бусад улсаас ялгаатай байдлаар хуульчлагдсан огцруулах үндэслэлийн хувьд Прокурорын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлийг хуульчилсан. Энэ нь Улсын Ерөнхий прокурорын хараат бус байдалд нөлөөлөхөөр байна. Мөн 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн дагуу шүүхийн байгууллагын хүрээнд тавигдаж байсан огцруулахыг үндэслэлийг хассан байдаг.

Зөвлөмж: Прокурорын тухай хуулиар “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан” гэх үндэслэлээр Улсын Ерөнхий прокурорыг огцруулж байгааг Шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд хассантай адилаар хасах нь зүйтэй. Үүнийг гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтын үүднээс авч үзсэн ч, дэмжигдэх бөгөөд Улсын Ерөнхий прокурорын хараат бус байдлыг бэхжүүлэх хүрээнд зайлшгүй яригдах учиртай.

Прокурорын өөрөө удирдах байгууллагын талаар:

Прокурорын өөрөө удирдах байгууллагууд нь прокурорын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл байдаг. Мөн Улсын Ерөнхий прокурорт прокурорын байгууллагын эрх мэдэл төвлөрөхөөс хязгаарлахад онцгой ач холбогдолтой байна.

Үйл ажиллагаа: Монгол Улс дахь прокурорын өөрөө удирдах байгууллагууд нь ерөнхийдөө хүний нөөц, сургалт, судалгаа шинжилгээ, гадаад харилцаа болон прокуроруудын эрх ашгийг хамгаалах, ёс зүй зөрчил, мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг шийдвэрлэх, ЭХХША-тай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон зохион байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байна. Тухайн прокурорын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа нь явцуу хүрээнд тодорхойлогдсон байх тул түүнийг олон улсын жишигт нийцүүлэх нь зохистой байж болно.

Зөвлөмж: Гадаад Улсуудын прокурорын өөрөө удирдах байгууллагууд нь прокурорыг томилох, огцруулах, дэвшүүлэх, сахилгын шийдвэр ногдуулах, урамшуулал олгох, тэдгээртэй холбоотой санал гаргах, прокурорын орон тоог тогтоох, Ерөнхий прокурорыг огцруулах санал гаргах, прокурорын хараат бус байдалд сөргөөр нөлөөлсөн гомдлыг шийдвэрлэх, Ерөнхий прокурорт зөвлөгөө өгөх гэх мэт өргөн чиг үүргийг гүйцэтгэдэг байна. Харин Монгол Улсын хувьд прокурорын өөрөө удирдах байгууллага нь хүний нөөц, сургалт, судалгаа шинжилгээ, ёс зүйн зөрчил, мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг шийдвэрлэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэж байгаа нь түүнийг илүү прокурорын байгууллагад бодит оролцоотой болгох ёстойг харуулж байна. Түүнчлэн прокуроруудын зөвлөл нь өргөн хэмжээний үйл ажиллагаа явуулах байтал Монгол Улсад үйл ажиллагаа нь хумигдмал байгаа нь түүнийг сайжруулах, чиг үүргийг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Бүрэлдэхүүн, түүнийг томилох процедур: Монгол Улсын прокурорын өөрөө удирдах байгууллагуудаас Монголын Прокуроруудын холбоо, Монголын Хуульчдын холбооны Прокурорын хорооны гишүүдээс бусад байгууллагын гишүүдийг Улсын Ерөнхий прокурор томилдог байна. Энэ нь прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүн, томилгоо нь Улсын Ерөнхий прокуророос ихээхэн хамааралтай болохыг харуулж байна.

Зөвлөмж: Гадаад улсуудын хэрэгжүүлж буй хангасан сайн туршлагын хүрээнд прокурорын өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүнийг шүүгч, өмгөөлөгч, прокурорын төлөөлөл, парламентын гишүүн, хууль зүйн сайд, хууль зүйн сургуулийн багш, нэр хүндтэй хуульч, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдүүлдэг байх, тал бүрийн оролцоог хамруулан томилолт, сонгон шалгаруулалт явуулдаг байх зохицуулалтыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Прокурорын туслах ажилтны талаар:

Шүүхийн тухай хуулийн дагуу шүүгчийн туслахын эрх зүйн байдлын зохицуулалтыг шинэчилсэнтэй адил прокурорын туслах ажилтны эрх зүйн байдлыг сайжруулах хэрэгцээ, шаардлага бий болсон байна.

Ажилтны чиг үүрэг: Монгол Улсын хувьд прокурорын туслах ажилтан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд хамаарах чиг үүргийг гүйцэтгэдэг хэдий ч, мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын процесст төдийлөн оролцдоггүй бөгөөд суралцах, дадлагажих чиг үүргийг илүүтэй гүйцэтгэдэг байна.

Зөвлөмж: Гадаад улс, орнуудын хувьд прокурорын туслах ажилтан нь прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эрүүгийн хэргийг танилцуулах, сэжигтнээс мэдүүлэг авах, баривчлах, нэгжлэг хийх, шинжилгээ хийлгэх, хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх гэх мэт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэж байна. Энэ нь тухайн мөрдөн шалгах ажиллагааны үйл ажиллагааг сайжруулах эерэг үр дагавартай бөгөөд нөгөө талдаа прокурорын туслах ажилтныг дадлагажуулахад сайнаар нөлөөлдөг. Иймээс Монгол Улсын прокурорын туслах ажилтны чиг үүргийг нэмэгдүүлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах боломжийг нээх байдлаар шинэчлэл хийх нь зүйтэй.

Тавигдах шаардлага: Монгол Улсын хувьд прокурорын туслах ажилтанд тавигдах шаардлагыг нийтлэг байдлаар зохицуулсан хэдий ч “Цэргийн алба хаасан байх” шаардлагыг тусгасан нь анхаарал татаж байна.

Зөвлөмж: Прокурорын туслахын албан тушаал нь Улсын ерөнхий прокурорын газрын ажлын албанд хамаарагддаг бөгөөд төрийн тусгай албан хаагчийн ангилалд хамаардаггүй. Иймд “Цэргийн алба хаасан байх” шаардлагыг эргэн харж болох юм. Түүнчлэн, прокурорын туслах ажилтны ур чадварыг дээшлүүлэхийн тулд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй болон хууль зүйн магистр зэрэгтэй байх гэх мэт шаардлагыг бий болгохыг үгүйсгэхгүй.

Томилох процесс: Монгол Улсын прокурорын туслах ажилтны томилгоо нь сонгон шалгаруулалт хэлбэрээр зохион байгуулагддаг байна. Түүнчлэн шалгаруулалтад тэнцсэн иргэн 2 жилийн хугацаанд хүний нөөцөд бүртгэлтэй байх ба дээрх хугацаа дууссан, нөөцөөс хасагдсан тохиолдолд дахин сонгон шалгаруулалтад орох ёстой. Энэхүү процесс нь тухайн иргэн нөөцөд бүртгэгдсэн ч прокурорын туслахаар томилогдох хүртэл хугацаа алдах, дахин сонгон шалгаруулалтад оролцох зэргээр сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Зөвлөмж: Гадаад улсуудын сайн туршлагад тулгуурлан авч үзвэл шалгаруулалтад тэнцсэний дараа тухайн байгууллагад өөрөө хүсэлт гаргах, хүний нөөцийн илүүдэл бий болохоос сэргийлж хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн хүнийг томилох гэх мэт арга хэрэгслийг ашиглан дээрх сөрөг үр дагаврыг даван туулах нь зохимжтой байж болох юм.

Цалин: Монгол Улсын Прокурорын туслах ажилтны дундаж 1.078.231 төгрөг байгаа нь гадаад улсуудын туслах прокурор(прокурорын цалин туслах ажилтан)-ын цалинтай харьцуулбал 7-15 дахин бага байна. Түүнчлэн, прокурорын туслах ажилтны дундаж цалинг прокурорын дундаж цалинтай харьцуулбал ойролцоогоор 58%-тай тэнцүү байна.

Зөвлөмж: Бусад улсын жишгээс үзэхэд Монгол Улсын прокурорын туслах ажилтны цалинг нэмэх нь зохистой байна. Ингэхдээ эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн орлогыг харгалзан прокурорын цалинтай харьцуулан тооцох нь бодит байдалд нийцнэ. Гадаад улсуудад энэхүү харьцаа нь 64%-тай тэнцүү байгаа бол Монгол Улсын хувьд ойролцоогоор 58% байна. Улмаар Монгол Улсын хувьд прокурорын туслах ажилтны цалинг нэмэгдүүлэх хүрээнд доод тал нь дээрх 6%-ийн зөрүүг арилгах нь зохимжтой байж болох юм.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, (2015).
3. Прокурорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2017).
4. Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, (2021).
5. Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2021).
6. 2021 оны Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын үзэл баримтлал.
7. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Гадаад хэлээр:

1. Austria's Constitution of 1920, Reinstated in 1945, with Amendments through 2009, Article 90a, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Austria_2009.pdf.
2. Singapore's Constitution of 1963 with Amendments through 2016, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Singapore_2016.pdf?lang=en.
3. Constitution of The Netherlands, 1814 (rev. 2008), Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Netherlands_2008?lang=en.
4. New Zealand's Constitution of 1852 with Amendments through 2014, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/New_Zealand_2014.pdf?lang=en.
5. The Constitution of the Kingdom of Norway, 17 May 1814, Холбоос: <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17>,
6. The Criminal Procedure Act of Norway, Act of 22 May 1981 No. 25, Холбоос: <https://app.uio.no/ub/ujur/over-satte-lover/data/lov-19810522-025-eng.pdf>,
7. Sweden's Constitution of 1974 with Amendments through 2012, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Sweden_2012.pdf?lang=en,
8. Constitution of Japan, Promulgated on November 3, 1946 Came into effect on May 3, 1947, Холбоос: https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html,
9. Finland's Constitution of 1999 with Amendments through 2011, Chapter 9, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Finland_2011.pdf?lang=en,
10. Austria's Constitution of 1920, Reinstated in 1945, with Amendments through 2009, Chapter III, Section B, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Austria_2009.pdf,
11. Romania's Constitution, 1991.
12. Decision U-I-42/12-15 of Slovenia's Constitutional Court, dated 7th February 2013.

13. Act on the Prosecution Service of Finland, (439/2011, amendments up to 738/2015 included), Section 2, Холбоос: https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2011/en20110439_20150738.pdf,
14. The Criminal Procedure Act of Norway, Act of 22 May 1981 No. 25, Холбоос: <https://app.uio.no/ub/ujur/oversatte-lover/data/lov-19810522-025-eng.pdf>,
15. Prosecutors' office act of Korea Republic, Expand Act No. 14582, Mar. 14, 2017, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42630&lang=ENG,
16. Prokuratūras likums, 35, Холбоос: <https://likumi.lv/ta/id/57276-prokuraturas-likums>,
17. Prosecutor's Office Act of Estonia, 1998, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/515092021001/consolide>,
18. 28 U.S. Code § 503 - Attorney General, <https://www.law.cornell.edu/uscode/text/28/503#:~:text=The%20President%20shall%20appoint%2C%20by,of%20the%20Department%20of%20Justice>,
19. Federal Law No. 2202-I of January 17, 1992 on The Prosecutor's Office of The Russian Federation (in the Wording of Federal Law No. 168-FZ of November 17, 1995).
20. Armenia's Constitution, July 5, 1995.
21. Law on the Prosecutor's Office of Bosnia and Herzegovina, 24/02, 3/03, 37/03, 42/03, 9/04, 35/04, 61/04.
22. Constitution of Serbia, 2006.
23. Law on Public Prosecution of Serbia, No. 116/08, 104/2009.
24. Law on State Prosecutorial Council of Serbia, No. 101/2010 and 88/2011.
25. State Prosecutor's Office Act of Slovenia (SPOA), 2011.
26. The Federal Constitution of Malaysia, 1957, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Malaysia_2007?lang=en,
27. Japanese Attorneys Act, No. 205 of June 10, 1949, Холбоос: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3636/en>,
28. Albania's Constitution of 1998 with Amendments through 2016, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Albania_2016.pdf?lang=en,
29. Law of The Republic of Armenia of December 1, 2017 No. ZR-198 About prosecutor's office, Холбоос: <https://cis-legislation.com/document.fwx?rgn=113216>,
30. Republic of Lithuania Law on the Prosecutor's office, 13 October 1994, No. I-599, Холбоос: <https://e-seimas.lrs.lt/portal/legalActPrint/lt?jfwid=fxdp7hpb&documentId=TAIS.24742&category=TAD>,
31. Latvia's Prosecution Office Law, 1994.
32. Prosecutors' office act of Korea republic, Mar. 14, 2017.
33. Act on the Salaries of Public Prosecutors of Japan, Act No. 76 of July 1, 1948, Холбоос: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4263>,

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Прокурорын ном:прокурорын гарын авлага, Хян. Б.Чимэд, (Уб, 2000).
2. Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт, (Уб, 2009).
3. Г.Баясгалан, Н.Туяа, Б.Цэрэнбалтав, Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, (Уб, 2003).
4. “Прокурорын хараат бус байдал /прокурорын байгууллагын тогтолцоо, удирдлага, өөрөө удирдах байгууллага” судалгааны тайлан, ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төв, (Уб, 2022).
5. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, (Уб, 2021).
6. Улсын Ерөнхий прокурорын тайлан мэдээ, 2023.04.12-ны өдрийн байдлаар.

Гадаад хэлээр:

1. The Independence of Prosecutors in Eastern Europe, Central Asia and Asia Pacific, OECD, (2020).
2. Bundesgesetz vom 5. März 1986 über die staatsanwaltschaftlichen Behörden (Staatsanwaltschaftsgesetz – StAG), Холбоос: <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnumm er=10000842>,
3. Rome Charter, XIV.
4. Venice Commission (2010), Report on European Standards as regards the Independence of the Judicial System: Part II – The Prosecution Service (hereinafter – Venice Commission Report), Холбоос: <https://rm.coe.int/1680700a60>,
5. The study When the Law Doesn’t Rule, by the Open Society European Policy Institute, Transparency Serbia, and the Centre of Investigative Journalism of Serbia.

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Х.Нямбаатар, “Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслөө татна”, (сурв. Г.Батжаргал), 2022.05.31, Холбоос: <http://itoim.mn/article/YQWxl/33377>,
2. Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын цахим хуудас, Холбоос: <https://prokuror.mn>,
3. Монгол Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл, Холбоос: <https://prokuror.mn/prosecutor-s-council>.
4. Прокурорын хорооны танилцуулга, Холбоос: <https://www.mglbar.mn/committee/9?page=intro>,
5. Прокурорын хорооны тэргүүнд нэр дэвшүүлэх, тэргүүнийг сонгох сонгууль явагдаж байна, Холбоос: <https://www.mglbar.mn/news/926>.

6. Ч.Өнөржаргал, “Ерөнхий прокурорт тавигдах шаардлагыг хасна гэдэг гэмт хэрэгтэй тэмцэх төрийн хүчийг сулруулна dnn.mn”, (сурв: Б.Энхзаяа), Холбоос: <https://dnn.mn/ч-өнөржаргал-ерөнхий-прокурорт-тавигдах-шаардлагыг-хасна-гэдэг-гэмт-хэрэгтэй-тэмцэх-төрийн-хүчийг-сулруулна-dnn-mn/>,
7. А.Бямбажаргал: “Шүүхийн тухай хуулийг батлах асуудал том сорилттой ямагт тулж байна”, 2021, Холбоос: <https://ikon.mn/n/237p>,
8. “Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын цалинг шинэчлэн тогтоолоо /2022.05.11/”, Холбоос: https://www.judcouncil.mn/site/news_full/12122,

Гадаад хэлээр:

1. “Legal professions – introduction”, Prosecutor, 2020, Холбоос: https://e-justice.europa.eu/content_legal_professions-29-se-en.do?member=1,
2. “Welcome to The Higher Prosecuting Authorities” - The Director of Public Prosecutions and the Regional Public Prosecution Offices, Холбоос: <https://www.riksadvokaten.no/english/>,
3. Masato Shimizu, Nikkei senior staff writer, Japanese prosecutors and politicians keep up a delicate dance, May 30, 2020, Холбоос: <https://asia.nikkei.com/Politics/Japanese-prosecutors-and-politicians-keep-up-a-delicate-dance#:~:text=The%20right%20of%20prosecution%2C%20however,right%20to%20investigate%20the%20government>,
4. “How is a judge appointed?”, Courts of New Zealand website, Холбоос: <https://www.courtsfnz.govt.nz/learn-about-our-courts/how-is-a-judge-appointed/#:~:text=The%20Attorney%2DGeneral%20is%20a,not%20influenced%20by%20party%20politics>,
5. Organisational overview new zealand prosecution office, <https://www.crownlaw.govt.nz/about-us/law-officers/>,
6. The prosecutors, Холбоос: <https://www.justiz.gv.at/home/justiz/justizbehoerden/staatsanwaltschaften.8ab4a8a422985de30122a92877dc6347.de.html#:~:text=Die%20Staatsanwaltschaften%20sind%20von%20den,des%20Bundesministers%20f%C3%BCr%20Justiz%20gebunden>,
7. Stellung in der Weisungshierarchie, Холбоос: <https://www.generalprokuratur.gv.at/information/>,
8. Liste, Холбоос: [Name Position Organization Country E-mail Mr.Allan Dahl Chief of Justice Unit EUPOL](#),
9. States’ qualifications for attorney general, Холбоос: <https://www.cga.ct.gov/2010/rpt/2010-R-0253.htm>,
10. Attorney General of India: Appointment, duties and special rights, Холбоос: <https://www.indiatoday.in/education-today/gk-current-affairs/story/attorney-general-of-india-appointment-duties-and-special-rights-1895843-2022-01-04>
11. Crown prosecutor, Холбоос: <https://nationalcareers.service.gov.uk/job-profiles/crown-prosecutor>,

12. Prosecutor General of the Republic of Korea, Холбоос: https://ko.wikipedia.org/wiki/%EB%8C%80%ED%95%9C%EB%AF%BC%EA%B5%AD%EC%9D%98_%EA%B2%80%EC%B0%B0%EC%B4%9D%EC%9E%A5,
13. Hiroataka Tokumoto, Professor, Faculty of Law, Chuo University, “Retirement Extension of the Superintending Prosecutor”, Холбоос: https://yab.yomiuri.co.jp/adv/chuo/dy/opinion/20200409_en.php,
14. Assistenz-Staatsanwältin/Staatsanwalt des Bundes (WiKri Zürich), Холбоос: <https://jobs.admin.ch/offene-stellen/Assistenz-Staatsanw-Itin-Staatsanwalt-des-Bundes-WiKri-Z-rich-/ffbdc28e-d9bc-4088-8c04-bb645e8f5d95>,
15. Duties of Public Prosecutors’ Assistant Officers, Холбоос: https://www.moj.go.jp/EN/keiji1/keiji_keiji05.html,
16. 2m88 pay range: ep10 prosecution assistant 1, Холбоос: <https://www.phila.gov/departments/office-of-human-resources/job-specs/2m88.htm>,
17. 공무원 직급표, Холбоос: https://m.blog.naver.com/sampoet/221734685493?fbclid=IwAR04k_2um6hoQNdHe6uV_pJD56dU9RftuP6MHiCRRkSPd8OaonsKPWnQHPGE,
18. Abiprokurör Prokuratuur, Холбоос: <https://cv.ee/et/vacancy/526481/prokuratuur/services>,
19. Prokuröride konkursi korraldamise ning konkursil osalejatele ja ametisse nimetatavatele prokuröridele esitatavad nõuded [RT I, 07.10.2014, 1 - jõust. 10.10.2014], Холбоос: <https://www.riigiteataja.ee/akt/101042015005>,
20. 検察事務官になるための資格について教えてください。 , Холбоос: <https://www.kensatsu.go.jp/qa/qa1.htm>. Сүүлд үзсэн:2023.05.01.
21. Assistant City Prosecutor- job post: City of Seattle, Холбоос: https://www.indeed.com/jobs?q=Prosecutor+Assistant&=&acid=&gclid=CjwKCAjwo7iiBhAEEiwAslxQEeuThD-DMxGAWoVhCctHj-HjdCzVw4DfywUu1pPNVDO-ygaXc0lmsxoC_bgQAvD_BwE&gclid=aw.ds&from=mobRdr&utm_source=%2Fm%2F&utm_medium=redir&utm_campaign=dt&vjk=93674f7ecde0fc3a,
22. 7급 공개경쟁채용시험, Холбоос: https://www.mpm.go.kr/mpm/info/fair/recruit/recruit01/recruit01_03/recruit01_03_01/,
23. German Federal Ministry of Justice and Consumer Protection website, Холбоос: https://www.bmjjv.de/EN/Jobs_Careers/HowToBecomeAPublicProsecutor/HowToBecomeAPublicProsecutor_node.html,
24. 2023년 공무원 봉급표, Холбоос: https://0muwon.com/entry/%EA%B3%B5%EB%AC%B4%EC%9B%90-%EB%B4%89%EA%B8%89%ED%91%9C?fbclid=IwAR13AdIUpVRYDR8Lyx6_RxWXtVVAHZh0gTfsvbKLp_gyz2XRg-8lfu06Lc,
25. 검사 연봉 월급 얼마? (초임 초봉부터 검찰총장까지), Холбоос: https://m.blog.naver.com/for_my_blog/22190252_2005,
26. Assistenz-staatsanwalt gehalt 2021, Холбоос: <https://www.gehalt.de/einkommen/suche/assistenz-staatsanwalt>,
27. Gehalt Staatsanwalt, Gehaltsreporter, Холбоос: <https://gehalsreporter.de/gehaelter-von-a-bis-z/recht/staat-sanwalt/>,

28. Prokuröriks kandideerijale, Холбоос: <https://www.prokuratuur.ee/et/too-ja-praktika/prokuroriks-kandideerijale>.
29. Prokuröre ootab ees palgatõus, Холбоос: <https://www.err.ee/616456/prokurore-ootab-ees-palgatõus>.
30. Assistant Public Prosecutor Salary, Холбоос: <https://www.ziprecruiter.com/Salaries/Assistant-Public-Prosecutor-Salary#:~:text=As%20of%20Apr%2021%2C%202023,%2Fweek%20or%20%244%2C778%2Fmonth>,
31. How Much Do Prosecutor Jobs Pay per Month?, Холбоос: <https://www.ziprecruiter.com/Salaries/Prosecutor-Salary-per-Month>.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛД ТАВИХ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
ТОДОРХОЙЛОХ ТАНДАН СУДАЛГАА

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

Х.Буянбат

Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)

О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ажилтан (LL.M)

Судалгааг захиалагч: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.04.25.

АГУУЛГА

УДИРТГАЛ	65
I. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	68
1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох	74
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох	74
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл	75
II. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	85
III. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	86
IV. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	91
4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	91
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	97
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	101
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	110
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх	112
V. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	115
VI. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	117
6.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	120
6.2. Бүгд Найрамдах Австри Улс	123
6.3. Бүгд Найрамдах Эстони Улс	130
VII. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	133
НОМ ЗҮЙ	136

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад Улсын Их Хурал “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхийг заасан. Ард түмнээс сонгуулиар итгэмжлэн олгосон нийт иргэн, улсын нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах зорилгоор УИХ хууль болон бусад шийдвэр гаргадаг бөгөөд түүнийг Засгийн газар, түүний бие бүрэлдэхүүн хэрхэн биелүүлснийг УИХ өөрөө эргэн хянах бүрэн эрхийг ийнхүү Үндсэн хуулиар баталгаажуулжээ.¹ Хууль батлах нь УИХ-ын бүрэн эрх байдгийн адил батлагдан гарсан хуулийн биелэлтийг хянан шалгах ч мөн УИХ-ын бүрэн эрх бөгөөд тус хоёр чиг үүргийн нийлбэр нь хууль тогтоох бүрэн эрх болохыг, түүнчлэн энэхүү чиг үүргүүд нь хоорондоо салшгүй холбоотой болохыг судлаачид хүлээн зөвшөөрдөг.² Иймээс УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баталсан билээ.

УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийн агуулга нь УИХ-аас баталсан хууль тогтоомжийг биелүүлэх Үндсэн хуулиар хүлээсэн чиг үүргээ Засгийн газрын бие бүрэлдэхүүн хэрхэн хэрэгжүүлж, хүлээсэн үр дүнд хүргэсэн байдлыг хуульд заасан арга, хэлбэрийг ашиглан ажиглан судлах, шинжлэх, үр дүн, үр нөлөөг тодорхой шалгуур үзүүлэлтээр тооцон гаргах, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааг ойлгох бөгөөд энэ ажиллагаа хууль тогтоох ажлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг учраас өөрийн хил хязгаартай, дүр зоргоос ангид, хуульчилсан процедураар хэрэгжих ёстой.³ Хэрхэн хянан шалгах вэ? гэдгээс хамаарч төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрт байдал, улсын аюулгүй байдал хамаарна. Гэвч өдгөө УИХ-ын хянан шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхой салбар, чиглэлийн хүрээнд илүү боловсронгуй болгох шаардлага байсаар байна. Тэр дундаа гүйцэтгэх ажилтай холбоотой хянан шалгах чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байгааг Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Улсын Их Хурал, Засгийн газар шаардлагатай гэж үзвэл өөрийн бүтэц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина” гэж зааснаас өөр тодорхой заалт бусад хууль тогтоомжид байхгүйгээс харж болно.

Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ хийгээд гүйцэтгэх ажлыг явуулах арга, аргачлал нь тодорхой үндэслэл бүхий шалтгааны улмаас хүний эрх, эрх чөлөөнд халдах шаардлагатай тулгардаг. НҮБ-ын холбогдох гэрээний хороод, тухайлбал, Хүний эрхийн хорооноос мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын нууц үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлах, үүний зэрэгцээ үндэсний аюулгүй байдалд хамаарах мэдээ, мэдээлэлд нэвтрэх, түүнтэй танилцах үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог байнга боловсронгуй болгож байхыг гишүүн улсуудад зөвлөсөн байдаг.

Гүйцэтгэх ажиллагаанд өндөр түвшний нууцлал шаардлагатай байдаг тул эдгээр байгууллагууд үйл ажиллагаагаа төрийн бусад байгууллагатай адилаар

1 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 418 дахь тал.

2 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 418-419 дэх тал, болон Б.Чимид “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал” илтгэл, *Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил*, (УБ, 2010), 63 дахь тал.

3 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 419 дэх тал.

нээлттэй тайлагнах боломжгүй байдаг учраас тэдгээр байгууллагуудын явуулж буй гүйцэтгэх ажил хуулийн хүрээнд явагддаг эсэх, хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халддаг эсэхэд бүрэн эргэлзээ тайлах хариулт авах боломжгүй байдагтай холбоотойгоор олон нийтийн зүгээс татвар төлөгчдийн мөнгөөр явуулж байгаа энэхүү ажиллагаа нь өөрийн болон хэн нэгний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдаж байгаа эсэх, гүйцэтгэх ажиллагаагаар олж авсан мэдээллүүд өөр зорилгоор ашиглагдаж байгаа эсэхэд үргэлж анхаарал хандуулж мөн эргэлзсээр ирсэн. Тиймээс ч гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ, нийгмийн шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий түр хороог байгуулж, тус түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг улс орон даяар нээлттэй зохион байгуулсан бөгөөд үр дүнд нь гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох дараах практик шаардлага буйг харууллаа. Үүнд:

- Улсын Их Хурлын гүйцэтгэх ажилд тавих хяналтын хүрээ, хязгаар, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, боловсронгуй болгох;
- Улсын Их Хурлын гишүүд гүйцэтгэх албадын мөрдөн шалгах үйл ажиллагаанд хяналт тавих замаар уг ажиллагаанд хэт их оролцох эрсдэлийг хаах, гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих бүрэн эрхийн зааг ялгааг тодорхой болгох;
- Гүйцэтгэх ажиллагаа явуулдаг байгууллагуудын хяналт, тэнцлийг хангаж, тэнцвэртэй, хяналттай төрийн үйл ажиллагааг бий болгох;
- Улсын Их Хурлаас тухайн жилд байгуулагдах хяналт шалгалтын түр хорооны тоонд хязгаар тогтоох.

Түүнчлэн, УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” бодлогын баримт бичигт “Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор явуулж байгаа гүйцэтгэх ажлыг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулах мөрдөн шалгах болон эрэн сурвалжлах нууц ажиллагаанаас ялгаж тодорхой болгох, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг ялгаатай байдлаар нарийвчлан хуульчлах, гүйцэтгэх ажилтны болон гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагатай нууцаар хамтран ажилладаг этгээдийн эрх зүйн байдлыг сайжруулах, мөн бусад хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулан зарим нэр томъёог шинээр хуульчлах, хуулийн хэрэгжилттэй холбоотой гарч байгаа хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах, гүйцэтгэх ажил, гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих механизмыг шинэчлэх зорилгоор Гүйцэтгэх ажлын тухай хуулийг өөрчлөхөөр” заасан. Мөн “Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороог байгуулах үндэслэл, түр хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээний хүрээ хязгаарыг тодорхой болгох, түр

хорооны гишүүнээр ажиллах тохиолдолд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан тодорхойлж, гэрч, хянан шалгагч, шинжээч нарыг томилох, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, нотлох баримттай танилцах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд, Монгол Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэг ба мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын онцлог, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тус тус даалгасан байна.

Энэхүү судалгаагаар гүйцэтгэх ажилд тавих хяналтыг гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг шинээр бий болгох замаар өргөжүүлэх, ингэхдээ Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай эсэхийг 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт батлагдсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв.

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Мөн гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын⁴ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

4 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол, Нэгдүгээр хавсралт.

I. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилт 7.3-т “Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.” гэж, 2020 оны 08 дугаар сарын 28-ны Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.12-т “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.” гэж тус тус тусгагдсан байна. Мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт) -ын 1.1.4-т “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн” гэж тусгасан байна.

Түүнчлэн, 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.1 дэх хэсгийн 2-т “Гүйцэтгэх ажлын тухай /Шинэчилсэн найруулга/-ыг баталж боловсронгуй болгох талаар тодорхойлжээ. Тус үйл ажиллагааны хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор явуулж байгаа гүйцэтгэх ажлыг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулах мөрдөн шалгах болон эрэн сурвалжлах нууц ажиллагаанаас ялгаж тодорхой болгох, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг ялгаатай байдлаар нарийвчлан хуульчлах, гүйцэтгэх ажилтны болон гүйцэтгэх ажлыг явуулдаг байгууллагатай нууцаар хамтран ажилладаг этгээдийн эрх зүйн байдлыг сайжруулах, мөн бусад хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулан зарим нэр томъёог шинээр хуульчлах, хуулийн хэрэгжилттэй холбоотой гарч байгаа хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах, гүйцэтгэх ажил, гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих механизмыг шинэчлэх зэргээр боловсронгуй болгохоор тусгасан байна.

Дээрх байдлаар хууль сахиулах байгууллага, тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүний эрхэд суурилсан бодлого, чиглэл баримтлахаар тусгажээ. Энэ хүрээнд гүйцэтгэх ажилтай холбоотой шинэчлэлтүүд мөн хийгдэж байна. Гүйцэтгэх ажилтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд дээрхээс гадна зайлшгүй авч үзэх шаардлагатай нэг асуудал бол гүйцэтгэх ажилд тавих хяналт юм.

Одоо хүчин төгөлдөр буй 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар гүйцэтгэх ажлыг “үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагаа” болохыг тодорхойлжээ. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их

Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхимд болон хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх техникийн үзлэг, шалгалт гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

Монгол Улсад тагнуулын үйл ажиллагааг 2015 оны 07 дугаар сарын 09-ийг дуустал Тагнуулын ерөнхий газар (ТЕГ), Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн тагнуулын байгууллага, Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ)-ын Хилийн тагнуулын газар, Цагдаагийн байгууллага (Эрүүгийн цагдаагийн газар), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ)-ын Гүйцэтгэх алба, Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын гүйцэтгэх алба зэрэг 6 байгууллага явуулж байв. Тэдгээр байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хангах, хуульд заасан гэмт хэрэгтэй нууц болон бусад хүч, арга, хэрэгсэл ашиглан тэмцэх нийтлэг зорилготой боловч холбогдох хууль болон эрх зүйн бусад актаар тэдгээрийн тус бүрийн зорилго, чиг үүргийг тогтоож өгсөн. Тагнуулын байгууллагын тухай хуульд 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн тагнуулын газар, Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн тагнуулын газрыг тус тус Тагнуулын ерөнхий газарт шилжүүлсэн.⁵ Өдгөө гүйцэтгэх ажлыг дор дурдсан байгууллагууд дараах зорилгоор гүйцэтгэж байна.

Хүснэгт 2.1. Гүйцэтгэх ажил явуулж буй байгууллагууд

Тагнуулын байгууллага	Гадаад тагнуул, хилийн тагнуул, сөрөх тагнуулын чиглэлээр гадаад улс, байгууллагын тодорхой бодлого, үйл ажиллагааны тухай болон төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий бусад мэдээ олох, дэмжлэг үзүүлэх, үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэл, аюул, занал, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох.
Цагдаагийн байгууллага	Тагнуулын байгууллагад хамаарахаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдал болон шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох.
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гүйцэтгэх алба	Хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах түүнчлэн бусад байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх.
Авлигатай тэмцэх газар	Авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.
Цэргийн тагнуулын байгууллага	Олон улсын болон бүс нутгийн цэрэг-улс төрийн байдлыг судалж, Монгол Улсад учирч болзошгүй аюул, заналхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээллээр төрийн дээд болон Зэвсэгт хүчний удирдлагыг хангах.

Манай улсын тагнуулын байгууллагуудын тагнуулын үйл ажиллагаа нь бүхэлдээ ҮАБ-ыг хангах, хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг зорилготой

⁵ М.Цогтоо, Ц.Очгэрэл нар, *Гүйцэтгэх ажлын удирдахуй*, (Уб, 2021), 39 дэх тал.

боловч түүнийг хэрэгжүүлэгч байгууллага тус бүрийн зорилго, зорилт, чиг үүрэг зэргийг үндэс болгон уг үйл ажиллагааг Гадаад тагнуулын үйл ажиллагаа, Сөрөх тагнуулын үйл ажиллагаа, Цэргийн тагнуулын үйл ажиллагаа, Хилийн тагнуулын үйл ажиллагаа, Эрүүгийн тагнуулын үйл ажиллагаа гэсэн үндсэн таван хэлбэртэй гэж үзэж болох юм.

Тагнуулын үйл ажиллагааны зорилго нь уг үйл ажиллагааны зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр биеллээ олно. Гүйцэтгэх ажлын тухай хуульд гүйцэтгэх ажлын зорилтыг тодорхойлоогүй ч тус хуульд заасан тагнуулын буюу гүйцэтгэх байгууллагуудын тагнуулын үйл ажиллагааны зорилго, үндэслэл зэргээс үзвэл манай улсын тусгай албадын тагнуулын үйл ажиллагааг дараах нийтлэг зорилттой гэж үзэж болохоор байна. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдолтой мэдээлэл олж, цуглуулан төр засгийн удирдлага болон төрийн холбогдох бусад байгууллагын удирдлагыг хуульд заасан тагнуулын мэдээллээр хангах;
- Гадаад улсын тусгай алба, байгууллага, түүнчлэн бусад этгээдүүдийн тагнах, хорлон бусниулах болон Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахад чиглэсэн бусад үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;
- Хуульд заасан бусад гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдсэн этгээдийг олж тогтоох;
- Оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах.

Тагнуулын үйл ажиллагааны нийтлэг зорилтууд нь хоорондоо харилцан уялдаа холбоотойгоос гадна зорилт тус бүх өөр өөрийн өвөрмөц агуулга, зорилго, зорилттой юм. Тиймээс тусгай алба тус бүрийн зорилго, зорилт, чиг үүргийн онцлогоос хамаарч тэдгээрээс тагнуулын үйл ажиллагаа явуулах үндэслэл ч өөр өөр байх учиртай.⁶

Дээрх гүйцэтгэх ажилд тавих хяналтын тухайд төрийн хяналт, шалгалтын нэг хэсэг болдог. Төрийн хяналт, шалгалтын⁷ нийтлэг үндсэн зорилго нь төрийн байгуулалт, төрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих, төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, төсөв зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, төрийн аппаратын үйл ажиллагааг хөнгөн шуурхай байлгахад оршино. Тусгай албадын удирдлагын хяналт, шалгалт нь тухайн байгууллага, ажилтны үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэх ёстой.

6 Мөн тэнд, 41-42 дахь тал.

7 **Хяналт** нь хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар тогтоосон журам хэрхэн биелэгдэж байгаа, төлөвлөгөөт болон бусад ажлын биелэлтийн явц байдлыг мэдэрч, үнэлж дүгнэж байх байнгын үйл ажиллагаа юм. Хяналт нь бүх шатны удирдлага, албан тушаалтнаас эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааных нь нэн чухал хэсэг байх ёстой. **Шалгалт** нь Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад актуудын биелэлтийн явц байдал, үр дүнг эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтан тогтоосон журмын дагуу нарийвчлан танилцан шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, шаардлагатай бол буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэж тэгснээрээ тухайн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэдэг.

Хяналт, шалгалт нь дараах үндсэн гурван чиг үүрэгтэй хэмээн үздэг. Нэгд, байгууллага, түүний удирдлагын хэвийн тогтвортой байдлыг хангадаг учраас зохион байгуулах чиг үүрэгтэй. Хоёрт, байгууллага, хамт олны үйл ажиллагаанд мэргэжлийн болоод бусад дэмжлэг туслалцаа үзүүлж, ажлын шинэлэг арга, туршлага олж илрүүлэх, нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэдэг учраас сургах чиг үүрэгтэй. Гуравт, байгууллагын удирдлага, ажилтнуудын ажлын хариуцлага, сахилгыг өндөржүүлдэг учраас хүмүүжүүлэх чиг үүрэгтэй.

Гүйцэтгэх ажилд тавих хяналт, шалгалт нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой. Үүнд:

- Удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийн явц байдалд байнга хяналт тавих;
- Гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагааны бодит үр дүнг тодорхойлох;
- Гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагааны явц байдал, үр дүн нь Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад акт, тагнуулын байгууллагын удирдлагын баримталж буй бодлого, дэвшүүлсэн зорилго, зорилтод хэрхэн нийцэж байгааг тогтоох;
- Бүх шатны удирдлагын шийдвэр, салбар нэгж, ажилтны чиг үүрэг, төлөвлөгөөт зорилтын хэрэгжилтийн байдлыг цаг тухайд нь бодитой үнэлж дүгнэх;
- Салбар нэгж, ажилтнаас удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй дутагдал, доголдлыг цаг тухайд нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх;
- Салбар нэгж, ажилтны гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагааны явц байдал, үр дүн нь тагнуулын байгууллагын удирдлагаас баримталж буй бодлого, дэвшүүлсэн зорилтоос хазайхад хүргэж байгаа шалтгаан, нөхцөлийг олж тогтоох;
- Хяналт, шалгалтын явцад илэрсэн нийтлэг, дутагдал, доголдлыг арилгах, цаашид тэдгээрийг гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тогтолцоог боловсруулах;
- Байгууллага, хамт олны үйл ажиллагаанд байгаа ажлын шинэлэг арга, тэргүүний туршлагыг судалж, дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;
- Ашиглагдаагүй байгаа нөөц, бололцоог илрүүлж ашиглах;
- Шалгагдагч байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулахад туслах.⁸

Гүйцэтгэх ажилд тавих дээрх хяналт, шалгалтыг бүхэлд нь дотоод ба гадаад гэж хоёр ангилж болно.

Дотоод хяналт

Аль ч төрлийн тагнуулын буюу гүйцэтгэх байгууллагын тухайд дотоодын хяналт, шалгалтыг бүх шатны удирдлага өөр өөрийн эрх хэмжээний хүрээнд хариуцсан салбар нэгждээ хэрэгжүүлэх ёстой. Мөн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн нэгж нь шаардлагатай гэж үзвэл байгууллагынхаа удирдлагын шийдвэрээр гүйцэтгэх болон гүйцэтгэх бус салбар нэгжүүдэд шалгалт хийж болно.

8 М.Цогтоо, Ц.Очгэрэл нар, *Гүйцэтгэх ажлын удирдахуй*, (УБ, 2021), 193-194 дэх тал.

Гадаад хяналт

Гадаад улс орнуудад тусгай албадынхаа үйл ажиллагаанд тавих гадаад хяналтын тогтолцоо, хэлбэр тэдгээрийн хууль тогтоох уламжлал, улс төрийн тогтолцоо болон бусад хүчин зүйлээс хамаардаг байна. Жишээлбэл, Их Британи болон түүний уламжлалт жишиг бүхий хуулийн тогтолцоотой орнуудад аливаа хяналтыг шүүх байгууллагаас тавих нь илүү үр өгөөжтэй гэж үздэг. Харин эх газрын хуулийн тогтолцоог гол болгосон орнууд хийгээд социалист гэгдэж байгаад ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн ихэнх улс орон парламентын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх болжээ.

АНУ-д уг хяналтын тогтолцоог хууль тогтоох, гүйцэтгэх хийгээд хяналтын мэргэшсэн байгууллагын хяналт, шалгалт бүрдүүлдэг. Харин Канад тусгай албадын үйл ажиллагаанд тавих хяналтыг тус улсын парламентын Аюулгүй байдал, тагнуулын хяналтын хороо болон Нийтийн аюулгүй байдал, онцгой бэлэн байдлын яаман дахь Ерөнхий хянан шалгагч хэрэгжүүлдэг. Энэ нь Канадын тусгай албадын тогтолцоо үүсэж, бүрэлдээд харьцангуй удаагүй гэх мэт хүчин зүйлтэй холбоотой байж болох юм.

Манай улсын эрүүгийн тагнуулын байгууллагуудын үйл ажиллагаанд тавих гадаад хяналт, шалгалтын тогтолцоог Монгол Улсын Их Хурлаас тавих хяналт шалгалт, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавих хяналт, Монгол Улсын Засгийн газраас тавих хяналт, прокурорын хяналт, ТЕГ-ын хяналт, шалгалт, аудитын байгууллагын хяналт тус бүрдүүлдэг гэж үзэж болно.

Улсын Их Хурлын уг нэгж нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Тусгай хяналтын дэд хороо юм. Улсын Их Хурал шаардлагатай тохиолдолд Тусгай хяналтын дэд хорооны гишүүд болон мөн хурал дахь сөрөг хүчний намын бүлгийн зарим гишүүнийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгах практикийг бий болгоод байна.⁹

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурлын цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог...” байгуулах замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бүрэн эрхийг нээж улмаар түүний онцгой бүрэн эрхэд хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийг хамааруулсан. Хууль батлах, түүний биелэлтийг хянан шалгах хоёрын нийлбэрийг хууль тогтоох ажиллагаа гэж үздэг.¹⁰

9 Мөн тэнд, 194-195 дахь тал.

10 Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал”, *Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил* /Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/, (УБ, 2010), 63 дахь тал.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайд танхимаа бүрдүүлэх эрхээ дангаар эдэлж, Улсын Их Хурлын төсөв батлах бүрэн эрх хязгаарлагдсан зэргээс үүдэн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангах, хууль, тогтоолын биелэлтийг хангах Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлж, хянан шалгах арга хэрэгсэл, үйл явцыг нарийвчлан зохицуулах, парламентын хяналт шалгалтад хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага, хөндлөнгийн шинжээч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн хараат бус, бие даасан байгууллага, хөндлөнгийн шинжээч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн хараат бус байдлыг сайжруулах, хараат бус бодит мэдээлэлд тулгуурлах, авлига, ашиг сонирхол, хүнд суртлаас ангид, хариуцлагатай гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэх, төрийн албаны бүх шатанд хариуцлага, сахилгыг бэхжүүлэх практик хэрэгцээ, шаардлага үүссэн.¹¹

Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас гүйцэтгэж буй гүйцэтгэх ажил нь дээрх гүйцэтгэх засаглалын хяналтад хамаарагдаж хяналт-тэнцэл хангагдах ёстой. Хүний эрх, эрх чөлөөг тусгай албадын хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахад тэдгээрийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, ялангуяа Улсын Их Хурал, түүний бүтэц дэх нэгж, албан тушаалтнуудаараа дамжуулан тавих хяналт онцгой ач холбогдолтой юм.

Мөн “Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороог байгуулах үндэслэл, түр хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээний хүрээ хязгаарыг тодорхой болгох, түр хорооны гишүүнээр ажиллах тохиолдолд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан тодорхойлж, гэрч, хянан шалгагч, шинжээч нарыг томилох, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, нотлох баримттай танилцах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд, Монгол Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэг ба мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын онцлог, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тус тус даалгасан.

Дээрхээс дүгнэвэл, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбоотой эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ, зайлшгүй шаардлага үүссэн байна.

Иймд аргачлалын дагуу дүн шинжилгээ хийхдээ тухайн асуудлын хүрээнд түүний мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тогтоож эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийн эрхэд тухайн асуудал хэрхэн нөлөөлж буй талаар авч үзсэн болно.

11 Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал.

1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Дээр дурдсан нөхцөл байдлаас дүгнэвэл, дараах асуудал голлон анхаарал татаж байна. Үүнд:

Нэгдүгээрт, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг бий болгох нь гүйцэтгэх ажлын болон Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах болон хүний эрхийн хандлага төлөвшүүлэх, хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, хянах хэрэгцээ, шаардлагаас үүсэж байна.

Хоёрдугаарт, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын тусгайлсан хяналтыг бий болгох нь 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүний дагуу батлагдсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын 2023 оны 26 дугаар тогтоолын дагуу хянан шалгах түр хороотой холбоотойгоор засаглалын хяналт-тэнцлийг хангах нөхцөл байдлаас шалтгаалж байна.

Тус асуудлын хүрээнд гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг бий болгох цар хүрээг “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын эрх зүйн орчныг бий болгох буюу тусгайлан хуульчилж хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, засаглалын хяналт-тэнцлийг хангах” гэж тодорхойлов.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох¹²

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Хүснэгт 2.2. Эрх ашиг нь хөндөгдөж буй бүлэг /Нөлөөллийн хэлбэр/

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд болох тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гүйцэтгэх алба, авлигатай тэмцэх газар, цэргийн тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих гадаад хяналт хангалтгүй байгаа ба Улсын Их Хурлын холбогдох Байнгын, дэд, хянан шалгах хороодоос гүйцэтгэх ажилд хяналт тавьснаар үйл ажиллагаа чанаржиж, хүний эрхэд суурилсан, хуулийг дээдэлсэн хандлага төлөвшинэ.
2	Гүйцэтгэх ажилд өртөгдөж буй хувь хүн, хуулийн этгээд	Гүйцэтгэх ажил нь нууцаар болон илээр явагддаг мэдээлэл олзворлох үйл ажиллагаа бөгөөд хувь хүн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөнд зайлшгүй шаардлагаар, холбогдох хууль болон эрх зүйн бусад актад заасан үндэслэл, журмын дагуу халдаж, хязгаарладаг. Улсын Их Хурлын холбогдох Байнгын, дэд, хянан шалгах хороодоос гүйцэтгэх ажилд хяналт тавьснаар дээрх хязгаарлалтад хөндлөнгөөс хяналт тавих боломж бүрдэж хувь хүн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хамгаална.

12 Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор тусгасан. Энэхүү судалгааны хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах оролцогчид болон хүн ам зэргээр эрх ашиг нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

3	Улсын Их Хурал	<p>Улсын Их Хурал болон түүний байнгын, дэд болон хянан шалгах түр хороо нь гүйцэтгэх ажилд хангалттай хяналт тавьж чадахгүй тохиолдолд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, засаглалын хяналт-тэнцэл хангагдахгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй. Тагнуулын албад засгийн газрын харьяа бусад байгууллагаас эрс ялгаатай тул парламент тагнуулын албадын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлтийг тухай бүр оруулж байх зорилго бүхий тусгай хороо байгуулан ажиллуулах жишиг бий. Эдгээр хороод нь мэдээлэл олзворлолт буюу гүйцэтгэх ажилтай холбоотой дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тусгай арга хэрэгслийн ашиглалтад хяналт тавих; - Төсвийн үйл ажиллагаа, зарцуулалтад хяналт тавих; - Хууль, эрх зүйн зохицуулалт нь хүний эрхийг хангалттай хамгаалж чадаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих; - Тагнуулын албад хууль тогтоомжийг сахин мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих.¹³
4	Гүйцэтгэх байгууллагын ажилтан	Гүйцэтгэх байгууллагын ажилтан болох гүйцэтгэх ажилтан, нууц гүйцэтгэх ажилтан, туслах ажилтан, туслагчийн үйл ажиллагаанд тавих хяналтад дотоодын буюу байгууллагын удирдлагын хяналт давамгайлж байгаа бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын, дэд, хянан шалгах түр хороодоос хяналт тавьдаг болсноор гадаад хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, зөрчлийг шийдвэрлэх боломж нэмэгдэнэ.
5	Гүйцэтгэх ажилд хяналт тавих бусад субъектүүд	Гүйцэтгэх ажилд хяналт тавих бусад субъектүүдийн үйл ажиллагаанд ямар нэг өөрчлөлт орохгүй ба Улсын Их Хурлын холбогдох Байнгын, дэд, хянан шалгах хороодоос гүйцэтгэх ажилд тавих хяналт тодорхой болсноор хяналтын үр дүн, хамрах хүрээ, давтамжийг илүү сайжруулна.
6	Хүн ам	Гүйцэтгэх ажлын явцад хувь хүн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх, засаглалын хяналт-тэнцэл алдагдсанаар Монгол Улсын нийт хүн амын эрх, эрх чөлөө, эрх ашиг хөндөгдөж болзошгүй. Улсын Их Хурал, түүний холбогдох Байнгын, дэд, хянан шалгах хороодоос гүйцэтгэх ажилд хяналт тавьснаар нийт хүн амын эрх, эрх чөлөө, эрх ашгийг болон ардчиллын суурь үнэт зүйлийг хамгаална.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Энэ хэсэгт гүйцэтгэх ажилд тавих хяналт, түүнд хамаарах асуудлын шалтгаан нөхцөл болон Улсын Их Хурлаас гүйцэтгэх ажилд тавих хяналтын ач холбогдлын талаар судлан үзэх болно.

Монгол Улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлт, шинэчлэлийн нэн чухал ололтын нэг нь хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ утгаар хангах эрх зүйн баталгааг бий болгосон явдал юм. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн ... халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцаан нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” хэмээн заасан билээ. Гэхдээ “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ Үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн дэг журмыг гажуудуулж болохгүй”. Мөн Үндсэн хуульд зааснаар “... үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”.

¹³ Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 139 дэх тал.

Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг зорилгоор эрүүгийн тагнуулын үйл ажиллагаа эрхэлдэг гүйцэтгэх байгууллагууд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа иргэдийн эрх, эрх чөлөөг хуульд заасны дагуу түр хязгаарлах нь үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах шаардлагаас урган гарч байгаа гарцаагүй үйлдэл гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах талаарх тодорхой зорилтыг холбогдох хуульд зааснаас өөр арга, хэрэгслийг ашиглан хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд л хүний эрх, эрх чөлөөнд ихэвчлэн нууцаар түр хязгаарлалт хийхэд хүрдэг тагнуулын буюу гүйцэтгэх ажлын арга хэмжээг хэрэглэнэ.¹⁴

Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар тэдгээр арга хэмжээнүүдийг зөвхөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд зохиовол прокурорын зөвшөөрөл авах тул анхны мэдээ олох, шалгах, гүйцэтгэх ажлын хэрэг шалгах шатанд тэдгээр арга хэмжээг зохиох ажиллагаа гадаад хяналтгүйгээр явагдаж байгаа билээ. Гэтэл гүйцэтгэх ажилтнууд гүйцэтгэх ажлын хэрэг, мэдээ шалгахад мэдээллийн нууц эх сурвалж болон бусад бололцоог ашиглахын оронд амар хялбарыг бодож, техникийн хяналт болон нууц ажиглалтыг ашиглах явдал хавтгайрч болзошгүй байгааг тагнуулын буюу гүйцэтгэх ажил эрхэлж буй байгууллагуудын практик харуулж байна. Энэ нь тагнуулын буюу гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хангах зарчмын мөн чанар, хүний эрх, эрх чөлөөг түр хязгаарлах тагнуулын аливаа арга хэмжээг зөвхөн зайлшгүй шаардлагаар, холбогдох хууль болон эрх зүйн бусад актад заасан үндэслэл, журмын дагуу явуулах шаардлагыг ноцтой зөрчихөд хүргэж болох юм.

Энэхүү зохисгүй байдлын нэг шалтгаан нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас өмнө дээрх арга хэмжээг явуулах үед гадаад хяналт байхгүйтэй холбоотой. Иймд дээр дурдсан тагнуулын аргуудыг ямар шатанд хэрэглэхийг үл харгалзан гадаад хяналт тавьдаг болгох нь зүйтэй. Ардчилал хөгжсөн орнуудад дээрх арга хэмжээг эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаах шатанд буюу түүнээс өмнө явуулахыг үл харгалзан прокурор буюу шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжүүлж хэвшсэн байна.

Түүнчлэн, гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажилд ил болон нууц арга, хэрэгслийг хослуулах зарчим үйлчилдэг. Энэ нь гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагуудын үүрэг, зорилт, үйл ажиллагааны онцлогтой холбоотой зөвхөн тухайн салбарын зарчим юм.

Хүснэгт 2.3. Ил болон нууц арга, хэрэгсэл

	<p>Тагнуулын үйл ажиллагаа буюу гүйцэтгэх ажил нь хэдийгээр нууцаар явагддаг ч гэсэн түүнийг бий болгож, ашиглаж ирсэн өмнөх түүхээс үзвэл уг үйл ажиллагааны нийтлэг зорилго, зорилт, хүч, арга, хэрэгсэл үндсэндээ ойролцоо буюу ижил байв. Гэхдээ түүнийг ашиглаж ирсэн зорилго нь тухайн үеийн нийгэм, улс төрийн тогтолцоо, эрх баригч бүлгийн улс төрийн бодлого, үйл ажиллагаа, улс төрийн дэглэм, гадаад, дотоод нөхцөл байдал, уламжлал гэх мэт олон хүчин зүйлийн улмаас харилцан адилгүй байсан.</p>
--	---

14 М.Цогтоо, Ц.Очгэрэл нар, *Гүйцэтгэх ажлын удирдахуй*, (Уб, 2021), 67-68 дахь тал.

Ил арга, хэрэгсэл	<p>Эдгээр нөхцөл байдлыг харгалзан тагнуулын үйл ажиллагааг хуулиар зохицуулахаар оролдож эхэлсэн бөгөөд эдүгээ дэлхийн цөөнгүй улс орон тухайн үйл ажиллагааг хуульчлаад байна. Тагнуулын үйл ажиллагааг хуульчлахдаа түүний зорилго, зорилт, зарчим, тагнуулын буюу гүйцэтгэх ажлын арга хэмжээ, тэдгээрийг явуулах үндэслэл, тусгай албадын чиг үүрэг, эрх, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналт зэрэг нийтлэг асуудлыг тусгаж байна. Ийнхүү тагнуулын буюу гүйцэтгэх үйл ажиллагааг зохих хэмжээгээр олон нийтэд ил, нээлттэй болгон хуульчилсан нь дээрх зарчмын агуулгын хоёр дахь тал буюу ил арга, хэрэгслийг ашиглах үндсэн хэсэг бөгөөд томоохон ололт байв. Тухайн зарчмын бас нэг чухал зүйл бол иргэд, байгууллагын санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шалгах болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэл зэрэг ил эх сурвалжийн мэдээллийг тагнуулын буюу гүйцэтгэх үйл ажиллагаанд ашиглах явдал юм.</p> <p>Ил арга, хэрэгслийг үр дүнтэй ашиглахын тулд аль ч гүйцэтгэх байгууллагын ажилтнууд үйл ажиллагаандаа нууцлалыг чанд хадгалахын зэрэгцээ ажлын үр дүн, ололт амжилт болон байгууллагынхаа үүрэг, зорилттой холбоотой бөгөөд байгууллага, иргэдийн анхаарах асуудлын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх тухай саналаа холбогдох журмын дагуу удирдлагадаа танилцуулан шийдвэрлүүлж, Хэвлэл, мэдээллийн албандаа хандах зэргээр идэвх санаачилга гаргаж ажиллах нь чухал байдаг. Гэхдээ гүйцэтгэх байгууллагаас олон нийтэд хандаж хийх аливаа арга хэмжээнд шалгагдаж, нотлогдоогүй, буруу ташаа, үүрэг зорилтдоо үл хамаарах мэдээлэл ашиглах нь олон нийтийг өөртөө татах биш, харин түлхэх аюултайг санах ёстой.</p>
Нууц арга, хэрэгсэл	<p>Тагнуул гэдэг үгийн гол утга нь өмнө тэмдэглэсэнчлэн "...нууц аргаар мэдэх, мэдээлэх..." явдал. Тиймээс бусдын нууцалж байгаа аливаа зүйлийг нууц аргаар мэдэх, мэдээлэхийн тулд түүнд ямар хүч, арга, мэх, хэрэгсэл ашиглах, тэдгээрийг чухам хэзээ, хаана, хэрхэн хэрэглэхээ нууцлах шаардлагатай болно. Чухам үүнд тагнуулын буюу гүйцэтгэх ажлын мөн чанар оршино.</p> <p>Тийнхүү энэ зарчмын агуулгын эхний хэсэг нь тагнуулын буюу гүйцэтгэх ажил нь нууц хүч, арга, хэрэгслийг нууцаар ашигладагтай холбоотой юм. Нууц арга, хэрэгслийг ил арга, хэрэгсэлтэй хослуулан ашиглахдаа зөвхөн өөрийн нууц арга, хэрэгслийн нууцлал, аюулгүй байдлыг хангаад зогсохгүй тагнуулын буюу гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиох явцад хүний эрх, эрх чөлөөнд халдах, гүйцэтгэх байгууллага, ажилтанд тодорхой болсон, бусад байгууллагын болон хувь хүний нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах ёсгүй. Хуульд энэ тухай заахдаа "Гүйцэтгэх ажлын явцад хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хүний эрх, эрх чөлөөг зөрчих, ... хуульд зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх ажлын явцад олсон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахыг хориглоно" гэжээ.¹⁵</p>

Иймд уг үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө ил болон нууц байдлаар зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүсдэг. Хүний эрх, эрх чөлөөг тусгай албадын хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахад тэдгээрийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, ялангуяа Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас өөрийн бүтэц дэх нэгж, албан тушаалтнуудаараа дамжуулан тавих хяналт онцгой ач холбогдолтой юм.¹⁶ Иймд гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурал буюу парламентын хяналтын ач холбогдлыг судлан үзье.

Тагнуулын буюу гүйцэтгэх ажлын хяналт¹⁷ нь тагнуулын албадын үйл ажиллагааны зүй зохистой болон хууль ёсны байдалд анхаарал хандуулахаас

¹⁵ М.Цогтоо, Ц.Очгэрэл нар, *Гүйцэтгэх ажлын удирдахуй*, (УБ, 2021), 75-77 дахь тал.

¹⁶ Мөн тэнд, 67-68 дахь тал.

¹⁷ Oversight буюу хяналт нь экс антэ /үйлдлээс өмнөх/ хяналт, тогтмол мониторинг, экс пост /үйлдлийн дараах/ шалгалт, түүнчлэн үнэлгээ, хянан шалгах үйл ажиллагааг хамарсан цогц ойлголт юм. Энэхүү цогц хяналтыг тагнуулын албадын удирдлага, гүйцэтгэх засаглалын албан тушаалтнууд, шүүгчид, парламентын гишүүд, омбудсмэний болон аудитын байгууллагууд, мэргэшсэн хяналтын байгууллагуудаас гадна сэтгүүлчид, иргэний нийгмийн төлөөлөл хэрэгжүүлдэг.

гадна үр нөлөө болон үр дүнг анхаардаг. Зүй зохистой гэдэгт тагнуулын албаны үйлдэл, үйл ажиллагаа ёс суртахууны хувьд зөв зүйтэй эсэхийг хамааруулдаг бол хууль ёсны гэдэгт тагнуулын байгууллага үйл ажиллагаандаа холбогдох хуулийг сахин биелүүлж байгаа эсэхийг ойлгоно. Үр нөлөөтэй гэдэгт тагнуулын алба тавьсан зорилгодоо хүрч ажиллаж байгаа эсэхийг, үр дүнтэй гэдэгт эдгээр зорилгыг хэрэгжүүлэхдээ тагнуулын алба эдийн засгийн хувьд хэр ашигтай хувилбарыг сонгож чадсаныг ойлгодог.¹⁸

Тагнуулын үр дүнтэй хяналт нь зөвхөн төрийн холбогдох байгууллагуудын уялдаа холбоотой үйл ажиллагааг шаардах бус, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг мөн адил шаардана. Эдгээрийн бүгдийнх нь үүрэг оролцоо чухал хэдий ч парламентын болон хөндлөнгийн мэргэшсэн хяналтын байгууллагуудад илүүтэй анхаарал хандуулсан. Учир нь эдгээр байгууллага тагнуулын албад болон гүйцэтгэх засаглалын аль алианаас хараат бус бөгөөд ардчилсан хариуцлагатай байдлыг бие даан хангуулж, хуулийн засаглал, хүний эрхийг дээдлэхэд тохиромжтой байдаг.

Парламентын болон хөндлөнгийн мэргэшсэн хяналтын байгууллагууд дараах хяналтыг хэрэгжүүлдэг.

- Тагнуулын албад, тэдгээрийн хяналтын хууль, эрх зүйн цогц зохицуулалтыг батлах, шаардлагатай тохиолдолд өөрчлөх;
- Тагнуулын албадын үйл ажиллагааны зүй зохистой, хуулийн дагуу, үр дүн, үр нөлөөтэй байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;
- Тагнуулын албадын төсвийг батлах, хянах.¹⁹

Тагнуулын хяналтын тогтолцоонд гүйцэтгэх засаглалын хяналтыг бий болгож бэхжүүлэх нь чухал хэдий ч парламентын болон хөндлөнгийн байгууллагын бие даасан хяналт түүнтэй адил ач холбогдолтой. Тагнуулын үйл ажиллагааны нууцлал, шүүхийн хяналт шалгалтаас ангид байдал, хүний эрхэд халдах тусгай арга хэрэгсэл ашиглах эрх, өмнө нь тагнуулын байгууллагатай холбоотой гарч байсан алдаа дутагдал зэргийг харгалзан үзвэл төрийн эрх барьж буй Засгийн газраас хараат бус хяналтын байгууллагууд оршин байхын ач холбогдол тод харагдана.

ОУПХ, ЗХАХТЖТ-өөс хамтран гаргасан “Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт” гарын авлагад гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажил болон бусад аюулгүй байдлын салбарт парламентын хяналт байх нь онцгой ач холбогдолтой талаар дурдсан байдаг.

18 Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 28 дахь тал.

19 Мөн тэнд, 29-30 дахь тал.

Шигтгээ 1.

Гүйцэтгэх засагт аюулгүй байдлын бодлого боловсруулахад шаардлагатай мэдлэг, түргэн шуурхай ажиллах боломж байдаг тул энэ нь тэдний зүй ёсны ажил үүрэг мөн. Харин парламентын үйл ажиллагаа их хугацаа зарцуулдаг, шаардлагатай мэдээлэл, ойлголт хомс учир аюулгүй байдлын асуудлуудыг хариуцахад тохиромж багатай гэж үзэх нь олонтаа. Гэсэн хэдий ч бүхий л салбарын нэгэн адил аюулгүй байдлын салбарт ч Засгийн газрыг хянах эрхийг парламент эдэлдэг. Парламентын хяналт яагаад ийм чухал болохыг нотлох дор хаяж дараах дөрвөн үндэслэл бий:

Дарангуйллаас сэргийлэх нь ардчиллын тулгын чулуу

Францын Ерөнхий сайд асан Жорж Клемансо нэгэнтээ “Дайныг зөвхөн цэргийнхний мэдэлд үлдээхэд дэндүү чухалдана” гэж хэлсэн нь бий. Эл ёжтой үгний цаана, ардчилсан нийгэмд ард түмний төлөөлөл төрийн дээд эрхийг эдлэх ёстой агаад аль ч салбар тэдний хараа хяналтаас гадуур орших ёсгүй гэсэн санаа оршино. Аюулгүй байдлын салбар, тэр дундаа цэргийн асуудлаар парламентын хяналт тогтоогоогүй улсыг сайндаа л бүрэн бус ардчилал, эсвэл бүрэлдэн тогтож буй ардчилал гэвээс зохилтой.

“Улс төрд хамгийн язгуур, амин чухал асуудал бол дарангуйллаас зайлсхийх явдал юм” гэж Америкийн нэрт судлаач Роберт А.Даль хэлжээ. Аюулгүй байдлыг хангах нь төрийн язгуур зорилтуудын нэг. Үүнээс үүдэн гүйцэтгэх засгийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх хараа хяналт, шалгалтын механизм зайлшгүй хэрэгтэй. Тийм ч учир аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт нь төрийн түвшин дэх эрх мэдлийн хуваарилалтын нэг чухал элемент бөгөөд үүнийг үр дүнтэй хэрэгжүүлсэн тохиолдолд засгийн газар эсвэл ерөнхийлөгчийн эрх мэдэлд зохистой хязгаарлалтыг тогтоож байна.

Төлөөллийн оролцоогүй татвар ноогдуулалт гэж үгүй

Парламентаас гүйцэтгэх засгийг хянах хамгийн чухал арга хэрэгсэл бол төсөв. Баруун Европт анх үүссэн цагаасаа эхлээд парламент бодлогын түвшинд оролцох эрхээ шаардсаар ирсэн бөгөөд ингэхдээ “Ард түмний төлөөллийн оролцоогүй татвар ноогдуулалт гэж үгүй” гэсэн зарчим дээр хатуу зогсож байв. Улсын төсвийн үлэмж хэсгийг аюулгүй байдлын салбарт зарцуулдаг тул улс орны хомсхон нөөц хөрөнгийг оновчтой, үр дүнтэй зарцуулж байгаа нь парламентын зүгээс хяналт тавих нь нэн чухал.

Аюулгүй байдлын асуудлын хууль зүйн цар хүрээг тодорхойлох

Бодит амьдрал дээр аюулгүй байдлын асуудлаарх хуулийн төслийг Засгийн газар боловсруулдаг. Гэхдээ парламентын гишүүд тэрхүү төслийг хянан засварлахад чухал үүрэгтэй оролцдог бөгөөд шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын шинэ сэтгэлгээ, үзэл баримтлалыг зохистойгоор тусгасан заалтуудыг баталгаажуулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг санал болгодог. Түүнээс гадна батлагдсан хууль тогтоомж зөвхөн цаас төдий үлдэх бус харин амьдрал дээр бүрэн хэрэгжихэд парламентын үүрэг оролцоо маш чухал.

Ард түмэнтэй холбох гүүр

Ард иргэдийн хувьд тэргүүлэх ач холбогдолтой аюулгүй байдлын бүх асуудлыг гүйцэтгэх засаг бүрэн дүүрэн мэдэхгүй байж болно. Харин парламентын гишүүд иргэдтэй байнгын харилцаа холбоотой байдгийн хувьд тэдний санаа бодлыг илүү ойлгож мэдрэх боломжтой. Өөрөөр хэлбэл, парламентын гишүүд иргэдийн санал, зовнилыг парламентын танхимд хэлэлцэж, аюулгүй байдлын бодлого, хууль тогтоомжуудад тусгах арга замуудыг эрэлхийлдэг.²⁰

Төрийн бусад цэрэгжсэн байгууллага иргэний цагдаагийн ажиллагаанд тохиромжгүй цэргийн арга техник ашигласан болон хүний эрхийг ноцтой зөрчсөн тохиолдол хэд хэд гарч байсан. Эдгээр байгууллагын хувьд иргэний цагдаагийн чиг үүрэг, цэргийн чиг үүрэг хоорондын зааг ялгаа бүдэг байдаг учир гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг нь урьдчилж нарийн тодорхойлсон байх ёстой. Ихэнх тохиолдолд дотоодын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тэднийг оролцуулахгүй байх нь зүйтэй. Энэ талаар парламент шаардлагатай хууль тогтоомжийг батлахын зэрэгцээ, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих ёстой. Нөгөө талаас Ерөнхийлөгч

20 Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014), 21-22 дахь тал.

буюу Ерөнхий сайд нь төрөөс санхүүжүүлж буй бүх хүчин парламентын хяналтад багтах ёстой гэсэн шалтгаанаас гадна, төрийн бусад цэрэгжсэн байгууллагын үйл ажиллагаа хяналтгүйгээр өргөн хүрээг хамарсан тохиолдолд үүсэх эрсдэл, аюул заналаас урьдчилан сэргийлэх үүднээс эдгээр байгууллагад парламентаас тавих хяналтыг дэмжих нь зүйтэй.²¹

Тагнуулын албад (“аюулгүй байдлын алба”) нь ямар ч улсын үндсэн нэгж бөгөөд тухайн улсын аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хамгаалахтай холбоотой мэдээллийг аливаа нөлөөллөөс ангид боловсруулан, дүн шинжилгээ хийж нийлүүлэх үүрэгтэй байдаг. Тэдгээр байгууллагын гол үйл ажиллагааг Засгийн газар хариуцдаг хэдий ч түүнд нь хяналт тавих чухал үүргийг парламент гүйцэтгэдэг.

Ардчилсан орны тагнуулын алба нь үйл ажиллагааны үр дүн өндөртэй, улс төрийн хувьд төвийг сахисан, мэргэжлийн ёс зүйг баримталдаг, хуулиар олгосон эрх хэмжээ болон тухайн улсынхаа үндсэн хуулийн хэм хэмжээ, ардчилсан зарчмуудын хүрээнд ажиллах ёстой. Тагнуулын бүтцэд тавих ардчилсан хяналт нь хуулийн хүрээнд нарийн тодорхой зохицуулагдсан байхын зэрэгцээ улсын хэмжээнд тагнуулын байгууллага шинээр байгуулах эсэхийг парламент шийдвэрлэдэг байх ёстой.

Ихэнх орнуудад албан ёсны хяналтыг парламентын хяналтын хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг. Зарим тохиолдолд батлан хамгаалах, зэвсэгт хүчний асуудал хариуцсан парламентын хороодын чиг үүрэгт тагнуулын хяналтыг багтаахаар өргөтгөсөн байдаг бол бусад оронд парламентын хороо буюу дэд хороог тусгайлан байгуулж, тагнуул, нууц албадын хяналтыг хариуцуулдаг.

Парламентын хяналтын хороод нь шаардлагатай мэдээлэлтэй танилцах, тагнуулын байгууллагын удирдлагын томилгоонд оролцох, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх эрхээр хангагдсан байх ёстой.

Мөн зарим оронд парламентын хороо байхгүй тохиолдолд эсвэл түүнтэй зэрэгцүүлэн Засгийн газрын бүтцээс гадна орших тагнуулын хяналтын хороог албан ёсоор байгуулдаг байна. Засгийн газрын түвшинд тагнуулын албадад хяналт тавих үүрэгтэй нэгжүүд нь улс төрийн олон талт төлөөллөөс бүрдсэн парламентын хороодыг бодвол бие даасан, хараат бус байдал харьцангуй бага байдаг.²²

Ерөнхийдөө парламентын хяналтын хороо болон хөндлөнгийн хяналтын байгууллагыг хяналтын хамгийн үр дүнтэй хэлбэр гэж үздэг. Парламентын хяналтын хороог өргөн хүрээтэй чиг үүрэг бүхий ерөнхий хороо (батлан хамгаалах, гадаад хэргийн асуудал эрхэлсэн байнгын хороо г.м) болон тагнуулын асуудлаар дагнасан тусгай хороо хэмээн ангилж болно. Хэдийгээр парламентын бусад хороо (ялангуяа төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн) тагнуулын хяналттай холбоотой зарим нэг үүрэг хүлээдэг ч тагнуулын хяналтыг голлон хэрэгжүүлэгч нь хяналтын тусгай хороо байдаг. Учир нь тусгай хорооны гишүүдийн мэргэшил, туршлага харьцангуй өндөр байхаас гадна нууц мэдээлэлтэй парламентын нийт гишүүд бус, зөвхөн тус хорооны гишүүд танилцах эрхтэй байдаг тул мэдээллийн аюулгүй байдлын үүднээс хамгийн тохиромжтой хувилбар гэж үздэг байна.²³

21 Мөн тэнд, 69 дэх тал.

22 Мөн тэнд, 78 дахь тал.

23 Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 34 дэх тал.

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын тусгай хяналт

Парламентын хороод нь хууль тогтоох ажилд тодорхой үүрэг гүйцэтгэхээс гадна Засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавихад оролцдог. Хяналтыг хэрэгжүүлэхдээ мэдээлэл цуглуулах үүрэг бүхий түр бүтэц байгуулна. Үүнд нэг буюу түүнээс дээш хороод хамтран оролцох бөгөөд ажлын тайланг нийтлэн гаргана. Парламентын тусгай хяналт нь шүүхийн хяналттай адил заавал мөрдөгдөх ёстой. Тусгай хяналтын хороодын үндсэн шинж болон давуу талууд:

Аюулгүй байдал/батлан хамгаалахын асуудлаарх түр хороо онцгой ач холбогдолтой бөгөөд давуу тал ихтэй. Тухайлбал,

- Ийм хороог байгуулж буй нь олон нийтийн хувьд улс төрийн эерэг үзэгдэлд тооцогдоно;
- Аюулгүй байдлын салбартай холбоотой, улс төрийн хувьд эмзэг асуудлуудад хяналт тавихад хамгийн тохиромжтой хэрэгсэл;
- Уг хороод аюулгүй байдлын тодорхой асуудлаарх Засгийн газрын бодлогыг үнэн зөвөөр үнэлж, шаардлагатай үед парламентын нийт танхим болон Засгийн газрын аль аль нь хүлээн авахуйц засаж залруулах арга хэмжээ санал болгох боломжийг олгоно.

Тусгай хяналтын хороодын хувьд өөр нэг чухал асуудал бол бүтэц, эрх баригч намын болон сөрөг хүчний гишүүдийн тооны харьцаа нь тухайн хяналтын үр дүнд онц чухал ач холбогдолтой.

Тухайн улсын парламент, хороодын чиглэлээс хамаарч уг хяналтын эрх хэмжээ харилцан адилгүй байдаг. Эдгээрээс хамгийн чухлыг нь дурдвал:

- Парламентын тусгай хяналтын сэдэв, хамрах хүрээг тодорхойлох;
- Армийн анги нэгтгэл болон аюулгүй байдлын бусад байгууламжид очиж танилцах;
- Ерөнхийлөгч, Засгийн газар, Зэвсэгт хүчний жанжин штаб зэргээс нууц, маш нууц зэрэглэлийг оролцуулан бүх мэдээллийг гаргуулж авах;
- Ерөнхийлөгч, Засгийн газар, цэргийн албан тушаалтнууд болон иргэний нийгмийн төлөөллөөс тангараг өргүүлсний үндсэн дээр баримт мэдүүлэг авах;
- Нээлттэй болон хаалттай сонсгол хийх.

Хяналт шалгалтын хороодыг тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор өргөн хэрэглэдэг. Энэ зорилгын хүрээнд парламентаас өөрийн хяналтын үүргийг зохистойгоор гүйцэтгэх, тухайн асуудлаар үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд чуулганаар хэлэлцүүлж шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл цуглуулах үүргийг тодорхой тооны гишүүдэд өгдөг. Тусгай хяналт шалгалт хийх эрх нь гүйцэтгэх засгийн үйл ажиллагааны аливаа асуудлын талаар бүрэн мэдээлэлтэй байх зарчмаас үүдэлтэй.

Зарим оронд хяналт шалгалтын хороодоос үр дүнтэй ажиллагаа явуулахад хүндрэл учирдаг. Учир нь уг хороод холбогдох албан тушаалтныг тусгай хяналтын асуулгад оролцохыг шаардах эрх байдаггүй тул шийдвэр гаргуулахаар шүүхэд

хандахаас өөр аргагүй болдог. Ингэснээр уг асуудал засгийн газар оролцож, хорооны үйл ажиллагааг удаашруулан асуулгын үр нөлөөг бууруулдаг байна.

Төрийн албан хаагчдаас баримт мэдүүлэг авахад тулгардаг гол асуудал нь тэд тухайн чиглэл хариуцсан сайдын удирдлагад ажилладагт оршино. Учир нь зарим оронд төрийн албан хаагч мэдүүлэг өгөхийн тулд холбогдох яамнаасаа зөвшөөрөл авах ёстой байдаг. Гэхдээ шаардсан мэдээлэл нь “улсын аюулгүй байдалд хамааралтай, эсвэл төрийн албыг хэрэгжүүлэхэд эрсдэл, хүндрэл учруулах” аюултай гэдгийг тогтоогоогүй л бол нуун дарагдуулахыг хориглоно.

Тогтолцооны хэлбэрээс үл хамааран, парламентаас үүсгэн байгуулсан энэхүү хороо бол парламентын танхимд тайлагнах үүрэг бүхий зөвхөн судалгаа, баримт цуглуулах зориулалттай бүтэц гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тус хорооноос гаргаж өгсөн тайлан, мэдээлэлд үндэслэн холбогдох дүгнэлт хийх нь харин парламентын танхимын өөрийнх нь асуудал юм.²⁴

Дээрхээс дүгнэвэл, гүйцэтгэх засаглалд хамаарах гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажилд Улсын Их Хурал хяналт тавих нь онцгой ач холбогдолтой, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, ардчиллын үнэт зүйл, хууль дээдлэх ёсонд нийцсэн ба тусгай хяналтыг парламентын тусгай хороо гүйцэтгэх нь үр дүнтэй байна. Монгол Улсын хувьд ч гүйцэтгэх ажилд Улсын Их Хурлын хяналтыг дээрх байдлаар тавих шаардлагатай ба хянан шалгах тусгай хороо хяналт тавьж Улсын Их Хуралд тайлагнах боломжтой байна.

Парламентын хяналт шалгалтыг гүйцэтгэж байгаа субъектээр нь парламент бүхэлдээ буюу түүний бүтцийн нэгж /Байнгын, түр болон дэд хороо/-ээр хэрэгжүүлэх хяналт шалгалт, парламентын гишүүний хэрэгжүүлэх хяналт шалгалт, парламентын бүтцэд ордоггүй хараат бус байгууллага /Төрийн аудит, Хүний эрхийн Үндэсний Комисс, Санхүүгийн зохицуулах хороо, Төв банк гэх мэт/-аар дамжуулан гүйцэтгүүлэх хяналт шалгалт гэж ангилан үздэг.²⁵

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1.8-д зааснаар “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавих” нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаардаг. Үүнтэй холбоотойгоор 2019 оны 11 дүгээр сарын 14-ний Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 28 дугаар зүйлийн 2-ийг “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж өөрчлөн найруулсан байна.

2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсан. Тус хуулиар Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд тавих Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулжээ.

24 Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014), 100-101 дэх тал.

25 Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал”, Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил /Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/, (УБ, 2010), 67 дахь тал.

Энэ хуулийн 7 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоог байнгын, дэд болон хянан шалгах түр хороо нь Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Эдгээрийг тус бүрд нь авч үзье.

Хүснэгт 2.4. Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо

Байнгын хороо	Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлынхаа ²⁶ хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах, эсхүл хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дангаар болон хамтран байгуулна. Байнгын хороо хяналт шалгалтын үр дүнд үндэслэн холбогдох санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.
Дэд хороо	Дэд хороо тухайн эрхэлсэн асуудлаараа хяналт шалгалт, судалгаа хийх, шаардлагатай мэдээлэл авах, холбогдох албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авч, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй. 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан “Монгол Улсын Их Хурлын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д “Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг” гэж зааснаар Тусгай хяналтын дэд хороо нь гүйцэтгэх ажлын талаар хяналт хэрэгжүүлдэг байна.
Хянан шалгах түр хороо	Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог заавал байгуулна. Хянан шалгах түр хороо нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар хянан шалгаж, дүнг тогтоосон хугацаанд УИХ-д тайлагнах үүрэгтэй. УИХ-д тогтоолын төсөл өргөн мэдүүлэх бөгөөд тогтоолын төсөлд хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана.

26 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т зааснаар дараах байнгын хороодтой байна:

- Аюулгүй байдал, гадаад бодлогын;
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын;
- Ёс зүй, сахилга хариуцлагын;
- Инновац, цахим бодлогын;
- Нийгмийн бодлогын;
- Төрийн байгуулалтын;
- Төсвийн;
- Үйлдвэржилтийн бодлогын;
- Хууль зүйн;
- Эдийн засгийн.

	<p>Өнөөдрийн байдлаар нийтдээ тус хууль батлагдсанаас хойш Улсын Их Хурлаас 5 удаа Хянан шалгах түр хороог байгуулсан байна. Тухайлбал, 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо²⁷, 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо²⁸, 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо²⁹, 2023 оны 06 дугаар сарын 30-ны 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо³⁰, 2023 оны 07 дугаар 06-ны өдөр 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо³¹ тус тус байна.</p>
--	---

Мөн Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг улс орон даяар нээлттэй зохион байгуулах явцад гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох дараах практик шаардлага байна гэж үзсэн. Үүнд:

-Улсын Их Хурлын гүйцэтгэх ажилд тавих хяналтын хүрээ, хязгаар, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, боловсронгуй болгох;

-Улсын Их Хурлын гишүүд гүйцэтгэх албадын мөрдөн шалгах үйл ажиллагаанд хяналт тавих замаар уг ажиллагаанд хэт их оролцох эрсдэлийг хаах, гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих бүрэн эрхийн зааг ялгааг тодорхой болгох;

-Гүйцэтгэх ажиллагаа явуулдаг байгууллагуудын хяналт, тэнцлийг хангаж, тэнцвэртэй, хяналттай төрийн үйл ажиллагааг бий болгох;

Дээрхээс нэгтгэн дүгнэвэл, аюулгүй байдлын салбар, тэр дундаа төрийн бусад цэрэгжсэн байгууллага, тусгай байгууллагын гүйцэтгэх ажилд парламент үр дүнтэй хяналт тавьж чадвал гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөө хамгаалагдах, засаглалын хяналт-тэнцэл хангагдах нөхцөл байдал сайжрах эерэг үр дүн гарахаар байна. Ийнхүү хяналт тавихдаа парламентаас тусгай хяналтыг тусгай хороогоор хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна. Монгол Улсын хувьд Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу болон дээрх ач холбогдлоос шалтгаалан гүйцэтгэх ажилд Улсын Их Хурал байнгын, дэд болон хянан шалгах түр хороогоор дамжуулан хяналт тавих зайлшгүй шаардлага бий болж байна.

27 Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлаар.

28 Хүний эмийн чанарын асуудлаар.

29 Монгол Улсын 2022 онд төлөвлөсөн 18.0 сая тонн нүүрс экспортлохоос 2022 оны эхний 4 сарын байдлаар 3.8 сая тонн нүүрс экспортолж, төлөвлөж байсан экспорт саатаж, нүүрсний экспортоос улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн 1.3 их наяд төгрөгийн орлого тасалдах нөхцөл байдал үүссэнийг, түүнчлэн Монгол Улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн зардал хэт өссөн, үүнтэй холбогдон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг тогтоох асуудлаар.

30 Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар.

31 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий.

II. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрлэх зорилгыг тодорхойлж байна.

Зорилго: “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчилж гүйцэтгэх ажлын хууль ёсны, эрх, эрх чөлөөг дээдэлсэн байдал, засаглалын хяналт-тэнцлийг сайжруулах”

Аргачлалын 4.1-д заасны дагуу зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байдлаар томьёолох хэрэгтэй юм. Бидний тодорхойлсон зорилгын тухайд гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлох хуульчлах шаардлагыг тооцоолох боломжтой байгаа нь тус зорилгыг тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байгааг харуулж байна. Мөн тус зорилго нь аргачлалын 4.2-т заасан ерөнхий зорилгод хамаарах бөгөөд тодорхой тоо, хувь хэмжээ заагаагүй зөвхөн гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах шаардлагатай эсэхэд хариу өгөх зорилготой юм.

Аргачлалын 4.3-т заасны дагуу хэрвээ зорилгыг ерөнхий байдлаар тогтоосон тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх зорилт байгаа эсэхийг судлах нь зүйтэй байдаг. Тус зорилгын хүрээнд зорилтуудыг тодорхойлж болохоор байна. Тухайлбал, гүйцэтгэх ажлын явцад эрх, эрх чөлөө зөрчигдөх, засаглалын хяналт-тэнцлийг хангахад хүндрэл бэрхшээл үүсэж байгаа эсэх, үүнийг нарийвчлан зохицуулж, парламентын тусгай хороодоор хянуулснаар тухайн бэрхшээл алга болох эсэх, эрх зүйн болон бодит шаардлага бий эсэх, энэ талаар тухайлсан хуулийг батлах шаардлагатай эсэх гэсэн зорилтуудыг агуулж байна.

III. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчилж гүйцэтгэх ажлын хууль ёсны, эрх, эрх чөлөөг дээдэлсэн байдал, засаглалын хяналт-тэнцлийг сайжруулах” зорилгоос гадна хангаж чадах бусад хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 2.5. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Гүйцэтгэх ажилд тавих одоогийн хяналт буюу прокурорын болон бусад дотоод, гадаад хяналт нь хэвээр үргэлжлэх ба тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжилнэ.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд одоогийн гүйцэтгэх ажилд тавих хяналтын тогтолцоо хэвээр байх буюу үр өгөөж хэвээрээ байна.	Үр дүн муутай
2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх нь хязгаарлагдмал бөгөөд мэдээлэл хомс байна. Учир нь гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажил нь өөрөө ил болон нууц аргыг хослуулдаг тул зорилгыг биелүүлэхэд нөлөө үзүүлэхгүй байна.	Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжгүй байдалд хүрнэ.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийснээр гүйцэтгэх ажилд тавих хяналт сайжрахад үр нөлөө үзүүлэхгүй.	Төрөөс их хэмжээний зардал гарах хэдий ч үр өгөөжгүй байна.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4. Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал нь аливаа эрх бүхий этгээдийн мөнгө, санхүүгийн дутагдал, хүндрэлтэй холбоогүй, зөвхөн хуулийн зохицуулалт, хяналтын тогтолцоо, засаглалын хяналт-тэнцэлтэй холбоотой асуудал тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Гүйцэтгэх ажил буюу тагнуулын үйл ажиллагаанд иргэний нийгмийн хяналт чухал хэдий ч практик нөхцөл байдлаас болоод хараахан үр дүн өгөхөөргүй байна. Мөн түүнчлэн төрийн бус байгууллага, хувийн хэвшил зэрэг иргэний нийгмийн хяналт нь ач холбогдлоор парламентын хяналтаас илүү байж чаддаггүй байна. ³²	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

32 Тагнуулын үр дүнтэй хяналт нь зөвхөн төрийн холбогдох байгууллагуудын уялдаа холбоотой үйл ажиллагааг шаардах бус, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг мөн адил шаардана. Эдгээрийн бүгдийнх нь үүрэг оролцоо чухал хэдий ч, парламентын болон хөндлөнгийн мэргэшсэн хяналтын байгууллагуудад илүүтэй анхаарал хандуулдаг. Учир нь эдгээр байгууллага тагнуулын албад болон гүйцэтгэх засаглал аль алинаас хараат бус бөгөөд ардчилсан хариуцлагатай байдлыг бие даан хангаж, хуулийн засаглал, хүний эрхийг дээдлэхэд хамгийн тохиромжтой байдаг.

6.	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах буюу захиргааны хэм хэмжээний акт буюу журам, дүрмээр тус гүйцэтгэх ажилд тавих хяналтыг сайжруулах нь нэг гарц хэдий ч зөвхөн гүйцэтгэх засаглалаас хамаарах учраас хөндлөнгийн хяналтын ач холбогдол алдагдахаар байна.	Гүйцэтгэх засаглалын хувьд зардал их гарах хэдий ч үр өгөөжийн хувьд муу байна.	Үр дүн муутай.
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т заасан халдашгүй чөлөөтэй байх эрхийг төрөөс хангах, засаглалын хяналт-тэнцлийг хангах зэрэг шалтгаанаар гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг нарийвчлан тусгайлан хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай.	Төрөөс хууль батлагдах болон үйл ажиллагаатай холбоотой зардал тодорхой хэмжээгээр гарах хэдий ч тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна.	Үр дүнтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийснээр тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

Дээрхээс дүгнэвэл, асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зорилтод хүрэхийн тулд гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах нь үр дүнтэй хувилбар байна. Мөн одоо байгаа тогтолцооны хүрээнд зардал гаргалгүйгээр гүйцэтгэх ажилд тавих одоогийн хяналт буюу прокурорын болон бусад дотоод, гадаад хяналтыг хэвээр үргэлжлүүлж болох юм. Харин захиргааны байгууллагаас шийдвэр гаргах замаар зохицуулах нь зардал гаргаж байгаа хэдий ч үр дүн муутай хувилбар байна.

Тиймээс “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчилж гүйцэтгэх ажлын хууль ёсны, эрх, эрх чөлөөг дээдэлсэн байдал, засаглалын хяналт-тэнцлийг сайжруулах” зорилгыг гүйцэтгэх хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

Хувилбар 1. Гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх;

Хувилбар 2. Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах замаар асуудлыг шийдвэрлэх.

Нэгдүгээр хувилбарын хувьд ямар нэг зохицуулалт хийлгүйгээр одоогийн хяналт буюу прокурорын болон бусад дотоод, гадаад хяналтыг үргэлжлүүлэх агуулгатай юм. Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар гүйцэтгэх ажилд Монгол Улсын Их Хурлаас тавих хяналт шалгалт, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавих хяналт, Монгол Улсын Засгийн газраас тавих хяналт, прокурорын хяналт, ТЕГ-ын хяналт, шалгалт, аудитын байгууллагын хяналт хамаарч байна.

Хоёрдугаар хувилбар нь гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийг Улсын Их Хурлаас баталж, түүний дагуу гүйцэтгэх ажилд Улсын Их Хурал, түүний тусгай хороодоос хяналт тавих агуулгатай. Энэхүү хяналт нь одоо

байгаа хяналтууд дээр нэмэгдсэнээр гүйцэтгэх ажилд тавих хяналт сайжирч хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, засаглалын хяналт-тэнцлийг хангах, ардчиллын суурь үнэт зүйлийг бүрдүүлэх боломжтой болох юм. Дээрх байдлаар зохицуулах нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал болон олон улсын жишигт нийцэж буй юм.

Иймд энэхүү хоёр хувилбар нь судалгаагаар дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой гэж үзэж тус хоёр хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан авч үзье.

Хувилбар 1. Томьёолол

“Гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх”

Зорилгод хүрэх байдал:

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчилж, гүйцэтгэх ажлын хууль ёсны, эрх, эрх чөлөөг дээдэлсэн байдал, засаглалын хяналт-тэнцлийг сайжруулах юм.

Хувилбар 1-ийн хувьд эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэхээр байна. Одоогийн гүйцэтгэх ажилд тавих хяналтын тухайд Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар Улсын Их Хурал, Засгийн газар шаардлагатай гэж үзвэл өөрийн бүтэц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих ба гүйцэтгэх байгууллагын дарга нь гүйцэтгэх ажилд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр тусгагджээ. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай танилцана.

Үүнээс гадна гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналтыг Улсын Ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор дараах байдлаар хэрэгжүүлдэг:

- Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэлд прокурор хяналт тавих;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, шуудан харилцааг хянах, орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх, нууцаар ажиглалт явуулах, хяналтын худалдан авалт, нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглах ажиллагаа явуулахад прокурорын зөвшөөрөл авах;
- Гүйцэтгэх ажлын явцад авагдаж, эрүүгийн хэргийн нотлох баримт болгосон баримт сэлтийг хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу цуглуулсан эсэхэд хяналт тавих гэх мэт.

Дээрх байдлаар хяналт тавьж буй тогтолцоо нь гүйцэтгэх ажилд хяналт тавих хамгийн сайн тогтолцоо биш бөгөөд зарим бэрхшээл үүсдэг. Тухайлбал, гүйцэтгэх ажилд тавих гадаад хяналт хангалтгүй буюу хөндлөнгийн зүгээс хянах хяналт сул байна. Үүнээс гадна хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх ёсны зарчмыг

хангахад зарим талаар дутагдалтай байгааг асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал хэсэгт судалсан билээ.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Тус хувилбарыг хэрэгжүүлснээр зардал огт гарахгүй хэдий ч өмнө дурдсанаар үр, өгөөж муутай байна.

Хувилбар 2. Томьёолол

“Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах замаар асуудлыг шийдвэрлэх”

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү хувилбарын хувьд өмнөх хувилбартай харьцуулбал, одоо байгаа тогтолцоог нарийвчлан дэлгэрүүлж гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тогтолцоог хуульчлах, тусгай хороодоор дамжуулан гүйцэтгэх ажилд хяналт тавих агуулгатай. Өмнөх хэсэгт буюу асуудалд дүн шинжилгээ хийсэн хэсэгт тухайн хяналтын ач холбогдлыг дэлгэрэнгүй авч үзсэн ба дараах давуу тал бий болохоор байна.

- Гүйцэтгэх ажилд Улсын Их Хурлаас хяналт тавих зохицуулалтыг бий болгосноор гүйцэтгэх ажилтай холбоотой хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах тогтолцоо сайжирна. Гүйцэтгэх ажил нь илээр болон нууц арга хэрэгслээр үйл ажиллагааг явуулдаг ба эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөл байдлыг байнга бий болгож байдаг учир хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ач холбогдолтой.
- Гүйцэтгэх ажилд Улсын Их Хурлаас хяналт тавьснаар ард түмнээс сонгогдсон төлөөлөл хяналт тавих боломжийг бүрдүүлж, дарангуйлал бий болохоос урьдчилан сэргийлж, ардчиллын үнэт зүйлийг хамгаална.
- Аюулгүй байдлын салбар, тэр дундаа төрийн бусад цэрэгжсэн байгууллага, тусгай байгууллагын гүйцэтгэх ажилд парламентын хяналт онцгой ач холбогдолтой.
- Гүйцэтгэх засаглалд хамаарах гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажилд Улсын Их Хурал хяналт тавьснаар эрх мэдлийн хяналт-тэнцэл хангагдана.
- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын байнгын, дэд болон хянан шалгах түр хороо нь тухайн хяналтыг хэрэгжүүлэх нь цаг үеийн шаардлагаас бий болж байна. Ийнхүү парламентын тусгай хороо гүйцэтгэх нь үр дүнтэй гэх дэлхийн жишиг байдаг.

Иймд тус судалгаагаар тодорхойлсон зорилгыг биелүүлэх болон дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэхэд тухайн хувилбар үр өгөөж сайтай байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Хувилбар 2-т тодорхойлсон байдлаар гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тусгайлан хууль баталж бий болговол хууль батлагдах үйл явцад шаардагдах зардлууд нь улсын төсвөөс гарахаар байна. Ийнхүү хуульчилснаар

тусдаа бүтэц, орон тоо бий болж, зардал нэмэгдүүлэхгүй бөгөөд шинэ хуулиар тогтолцооны асуудал, УИХ-ын тавих хяналтын үйл ажиллагааг тодорхой зохицуулснаар ард түмний төлөөллийн байгууллага болох УИХ-ын онцгой бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэх юм. Түүнчлэн, гүйцэтгэх ажилд Улсын Их Хурлаас хяналт хэрэгжүүлсний үр дүнд үүсэх үр өгөөж нь онцгой ач холбогдолтой буюу эергээр нөлөөлөхөөр байна. Мөн одоогийн хяналт тавьж буй байгууллагуудын төсвийг хэмнэх учир зардал, үр өгөөжийн харьцааны хувьд үр өгөөж нь илүү байхаар байна.

IV. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалахад чиглэдэг учир асуудлыг зохицуулахаар сонгож буй хувилбар нь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн, хууль бусаар хязгаарласан байх ёсгүй ба тухайн хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө аливаа хэлбэрээр зөрчигдөх ёсгүй. Иймд үүнийг урьдчилан шалгасан байх шаардлагатай тул энэ хэсэгт шалгах болно.

Доорх хүснэгт 1-д зохицуулалтын хувилбаруудын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд хариултын тайлбарыг дэлгэрэнгүй байдлаар тусад нь бичсэн болно.

Хүснэгт 2.6. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Хувилбар 1	Тийм	Эрсдэлтэй.
		Хувилбар 2	Тийм	УИХ-ын хяналт нь урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлнэ.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Эрсдэлтэй.
		Хувилбар 2	Үгүй	Хөндлөнгийн хяналтыг бий болгосноор аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхээс сэргийлэхэд ач холбогдолтой.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	НҮБ-ын Хүний эрхийн хорооны зөвлөмжид нийцсэн.
	1.2.Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.	
	Хувилбар 2	Тийм	УИХ-ын хяналт нь иргэдийн оролцоог хангана.	

	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавих хяналт өргөжсөнөөр дээрх дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	НҮБ-ын Хүний эрхийн хорооны зөвлөмжид нийцсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Хариуцлагын тогтолцоо сайжирна.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Хувилбар 1	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй
		Хувилбар 2	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хяналтыг сайжруулах тул.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	УИХ буюу төлөөллийн байгууллага хяналт тавих тул.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Үүрэг хүлээгчдийг шинээр тодорхойлсон.

5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Хувилбар 1	Үгүй	Тусгаагүй.
		Хувилбар 2	Тийм	Хангах боломжтой.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх

Энэ хэсэгт хүний бүхий л эрх, эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар гадуурхах, хязгаарлах буюу дээрд үзэхийг хориглосон заалт, агуулгыг зохицуулалтын хувилбаруудад тусгасан эсэхийг шалгана.

Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх тухайд, зохицуулалтын хувилбаруудад ялгаварлан гадуурхахыг хориглосон шууд зохицуулалт байхгүй. Гэвч ялгаварлан гадуурхахыг хориглох буюу хязгаарлах боломжийг бий болгох боломжтой.

Зохицуулалтын хувилбар 1 нь гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах буюу одоогийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэ нь гүйцэтгэх ажилд тавих хяналтыг өргөжүүлэхгүй гэсэн үг. Ингэснээр мэдээлэл олзворлох явцад авагдсан хүний хувийн мэдээллийн хамгаалалт, нууцлалт байдал эрсдэлтэй хэвээр байна гэсэн үг. Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр ялгаварлан гадуурхалтыг хязгаарлах боломжтой байж болох юм.

Гүйцэтгэх ажил болон ялгаварлан гадуурхлын хамаарал гүйцэтгэх ажлын явц дахь мэдээлэл олзворлолт, үр дүнд нь олж авсан тухайн мэдээллийн нууцлалтай холбогдоно. Тухайлбал, хүний хувийн нууцтай холбоотойгоор ялгаварлан гадуурхал үүсэх эрсдэлтэй.

Тагнуулын хяналт нь тагнуулын албадын үйл ажиллагааны зүй зохистой болон хууль ёсны байдал, үр нөлөө болон үр дүнтэй эсэхэд анхаардаг. Зүй зохистой гэдэгт тагнуулын албаны үйлдэл, үйл ажиллагаа ёс суртахууны хувьд зөв зүйтэй эсэхийг хэлж байгаа бол хууль ёсны гэдэг нь тагнуулын байгууллага үйл ажиллагаандаа холбогдох хуулийг сахин биелүүлж байгаа эсэхийг ойлгох ойлгодог.

Тагнуулын албадын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр зөрчигддөг эрх бол хувь хүний нууцтай байх эрх юм. Тиймээс ч тагнуулын хяналтын байгууллагуудын гол үүргийн нэг нь тагнуулын албадын мэдээлэл цуглуулах ажиллагаа хувь хүний нууцын тухай дотоодын болон олон улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих явдал байдаг. Гүйцэтгэх ажилд тавих хяналтыг УИХ хэрэгжүүлснээр хяналтын тогтолцоо, хяналтын үр дүн буюу гүйцэтгэх ажиллагааны зүй зохистой болон хууль ёсны байдлыг сайжруулах ач холбогдолтой. Иймд зохицуулалтын хувилбар 2 нь ялгаварлан гадуурхал бий болохоос урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Харин хяналт тавих эрх бүхий УИХ-ын гишүүдийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулах шаардлагатайг анхаарах нь зүйтэй. Энэхүү ажиллагаа хууль тогтоох ажлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг учраас өөрийн хил хязгаартай, дур зоргоос ангид, хуульчилсан процедураар хэрэгжих ёстой.³³

Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд хөндлөнгийн хяналтыг бий болгосноор аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхээс сэргийлэхэд ач холбогдолтой. Энэ нь НҮБ-ын Хүний эрхийн хорооноос мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын нууц үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлах, үүний зэрэгцээ үндэсний аюулгүй байдалд хамаарах мэдээ, мэдээлэлд нэвтрэх, түүнтэй танилцах үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог байнга боловсронгуй болгох тухай зөвлөмжид нийцэж буй.

2. Оролцоог хангах

Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдалд өөрчлөлт гарахгүй. Энэ нь хяналтыг хязгаарлагдмал хүрээллийн хяналтад хэвээр үлдээнэ гэсэн үг. Харин зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажилд УИХ-ын хяналтыг бий болгосноор иргэдийн төлөөллийн байгууллагын хяналтыг бий болгож иргэдийн оролцоог хангаж буй юм.

3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага

Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1 нь гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхгүй. Энэ нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах боломж хязгаарлагдмал гэсэн үг.

Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах боломжтой гэж үзэж байна.

Тагнуулын үр дүнтэй хяналт нь зөвхөн төрийн холбогдох байгууллагуудын уялдаа холбоотой үйл ажиллагааг шаардах бус, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг мөн адил шаардана. парламентын болон хөндлөнгийн мэргэшсэн хяналтын байгууллагууд нь тагнуулын албад болон гүйцэтгэх засаглал аль алианаас хараат бус бөгөөд ардчилсан хариуцлагатай байдлыг бие даан хангаж, хуулийн засаглал, хүний эрхийг дээдлэхэд хамгийн тохиромжтой байдаг.³⁴ Манай улсад гүйцэтгэх ажлын явцад хүний эрх зөрчсөн тохиолдлыг УИХ-ын түр хороо хянан шалгаж тогтоож улмаар шүүхээр баталгаажсан жишээ бий.

33 Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 419 дэх тал.

34 Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 29 дэх тал.

Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх тухайд, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын нууц үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлах, үүний зэрэгцээ үндэсний аюулгүй байдалд хамаарах мэдээ, мэдээлэлд нэвтрэх, түүнтэй танилцах үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог байнга боловсронгуй болгож байхыг гишүүн улсуудад зөвлөсөн байдаг. Зохицуулалтын хувилбар 2 нь энэхүү зөвлөмжид нийцсэн болно.

Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх тухайд, гүйцэтгэх ажлын явцад хүний эрхийг зөрчсөн тохиолдолд зөрчигчдөд Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага оногдуулдаг тул зохицуулалтын хувилбаруудад уг харилцааг зохицуулах боломжгүй. Харин зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажилд тавих хяналтыг хөндлөнгийн хяналтын хэлбэрээр өргөжүүлэх тул гүйцэтгэх ажлын явцад хүний эрх зөрчигдсөн тохиолдолд илрүүлэлтийг нэмэгдүүлж хариуцлагын тогтолцоог дэмжинэ.

4. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх

Гүйцэтгэх ажилд тавих хяналтын асуудал нь хүний эрхийг хязгаарлах зохицуулалтаас илүүтэй хүний эрхийг хязгаарлах зохицуулалт бүхий гүйцэтгэх ажил хэрхэн хэрэгжсэнд хяналт тавих тухай юм. Ийм учир хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулахгүй байх нь чухал. Зохицуулалтын хувилбарууд нь хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй болно.

5. Эрх агуулагч

Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь өдгөө гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх бүхий байгууллагууд л хяналтыг хэрэгжүүлнэ гэсэн үг.

Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр УИХ гүйцэтгэх ажилд хяналт тавих эрхтэй болно. Тийнхүү хяналтыг хэрэгжүүлэхдээ хэрхэн хэрэгжүүлэхээс хамааран УИХ-ын гишүүн, УИХ-ын байнгын, дэд, түр хороод ямар эрхтэй байх нь тодорхой болох ба үүнийг бие даасан хуульд тодорхойлно.

6. Үүрэг хүлээгч

Энэ хэсэгт хүний эрхийг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээсэн этгээдийг тодорхойлсон эсэхийг авч үзнэ.

Зохицуулалтын хувилбар 1 нь хүний эрхийг хэрэгжүүлэх талаар тодорхой үүргийг шинээр хүлээлгэхгүй. Харин өдгөө хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хүний эрхийн хэрэгжилт гүйцэтгэх ажилд тавих хяналт хязгаарлагдмал байгаатай холбоотойгоор дутагдалтай байгаа билээ.

Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавих хяналтыг өргөжүүлэн УИХ-ын хяналтыг бий болгоно. Үүний тулд бие даасан хууль батлах шаардлагатай ба тухайн хуульд хүний эрхийг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээсэн этгээдийг тодорхойлох нь зайлшгүй. хүний эрхийг хэрэгжүүлэх талаар

тодорхой үүрэг хүлээсэн этгээдүүд нь гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, УИХ-ын гишүүд, тэр дундаа УИХ-ын холбогдох байнгын, дэд, түр хороодын гишүүд, холбогдох этгээдүүд байна.

7. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх

Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх тухайд, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын иргэн, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна. Иймд зохицуулалтын хувилбарууд заавал тус хуульд нийцсэн байх ёстой.

Зохицуулалтын хувилбаруудад жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх нь шууд хамааралгүй буюу энэхүү үзүүлэлт нь хамгийн гол шалгуур үзүүлэлт болохгүй. Гэвч дээр дурдсанчлан Жендерийн үзэл баримтлалыг тусгасан байх шаардлага бий.

Зохицуулалтын хувилбар 1 нь гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах буюу одоогийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэ нь гүйцэтгэх ажилд тавих хяналтыг гүйцэтгэх засаглалын байгууллагын давамгайл хяналтад үлдээнэ гэсэн үг. Гүйцэтгэх ажилд хяналт тавих гол субъект болох Засгийн газар, агентлагийн удирдах албан тушаалтнуудын доторх хүйсийн харьцаа Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан доод хэмжээнээс ихээхэн зөрүүтэй буюу Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга нар бараг бүгд нэг хүйсийн хүмүүс байна.³⁵ Энэ нь зохицуулалтын хувилбар 1 жендерийн үзэл баримтлалыг хангалттай тусгаагүй болохыг харуулж буй үзүүлэлт юм.

Зохицуулалтын хувилбар 2 буюу гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг шинээр бий болгосноор хяналт тавих субъект нь УИХ буюу УИХ-ын гишүүд болох тул УИХ дахь жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдоно. Өдгөө бүрэн эрх нь хэрэгжиж буй УИХ-ын гишүүдийн 13 нь буюу 17 хувь нь эмэгтэй гишүүд байна. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 6-р сарын 16-ны өдөр баталсан ба энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тус хуульд оруулсан. Тухайлбал, жагсаалтаар нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа 1:1 байхаар тусгасан бөгөөд харин тойрогт нэр дэвшигчдийн тухайд “нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй /эмэгтэйчүүд/” хэмээн заажээ. Уг заалт хэрэгжиж эхэлснээр гүйцэтгэх ажилд тавих хяналтад жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдэнэ. Иймд зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр жендерийн үзэл баримтлалыг хангах боломжтой гэж үзэж байна.

³⁵ Монгол Улсын жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Жендерийн үндэсний хорооны ажлын алба (УБ, 2021), 71 дэх тал.

Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх тухайд, гүйцэтгэх ажилд тавих хяналтын асуудал нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэхтэй шууд холбогдохгүй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний үнэлгээний зорилго нь тухайн зохицуулалтын хувилбар нь өсөлт, ажил эрхлэлт, бизнес, өрсөлдөх чадвар болон нийтийн баялагт хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тогтооход оршино. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг шууд болон шууд бус үр нөлөө гэж ангилагдана. Шууд үр нөлөөний энгийн жишээ бол зохицуулалтын хувилбарын улмаас улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт зардал үүсэх, аж ахуйн үйл ажиллагааны татварын хэмжээг өөрчлөх зэрэг байж болно.

Хүснэгт 2.7. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Хил дамнансан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хүний эрхийг хамгаалахад чухал нөлөөтэй ба холбогдох олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг болох тул гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулахад эергээр нөлөөлнө.
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөлд үзүүлэх эерэг нөлөөллөөр дэмжигдэх боломжтой.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
	Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Хуулийн этгээдэд мэдээлэх үүрэг хүлээлгэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
	Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	УИХ гүйцэтгэх ажилд тавих хяналтыг УИХ-ын дэд хороо, байнгын хороо болон түр хороогоор хэрэгжүүлнэ. Ингэхдээ шинээр эсвэл одоо байгаа бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлагатай болно. Энэ нь ажлын байр бий болох нөхцөлийг зайлшгүй үүсгэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир улсын төсөвт нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зардлыг улсын төсвөөс шийдвэрлэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	УИХ гүйцэтгэх ажилд тавих хяналтаа УИХ-ын дэд хороо, байнгын хороо, түр хороогоор хэрэгжүүлнэ. Ингэхдээ шинээр эсвэл одоо байгаа бүтцийг шинэчлэн зохион байгуулна.

		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болох учир гүйцэтгэх байгууллага болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллагууд, шинээр хяналт тавих УИХ-ын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх бөгөөд тухайн хэрэгжилтийг хангах чиг үүрэг холбогдох төрийн байгууллагуудад нэмэгдэнэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хөрөнгө оруулалтын нөхцөл дэх эерэг нөлөөлөл нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хүний эрхийг хамгаалахад чухал нөлөөтэй ба холбогдох олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг болох тул гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулахад эерэгээр нөлөөлнө.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 1	-	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Холбогдох олон улсын гэрээний хэрэгжилт хангагдаж байгаа.

Гүйцэтгэх ажилд тавих хяналтын асуудал нь эдийн засагтай шууд хамаарал багатай. Зохицуулалтын хувилбар 1 болон 2 аль аль нь инноваци болон судалгаа шинжилгээ, өмчлөх эрх, хэрэглэгч болон гэр бүлийн төсөв, дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдалд сөрөг болоод эерэг нөлөө үзүүлэхээргүй байна. Мөн мэдээлэх үүргийн улмаас хуулийн этгээдэд захиргааны зардлын ачаалал үүсэхгүй.

Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир эдийн засагт үзүүлэх үр нөлөө илүү бага. Харин зохицуулалтын хувилбар 2 нь хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зардлыг улсын төсвөөс шийдвэрлэх учир улсын төсвөөс зардал гарахгүй хувилбар 1-тэй харьцуулахад зардлын хувьд сөрөг үр нөлөөтэй гэж үзэж болох юм. Гэвч үүгээр тус хувилбар 2-ыг эдийн засагт сөрөг үр нөлөөтэй гэж үзэж

болохгүй. Дээр дурдсанчлан, гүйцэтгэх ажилд тавих хяналтын асуудал нь эдийн засагтай шууд хамаарал бага. Гэвч зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр шууд бус байдлаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болох учир гүйцэтгэх байгууллага болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллагууд, шинээр хяналт тавих УИХ-ын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх бөгөөд тухайн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагаа өргөжнө. УИХ гүйцэтгэх ажилд тавих хяналтыг УИХ-ын дэд хороо, байнгын хороо болон түр хороогоор хэрэгжүүлнэ. Ингэхдээ шинээр эсвэл одоо байгаа бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлагатай болно. Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр тодорхой тооны ажлын байр шинээр бий болгож болох ч энэ нь хөдөлмөрийн зах зээлд, цаашлаад улсын эдийн засагт нөлөөлөх хэмжээнд нөлөө үзүүлэхгүй.

Тагнуулын хяналт нь тагнуулын албадын үйл ажиллагааны зүй зохистой болон хууль ёсны байдалд анхаарал хандуулахаас гадна үр нөлөө болон үр дүнтэй эсэхийг анхаардаг. Зүй зохистой гэдэгт тагнуулын албаны үйлдэл, үйл ажиллагаа ёс суртахууны хувьд зөв зүйтэй эсэхийг хэлж байгаа бол хууль ёсны гэдэг нь тагнуулын байгууллага үйл ажиллагаандаа холбогдох хуулийг сахин биелүүлж байгаа эсэхийг ойлгох бол үр нөлөөтэй гэж тагнуулын алба тавьсан зорилгодоо хүрч ажиллаж байгаа эсэхийг ойлгодог. Үр дүнтэй гэдэг нь эдгээр зорилгыг хэрэгжүүлэхдээ тагнуулын алба эдийн засгийн хувьд хэр ашигтай хувилбарыг сонгож чадсаныг хэлнэ. Зохицуулалтын хувилбар 2 нь тагнуулын буюу гүйцэтгэл ажилд тавих хяналтыг өргөжүүлэх, ийнхүү өргөжүүлэхдээ хөндлөнгийн хяналтыг бий болгож буй. Энэ нь өдгөө тавигдаж буй гүйцэтгэх болоод шүүхийн хяналтаас үр дүн сайтай гэдгээрээ онцлог. Иймд гүйцэтгэх ажиллагааны хууль ёсны байдал, үр нөлөө болон үр дүн сайжирна.

Хууль ёсны байдал сайжирснаар хүний эрхийг хамгаалахад чухал нөлөөтэй ба холбогдох олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг болох тул гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулахад эерэгээр нөлөөлөх бөгөөд санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж, макро эдийн засгийн хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой гэж үзлээ.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэ хэсэгт зохицуулалтын хувилбаруудын нийгэмд үзүүлэх үр нөлөөг авч үзсэн болно. Нийгэмд үзүүлэх үр нөлөө нь үндсэн шинжийн хувьд олон хэлбэрийг агуулдаг бөгөөд өөр хоорондоо болон бусад төрлийн үр нөлөөтэй давхцах нь бий. Доорх хүснэгт 3-т нийгэмд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд дэлгэрэнгүй буюу нэмэлт тайлбарыг тухайлан бичсэн болно.

Хүснэгт 2.8. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	УИХ гүйцэтгэх ажилд тавих хяналтыг УИХ-ын дэд хороо, байнгын хороо болон түр хороогоор хэрэгжүүлнэ. Ингэхдээ шинээр эсвэл одоо байгаа бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлагатай болно. Энэ нь ажлын байр бий болох нөхцөлийг зайлшгүй үүсгэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын алба хаагчдад нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд УИХ-аас хяналт тавих болсноор хяналтын шинэ процедур бий болж түүнд тавигдах чанар, стандарт шинээр тогтоогдоно.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх байгууллагын алба хаагчид болоод УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын алба хаагчдын эрх үүрэгт өөрчлөлт гарна.

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд УИХ-аас хяналт тавих болсноор хяналтын шинэ процедур бий болж түүнд тавигдах чанар, стандарт шинээр тогтоогдоно.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Хувилбар 1	-	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэхээс сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Гадаадын иргэдэд илэрхий нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болгож байгаа.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болгож байгаа.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болгож байгаа.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болгосноор иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.

		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болгож байгаа учир УИХ-д суудалтай намуудын төлөөллийг хяналтыг хэрэгжүүлэх хороонд хангах, гүйцэтгэх ажлыг улс төрийн зорилгоор ашиглахаас сэргийлэх гэх мэтээр зөрөг нөлөө үзүүлнэ.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажилд тавих УИХ-ын хяналтыг бий болгосноор аюулгүй байдлын салбарт эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажил дахь хяналт нь албадан хэрэгждэг онцлогтой.
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Гүйцэтгэх ажлын явцад үйлдэгдсэн гэмт хэргийг хяналт, шалгалтын үр дүнд илрүүлэх боломжтой.
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	-	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Тус хувилбар нь Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд чухал үр нөлөөтэй.
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Зохицуулалтын хувилбар 1 болон 2 аль аль нь соёл, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг болоод эерэг нөлөө үзүүлэхээргүй байна.

1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөг ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлтийн үндсэн дээр үнэлнэ. Хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх үр нөлөө бүс нутаг, мэргэжил, ажиллах нөхцөл, хүйс, болон үндэс угсаанаас хамааран өөр бүлгүүдэд өөр өөрөөр нөлөөлөх боломжтой ба үүнээс шалтгаалан, хөдөлмөрийн үр нөлөөг үнэлэхдээ өөр бүлгүүдийг салган үнэлэх шаардлагатай. Гүйцэтгэх ажилд тавих хяналт нь гүйцэтгэх байгууллагын албан хаагчид болоод хяналт тавих эрх бүхий субъектүүдийн харилцаа учир энэ хүрээн дэх хөдөлмөрийн зах зээлд нөлөөлнө хэмээн үзлээ.

Зохицуулалтын хувилбар 1-ийн тухайд гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах учир одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй буюу шинээр ажлын байр бий болохгүй.

Зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг шинээр бий болгох учир ажлын байр шинээр бий болгох боломжтой. УИХ гүйцэтгэх ажилд хяналт тавихдаа дэд хороо, байнгын хороо, түр хороо зэргийг байгуулна. Ингэхдээ шинээр эсвэл одоо байгаа бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлагатай болно. Энэ нь ажлын байр бий болох нөхцөлийг зайлшгүй үүсгэнэ.

Парламентаас аюулгүй байдлын салбарт хяналт тавих чадавх нь ерөнхийдөө цаг хугацааны хүчин зүйлс хийгээд авч болох мэдээллийн цар хүрээ, мэргэжлийн чадавхаас хамаарна.³⁶ Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналт үр дүнтэй байхын тулд парламентын дотоодод буюу түүний мэдэлд мэргэжлийн эксперт болон бусад шаардлагатай нөөц бололцоо байх ёстой. ОУПХ болон ЗХАХТЖТ аюулгүй байдлын асуудлаарх парламентын чадавхыг бэхжүүлэхэд парламент сайн бэлтгэгдсэн, хангалттай тооны ажилтантай байх, хөндлөнгийн бие даасан шинжээчдээс зөвлөгөө авах явдлыг чухал арга хэрэгсэл³⁷ хэмээн тодорхойлсон байдаг.

Гүйцэтгэх байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй ч хяналт тавих байгууллагын бүрэлдэхүүнд илүүтэй нөлөө үзүүлнэ. Тухайлбал, шинээр байнгын болон дэд хороо байгуулагдах, эсвэл одоо үйл ажиллагаа явуулж буй байнгын болон дэд хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх шаардлагатай болно. Мөн түр хороо байгуулагдах тохиолдолд тухай бүртээ бүтэц, бүрэлдэхүүн нь шинээр зохион байгуулагдана.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна” гэж заасан байх тул Тамгын газрын бүтэц, бүрэлдэхүүнд шууд өөрчлөлт гарах ба ингэхдээ шинээр хэлтэс байгуулах эсвэл одоогийн хэлтсүүдэд шинээр нэгж бий болгох, эсвэл харьяалагдах албан хаагчдын тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай болно. Жишээ нь, шинээр байнгын болон дэд хороо байгуулагдахаас үл хамааран хуралдааны тоо нэмэгдэх учир Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн албан хаагчдын тоог нэмэгдүүлнэ.

Түүнчлэн, дээрх зохицуулалтын хувилбарууд нь шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгохгүй нь харагдаж байна.

Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир нөлөө үзүүлэхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг шинээр бий болгохдоо дээр дурдсанчлан гүйцэтгэх байгууллагын албан хаагчид, түүнд хяналт тавих эрх бүхий байгууллагын албан хаагчид, УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын албан

36 Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014), 92 дахь тал.

37 Мөн тэнд, 94-95 дахь тал.

хаагчдад нөлөө үзүүлнэ. Хэрхэн нөлөөлөх нь Улсын Их Хурлын хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхээс хамаарна. Гэвч УИХ-д байнгын болон дэд хороог шинээр байгуулах эсэхээс үл хамааран аль ч тохиолдолд УИХ-ын байнгын хороодын болон Тамгын газрын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэх нь зайлшгүй. Энэ нь тухайн байгууллагуудын ажилчдад тавигдах нийтлэг шаардлагаар хязгаарлагдана гэсэн үг бөгөөд насны болоод бусад шалгуур тус нийтлэг шаардлагын хүрээнд тавигдана. Иймд зохицуулалтын хувилбаруудыг хэрэгжүүлснээр тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөхгүй.

2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх

Зохицуулалтын хувилбар 1 нь гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах учир одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Иймд ажлын стандарт, хөдөлмөрлөх эрхэд шинээр нөлөөлөл үүсгэхгүй.

Зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг шинээр бий болгох учир ажлын стандарт, хөдөлмөрлөх эрхэд нөлөө үзүүлнэ.

Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх тухайд, гүйцэтгэх ажилд УИХ-аас хяналт тавих болсноор хяналтын шинэ процедур бий болж түүнд тавигдах тусгай шаардлага шинээр тогтоогдох ёстой. УИХ-д гүйцэтгэх ажилд хяналт тавих байнгын эсвэл дэд хороо шинээр байгуулагдсан тохиолдолд тагнуулын асуудал хариуцсан (дэд) хороо ихэвчлэн хаалттай хуралддаг³⁸ онцлог бөгөөд нийтлэг жишгийн дагуу хуралдаан зохион байгуулах чиг үүрэг бүхий хэлтэс, нэгжүүдийг шинээр байгуулах, эсвэл одоо байгаа бүтцэд өөрчлөлт оруулах шаардлага үүсэх бөгөөд уг ажилд ажлын чанар, стандарт, ажиллах нөхцөл зэргийг шинээр боловсруулан тогтоох ёстой болно. Үүнтэй холбоотойгоор ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх ба хэрхэн нөлөөлөх нь УИХ-аас хяналтыг хэрхэн тавихтай шууд холбоотой учир дэлгэрэнгүй тайлбарлах боломжгүй.

Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх тухайд, гүйцэтгэх байгууллагын албан хаагчид болоод УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын албан хаагчдын эрх, үүрэгт өөрчлөлт гарна. Ажилчдын эрх үүргийг Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ерөнхийлөн авч үзэх нь хэт явцуу ба гүйцэтгэх ажил болон түүнд тавих хяналтын тухайд учир ажилчдын эрх үүргийг нарийвчлан тогтоох шаардлагатай болно. Ямар байдлаар өөрчлөлт орох нь манай улс уг хяналтыг хэрэгжүүлэхдээ ямар арга, загварыг сонгохоос хамаарна.

Шинээр ажлын стандарт гаргах эсэх тухайд, гүйцэтгэх ажилд УИХ-аас хяналт тавих болсноор хяналтын шинэ процедур бий болж түүнд тавигдах чанар, стандарт шинээр тогтоогдоно. Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналт нь манай улсад бий болж буй шинэ хяналтын тогтолцоо учир үйл ажиллагаатай нь холбоотойгоор шинэ зохицуулалт бий болгох нь зайлшгүй шаардлага бий болно. Харин ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлт бий болгохыг шаардахгүй.

38 Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014), 104 дэх тал.

3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал

Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх тухайд Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлэх хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн. Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэхээс сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Тус хувилбарыг хэрэгжүүлснээр тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин эрх нь зөрчигдсөн хүмүүст эерэг нөлөөтэй. Мөн энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх нь гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөхгүй.

4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун

Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх тухайд, Монголын Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх мэдэлд нөлөөлөх харилцаа сонгосон хувилбаруудыг хэрэгжүүлснээр үүсэх эсэхийг шалгах ёстой.

Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй тул Засаглалын харилцаанд оролцогчдод шинэ нөлөөлөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр хууль тогтоох эрх мэдэл буюу УИХ-д гүйцэтгэх ажилд хяналт тавих шинэ чиг үүрэг нэмэгдэнэ.

Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй тул төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөхгүй. Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болох учир гүйцэтгэх байгууллага болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллагууд, шинээр хяналт тавих УИХ-ын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх бөгөөд тухайн хэрэгжилтийг хангах чиг үүрэг холбогдох төрийн байгууллагуудад нэмэгдэнэ.

Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх тухайд, төрийн захиргааны албан тушаал гэж Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т “Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны ажлын алба, бүх шатны шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны бусад байгууллага, прокурорын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэж, мөн зүйлийн 12.1.6-д “хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэж тус тус заажээ.

Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй тул төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болж үйл ажиллагаанд нөлөөлөхгүй. Гүйцэтгэх байгууллага болон түүнд өдгөө хяналт тавих эрх бүхий байгууллагууд, шинээр хяналт тавих УИХ-ын Тамгын газрын албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд

нөлөө үзүүлнэ. Эдгээр албан хаагчид нь дээр дурдсан Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн захиргааны албан хаагчид мөн тул зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлнө гэж үзэх үндэслэлтэй байна.

Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх тухайд, Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь эерэг нөлөөлөл биш буюу өдгөө аюулгүй байдлын салбар, тэр дундаа гүйцэтгэх ажил, түүнд тавигдах хяналтад тулгараад буй асуудлууд огт шийдвэрлэгдэхгүй гэсэн үг.

Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болж иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд эерэг нөлөө үзүүлнэ. Шүүхийн тагнуулын үйл ажиллагаанд гүйцэтгэх нэг чухал үүрэг нь тагнуулын албадын үйл ажиллагаатай холбоотой Үндсэн хууль зөрчсөн, эрүүгийн, иргэний, захиргааны хэргийг шүүн таслах байдаг.³⁹ Энэ хяналт хэрэгжихийн тулд тухайн зөрчил илрэх шаардлагатай ба зөрчлийг илрүүлэхэд бусад хараат бус хяналт чухал. УИХ-ын хяналтыг бий болгосноор гүйцэтгэх ажлын явцад үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч болсон иргэд шүүхэд хандах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх тухайд, Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь эерэг нөлөөлөл биш буюу өдгөө аюулгүй байдлын салбар, тэр дундаа гүйцэтгэх ажил, түүнд тавигдах хяналтад тулгараад буй асуудлууд огт шийдвэрлэгдэхгүй гэсэн үг. Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавигдах парламентын хяналтыг шинээр бий болгож байгаа учир УИХ-д суудалтай намуудын төлөөллийг хяналтыг хэрэгжүүлэх хороонд хангах, гүйцэтгэх ажлыг улс төрийн зорилгоор ашиглахаас сэргийлэх гэх мэтээр эерэг нөлөө үзүүлнэ.

Аюулгүй байдлын салбарт парламентын хяналт хэрэгжих өөр нэг чухал хүчин зүйл нь парламентын гишүүдийн улс төрийн хүсэл эрмэлзэл мөн.⁴⁰ Улс төрийн хүсэл эрмэлзэл дутагдах нэг шалтгаан нь улс төрийн намын сахилга бат буюу эрх баригч намын парламентын гишүүд нь Засгийн газраа хамгаалах, олон нийтийн өмнө илээр шүүмжлэхээс зайлсхийх хандлагатай байдгаас үүддэг. Иймээс ОУПХ болон ЗХАХТЖТ аюулгүй байдлын асуудлаарх парламентын чадавхыг бэхжүүлэхэд парламентад суудал бүхий бүх намын төлөөллөөс бүрдсэн аюулгүй байдал/батлан хамгаалах асуудлаарх бүлэг байгуулахыг зөвлөдөг.⁴¹

5. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал

Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх тухайд, Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй бөгөөд аюулгүй байдлын салбар, тэр дундаа гүйцэтгэх ажил, түүнд тавигдах хяналтад тулгарч буй асуудлууд шийдвэрлэгдэхгүй.

39 Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 30 дахь тал.

40 *Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003*, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014), 95 дахь тал.

41 *Мөн тэнд.*

Тагнуулын хяналт нь тагнуулын албадын үйл ажиллагааны зүй зохистой болон хууль ёсны байдалд анхаарал хандуулахаас гадна үр нөлөө болон үр дүнтэй эсэхийг анхаардаг. Зүй зохистой гэдэгт тагнуулын албаны үйлдэл, үйл ажиллагаа ёс суртахууны хувьд зөв зүйтэй эсэхийг хэлж байгаа бол хууль ёсны гэдэг нь тагнуулын байгууллага үйл ажиллагаандаа холбогдох хуулийг сахин биелүүлж байгаа эсэхийг ойлгоно. Үр нөлөөтэй гэж тагнуулын алба тавьсан зорилгодоо хүрч ажиллаж байгаа эсэхийг ойлгодог. Үр дүнтэй гэдэг нь эдгээр зорилгыг хэрэгжүүлэхдээ тагнуулын алба эдийн засгийн хувьд хэр ашигтай хувилбарыг сонгож чадсаныг хэлдэг.⁴² Зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавих УИХ-ын хяналтыг бий болж аюулгүй байдлын салбарт эерэг нөлөө үзүүлнэ хэмээн үзлээ. Учир нь парламентын хяналтын хороо болон хөндлөнгийн хяналтын байгууллагыг хяналтын хамгийн үр дүнтэй хэлбэр гэж үздэг.⁴³ Энэ талаар судалгааны гуравдугаар бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй буюу гэмт хэргийн илрүүлэлтэд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажилд тавигдах хяналт өргөжих бөгөөд ийнхүү хяналт, шалгалтын цар хүрээ өргөжих нь гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэхэд чухал дэмжлэг болдог. Иймд тус хувилбарын үр дүнд гүйцэтгэх ажлын явцад үйлдэгдсэн гэмт хэргийг хяналт, шалгалтын үр дүнд илрүүлэх боломжтой байна.

Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхийн өнөөгийн нөхцөл байдал сайжрах боломжгүй. Харин зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажлын явцад үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлтийг дэмжсэнээр гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд чухал үр нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Гүйцэтгэх ажилд тавих хяналтын асуудал нь байгаль орчинд шууд болон дам байдлаар сөрөг нөлөө бий болгохгүй. Үүнийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй авч үзлээ.

Хүснэгт 2.9. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

42 Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 28 дахь тал.

43 Мөн тэнд, 34 дэх тал.

2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Энэ хэсэгт зохицуулалтын 1 болон 2 дугаар хувилбар нь дараах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцэж байгаа эсэхийг шалгана.

Зохицуулалтын хувилбар 1 нь гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэхийг зорино. Тус хувилбарыг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд үр нөлөө багатай бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийн байдлыг хангахад эергээр нөлөөлөх боломжгүй нөхцөлийг бий болгож байна.

Зохицуулалтын хувилбар 2 нь гүйцэтгэх ажилд тавих УИХ-ын хяналтыг шинээр бий болгоно. Ингэснээр гүйцэтгэх ажилд тавих хяналтыг хөндлөнгийн хяналтаар өргөжүүлэх юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийг хангахад чухал нөлөөтэй. Мөн НҮБ-ын Хүний эрхийн хорооноос мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын нууц үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлах, үүний зэрэгцээ үндэсний аюулгүй байдалд хамаарах мэдээ, мэдээлэлд нэвтрэх, түүнтэй танилцах үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог байнга боловсронгуй болгож байхыг гишүүн улсуудад зөвлөсөн байдаг. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд УИХ-ын хяналтыг шинээр бий болгох шаардлагатай.

Ийнхүү УИХ-ын хяналтыг шинээр бий болгох нь Монгол Улсын Үндсэн хууль болон дараах хууль, бодлогын баримт бичигт нийцсэн болно. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж, Арван

зургадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан. Мөн Хорин тавдугаар зүйлийн 1.8-д “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” гэж, Хорин наймдугаар зүйлийн 2-т “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

- Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэйгээр ажиллана.” гэж, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулж болно: 28.1.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын” гэж тус тус заасан.
- Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална.”, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Улсын Их Хурал нь өөрийн бүтцийн зохих хэлбэрээр дамжуулан энэ хуулийн биелэлтэд хяналт тавина.” гэж тус тус заасан.
- Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Гүйцэтгэх ажилд үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдал, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай, тасралтгүй байх, нууц хамгаалах зарчмыг удирдлага болгоно.” гэж, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Улсын Их Хурал, Засгийн газар шаардлагатай гэж үзвэл өөрийн бүтэц дэх зохих нэгж, албан тушаалтнаар дамжуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.” гэж тус тус заасан.

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт)-ын 1.1.4-т “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.” гэж, 1.2.2-т “Төр, иргэний хамтын ажиллагаа Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна.” гэж, 3.3-т “Дотоод аюулгүй байдал Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.” гэж, 4.2.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ.” гэж тус тус заасан.

V. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хүснэгт 2.10. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбарууд	Хувилбар 1. Гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх.	Хувилбар 2. Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах замаар асуудлыг шийдвэрлэх.
	Зорилгод хүрэх байдал	Тус хувилбар нь гүйцэтгэх ажилд хяналт тавих хамгийн сайн тогтолцоо биш. Тухайлбал, гүйцэтгэх ажилд тавих гадаад хяналт хангалтгүй буюу хөндлөнгийн зүгээс хянах хяналт сул байна. Үүнээс гадна хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх ёсны зарчмыг хангахад учир дутагдалтай.	Гүйцэтгэх ажилд УИХ хяналт тавих нь илүү ач холбогдолтой. Энэхүү хувилбарыг хэрэгжүүлснээр гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөө хамгаалагдах, засаглалын хяналт-тэнцэл хангагдах нөхцөл байдал сайжирна.
	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Тус хувилбар нь манай улсын өнөөгийн нөхцөл байдалд ямар нэгэн өөрчлөлт бий болгохгүй. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх ажил дахь өнөөгийн тулгамдаж асуудлууд шийдвэрлэгдэх боломжгүй байна.	Энэхүү хувилбар нь судалгааны өмнөх хэсэгт шалгасны үр дүнд хүний эрх, эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх нь батлагдсан болно. Харин асуудлын онцлогоос шалтгаалж байгаль орчинд ямар нэгэн нөлөө үзүүлэхээргүй байна.
	Зардал, үр өгөөжийн харьцаа	Тус хувилбарыг хэрэгжүүлснээр зардал гарахгүй хэдий ч өмнө дурдсанаар үр өгөөж муутай болох нь тогтоогдож байна.	Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тусгайлан хууль баталж бий болговол хууль батлагдах үйл явцад шаардагдах зардлууд нь улсын төсвөөс гарах буюу зардал их гарахаар байна. Мөн ийнхүү эрх зүйн зохицуулалтыг хуульчилж тусдаа бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааг бий болгох нь Улсын Их Хурал, гүйцэтгэх байгууллагуудын төсвийг нэмэгдүүлж одоо байгаагийнхаас илүү зардал гаргахаар байна. Гэвч үүний үр дүнд үүсэх үр өгөөж нь манай улсын нийгэм, эдийн засаг, хүний эрхийн нөхцөл байдалд онцгой ач холбогдолтой.
	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Тус хувилбарыг сонгосноор одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд үр нөлөө багатай бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийн байдлыг хангахад эергээр нөлөөлөх боломжгүй нөхцөлийг бий болгож байна.	Тус хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцсэн буюу эдгээрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй.

	<p>Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох</p>	<p>Хүн ам; Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд, тэдгээр байгууллагын албан хаагчид; Гүйцэтгэх ажилд өртөгдөж буй хувь хүн, хуулийн этгээд буюу гүйцэтгэх ажлын объект; Гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх бүхий субъектүүд буюу Засгийн газар, Прокурор, Шүүх;</p>	<p>Хүн ам; Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд, тэдгээр байгууллагын албан хаагчид; Гүйцэтгэх ажилд өртөгдөж буй хувь хүн, хуулийн этгээд буюу гүйцэтгэх ажлын объект; Гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх бүхий субъектүүд буюу Засгийн газар, Прокурор, Шүүх, УИХ;</p>
--	---	---	--

Дээрх судалгаанд үндэслэн тухайн хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дүн

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 2 нь хувилбар 1-ээс эерэг үр дүнг үзүүлж байгаа нь харагдаж байна. Мөн зохицуулалтын хувилбар 2-ыг сонгон хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцсэн буюу эдгээрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй болохыг анхаарах нь зүйтэй.

Гарч болох сөрөг үр дагавар

Гарч болох сөрөг үр дагаврын хувьд зохицуулалтын хувилбар 1 нь хувилбар 2-оос сөрөг үр дагавар ихтэй болох нь зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдлаас харагдаж байна. Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр өнөөгийн тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдэх боломжгүй юм.

VI. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

2017 онд Олон улсын парламентын холбоо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтран дэлхийн 150 гаруй орнуудын парламент болон парламентын гишүүдийн дунд парламентын хяналтын асуудлаар судалгаа явуулж “Дэлхийн парламентын тайлан-2017: Парламентын хяналт ба Парламентаас Засгийн газрын хянах чадамж” сэдэвт тайлан, судалгаанд авагдсан орнуудын сайн туршлагад тулгуурлан Олон улсын парламентын холбооноос парламентын хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр гаргасан зөвлөмж, түүнчлэн парламентын хяналтын эрх зүйн орчин, тогтолцооны талаарх бусад орны туршлага, дэлхий нийтийн парламентын хяналтын тогтолцоо, эрх зүйн орчны жишгийг судалсны үндсэн дээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг боловсруулсан байна.⁴⁴ Тухайн хууль болон 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь гүйцэтгэх ажилд тавих хяналтад ач холбогдолтой болохыг өмнөх хэсгүүдэд дурдсан билээ.

Дэлхийн улс орнуудад гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтыг хууль тогтоох байгууллагын зүгээс хууль, бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүргээрээ дамжуулан хэрэгжүүлдэг, Засгийн газраас тодорхой асуудлаар асуулга, асуулт асуух зэрэг хяналт шалгалтын нийтлэг үйл ажиллагаанаас онцлогтой гэж үзэж, бие даасан хуулиар уг харилцааг зохицуулж, парламентын хяналт шалгалтын хүрээ хязгаарыг тогтоож өгдөг байна. Жишээлбэл, эх газрын эрх зүйн тогтолцоотой ХБНГУ-д Тагнуулын гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтын тухай хууль (Gesetz über die parlamentarische Kontrolle nachrichtendienstlicher Tätigkeit des Bundes) 2009 оноос хойш үйлчилж байна. Түүнчлэн, аюулгүй байдлын салбарыг улс төрийн хүчирхийллийн зорилгоор ашиглахаас сэргийлсэн байнгын хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлсэн эрх мэдлийн тэнцвэртэй хуваарилалт үргэлж байх шаардлагатай гэж Олон Улсын парламентын холбооноос үзжээ.

Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Олон Улсын Парламентын холбооноос гаргасан “Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа” гарын авлагад “Гадаад улс орнуудад тусгай албадынхаа үйл ажиллагаанд тавих гаднын байгууллагуудын хяналтын тогтолцоо, хэлбэр тэдгээрийн хууль тогтоох уламжлал, улс төрийн тогтолцоо болон бусад хүчин зүйлээс хамаардаг байна. Жишээлбэл, Их Британи болон түүний уламжлалт жишиг бүхий хуулийн тогтолцоотой орнуудад аливаа хяналтыг шүүхийн байгууллагаас тавих нь илүү үр өгөөжтэй гэж үздэг. Харин эх газрын эрх зүйн тогтолцоог гол болгосон орнууд хийгээд социалист гэгдэж байгаад ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн ихэнх улс орон парламентын хяналт, шалгалтыг хэрэглэх болжээ” гэж нийтлэг жишгийг тодорхойлсон байна. Үүнээс гадна гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажил болон бусад аюулгүй байдлын салбарт парламентын хяналт байх нь онцгой ач холбогдолтой талаар дурджээ. Тагнуулын үйл ажиллагааны нууцлал, шүүхийн хяналт шалгалтаас ангид байдал, хүний эрхэд халдах тусгай арга хэрэгсэл ашиглах эрх, өмнө нь тагнуулын байгууллагатай холбоотой гарч байсан алдаа дутагдлууд зэргийг харгалзан үзвэл төрийн эрхийг барьж буй засгийн газраас хараат бус хяналтын байгууллагууд оршин байхын ач

44 Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн танилцуулга.

холбогдол тод харагдана.⁴⁵

Мөн Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвөөс гаргасан “Тагнуулын албадыг хянах нь” гарын авлагад ерөнхийдөө парламентын хяналтын хороо болон хөндлөнгийн хяналтын байгууллагыг хяналтын хамгийн үр дүнтэй хэлбэр гэж үздэг. Парламентын хяналтын хороог өргөн хүрээтэй чиг үүрэг бүхий ерөнхий хороо (батлан хамгаалах, гадаад хэргийн асуудал эрхэлсэн байнгын хороо г.м) болон тагнуулын асуудлаар дагнасан тусгай хороо хэмээн ангилж болно. Хэдийгээр парламентын бусад хороо (нэн ялангуяа, төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн) тагнуулын хяналттай холбоотой зарим нэг үүрэг хүлээдэг ч, тагнуулын хяналтыг голлон хэрэгжүүлэгч нь хяналтын тусгай хороо байдаг. Учир нь тусгай хорооны гишүүдийн мэргэшил, туршлага харьцангуй өндөр байхаас гадна нууц мэдээлэлтэй парламентын нийт гишүүд бус, зөвхөн тус хорооны гишүүд танилцах эрхтэй байдаг тул мэдээллийн аюулгүй байдлын үүднээс хамгийн тохиромжтой хувилбар гэж үздэг байна.⁴⁶

Ихэнх ардчилсан оронд тагнуулын албадын мэдээлэл олзворлолтыг зохицуулахдаа хариуцлагатай, ил тод байдлыг эрхэмлэсэн хууль тогтоомжийг ашигладаг. Ингэхдээ зөвшөөрөл өгөх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэх засаглалын эрх мэдлээс гаргаж, парламент, шүүх болон гүйцэтгэх засаглалд холбоогүй бусад бүтцийн хооронд (харилцан адилгүй байдлаар) хуваарилдаг байна.

Олон улсын хууль тогтоомж дотоодын хууль тогтоомжийн хөгжилд түлхэц өгч болно. Жишээ нь, Европын зөвлөлөөс 2005 онд эрүүгийн хэрэг мөрдөн шалгахад тусгай арга хэрэгсэл ашиглах асуудлыг зохицуулсан дотоодын хууль боловсруулах талаар дараах зөвлөмжийг гаргаж байв. Үүнд:

1. Хүний эрхийн Европын конвенц (ETS No. 5)-ийн шаардлагын дагуу, Гишүүн орнууд нь эрх бүхий байгууллагын зүгээс мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл ашиглаж болох нөхцөлүүдийг тус тусын хуульд тодорхойлж оруулах ёстой.

2. Нэгдүгээр зүйлд заасны дагуу, Гишүүн орнууд эрх бүхий этгээдийн мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл ашиглалтыг ардчилсан нийгэмд хэрэгцээтэй хийгээд эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж, яллахад тохирох хэмжээнд байлгахад чиглэсэн хууль зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

3. Гишүүн орнууд тусгай арга хэрэгслийн ашиглалтын зөвшөөрөл урьдчилан олгох, мөрдөн шалгах ажиллагааны явцад болон «экс пост» хэлбэрээр зохих хяналт тавих эрхийг шүүх эсвэл хөндлөнгийн бусад этгээдэд олгох хууль зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.⁴⁷

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 14 дүгээр хурлын “Терроризмтой тэмцэх үед тагнуулын байгууллагуудын хүний эрхийг дээдлэх, түүний дотор тэдний хяналтыг хангах хууль эрх зүй, институцийн тогтолцоо, арга хэмжээний сайн туршлага” тайланд мөн гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтын ач холбогдлыг

45 Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014), 21-22 дахь тал.

46 Ханс Борн, Эйдэн Уиллс, Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 34 дэх тал.

47 Мөн тэнд, 133 дахь тал.

тодорхойлсон байна. Мөн энэхүү ач холбогдлыг Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төвийн “Тагнуулын байгууллагын сайн туршлага ба тэдгээрийн хяналт”-ын стандарт⁴⁸ болгосон байна.

Тус тайланд дурдагдсанаар тагнуулын албаны хяналт нь дотоод, гүйцэтгэх, парламент, шүүх болон мэргэжлийн хяналтын байгууллагуудын хяналтаас бүрддэг байна. Энэхүү олон шатлалт хяналтын тогтолцоонд тагнуулын алба болон гүйцэтгэх засаглалын аль алианаас бүрэн хараат бус багадаа нэг институцийг оруулах нь сайн туршлага болдог. Энэ арга нь тагнуулын албанд хяналт тавихад эрх мэдлийн хуваарилалт байгааг илэрхийлдэг. Эдгээрийн чиг үүрэг нь тагнуулын байгууллагын үйл ажиллагааны бүх тал, түүний дотор хууль тогтоомжийг дагаж мөрдөх, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөтэй байдал, санхүү, захиргааны үйл ажиллагаа хамаарагддаг. Мөн хяналтын тогтолцооны үндсэн чиг үүргийн нэг бол тагнуулын албад холбогдох хууль тогтоомж, тэр дундаа хүний эрхийг хэрхэн мөрдөж байгаа эсэхийг шалгах явдал юм. Хяналтын үр дүнтэй тогтолцоо нь тагнуулын салбарт онцгой чухал бөгөөд учир нь эдгээр алба нь ихэнх ажлаа нууцаар гүйцэтгэдэг тул олон нийтийн хяналтад амархан ордоггүй. Ингэснээр мөн олон нийтийн итгэх итгэл нэмэгдэх ач холбогдолтой.⁴⁹

Мөн Европын Зөвлөлийн Венецийн Комиссын 102 дугаар хурлын “Тагнуулын байгууллага дахь ардчилсан хяналт” гэх тайланд гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтын ач холбогдлыг тодорхойлсон ба үүсэж болох асуудлын талаар дурджээ. Нэгдүгээрт, тагнуулын техникийн боловсронгуй байдал нь парламентын гишүүдэд техникийн мэргэжилтнүүдийн тусламжгүйгээр хяналт тавихад хэцүү болгодог. Хоёрдугаарт, парламентын гишүүд бусад бүх үүргийнхээ зэрэгцээ хяналт тавихад хангалттай цаг гаргаж чаддаггүй. Гуравдугаарт, зарим тагнуулын байгууллагуудын хамтын ажиллагаа өндөр байгаа нь парламентын хяналтыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах юм.⁵⁰

Европын парламентын “Европын холбоо дахь аюулгүй байдал, тагнуулын байгууллагуудын парламентын хяналт” судалгаанд дурдагдсанаар ихэнх улсуудад тагнуулын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгах үүрэгтэй парламентын болон тусгай хяналтын байгууллагууд байдаг талаар авч үзжээ. Тухайлбал, Австри, Бельги, Булгар, Болгар, Чех, Латв, Литв гэх мэт 31 улсуудад парламент нь гүйцэтгэх ажил буюу тагнуулын ажилд хяналт тавьдаг байна. Тогтолцоогоор авч үзвэл (1) парламентын ерөнхий хороод; (2) парламентын хяналтын мэргэшсэн хороод; (3) парламентын бус хяналтын тусгай байгууллагууд хамаарч байна.⁵¹

48 *International Standards, Compilation of Good Practices for Intelligence Agencies and their Oversight*, Geneva Centre for the Democratic Control of Armed Forces (DCAF), (DCAF, 2011), pp.17.

49 Martin Scheinin, *Report of the Special Rapporteur on the promotion and protection of human rights and fundamental freedoms while countering terrorism*, Human Rights Council Fourteenth session Agenda item 3.

50 Mr Iain Cameron (Member, Sweden), *Report on the democratic oversight of signals intelligence agencies*, Adopted by the Venice Commission at its 102nd Plenary Session (Venice, 20-21 March 2015)

51 *Parliamentary oversight of security and intelligence agencies in the european union*, European parliament, (2011), pp.87.

Гадаад улсуудын харьцуулсан судалгаа

Өмнөх хэсгүүдэд гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын ач холбогдол, хэрэгцээ, шаардлагын талаар авч үзсэн бол энэхүү хэсгээр гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналттай улсуудын сайн туршлага, практик, эрх зүйн зохицуулалтын талаар авч үзэх юм. Судлах улсуудын тухайд ардчилал, хууль дээдлэх ёс өндөр хөгжсөн улс болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улстай ижил пост-социалист эрх зүйн тогтолцоонд хамаарах Бүгд Найрамдах Эстони Улс болон Бүгд Найрамдах Австри улсыг сонгон судаллаа.

6.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны түвшинд бүх аюулгүй байдлын гурван алба (дотоод, гадаад, цэрэг) болон бүс нутгийн дотоод аюулгүй байдлын албаны хувьд парламентын хяналтад онцгой анхаарал хандуулдаг. Үйл ажиллагааны далд шинж чанараас шалтгаалж тэдний үйлдлийг шүүх, олон нийт хянахад хүндрэлтэй байгааг Парламентын хяналт нөхөх ёстой гэж үздэг. Парламентын хяналтын тогтолцоог холбооны түвшинд янз бүрийн үе шаттайгаар хэрэгжүүлсэн байдаг. 1956 онд хамгийн анх Парламентын омбудсмений хороог байгуулсан ч эрх зүйн үндэслэлгүй байсан учраас удаан үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнийг 1979 онд Парламентын Хяналтын зөвлөл залгамжилж, улмаар 1999 онд Парламентын Хяналтын хороо болсон.⁵² Өнөөдрийн байдлаар ХБНГУ-д гүйцэтгэх ажил буюу мэдээлэл олзворлох тусгай арга хэрэгслийн ашиглалтыг Парламентын хяналтын хороо хянадаг.

Хуулийн дагуу Засгийн газар тус хороонд тусгай арга хэрэгслийн ашиглалтын талаарх тайланг “зургаан сараас илүүгүй хугацааны давтамжтай” хүргүүлэх ёстой. Хороо нь эдгээр тайланд тулгуурлан Бундестагт тусгай арга хэрэгсэл ашигласан ажиллагаа, түүний хамрах хүрээний талаарх тайланг жил бүр гаргаж өгдөг байна. Тус хороо хяналтын энэ чиг үүргийн зэрэгцээ зөвшөөрөл олгох эрхийг мөн хуулиар эдэлдэг. Холбооны тагнуулын алба (гадаад тагнуулын алба) нь олон улсын цахилгаан холбооны сүлжээгээр “багцлан” дамжуулж буй, Герман Улс болон Германы иргэдтэй холбоотой байж болох мэдээлэлд нэвтрэхийн тулд тус хорооноос зөвшөөрөл авах ёстой. Энэ нь хэн нэгний харилцаа холбоонд тусгайлан чиглээгүй, харин түлхүүр үг ашиглан нийт мэдээллийг шүүж үзэх хэлбэр юм.⁵³

Үүнээс гадна ХБНГУ-д гүйцэтгэх ажиллагаанд G10 комисс⁵⁴ хяналт тавьдаг. Уг комисс нь дөрвөн гишүүнтэй, тэдний нэг нь шүүгч байх ёстой бөгөөд парламентын

52 Norbet Putter, “The Federal Republic’s security services from the Cold War to the “new security architecture””, *Statewatch Journal*, vol 19 no 4, pp.8.

53 Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 140 дэх тал.

54 Германы холимог тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бол хараат бус, хагас-шүүхийн шинж бүхий G10 хороо бөгөөд тус хорооны шийдвэрийг засгийн газар, тагнуулын байгууллага заавал даган биелүүлэх үүрэгтэй. Хорооны гишүүдийг Парламентын хяналтын хорооноос томилох ба заавал Бундестагийн гишүүн байх шаардлагагүй. G10 хороо нь захидал, харилцаа холбоонд нэвтрэх зөвшөөрлийг тагнуулын албадад олгох, энэ асуудлаар хяналт тавих үүрэгтэйгээр анх байгуулагдсан. Харин 2007 онд батлагдсан Терроризмтой тэмцэх тухай хуулиар тагнуулын албадын эрх мэдэл шинэчлэгдэхэд уг хорооны үүрэг хариуцлага мөн адил өөрчлөгдсөн байна. Өдгөө, сонирхож буй гар утасны байрлал, серийн дугаар, картын нууц дугаарыг тогтооход шаардлагатай мэдээллийг цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэгчдээс авахын тулд тагнуулын албад G10 хорооноос заавал урьдчилж зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

гишүүнийг оролцуулж болно. Комиссын гишүүдийг парламентын хяналтын хорооноос томилдог хэдий ч хараат бус байдлыг нь хуулиар тусгайлан баталгаажуулсан байдаг. Хорооны нэг гол үүрэг бол тагнуулын албадын зүгээс мэдээлэл олзворлох тусгай арга хэрэгсэл ашиглах нь хуулиар зөвшөөрөгдсөн хийгээд зайлшгүй шаардлагатай эсэхийг тогтоох явдал юм. Энэ хүрээнд Германы Засгийн газар уг хороонд тухайн сард тусгай арга хэрэгсэл ашиглан явагдах ажиллагааны мэдээллийг сар тутам хүргүүлэх үүргийг хуулиар хүлээдэг аж. Улмаар хорооноос тэдгээр арга хэрэгслийн аль нэгийг шаардлагагүй буюу хуульд нийцэхгүй гэж тогтоосон тохиолдолд Засгийн газар ажиллагаа явуулах шийдвэрээ цуцлах ёстой. G10 комисс нь мөн гомдол хүлээн авч, шийдвэрлэх чиг үүрэг гүйцэтгэдэг. Тодруулбал, мэдээлэл олзворлолтын тусгай арга хэрэгсэлтэй холбоотой гомдлыг хүлээн авч, уг гомдол уг арга хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах үндэслэл болох эсэхийг тогтоодог байна.⁵⁵

ХБНГУ-д гүйцэтгэх ажилд тавих парламентын дээрх хяналтыг тусдаа бие даасан “Холбооны Засгийн газрын гүйцэтгэх ажилд тавих Парламентын хяналтын тухай хууль” (Gesetz über die parlamentarische Kontrolle nachrichtendienstlicher Tätigkeit des Bundes (Kontrollgremiumgesetz - PKGrG)) гэх 2009 онд батлагдсан хуулиар зохицуулдаг байна. Тус хууль нь нийтдээ 15 зүйлээс бүрдэх бөгөөд зохицуулалтын агуулгыг дэлгэрүүлэн авч үзье.

Холбооны Засгийн газрын Холбооны Үндсэн хуулийг хамгаалах алба, Цэргийн сөрөх тагнуулын алба, Холбооны тагнуулын албаны үйл ажиллагаа нь Парламентын хяналтын хорооны хяналтад байдаг.

ХБНГУ-ын Бундестагаас хяналтын хорооны гишүүдийг сонгуулийн хугацааны эхэнд өөрийн гишүүдээсээ сонгодог бөгөөд гишүүдийн тоо, бүрэлдэхүүн, ажиллах арга, хэлбэрийг тогтоодог. Хяналтын хорооны гишүүн нь тус үүргээс татгалзсан, эсхүл Бундестаг болон түүний парламентын бүлгээс огцорсон, Холбооны Засгийн газрын гишүүн, Парламентын Төрийн нарийн бичгийн дарга болсон тохиолдолд парламентын хяналтын хорооны гишүүнчлэлээ алдана.

Тус хяналтын хороо нь улиралд дор хаяж нэг удаа хуралдах ёстой ба тус хурлаар хорооны дарга болон түүний орлогчийг сонгодог. Хорооны гишүүн бүр Парламентын хяналтын хороог хуралдуулж, мэдээлэл өгөх эрхтэй. Тус мэдээлэл нь нууцад хамаарахгүй мэдээлэл бол үүнийг хурлаас гадуур бичгээр болон цахимаар өгч болдог.

Холбооны Засгийн газар нь тус хяналтад хамаарах байгууллагуудын үйл ажиллагаа болон онцгой ач холбогдолтой үйл явдлын талаар тус хороонд иж бүрэн мэдээлэх үүрэгтэй. Ялангуяа дараах чиглэлээр мэдээллийг өгдөг.

1. Гадаад болон дотоод аюулгүй байдлын нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт үзүүлсэн;
2. Холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэхүйц дотоод үйл явц;
3. Улс төрийн хэлэлцүүлэг болон нийтийн сонсголын төв болж буй хувь хүний үйл явдал;

⁵⁵ Ханс Борн, Эйдэн Уиллс, *Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага*, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, 142 дахь тал.

Түүнчлэн, Парламентын хяналтын хорооны хүсэлтээр Холбооны Засгийн газар бусад үйл явдлын талаар мэдээлэх ёстой.

Парламентын хяналтын байгууллагын байнгын төлөөлөгч тогтмол болон тохиолдол тус бүрээр мөрдөн шалгалт явуулахад нь Парламентын хяналтын хороонд туслалцаа үзүүлнэ. Парламентын хяналтын хорооны даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулж, баримтыг шалгана. Байнгын төлөөлөгч нь Парламентын хяналтын хорооны шаардлагын хүрээнд заасны дагуу өгсөн үүрэг даалгавраа биелүүлэхийн тулд өөрийн үзэмжээр ажиллана. Парламентын нууцын хороо нь Парламентын хяналтын хороотой зөвшилцсөний үндсэн дээр Холбооны Төсвийн тухай хуульд заасан хяналт тавих эрхийн хүрээнд Байнгын бүрэн эрхт төлөөлөгчдөд тушаал гаргаж болно. Байнгын төлөөлөгч нь мөн Парламентын хяналтын хорооны хуралдаан, түүний тайланг Германы Бундестагийн нэгдсэн хуралдаанд бэлтгэдэг. Байнгын бүрэн эрхт төлөөлөгч өөрийн мөрдөн шалгалт болон бусад үйл ажиллагааны үр дүнгийн талаар парламентын хяналтын хорооны хурал бүрд тайлагнана. Парламентын Хяналтын хороо Байнгын бүрэн эрхт төлөөлөгчийн үйл ажиллагааны удирдамжийг гаргадаг. Байнгын төлөөлөгчийг Парламентын хяналтын хорооны санал болгосноор Германы Бундестагийн Ерөнхийлөгч таван жилийн хугацаагаар томилдог ба нэг удаа дахин томилохыг зөвшөөрдөг. Байнгын төлөөлөгчөөр зөвхөн 35 нас хүрсэн, шүүгчийн албан тушаал хаших эсвэл техникийн бус захиргааны өндөр алба хаших чадвартай, нууц мэдээлэлтэй ажиллах эрх авсан, нууцыг хадгалах үүрэг албан ёсоор хүлээсэн хүмүүсийг томилж болно. ХБНГУ-ын Бундестагийн Ерөнхийлөгч томилсон бичгийг гардуулснаар бүрэн эрх нь эхэлдэг. Байнгын төлөөлөгч тангараг өргөдөг. Бүрэн эрхийн хугацаа дуусах, эсвэл Германы Бундестагийн Ерөнхийлөгч түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үед бүрэн эрх нь дуусгавар болно. Байнгын төлөөлөгч нь ажил үүргийн хувьд зөвхөн Парламентын хяналтын хорооны зааврыг дагаж мөрдөнө.

Холбооны Засгийн газрын гаргаж өгөх мэдээлэл нь зөвхөн Холбооны тагнуулын албанд хамаарах мэдээллээр хязгаарлагдана. Хэрэв тухайн мэдээлэл хамаарахааргүй бол Парламентын хяналтын хороонд мэдэгддэг. Парламентын хяналтын байгууллагын хүсэлтээр Холбооны Засгийн газар холбогдох арга хэмжээг авч, Парламентын хяналтын байгууллагад энэхүү мэдээлэл, объектын талаар мэдээлэх боломжийг олгоно.

Парламентын хяналтын байгууллага нь гишүүдийнхээ гуравны хоёрын саналаар Холбооны Засгийн газрыг сонссоны дараа хяналтын үүргээ хэрэгжүүлэхийн тулд мөрдөн шалгалт явуулах тусгайлсан тохиолдолд шинжээч томилж болно. Шинжээч шалгалтынхаа үр дүнг Парламентын Хяналтын хороонд мэдээлэх ёстой. Парламентын хяналтын хороо гишүүдийн гуравны хоёрын саналаар мөрдөн шалгалтын талаарх бичгэн тайланг ХБНГУ-ын Бундестагт хүргүүлэхээр шийдвэрлэж болно. Тайлан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, тогтоосон баримт, мөрдөн байцаалтын үр дүнг тодорхойлсон байх ёстой.

Тагнуулын байгууллагын гишүүд албан ёсны асуудлаар болон дотоодод гарсан асуудлын талаар Парламентын хяналтын хороонд шууд мэдэгдэх боломжтой. Мөн ХБНГУ-ын Бундестагт хандсан иргэдийн мэдүүлгийг Парламентын хяналтын хороонд мэдэгдэж болно.

Парламентын нууцлалын хорооны хуралдаанд дарга, түүний орлогч, эрх бүхий гишүүн Парламентын хяналтын хороонд зөвлөхөөр оролцож болно. Парламентын хяналтын хорооны хэлэлцүүлэг нууц байна. Парламентын Хяналтын Хороо жилд нэг удаа холбооны тагнуулын албаны ерөнхийлөгч нарын нийтийн сонголыг явуулдаг. Парламентын хяналтын хорооны гишүүд Холбооны Засгийн газрыг сонссоны дараа хяналтын хороо зөвшөөрснөөр парламент дахь бүлгийнхээ гишүүдийг ажилд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор томилох эрхтэй. Энэхүү үйл ажиллагааны урьдчилсан нөхцөл нь нууц мэдээлэлтэй ажиллах зөвшөөрөл, нууцыг хадгалах албан ёсны үүрэг юм.

Парламентын хяналтын хороонд Бундестагийн захиргааны ажилтнууд шаардлагатай хэмжээгээр туслалцаа үзүүлнэ. Түүнчлэн тус хяналтад шаардагдах боловсон хүчин, материаллаг нөөцийг ХБНГУ-ын Бундестагийн төлөвлөгөөнд тагнуулын албанд тавих парламентын хяналт гэх тусдаа бүлэгт тусгах ёстой. Байнгын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хороонд томилогдсон ажилтнуудыг удирдаж үйл ажиллагаагаа явуулдаг.

Парламентын хяналтын хороо ХБНГУ-ын Бундестагт хийсэн хяналтын талаар сонгуулийн хугацаа бүрийн дунд болон төгсгөлд тайлагнадаг. Түүнчлэн Холбооны Засгийн газар тус байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэх, ялангуяа онцгой ач холбогдолтой үйл явдлын талаар мэдээлэх үүргээ биелүүлсэн эсэх талаар байр сууриа илэрхийлдэг.

Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Холбооны Засгийн газар болон Парламентын хяналтын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн хүсэлтээр Парламентын хяналтын хороо ба Холбооны Засгийн газар хоорондын маргааныг шийдвэрлэдэг.

Парламентын хяналтын байгууллага нь эрх бүхий байгууллагад хяналт тавих үүрэгтэй байгууллагуудтай хяналтын үйл ажиллагаатай холбоотой нийтлэг асуудлаар нууцлалын журмыг сахин мэдээлэл солилцож болно. G10 Комисс, Хараат бус хяналтын зөвлөл болон Холбооны Мэдээлэл хамгаалах, мэдээллийн эрх чөлөөний комиссар нь парламентын хяналтын байгууллагын хүсэлтээр нууцлалын холбогдох журмыг дагаж мөрдөхийн зэрэгцээ парламентын хяналтын хороонд мэдээлэл дамжуулж болно.⁵⁶

6.2. Бүгд Найрамдах Австри Улс

Бүгд Найрамдах Австри Улсын Парламентын хяналтыг ерөнхийдөө улс төрийн хяналт, хуулийн хяналт, санхүүгийн хяналт, аудитын хяналт гэж ангилдаг ба мөн омбудсмений хяналт, Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хамруулан авч үздэг.

Улс төрийн хяналт

Үндэсний зөвлөл ба Холбооны зөвлөл нь засгийн газрын үйл ажиллагааг шалгаж, хэрэгжилттэй холбоотой бүх асуудлаар түүний гишүүдэд асуулт тавих эрхтэй. Мөн шийдвэр гаргах ажиллагааны талаар (шийдвэр гаргах эрх) хүсэлтээ илэрхийлж болно. Мөрдөн шалгах хороодыг зөвхөн Үндэсний зөвлөл байгуулж болно.

⁵⁶ Kontrollgremiumgesetz vom 29. (Juli 2009), BGBl. I S. 2346, das zuletzt durch Artikel 10 des Gesetzes vom 19. (April 2021), BGBl. I S. 771 geändert worden ist.

Засгийн газрын үйл ажиллагаанд тавих дараах Парламентын хяналтын арга, хэрэгслүүд байдаг. Үүнд:

- Парламентын асуулт (тайлбарлах, асуулт асуух эрх)
- Итгэл үзүүлэхгүй байх санал
- Шийдвэр (шийдвэр гаргах эрх)
- Засгийн газрын гишүүдийг байлцуулахыг шаардах
- Мөрдөн шалгах хороо байгуулах
- Үндэсний зөвлөл болон Холбооны зөвлөлд тайлагнах
- Тагнуулын хяналтын байнгын болон дэд хороодыг байгуулах.⁵⁷

Хуулийн хяналт

Улс төрийн хяналтын хэрэгсэл нь мэдээлэл олж авах, дараа нь олон нийтэд болон улс төрийн хүрээнд хэлэлцэх зорилготой байдаг. Парламентын гишүүд улс төрийн хяналтын хэрэгслийг хэзээ ч ашиглаж болдог. Хуулийн хяналтын тухайд нөхцөл байдал өөр байдаг. Хуулийн хяналт нь улс төрийн хяналтаас илүү өндөр шаардлагууд тавьдаг. Энэ нь зөвхөн тодорхой тохиолдолд л үйлчилдэг. Зөвхөн хууль, эрх зүйн дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргана. Холбогдох бүх талуудад шударга байдлыг хангах ёстой.⁵⁸

Санхүүгийн хяналт

Үндэсний зөвлөл нь төсвийг баталж, төсвийн хяналтыг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналтын хувьд Аудитын шүүхийн хороонд тайланг нь урьдчилан хэлэлцдэг Аудитын шүүхийг ашигладаг. Мөн Аудитын хорооны байнгын дэд хороонд аудит хийх үүрэг өгч болно. Аудиторын шүүхээс гаргасан холбооны санхүүгийн тайланг Үндэсний зөвлөлөөр батлуулахаар хүргүүлдэг.⁵⁹

Аудитын хяналт

Аудиторын шүүх нь засгийн газрын удирдлага, хяналтад байдаг компаниуд болон Үндэсний зөвлөлийн нэрийн өмнөөс бусад хуулийн этгээдийг шалгадаг. Үйл ажиллагааныхаа талаар Үндэсний зөвлөлд тогтмол тайлагнадаг бөгөөд тусгай шалгалт хийлгэх боломжтой байдаг. Мөн улсын санхүүгийн тайлан, төсвийн орлогын тайланг бэлтгэдэг.⁶⁰

Омбудсмений хяналт

Омбудсмений зөвлөл нь бие даасан хяналтын байгууллага юм. Энэ нь сэжигтэй эсвэл захиргааны буруутай үйл ажиллагаа байгаа эсэхийг шалгах үүрэгтэй. Хууль эрх зүйн арга хэмжээ авах боломжгүй, эсвэл боломжтой хугацаа нь дууссан хэн бүхэн гомдол гаргаж болно. Баримтыг шалгасны дараа Омбудсмений зөвлөл зөвлөмж гаргаж болно.

57 Instrumente der politischen Kontrolle, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/politische-kontrolle>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

58 Politische und rechtliche Kontrolle, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/rechtliche-kontrolle>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

59 Finanzielle Kontrolle im Überblick, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/finanzielle-kontrolle>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

60 Rechnungshof, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/rechnungshof>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

Мөн Омбудсмений зөвлөл нь хүний эрхийг хамгаалах, дэмжих үүрэгтэй. Төрөл бүрийн чиг үүргийнхээ дагуу хууль дээдлэх, ардчиллын төлөө олон нийтийн хяналтыг хэрэгжүүлж, улс төр, хууль эрх зүй, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлдэг. Зөвлөл нь гурван гишүүнээс бүрддэг ба Үндэсний зөвлөлөөс зургаан жилийн хугацаатай сонгодог.⁶¹

Үндсэн хуулийн шүүхийн хяналт

Үндсэн хуулийн шүүх нь холбооны болон муж улсын хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгадаг. Энэ нь шүүх учраас зөвхөн эрх бүхий хүмүүсийн хүсэлтээр (жишээ нь, шүүх хуралдаанд оролцогчид) маргаан үүсгэх боломжтой. Харин нэг онцлог нь Үндсэн хуулийн шүүх өөрийн санаачилгаар хуулийн заалтыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах шийдвэр гаргадаг. Үндсэн хуулийн шүүх Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл уг хуулийг хүчингүй болгож болно. Тэрээр Үндэсний зөвлөл, Холбооны Зөвлөл, муж улсын парламентын хууль тогтоомжийг хянаж, засаж залруулдаг.⁶²

Австри дахь тагнуулын алба (Nachrichtendienste) нь төрийн захиргааны нэг хэсэг бөгөөд Австрийн эрх баригчдын бүтцэд багтдаг. Тагнуулын үйлчилгээ эрхэлдэг гурван байгууллага байдаг: Төрийн хамгаалалт, терроризмын эсрэг Холбооны агентлаг (Bundesamt für Verfassungsschutz und Terrorismusbekämpfung, BVT), Цэргийн батлан хамгаалах агентлаг (Heeresabwehramt) болон Цэргийн тагнуулын алба (Heeresnachrichtenamt).

1975 онд батлагдсан Процедурын тухай хуулийн § 32b (Geschäftsordnungsgesetz 1975)-ийн дагуу тагнуулын албыг хянах байнгын ажиллагаатай хоёр дэд хороог парламент байгуулдаг. БНАУ-ын Дотоод хэргийн байнгын дэд хороо нь Төрийн хамгаалалт, терроризмын эсрэг Холбооны агентлаг буюу цагдаагийн тагнуулын албыг хянадаг бол Улсын Батлан хамгаалах хорооны байнгын дэд хороо нь цэргийн тагнуулын албыг хянадаг. Дотоод хэргийн болон Батлан хамгаалахын сайд нар тухайн хороонд мэдээлэл өгөх ёстой. Үндэсний зөвлөлийн эрх бүхий хороод тус бүр цагдаагийн тагнуулын алба (жишээлбэл, улсын аюулгүй байдал, тагнуулын газар) болон зэвсэгт хүчин (сөрөг тагнуул, цэргийн тагнуул)-д хяналт тавих байнгын дэд хороог байгуулах ёстой. Энэ нь Дотоод хэргийн хороо, Үндэсний батлан хамгаалах хороонд нөлөөлдөг.

Бүрэлдэхүүн:

Үндэсний зөвлөлийн үндсэн хороонд хамаарах намын нэгээс доошгүй гишүүн дэд хороонд харьяалагдах ёстой. Хороо тус бүр нь 18 гишүүнээс бүрддэг. Хорооны гишүүд Засгийн газрын гишүүдээс мэдээлэл авах эрхтэй.⁶³ Тухайн гишүүдийг пропорциональ төлөөллийн зарчмаар сонгодог ба энэ нь сөрөг хүчин болон цөөнх

61 Volksanwaltschaft: Unabhängige Kontrolleinrichtung, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/volksanwaltschaft>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

62 Ein einzigartiges Gericht, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/verfassungsgerichtshof>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

63 National intelligence authorities and surveillance in the EU: Fundamental rights safeguards and remedies AUSTRIA Version of 22 September 2014, Холбоос: https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/austria-study-data-surveillance-at.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

намуудын баталгаа болдог.⁶⁴

Бүрэн эрх:

Дэд хорооны гишүүн бүр дэд хорооны хуралдааны үеэр Засгийн газрын хариуцлагатай гишүүнээс холбогдох мэдээллийг авах хүсэлт гаргаж болно. Гэхдээ баримт бичгийг шалгах хүсэлтэд дэд хорооны тогтоол шаардлагатай. Засгийн газрын гишүүн өөрөө боломжгүй, эсхүл энэ нь үндэсний аюулгүй байдал, хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулахгүй бол ийм мэдээлэл өгөх, баримт бичигт хандах эрх олгох үүрэгтэй.

Хурал:

Хорооны дарганаргурвансарднэгудаадэдхороодоохуралдуулдаг.Цаашилбал, дэд хорооны гишүүдийн дөрөвний нэг буюу засгийн газрын хариуцлагатай гишүүн хурлыг зарлан хуралдуулахыг шаардаж болно. Мөн хууль зүйн хамгаалалтын ажилтан, хариуцах чиглэлээр байгуулагдсан хяналтын комиссын дарга нар хурлыг зарлан хуралдуулахыг шаардаж болно.

Нууцлал:

Дэд хорооны хуралдаанууд нууц байдаг. Гишүүд нууцыг хадгалах үүргээ биелүүлэхийн тулд Үндэсний зөвлөлийн ерөнхийлөгчид тангараг өргөх ёстой.⁶⁵

64 *Parliamentary oversight of security and intelligence agencies in the european union*, European parliament, (2011), pp.92.

65 *Instrumente der politischen Kontrolle*, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/politische-kontrolle>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

Хүснэгт 2.11. БНАУ-ын гүйцэтгэх ажилд хяналт тавих байгууллага болон механизм⁶⁶

Хяналт тавих байгууллага, механизмын нэр	Хяналт тавих байгууллага, механизмын төрөл	Хуулийн үндэслэл	Хяналтын төрөл	Ажилтан	Эрх мэдэл
Тагнуулын албыг хянах байнгын дэд хороод (Ständige Unterausschüsse zur Kontrolle der Nachrichtendienste)	Парламентын нэг дэд хороо нь Дотоод хэргийн хорооны дэд хороо (Ausschuss für innere Angelegenheiten), нэг нь Батлан хамгаалах хорооны дэд хороо (Landesverteidigungs ausschuss) хэлбэрээр зохион байгуулагддаг. Энэ нь Австрийн тагнуулын албад хуваагдсантай холбоотой.	§ 32 b Процедурын тухай хууль (Geschäftsordnungsgesetz 1975)	Ex-post (дараах хяналт)	Дэд хороо бүр үндсэн байгаа намуудын нэг гишүүнээс бүрдэх ёстой. Хоёр дэд хороо 18 гишүүнтэй. Дэд хороодод бүлэг тус бүрээс нэг ажилтан, мөн УИХ-ын Тамгын газрын хоёр ажилтан тус тус ажилладаг.	Дэд хороодын гишүүн бүр Засгийн газрын гишүүдээс мэдээлэл авах эрхтэй. Баримт бичгийг шалгах хүсэлт гаргахад холбогдох салбар хорооны шийдвэр шаардлагатай. Засгийн газрын гишүүд баримт бичиг хандах боломжгүй, эсхүл үндэсний ашиг сонирхол, хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулахаас бусад тохиолдолд зөвшөөрөл олгох үүрэгтэй. Дэд хороодын ажил нууц учраас хэвлэл мэдээлэл, олон нийтэд мэдээлэл өгөх боломжгүй.

⁶⁶ National intelligence authorities and surveillance in the EU: Fundamental rights safeguards and remedies AUSTRIA Version of 22 September 2014, pp.20-26, Холбоос: https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/austria-study-data-surveillance-at.pdf, Сүүлд үзсэн: 2023.08.15.

<p>Хууль зүйн хамгаалалтын ажилтан (Аюулгүй байдлын цагдаагийн хууль)</p>	<p>Төрийн захиргааны ажилтан</p>	<p>§ 91a Аюулгүй байдлын цагдаагийн тухай хууль</p>	<p>Ex-ante (Өмнөх хяналт) болон Ex-post (дараах хяналт)</p>	<p>Аюулгүй цагдаагийн дагуу гүйцэтгэгчтэй зүйн Холбооны ажилтан байна. Тэднийг Холбооны Ерөнхийлөгч, санал болгосны дараа, Үндэсний ассамблейн дарга (Nationalrat), Үндсэн хуулийн шүүхийн дарга, захиргааны дээд шүүхийн саналыг сонссоны дараа таван жилийн хугацаагаар томилдог. Дахин томилох боломжтой. Түүнд хоёр орон гүйцэтгэгч болон өөр хоёр хүн (нэг товчооны дарга, нэг хуулийн туслах) тусалдаг.</p>	<p>(§ 21 3 SPG-д заасан) § 91c (3)-д зааснаар энэхүү урьдчилсан зөвшөөрөл нь § 21 (3) SPG-ийн бүх арга хэмжээнд хамаарна. § 54 (2, 2a, 3, 4)-д заасны дагуу (ажиглалт, мөрдөн шалгалт, видео болон аудио тандалт) аюулын судалгааны тусгай аргыг мөрдөн байцаалтын тусгай аргуудаар төлөвлөж байгаа бол түүнчлэн цуглуулсан өгөгдлийг боловсруулах шаардлагатай бол мөн адил хамаарна. § 53 (5)-д (өөрөөр хэлбэл, төрийн болон хувийн хэвшлийн хуулийн субъектүүдийн аудио эсвэл видео төхөөрөмж ашиглан цуглуулсан мэдээлэл). Хувийн мэдээлэлтэй холбоотой аливаа мөрдөн байцаалтын талаар өмнө нь эсвэл аль болох хурдан (ehestmöglich) мэдэгдэх ёстой. § 91 в SPG-ийн дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хянах эрхтэй. Нөлөөлд өртсөн хүмүүст § 26 (2) Мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу мэдэгдэхгүй бол мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэх эсвэл гомдол гаргах шаардлагатай. Жил бүрийн 3 дугаар сарын 31-ний хүртэл Холбооны Дотоод хэргийн яаманд жилийн тайлан гаргаж өгдөг. § 91 в (1)-д зааснаар SPG-ийн аюулгүй байдлын эрх бүхий байгууллага нь Холбооны Дотоод хэргийн сайдад мэдээлэх замаар хувийн мэдээлэлд хийсэн аливаа шалгалтын талаар Хууль зүйн хамгаалалтын ажилтанд мэдэгдэх үүрэгтэй. Гурав хоногийн дотор хууль хяналтын ажилтанд мэдэгдэл хийх боломжийг олгох ёстой. Видео болон аудио тандалтыг бодитоор ашиглах эсвэл мэдээлэл боловсруулах ажлыг зөвхөн гурван өдрийн дараа буюу Хууль зүйн албаны ажилтан мэдэгдэл хийсний дараа эхлүүлэхийг зөвшөөрнө (§ 91 в (2)).</p>
---	----------------------------------	---	---	---	--

<p>Хууль зүйн хамгаалалтын ажилтан (Цэргийн эрх мөдлийн тухай хууль)</p>	<p>Төрийн захиргааны ажилтан</p>	<p>§ 57 Цэргийн эрх мөдлийн тухай хууль</p>	<p>Аль аль хяналт</p>	<p>Цэргийн албаны дагуу хоёр орлон гүйцэтгэгчтэй нэг хууль хяналтын ажилтан байна. Тэднийг Холбооны Ерөнхийлөгч, Холбооны Засгийн газрын санал болгосны дараа, Үндэсний ассамблейн (Nationalrat), дарга (Yndesnen Huuulin Shuuxiin Darga, захиргааны дээд шүүхийн саналыг сонссоны дараа таван жилийн хугацаагаар томилдог. Дахин томилгох боломжтой. Хууль зүйн ажилтан болон түүнийг орлон гүйцэтгэгч нь туслах ажилтнаар гурван хүнтэй байна.</p>	<p>Холбогдох бүх мэдээлэлд хандах, албан ёсны нууцыг ашиглах боломжгүй. Мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу өгөгдлийг засварлах, устгахтай холбоотой үүргийг дагаж мөрдөх ёстой. Цэргийн бэлэн байдал эсвэл Үндэсний батлан хамгаалахын ашиг сонирхолд аюул учруулахаас бусад тохиолдолд хүмүүст аюул учруулах, саад учруулбал мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэх эсвэл гомдол гаргах шаардлагатай. Жил бүрийн 3 дугаар сарын 31-ний хүртэл Холбооны Батлан хамгаалах, спортын сайдад жил бүрийн тайлан гаргана.</p>
<p>Мэдээлэл хамгаалах газар</p>	<p>Төрийн захиргааны ажилтан</p>	<p>§§ 30, 31, 35, 36 Мэдээлэл хамгаалах тухай хууль</p>	<p>Ex-post (дараах хяналт)</p>	<p>Мэдээллийг хамгаалах байгууллагын даргыг Холбооны Ерөнхийлөгч (Бундеспresident) § 36 DSG-ийн дагуу таван жилийн хугацаатай томилдог. Үүнийг Холбооны канцлер зохицуулах ёстой. Мэдээлэл хамгаалах газар нь нийт 24 хүний бүрэлдэхүүнтэй, тэдний 6 нь цагийн ажилтан байдаг.</p>	<p>Хувь хүний гомдлын дагуу хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гаргадаг. Зарим тохиолдолд (§ 30 DSG 2000) зөвлөмж гаргадаг. (заавал биелүүлэх шаардлагагүй)</p>

6.3. Бүгд Найрамдах Эстони Улс

Рийгикогугийн Аюулгүй байдлын албанд хяналт тавих хороо

БНЭУ-д тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих парламентын хяналтыг Рийгикогугийн Аюулгүй байдлын албанд хяналт тавих хороо хэрэгжүүлдэг.⁶⁷ Харин гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Засгийн газрын аюулгүй байдлын хороо хэрэгжүүлдэг. Рийгикогу буюу тус улсын парламент нь байнгын 11 хороо, сонгон шалгаруулалт, хяналт шалгалтын 3 хороотой. Сонгон шалгаруулах, хяналт шалгалтын хороодын нэг нь Аюулгүй байдлын албанд хяналт тавих хороо юм. Хороо нь 6 гишүүний бүрэлдэхүүнтэй. Мөн тус хорооны хуралдаан хаалттай явагддаг.⁶⁸

Тус улсад үндэсний аюулгүй байдал, үндсэн хуулийн дэг журмыг сахиулах, аюулгүй байдлын байгууллагын чиг үүрэг, бүрэн эрх, аюулгүй байдлын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх журмыг Аюулгүй байдлын албаны тухай хууль (Security Authorities Act)-аар зохицуулдаг.⁶⁹ Аюулгүй байдлын албанд хяналт тавих хорооны эрх, үүргийг тус хуулиар зохицуулсан бөгөөд энэхүү хороо нь тус хуулийн 36-р зүйлийн дагуу байгуулагдсан.

Чиг үүрэг

Рийгикогугийн Аюулгүй байдлын албанд хяналт тавих хорооны үндсэн чиг үүрэг нь аюулгүй байдлын байгууллага болон тандалтын агентлагуудын үйл ажиллагаа, тэр дундаа хүний хувийн мэдээллийг олзворлох, боловсруулахад тавигдах шаардлагыг дагаж мөрдөх, баталгаа гаргахтай холбоотой асуудлаар гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих⁷⁰ явдал юм. Тус хорооны гишүүд нь албан тушаалтнууд төрийн болон хувийн нууц, түүнчлэн ажлын явцад олж мэдсэн гадаад улсын нууцын зэрэглэлтэй мэдээллийн нууцыг хадгалах үүргийг хүлээдэг.

Тодруулбал, Дотоод аюулгүй байдлын алба, Гадаад тагнуулын албаны үйл ажиллагаа нь Бүгд Найрамдах Эстони Улсын Үндсэн хууль, Эрүүгийн процессын хуульд нийцэж буй эсэх, түүнчлэн тус улсад алба хааж байсан болон хамтран ажиллаж байсан хүмүүсийг бүртгэх, задруулах журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина. Мөн хороо нь Цагдаа, Хил хамгаалах зөвлөл, Хууль зүйн яамны Хорих анги, Татвар, гаалийн газрын Мөрдөн шалгах хэлтсийн үйл ажиллагаа Эрүүгийн процессын хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг.⁷¹

Аюулгүй байдлын албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2-т зааснаар Ерөнхий сайд, холбогдох сайд нь аюулгүй байдлын байгууллага болон тандалтын агентлагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн үйл ажиллагаанд тавьсан хяналтын

67 *Parliamentary oversight of security and intelligence agencies in the european union*, European parliament, (2011), pp.94.

68 БНЭУ-ын парламент Рийгикогугийн албан ёсны цахим хаяг, Security Authorities Surveillance Select Committee, Холбоос: <https://www.riigikogu.ee/en/parliament-of-estonia/committees/security-authorities-surveillance-select-committee/>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

69 Security Authorities Act, 2000, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/503062020002/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

70 Мөн тэнд.

71 БНЭУ-ын парламент Рийгикогугийн албан ёсны цахим хаяг, Security Authorities Surveillance Select Committee, Холбоос: <https://www.riigikogu.ee/en/parliament-of-estonia/committees/security-authorities-surveillance-select-committee/>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

тухай тайланг зургаан сард нэг ба түүнээс дээш удаа Аюулгүй байдлын албаны хяналтын хороонд тайлагнах үүргийг хүлээсэн байдаг.

Бүрэн эрх

Аюулгүй байдлын албаны хяналтын хороо нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дуудан ирүүлэх, баримт бичиг гаргуулах эрхтэй.⁷²

Мөн аюулгүй байдлын албаны хяналтын хороо аюулгүй байдлын байгууллагын төсвийг батлахад чухал оролцоотой. Аюулгүй байдлын байгууллагын төсвийн төслийг улсын төсвийн төслийг хэлэлцэхтэй зэрэг Рийгикогуд хэлэлцдэг.

Аюулгүй байдлын албаны хяналтын хороо нь жилд нэг удаа Хорооны үйл ажиллагаа, үр дүнгийн тайланг Рийгикогуд хүргүүлдэг.

Аюулгүй байдлын албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 6-д зааснаар Аюулгүй байдлын албаны хяналтын хорооны шалгалтын явцад гэмт хэрэг илэрсэн тохиолдолд хороо холбогдох материалыг мөрдөн шалгах байгууллага, эсвэл Хууль зүйн канцлерт шилжүүлдэг.

Аюулгүй байдлын албаны даргын томилгоо

Тагнуулын байгууллагын даргыг томилоход парламентын хяналтын байгууллагууд тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Улс орнуудад түгээмэл оролцооны гурван хэлбэр байна. Нэгдүгээрт, засгийн газраас тодорхой хүнийг агентлагийн захирлаар томилох хүсэлтэй байгаагаа хяналтын хороодод мэдээлэхийг шаардах, хоёрдугаарт, хамгийн түгээмэл нь хяналтын хороод нь нэр дэвшигчийн сонгол хийх боломжтой бөгөөд санал болгож буй томилгооны талаар заавал биелүүлэх үүрэг хүлээдэггүй дүгнэлт, зөвлөмж гаргадаг. БНЭУ-ын хувьд энэ төрөлд хамаарна. Рийгикогу (парламент)-ын Аюулгүй байдлын албаны хяналтын хороо санал болгож буй томилгооны талаар дүгнэлт гаргах эрхтэй байдаг.

Харьцуулсан судалгааны дүгнэлт

Гүйцэтгэх ажилд парламент, түүний тусгай хороо хяналт тавих нь олон улсын жишиг болсон үйл ажиллагаа бөгөөд олон улсын байгууллагууд болон улс, орнууд тус механизмын ач холбогдлыг чухалчилж авч үздэг байна. Тухайлбал, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв (DCAF), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Европын зөвлөлийн Венецийн комисс, Европын парламент зэрэг олон улсын байгууллагын зүгээс гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтын ач холбогдлыг онцолсон ба хараат бус, хөндлөнгийн хяналтыг бий болгож хүний эрх, эрх чөлөөг хангагдах сайн туршлага, стандарт гэж үзсэн байна. Мөн түүнчлэн гадаад улсуудад (ялангуяа эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад) гүйцэтгэх ажилд парламент хяналт тавих тогтолцоо өргөнөөр нэвтэрсэн нь түүний онцгой ач холбогдол нь дэлхий нийтийн жишиг болсныг харуулж байна. Тус харьцуулсан судалгааны хүрээнд сайн туршлага болгон Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Эстони Улсыг судлан үзсэнээр дараах дүгнэлтэд хүрч байна.

72 БНЭУ-ын парламент Рийгикогугийн албан ёсны цахим хаяг, Security Authorities Surveillance Select Committee, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Холбоос: <https://www.riigikogu.ee/en/parliament-of-estonia/committees/security-authorities-surveillance-select-committee/>, Сүүлд үзсэн огноо: 2023.08.15.

ХБНГУ-ын хувьд тагнуулын албанд буюу гүйцэтгэх ажилд Парламентын хяналтын хороо болон гүйцэтгэх ажил хуулиар зөвшөөрөгдсөн, зайлшгүй эсэхийг шалгах үүрэгтэй Парламентын хяналтын хорооноос томилогддог G10 комисс хяналт тавьдаг байна. ХБНГУ-ын Бундестаг нь “Холбооны засгийн газрын гүйцэтгэх ажилд тавих Парламентын хяналтын тухай хууль”-ийг 2009 онд баталсан бөгөөд тус хуулиар гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтыг зохицуулдаг байна. Энэ хууль нь 15 зүйлтэй бөгөөд сайн туршлага болохуйц зохицуулалтуудыг агуулсан. Тухайлбал, Парламентын хяналтын хорооны гишүүдийг сонгох журам, огцруулах үндэслэл, ажиллах хэлбэрийг тогтоох, Парламентын хяналтын хорооны хуралдах журам, нууцлалыг хамгаалах, мэдээллийг хязгаарлах үндэслэл, Парламентын хяналтын хорооны чиг үүрэг, бүрэн эрх, хамаарах асуудал, шинжээч томилох, байнгын төлөөлөгч томилох, ажиллах журмыг тогтоох, Бундестагт үйл ажиллагааг тайлагнах, бусад байгууллагуудтай харилцах зэрэг эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Түүнчлэн, тус тогтолцоо 1999 оноос хойш ХБНГУ-д хэрэгжиж байгаа нь түүний тогтвортой шинжийг илтгэж байна.

БНАУ-ын тухайд Парламентын хэрэгжүүлэх хяналтыг улс төрийн хяналт, хуулийн хяналт, санхүүгийн хяналт, омбудсмены хяналт, Үндсэн хуулийн шүүхийн хяналт гэж хувааж үздэг. Улс төрийн хяналтын хэлбэрт тагнуулын хяналтын байнгын болон дэд хороог байгуулах үйл ажиллагаа хамаардаг бөгөөд үүгээр дамжуулж гүйцэтгэх ажилд Парламент буюу Үндэсний зөвлөл нь хяналт тавьдаг. Энэхүү хяналтыг 1975 оны “Процедурын тухай хууль”-аар зохицуулдаг бөгөөд Дотоод хэргийн байнгын дэд хороо, Улсыг батлан хамгаалах байнгын дэд хороо нь хяналт тавих нэгжийг бүрдүүлдэг. Зохицуулалтын тухайд тус хороодын бүрэлдэхүүн, томилгооны журам, засгийн газраас мэдээлэл авах журам, хурлын үйл ажиллагаа, нууцлал зэргийг зохицуулснаас гадна хууль зүйн хамгаалалтын ажилтан болон мэдээлэл хамгаалах газар нь тус хяналтад чухал үүрэгтэй байна.

БНЭУ-ын тухайд тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих парламентын хяналт нь зөвхөн тагнуулын байгууллагын үйл ажиллагаан дахь хяналтаар хязгаарлагддаггүй. Тагнуулын ажиллагаа явуулдаг бүхий л байгууллагын тагнуулын ажиллагаанд хяналт тавьдагараа онцлог. Мөн парламент тагнуулын үйл ажиллагаанд хяналт тавихад нэн түрүүнд учирдаг бэрхшээл болох холбогдох байгууллагаас баримт бичиг гаргуулах явдлыг Аюулгүй байдлын албаны хяналтын хорооны бүрэн эрхэд хамааруулан хуульчилсан нь дэвшилттэй зохицуулалт болжээ. Түүнчлэн тагнуулын байгууллагын удирдлагын томилгоонд заавал биелүүлэх үр дагаваргүй зөвлөмж гаргаж оролцдог нь аюулгүй байдлын салбарт хяналт тавих чиг үүргээ эрх мэдэл хоорондын тэнцвэрт байдлыг алдагдуулалгүйгээр хэрэгжүүлж буй сайн туршлага болж байна.

VII. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгаа буюу “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-ны хүрээнд 6 бүлэг бүхий аргачлалыг үндэслэн Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судаллаа. Энэхүү үе шатуудыг дүгнэн үзвэл дараах үр дүнд хүрч байна.

Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг бий болгох хэрэгцээ, шаардлага нь ерөнхийдөө хоёр нөхцөл байдлаас үүдэлтэй гэж харагдаж байна. Нэгдүгээрт, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг бий болгох нь гүйцэтгэх ажлын болон Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах болон хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, хянах хэрэгцээ, шаардлагаас үүсэж байна. Хоёрдугаарт, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг бий болгох нь 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүний дагуу батлагдсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын 2023 оны 26 дугаар тогтоолоор үүрэг болгосны дагуу Хянан шалгах түр хороотой холбоотойгоор засаглалын хяналт-тэнцлийг хангах нөхцөл байдлаас шалтгаалж байна.

Гүйцэтгэх ажил нь үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах тодорхой зорилтыг хэрэгжүүлэхдээ холбогдох хуульд зааснаас өөр арга хэрэгслийг ашиглах боломжгүй тохиолдолд хүний эрх, эрх чөлөөнд нууцаар болон илээр түр хязгаарлалт хийдэг. Нууц арга хэрэгсэл нь гүйцэтгэх ажлын зарчим бөгөөд мөн чанар болдог. Иймд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх эрсдэлтэй байдаг. Өнөөгийн практикаас үзвэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас өмнө гадаад хяналтгүйгээр буюу зөвшөөрөл авахгүйгээр гүйцэтгэх ажил явуулах болон тодорхой тохиолдолд хуульд заасан үндэслэл, шаардлагыг зөрчиж гүйцэтгэх ажил явуулах гэх мэтээр хүний эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдөх нөхцөл байдалд хүргэж байна.

Аюулгүй байдлын салбар, тэр дундаа төрийн бусад цэрэгжсэн байгууллага, тусгай байгууллагын гүйцэтгэх ажилд парламентын хяналт онцгой ач холбогдолтой байдаг. Ингэснээр гүйцэтгэх ажлын явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, засаглалын хяналт-тэнцэл хангагдах нөхцөл бүрдэнэ. Ийнхүү хяналт тавихдаа парламентаас тусгай хяналтыг тусгай хороогоор хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна. Монгол Улсын хувьд Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу болон дээрх ач холбогдлоос шалтгаалан гүйцэтгэх ажилд Улсын Их Хурал, түүний байнгын, дэд болон хянан шалгах түр хороогоор дамжуулан хяналт тавих зайлшгүй шаардлага бий болж байна.

Дээрхтэй холбоотой судалгааг өмнөх хэсгүүдэд оруулсан ба аргачлалын дагуу эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдийг тодорхойлсон. Мөн үүнээс гадна тус хэрэгцээ, шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэдгээрээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан. Нэгдүгээр хувилбарыг “Гүйцэтгэх ажилд хяналт тавих эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх” гэж, хоёрдугаар хувилбарыг “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах замаар асуудлыг шийдвэрлэх” гэж тус тус тодорхойлсон.

Улмаар тус хоёр хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр эерэг үр дүн болон сөрөг үр дагаврыг нэг бүрчлэн, нарийвчлан тодорхойлсон. Үүний үр дүнд зорилгод хүрэх байдал, шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 2 нь хувилбар 1-ээс эерэг үр дүнг үзүүлж байна. Мөн зохицуулалтын хувилбар 2-ыг сонгосноор Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцсэн буюу эдгээрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй болохыг анхаарах нь зүйтэй.

Дүгнэж үзвэл, хувилбар 2 буюу “Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтыг тодорхойлон хуульчлах замаар асуудлыг шийдвэрлэх” хувилбарын тухайд хэрэгцээ, шаардлагад илүү нийцтэй, шийдвэрлэх арга зам болж чадахаар байна.

Харьцуулсан судалгааны хувьд гүйцэтгэх ажилд парламент, түүний тусгай хороо хяналт тавих нь олон улсын жишиг бөгөөд олон улсын байгууллагууд болон улс, орнууд тус механизмын ач холбогдлыг чухалчилж авч үздэг болох нь тодорхойлогдсон. Тухайлбал, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв (DCAF), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Европын зөвлөлийн Венецийн комисс, Европын парламент зэрэг олон улсын байгууллагын зүгээс гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтын ач холбогдлыг онцолсон ба хараат бус, хөндлөнгийн хяналтыг бий болгож хүний эрх, эрх чөлөө хангагдах сайн туршлага, стандарт гэж үзсэн байна. Мөн гадаад улсуудад (ялангуяа эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад) гүйцэтгэх ажилд парламент хяналт тавих тогтолцоо өргөнөөр нэвтэрсэн нь түүний онцгой ач холбогдол нь дэлхий нийтийн жишиг болсныг харуулж байна.

Түүнчлэн, тус судалгаагаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Эстони Улсыг сонгон судлан үзэхэд сайн туршлага болох зохицуулалтууд тусгагдсан байна. Тодруулбал, ХБНГУ нь тухайлсан хуулиараа Парламентын хяналтын хорооны гишүүдийг сонгох журам, огцруулах үндэслэл, ажиллах хэлбэрийг тогтоох, Парламентын хяналтын хорооны хуралдах журам, нууцлалыг хамгаалах, мэдээллийг хязгаарлах үндэслэл, Парламентын хяналтын хорооны чиг үүрэг, бүрэн эрх, хамаарах асуудал, шинжээч томилох, байнгын төлөөлөгч томилох, ажиллах журмыг тогтоох, Бундестагт үйл ажиллагааг тайлагнах, бусад байгууллагуудтай харилцах зэрэг харилцааг зохицуулсан нь иж бүрэн зохицуулалт бөгөөд бүхэлдээ сайн туршлага болж байна. БНАУ-ын тухайд хоёр тусдаа хороогоор буюу Дотоод хэргийн байнгын дэд хороо, Улсыг батлан хамгаалах байнгын дэд хороогоор тус хяналтыг хэрэгжүүлдэг ба тус хороодын бүрэлдэхүүн, томилгооны журам, засгийн газраас мэдээлэл авах журам, хурлын үйл ажиллагаа, нууцлал зэргийг зохицуулсныг мөн сайн туршлага гэж үзэж байна. БНЭУ-ын тухайд тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих парламентын хяналт нь зөвхөн тагнуулын байгууллагын үйл ажиллагаан дахь хяналтаар хязгаарлагддаггүй бөгөөд холбогдох байгууллагаас баримт бичиг гаргуулах явдлыг Аюулгүй байдлын албаны хяналтын хорооны бүрэн эрхэд хамааруулан хуульчилсан

нь дэвшилттэй зохицуулалт болжээ. Түүнчлэн, тагнуулын байгууллагын удирдлагын томилгоонд заавал биелүүлэх үр дагаваргүй зөвлөмж гаргаж оролцдог нь аюулгүй байдлын салбарт хяналт тавих чиг үүргээ эрх мэдэл хоорондын тэнцвэрт байдлыг алдагдуулалгүйгээр хэрэгжүүлж буй сайн туршлага байна.

Эцэст нь дүгнэвэл, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага дээрх байдлаар тодорхойлогдож байх ба Монгол Улсын хувьд тусгайлан хуульчлах замаар тус харилцааг бий болгох нь зүйтэй. Ийнхүү зохицуулахдаа гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтыг зохицуулсан гадаадын улсуудын зохицуулалтаас сайн туршлагыг нутагшуулах замаар болон өөрийн орны парламентын болон гүйцэтгэх ажилд нийцүүлэх замаар хуульчлах шаардлагатай юм.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, (2001).
3. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, (2015).
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017).
5. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, (2020).
6. Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, (2020).
7. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, (2021).
8. Гүйцэтгэх ажлын тухай хууль, (1997).
9. Тагнуулын байгууллагын тухай хууль, (1999).
10. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2020).
11. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, (2021).
12. Төрийн албаны тухай хууль, (2017).
13. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, (2010).
14. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал.
15. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн танилцуулга.
16. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.

Гадаад хэлээр:

1. Kontrollgremiumgesetz vom 29. (Juli 2009), BGBl. I S. 2346, das zuletzt durch Artikel 10 des Gesetzes vom 19. (April 2021), BGBl. I S. 771 geändert worden ist (Germany).
2. Geschäftsordnungsgesetz, (1975), Austria.
3. Security Authorities Act of Estonia (2000).

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. М.Цогтоо, Ц.Очгэрэл нар, Гүйцэтгэх ажлын удирдахуй, (УБ, 2021).
2. Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал”, Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил /Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл/, (УБ, 2010).
3. Ханс Борн, Эйдэн Уиллс, Тагнуулын албадыг хянах нь: гарын авлага, Орч. Улаанбаатар Бодлогын Судалгааны Төв, (Женев, 2002), Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв.

4. Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт: Зарчим, механизм, үйл ажиллагаа, Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №5-2003, Олон улсын парламентын холбоо, Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв, Орч. Э.Энхгэрэл, (УБ, 2014).
5. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, (УБ, 2022).
6. Монгол Улсын жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Жендерийн үндэсний хорооны ажлын алба (УБ, 2021).

Гадаад хэлээр:

1. International Standards, Compilation of Good Practices for Intelligence Agencies and their Oversight, Geneva Centre for the Democratic Control of Armed Forces (DCAF), (DCAF, 2011).
2. Martin Scheinin, Report of the Special Rapporteur on the promotion and protection of human rights and fundamental freedoms while countering terrorism, Human Rights Council Fourteenth session Agenda item 3.
3. Mr Iain Cameron (Member, Sweden), Report on the democratic oversight of signals intelligence agencies, Adopted by the Venice Commission at its 102nd Plenary Session (Venice, 20-21 March 2015).
4. Parliamentary oversight of security and intelligence agencies in the european union, European parliament, 2011.
5. Norbet Putter, "The Federal Republic's security services from the Cold War o the "new security architecture"", Statewatch Journal, vol 19 no 4.

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Холбоос: <https://legalinfo.mn/mn>.
2. Монгол Улсын тагнуулын ерөнхий газрын цахим хуудас, Холбоос: <https://www.gia.gov.mn/>.

Гадаад хэлээр:

1. Instrumente der politischen Kontrolle, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/politische-kontrolle>.
2. Politische und rechtliche Kontrolle, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/rechtliche-kontrolle>.
3. Finanzielle Kontrolle im Überblick, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/finanzielle-kontrolle>.
4. Rechnungshof, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/rechnungshof>.
5. Volksanwaltschaft: Unabhängige Kontrolleinrichtung, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/volksanwaltschaft>.
6. Ein einzigartiges Gericht, Холбоос: <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/verfassungsgerichtshof>.

7. National intelligence authorities and surveillance in the EU: Fundamental rights safeguards and remedies AUSTRIA Version of 22 September 2014, Холбоос: https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/austria-study-data-surveillance-at.pdf.
8. БНЭУ-ын парламент Рийгикогугийн албан ёсны цахим хаяг, Security Authorities Surveillance Select Committee, Холбоос: <https://www.riigikogu.ee/en/parliament-of-estonia/committees/security-authorities-surveillance-select-committee/>.

ГУРАВ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Дөлгөөн	Судлаач, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
О.Төрболд	Судлаач
З. Янжинлхам	Судлаач

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.12.12.

АГУУЛГА

УДИРТГАЛ	141
I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	143
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	143
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	144
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	145
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	145
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	145
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	146
II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	147
III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	149
3.1. Эрх хязгаарлах арга хэмжээ авдаг улс	150
3.2. Эрх хязгаарлах арга хэмжээ авдаггүй улс	156
IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	171
4.1 Дүгнэлт	171
4.2. Зөвлөмж	173
НОМ ЗҮЙ	175

УДИРТГАЛ

Монгол Улс нь анх 1964 онд “Захиргааны комиссын дүрэм”¹ –ээр “Захиргааны зөрчил”-ийг “төрийн удирдлагын явцад үүссэн нийгмийн харилцааг хөндөж уг харилцаанд нийтээр дагаж биелүүлбэл зохих журмыг зөрчсөн нийгмийн хор аюултай, гэм буруутай үйлдэл ба эс үйлдэхүй”² хэмээн тодорхойлж, зөрчил шалгах процессыг тусгаж байсан түүхтэй. 1992 онд ардчилсан Үндсэн хууль батлагдсантай холбогдуулан, захиргааны зөрчил, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг Захиргааны хариуцлагын тухай хууль (1992)³-аар зохицуулах болж, 2015 онд Зөрчлийн тухай хуулиар⁴ шинэчлэн найруулсан.

2015 оны Зөрчлийн тухай хуулиар Захиргааны хариуцлагын тухай хууль болон нийгмийн тодорхой харилцааг зохицуулж буй 220 гаруй салбарын хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээнүүдийг төрөлжүүлэн нэгтгэсэн. Гэвч хэд хэдэн хуулиар зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг харилцан адилгүй зохицуулж, хууль бусаар байгууллагын хэмжээнд тогтоосон журмаар хүний эрхийг хязгаарлах зэргээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг гажуудуулж, улмаар хуулийн давхардал хийдэл, зөрчлийг бий болгож байсан.⁵ Эдгээр сөрөг үр дагавруудыг залруулж аливаа зөрчлийг шалган шийдвэрлэхэд баримтлах журмыг бие даасан, нэгдмэл хуулиар зохицуулах замаар хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хүний эрхийг хангах үүднээс 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (цаашид “ЗШШТХ” гэх)-ийг баталсан байна. Хууль тогтоогчийн зүгээс 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Зөрчлийн тухай хууль (цаашид “ЗТХ” гэх), ЗШШТХ-аар нэгдүгээрт нийгмийн хор аюул багатай, хүний эрх чөлөө, эрүүл мэнд, эд хөрөнгийн эсрэг чиглэсэн үйлдлүүд; хоёрдугаарт хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлууд; гуравдугаарт гудамж талбайд ил үйлдэгддэг нийтлэг журмын эсрэг зөрчлүүд гэсэн гурван бүлэг эрх зүйн зөрчлүүдийг нэгтгэн төрөлжүүлж тус бүрд нь шалгах, шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ялгамжтай тодорхойлох бодлогыг баримталжээ.⁶

Гэвч ЗШШТХ хэрэгжиж эхэлснээс хойш 6 жилийн хугацаа өнгөрөөд байгаа боловч тус хуульд нийт 36 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд практикт хууль хэрэгжүүлэгчид болон судлаач нарын дунд хуулийн зарим зүйл, заалт бодит байдал дээр хангалттай хэрэгжихгүй, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод заасан хүний эрх, эрх чөлөөний зохицуулалттай зөрчилдөж байгаа талаар шүүмжлэл өрнөсөөр байна. Тиймээс энэхүү судалгааны хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т заасны дагуу ЗШШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв. Тус судалгааны зорилго нь ЗШШТХ-ийн сонгон авсан зохицуулалтын хэрэгжилтийн

1 Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Тавдугаар боть (1958.11 сар-1970 он), 395 дахь тал.

2 Б.Чимид, БНМАУ-ын Захиргааны эрх зүй, (УБ, 1973), 243 дахь тал.

3 Энэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

4 Энэ хуулийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

5 Хууль зүйн байнгын хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэлэлцүүлэг, (2017.02.09).

6 Мөн тэнд.

бодит байдалд дүн шинжилгээ хийж, тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүд, тэдгээрийн үр дагаврыг тодорхойлох, мөн гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах замаар онолын буюу байх ёстой түвшний үнэлгээ хийх замаар эрх зүйн зохицуулалтыг цаашид сайжруулж боловсронгуй болгох талаар дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

ЗШШТХ-ийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улс нь 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуульд “эрх хязгаарлах арга хэмжээ”-ний талаар зохицуулж байсан түүхтэй. Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар эрх бүхий байгууллага нь зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэхдээ, зөрчлийг зогсоох, нотлох баримтыг цуглуулж, хадгалахын тулд тус хуулийн 13-аас 16 дугаар зүйлд заасан дараах арга хэмжээнээс сонгон хэрэглэхээр зохицуулжээ. Үүнд:

- харьяалах шүүхэд албан ёсоор мэдэгдэж түүнийг 72 цаг хүртэл хугацаагаар захиргааны журмаар албадан саатуулах;
- согтуурах, мансуурах донтой, түүнчлэн сэтгэцийн өвчтэй буюу биеийн байцаалт тодорхойгүй этгээд зөрчил гаргасан бол тэдгээрийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулах;
- зөрчил гаргасан этгээдийн биед болон эд зүйлд үзлэг хийх;
- эд зүйл, баримт бичиг түр хураах;
- зөрчил гаргасан этгээд согтууран хэвийн бус байдалтай байвал түүний амь насыг хамгаалах, эрх зүйн зөрчил дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 24 цаг хүртэл хугацаагаар эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай байранд эрүүлжүүлэх зэрэг арга хэмжээг авна.

Харин 2017 оны ЗШШТХ-д зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаас нь хамааруулан дөрвөн төрлийн эрх хязгаарлах арга хэмжээ хэрэглэж болохоор хуульчилсан. Гэтэл эдгээр арга хэмжээнүүдийг практикт хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг нөөц дутмаг, зарим зохицуулалт хийдэлтэй, боловсронгуй бус, хуулийн зохицуулалтыг практикт нэг мөр ойлгож, хэрэглэхэд шаардлагатай нарийвчилсан журмууд хангалтгүй зэрэг хүндрэлүүдийн улмаас зорилгодоо хүрч үйлчилж чадахгүйд хүрээд байна. Үүний дээр энэ асуудлаар дагнан судалсан судалгааны ажил ховор бөгөөд эрх хязгаарлах арга хэмжээний талаарх онолын ойлголт, харьцуулсан судалгаа дутмаг байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Аливаа эрх зүйн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь тухай зөрчлийн шинж чанартай нягт уялдаатай байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн төрлийн эрх зүйн зөрчлийн улмаас хөндөгдсөн эрх ашгийг хамгаалах, зөрчлийг таслан зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг хангахуйц процедурыг бүрдүүлсэн, хүний эрхийн шаардлагад нийцсэн процесс, шийдвэр гүйцэтгэлээр хангагдсан байх учиртай. Зорилготойгоо уялдаагүй хэт хялбар, эсхүл хүнд процессоор зөрчлийг шалган шийдвэрлэж, хүний эрхийн хамгаалалтыг зохистой түвшинд үзүүлж чадаагүй нөхцөлд эрх зүйн зөрчлийн эсрэг хэрэгжүүлж буй бүхий л арга хэмжээ үр дүнгүй болох эрсдэлтэй.

Иймээс энэхүү судалгааны хүрээнд ЗШШТХ-д заасан эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг судлан тодорхойлж, бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дүгнэлт, саналыг дэвшүүлэхийг зорилоо.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо дээрх хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг харгалзан үзэж дараах зүйл, заалтыг сонгон авсан болно.

Хүснэгт 3.1. Үнэлэх зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	5.1 дүгээр зүйл. Эрх хязгаарлах арга хэмжээ	<p>1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор энэ хуульд заасан журмын дагуу эрх хязгаарлах дараахь арга хэмжээг авна:</p> <p>1.1.хүнийг саатуулах;</p> <p>1.2.үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох;</p> <p>1.3.холбогдогчийн баримт бичгийг хураан авах;</p> <p>1.4.Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх.</p>
2.	5.2 дугаар зүйл. Хүнийг саатуулах	<p>1.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан үндэслэл, хугацаагаар хүнийг саатуулна:</p> <p>1.1.тагнуулын болон цагдаа, дотоодын цэргийн эрх бүхий алба хаагч, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар;</p> <p>1.2.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар;</p> <p>1.3.хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор 7 хүртэл хоногийн хугацаагаар;</p> <p>1.4.гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол эрүүгийн хэргийн шүүх тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг 14 хүртэл хоногийн хугацаагаар.</p>

3.	5.3 дугаар зүйл. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох	1. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн үед холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг прокурорын зөвшөөрлөөр түр зогсооно.
4.	5.4 дүгээр зүйл. Баримт бичгийг хураан авах	1. Эрх бүхий албан тушаалтан холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө.
5.	5.5 дугаар зүйл. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх	1. Прокурор зөрчил шалгах ажиллагаанд саад учруулж болзошгүй талаархи эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл Зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх, эсхүл хөрөнгө, орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ нь арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж болно.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Уг судалгааг үнэлгээ хийх шалтгаантай уялдуулан үзэж, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлт болгон хийж гүйцэтгэлээ. Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЗШШТХ-ийн сонгон авсан зүйл, заалтуудад тохируулан дараах таамаглал дэвшүүлж асуулт боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд эрх хязгаарлах арга хэмжээ авдаг болон эрх хязгаарлах арга хэмжээний талаар зохицуулалтгүй гадаадын улс орнуудад захиргааны зөрчлийг хэрхэн тодорхойлж, төрөлжүүлдэг болох? Энэхүү ойлголтыг судлах замаар тус улсуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалтын онцлогийг тодорхойлох.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хүнийг саатуулах арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан холбогдогчийн баримт бичгийг хураан авах арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, холбогдох ярилцлага, хууль тогтоомж, эрх зүйн актуудтай танилцаж, аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

Гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах: Сонгон авсан улс орнуудын эрх зүйн хэм хэмжээ, түүний тайлбар, болон холбогдох ном, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг ашиглав.

Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн акт, тус сэдэвтэй холбоотойгоор эрдэмтэн, судлаачдын сонин сэтгүүл, телевизэд өгсөн ярилцлага, нэг сэдэвт болон олон сэдэвт бүтээлүүд, гадаад улсын туршлага болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах: Улсын Ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газраас тоон мэдээ, бусад мэдээллийг гаргуулан авсан ба үүнээс гадна шүүгч, прокуроруудаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав.

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ЗШШТХ-ийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх мэдээллийг цуглуулахдаа баримт бичиг судлах, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, ярилцлагын арга, харьцуулсан судалгааны аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: ЗШШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаач, салбарын мэргэжилтэн нарын ярилцлага, нийтлэл, нэг сэдэвт болон олон сэдэвт бүтээлүүдийг ашигласан болно. Үүнд:

Хууль, эрх зүйн акт

1. Зөрчлийн тухай хууль (2017);
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017);
3. Зөвлөлт Холбоот улсын Захиргааны зөрчлийн кодекс (1984);
4. Монгол Улсын Үндсэн хууль (1992);
5. Оросын Холбооны улсын Захиргааны зөрчлийн тухай кодекс (2001);
6. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль (2003);
7. Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн а/81, а/232 дугаар тушаал, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”;
8. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2017);
9. Эрүүгийн хууль (2015);
10. Япон улсын Эрүүгийн хууль (1907);
11. Япон улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (1948);
12. Япон улсын маргааны шинжгүй хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль (2011);
13. Япон улсын засаг захиргааны нэгжийн тухай хууль (1947);
14. Administrative Criminal Law Act of Switzerland (1974);
15. Criminal Procedure Code of Switzerland (2011);
16. Regulatory Offence Act of Germany (1987);

Ном, гарын авлага, сэтгүүл

1. А.Ариунзаяа, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний эрхийг хангах нь” <https://prokuror.mn/post/96497>;
2. Б.Батзориг, Б.Цогтбаатар, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь сургалтын гарын авлага /байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал, эрх зүйн орчин/, (2019);
3. Б.Дөлгөөн, “Захиргааны зөрчлийг түүний шинжээр нь ялган зааглах онолын асуудал,” 2023, <https://legaldata.mn/b/1596>;

4. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, (2023);
5. Нээлттэй Нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл хэсгийн хэрэгжилт /судалгааны тайлан/, (2022);
6. НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг, Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт, (2022). https://www.ohchr.org/sites/default/files/documents/issues/detention-wg/country-visit/2022-10-13/EOM_statement_Visit_Mongolia_14Oct2022_Mongolian.pdf
7. Хууль зүй, дотоод хэргийн яам, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар (хэсэгчилсэн үнэлгээний тайлан), (2020);
8. Ц.Цогт, “Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт,” 2018, <https://legaldata.mn/buteel/pdf?id=387>;

Гадаад эх сурвалж

1. Council of Europe, Replies to questionnaire on Administrative sanctions, (2019).
2. Vanessa Franssen and Christopher Harding, Criminal and Quasi-criminal Enforcement Mechanisms in Europe, (Hart publishing, 2022).
3. Министерство образования и науки Российской Федерации Московский Государственный юридический университет имени О.Е.Кутафина, Административный процесс Российской Федерации, М., (2018);
4. 市橋克哉「日本の行政処罰法制」名古屋大学法政論集149号(1993年)。
5. 市橋克哉「行政罰—行政刑罰、通告処分、過料」公法研究58号(1996年)。
6. 市橋克哉「旧ソ連およびロシアにおける行政処罰法制」、藤田勇『体制転換期ロシアの法改革』(1998年)。
7. 大橋洋一『行政法Ⅰ現代行政過程論(第4版)』(有斐閣・2019年)
8. 碓井光明「地方公共団体の科す過料に関する考察」明治大学法科大学院論集16号(2015年)。
9. 碓井真英「行政罰たる過料による制裁の在り方をめぐる研究—わが国とドイツの過料手続に関する比較研究を中心として—」亜細亜法学49巻1号(2014年)。
10. 北村和生、佐伯彰洋、佐藤英世、高橋明男『行政法の基本—重要判例からのアプローチ(第7版)』(法律文化社・2019年)。
11. 高田敏『新版行政法—法治主義具体化法としての—』(有斐閣・2009年)。
12. 蔡秀卿「行政の実効性確保制度の法典化に関する一試論—台湾の行政執行法・行政罰法の施行を踏まえて—」市橋克哉先生退職記念論文集『転形期における行政と法の支配の省察』(法律文化者・2021年)。
13. 板倉宏「行政刑法の課題」ジュリスト増刊『現代の法理論』(1970年)。
14. 藤田勇『ソビエト法』(東京大学出版会・1986年)。

III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд ЗШШТХ-ийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5 дугаар зүйлүүдийг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд эрх хязгаарлах арга хэмжээ авдаг болон эрх хязгаарлах арга хэмжээний талаар зохицуулалтгүй гадаадын улс орнуудад захиргааны зөрчлийг хэрхэн тодорхойлж, төрөлжүүлдэг болох? Энэхүү ерөнхий ойлголтыг судлах замаар тус улсуудын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалтын онцлогийг тодорхойлох.

5.1 дүгээр зүйл. Эрх хязгаарлах арга хэмжээ

1. Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор энэ хуульд заасан журмын дагуу эрх хязгаарлах дараахь арга хэмжээг авна:

- 1.1. хүнийг саатуулах;
- 1.2. үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох;
- 1.3. холбогдогчийн баримт бичгийг хураан авах;
- 1.4. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх.

Үнэлгээ:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1-н хүрээнд гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалтын талаар судалсан бөгөөд судалгааг ойлгомжтой, тодорхой болгох үүднээс шалгуур үзүүлэлтийг дотор нь эрх хязгаарлах арга хэмжээг авдаг улс болон авдаггүй улсаар нь 2 хуваан тодорхой агуулгын хүрээнд тус тусад нь үнэлгээг хийлээ. Тодруулбал,

ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АВДАГ УЛС:

Оросын Холбооны Улс

- ОХУ-ын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

Швейцарь улс

- Швейцарь улсын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

2.Эрх хязгаарлах арга хэмжээг авдаггүй улс:

Япон улс

- Япон улсын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

ХБНГУ

- ХБНГУ-ын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

3.1.ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВДАГ УЛС

3.1.1.Оросын Холбооны Улс

ОХУ-ын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал

Оросын Холбооны Улсын (цаашид “ОХУ” гэх) хувьд захиргааны зөрчилд тооцогдох үйлдлүүд, зөрчлийг шалгаж, шийтгэл оногдуулах процессын талаар 2001 оны Захиргааны зөрчлийн тухай кодекс (Кодекс Российской Федерации об административных правонарушениях)-оор нарийвчлан зохицуулсан байна. Энэхүү кодекс нь 1984 оны Захиргааны зөрчлийн тухай кодекс (Кодекс РСФСР об административных правонарушениях)⁷-ын үзэл санааг уламжлан хуульчилсан онцлогтой юм.

ОХУ нь “захиргааны зөрчил” гэдгийг Захиргааны зөрчлийн тухай кодекс болон захиргааны зөрчлийн тухай Холбооны улсуудын хуульд захиргааны хариуцлага оногдуулахаар заасан, хувь хүн болон хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Захиргааны зөрчил нь нийгэмд аюултай, хууль бус, гэм буруугийн шинжтэй, шийтгэл хүлээх, ёс суртахууны эсрэг байх шинжүүдийг агуулна.⁸

Мөн шүүгч, насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах комисс, холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болон орон нутгийн байгууллага зэрэг Кодекст жагсаасан субъектүүд зөрчилд хариуцлага оногдуулна. Зөрчил хүлээлгэх хариуцлагын хувьд 1/ сануулах, 2/ торгох, 3/ эрх хасах, 4/ захиргааны журмаар баривчлах, 5/ үйл ажиллагааг зогсоох, 6/ албадан хөдөлмөрлүүлэх зэрэг Кодексын 3.2-т заасан шийтгэлээс оногдуулна. Түүнчлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хууль ёсны байдлыг прокурор хянана (Кодексын 25.11).

7 Кодекс РСФСР об административных правонарушениях: федер.закон от 20.07.1984 г. Холбоос: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_2318/ дата обращения:20.06.2020.

8 Х.И.Цечоев, “Административное правонарушение и административная ответственность”, ЭКОНОМИКА, ПРАВО, С.229.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

2001 оны Кодексын 27.1-д зааснаар захиргааны зөрчлийг шалгах үе шатанд тус шалгалтын явцад саад учрах эрсдэл байгаа тохиолдолд дараах “эрх хязгаарлах арга хэмжээ (меры обеспечения)” -ээс авах боломжтой.

1) Албадан шилжүүлэх (доставление): Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил илэрсэн газарт протокол үйлдэнэ. Гэхдээ тус газарт протокол үйлдэх боломжгүй тохиолдолд холбогдогчийг тодорхой албан байр луу албадан шилжүүлнэ. Тодорхой албан байр гэдэгт ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай Кодекст жагсаасан байрыг ойлгох бөгөөд тодруулбал: цагдаагийн байгууллагын байр, орон нутгийн захиргааны байгууллагын байр, цэргийн ангийн оффисын байр гэх мэт жижүүрийн байртай байгууллагуудыг хамруулдаг.⁹

2) Захиргааны журмаар саатуулах (административное задержание): Захиргааны зөрчлийг цаг тухайд нь шийдвэрлэх шаардлагатай онцгой тохиолдолд холбогдогчийг 3 цагаас хэтрэхгүй¹⁰ хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлан, саатуулна. Захиргааны журмаар баривчлах арга хэмжээг дотоод хэргийн байгууллага, цагдаа, цэрэг, цэргийн тээврийн хэрэгслийн хяналтын ажилтнууд, хилийн байгууллагын цэргийн албан хаагчид, гаалийн ажилтнууд авах эрхтэй байна.¹¹

3) Үзлэг хийх: Хүний бие болон биедээ авч яваа эд зүйлд үзлэг хийнэ. Биед үзлэг хийхдээ холбогдогчтой ижил хүйсийн хоёр гэрчийг байлцуулан, ижил хүйсийн албан тушаалтан явуулна.

4) Эд хөрөнгө болон баримт бичгийг хураах (изъятие вещей и документов): Захиргааны зөрчлийг үйлдэхдээ хэрэглэсэн эд зүйл, хэрэгсэл болон холбогдох нотлох баримтыг хураан авна.

5) Тээврийн хэрэгсэл жолоодохыг түр зогсоох (отстранение от управления транспортным средством соответствующего вида): Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг мөн эрүүл мэндийн байдлыг шалгах зорилгоор шинжилгээнд хамруулна. Энэ тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодохыг түр зогсооно. Уг арга хэмжээг замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтнууд гүйцэтгэдэг.

6) Тээврийн хэрэгслийг саатуулах (задержание транспортного средства): Тээврийн хэрэгслийг саатуулах арга хэмжээг захиргааны зөрчлийн протокол үйлдэх эрх бүхий албан тушаалтнууд гүйцэтгэнэ.

7) Бараа, тээврийн хэрэгсэл болон бусад эд зүйлийг хураах (арест товаров, транспортных средств и иных вещей): Захиргааны зөрчил үйлдэхдээ хэрэглэсэн

9 Министерство образования и науки Российской Федерации Московский Государственный юридический университет имени О.Е.Кутафина, Административный процесс Российской Федерации, М., 2018. С. 300.

10 ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай кодекс зарим төрлийн зөрчлийн хувьд баривчлах хугацааг 48 цаг гэж заасан байдаг.

11 Министерство образования и науки Российской Федерации Московский Государственный юридический университет имени О.Е.Кутафина, Административный процесс Российской Федерации, М., 2018. С. 301.

хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгслийг хураах нь тухайн эд зүйлийн бүртгэл зэргийг шалгах болон захиран зарцуулахаас сэргийлэх, эд зүйлийн аюулгүй байдлыг хангах зорилготой юм. Эд зүйлсийг хураах ажиллагааг эрх бүхий албан тушаалтан, эд зүйлсийн эзэмшигч болон хоёр гэрчийг байлцуулан явуулна.

8) Баривчилгаа (привод): Захиргааны зөрчилд холбогдогч хувь хүн, хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч, зөрчил шалгах ажиллагааны үеэр эрх бүхий албан тушаалтны дуудсан цагт очоогүй тохиолдолд уг арга хэмжээг авна. Баривчлах ажиллагааг эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон хуульд заасан журмын дагуу явуулна.

9) Үйл ажиллагаа түр зогсоох (временный запрет деятельности): Захиргааны зөрчлийг шүүх болон эрх бүхий албан тушаалтан шалган, шийдвэрлэх хүртэл түр хугацаанд үйл ажиллагааг нь зогсоох арга хэмжээ юм. Тухайн үйл ажиллагаа нь үргэлжлэн явагдсанаар хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол үүсэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг түр зогсооно. Ихэнх тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох захиргааны шийтгэл ногдуулах магадлалтай тохиолдолд үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээг авдаг. Уг арга хэмжээг хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг эрх бүхий албан тушаалтан, тухайлбал, гал түймэр, байгаль орчин, эрүүл ахуй, эрчим хүчний хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч албан тушаалтан гүйцэтгэдэг. Хугацааны хувьд 5 хоногоос хэтрэхгүй байна.¹²

10) Саатуулагдсан хөлөг онгоцноос батлан даалтын мөнгө гаргуулах (залог за арестованное судно)

11) Тусгай байранд байрлуулах: Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ОХУ-аас захиргааны журмаар албадан гаргах тохиолдолд хилээр гаргах хүртэл хугацаанд тусгай байгууллагын байранд байрлуулна.

Дээрхээс үзвэл ОХУ нь нэлээд олон төрлийн эрх хязгаарлах арга хэмжээний талаар зохицуулсан байна. Гэхдээ тус улс нь 1984 оны Захиргааны зөрчлийн тухай кодекстоо ч захиргааны журмаар саатуулах; бие болон эд материалд үзлэг хийх; эд материал болон бичиг баримтыг хураан авах зэрэг эрх хязгаарлах арга хэмжээний талаар хуульчилж байсан. Энэхүү нөхцөл байдлыг бусад улсын судлаачид Зөвлөлт холбоот улс нь захиргааны зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай төсөөтэй болгосон гэж шүүмжилж¹³ байсан. Гэсэн хэдий ч тус улс нь 2001 оны Кодекстоо эрх хязгаарлах арга хэмжээг илүү олон төрөлтэй байхаар нарийвчлан зохицуулсан байна.

12 Министерство образования и науки Российской Федерации Московский Государственный юридический университет имени О.Е.Кутафина, Административный процесс Российской Федерации, М., 2018. С. 306.

13 市橋克哉「旧ソ連およびロシアにおける行政処罰法制」、藤田勇『体制転換期ロシアの法改革』(1998年) 249頁。

3.1.2. Швейцар улс

Швейцар улсын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал

Швейцар улсад зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн нэг төрөлд тооцогддог онцлогтой бөгөөд түүнийг шалган шийдвэрлэх албан тушаалтнаараа ялгардаг. Тодруулбал, тус улсад гурван шатлалт гэмт хэргийн категоричлон ангилал хандлагыг баримталдаг. Эрүүгийн хууль болон бусад хуулиудаар тодорхойлсон гэмт хэргүүдийг хүнд /felony/, хөнгөн /misdemeanor/, эрүүгийн зөрчил /contravention/ гэсэн ангилалд хуваана. Хуулиар гурав болон түүнээс дээш жилийн хорих ял оногдуулахаар заасан бол хүнд гэмт хэрэг, гурав болон түүнээс доош жилийн хугацаагаар хорих ял оногдуулах, эсхүл эрүүгийн торгох ял¹⁴ оногдуулахаар заасан хэргүүдийг хөнгөн гэмт хэрэг, зөвхөн торгууль оногдуулахаар заасан хэргүүд нь эрүүгийн зөрчилд хамаарна. Эрүүгийн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаас нь шалтгаалан өөр өөр процессын журмууд хэрэгждэг байна.

Эрүүгийн процесс хуульд (2011) зааснаар гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий субъектүүдэд цагдаагийн албан хаагч, прокурор, эрүүгийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд хамаарна.¹⁵ Холбооны болон мужийн захиргаанаас эрүүгийн зөрчлүүдийг шалган шийдвэрлүүлэхээр эрх бүхий албан тушаалтнуудыг буюу захиргааны албан тушаалтнуудыг томилж болно.¹⁶ Өөрөөр хэлбэл, хуулиар харьяалуулсан тодорхой төрлийн эрүүгийн зөрчлүүдийг холбогдох захиргааны байгууллагын албан тушаалтан шалган шийдвэрлэдэг. Жишээлбэл, татварын хууль тогтоомж зөрчсөн эрүүгийн зөрчлүүдийг татварын асуудал хариуцсан захиргааны албан хаагч шалган шийдвэрлэнэ. Ийм төрлийн захиргааны эрх бүхий албан тушаалтны харьяалан шийдвэрлэдэг зөрчлийг гэмт хэргийн шинжтэй захиргааны зөрчил буюу administrative criminal offense гэнэ. Эдгээр зөрчлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагааг “Захиргааны шийтгэлийн тухай

/Administrative Criminal Law Act/” хуульд заасан журмын дагуу явуулна. Харин тухайн зөрчил нь хүнд буюу хөнгөн гэмт хэрэгтэй холбогдож үйлдэгдсэн бол Эрүүгийн процесс хуулийн дагуу цагдаагийн албан хаагч мөрдөн шалгах ажиллагааг явуулж, прокурор хяналт тавьдаг байна.

Ийнхүү тодорхой төрлийн эрүүгийн зөрчлүүдийг захиргааны албан тушаалтнаар шийдвэрлүүлж буй шалтгаан нь тодорхой нэг салбарын эрх зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн салбараар мэргэшсэн тусгай мэдлэгтэй субъект явуулах нь илүү үр дүнтэй гэж үздэгтэй холбоотой аж.¹⁷ Өөрөөр хэлбэл, нийгмийн аюулын хэр хэмжээ багатай эрх зүйн зөрчлүүдийг илүү хурдавчилсан процессоор мэргэжлийн хүмүүсээр шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үздэг байна.

14 Швейцар улсын Эрүүгийн хуульд торгох ялын хоёр төрлийн хуульчилсан байдаг. Эрүүгийн торгох ял буюу monetary penalty нь 3-аас 180 хүртэлх өдрийн нэгжээр торгох бөгөөд нэг өдрийн нэгж нь доод тал нь 30 франк дээд тал нь 3,000 франктай тэнцүү байна. Харин эрүүгийн зөрчилд оногдуулах торгууль нь хуульд өөрөөр заагаагүй бол 10,000 хүртэлх франкаар торгоно.

15 Criminal Procedure Code of Switzerland (2011), article, Холбоос: <https://www.fedlex.admin.ch/eli/cc/2010/267/en>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

16 Ibid, article 17.

17 Vanessa Franssen and Christopher Harding, *Criminal and Quasi-criminal Enforcement Mechanisms in Europe*, (Hart publishing, 2022), p 25.

Ийнхүү захиргааны албан тушаалтны шалган шийдвэрлэх зөрчлийг эрүүгийн зөрчилд хамааруулан үзэж буй шалтгааныг түүнд оногдуулах шийтгэлийн зорилготой холбож тайлбарладаг.¹⁸ Тус улсын судлаач нар гэмт хэргийн шинжтэй захиргааны зөрчилд хүлээлгэж буй хариуцлага нь Эрүүгийн хуульд заасан ялын зорилгуудтай ижил нэг талаас шийтгэх, нөгөө талаас таслан зогсоох зорилготой. Ийм ч учраас захиргааны шинжтэй зөрчлүүдийг эрүүгийн зөрчилд хамааруулдаг буюу эрүүгийн зөрчлийн нэг дэд төрөл гэж үздэг байна.¹⁹

Гэмт хэргийн шинжтэй захиргааны зөрчилд Эрүүгийн хуулийн 106 дугаар зүйлд зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол 10,000 хүртэлх франкаар торгож болно. Үүний дотор 300 хүртэлх франкаар торгох, нийгмийн аюулын хэр хэмжээ харьцангуй багатай хөнгөн зөрчлүүдийг дэг журмын эсрэг зөрчлүүд /administrative offence/²⁰ гэх буюу ердийн журмаас илүү хурдан, хялбаршуулсан процессоор шийдвэрлэгддэг.

Түүнчлэн, гэмт хэргийн шинжтэй захиргааны зөрчилд торгох ялаас гадна эрх чөлөө хязгаарлах шийтгэл оногдуулж болно. Хэрэв захиргааны эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалгаад эрх чөлөө хязгаарлах /баривчлах, улсын хилээр албадан гаргах/ шийтгэл оногдуулахаар бол хэргийн материалыг эрүүгийн хэргийн шүүхэд шилжүүлэх²¹ ба шүүхээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг тал болж оролцоно.

Эдгээрээс гадна захиргааны зөрчлүүдэд дараах төрлийн шийтгэлүүдийг оногдуулдаг байна. Жишээлбэл, сахилгын шийтгэл буюу тусгай мэргэжлийн үйл ажиллагааны эрх шаардах нийтийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагаа эрхэлдэг этгээдүүд, эсхүл төртэй тусгайлсан харилцаатай буюу цэргийн албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагч гэх мэт субъектүүдэд оногдуулах сануулга, мэргэжлийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, сахилгын торгууль гэх мэт шийтгэлүүд; мөн шийтгэлийн шинжтэй захиргааны арга хэмжээнүүд - Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах, тусламж үйлчилгээ авах эрхийг хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох гэх мэт шийтгэлүүд гэх мэт.²²

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

Захиргааны албан тушаалтнууд зөрчил шалган шийдвэрлэх журмыг 1975 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн “Захиргааны шийтгэлийн тухай хууль”-иар зохицуулдаг. Энэ хууль нь материаллаг болон

18 Европын холбооноос гишүүн орнуудын дунд явуулсан захиргааны болон эрүүгийн хариуцлагын ялгааг дотоодын хууль тогтоомжид хэрхэн тусгасан талаарх асуулгад Швейцар улс онолын хувьд тухайн шийтгэл нь захиргааны хууль тогтоомжийн зохистой хэрэгжилтийг хангах зорилготой бол захиргааны шийтгэл, хувь хүний нийгэмд харш зан үйлийг шийтгэх, дахин үйлдэхээс сэргийлэх зорилготой бол эрүүгийн ял гэж ялгамжтай байдлаар авч үздэг. Гэсэн хэдий ч практикт уг ялгаа нь тодорхой гардаггүй гэжээ. Тус улсын судлаач нарын бүтээлийг судлах явцад үүнээс өөр буюу дээрх байр суурийг илэрхийлсэн байна.

19 Vanessa Franssen and Christopher Harding, *Criminal and Quasi-criminal Enforcement Mechanisms in Europe*, (Hart publishing, 2022), page 26-29-с дэлгэрүүлэн үзнэ үү.

20 Administrative Criminal Law Act of Switzerland (1974), article 3. Ordnungswidrigkeiten rep.

21 Ibid, article 73.

22 Council of Europe, Replies to questionnaire on Administrative sanctions, (2019), Холбоо: <https://rm.coe.int/cdpc-2019-1-replies-to-questionnaire-on-administrative-sanctions/168093669b>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

процессын зохицуулалтыг хамтад нь агуулна. Уг хуулиар тусгайлан зохицуулаагүй харилцаанд эрүү болон эрүүгийн процессын хуулийн суурь зохицуулалтуудыг баримтална. Захиргааны албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад гэм буруугүйд тооцогдох эрх, хэргийн материалтай танилцах, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримт цуглуулах ажиллагаанд оролцох, нотлох баримт гаргаж өгөх, өөрт холбогдох хэргийн талаар мэдээлэл авах зэрэг эрүүгийн процессын суурь хамгаалалтууд нэгэн адил үйлчилнэ.

Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа нь дийлэнхдээ хялбаршуулсан процессоор явагддаг. Зөрчлийн төрөл болон оногдуулах шийтгэлийн хэмжээнээс хамаарч хэд хэдэн ялгаатай процесс хэрэгжинэ. Ингэснээр зөрчлийн шинж буюу нийгмийн аюулын хэр хэмжээнээс нь хамааран богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх бололцоог бүрдүүлж өгдөг.

Тухайлбал, захиргааны эрх бүхий албан тушаалтан нь зөрчил үйлдэгчийн үйлдэл хангалттай тогтоогдсон гэж үзсэн, эсхүл зөрчил үйлдэгч гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулах тушаал /summary penal order/ гаргана. Энэхүү тушаалыг гаргах процесс нь Эрүүгийн процесс хуульд заасан зохицуулалтуудын дагуу явагдана. Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийтгэл оногдуулах тушаалыг хүлээн авсан зөрчил үйлдэгч 10 хоногийн дотор гомдол гаргаагүй бол шийдвэр хүчин төгөлдөр болно. Зөрчил гаргагч гомдол гаргасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хэргийг хаах, шинээр шийтгэх тушаал үйлдэх, эсхүл өмнөх тушаал нь үндэслэлтэй гэж үзвэл хэргийн материалыг шүүхийн хяналтад шилжүүлнэ. Хэрэв тухайн зөрчилд эрх чөлөө хязгаарлах шийтгэл (баривчлах болон албадан гаргах) оногдуулахаар бол захиргааны эрх бүхий албан тушаалтан хэргийн материалыг харьяалах эрүүгийн хэргийн шүүхэд шилжүүлэх бөгөөд шүүхэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг тал болж оролцоно.

Харин хөнгөн захиргааны зөрчлүүдийг /administrative offence/ шалган шийдвэрлэх процесст эрх бүхий албан тушаалтан зөрчлийн шинжийг шууд тогтоох боломжтой буюу шалгах ажиллагаа заавал хийгдэх шаардлагагүйгээр бага хэмжээний торгууль оногдуулах шийдвэрийг шууд гаргана. Нийгмийн аюулын хэр хэмжээ харьцангуй багатай зөрчлүүдийг нотлох үүргээс захиргааны албан тушаалтныг чөлөөлөх, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор энэ процессыг хэрэглэдэг. Хэрэв зөрчилд холбогдогч торгох шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийтгэл оногдуулсан захиргааны албан тушаалтанд гомдол гаргах бөгөөд эрх бүхий албан тушаалтан гомдлыг хүлээн авахаас татгалзвал харьяалах шүүхэд хандаж шийдвэрийг хянуулах боломжтой.

Зөрчлийг шалган шийдвэрлэх явцад Эрүүгийн процесс хуулийн 201 дүгээр зүйлд зааснаар эрх бүхий албан тушаалтан зөрчилд холбогдогч этгээдийг дуудан ирүүлэх хуудсаар дуудаж болно. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дуудан ирүүлэх хуудасны дагуу ирээгүй этгээдэд торгууль оногдуулах ба шаардлагатай тохиолдолд цагдаагийн ажилтанд бичгээр зөвшөөрөл олгож албадан ирүүлж болно.

Мөн зөрчил шалган шийдвэрлэх явцад Захиргааны шийтгэлийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар зөрчлийг шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл байна гэж үзвэл 48 хүртэлх цагаар зөрчил үйлдсэн сэжигтнийг баривчилж болно. 48 цагийн дотор баривчлагдсан этгээдийг

саатуулах эсэх талаар шүүхийн зөвшөөрлийг гаргуулах ёстой. Шүүх дараах үндэслэлээр хүнийг саатуулах зөвшөөрлийг олгож болно. Үүнд :

- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлах эрсдэлтэй;
- Зөрчлийн ул мөрийг нуун далдлах, нотлох баримтыг устгах, гэрч, хамтран зөрчил үйлдэгчдийг худал мэдүүлэг өгүүлэх болон бусад байдлаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахуйц нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй.

Сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох талаарх шүүхийн шийдвэрт сэжигтний хувийн мэдээлэл, шалгагдаж буй зөрчил, оногдуулах хариуцлагатай холбоотой хуулийн зохицуулалт, саатуулах болсон үндэслэл, саатуулах байр, шийдвэрт гомдол гаргах журам, талуудын эрх, ойр дотнын хүнд мэдэгдэх журмыг тусгасан байна. Саатуулах зөвшөөрлийн хуулбарыг саатуулагдаж буй этгээдэд заавал гардуулна. Саатуулах хугацаа 14 хоног байна. Зөвшөөрөл олгосон шүүхээс тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд үүнээс урт хугацаагаар саатуулж болно. Хүнийг саатуулах арга хэмжээ авагдсан тохиолдолд зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг хамгийн боломжит хурдан хугацаанд явуулах бөгөөд саатуулах нийт хугацаа зөрчил үйлдэгчид оногдуулах хуульд заасан баривчлах шийтгэлийн хугацаанаас хэтэрч болохгүй.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэглэхэд пропорциональ байдлын зарчмыг баримтална. Өөрөөр хэлбэл, тухайн зөрчлийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанарт нийцээгүй тохиолдолд саатуулах арга хэмжээ хэрэглэхгүй. Захиргааны торгууль оногдуулахаар заасан захиргааны зөрчлүүдэд саатуулах арга хэмжээ хэрэглэхийг зөвшөөрдөггүй.

3.2. ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВДАГҮЙ УЛС

3.2.1. Япон улс

Япон улсын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал

Япон улс нь “захиргааны зөрчил (行政罰)”-ийг 1/ гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчил (行政刑罰) болон 2/ дэг журмын эсрэг зөрчил (秩序罰) гэж хоёр ангилан, өөр өөр субъектээс ялгаатай процессын дагуу, ялгаатай шийтгэл оногдуулахаар хуульчилсан байдаг. Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчил гэдэг нь “захиргааны хууль тогтоомжийг зөрчсөн нь шууд байдлаар гүйцэтгэх эрх мэдлийн зорилго (行政目的) болон нийгмийн хууль ёсны ашиг сонирхол (社会法益) -д халдсан зөрчлийг” харин дэг журмын эсрэг зөрчил гэдэг нь “шууд бус байдлаар захиргааны дэг журмыг (行政秩序) алдагдуулах үйлдлийг” ойлгоно.²³ Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчил нь нийгмийн эсрэг, ёс зүйн (ethics) эсрэг үйлдэл бөгөөд тус үйлдэлдээ буруутгагдах (非難) ёстой тул эрүүгийн хуульд заасан ял оногдуулах нь зүйтэй байдаг бол дэг журмын эсрэг

23 Уг хоёр төрлийн захиргааны зөрчлийг ямар шалгуураар ангилах тухай Танака Жирогийн онол судлаачдын дунд хүлээн зөвшөөрөгддөг. Танака Жиро нь 1906 онд төрсөн бөгөөд Токиогийн их сургуулийн хүндэт профессор, 1964 оноос Улсын дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байсан. Захиргааны эрх зүй болон татварын эрх зүйгээр мэргэшсэн ба Японы эрх зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, олон онолын үзэл баримтлалыг дэвшүүлж байсан хүн юм. 田中二郎『新版行政法上巻〔全訂第2版〕』（弘文堂・1974年）195頁。

зөрчил нь ялимгүй хэмжээнд үүргээ цалгардуулж, биелүүлээгүй үйлдэл юм.²⁴

а/ Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчлийн ойлголт: Шүүхээс тус төрлийн зөрчилд Япон улсын эрүүгийн хууль²⁵ (1907)-ийн 9 дүгээр зүйлд заасан ялын төрөл болох цаазаар авах ял, хөдөлмөр эрхлэлттэй хорих ял (懲役), хөдөлмөр эрхлэлтгүй хорих ял (禁錮), нэгээс гуч хоногийн баривчлах ял (拘留), 1000 иенээс 10000 иений торгох ял (科料), 10000 иенээс дээш торгох ял (罰金), хураан авах ял (没収) –аас оногдуулна. Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчил нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргээс ялгаатай нь нийгэмд учруулах хор хөнөөлийн хувьд бага байдаг.²⁶

б/ Дэг журмын эсрэг зөрчлийн ойлголт: Захиргааны зөрчлийн нэг төрөл болох дэг журмын эсрэг зөрчил гэдэг нь захиргааны дэг журамд саад учруулах аюултай зөрчил дундаас, харьцангуй ялимгүй (比較的輕微) үүргийн зөрчилд оногдуулах торгуулийг (過料) хэлнэ.²⁷ Тухайлбал, оршин суух хаягаа өөрчилсөн бүртгэлээ хийлгээгүй, шинээр хүүхэд төрсний бүртгэлийг хийлгээгүй зэрэг захиргааны байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй үйлдлүүд ихэнхдээ хамаарна. Уг зөрчилд торгууль оногдуулах субъект нь орон нутгийн засаг дарга эсхүл орон нутгийн шүүх байна.

Хүснэгт 3.2. Захиргааны зөрчлийн төрөл²⁸

Төрөл	Шийтгэлийн төрөл	Ногдуулах субъект	Хэрэглэгдэх хууль
Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчил	Хөдөлмөр эрхлэлттэй хорих ял	Шүүх	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
	Хөдөлмөр эрхлэлтгүй хорих ял		
	1-30 хоногийн баривчлах ял		
	10000 иенээс дээш 1000000 иенээс доош торгох ял		
	1000 иенээс 10000 иений торгох ял		
Дэг журмын эсрэг зөрчил	Торгууль /50000 иенээс доош/	Засаг дарга Орон нутгийн шүүх	Маргааны шинжгүй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хууль Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

а/ Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчлийг шалгах ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээ: Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчилд эрүүгийн хуульд заасан ялын төрлөөс оногдуулахын тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

24 田中二郎「過料小論」国家学会雑誌 62 卷 11 号 (1948 年) 635 頁以下。

25 刑法 (明治四十年法律第四十五号)。

26 大橋洋一『行政法 I 現代行政過程論 (第 4 版)』(有斐閣・2019 年) 317 頁以下。

27 藤田宙靖『行政法総論』(青林書院・平成 25 年) 280 頁。

28 Миеэ аймгийн цахим хуудас, Холбоос: <https://www.pref.mie.lg.jp/common/content/000945625.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.05.18.

тухай хууль²⁹ (1948)-д заасан ажиллагаа болон тус хуулийн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг баримтална. Гэхдээ татвар болон гаалийн тухай хууль тогтоомжийг зөрчих, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн хувьд хуульд заасан “онцгой ажиллагаа” явагдана.

Замын хөдөлгөөний тухай хуулийн зөрчлийг шалгах ажиллагаа (反則金制度): Замын хөдөлгөөний тухай хуулийн 8 дугаар бүлэгт заасан зөрчлөөс зөвхөн ялимгүй зөрчлийн (зөрчлийн оноо нь 6-аас доош³⁰) хувьд, цагдаагийн албан хаагч нь зөрчлийн тухай “мэдэгдэх хуудас” болон “торгуулийн хуудас”-ыг зөрчилд холбогдогчид хүргүүлнэ. Хэрвээ зөрчилд холбогдогч нь заагдсан хугацаанд торгуулийг төлсөн тохиолдолд зөрчлийн хэрэг нь шүүхэд шилжихгүй. Харин торгуулиа заагдсан хугацаанд төлөөгүй бол зөрчлийн хэрэг нь шүүхэд шилжих бөгөөд эрүүгийн процесс хууль хэрэглэгдэнэ. Тиймээс эрүүгийн процесс хууль дахь эрх хязгаарлах арга хэмжээ авагдах боломжтой гэж үзнэ. (Замын хөдөлгөөний тухай хуулийн 126 -129 дүгээр зүйл). Мөн зөрчлийн оноо болон урьд нь замын хөдөлгөөний тухай хуулийг зөрчиж байсан эсэхээс хамааран зөрчилд холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэхийг 30 хоногоос дээш хугацаагаар хураан авах, жолоодох эрхийг хасах зэрэг “захиргааны акт”-ыг гаргадаг.³¹ Энэ нь захиргааны акт тул эрх хязгаарлах арга хэмжээ авагдахгүй.

Схем 3.1. Замын хөдөлгөөний тухай хуулийн зөрчлийг шалгах ажиллагаа



Гаалийн тухай хууль болон Татварын тухай хуулийн зөрчлийг шалгах ажиллагаа (通告処分の制度): Гаалийн ажилтан нь зөрчлийг шалгахын тулд шаардлагатай гэж үзвэл, тухайн газрын харьяалах газрын орон нутгийн шүүх эсхүл хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шүүгчийн зөвшөөрлийн дагуу дараах арга хэмжээг авна.

- нэвтрэн орох (臨検)
- холбогдогчийн бие, эд зүйл, орон байрт нэгжлэг хийх (搜索)

29 刑事訴訟法 (昭和二十三年法律第三十一号)。


30 15 км цагийн хурднаас бага хурдтай явах – 1 оноо, Тээврийн хэрэгсэл хоорондын зайг бариагүй зөрчил – 1 оноо, Огцом тооромз авахыг хориглосон заалтыг зөрчсөн зөрчил – 2 оноо, Гэрлэн дохиог үл тоосон зөрчил – 2 оноо гэх зэргээр нарийвчлан тусгасан байдаг.

31 Цагдаагийн газрын цахим хуудас, “Захиргааны акт болон зөрчлийн оноо”, Холбоос: <https://www.keishicho.metro.tokyo.lg.jp/menkyo/torishimari/gyosei/seido/gyosei20.html>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

- нотлох баримт болон хураан авах шаардлагатай гэж үзсэн эд зүйлийг хураан авах (差押え)
- Цахим хэрэгсэлд хадгалагдсан тэмдэглэлийг гаргуулан авах

Хуульд зааснаар гаалийн ажилтан нь зөрчлийг шалгах үед шаардлагатай тохиолдолд цагдаагийн туслалцааг авах боломжтой.

Схем 3.2. Гаалийн тухай хуулийн зөрчлийг шалгах ажиллагаа



Гааль болон татварын тухай хууль, замын хөдөлгөөний тухай хуулийн ялимгүй зөрчил үйлдсэн этгээд нь заагдсан хугацаанд торгуулиа төлөх эсэх нь сонголтын асуудал бөгөөд албадлагын шинж чанартай биш юм.³² Тийм ч учраас эрх хязгаарлах арга хэмжээ авдаггүй байна. Гэхдээ зөрчил гаргагч нь торгуулийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагаанд шилжих бөгөөд энэ тохиолдолд эрх хязгаарлах арга хэмжээ авагдах боломжтой юм.

б/ Дэг журмын эсрэг зөрчлийг шалган ажиллагаа болон эрх хязгаарлах арга хэмжээ: Дэг журмын эсрэг зөрчлийг оногдуулах субъектээр нь хоёр хувааж үздэг. Нэгдүгээрт, захиргааны хууль зөрчсөн үйлдэлд орон нутгийн шүүхээс торгууль оногдуулдаг³³ бол хоёрдугаарт, орон нутгийн байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэлд засаг дарга торгууль оногдуулдаг. Засаг дарга нь торгууль оногдуулахдаа зөрчилд холбогдогчид мэдэгдэж, сонсох ажиллагаа явуулах зэргээр захиргааны шийдвэр гаргах ажиллагаа явуулсны үндсэн дээр торгуулийн шийтгэврийг гаргана.³⁴ Дэг журмын эсрэг зөрчилд оногдуулах торгуулийн шийдвэр нь захиргааны акт учир уг ажиллагаанд эрх хязгаарлах арга хэмжээ авагдахгүй.

32 Цагдаагийн газрын цахим хуудас, “Захиргааны акт болон зөрчлийн оноо”, Холбоос: <https://www.keishicho.metro.tokyo.lg.jp/menkyo/torishimari/gyosei/seido/gyosei20.html>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

33 Орон нутгийн шүүхээс торгууль оногдуулахдаа Маргааны шинжгүй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (2011)-д заасны дагуу явагдах бөгөөд урьдчилан зөрчилд холбогдогч болон прокурорын саналыг сонсох ёстой.

34 Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль 255.3.1-д заасан захиргааны шийдвэр гаргах ажиллагааг мөрдөнө.

3.2.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын зөрчлийн тухай ойлголт, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын асуудал

ХБНГУ-ын Дэг журмын эсрэг зөрчлийн тухай хууль /Gesetz über Ordnungswidrigkeiten/³⁵ анх 1968 онд батлагдсан бөгөөд зөрчилд хариуцлага хүлээлгэх нийтлэг журам, процессын зохицуулалтыг агуулдаг. Энэ хууль батлагдахад хүнд ангилалд хамаарахаас бусад зам тээврийн гэмт хэргүүдийг дэг журмын эсрэг зөрчилд тооцож эхэлжээ. Үүний дараа 1974 онд эрүүгийн эрх зүйн хүрээнд хийгдсэн томоохон реформын хүрээнд нийгмийн аюул багатай жижиг эрх зүйн зөрчлүүдийг Эрүүгийн хуулиас хасаж, дэг журмын эсрэг зөрчилд тооцсон байдаг. Ингэснээр олон тоогоор үйлдэгддэг хөнгөн хэргүүдийг хянан шийдвэрлэхэд тавигдах процессын шаардлагуудыг хөнгөрүүлсэн ач холбогдолтой гэж үздэг байна.³⁶

Тус хуульд зааснаар дэг журмын эсрэг зөрчил гэдэг нь холбогдох салбар хуулиудад торгууль /Geldbusse/ оногдуулахаар заасан, хууль бус, буруутай үйлдлийг хэлнэ.³⁷ Зөрчил үйлдэгчид 5-1000 хүртэл еврогоор торгох шийтгэл оногдуулж болно. Зөрчилд оногдуулах торгууль нь эрүүгийн хэрэгт хүлээлгэх торгох ялаас зорилгын хувьд ялгаатай гэж үздэг. Энэ төрлийн хариуцлага нь нийгэм-ёс зүйн зэмлэл, ялын цээрлэлийн шинжийг агуулдаггүй.³⁸ Дэг журмын эсрэг зөрчилд хариуцлага хүлээлгэхэд тухайн субъект заавал гэм буруутай байхыг шаарддаггүй. Энэ утгаараа эрүүгийн хариуцлагаас ялгаатай гэж үздэг.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт

Зөрчлийг захиргааны байгууллагын албан тушаалтан бие даан шалгаж, шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Ийнхүү захиргааны байгууллагын албан тушаалтнаас шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд прокурор болон шүүхийн хяналт хэрэгждэг. Тодруулбал, зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан зөрчил шалгаж торгууль оногдуулах шийдвэр гаргах ба уг шийдвэрт 14 хоногийн дотор гомдол гаргаагүй бол хүчин төгөлдөр болно. Хэрэв шийтгүүлэгч захиргааны эрх бүхий албан тушаалтны шийдвэрт гомдол гаргавал түүнийг гаргасан захиргааны албан тушаалтан нэмэлт шалгалт явуулан хэргийг хаах, эсхүл өмнөх шийдвэрийг хэвээр үлдээх шийдвэр гаргаж болно. Өмнөх шийдвэрээ хэвээр үлдээх шийдвэрт хүрсэн тохиолдолд хэргийн материалыг хянуулахаар прокурорт шилжүүлнэ. Прокуророос зөрчлийн хэргийг хянаад хэргийг хаах, эсхүл цааш шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргана.

Зөрчлийг шалгах явцад гэрч, зөрчил үйлдэгчээс мэдүүлэг авах, нэгжлэг хийх, хураан авах, хүний биед үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд /зам тээврийн журмын эсрэг зөрчлүүдэд/ дээж авах зэрэг ажиллагаа явуулж болно. Энэ процесст

35 Regulatory Offence Act (англи.)

36 Council of Europe, Replies to questionnaire on Administrative sanctions, (2019), Холбоос: <https://rm.coe.int/cdpc-2019-1-replies-to-questionnaire-on-administrative-sanctions/168093669b>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02

37 Regulatory Offence Act (1987), article 1.

38 Council of Europe, Replies to questionnaire on Administrative sanctions, (2019) Холбоос: <https://rm.coe.int/cdpc-2019-1-replies-to-questionnaire-on-administrative-sanctions/168093669b>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах хүний эрхийн суурь шаардлагуудыг нэгэн адил баримтална. Тухайлбал, пропорциональ байдлын зарчим, хууль зүйн туслалцаа авах эрх, гэм буруугүйд тооцогдох эрх, дуугүй байх эрх, тайлбар гаргах эрх гэх мэт эрхүүдийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хангана.³⁹ Мөн хуулийн 46 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тусгай байгууллагад хүлээлгэн өгөх (committal to institution); түр саатуулах; баривчлах (provisional detention); захидал харилцааны хэрэгсэл, цахилгаан шуудангийн мэдээллийг (telegram) хураан авах, шуудан болон харилцаа холбооны нууцад хамаарах мэдээллүүдийг гаргуулан авах талаар хүсэлт гаргах зэрэг ажиллагааг дэг журмын эсрэг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжүүлэхийг хориглоно. Харин хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дуудан ирүүлэх хуудасны дагуу ирээгүй зөрчилд холбогдогч, гэрчийг зөвхөн шүүгчийн захирамжаар албадан ирүүлнэ. Гэрч хууль ёсны үндэслэлгүйгээр⁴⁰ мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол Эрүүгийн процесс хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу холбогдох зардлыг гэрчээр төлүүлэх, торгууль оногдуулах арга хэмжээ авч болно. Хэрэв гэрч торгуулийг төлөөгүй бол түүнийг саатуулах арга хэмжээгээр сольж болох ба саатуулах хугацаа 6 долоо хоногоос илүүгүй байна.⁴¹

ХБНГУ-ын дэг журмын эсрэг зөрчлийн тухай ойлголтын Швейцарын дэг журмын эсрэг зөрчлөөс ялгаатай нь эрүүгийн гэмт хэргийн хүрээнд хамаардаггүй. Гэсэн хэдий ч зөрчлийг шалган шийдвэрлэх процессын журам нь эрүүгийн процесст тулгуурлан боловсруулагдсан бөгөөд Захиргааны зөрчлийн хуульд тусгайлан зохицуулаагүй бол Эрүүгийн процесс хуулийн зохицуулалтыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд баримталж болно.⁴² Гэхдээ хүний халдашгүй байдалд хэтрүүлэн халдах буюу захиргааны зөрчлийн мөн чанартай пропорциональ бус арга хэмжээнүүдийг хэрэглэхийг хуулиар хориглосон байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хүнийг саатуулах арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

5.2 дугаар зүйл. Хүнийг саатуулах

1. Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан үндэслэл, хугацаагаар хүнийг саатуулна:
 - 1.1. тагнуулын болон цагдаа, дотоодын цэргийн эрх бүхий алба хаагч, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар;
 - 1.2. цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар;
 - 1.3. хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор 7 хүртэл хоногийн хугацаагаар;
 - 1.4. гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол эрүүгийн хэргийн шүүх тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг 14 хүртэл хоногийн хугацаагаар.

39 Vanessa Franssen and Christopher Harding, *Criminal and Quasi-criminal Enforcement Mechanisms in Europe*, (Hart publishing, 2022), p 51.

40 Өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг.

41 Regulatory Offence Act (1987), article 46.5.

42 Ibid, article 46.1.

Үнэлгээ:

ЗШШТХ-д заасан үндэслэлээр хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авах үндэслэл, журам, нөхцөлийг дараах байдлаар хуульчлан баталгаажуулжээ.

Албан тушаалтан	Зорилго	Хугацаа
Тагнуулын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах	Холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор	6 цаг хүртэл
Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	Зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг	24 цаг хүртэл хугацаагаар
Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах	Хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор	7 хоног хүртэл хугацаагаар
Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр эрүүгийн хэргийн шүүх	Холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол	Тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг 14 хоног хүртэл, цаашид хугацааг 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.


Дээрхээс үзвэл хуульд зааснаар хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг:

- Шүүгч;
- Цагдаа байгууллагын эрх бүхий алба хаагч;
- Тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтан;
- Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах;
- Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч авах эрхтэй байна.

Гэсэн хэдий ч практикт энэхүү эрх хязгаарлах арга хэмжээг дийлэнх тохиолдолд цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж байна. Тодруулбал, зөрчлийн хэрэгт холбогдуулан 2020 оны байдлаар нийт 2886 хүнд саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 2881 буюу 99.8 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч, 5 буюу 0.2 хувийг гадаадын иргэний хяналтын байцаагчийн саналаар шүүх, 2021 оны байдлаар нийт 2416 хүнд саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 2400 буюу 99.3 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч, 2 буюу 0.1 хувийг гадаадын иргэний хяналтын байцаагчийн гаргасан хүсэлтээр шүүх, 14 буюу 0.6 хувийг хилийн төлөөлөгч, 2022 оны байдлаар нийт 7153 хүнд саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 7150 буюу 99.9 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч, 3 буюу 0.1 хувийг хилийн төлөөлөгч, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 4144 саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг авснаас 4144 буюу 100 хувь цагдаагийн эрх бүхий албан хаагч тус тус авсан.⁴³

43 Улсын Ерөнхий прокурорын газар, Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад авсан “Эрх хязгаарлах арга хэмжээ”-ний тоон судалгаа (2020, 2021, 2022, 2023 оны эхний хагас жилийн байдлаар)

График 3.1. Хүнийг саатуулах арга хэмжээний тоон үзүүлэлт



Уг арга хэмжээг практикт авч хэрэгжүүлэх явцад тулгардаг асуудлуудыг тус бүрд нь авч үзвэл:

ЗШШТХ-ийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрх бүхий алба хаагч ЗтХ-ийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл 8.6, 8.7 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.33 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ зүйлд заасан тусгай журмыг баримтлан хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулна гэж заажээ. Энэхүү 17 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны үед хүнийг саатуулах албадлага хэрэглэх зохицуулалтыг 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт холбогдогч оргон зайлах, эсхүл дахин зөрчил үйлдэж болзошгүй тохиолдолд прокурорт мэдэгдэж 24 цаг хүртэлх хугацаагаар саатуулж болохоор зохицуулсан бөгөөд шаардлагатай бол энэ хугацааг харьяалах шүүхийн зөвшөөрлөөр 48 хүртэл цагаар нэг удаа сунгаж болно гэж заажээ.⁴⁴ Тодруулбал, уг зохицуулалтын дагуу холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар, согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар, хуульд тусгайлан заасан зөрчилд оргон зайлах, эсхүл дахин зөрчил үйлдэж болзошгүй үндэслэлээр 24 цаг хүртэл хугацаагаар саатуулж энэхүү хугацааг шүүхийн зөвшөөрлөөр 48 цаг хүртэл хугацаагаар сунгахаар зохицуулжээ. Дээрх үндэслэлүүдээр хүнийг нийтдээ 78 цагийн хугацаагаар саатуулах боломжтой байна.

Гэтэл дээрх 17 төрлийн зөрчлөөс бусад зөрчлийн тухайд холбогдогч этгээдийг саатуулах нийт хугацааг хуульд тодорхой тусгаж өгөөгүйгээс хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бий болгож байна. Жишээлбэл, зөрчил гаргасан хүнийг эхлээд эрүүлжүүлэх байранд албадан эрүүлжүүлээд, дараа нь эрүүлжүүлэх байрнаас цагдаагийн хэлтэс рүү шилжүүлэхдээ хугацааг (48 цагийг) шинээр тооцож эхэлдэг

44 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг "Холбогдогч оргон зайлах, эсхүл дахин зөрчил үйлдэж болзошгүй тохиолдолд прокурорт мэдэгдэж 24 цаг хүртэлх хугацаагаар саатуулж болно. Шаардлагатай бол энэ хугацааг харьяалах шүүхийн зөвшөөрлөөр 48 хүртэл цагаар нэг удаа сунгаж болно."

энэ нь бодит саатуулах хугацааг зөвшөөрөгдсөн 48 цагаас хэтрүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.⁴⁵

Дээр дурдсанчлан энэхүү эрх хязгаарлах арга хэмжээг дийлэнх тохиолдол буюу 99 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч авч хэрэгжүүлдэг бөгөөд цагдаагийн албан хаагч нь тус арга хэмжээг хэрэглэхдээ ЗШШТХ-аас гадна Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийг⁴⁶, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 225 буюу “Түр саатуулах” журмыг тус тус удирдлага болгодог. Гэсэн хэдий ч цагдаагийн эрх бүхий албан хаагч тодорхой баримт бичиг, хууль зүйн үндэслэл танилцуулалгүй түр саатуулсан тохиолдлууд практикт гарсаар байна. Тодруулбал, Нээлттэй нийгэм форумгаас Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, хэсгийн хэрэгжилттэй холбоотойгоор нийт 153 хүнээс судалгаа авахад 14 буюу 11.2 хувь нь удаан хугацаагаар цагдаагийн хэлтэст саатуулагдаж байсан ч ямар нэг тогтоол, шийдвэр харуулаагүй, танилцуулаагүй гэсэн хариултыг өгсөн байна.⁴⁷

Хүнийг саатуулах арга хэмжээг тухайн зөрчлийн шинж байдлаас хамаарахгүйгээр зөвхөн түүнийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны харьяаллыг харгалзан тогтоосон нь зарим хүндрэлийг учруулдаг байна. Тодруулбал, гамшгаас хамгаалах улсын байцаагч, гаалийн улсын байцаагч, байгаль хамгаалагч, нислэгийн болон төмөр замын аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нь зарим төрлийн зөрчлийг газар дээр нь⁴⁸ шалган шийдвэрлэх явцад мансуурсан, согтуурсан холбогдогчийг саатуулах шаардлага үүсдэг бөгөөд энэ тохиолдолд согтуурсан, мансуурсан хүн зөрчил үйлдсэн бол зөвхөн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан саатуулахаар хуульд заасан⁴⁹ нь дээрх албан тушаалтнууд саатуулах арга хэмжээг тухайн нөхцөлд хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна⁵⁰.

45 НҮБ-н Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг, Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт, (2022), 6 дахь тал, Холбоос: https://www.ohchr.org/sites/default/files/documents/issues/detention-wg/country-visit/2022-10-13/EOM_statement_Visit_Mongolia_14Oct2022_Mongolian.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

46 Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2017)-ийн 26 дугаар зүйл “Түр саатуулах” 26.1.Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.

26.3.Цагдаагийн алба хаагч хүнийг түр саатуулсан даруй тухайн хүний талаар 18 насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, ойр дотны хүнд нь мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

26.4.Энэ хуулийн 26.3 дахь хэсэг нь цагдан хорих, баривчлах байр, эмнэлэг, хорих байгууллагаас оргон зайлсан ялтан, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хамаарахгүй.

26.5.Хүнийг түр саатуулах үндэслэл арилсан тохиолдолд түүнийг даруй суллана.

26.6.Түр саатуулах байрны дэглэм, журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

47 Нээлттэй Нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл хэсгийн хэрэгжилт /Судалгааны тайлан/, (2022), 52 дахь тал, Холбоос: https://forum.mn/uploads/users/3093/files/Tsagdaagiin_albanii_tuhai_huulin.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

48 Уг эрхийг эрх бүхий албан тушаалтанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр олгосон.

49 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 5.2 дугаар зүйлийн 1дэх хэсгийн 1.2 дахь заалт “цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар”.

50 ХЗДХЯ, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар (хэсэгчилсэн үнэлгээний тайлан), (2020), 14 дэх тал.

ЗтХ-ийн 3.5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно.” гэж заасан. Гэтэл ЗтХ-д дийлэнх тохиолдолд торгох шийтгэлээс сонгож оногдуулахаар заасан төдийгүй торгох шийтгэл бүхий зөрчлийн холбогдогчид саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авахыг хориглосон зохицуулалт байхгүй байна. Энэ нь саатуулсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцож байгаа хэр нь торгох шийтгэлд оруулан тооцохгүй байгаа нь шударга ёсны зарчмыг алдагдуулж байна.⁵¹

Согтуурсан, мансуурсан хүнийг саатуулах гэх үндэслэл тусгагдсан боловч саатуулах байр нь согтуурсан, мансуурсан хүнийг хүлээж авдаггүй бөгөөд Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас хаана байгаага болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгнө.”⁵² гэж заасны дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх тохиолдол түгээмэл гардаг байна. Ийнхүү эрүүлжүүлэх байранд хүргэхдээ эрүүлжүүлэх байрны карт бөглөж хүлээлгэж өгдөг боловч саатуулсан талаар ямар нэгэн тогтоол, шийдвэр гардаггүй бөгөөд энэ тохиолдолд хуульд заасан эрх бүхий албан тушаалтан нь саатуулах тогтоол үйлдэх, прокурорт даруй мэдэгдэх зэрэг ажиллагаанууд хийгдэлгүй өнгөрөх асуудлууд үүсдэг байна.⁵³

Дүгнэн үзвээс хүнийг саатуулах арга хэмжээг хэрэглэх нөхцөлийг зөрчлийн шинжээс нь хамаарч тодорхойлох, хүнийг саатуулах арга хэмжээ авахыг хориглох нөхцөлийг нарийвчлан тусгах нь зүйтэй байна. Мөн дээр дурдсан хуулиудад эрх бүхий албан тушаалтанд хуульд заасан үндэслэлээр саатуулах албадлагыг хэрэглэх эрх хэмжээ олгогдсон хэдий ч нарийвчилсан процессын зохицуулалтыг тус бүрд нь хуульчлаагүй, саатуулах нийт хугацааг тусгаж өгөөгүй, саатуулах үндэслэл нь хэт өргөн хүрээтэй зохицуулагдсан, мөн таамаглал, сэжиглэлд шууд тулгуурласан байгаа нь тус арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

51 Мөн тэнд, 14-15 дахь тал.

52 Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, (2003), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/457>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

53 Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, (2023), 97 дахь тал.

5.3 дугаар зүйл. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох

1. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн үед холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг прокурорын зөвшөөрлөөр түр зогсооно.
2. Эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг авч, энэ тухай прокурорт даруй мэдэгдэнэ.
3. Прокурор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны авсан эрх хязгаарлах арга хэмжээг хүчинтэйд тооцох эсэхийг энэ хуулийн 4.2 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.


Үнэлгээ:

Хуульд үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээг “хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн” нөхцөлд прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээр заажээ. Ихэнх тохиолдолд уул уурхайн компаниуд нь техник эдийн засгийн үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаа явуулдаггүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг хугацаанд нь хийгээгүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамгүй, комиссын актгүйгээр олборлолт явуулсан, овоолго даланд үүссэн хагарал, нуралтыг илрүүлэх, аюулгүй болгох арга хэмжээ авдаггүйгээс хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, осол гарах, хүний эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэл бий болгосон зэрэг үндэслэлээр хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан байна.⁵⁴ Тодруулбал, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох арга хэмжээг 2020 оны байдлаар хэрэгжүүлсэн 118 тохиолдлын 108 буюу 92 хувь нь үйл ажиллагааг бүхэлд нь, 10 буюу 8 хувь нь хэсэгчлэн, 2021 оны байдлаар нийт 64 тохиолдлын 61 буюу 95 хувь нь үйл ажиллагааг бүхэлд нь 3 буюу 5 хувь нь хэсэгчлэн, 2022 оны байдлаар нийт 36 тохиолдлын 29 буюу 81 хувь нь үйл ажиллагааг бүхэлд нь 7 буюу 19 хувь нь хэсэгчлэн, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 тохиолдлын 24 буюу 89 хувь нь үйл ажиллагааг бүхэлд нь 3 буюу 11 хувь нь үйл ажиллагааг хэсэгчлэн зогсоох арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна.⁵⁵

54 А.Ариунзаяа, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний эрхийг хангах нь” 6 дахь тал, Холбоос: <https://prokuror.mn/post/96497>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.01.

55 Улсын Ерөнхий прокурорын газар, Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад авсан “Эрх хязгаарлах арга хэмжээ”-ний тоон судалгаа (2020, 2021, 2022, 2023 оны эхний хагас жилийн байдлаар)

График 3.2. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээ авсан тоон үзүүлэлт



Уг арга хэмжээг хэрэгжүүлэх явцад практикт дараах асуудлууд үүсдэг байна. Үүнд:

ЗШШТХ-д “үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох” эрх хязгаарлах арга хэмжээг авах үндэслэл нь “хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулах” нөхцөлөөр хязгаарлагдсан байна. Гэтэл ЗТХ-аар зөрчилд тооцсон 2300 орчим үйлдэл, эс үйлдэхүйн улмаас нэр төр, нийтийн ашиг сонирхол, нийгмийн хэв журам болон хүн, хуулийн этгээд, төрд эд хөрөнгийн хохирол учрах эрсдэлтэй ч эдгээр нөхцөлд үйл ажиллагаа, ашиглалтыг нь түр зогсоох боломжгүй болж байна. Үүнээс дүгнэхэд үйл ажиллагаа, ашиглалтыг нь түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг илүү тодорхой хуульчлах, мөн төрийн хяналт шалгалтын явцад хэрэгжүүлэх ажиллагаанаас ялгаатай зохицуулах шаардлагатай байгааг анхаарч холбогдох өөрчлөлтийг тусгах нь чухал байна.⁵⁶

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа дуусахад эрх хязгаарлах арга хэмжээг дуусгахаар заасан. Гэтэл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээ авсан үндэслэл нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа дуусах үед ч гэсэн арилаагүй байх нь түгээмэл байдаг ба тус арга хэмжээг хэрхэн үргэлжлүүлэх нь тодорхойгүй байна. Практикт ЗШШТХ-ийн 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл ЗТХ-д заасан үндэслэлээр зөрчлийн үр дагаврыг арилгах зорилгоор ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч болно.” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаас хугацаатай даалгавар өгөх байдлаар шийдвэрлэж байна. Гэвч хуульд хугацааг тодорхой заагаагүй тул эрх бүхий албан тушаалтан харилцан адилгүй байдлаар өөр өөр хугацаа тогтоон хэрэгжүүлж байна.

56 Хууль зүй, дотоод хэргийн яам, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар (хэсэгчилсэн үнэлгээний тайлан), (2020), 16 дахь тал.

Иймд ЗШШТХ-ийн 5.3 болон 7.4 дүгээр зүйлийн зохицуулалтын уялдааг хангах, хугацааг тогтоох үндэслэл болон хугацааны дээд, доод хэмжээг хуульчлах нь чухал байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

5.4 дүгээр зүйл.Баримт бичгийг хураан авах

1.Эрх бүхий албан тушаалтан холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө.

2.Холбогдогч хураалгасан баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Үнэлгээ:

Хуульд заасан чиг үүргийн хүрээнд эрх бүхий албан тушаалтан холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө. Тухайлбал, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох эрх хязгаарлах арга хэмжээтэй хэрэгжүүлэх зорилгоор хураан авч болно.

Зөрчлийн хэрэгт холбогдуулан 2020 оны байдлаар нийт 6166 холбогдогчийн баримт бичгийг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 6166 буюу 100 хувийг цагдаагийн эрх бүхий алба хаагч, 2021 оны байдлаар нийт 12347 холбогдогчийн баримт бичгийг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 12347 буюу 100 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч, 2022 оны байдлаар нийт 29280 холбогдогчийн баримт бичгийг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 29167 буюу 99.6 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч, 19 буюу 0.06 хувийг мэргэжлийн хяналт, 3 буюу 0.01 хувийг хилийн төлөөлөгч, 91 буюу 0.3 хувийг авто тээврээс, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 11238 холбогдогчийн баримт бичгийг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээ авснаас 11203 буюу 99.6 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч, 1 буюу 0.01 хувийг хилийн төлөөлөгч, 28 буюу 0.25 хувийг авто тээвэр, 6 буюу 0.05 хувийг улсын бүртгэлээс тус тус авсан байна.

Дээрхээс үзвэл баримт бичгийг хураан авах арга хэмжээг бусад эрх хязгаарлах арга хэмжээтэй нэгэн адил сүүлийн 3 жилийн нийт тохиолдлын 99 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагчаас авч хэрэгжүүлсэн байна.

Цагдаагийн эрх бүхий албан хаагч нь дээрх эрх хязгаарлах арга хэмжээг авахдаа ЗШШТХ-ын холбогдох заалтаас гадна Цагдаагийн албаны тухай хуулийн

30 дугаар зүйлийг,⁵⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 217 буюу “Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам”, Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”⁵⁸-г тус тус удирдлага болгодог. Гэсэн хэдий ч дээрх хууль болон журмын зохицуулалтуудад баримт бичгийг түр хураан авсан тохиолдолд хэр хугацаанд өөртөө байлгах талаар ямар нэг зохицуулалт байдаггүй байна. Мөн үүнээс гадна практикт бичиг баримт шалгахдаа биш түүнийг барьцаалах хэлбэрээр хураан авах тохиолдол гардаг байна. (Тохиолдол 1.)⁵⁹

Тохиолдол 1.

Олон нийтийн газар хогийн савны дэргэд утаат тамхи татаж байхад ирж зөрчил гаргасан гэж дарамталсан. Тухайн газар тамхи татахыг хориглосон бичиг байгаагүй ч зөвхөн тэнд хүлээж байгаад гэнэт гараад ирсэн юм шиг санагдсан. Гол нь тухайн үед торгоно гэж байснаа “Хэн юм ер нь чи? Бичиг баримтаа шалгуул” гэсэн. Тэгснээ бичиг баримт хурааж аваад “50 мянган төгрөгийн торгуулийн мөнгөө авч ирээд бичиг баримтаа аваарай” гэсэн. Гуйгаад ч нэмэр болоогүй “Тавьсан шаардлага эсэргүүцсэн гээд ахиад торгоно шүү” гэж айлгасан. Сүүлд нь таньдаг хүнээр нь гуйлгаж авсан.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

5.5 дугаар зүйл. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх

1. Прокурор зөрчил шалгах ажиллагаанд саад учруулж болзошгүй талаархи эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл Зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх, эсхүл хөрөнгө, орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ нь арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж болно.

57 Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, (2017)-ийн 30 дугаар зүйл “Эд, зүйл баримт бичиг хураан авах”

Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ үүрэн холбооны хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйл, тээврийн хэрэгсэл, цахим төхөөрөмж, баримт бичгийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр түр хураан авч болно.

Хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах эд зүйл, баримт бичгийг сайн дураар гаргаж өгөх, байгаа газрыг нь зааж өгөх боломжийг тухайн хүнд олгоно.

Цагдаагийн алба хаагч хураан авсан эд зүйлийн төрөл, шинж байдал, тоо ширхэгийг тусгасан жагсаалт үйлдэнэ.

58 Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/81, А/232 дугаар тушаал, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”

59 Нээлттэй Нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл хэсгийн хэрэгжилт /Судалгааны тайлан/, (2022), 49 дэх тал, Холбоос: <https://forum.mn/uploads/users/3093/files/Tsagdaagiin-albanii-tuhai-huuliin.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.02.

Үнэлгээ:

Судалгааны хүрээнд Улсын Ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газраас тоон мэдээ, бусад мэдээллийг гаргуулан авахаас гадна шүүгч, прокуроруудаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахад хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ нь Монгол Улсын хэмжээнд авагдаж байгаагүй гэсэн хариуг өгсөн бөгөөд авагдаагүй учир шалтгааныг тодруулахад тухайн эрх хязгаарлах арга хэмжээ нь зөрчлийн хэрэгт тохиромжгүй хүнд арга хэмжээ гэсэн хариултыг өгсөн.⁶⁰

60 2023 оны 11 дүгээр сарын 23, 24-ний өдөр, Улсын ерөнхий прокурорын зөрчил хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор ... /судалгаанд оролцогч нэрээ нууцлахыг хүссэн/ болон Сонгинохайрхан дүүргийн зөрчил хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор ..., ... нараас ярилцлагын аргаар авсан судалгаа.

IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны хүрээнд ЗШШТХ-д заасан эрх хязгаарлах арга хэмжээний хэрэгжилтийн үр дагаврыг судлахдаа нэгдүгээрт, гадаадын улс орнуудын эрх хязгаарлах арга хэмжээний зохицуулалт (Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1), хоёрдугаарт, Монгол Улсын ЗШШТХ-д заасан дөрвөн төрлийн арга хэмжээ нь практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл байгааг тодорхойлох (Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2-5) гэсэн үндсэн хоёр шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1-ийн хувьд:

ОХУ-ын хувьд: ОХУ-ын хувьд захиргааны зөрчил гэдэг нь Захиргааны зөрчлийн тухай кодекс болон бүрэлдэхүүн улсуудын захиргааны зөрчлийн тухай хуульд захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан хууль бус үйлдэл, эс үйлдэхүй юм. Ийнхүү өргөн хүрээгээр тодорхойлж, Япон болон бусад улсын адил гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчил, дэг журмын эсрэг зөрчил гэж ялгахгүйгээр нэг кодексоор шалган шийдвэрлэх процессыг хуульчилснаараа Монгол Улстай төсөөтэй байна. Түүнчлэн, ОХУ-д зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах зорилгоор тодорхой төрлийн эрх хязгаарлах арга хэмжээг авах эрхийг хуульчилж өгсөн нь Монгол Улстай төсөөтэй байна. Гэхдээ тус улсын Кодекст заасан эрх хязгаарлах арга хэмжээ нь Монгол Улсынхтай харьцуулахад хугацааны хувьд бага, тухайлбал 3 хүртэл цаг саатуулах, үйл ажиллагааг 5 хүртэл хоног түр зогсоох зэргээр хуульчлагдсан байна. Тус улсын хувьд эрх хязгаарлах арга хэмжээ нь “оногдуулах магадлалтай зөрчлийн шийдвэр”-ийн агуулгатай уялдаатай байна. Тухайлбал, үйл ажиллагааг зогсоох шийтгэл оногдуулах магадлалтай тохиолдолд үйл ажиллагааг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээ авах, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг албадан гаргах тохиолдолд, тусгай байранд байрлуулах зэргийг дурдаж болно.

Швейцар улсын хувьд: Швейцар улсад захиргааны албан тушаалтан гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалган шийдвэрлэх явцад шаардлагатай тохиолдолд 48 хүртэлх цагаар хүнийг түр баривчилж болох боловч энэ хугацаанд багтаан цааш тухайн хүнийг саатуулах шүүхийн зөвшөөрлийг заавал авна. Шүүхээс хүнийг саатуулах арга хэмжээ авах зөвшөөрөл олгох үндэслэлийг хуульд тодорхой заасан байна. Гэхдээ энэ арга хэмжээг зөвхөн эрх чөлөө хязгаарлах ял оногдуулах зөрчлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжүүлэх бөгөөд хүнийг саатуулах нийт хугацаа нь тухайн зөрчилд оногдуулж болох эрх чөлөөг хязгаарлах ялын хугацаанаас хэтрэхгүй. Хэрэв зөрчлийн хэргийн оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр захиргааны эрх бүхий албан тушаалтны дуудан ирүүлэх хуудасны дагуу ирээгүй бол Эрүүгийн процесс хуульд зааснаар түүнийг торгох, цагдаагийн албан хаагчийн тусламжтай албадан авч ирэх арга хэмжээ хэрэглэнэ. Үүнээс бусад эрүүгийн процесс ажиллагааны явцад хэрэгжүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг захиргааны албан тушаалтан авахыг хориглодог.

Япон улсын хувьд: Япон улсын хувьд захиргааны зөрчлийн эрх зүй нь Монгол Улсын эрх зүйн тогтолцооноос нэлээдгүй ялгаатай байна. Тодруулбал, Монгол Улсын хувьд ЗШШТХ-д заасны дагуу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага

болон хуульд заасан бусад эрх бүхий албан тушаалтан захиргааны зөрчилд шийтгэл оногдуулдаг бол Япон улсын хувьд гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчилд цагдаагийн байгууллага, дэг журмын эсрэг зөрчлийн хувьд Засаг дарга эсхүл орон нутгийн шүүх шийтгэл оногдуулдаг байна. Гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчилд эрүүгийн хуульд заасан ялын төрлөөс оногдуулах тул эрүүгийн процессын хууль хэрэглэгдэнэ. Гэхдээ гааль, татвар, замын хөдөлгөөний тухай хуулийн зөрчлийн хувьд онцлог шинжээс нь хамаарч шалган шийдвэрлэх “онцгой ажиллагаа”-г хуульчилж өгсөн байдаг. Тодруулбал, гааль болон татварын байцаагч, цагдаа нар зөрчлийг илрүүлж, зөрчилд холбогдогчид торгууль оногдуулах ба торгуулийг заасан хугацаанд төлсөн тохиолдолд зөрчлийн хэрэг нь шүүх рүү шилжихгүй. Харин шүүх рүү шилжсэн тохиолдолд эрүүгийн процессын хуулийн дагуу ажиллагааг цагдаа, прокурор явуулж эхлэх юм. Тиймээс энэ тохиолдолд эрүүгийн процесс хуульд заасан эрх хязгаарлах арга хэмжээ авагдах боломжтой юм. Харин дэг журмын эсрэг зөрчлийн хувьд орон нутгийн шүүх болон засаг даргаас зөвхөн торгууль оногдуулна. Торгууль оногдуулахдаа захиргааны шийдвэр гаргах ажиллагааны дагуу мэдэгдэх, сонсох ажиллагаа явагдах ба шийдвэр нь захиргааны акт байна. Тиймээс эрх хязгаарлах арга хэмжээ авахгүй.

ХБНГУ-ын хувьд: ХБНГУ-д дэг журмын эсрэг зөрчлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах явцад нэгжлэг хийх, мэдүүлэг авах, эд зүйл хураан авах, хүний биед үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд дээж авах зэрэг ажиллагаануудыг явуулж болно. Гэхдээ эрүүгийн процесст хэрэглэгддэг зарим төрлийн хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд халддаг мөрдөн шалгах болон таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэглэхийг хуулиар хориглосон.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2-5-ийн хувьд:

Энэхүү судалгааны хүрээнд хийсэн практик судалгааны үр дүнгээс харвал, Монгол Улсын хувьд улсын хэмжээнд 2020 оноос 2023 оны хагас жилийг хүртэл нийт 75870 эрх хязгаарлах арга хэмжээ авсан байгаагаас 75473 буюу 99.4 хувийг цагдаагийн эрх бүхий албан хаагч авч хэрэгжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын тухайд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтнаас хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлаж саатуулах арга хэмжээ авах эрх олгогдсон ч түүнийг хэрэгжүүлэх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй нь хүнийг дур мэдэн саатуулах, эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын ЗтХ-ийн 3.1 дүгээр зүйлд зөрчилд оногдуулах шийтгэлийн зорилго нь “хүн хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино” хэмээн тодорхойлсон. Эндээс харахад Эрүүгийн хуульд заасан ялын зорилгоос ялгаатай буюу урьдчилан сэргийлэх зорилго давамгайлсан шинжтэй байна. Гэсэн хэдий ч зөрчил шалган шийдвэрлэх явцад шүүхийн хяналтаас гадуур хүнийг 7 хүртэлх хоногийн хугацаагаар захиргааны албан тушаалтан тодорхой бус үндэслэлээр саатуулах зэргээр хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хэт хязгаарласан шинжтэй зохицуулалтуудыг хуульчилсан нь хүний эрхийн шаардлагад нийцэхгүй бөгөөд пропорциональ байдлын зарчим алдагдахад хүрч буйг дурдах нь зүйтэй.

4.2. ЗӨВЛӨМЖ

Дээрх дүгнэлтээс үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Монгол Улсын хувьд ЗтХ-д тусгагдсан зөрчлийг түүний шинжээр нь дэг журмын эсрэг зөрчил болон гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчилд ялган зааглах зайлшгүй шаардлага тулгараад байна. Дэг журмын эсрэг зөрчлийн хувьд дараах шалгуураар ангилах нь зүйтэй:

- Зөвхөн ялимгүй үүргийн зөрчил байх,
- Захиргааны байгууллаас оногдуулдаг байх,
- Зөрчлийг шалгах ажиллагаа нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны дагуу явагддаг байх,
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад “эрх хязгаарлах арга хэмжээ” авдаггүй байх,
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавьдаггүй байх,
- Захиргааны байгууллагын шийдвэр нь захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаардаг байх.

Харин гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчлийн хувьд бусад улсуудын хувьд ч эрүүгийн процесс хуулийг тохируулан хэрэглэх, эсхүл тусгай процессыг хуульчлах /эрүүгийн шинж бүхий/ хандлага ажиглагдаж байна. Монгол Улсын хувьд ч ЗШШТХ-д зөвхөн гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг зохицуулах боломжтой юм. Энэ тохиолдолд гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчилд шийтгэл оногдуулах эрхийг цагдаагийн албан хаагч, шүүхэд олгох нь зохистой. Гэхдээ зарим төрлийн зөрчил тухайлбал, гаалийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг шалгах эрхийг гаалийн байцаагчид олгож болох ч энэ нь “тусгай процесс” -оор зохицуулагддаг байх нь хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарлаж, цагдаажсан төр үүсэхээс хамгаалах юм.

Мөн Монгол Улсын хувьд гэмт хэргийн шинж бүхий захиргааны зөрчлийг шалгахдаа авах эрх хязгаарлах арга хэмжээний “зайлшгүй нөхцөл”-ийг илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай юм. Тус арга хэмжээ авагдах хугацааг “багасгах” зэргээр “эрүүгийн эрх зүйн таслан сэргийлэх арга хэмжээ”-ээс ялган, зааглах нь зүйтэй юм. Үүнээс гадна тодорхой ажиллагааны хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд

- Хүнийг саатуулах арга хэмжээ авах үндэслэлүүдийг нарийвчлан тодорхой болгох. Ингэхдээ зөвхөн зайлшгүй шаардлагатай нөхцөлүүдэд буюу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулахад хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах замаар саад учруулахаас сэргийлэхээс өөр гарцаагүй нөхцөлүүдэд л түр саатуулах арга хэмжээг авах;
- Хүнийг саатуулах арга хэмжээг зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр авах;
- Захиргааны албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд хүнийг түр баривчлах арга хэмжээ авсан тохиолдолд харьяалах шүүхэд даруй мэдэгдэх, үндэслэлийг тодорхой тайлбарлах зохицуулалтуудыг нэмж хуульчлах;

- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээг эрх хязгаарлах арга хэмжээний төрлөөс хасах;
- Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээний дээд болон доод хугацааг тодорхойлох;
- Баримт бичгийг хураан авсан тохиолдолд эрх бүхий албан хаагч тухайн баримт бичгийг хураан авч, хадгалах, буцаан өгөх нөхцөл болон хугацааг тодорхой болгох.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Зөрчлийн тухай хууль, (2017).
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, (2017).
4. Зөвлөлт Холбоот улсын Захиргааны зөрчлийн кодекс, (1984).
5. Оросын Холбооны улсын Захиргааны зөрчлийн тухай кодекс, (2001).
6. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, (2003).
7. Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/81, А/232 дугаар тушаал, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”.
8. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, (2017).
9. Эрүүгийн хууль, (2015).

Гадаад хэлээр:

1. Япон улсын эрүүгийн хууль, (1907).
2. Япон улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (1948).
3. Япон улсын маргааны шинжгүй хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, (2011).
4. Япон улсын засаг захиргааны нэгжийн тухай хууль, (1947).
5. Administrative Criminal Law Act of Switzerland, (1974).
6. Criminal Procedure Code of Switzerland, (2011).
7. Regulatory Offence Act of Germany, (1987).

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. А.Ариунзаяа, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний эрхийг хангах нь”, Холбоос: <https://prokuror.mn/post/96497>
2. Б.Батзориг, Б.Цогтбаатар, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь сургалтын гарын авлага /байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал, эрх зүйн орчин/, (2019).
3. Б.Дөлгөөн, “Захиргааны зөрчлийг түүний шинжээр нь ялган зааглах онолын асуудал,” 2023, Холбоос: <https://legaldata.mn/b/1596>
4. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, (2023).
5. Нээлттэй Нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл хэсгийн хэрэгжилт /судалгааны тайлан/, (2022).

6. НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг, Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт, (2022), Холбоос: https://www.ohchr.org/sites/default/files/documents/issues/detention-wg/country-visit/2022-10-13/EOM_statement_Visit_Mongolia_14Oct2022_Mongolian.pdf
7. Хууль зүй, дотоод хэргийн яам, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар (хэсэгчилсэн үнэлгээний тайлан), (2020).
8. Ц.Цогт, “Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт,” (2018), Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=387>

Гадаад хэлээр:

1. Council of Europe, Replies to questionnaire on Administrative sanctions, (2019).
2. Vanessa Franssen and Christopher Harding, Criminal and Quasi-criminal Enforcement Mechanisms in Europe, (Hart publishing, 2022).
3. Министерство образования и науки Российской Федерации Московский Государственный юридический университет имени О.Е.Кутафина, Административный процесс Российской Федерации, М., (2018).
4. 市橋克哉「日本の行政処罰法制」名古屋大学法政論集 149 号 (1993 年)。
5. 市橋克哉「行政罰—行政刑罰、通告処分、過料」公法研究 58 号 (1996 年)。
6. 市橋克哉「旧ソ連およびロシアにおける行政処罰法制」、藤田勇『体制転換期ロシアの法改革』(1998 年)。
7. 大橋洋一『行政法 I 現代行政過程論 (第 4 版)』(有斐閣・2019 年)
8. 碓井光明「地方公共団体の科す過料に関する考察」明治大学法科大学院論集 16 号
9. (2015 年)。
10. 碓井真英「行政罰たる過料による制裁の在り方をめぐり研究—わが国とドイツの過料手続に関する比較研究を中心として—」亜細亜法学 49 卷 1 号 (2014 年)。
11. 北村和生、佐伯彰洋、佐藤英世、高橋明男『行政法の基本—重要判例からのアプローチ (第 7 版)』(法律文化社・2019 年)。
12. 高田敏『新版行政法—法治主義具体化法としての—』(有斐閣・2009 年)。
13. 蔡秀卿「行政の実効性確保制度の法典化に関する一試論—台湾の行政執行法・行政罰法の施行を踏まえて—」市橋克哉先生退職記念論文集『転形期における行政と法の支配の省察』(法律文化者・2021 年)。
14. 板倉宏「行政刑法の課題」ジュリスト増刊『現代の法理論』(1970 年)。
15. 藤田勇『ソビエト法』(東京大学出版会・1986 年)。

Цахим эх сурвалж

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Холбоос: www.legalinfo.mn
2. Япон улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Холбоос: <https://elaws.e-gov.go.jp/>

ДӨРӨВ. ЦАГДААГИЙН АЛБАНД ТУЛГАМДАЖ БУЙ ЭРХ ЗҮЙН
ЗАРИМ АСУУДАЛ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
----------------	---

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Б.Энх-Амгалан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
Б.Сүнжидмаа	Эрдэм шинжилгээний ажилтан
Т.Билгүүн	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.12.28

АГУУЛГА

УДИРТГАЛ	179
I. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО	181
1.1. Монгол Улс дахь цагдаагийн алба хаагчийн сургалт	181
1.2. Сургалт хариуцан зохион байгуулах байгууллага: Монгол Улс ба гадаад орнууд	189
1.3. Цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт	195
1.4. Төгсөлтийн дараах үргэлжилсэн, мэргэшүүлэх сургалт	202
II. ЦАГДААГИЙН АЛБАНЫ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ	210
2.1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын дотоод хяналт-аюулгүй байдлын эрх зүйн үндэс	210
2.2. Гадаадын зарим орны цагдаагийн албанд хяналт тавих чиг үүрэг бүхий хараат бус байгууллага	216
III. МӨРДӨГЧИД ТАВИГДАХ ШАЛГУУР БА СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ	223
3.1. Монгол Улс	224
3.2. Америкийн Нэгдсэн Улс	226
3.3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	228
IV. ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛЛАГАА БА СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ	237
4.1. Албаны чиг үүрэг гүйцэтгүүлэх ажилд оролцох сонсогчийн эрх зүйн байдал, хүрээг тогтоох хэрэгцээ, шаардлага	231
4.2. Суралцагчийг цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажиллагаанд оролцуулах эрх зүйн орчин	232
4.3. Гадаад улсын жишиг	234
V. ЦАГДААГИЙН АЛБА ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЛБАДАН ТАРААХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ	239
5.1. Цагдаагийн алба жагсаал цуглаан албадан тараах ажиллагааны үед үүсэж буй хүний эрхийн зөрчил	239
5.2. Цагдаагийн байгууллагын жагсаал цуглааныг албадан тараах ажиллагааны өнөөгийн эрх зүйн зохицуулалт ба тулгамдсан асуудал	242
VI. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	254
НОМ ЗҮЙ	256

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.5 дахь хэсгийг үндэслэн, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд, цагдаагийн албанд тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбар тодорхойлох үүднээс гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн энэхүү судалгааг гүйцэтгэв.

Судалгааны зорилго. Цагдаагийн албанд тулгамдаж буй зарим асуудлын эрх зүйн зохицуулалтыг судалж, гадаад орнуудын сайн туршлага, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, дүгнэлт, санал боловсруулахад тус судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны зорилт. Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилт болон тус албанд тулгамдаж буй асуудал (Цагдаагийн албан хаагчийн сургалт, төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалтын тогтолцоо; Цагдаагийн албаны дотоод хяналт шалгалтын тогтолцоо; Мөрдөгчид тавигдах шалгуур; Сонсогчийг дайчлан ажиллуулах үеийн эрх зүйн байдал; Цагдаагийн алба жагсаал цуглаан албадан тараах ажиллагаа ба хүний эрх)-ын эрх зүйн зохицуулалтыг судалж, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах; Эрх зүйн зохицуулалтын нийтлэг чиг хандлагыг шинжлэн дүгнэсний үндсэн дээр дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг дэвшүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлэв.

Судалгаанд баримталсан зарчим, арга зүй. Судалгааг хараат бус, бие даасан байдлаар шинжлэх ухааны арга зүйг баримтлан явуулсан бөгөөд судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн гаргах хандлага баримталсан. Судалгааны арга зүйн хувьд, холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан, илтгэл, зөвлөмж, судлаачдын бүтээл зэрэг эх сурвалжид үндэслэн Монгол Улсын олон улсын гэрээний хэм хэмжээ ба Монгол Улс, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахдаа баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, хууль зүйн техник, хууль тайлбарлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон ярилцлага хийх зэрэг аргыг ашигласан болно.

Судалгааны хамрах хүрээ. Судалгааг олон улсын эрх зүйн болон Үндсэн хууль, холбогдох эрх зүйн онол, арга зүй, туршлагад тулгуурлан, ХЗДХЯ-аас ирүүлсэн “Судалгааны зорилт”-д тусгасан 5 асуудалтай холбоотой олон улсын эрх зүйн хэм хэмжээ, холбогдох бусад эх сурвалж, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын эрх зүйн орчин, зарим практикийн хүрээнд явуулав.

“Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо” сэдэвт I бүлгийн хүрээнд цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт болон төгсөлтийн дараах мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтын талаар судалсан бөгөөд цагдаа - мэргэжлийн дээд боловсролын сургалт/ бакалавр, магистр, доктор, адъюнктур/ болон иргэд, олон нийтэд чиглэгдсэн сургалтыг хамруулаагүй.

“Цагдаагийн албаны дотоод хяналт шалгалт” сэдэвт II бүлэгт цагдаагийн албанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэх олон улсын хяналтын загвар, Монгол Улсын цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоог судалж, зарим улс орны туршлагыг харьцуулав.

“Мөрдөгчид тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт” сэдэвт III бүлэгт эрүүл мэнд, бие бялдар, гоо зүй, боловсрол, мэргэжлийн гэх мэт цагдаагийн албан хаагчид тавигдах ерөнхий шаардлагаас гадна тухайн салбарын мөрдөгчийн ажлын байранд тохирох ур чадварууд (асуудал шийдвэрлэх, логик дүгнэлт гаргах г.м)-ын шалгуур, сонгон шалгаруулалтын талаарх гадаад орнуудын зохицуулалттай Монгол Улсын өнөөгийн байдлыг харьцуулж шинжилсэн.

“Онцгой тохиолдолд албаны чиг үүрэг гүйцэтгүүлэх ажиллагаа ба сургалтын байгууллагын суралцагчийн эрх зүйн байдал” сэдэвт IV бүлэгт тусгай албаны чиг үүргийг гүйцэтгэх ажиллагаанд сонсогч оролцуулах нөхцөл, журам, эрх, үүргийн хүрээ хязгаарыг хуульчилсан гадаад орнуудын туршлага, Монгол Улсын холбогдох эрх зүйн орчин, хэрэгжилтийн байдал, цаашид шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага, арга замын талаар судлан үзлээ.

“Цагдаагийн алба жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаа ба хүний эрх” сэдэвт V бүлэгт олон улсын чиг хандлага, гадаад орнуудын жишиг, Монгол Улсын өнөөгийн байдал, цаашид шийдвэрлэх асуудлыг хамруулж тус тус судлав.

I. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО

1.1. Монгол Улс дахь цагдаагийн алба хаагчийн сургалт

Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.1-д “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна”, мөн хуулийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.”, Цагдаагийн албаны тухай хуулийн 21.1.11-д “Хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, мэргэшлийн зэрэг олгох”, Дотоодын цэргийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Дотоодын цэргийн алба хаагч энэ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн мэдлэг олгох, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техник хэрэглэх бэлтгэл, сургалтад заавал хамрагдсан байна” гэж цагдаагийн алба хаагчийг сургах эрх зүйн үндэслэлийг тус тус тогтоосон байна.

Мөн цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах албан тушаалтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх замаар үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлох зорилгоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”¹-ийг 2014, 2020 онд Засгийн газраас тус тус баталжээ. 2014 оны хөгжлийн хөтөлбөр²-ийн 5.3.5-д цагдаагийн алба хаагчийн бакалавр, магистр, докторын түвшний сургалтыг уялдуулан зохион байгуулж, давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүсчилсэн сургалтын төвүүдийг байгуулахаар заасан. 2020 оны хөгжлийн хөтөлбөрт цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлэхийн тулд сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх; сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, бүсчилсэн сургалтын 2 төвийг шинээр байгуулах; албаны сургалтын агуулга, технологийг шинэчилж, чадамжид суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулах талаар төлөвлөжээ. Эдгээрээс үзэхэд цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, сургах боловсролын тогтолцоог Засгийн газраас үе шаттайгаар, тасралтгүй хөгжүүлэхээр төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгаж ирсэн бөгөөд нэг талаас энэ нь анхаарлын төвөөс холдоогүй чухал асуудлын нэг болж байгаа боловч нөгөө талаас цагдаагийн алба хаагчийг сургах тогтолцоо хангалттай хэмжээнд боловсронгуй болоогүй, шинэ тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай гэдгийг илтгэж байна.

Цагдаагийн алба хаагчдыг сургаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргээ хэрэгжүүлж иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд онц ач холбогдолтой. Иймээс цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэн сургах тогтолцоо боловсронгуй болгох нь чухал.

1 Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211003&showType=1>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

2 Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралт, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206264&showType=1>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

“Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” 118 дугаар журамд зааснаар Монгол Улсад цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоо нь өнөөгийн байдлаар дараах төрлийн сургалтаас бүрдэж байна. Үүнд:

- а/ цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт;
- б/ цагдаа - мэргэжлийн дээд боловсролын сургалт /бакалавр, магистр, доктор, адъюнктуур/;
- в/ цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт;
- г/ иргэд, олон нийтэд чиглэгдсэн бусад сургалт.³

Харин Цагдаагийн албаны тухай хуулийн 17.2-т “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэж зааснаар цагдаагийн албаны сургалтын тогтолцоог тодорхойлсон гэж үзэж болох юм. Мөн албаны нохой ашиглах, галт зэвсэг ашиглах болон гэрээт харуул хамгаалалтын сургалт, шийтгэл хүлээсэн алба хаагчийн хамрагдах ёс зүйн сургалтууд тус тус хуульд тусгалаа олжээ. Бусад сургалтын талаар Цагдаагийн албаны тухай хуульд нарийвчлан тусгаагүй байна.

Энэхүү судалгааны хүрээнд цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт болон мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтын агуулга, хөтөлбөр, холбогдох журмуудад дүн шинжилгээ хийж цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын тогтолцоог тодруулж, гадаадын сайн жишигтэй харьцуулан, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Хууль тогтоомжийн харилцан уялдаа

Монгол Улсын цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог судлах явцад холбогдох хууль тогтоомж болон батлагдсан хөтөлбөрүүд харилцан уялдаагүй байдал ажиглагдсан. Иймд юуны түрүүнд дээрх асуудлыг хөндөн авч үзье.

Тогтолцооны хувьд

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 118-д а/ цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт; в/ цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтууд байхаар тусгасан бөгөөд цагдаагийн мэргэжлийн бэлтгэлийг дараах төрөлтэй байхаар журамлажээ:

1. Мэргэшүүлэх сургалт;
2. Ур чадварын сургалт;
3. Чадавхжуулах сургалт;
4. Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалт;
5. Ёс зүйн сургалт

Харин СГАСХ-ийн мэргэжилтэнтэй ярилцлага хийсний дүнд “Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам”⁴-ыг мөн онцолж авч үзэх нь зүйтэй гэсэн юм. Уг журамд мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтыг тусгасан бөгөөд эдгээрээс гадна:

³ Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх код журам 118.4.1.

⁴ Цагдаагийн ерөнхий газрын даргын А/211 дүгээр тушаалын хавсралт, 2017.

1. Мэргэшүүлэх сургалт;
2. Ур чадварын сургалт;
3. Чадавхижуулах сургалт;
4. Мэдлэг, ур чадварын сургалт;
5. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн сургалт;
6. Сахилгын дүрэм зөрчсөн алба хаагчийн ёс зүйн сургалтуудыг тус тус давтан болон албаны сургалтын төрөл, хэлбэр гэсэн 4 дүгээр зүйлд багтаасан байна.

Үүнээс үзэхэд дээр дурдсан 6 төрлийн сургалт нь давтан сургалтын төрөл эсхүл албаны сургалтын төрөл үү? гэдэг нь ойлгомжгүй бөгөөд хэл зүйн дүрмийн дагуу давтан болон албаны сургалтын аль алинд хамаарахаар ойлгогдож байна. Мөн эдгээр сургалт нь хоёр журамд өөр, өөр сургалтын төрөл байхаар тусгагдсан буюу мэргэжлийн бэлтгэлийн эсхүл давтан болон албаны сургалтын алинд хамаарах нь тодорхойгүй нөхцөл үүсжээ.

Мөн Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх тухай 118 дугаар журмын 118.7.5-д Ёс зүйн сургалтыг ЦЕГ-ын даргын А/99 дүгээр тушаалаар баталсан Ёс зүйн төлбөртэй сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулна гэсэн нь ойлгомжгүй байна. Учир нь энэхүү төлбөртэй сургалт нь зөвхөн ёс зүйн зөрчил гаргасан цагдаагийн алба хаагчдад хэрэгжүүлдэг сургалт буюу тус журмын 118.7.3-т заасан “Ёс зүйн сургалт” нь зөвхөн зөрчил гаргасан алба хаагчдын хамрагдах сургалт гэж үзэхэд хүргэж байна. Ингэснээр сургалтын тогтолцоог тодорхойлсон уг журам дахь ёс зүйн сургалт нь алба хаагчдын зайлшгүй хамрагдах сургалтын төрөлд орохгүй байна.

Эдгээр журмуудыг удирдлага болгон баталсан, сүүлийн 2 жилийн буюу 2022-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цагдаагийн албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг дор харьцуулан авч үзэв:

Хүснэгт 4.1. 2022 болон 2023 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр

2022 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр	2023 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр
Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 онд явуулах албаны /ажлын байрны/ сургалт явуулах төрөл:	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 онд явуулах албаны сургалт явуулах төрөл:
<ol style="list-style-type: none"> 1. Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 2. Алба хаагчийг хөгжүүлэх сургалт 3. Дадлагажуулах сургалт 4. Бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах сургалт 5. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах сургалт 6. Алба хаагчийн давтан, мэргэшүүлэх сургалт 	<ol style="list-style-type: none"> 1. Албаны сургалт 2. Алба хаагчийн үргэлжилсэн сургалт <ul style="list-style-type: none"> - Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт; - Алба хаагчийг хөгжүүлэх сургалт; - Дадлагажуулах сургалт; 3. Алба хаагчийн давтан, мэргэшүүлэх сургалт.

Энэхүү 2 хөтөлбөр болон холбогдох журмуудад тусгагдсан сургалтын төрлүүд нь цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог эмх цэгцгүй, төөрөгдүүлэхэд хүргэсэн, ойлгомжгүй байдлыг бий болгожээ. Учир нь:

Мэргэжлийн бэлтгэл. Сургалтын хоёр хөтөлбөрийн аль алинд нь ЦАТХ болон журмаар баталгаажуулсан мэргэжлийн бэлтгэлийн талаар дурдаагүй. Цагдаагийн ерөнхий газрын даргын А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам болон 118 дугаар журмын 118.7.2-т тус тус зааснаар Мэргэжлийн бэлтгэл гэдэг нь цагдаагийн алба хаагчаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэх, мэдлэг ур чадварыг олгохыг хэлжээ. Уг тодорхойлолтоос үзвэл мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт болон бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах сургалтууд нь “мэргэжлийн бэлтгэл”-д багтах боломжтой байна.

Мөн 2022 оны хөтөлбөрт алба хаагчийг хөгжүүлэх, дадлагажуулах зэрэг шинэ төрлийн сургалтыг орохоор тогтоож, тодорхойлсон байна. Хэдий шинэ нэртэй болгож тодорхойлсон ч мэргэжлийн бэлтгэл эсхүл албаны болон давтан сургалтын төрөл байхаар А/211 болон 118 дугаар журамд тусгасан “ёс зүйн сургалт” нь алба хаагчийг хөгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нь олон, өөр өөр нэршилтэй ч адилхан агуулга бүхий сургалтын төрлүүдийг үүсгэж байгаа төдийгүй цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд төвөгтэй байдлыг бий болгож байна.

Давтан, мэргэшүүлэх ба ур чадварын, чадавхжуулах зэрэг сургалтууд.

Давтан сургалтын төрөл нь алба хаагчийн урьд нь олж авсан мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалтыг хэлнэ. Давтан сургалт нь цагдаагийн алба хаагч нь хуулиар хэрэгжүүлсэн чиг үүргээ хэрэгжүүлэх мэргэжлийн чадамжийг дээшлүүлж, дадал чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгдэх ба ажлын 3-5 хоногийн хугацаатайгаар зохион байгуулагдана. Сургалтын агуулгын 60 ба түүнээс дээш хувь нь алба хаагчийг дадлагажуулж, чадавхжуулах сургалт байна.⁵ Энэ сургалтын төрлийг мөн ЦАТХ-д баталгаажуулсан байдаг.

Мэргэшүүлэх сургалт нь алба хаагчдын тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын арга, тактикийн мэдлэг, ур чадварын түвшинг нь дээшлүүлэх, цагдаагийн тодорхой албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшлийн чадамж олгох болон түвшинг нь дээшлүүлэхэд чиглэгдэх бөгөөд ажлын 3-10 хоногийн хүртэл хугацаанд зохион байгуулагдана.⁶ ЦАТХ-д мэргэшүүлэх сургалтын талаар тусгаагүй ч 118 дугаар журамд мэргэжлийн бэлтгэлийн нэг төрөл гэж зааж, харин А/211 дүгээр журамд албаны сургалтад хамааруулж үзсэн байна. Харин 2022, 2023 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд “давтан, мэргэшүүлэх” сургалт нэрээр хамтдаа тусгагдсан. Энэ нь хуульд заасан давтан болон албаны сургалтаас өөрөөр тусгагджээ. Мөн ЦБҮАЖ код 950.6.3-ын “б”-д сургагч багш нарыг сонгон шалгаруулах, мэргэшүүлэх ур чадварын сургалтыг зохион байгуулах..., код 509.4.16-ын “е”-д алба хаагчийг жилд 2–оос доошгүй удаа давтан болон мэргэшүүлэх дадлага, сургалтад хамруулах

⁵ Цагдаагийн ерөнхий газрын даргын А/211 дүгээр тушаалын хавсралт, 2017, 4.1 дүгээр зүйл.

⁶ Мөн тэнд, 4.2 дугаар зүйл.

гэх мэтчилэн өөр өөр хэллэгээр томъёолсон нь практикт мөн өөр өөр утгаар хэрэглэгдэж байж болзошгүйг илэрхийлж байна.

Түүнчлэн, мэргэшүүлэх сургалтыг мэргэшлийн чадамж олгох, мэдлэг, ур чадварын түвшинг нь дээшлүүлэх зэргээр тодорхойлсон нь алба хаагчийн урьд нь олж авсан мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг давтан сургалттай мөн алба хаагчдын ур чадварыг ахиулах, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд чиглэгдэх ур чадварын сургалтуудтай давхацсан, ойлгомжгүй тодорхойлолтуудыг бий болгосон байна. Иймд 2023 онд батлагдсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3.1.9.-д «мэргэшүүлэх сургалт» гэж иргэнийг мэргэжлийн чиглэлээр давтан сургах, мэргэшлийн түвшин ахиулах сургалт гэж тодорхойлсныг анхаарч, бусад сургалтаас ялгамжтай зохицуулах шаардлагатай.

Харин ур чадварын сургалтын агуулга нь дадлагажуулах, чадавхжуулахад чиглэгдэнэ гэснээр А/211 дугаар журамд заасан чадавхжуулах сургалтаас ялгаж авч үзэхэд хүндрэл бий болгож байна. Учир нь уг журамд “Цагдаагийн албанд тусгай мэдлэг, мэргэжил шаардсан албан тушаалд дадлагажих ажилтнаар ажиллаж байгаа иргэнийг холбогдох журмын дагуу ажлын үр дүнг харгалзан 1 сараас доошгүй хугацааны чадавхижуулах сургалтад хамруулна.” гэснээс өөрөөр чадавхжуулах сургалтыг тодорхойлоогүй бөгөөд 118 дугаар журамд мөн чадавхжуулах сургалтыг тодорхойлоогүй байна. Мөн “Алба хаагчийг удирдах албан тушаалд дэвшүүлэн томилох өөр ажлын байр /албан тушаал/-нд томилох тохиолдолд тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалтад хамруулна.” гэсэн нь мэдлэг, ур чадварын сургалт гэсэн тусдаа төрлийг бий болгож байна гэж ойлгоход хүргэжээ.

Албаны сургалт

2023 оны сургалтын төлөвлөгөөнд “албаны сургалт” нь өөрөө албаны сургалтын нэг төрөл болж тусгагдсан байна. Гэтэл 118 дугаар журамд албаны сургалтын 3 төрлийг дараах байдлаар тодорхойлсон:

- ажлын байрны сургалт;
- алба хаагчийн үргэлжилсэн сургалт;
- ажлын байран дээрх албаны сургалт.

Өөрөөр хэлбэл, 118 дугаар журамд заасан энэхүү 3 сургалтад албаны сургалт багтаагүй байна.

“**Албаны сургалт**” гэж Цагдаагийн төв, харьяа алба, нэгж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах сургалт хэлнэ гэж хэт ерөнхий байдлаар тодорхойлсон байна. Харин практикт албаны сургалт гэдэгт цагдаагийн алба хаагчийг хөгжүүлэх бүх сургалтыг хамруулан ойлгох явдал түгээмэл байна.

Ажлын байрны сургалт ба ажлын байран дээрх албаны сургалт

118 дугаар журмын “118.7.11-д “Ажлын байрны сургалт нь шинээр томилогдсон алба хаагчдад ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, түвшинг нь дээшлүүлэх, ажил, албанд хандах хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэх...”

118.7.13-т "Ажлын байран дахь албаны сургалт нь алба хаагчдын мэдлэг, ур чадварыг ажлын байрнаас хөндийрүүлэхгүйгээр дээшлүүлэхэд чиглэгдэх ба энэ журмын 118.9, 118.12-т зааснаар зохицуулна." гэж тус тус тодорхойлжээ.

Дээрхээс үзвэл, нэг нь шинээр томилогдсон алба хаагчдад зориулсан сургалт бол нөгөө нь одоо ажиллаж байгаа буюу 1 ба түүнээс дээш жил ажиллаж буй алба хаагчдад зориулсан, ажлын байрнаас хөндийрүүлэхгүйгээр мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхийг зорьж байгаа сургалт гэж ойлгогдож байна. Түүнчлэн, ЦБҮАЖ код 118-д сургалтын 3 төрлийг ангилахдаа "ажлын байран дээрх албаны сургалт" гэж томъёолсон боловч тус журмын 118.7.13-т тухайн төрлийн сургалтыг тодорхойлохдоо "ажлын байран дахь албаны сургалт" гэж өөрөөр томъёолсон, мөн Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах 951 дүгээр журамд заасан алба хаагчийн үргэлжилсэн сургалтын чиглэл, багтаамжийн агуулгад "... ажлын байран дээр зохион байгуулагдсан сургалт;"-ыг хамруулсан нь оновчтой эсэхийг нягтлах шаардлагатай.

ЦБҮАЖ код 239 нь ажлын байрны сургалтын үйл ажиллагааг зохицуулдаг журам юм. Тус журамд зааснаар шинээр томилогдсон алба хаагчид 16-аас доошгүй долоо хоногийн ажлын байрны сургалтыг амжилттай төгссөн байх ёстой ба өөрийн ажиллаж байсан албан тушаалаас өөр мэргэшил шаардсан албан тушаалд шилжсэн алба хаагчид зориулсан сургалтын хугацааг тухайн алба хаагчийн ажлын гүйцэтгэл, туршлагын түвшингээс хамаарч 8-аас доошгүй 7 хоногоор явуулдаг байна.

Мөн тус журмын 239.5.2-т Ажлын байрны сургалтын хөтөлбөрийн загварыг Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж, цагдаа, дотоодын цэргийн сургалтын ажил хариуцсан нэгжтэй хамтран боловсруулахаар заажээ. Нээлттэй нийгэм форум, ДХИС-ийн хамтран гүйцэтгэсэн "Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх" сэдэвт судалгаанд "Сургалтын хөтөлбөрийн загварыг хавсаргах шаардлагатай. Уг хөтөлбөрт шинээр томилогдсон, өөр ажилд шилжсэн алба хаагчаас гадна албан тушаал ахихын өмнөх сургалтад хамрагдах асуудал тусгагдаагүй. Энэ нь хүний эрхийн зөрчлийг гаргуулахгүй байх, алба хаагчдын хүний эрхийн сэтгэлгээг хөгжүүлэх, албаны нэр хүндийг дээшлүүлэхэд тустай." гэж дүгнэсэн. Үүний дагуу нягтлахад 2022 онд шинэчлэн баталсан ЦБҮАЖ-д эдгээр шаардлагыг хангаагүй байгаа бөгөөд Цагдаа, дотоодын цэргийн сургалтын төвөөс үүнийг тодруулахад, холбогдох хөтөлбөр, төлөвлөгөө, загвар олдоогүй бөгөөд СГАСХ-ийн мэргэжилтэн нь ийм загвар байдаггүй гэсэн албан хариуг өгсөн.⁷ Иймээс энэхүү журмын дээрх заалт хэрэгжихгүй байгааг анхаарч албан тушаал ахихын өмнө хамрагдах сургалтын талаар энэхүү журамд оруулах эсэхийг нягтлах нь зүйтэй.

Үргэлжилсэн сургалт

"Алба хаагчийн үргэлжилсэн сургалт" гэж мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг тасралтгүй дээшлүүлэх, алба хаагчийн өөрөө сурч, хөгжих хандлагыг төлөвшүүлэх, эрмэлзлийг дэмжиж, хөгжүүлэхэд чиглэгдэх⁸ сургалтыг хэлнэ. Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах 951 дүгээр журамд зааснаар уг төрлийн сургалтын чиглэл, багтаамжид дараах агуулгыг тусгажээ. Үүнд:

⁷ ЦЕГ-ын СГАСХ-ийн мэргэжилтэнтэй ярилцсан ярилцлагын тэмдэглэл, 2023.12.21.

⁸ ЦБҮАЖ код 118.7.12.

<p>951.3.АЛБА ХААГЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН ЧИГЛЭЛ, БАГТААМЖ</p> <p>951.3.1.Алба хаагч нь дараах сургалтад хамрагдаж, сургалтын кредит цагийг заавал хангана.</p> <p>а/ цагдаагийн байгууллагын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан сургалт;</p> <p>б/ бүсийн сургалтын төвд зохион байгуулагдсан сургалт;</p> <p>в/ цагдаагийн байгууллагаас сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын байран дээр зохион байгуулагдсан сургалт;</p> <p>г/ гадаад улсад явагдсан мэргэжлийн болон мэргэшүүлэх богино хугацааны сургалт;</p> <p>д/ төрийн ба төрийн бус байгууллага, их, дээд сургууль, академи, бусад сургалтын байгууллагаас цагдаагийн алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон гадаад хэл, алба хаагчийг хөгжүүлэх бусад чиглэлээр тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан сургалт;</p> <p>е/ дээд боловсролын мэргэжлийн сургалт /бакалавр, магистр, доктор/.</p>

Дээрхээс үзвэл, цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтад мэргэжлийн дээд боловсролын сургалт, мэргэшүүлэх сургалт зэрэг тусдаа бие даасан сургалтын төрлүүдээс гадна ажлын байран дээр зохион байгуулагдсан сургалт буюу албаны сургалт, ажлын байрны сургалт зэрэг ойролцоо сургалтууд багтаж байгаа нь сургалтын тогтолцооны замбараагүй байдлыг үүсгэж байна.

Европын зарим орнууд болон АНУ, Канад зэрэг орны цагдаагийн боловсролын сургалт явуулдаг академи, сургалтын байгууллагуудыг судалж үзвэл:

а. цагдаагийн анхан шатны боловсролын сургалт буюу мэргэжлийн сургалт (Basic education/training)

б. Цагдаагийн дээд боловсролын сургалт (elevated studies)

в.одоо ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдад зориулсан боловсрол /сургалт буюу анхан шатны сургалт/ боловсролын дараа үүрэг гүйцэтгэгч цагдаагийн алба хаагчдыг үйл ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн өөрчлөлтийн дагуу мэдлэгийг шинэчлэх, тодорхой нөхцөл байдлыг үндэслэсэн үргэлжилсэн сургалт (Continuing education/training)

г. цагдаагийн мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэхэд чиглэсэн хөтөлбөр сургалтуудыг санал болгодог ба эдгээр хөтөлбөрүүд нь ур чадвараа ахиулах, бататгахад чиглэгддэг мэргэшүүлэх сургалт (specialized training, in-service training)

д. ихэвчлэн албан тушаалын зэрэглэл дэвшихэд болон удирдлага, манлайлал, хяналтын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор шинэ албан тушаалд томилогдохоос өмнө эсвэл дараа нь олгодог Удирдлагын (ахисан түвшний сургалт/ advanced training) зэргээс тогтож байна.⁹

Зарим орнуудын сургалтын тогтолцоог Монгол Улсын сургалтын тогтолцоотой харьцуулбал, мэргэжлийн сургалтын хувьд бусад улстай адил зохицуулалттай байна гэж үзэж болно. Гэвч үргэлжилсэн сургалтын агуулгын хувьд зөрүүтэй байна. Учир нь Монгол Улс албаны сургалт гэсэн хүрээнд олон төрлийн сургалтуудыг хамруулж, ерөнхийлөн авч үздэг бөгөөд үргэлжилсэн сургалтыг албаны сургалтын

9 Police education and training systems in the OSCE region, 2018, Холбоос: <https://www.osce.org/files/f/ documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

төрөл дотор багтаадаг бол бусад улсад үргэлжилсэн буюу мэргэшүүлэх сургалт зэрэг цөөн тооны ерөнхий сургалтын хүрээнд цагдаагийн алба хаагчдыг чадавхжуулах, ур чадвар ахиулах гол зорилго бүхий ажлын байран дээрх бусад дэд сургалтуудыг хамруулж байна. Гэхдээ энэ шинжээрээ Монгол Улсын албаны сургалт нь цагдаагийн дадлагажуулах сургалт (in-service training) эсхүл үргэлжилсэн сургалт (Continuing education/training) байх боломжтой юм.

Харин мэргэшүүлэх сургалтыг ЦАТХ-д тусгаагүй ч журмууд болон хөтөлбөрт тусгайлан тусгасан байгаа ба хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзвэл үндсэн сургалтын төрөл болгож хуульчлах шаардлагатай гэж үзлээ. Гэхдээ мэргэшүүлэх сургалтыг үргэлжилсэн сургалтаас ялгаж хуульчлах нь зүйтэй. “Алба хаагчийг удирдах албан тушаалд дэвшүүлэн томилох өөр ажлын байр /албан тушаал/-нд томилох тохиолдолд тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалтад хамруулна.”¹⁰ гэж заасан нь мэдлэг, ур чадварын сургалтыг дээр дурдагдсан ахисан шатны сургалтад хамааруулахаар байна.

Нэр томьёоны тухайд

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсанаар Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсон байна. Гэтэл 118 дугаар журмын хамрах хүрээ буюу үйл ажиллагаандаа баримтлах хууль тогтоомж нь хүчингүй болсон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг иш татан зохицуулсан явдал ажиглагдлаа. Иймээс журамд заасан хуулийн нэрийг хасаж хүчин төгөлдөр хуулийг тусгах шаардлагатай.

“Мэргэжлийн дээд боловсрол” гэсэн нэр томьёог Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон Дээд боловсролын тухай хуулиар томьёолоогүй атал 118 дугаар журамд “Цагдаа-мэргэжлийн дээд боловсролын сургалт” гэж хуульд заагаагүй нэр томьёо хэрэглэснээс гадна “Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт”-аас ялгаж ойлгоход хүндрэлтэй болж байгааг анхаарах нь зүйтэй. Боловсролын ерөнхий хуулийн 3.1.18-д заасны дагуу Цагдаагийн дээд боловсролын сургалт гэж томьёолох нь оновчтой юм. Мөн 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд “Цагдаа-мэргэжил олгох сургалт” гэсэн нэршилтэй байгаа ч 118 дугаар журамд Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт гэж томьёолсон байна. Эдгээр бүгд анхан шатны сургалтын агуулгыг илтгэж буй бол нэр томьёог нэгтгэх шаардлагатай.

Түүнчлэн, уг төлөвлөгөөг “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө” гэж нэрлэсэн байна. Энэ нь 118.7.3.г-д заасан “Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалт” гэсэнтэй төстэй буюу үүнийг хэлж байгаа мэт ойлгогдоно. Гэсэн ч нэгдсэн төлөвлөгөө нь 118.7.3.а-д заасан мэргэшүүлэх сургалт болон 118.7.3.б-д заасан ур чадварын сургалт /гэхдээ ур чадвар ахиулах сургалт гэсэн нэртэй тусгагдсан./ зэргийг өөртөө багтаасан ерөнхий төлөвлөгөө юм.

Уг нь дээрх сургалтууд нь 118.7.3-т зааснаар “Цагдаагийн мэргэжлийн бэлтгэл” гэсэн нэртэй. Тэгвэл албаны сургалтын төлөвлөгөө гэж үүнээс тусдаа батлагдсан байх тул “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө” гэсэн нэршил нь албаны сургалтыг хасаад

10 Цагдаагийн ерөнхий газрын даргын А/211 дүгээр тушаалын хавсралт, 2017, 4.5 дугаар зүйл.

118.7-д заасан “Мэргэжлийн бэлтгэл болон давтан сургалтын төлөвлөгөө” гэсэн нэртэй байх нь зохистой байж мэднэ.

118.9.3.б-д зөвлөл нь “цагдаагийн алба хаагчийг мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй стандартуудтай танилцаж, зөвлөх;” гэж заасан бөгөөд “...хөтөлбөртэй стандартууд” гэж юуг хэлж байгаа нь тодорхойгүй байна. “...хөтөлбөр, стандартуудтай” гэж бичих гэсэн боловч техник алдаа гарсан байж магадгүй байна.

Мөн 118.9.3-т заасан зөвлөл нь уг зүйлийн д-д заасан “гадаад, дотоодын сургууль, байгууллагын дэвшилтэт арга технологийг судлах, дэмжин дэлгэрүүлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах” гэсний дагуу ямар үйл ажиллагаа, судалгаа хийсэн нь мөн зүйлийн з-д заасан “цагдаагийн алба хаагчийн сургалтын тайланд дүн шинжилгээ хийж, аргачлал зөвлөмж боловсруулан хүргүүлэх” гэсний дагуу ямар зөвлөмж, аргачлал гаргасан нь ч тодорхойгүй байна.

1.2. Сургалт хариуцан зохион байгуулах байгууллага: Монгол Улс ба гадаад орнууд

Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам¹¹-ын 3.2-т заасны дагуу Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын нэгдсэн төв нь цагдаагийн байгууллагын алба хаагчийг бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр давтан болон албаны сургалтыг, бүсийн сургалтын төв нь цагдаагийн алба хаагчдын бүсчилсэн сургалтыг, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага дотооддоо албаны сургалтыг хариуцан зохион байгуулахаар байна. Уг заалтаас дараах хэд хэдэн асуудал үүсэж байна.

Нэгдүгээрт, Цагдаагийн ерөнхий газарт бүтцийн өөрчлөлт орсноос хойш холбогдох журмуудад бүрэн өөрчлөлт ороогүй байна. Тухайлбал, дээрх заалтад заасны дагуу Цагдаагийн төв байгууллагын хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын нэгдсэн төв нь цагдаагийн байгууллагын алба хаагчийг бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр давтан болон албаны сургалтыг хариуцан зохион байгуулахаар байгаа боловч 2018 оноос хойш Хүний нөөц, сургалтын хэлтсийн бүтцэд байсан Соён гэгээрүүлэх, албаны сургалтын тасгийг “Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс” болгон өргөжүүлж, одоогоор Хүний нөөцийн хэлтэс болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс нь тусдаа үйл ажиллагаа явуулж байна. Харин Сургалтын нэгдсэн төв нь “Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв” нэрээр өөрчлөгдсөн байна. Ингэснээр цагдаагийн байгууллагын алба хаагчийн дээрх сургалтыг зохион байгуулах, хөтөлбөр, төлөвлөгөө батлах хэлтэс, нэгж нь журамд тодорхойгүй байна.

Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 118.5.3, 239.5.2-т тус тус зааснаар Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс нь цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хариуцах ба ажлын байрны сургалтын хөтөлбөрийн загварыг мөн энэхүү нэгж, цагдаа, дотоодын цэргийн сургалтын ажил хариуцсан нэгжтэй хамтран боловсруулахаар тусгажээ. Эдгээр журмууд 2017 оны 12 дугаар сарын 20, 28-ны

¹¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/211 дүгээр тушаалын хавсралт, Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам.

өдөр тус тус батлагдсан бөгөөд Сургалтын бодлого, боловсруулж хэрэгжүүлэх 118 дугаар журам 2022 онд шинэчлэгдэн батлагдсан боловч өнөөг хүртэл нэгжийн өөрчлөлтийн талаар нэмэлт, өөрчлөлт ороогүй байна. Тухайлбал, урьд нь Хүний нөөц, сургалтын хэлтэс үйл ажиллагаагаа явуулж байсан учраас «хүний нөөц, сургалт хариуцсан нэгж» гэсэн нэршлээр журамлагдсан бөгөөд одоогоор Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс нь сургалтын ажил хариуцсан нэгж болжээ. Үүний улмаас цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөө, ажлын байрны сургалтын хөтөлбөрийн загвар батлах, боловсруулах сургалтын чиг үүргүүдийг аль хэлтэс хэрэгжүүлж байгаа нь ойлгомжгүй болсон байна.

Түүнчлэн, “Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж”, “Сургалтын ажил хариуцсан нэгж”-үүд байхаар журамд тусгагджээ. Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмын дээрх заалтаас үзэхэд Хүний нөөц, сургалтын хэлтэс болон Сургалтын нэгдсэн төв нь давтан болон албаны сургалтыг аль аль нь хариуцан зохин байгуулахаар мөн 118.7.1-д “Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж”, “Сургалтын ажил хариуцсан нэгж”-үүд нь мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтад хамруулах, байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах ажлыг хариуцахаар журамд тусгагджээ. Гэтэл практикт Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс нь албаны сургалтуудыг хариуцдаг бол ЦДЦСНТ нь мэргэжлийн бэлтгэл болон давтан сургалтуудыг хариуцан зохион байгуулж байна.¹²

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Сургалтын хэлтэс нь цагдаагийн алба хаагчдыг богино хугацаанд сургаж, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх, алба хаагчдын сэтгэлгээ, хандлагыг өөрчлөх, сургалтыг шинэлэг арга, хэлбэрээр явуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг бол СГАСХ нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, албаны сургалтын төлөвлөгөө, алба хаагчийн үргэлжилсэн сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулж хэрэгжүүлдэг¹³. Өөрөөр хэлбэл, СГАСХ нь зөвхөн албаны сургалтыг хариуцдаг ч давтан, мэргэшүүлэх зэрэг ЦДЦСНТ-ийн хариуцдаг сургалтын хөтөлбөрүүдийг баталдаг нь ойлгомжгүй байгаа юм. Мөн СГАСХ-ийн мэргэжилтэнтэй хийсэн уулзалтын үеэр “хүний нөөцийн хэлтэс болон сургалтын хэлтсийн үйл ажиллагаа хоорондоо уялддаг тул тусдаа байх нь учир дутагдалтай байгаа” гэсэн тайлбар өгсөн байдаг¹⁴. Иймээс Хүний нөөцийн хэлтэс, СГАСХ, ЦДЦСНТ зэрэг харилцан уялдаа бүхий хэлтсүүдийг бүтэц, зохион байгуулалт талаас харгалзан үзэж үйл ажиллагааг нэгтгэх талаар анхаарах нь чухал байна.

Зарим оронд цагдаагийн албаны бүх төрлийн боловсрол/сургалт хариуцсан нэг байгууллага байдаг бол заримд улсад сургалт тус бүрийг хариуцсан хэд хэдэн байгууллага, институт байна. Тухайлбал, АНУ-ын хэд хэдэн сургалтын байгууллага төрөл бүрийн сургалтыг явуулдаг. Жишээ дурдвал, Лексингтон дахь Эрүүгийн эрх зүйн сургалтын газар (Department of criminal justice training) анхан шатны болон манлайллын сургалтыг явуулдаг бол Хьюстоны Цагдаагийн академи болон Нэшвилл дэх Цагдаагийн газрын сургалтын академи нь анхан шатны болон

12 ЦЕГ-ын СГАСХ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2023.12.21.

13 Б.Алтантулга, СГАСХ, 2023, Холбоос: <https://prezi.com/p/hzsshw681kbl/presentation/>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

14 ЦЕГ-ын СГАСХ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, 2023.12.21.

мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулж байна. Харин эдгээрээс бусад сургалтын байгууллагууд нэг төрлийн сургалт дагнан явуулдаг. Мөн Оттава дахь Канадын Цагдаагийн коллеж нь үргэлжилсэн сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг бол Канадын эзэн хааны морьт цагдаагийн Академийн Депо хэлтэс нь голчлон анхан шатны сургалтууд явуулдаг.

Судалсан европын орнуудын сургалтын байгууллагын хувьд Австри, Хорват, Эстони, Латви, Монтенегро зэрэг улсад өөр өөр боловсрол/сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг ганц байгууллага, институт байхад ХБНГУ, Нидерланд, Польш зэрэг улсад анхан шатны/мэргэжлийн болон үргэлжилсэн сургалтын аль алиныг нь хэрэгжүүлдэг хэд хэдэн сургалтын байгууллага байна. Эдгээрээс үргэлжилсэн сургалтуудыг дангаар хэрэгжүүлдэг орнуудыг судлав.

Тухайлбал, **Эстони улсын Аюулгүй байдлын шинжлэх ухааны академи (EASS)**¹⁵ нь Дотоод хэргийн яаманд харьяалагддаг ба Эстони дахь цорын ганц цагдаагийн боловсролын байгууллага бөгөөд цагдаагийн анхан шатны сургалт, бакалавр, магистрын зэрэг олгох дээд боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна энэхүү академийн үргэлжилсэн сургалтын төв нь цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтыг явуулдаг байна.

Австрийн цагдаагийн албан тушаалын тогтолцоо нь гурван шатлалтай бөгөөд цагдаагийн ажилтан болохын тулд иргэн бүр анхан шатны сургалтаас (өмнөх боловсролоос үл хамааран) эхлэх ёстой. Сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн түвшинд ажиллах хамгийн бага хугацаанд, зохих түвшний сургалтад хамрагдсаны дараа дараагийн дээд түвшинд дэвших боломжтой байна. Австри улсад цагдаагийн боловсролын нэг гол байгууллага нь "Sicherheitsakademie" (SIK) Аюулгүй байдлын академи юм. Энэ байгууллага нь Дотоод хэргийн яамны харьяа 9 байгууллагын нэг бөгөөд уг яамны харьяа цагдаа, төрийн албан хаагчдын ерөнхий сургалт, хүмүүжлийн бүхий л үйл ажиллагаа, шинжлэх ухааны, судалгаа, олон улсын хамтын ажиллагааг хариуцна. Харин нарийн мэргэжлийн сургалтууд (албаны нохой ашиглах сургалт шүүх эмнэлэг, терроризмын эсрэг отрядын сургалт)-ыг Цагдаагийн байгууллагын тусгай хэлтэс хариуцан зохион байгуулдаг.¹⁶

Хорват улсын Цагдаагийн академийн Мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалтын хэлтэс (Department for Professional Development and Specialization) нь цагдаагийн бүх төрлийн нэгдсэн сургалтыг зохион байгуулдаг. Хорват улсын насанд хүрэгчдийн боловсролын хөгжлийн чиг хандлага, өсөн нэмэгдэж буй практикийн эрэлт хэрэгцээ, шаардлага, олон улсын өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа болон өөрийн хөгжлийн хүчин чармайлтын үр дүнд сүүлийн 10 жилийн хугацаанд мэргэшүүлэх сургалт, мэргэжлийн хөгжил, мэргэжлийн боловсролын сургалтын чиглэлүүд ихээхэн хөгжиж байна.¹⁷ Эдгээр сургалтад цагдаагийн байгууллагын бүхий л салбарт яамны түвшинд явуулдаг мэргэшүүлэх сургалт, мэргэжил дээшлүүлэх семинар, цагдаагийн газрын удирдлага, цагдаагийн байгууллагын түвшинд явагддаг цагдаагийн сургалт болон нэмэлт сургалтууд, түүнчлэн гадаад сургалтын хөтөлбөрүүд (humanitarian de-mining, гаалийн алба,

15 The Estonian Academy of Security Sciences, Холбоос: <https://www.sisekaitse.ee/en/eass-home>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

16 Sicherheitsakademie, Холбоос: <https://www.bmi.gv.at/104/>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

17 Police education and training systems in the OSCE region, 2018, p.129, Холбоос: <https://www.osce.org/files/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

цэргийн цагдаа, нисэх онгоцны буудлын ажилтнууд, замын цагдаагийн ажилтнуудад хамаарах гэх мэт) багтдаг.¹⁸ Насан туршийн/үргэлжилсэн боловсролыг дэлхийн насанд хүрэгчдийн боловсролын хөгжлийн үндсэн элемент гэж үздэг учир эдгээр бүх үйл ажиллагааг Хорватын насанд хүрэгчдийн боловсролын тогтолцоонд нэгтгэсэн байна.

Монтенегро улсын Цагдаагийн академи нь цагдаагийн алба хаагчдын бүх төрлийн сургалтыг эрхэлдэг байгууллага юм. Цагдаагийн академи нь Цагдаагийн анхан шатны боловсрол; Цагдаагийн алба хаагчдад зориулсан нэмэлт сургалтууд; Мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалт; Цагдаагийн байгууллагын удирдлагын сургалт; Гадаад хэл, компьютерын шинжлэх ухаан; Дотоод хэргийн яамны болон төрийн захиргааны ажилтнуудын боловсрол; Гаалийн ажилтнуудын боловсрол; Засан хүмүүжүүлэх ажилтны боловсрол; Хүн ба эд хөрөнгө хамгаалах ажилтнуудын боловсрол (аюулгүй байдлын үйлчилгээ); Номын санч, хэвлэн нийтлэх, судалгаа шинжилгээ хийх үйл ажиллагааг хөгжүүлэх; Олон улсын хамтын ажиллагааг дэмжих зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хувьд цагдаагийн боловсрол олгодог ганц байгууллага нь Дотоод хэргийн их сургууль юм. ДХИС нь дээд боловсрол буюу цагдаа мэргэжлээр бакалавр, магистр, доктор, адъюнктурын боловсрол эзэмшүүлж зэрэг олгохоос гадна иргэдэд зориулж цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт явуулдаг боловч алба хаагчийн үргэлжилсэн сургалтыг явуулах чиглэлээр үүрэг хүлээгээгүй. Гэхдээ Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар нь Сургалт эрхэлсэн дэд захирлын удирдлагад сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сургалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан сургалтын чанарын баталгаажуулалтыг хариуцах, сургалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сургалтын хөтөлбөрийг түүнд тавигдах шаардлага, стандартад нийцүүлэн боловсруулах, шинээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах, сургалт, бүртгэл мэдээлэл, элсэлт, шилжих хөдөлгөөн, төгсөлт, багшийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, сургуулийн анги танхимын хуваарилалт, хичээлийн хуваарь хийх, сургалтын төлөвлөгөөний биелэлт, чанарт хяналт тавих, бүх шатны сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, магадлан итгэмжлүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангахын сацуу захиалагч агентлаг, байгууллагын эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүх шатны сургалтын чанар, хөтөлбөрийн агуулга, тогтолцоо, арга хэлбэрийг олон улсын боловсролын стандартын дагуу боловсруулж хэрэгжүүлэх, чиглэлийг тодорхойлох, хөгжүүлэх, суралцагчдад ээлтэй сурах орчныг бүрдүүлэн ажиллахад бүхий л талаар дэмжлэг үзүүлэх зэрэг сургалтын олон төрлийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Харин ЦЕГ-ын **Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв** нь цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтын бодлогыг хэрэгжүүлж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, сургалт зохион явуулах¹⁹ чиг үүрэгтэй бол **Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс** нь цагдаагийн байгууллагын сургалтын бодлогыг боловсруулах, мөрдүүлэх, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, байгууллагын соёл, алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх

18 Мөн тэнд.

19 ЦБҮАЖ код 100, Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох, хавсралт.

ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах²⁰ үүрэгтэй юм.

Иймд ЦЕГ-ын ЦДЦСНТ, СГАСХ болон ДХИС-ийн Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар нь цагдаагийн алба хаагчийн бүх төрлийн сургалтыг зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах, дэвшилтэт сургалтын тогтолцоог бий болгох зэрэг олон ажлын хүрээнд хамтран ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байна. Үүнээс гадна цөөн хүн амтай Монгол Улсын хувьд дээрх байдлаар чиг үүрэг нь төсөөтэй хэд хэдэн сургалтын байгууллагууд байгаа нь хүний нөөцийн үр ашиггүй зардал гаргахаас гадна сургалтын хэврэг тогтолцоог бий болгож байж болзошгүй тул харьцуулсан судалгааны хүрээнд авч үзсэн цөөн хүн амтай орнууд болох Эстони, Австри, Хорват зэрэг орнууд шиг цагдаагийн боловсрол эзэмшүүлдэг их сургууль, академид цагдаагийн сургалтын чиг үүргүүдийг төвлөрүүлж сургалтын салангид тогтолцооноос нэгдсэн сургалтын тогтолцоо руу шилжүүлснээр үр ашиггүй зардал буурч цагдаагийн боловсрол, сургалтын тогтолцоог илүү тогтвортой хөгжүүлэх боломж нээгдэж болох юм.

Цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт

Цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт гэдэг нь цагдаагийн албанд ажиллах хүсэлтэй энгийн иргэдэд цагдаагийн талаарх наад захын, суурь ойлголт, мэдлэг өгөхөд чиглэсэн цагдаагийн мэргэжлийн сургалтыг хэлдэг. Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар Цагдаагийн төв байгууллага буюу Цагдаагийн ерөнхий газар цагдаагийн албаны хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад захиалга өгдөг.²¹ Уг байгууллага нь ХЗДХЯ-ны харьяа Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна. Уг төв нь мэргэжлийн сургалт буюу “Ахлагч” бэлтгэх сургалтад цагдаагийн албаны “Цагдаа”, “Цагдаа жолооч” зэрэг мэргэжлээр, ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэн төгсгөдөг.

Сургалтын хугацаа

2017 онд Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалтыг 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар зохион байгуулахаар журамласан боловч 2022 оны шинэчилсэн журамд 1 сараас 1 жил хүртэл хугацаатай болгож өөрчилсөн байна. ДХИС-ын сургалт хариуцсан холбогдох мэргэжилтнээс тодруулахад практикт цагдаагийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 45 хоногийн хугацаагаар зохион байгуулж байна гэсэн юм. Өмнө нь 3 сарын хугацаанд сургалт явуулахдаа 600 орчим цагийн багтаамжтайгаар зохион байгуулдаг байсан бол журмын дагуу 1 сарын хугацаатай болгосноор сургалтын цаг улам багасна гэж үзэж байна.

Зарим гадаад орны цагдаагийн анхан шатны сургалтын хугацааг авч үзвэл 6 сараас (АНУ-ын Хьюстоны цагдаагийн академи, Канадын хааны морьт цагдаа (RCMP) Саскачеван дахь Академийн Депо хэлтэс, Польш дахь Szczytno-ийн цагдаагийн академи (WSPOL)) 30 сар хүртэл (Германы Бранденбургийн цагдаагийн академи, коллеж (Fachhochschule der Polizei), мөн Эстонийн Аюулгүй байдлын шинжлэх ухааны академи (EASS), Эстони болон Хорват дахь Цагдаагийн академид

20 Мөн тэнд.

21 Цагдаагийн албаны тухай хууль 66 дугаар зүйлийн 8 дахь хэсэг.

18 сар орчим үргэлжилдэг байна. Сургалтын хөтөлбөрийн нийт цаг нь Канадын Депо хэлтэст 785 цаг, Германы Бранденбургийн цагдаагийн академи, коллежид 2861 цаг, Латви улсын Цагдаагийн коллежид 1560 цаг хүртэл байдаг.

ХБНГУ-ын Бранденбургийн цагдаагийн академийн цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт нь нийт 2 жил 6 сарын хугацаатай үргэлжилдэг ба эхний сургалт 12 сар, 2 дахь сургалт нэгдсэн дадлагын хамт 9 сар, 3 дахь сургалтын гуравны нэг нь онолын хичээл, гуравны хоёр нь практик хичээлээс бүрдсэн 9 сарын сургалт бүхий 3 шатлалт сургалт ордог.

Францын үндэсний цагдаагийн Ерөнхий удирдлагын бүрэлдэхүүн дэх Цагдаагийн боловсролын захиргаа (la direction de la formation de police nationale - dFPn) нь цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт, бэлтгэлийг зохион байгуулах ажлыг хариуцдаг.²² Цагдаагийн анхан шатны бие бүрэлдэхүүнийг 12 сарын турш сургаж бэлтгэдэг. Эхний 4 сард цагдаагийн үйл ажиллагаа, ялангуяа эргүүл-хамгаалалтын алба хаахад шаардлагатай суурь мэдлэгүүдийг эзэмшээд 8 сарын турш цагдаагийн хэлтэст дадлагаар суралцдаг.²³ Цагдаагийн дунд шатны офицерууд 18 сарын сургалтад хамрагдах бөгөөд үүний 1 сар нь аль нэг хотын цагдаагийн газар урьдчилсан бэлтгэлд хамрагдаад, 7 сар Канне-эклюз дэх үндэсний цагдаагийн офицерын дээд сургуульд суралцана.²⁴ Дараа нь 3 сар нийслэлийн мөрдөн байцаах газар, дүүргийн эрүүгийн цагдаагийн алба, комиссириатад “стажер” буюу мэргэжил дээшлүүлэх хэлбэрээр суралцана.²⁵ Дадлагын дараа 2 сар сургуульдаа суралцаж, шалгалт өгснөөр сургалт дуусна.

Эдгээр сонгон судалсан цагдаагийн сургалтын байгууллага/академид цагдаагийн анхан шатны сургалтыг хамгийн багадаа 6 сар байхаар төлөвлөсөн байгаатай харьцуулбал, Монгол Улсад 1 сарын сургалтад хамрагдсан иргэнд цагдаагийн албаны үйл ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэх эрх олгож байгаа нь хэт богино хугацаанд тооцогдоно.

Сургалтын агуулга

Цагдааг бэлтгэх, сургах хөтөлбөрийн агуулга олон жилийн туршид ихээхэн өөрчлөгдсөөр иржээ. Тухайлбал, уламжлалт цагдаагийн ажил нь цагдаагийн алба хаагчдаас өөрийгөө хамгаалах, баривчлах, буудах, жолоодох зэрэг механик аргыг хэрэглэх үр чадвартай байхыг шаарддаг байсны улмаас цагдаад эдгээрт холбогдсон биеийн хүчний дасгалуудыг заахад сургалтын хөтөлбөр чиглэгддэг байжээ.²⁶ Харин орчин үед цагдаагийн ажил нь бусадтай харилцах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах зэрэг нэмэлт үр чадварт анхаарлаа хандуулдаг болсон.²⁷ Тиймээс цагдаагийн академи, сургалтын байгууллагууд эдгээр үр чадварыг цагдаагийн алба хаагч, суралцагчдад эзэмшүүлэхийн тулд сургалтын бүтэц, агуулга, хэрэгжилтийг

22 Law enforcement theoretical and methodological journal, 2014, Б.Одончимэг, “Олон улсын хууль сахиулах чиглэлийн боловсролын тогтолцооны хөгжлийн тойм: цагдаагийн боловсролын жишээн дээр”, 117 дахь талаас дам эшлэв.

23 Мөн тэнд.

24 Мөн тэнд.

25 Мөн тэнд.

26 Chappell, A.T. (2008), “Police academy training: comparing across curricula”, *Policing: An International Journal*, Vol. 31 No. 1, pp. 36-56. <https://doi.org/10.1108/13639510810852567>

27 Blumberg, D. M., Schlosser, M. D., Papazoglou, K., Creighton, S., & Kaye, C. C. (2019). New directions in police academy training: A call to action. *International journal of environmental research and public health*, 16(24), 4941.

оновчтой тохируулах шаардлагатай юм.²⁸ Цаашилбал, Цагдаагийн сургалт нь гүйцэтгэл, ур чадварыг сайжруулах түүнийгээ өөриймшүүлэхэд чиглэж байгаа буюу уламжлалт анги танхимд суурилсан, сургагч төвтэй заах аргаас татгалзаж суралцагч төвтэй заах арга руу шилжиж байна.

Монгол Улсын цагдаагийн мэргэжлийн сургалтаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны тактик, Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа, Цагдаагийн байгууллагын захиргааны үүрэг, Зохицуулагч цагдаагийн хийж гүйцэтгэх ажиллагаа, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Цагдаагийн байгууллагын ажиллагаа, Цагдаагийн алба хаагчийн харилцааны ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэл, Хүний эрх ба Цагдаагийн байгууллага, Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа” зэрэг 21 төрлийн хичээлийг үзэж судалдаг.²⁹ Гэвч ДХИС-ийн сургалтын хөтөлбөрийн бүрэн агуулгыг олоход зарим хүндрэл үүссэн тул өнөөгийн сургалтын үндсэн хөтөлбөрт дүн шинжилгээ хийгээгүй болно. Харин практикт үүсэж буй бодит нөхцөлүүдэд үндэслэн сайн жишиг болохуйц олон улсын туршлагыг нарийвчлан судлахыг зорьсон.

1.3. Цагдаагийн албаны анхан шатны сургалтын сайн туршлага / Сургалтын хөтөлбөр

ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Цагдаагийн ахлах зөвлөхөөс гаргасан “Ардчилсан цагдаагийн үйл ажиллагааны удирдамж”-д заасан зарчим, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор “Цагдаагийн албаны анхан шатны сургалтын сайн туршлага – сургалтын хөтөлбөр”³⁰ хэмээх гарын авлагыг бүтээжээ. Энэхүү гарын авлагад цагдаагийн байгууллагын үндсэн сургалтын загварыг сайжруулах нийтлэг стандартыг тусгасан ба ЕАБХАБ-ын гишүүн орнуудын цагдаагийн ерөнхий соёлыг дээшлүүлэх, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг илүү үр дүнтэй болгохын тулд цагдаагийн алба, чиг үүргийн загварыг илүү ардчилсан, олон нийтэд чиглэсэн байхад анхаарсан байна.

Дээрх гарын авлагад цагдаагийн алба хаагчийн заавал суралцах ёстой сургалтын агуулгыг гурван хэсэгт хуваажээ. Нэгд, ардчилсан цагдаагийн үйл ажиллагааны гол цөм болох үнэт зүйл, ёс зүй; Хоёрт, цагдаагийн ажилтнууд эдгээр үнэт зүйлс, ёс зүйд тулгуурлан өөр өөр практик орчинд хэрхэн шийдвэр гаргах талаар; Гуравт, цагдаагийн алба хаагчийн ур чадварт анхаарч үндсэн шаардлага, эргүүл, мөрдөн байцаалт, журам, хээрийн сургалтын талаарх агуулгыг хамруулсан байна. Эдгээрийг дор дэлгэрүүлж авч үзье.

а. Үнэт зүйл ба ёс зүй

Цагдаагийн алба хаагч нь иргэдийн эрхийг хамгаалах, хууль сахиулах үүрэг хүлээдэг. Ингэхдээ өдөр тутмын үйл ажиллагаанд ардчиллын үнэт зүйлийг баримтлах ёстой. Эдгээр үнэт зүйл нь соёлын олон талт байдал, ялгаварлан гадуурхалтын талаар ухамсарлан бүх хүмүүст тэгш, шударга хандах, арьс өнгө,

28 Marenin, O. (2004). Police training for democracy. *Police practice and Research*, 5(2), 107-123.

29 Цагдаагийн мэргэжлийн сургалт, Холбоос: <https://police.gov.mn/resource/policegovmn/media/XHCX/.docx>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

30 Good Practices in Basic Police Training – Curricula Aspects by the Senior Police Adviser to the OSCE Secretary General SPMU Publication Series Vol.5, 2009, Холбоос: <https://www.osce.org/files/f/ documents/a/2/109933.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

үндэс угсаа, бэлгийн чиг баримжаа, хүйс, шашны хүчин зүйл зэрэгт мэдрэмжтэй, ёс зүйтэй хандах зэргээр илэрнэ. Эдгээрийг хэрэгжүүлэхдээ хүний үндсэн эрхийн баримт бичгүүд, цагдаагийн ёс зүйн дүрэм зэргийг хүндэтгэж, сахин биелүүлэх нь суурь ач холбогдолтой юм.

Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл буюу «Шаардлага тавих» харилцаа нь цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн өдөр тутам, хамгийн түгээмэл хэрэглэж буй тодорхой ажиллагаа юм. Цагдаагийн байгууллагаас энэ тодорхой ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг нарийвчлан гаргадаггүй бөгөөд нийтийн хэв журам хамгаалах болон тээврийн цагдаагийн албаны чиг үүрэг гүйцэтгэж буй нэг алба хаагчийн зүгээс өдөрт дунджаар 30-аас дээш удаа хэрэглэдэг байж болох тооцоолол гарч байна.³¹

Цагдаагийн алба хаагч шаардлага тавих үед иргэд, цагдаагийн алба хаагчийн хооронд зөрчил үүсэх эрсдэл хамгийн өндөр байгаа бөгөөд судалгаанд оролцсон цагдаагийн 1035 алба хаагчийн 884 нь «иргэд бидний үйл ажиллагаанд сөрөг хандлагатай байдаг» гэж, 725 буюу 70 хувь нь «Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас иргэд болон цагдаагийн алба хаагчдын хооронд үл ойлголцол үүсдэг» гэх нэмэлт тайлбар ирүүлсэн байна.³²

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны үндсэн баримт бичиг болох Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам кодоод энэхүү «Шаардлага тавих»-тай холбоотой журмыг код-921 буюу «Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал» гэсэн журамд заасан нийтлэг шаардлагад тусган зохицуулж байна.

Шаардлага тавихтай холбоотой тусгайлан гаргасан үйл ажиллагааны журам байхгүй бөгөөд уг код-921-д цагдаагийн алба хаагчийн хүнтэй харилцах, биеэ авч явах байдлыг дэлгэрэнгүй тусгасан ч «иргэдэд шаардлагатай хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг тайлбарлахаас цааргалах», «тухайн иргэний хувийн байдлыг шууд дүгнэх боломжгүй тул харилцаандаа залхсан, төвөгшөөсөн байдал үзүүлэх»-ийг хориглосон агуулга бүхий нэмэлт оруулах боломж хэвээр байна. Тиймээс ЦБҮАЖ-д иргэдтэй харилцахдаа анхаарах зарим зүйл, заалт нэмж оруулах шаардлагатай гэж судлаачид үзжээ.³³

Цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдол мэдээллийн статистик³⁴-ийг авч үзвэл:

102 тусгай дугаарт 2018 оны 4-р сараас 2021 оны 11-р сар хүртэлх хугацаанд цагдаагийн алба хаагч, түүний үйл ажиллагаатай холбоотой гомдлын шинжтэй 3442 дуудлага, мэдээлэл ирсэн байна. Эдгээр дуудлагын 287 тохиолдол буюу 8.3 хувь нь цагдаагийн алба хаагч, техник хэрэгсэл хохирсонтой холбоотой бол 2450 буюу 71.2 хувийг цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээлэл эзэлж байна.

31 Нээлттэй нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, хэсгийн хэрэгжилт /Судалгааны тайлан/, (УБ, 2022), 36 дахь тал.

32 Мөн тэнд.

33 Мөн тэнд, 40 дэх тал.

34 Хууль зүйн үндэсний хүрээлэнд ЦЕГ-ын Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвөөс ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний 50/11461 дугаартай албан бичиг.

2022 онд Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой 126 дугаарын тусгай утас, Засгийн газрын 11-11 төв болон бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шалгаж шийдвэрлэхэд 515 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн 486 өргөдөл, гомдлын 217 гомдолд алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдсон бол давхардсан тоогоор нийт 515 алба хаагч холбогдон шалгагдсаны 451 буюу 87.6 хувь нь офицер, 64 буюу 12.4 хувь нь ахлагч байна.

Харин 2023 оны 10 дугаар сарын байдлаар иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой 492 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 458-ыг шалган шийдвэрлэснээс 165 гомдолд алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдсон бол хүлээн авсан өргөдөл, гомдолд давхардсан тоогоор нийт 506 алба хаагч холбогдон шалгагдсаны 465 буюу 91.9 хувь нь офицер, 39 буюу 8.1 хувь нь ахлагч байна.

Эдгээр тоон мэдээллээс үзэхэд цагдаагийн алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийн тоо сүүлийн 5 жилд буураагүй үзүүлэлттэй байна. Гомдол, мэдээлэлд холбогдон шалгагдсан алба хаагчдын дийлэнх хувийг офицерууд эзэлж байгаа бөгөөд ахлагчийн тоо ч хангалттай буураагүй байна. Иймд офицер, ахлагч бэлтгэхдээ ёс зүйн сургалтыг анхан шатнаас нь эхлэн заах шаардлагатай байна.

Мөн цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийн хувьд цагдаагийн алба хаагч «хараал хэлсэн», «заналхийлсэн», «сүрдүүлсэн», «хууль бус шаардлага тавьсан», «дарамталсан» гэсэн агуулга бүхий гомдол, мэдээлэл иргэдийн зүгээс давамгайл ирдэг бөгөөд тодорхой аж ахуйн нэгж, албан газар, орон байранд дуудлагаар очих үедээ зүй бус харилцдаг, энгийн хувцас согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ албаны үнэмлэхээ хэрэглэн бусдыг айлгадаг, төвөг уддаг гэсэн тохиолдлууд давамгайлж байна. Энэ нь алба хаагчид иргэдтэй харилцаа тогтоох анхны үе шатанд ёс зүйн шинжтэй зөрчил нийтлэг гаргагдсаар энэ нь цаашлаад хүний эрхийн зөрчил гарах суурь нөхцөл болдог байна.³⁵

Алба хаагчийн хувьд «Шаардлага тавих» тодорхой ажиллагаа нь алба хаагчийн харилцааны соёл, хууль, эрх зүйн мэдлэг чадвар, мэргэжлийн ур чадвараас шууд хамаардаг. Мөн өмнө хийгдсэн зарим судалгаануудад³⁶ алба хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулах шаардлагатай болохыг зөвлөсөн ч хэрэгжилтэд нь ахиц гараагүй, цар тахлын нөхцөлд энэ асуудал орхигдсон, ор нэр төдий болсон, үр дүнд хүрээгүй гэж алба хаагчид өөрсдөө дүгнэжээ.

“Цагдаагийн албаны анхан шатны сургалтын сайн туршлага- сургалтын хөтөлбөр” гарын авлагын эхний бүлэг буюу “Үнэт зүйл ба ёс зүй” гэсэн бүлэгт судалбал зохих хичээлүүдэд нийт 7 чиглэлийн хичээлийн агуулга тусгасныг жагсаавал:

1. Хүний эрх
2. Ардчилсан зарчимт цагдаагийн үйл ажиллагаа
3. Цагдаа болон олон нийтийн түншлэл

35 О.Энххүслэн, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд оролцсон илтгэлийн хэсгээс, (2022).

36 Нээлттэй нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, хэсгийн хэрэгжилт судалгааны тайлан, (2022).

4. Соёлын олон талт байдал
5. Жендэрийн асуудал
6. Цагдаагийн ёс зүй ба Ёс зүйн дүрэм
7. Авлигал зэрэг агуулга багтаж байна.

Цагдаагийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ нь ажил, мэргэжлийн үйл ажиллагааны бүхий л салбарт ёс суртахууны өндөр зарчим, мэргэжлийн стандартыг тууштай баримталж, нэр төртэй, үнэнч шударга байх амлалтуудыг агуулж байдаг. Цагдаагийн алба хаагч нь бусдын ашиг сонирхлыг хэтрүүлэн ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх ёстой ба цагдаагийн байгууллагын стандарт, бодлого, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

“Цагдаагийн ёс зүй ба Ёс зүйн дүрэм” гэсэн хичээлийн агуулгад:

Ёс зүйн дэд бүтэц; мэргэжлийн ёс зүйг баримтлаагүйгээс гарах үр дагавар; хүний хувийн үнэт зүйлсийн тогтолцоо; ухамсар; тэгш, шударга байдал; ил тод байдал - дотоод болон гадаад хяналт; нууцлал; зохих шалгалт; ёс зүйн эрсдэл, түүнийг удирдах арга хэмжээ; ашиг сонирхлын зөрчил; ёс зүйгүй үйлдлүүдийн болзошгүй анхааруулах шинж тэмдэг; хяналтын тогтолцоо; цагдаагийн албыг гутаан доромжлох-хувийн болон мэргэжлийн үр дагавар; өөрийгөө үнэлэх, ухамсарлах; эрх мэдлийн хязгаарлалт; зөрчил гаргагсдыг баривчлах, тэдгээртэй тэмцэх; олон нийтэд хандах хандлага зэрэг сэдвүүдийг гол болгож анхаарч байна.

Ёс зүйн сургалтыг цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах нь зайлшгүй боловч үүнээс гадна цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт мөн тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Анхан шатны болон ахисан түвшний сургалтын үйл ажиллагаанд мэргэжлийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн сэдвийг тогтмол хамруулж байх ёстой.³⁷ Иймд ардчиллын үнэт зүйлс, соёлын олон талт байдал, ялгаварлан гадуурхалтгүй харилцаа зэрэг чиглэлийг хөтөлбөрт тусгадаг олон улсын сайн туршлагыг харгалзан, хүний эрхийн олон улсын гэрээний зарчим, хэм хэмжээнд тулгуурласан агуулгыг сургалтын хөтөлбөрт нэмж, багц цагт тооцох нь зүйтэй.

б. Үйл ажиллагааны үнэт зүйлс ба ёс зүй

Цагдаа бол олон нийтийн аюулгүй байдлыг хариуцдаг төрийн эрх мэдлийн хамгийн тод илрэл бөгөөд эргүүл, замын хөдөлгөөн, олон нийтийн болон хамгаалалтын цагдаагийн алба зэрэг нь тэргүүн эгнээнд иргэдтэй харилцдаг. Тэдний ажил үүргээ гүйцэтгэж буй ур чадвар нь үндэсний цагдаагийн албаны талаарх олон нийтийн эерэг, сөрөг ойлголтыг тодорхойлдог учир ажлын байран дээрх шийдвэр гаргалт, үйлдлүүд нь дээрх үнэт зүйлс, ёс зүйд тулгуурласан зөв дүгнэлтийг агуулсан байхыг шаарддаг. Энэ хэсэгт насанд хүрээгүй хүүхдүүд, хохирогчидтой ажиллах, эмх замбараагүй байдал зэрэг ихэвчлэн эмзэг нөхцөлд, практикт ёс зүй, үнэ цэнд суурилсан шийдвэр гаргах үйл явц хэрхэн илрэх ёстойг судалдаг.

37 О. Энххүслэн, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь”, «Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь» сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд оролцсон илтгэлийн хэсгээс, (2022).

в. Цагдаагаар ажиллах ур чадвар

Цагдаагийн анхан шатны сургалт нь практик ур чадварыг агуулсан байх ёстой. Мэргэжлийн ур чадварын сургалт нь ердийн сорилт, нөхцөл байдалд шууд, зохист хариу арга хэмжээ авахаас гадна онцгой байдлын үед болон стандарт бус нөхцөлд зохих арга хэмжээг авахад бэлтгэдэг.

➤ Үндсэн шаардлага

Цагдаа нар үүргээ гүйцэтгэхийн тулд олон төрлийн үндсэн ур чадварыг эзэмшсэн байх ёстой. Үүнд: техник хэрэгсэл ашиглах, харилцаа холбоо, өөрийгөө удирдах чадвар, галт зэвсгийг зүй зохистой ашиглах зэрэг багтана.

➤ Эргүүл хийх

Урд шугамын цагдаагийн ажилтнууд өдөр тутмын ажлаа гүйцэтгэхийн тулд эргүүл хийх ур чадвар шаарддаг. Үүнд ерөнхий журам, замын хөдөлгөөний хууль, хэрхэн эрэн хайлт хийх, мөн томоохон ослын үед хэрхэн ажиллах талаар гүнзгий мэдлэг орно.

➤ Үндсэн мөрдөн байцаалтын ажиллагаа ба журам

Цагдаагийн алба хаагчаас төвийн болон орон нутгийн цагдаатай холбоотой хууль тогтоомж, холбогдох бодлогын талаар нарийн мэдлэгтэй байхыг шаарддаг. Тэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэс, нотлох баримт цуглуулах талаар нарийн мэдлэгтэй байх ёстой.

➤ Хээрийн сургалт

Хээрийн сургалт нь цагдаагийн анхан шатны сургалтын салшгүй хэсэг бөгөөд үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг юм. Хээрийн сургалт нь дадлагажигчдад танхимаар сурсан мэдлэг, ур чадвараа цагдаагийн бодит ажилд ашиглах боломжийг олгодог.

Бусад сургалтын хувьд цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалтын агуулгад тодорхой хэмжээгээр багтаж байгаа хэдий ч тэдгээр сургалтын агуулга, зорилго зэргийг уг гарын авлагын хүрээнд болон бусад судалгааны эх сурвалжийг ашиглан цаашид дэлгэрүүлж судлах нь зохистой. Энэхүү судалгааны хүрээнд багтсан цагдаагийн албанд тулгамдаж буй бусад асуудалд гол анхаарлаа хандуулах зорилгоор товч дурдсан болно.

1.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын цагдаагийн анхан шатны сургалт

ХБНГУ-ын Бранденбургийн цагдаагийн академийн цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт нь нийт 2 жил 6 сарын хугацаатай 3 шатлалт сургалттай талаар бид өмнө нь авч үзсэн. Сургалт нь агуулгын хувьд дараах 6 модуль бүхий хөтөлбөрөөр явагддаг байна.

Үндсэн модуль:

1. Цагдаагийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс;

2. Цагдаагийн арга техник;
3. Гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн үйл ажиллагаа;
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдал;
5. Нэгдсэн арга хэмжээ/ Иргэдийн нэгдсэн зөвлөгөө;
6. Зааварчилгаа-дагалдах сургалтууд.

Цагдаагийн мэргэжлээр суралцагч нь сургалтын төгсгөлд 3-4 сарын дадлага хийдэг.

Эхний шатанд дараах хичээлийг үзнэ. Үүнд: Үндсэн хуулийн эрх зүй 62 цаг, Захиргааны эрх зүй 208 цаг, Гэмт хэрэг/зөрчлийн тохиолдлууд 134 цаг, Төрийн албаны эрх зүй 46 цаг, Мэргэжлийн ёс зүй 10 цаг, Цагдаагийн түүх 40 цаг, Сургалт явуулах үе шат (танилцах 7 хоног / сурах арга барил) 48 цаг, Номлолын хэрэглээ (нэгдсэн харилцаа/ герман хэл) 126 цаг, Удирдахуйн ухаан 26 цаг, Англи хэл 52 цаг, Нийгмийн ур чадвар 48 цаг, Цагдаагийн зураг авалт 32 цаг, Түгшүүрийн үеийн сургалт 16 цаг, Криминологи/ шүүх эмнэлэг судлал 106 цаг, Хэрэглээний сэтгэл зүй 16 цаг, Мэдээлэл, харилцаа холбооны технологи 96 цаг, Замын хөдөлгөөний эрх зүй 74 цаг, Тээврийн онол 54 цаг, Галт зэвсгийн сургалт 70 цаг, Сэлэлт ба аврах ажиллагаа 32 цаг, Бие хамгаалах/ таслан сэргийлэх ажиллагаа 82 цаг, Биеийн хүчний сургалт 60 цаг, Жолооны сургалт 30 цаг.³⁸

Хоёрдугаар шатанд: Захиргааны эрх зүй 76 цаг, Гэмт хэрэг/зөрчлийн тохиолдлууд 32 цаг, Мэргэжлийн ёс зүй 18 цаг, Номлолын хэрэглээ (нэгдсэн харилцаа/ герман хэл) 75 цаг, Англи хэл 48 цаг, Нийгмийн ур чадвар 24 цаг, Криминологи/ шүүх эмнэлэг судлал 62 цаг, Хэрэглээний сэтгэл зүй 10 цаг, Мэдээлэл, харилцаа холбооны технологи 24 цаг, Замын хөдөлгөөний эрх зүй 36 цаг, Тээврийн онол 38 цаг, Галт зэвсгийн сургалт 24 цаг, Бие хамгаалах/ таслан сэргийлэх ажиллагаа 42 цаг, Биеийн хүчний сургалт 40 цаг, Жолоо барих болон аюулгүй байдлын сургалт 30 цаг, Анхны тусламж 21 цаг.³⁹

Гуравдугаар шатанд: Үндсэн хуулийн эрх зүй 10 цаг, Захиргааны эрх зүй 72 цаг, Гэмт хэрэг/зөрчлийн тохиолдлууд 42 цаг, Номлолын хэрэглээ (нэгдсэн харилцаа/ герман хэл) 60 цаг, Англи хэл 48 цаг, Нийгмийн ур чадвар 24 цаг, Практикийн сургалт «анхан шатны хэрэглээ» 40 цаг, Практикийн сургалт «хаалттай нэгж» 80 цаг, Криминологи/ шүүх эмнэлэг судлал 110 цаг, Криминологи 36 цаг, Хэрэглээний сэтгэл зүй 12 цаг, Мэдээлэл, харилцаа холбооны технологи 12 цаг, Замын хөдөлгөөний эрх зүй 52 цаг, Тээврийн онол 25 цаг, Галт зэвсгийн сургалт 30 цаг, Бие хамгаалах/ таслан сэргийлэх ажиллагаа 38 цаг, Биеийн хүчний сургалт 24 цаг буюу 3 шатны нийт 2861 цагийн сургалт байна.⁴⁰

Чанарын хяналтыг Бранденбургийн цагдаагийн академийн Ерөнхийлөгчийн дэргэдэх чанарын тусгай төв хэрэгжүүлдэг. Жил бүр оюутнууд нэрээ нууцлан хөтөлбөрийн талаарх судалгаа, санал асуулгад хамрагддаг. Хөтөлбөрийг тус сургуулийн багш нар боловсруулж яам баталдаг. Сургуулиа төгсөөд цагдаагийн алба хаагчид “Цагдаагийн алба” (дунд шатны удирдлага) мэргэжлээр диплом авна.

38 Police education and training systems in the OSCE region, 2018, pp. 105-118, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

39 Мөн тэнд.

40 Police education and training systems in the OSCE region, 2018, pp. 105-118, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

Онолын сургалт нь цагдаагийн байгууллагад явагдах бөгөөд салбар дундын болон практикт чиглэсэн сэдвээр хийгддэг. Дадлагын ажлыг Дотоод хэргийн яамнаас Бранденбургийн тодорхой сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Сургалт нь мэргэшүүлэх/төрөлжсөн, онол, практик гэсэн гурван хэсэгтэй.

1.3.2. Польш Улсын цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт

“Szczytno” цагдаагийн академи (WSPOL)-ийн сургалтын жишээг авч үзэв. Үүнд үндсэн сургалт зургаан сар үргэлжлэх бөгөөд энгийн иргэд заавал хамрагдах ёстой. Оюутнууд анхан шатны сургалтад хамрагдсаны дараа дасан зохицох (туршилтын) хугацаанд 38 ээлжээр (ойролцоогоор хоёр сар), цагдаагийн газарт тодорхой хяналтан дор ажилладаг.⁴¹

Бүх суралцагчид зориулсан үндсэн сургалт 124 хоног (зургаан сар) үргэлжилнэ. Үндсэн сургалтын 10 модуль байдаг:⁴²

1. Эрүүгийн ерөнхий хууль, цагдаагийн хууль тогтоомж – 127 цаг. Эрүүгийн хууль болон гэмт хэрэгтэн этгээдийн эрхийг судлах. Хэргийн газар, хэргийн газрын үзлэг, гэрчийн мэдүүлэг авах, цагдаагийн мэргэжлийн ёс зүй, хүний эрх;

2. Аюулгүй ажиллагааг явуулах, цагдаагийн үүрэг гүйцэтгэх, таслан сэргийлэх ажиллагаа – 326 цаг. Цагдаагийн зэвсэг, радио холбоо ашиглах. Хүн таних ажиллагаа, Шууд албадлага, галт зэвсэг хэрэглэх, Анхны тусламж, Нэгжлэг хийх. таслан сэргийлэх, эргүүл хийх журам;

3. Тагнуулын үйл ажиллагааны болон захиргааны хуулиар хүн, эд зүйлийг эрэн хайх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх – 89 цаг. Цагдаагийн мэдээллийн системийг ашиглах, Илрүүлсэн хүмүүстэй харьцах, Эрүүгийн тагнуул/мэдээлэл цуглуулах, Тайлагнах, баримтжуулах, Шенгений Aquis хөтөлбөр ашиглах, Техникийн аргууд;

4. Баривчлагдсан этгээдийн байр болон дүрвэгсдийн цуваанд ажиллах – 20 цаг, Замчлах/хамгаалах үйлчилгээ үзүүлэх, Баривчлагдсан этгээдэд авах арга хэмжээ.

5. Замын хөдөлгөөний дүрэм, журам – 61 цаг. Замын хөдөлгөөний үндсэн дүрэм, Зам дээрх ажиллагаа, Баримт бичиг, протокол, Ослын газар. Согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүстэй харьцах, Замын хяналт, тээврийн хэрэгсэлтэй холбоотой үндсэн үйл ажиллагаа;

6. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа – 50 цаг. Зөрчлийн хэрэг, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Заавал явуулах ажиллагаа, Тайлбарлах ажиллагаа. Байцаалт;

7. Нийтийн хэв журам хамгаалах – 52 цаг. Дүрэм журам. Олон нийтийн арга хэмжээний үеэр хямралын менежмент.Тактик;

41 Мөн тэнд.

42 Мөн тэнд.

8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (олон нийтийн цагдаа) – 13 цаг. Нийгмийн эмгэг судлал, Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт;

9. Буудлага – 98 цаг. Аюулгүй байдлын арга хэмжээ. Шуурхай, динамик нөхцөл байдлын буудлага. Пулемёт, винтовын хэрэглээ;

10. Хүч хэрэглэх, хөндлөнгөөс оролцох тактик – 132 цаг. Үндсэн моторт ур чадвар. Өөрийгөө хамгаалах элементүүд ба тактикийн арга хэмжээ. Саад тавих. Цагдаагийн бусад довтолгооны арга хэрэгсэл ашиглах. Хүмүүстэй харилцах.

Мэргэжлийн анхан шатны сургалтын хөтөлбөр нь урьдчилан сэргийлэх алба, эргүүлийн хамгаалалтын зохион байгуулалтын нэгж, цагдаагийн урьдчилан сэргийлэх нэгжид цагдаагийн алба хаагчийг (онол болон практикийн хувьд) анхан шатны түвшинд бэлтгэдэг.

1.4. Төгсөлтийн дараах үргэлжилсэн, мэргэшүүлэх сургалт

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар Цагдаагийн албаны сургалтын байгууллага буюу аймаг, нийслэлийн бүсчилсэн сургалтын төвөөр дамжуулан цагдаагийн алба хаагч, ажилтныг мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтад хамруулдаг. Мөн энэ төв нь албаны нохой ашиглах сургалт, Галт зэвсгийн тухай хуулийн 10.4-т заасан иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт болон гэрээт харуул хамгаалалтын сургалтыг төлбөртэй зохион байгуулахаас гадна шийтгэл хүлээсэн алба хаагчийн хамрагдах ёс зүйн сургалтыг цагдаагийн төв байгууллагын даргын баталсан үнэлгээний дагуу төлбөртэй явуулдаг.

Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, иргэний төлөөлөл бүхий орон тооны бус Иргэний зөвлөл ажилладаг. Энэхүү зөвлөл нь цагдаагийн алба хаагчийн сургалт болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хүний эрхийн сургагч багшийн давтан сургалт болон хүний эрх, харилцаа хандлага, ёс зүйн цахим сургалтуудыг орохоор тусгажээ. Мөн Цагдаагийн алба хаагчийн 2023 оны үргэлжилсэн сургалтын төлөвлөгөөнд Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, хувийн соёл, анхаарах асуудал, Бие хүний хоорондын харилцаа ба ёс зүй, мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн өөрчлөлт болон Хүний эрхийн тухай ойлголт, үндсэн зарчим /Цагдаагийн алба хаагч үүргээ гүйцэтгэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангахад анхаарах асуудал/, Жендерийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхий тухай ойлголтын үзэл баримтлал зэрэг хүний эрхэд чиглэсэн хичээл орохоор тусгасан нь сайн талтай байна.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (ОЕСД)-аас хийсэн “Зүүн Европ, Төв Ази, Ази Номхон далайн улсуудын прокурорын бие даасан байдал” судалгааны тайланд алба хаагчийн бие даасан байдлын шалгуур үзүүлэлтийг гаргасан байна. Тус судалгааны хүрээнд цагдаа, мөрдөгчид холбогдох бие даасан

байдлын шалгуур үзүүлэлтүүдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект, хууль сахиулагч болохын хувьд прокурорынхтой төсөөтэй байдлаар авч үзье. Үүнд зааснаар цагдаагийн алба хаагч нь мэргэшсэн чиглэлээрээ анхан шатны болон байнгын тасралтгүй сургалтад хамрагдах эрх, үүрэгтэй бөгөөд мөн цагдаагийн албан хаагчид орох сургалтын хөтөлбөр, стандартыг тодорхойлоход хөндлөнгийн болон шинжилгээний байгууллага оролцох ёстой бөгөөд цагдаа бэлтгэх сургалтанд цагдаагийн бие даасан байдлыг хамарсан агуулгыг тусгасан байх ёстой байна. 2023 оны сургалтын төлөвлөгөөнд бие даасан байдлын талаар тодорхой хичээл, сургалт байгаагүй ч бусад хичээлийн агуулгад нэмэлт маягаар оруулах нь зохистой гэж үзэж байна.

Хууль сахиулахын их сургууль /одоогийн ДХИС/-аас Цагдаагийн сургуулийн хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор 2017 онд сургалтын хөтөлбөрийн талаарх ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа хийжээ. Үүний дагуу Нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн 101 удирдах албан тушаалтнаас ажил олгогчдын Цагдаагийн сургуулийн төгсөгчдийн мэдлэг, ур чадварын түвшин, шаардагдаж буй дадал, чадварын талаар 18 асуулга бүхий төгсөгчийн судалгааны фокус бүлгийн ярилцлагаар төгсөгчдийн бие даан ажиллах чадвар дунд зэрэг буюу 54 хувь, бичих ур чадвар хамгийн муу буюу 16 хувь нь, ерөнхий мэдлэг, ур чадварыг дунд зэрэг гэж 63 хувь нь хариулсан байна.⁴³ Үүнээс үзэхэд цагдаагийн шинэ төгсөгчдөд ажлын байранд гарахад бичих ур чадвар, бие даан ажиллах чадварууд ихээхэн шаардагддаг ч төгсөгчдийн эдгээр чадвар нь хангалттай хөгжөөгүй байгааг харуулж байна. Иймээс цагдаагийн алба хаагчдад бичих ур чадвар, тайлагнах, судалгаа хийх зэрэг чадваруудыг хөгжүүлсэн хэл зүйн сургалтуудыг орох шаардлагатай гэж дүгнэв.

1.4.1. Эстонийн Аюулгүй байдлын шинжлэх ухааны академи⁴⁴

Эстонийн Аюулгүй байдлын шинжлэх ухааны академи (EASS) нь Эстони дахь цорын ганц цагдаагийн боловсролын байгууллага юм. Эстонийн дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагуудын чанарын агентлагаас Академийн бүх сургалтын хөтөлбөрийг Эстони улсын үндэсний чанарын хамгийн дээд тэмдгээр шагнасан байна.

Цагдаагийн үргэлжилсэн сургалтыг тус Академийн Үргэлжилсэн сургалтын төв зохион байгуулдаг. Энэ төв нь түнш байгууллагууддаа тусгайлан зориулсан буюу байгууллагын шаардлагад (цагдаа, онцгой байдал гэх мэт) нийцүүлсэн сургалтуудын хөтөлбөр санал болгодог.

Цагдаагийн алба хаагч бүрийн жил бүр заавал хамрагдах ёстой бие бялдрын сургалтууд байдаг. Цагдаагийн алба хаагчийн хамрагдах ёстой сургалтын хэмжээ нь ажлын онцлогоос хамаарна. Гадуур ажилладаг цагдаа нар жилдээ буудлагын нэг, бие хамгаалалтын хоёр сургалтад хамрагдах ёстой. Харин оффист ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид зөвхөн бие хамгаалах нэг сургалт, буудлагын нэг сургалтад л хамрагддаг. Мөн цагдаагийн бүх алба хаагч жил бүр бие бялдрын шалгалт өгөх шаардлагатай. Бүх цагдаагийн алба хаагч жил бүр оролцох ёстой биеийн хүчний бус тусгай сургалт байхгүй ч зарим тусгай ажлын байранд ийм

43 ХСИХ-ын Цагдаагийн сургуулийн сургалтын хөтөлбөрийн талаарх ажил олгогч, төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, 2017, 5 дах тал.

44 The Estonian Academy of Security Sciences, Холбооц: https://www.sisekaitse.ee/en/estonian-academy-security-sciences?language_content_entity=en, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

төрлийн сургалт хийж болно. Хэрэв офицер тушаал дэвшихээр бол шаардлагатай тусгай сургалтад хамрагдах ёстой.

1.4.2. Хорват Улсын Цагдаагийн академи⁴⁵

Хорват Улсын Цагдаагийн академи нь Мэргэжил дээшлүүлэх үргэлжилсэн сургалт, мэргэшүүлэх сургалт болон дадлагажуулах сургалтууд явуулдаг.

Мэргэшүүлэх сургалт (specialized training) нь цагдаагийн аль нэг мэргэжлээр (цагдаа, хилийн цагдаа, эрүүгийн мөрдөгч) мэргэшиж ажиллахад шаардлагатай мэдлэг, зөвшөөрлийг олгодог бөгөөд ажлын нарийн төвөгтэй байдлаас хамааран хэд хоногоос зургаан сар хүртэл үргэлжилдэг.

Мэргэжил дээшлүүлэх сургалт (professional development) нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх зорилготой цагдаагийн алба хаагчдын байнгын сургалт бөгөөд семинар, эрдэм шинжилгээний хурал, лекц, дахин мэргэжил дээшлүүлэх болон, сургагч багшийг бэлтгэх цагдаагийн сургалт зэрэг хэлбэрээр явагддаг.

Мэргэшүүлэх болон дадлагажуулах сургалт (in-service training) нь Дотоод хэргийн яамны зорилго, зорилтоос хамаардаг. Энэ ангиллын сургалтыг Дотоод хэргийн сайдын баталсан жилийн төлөвлөгөөнд яам, Цагдаагийн газрын хэрэгцээ, шаардлага, зорилттой уялдуулан тусгана.

Сүүлийн жилүүд дэх дадлагажуулах сургалтын гол агуулга нь

- Хилийн цагдаа;
- Гэмт хэргийн техник;
- Олон нийтийн цагдаа;
- Замын хөдөлгөөний зохицуулалт;
- Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүд;
- Олон нийтийн цагдаагийн офицерын тусгай сургалт;
- Гэр бүлийн хүчирхийлэл зэрэг агуулгын хүрээнд байсан байна.⁴⁶

1.4.3. Монтенегро Улсын Цагдаагийн академи⁴⁷

Монтенегро улсад цагдаагийн сургалтыг нэгдсэн байдлаар явуулдаг байгууллага нь Монтенегро улсын Цагдаагийн академи байна. Мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтыг Боловсролын яам, Дотоод хэргийн яамнаас жил бүр баталсан хөтөлбөрт үндэслэн хэрэгжүүлдэг.

Цагдаагийн байгууллагын дадлагажуулах сургалтын үндсэн чиглэл нь:

- Зохион байгуулалттай гэмт хэрэг;
- Кибер гэмт хэрэг;

45 Education for police officers, Холбоос: <https://gov.hr/en/education-for-police-officers/1044>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

46 Police education and training systems in the osce region, 2018, pp. 125-131, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

47 Montenegro, Холбоос: <https://polis.osce.org/country-profiles/montenegro>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

- Үй олноор хөнөөх зэвсгийн тархалтаас урьдчилан сэргийлэх;
- Зөрчилдөөнийг зохицуулах нөхцөл байдал;
- Гэр бүлийн хүчирхийлэл;
- Эрсдэл ихтэй цуглааны аюулгүй байдал;
- Хүний эрх гэх мэт.

Жилд ойролцоогоор цагдаагийн алба хаагчболон цагдаагийн бусад албан хаагчдад 60-70 орчим төрлийн сургалт явуулахаар төлөвлөдөг байна. Эрүүгийн эрх зүй болон хилийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр агуулгыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг. Цагдаагийн академи нь алба хаагчдад англи хэлний сургалт явуулдаг бөгөөд энэ нь шинэчлэлийн чадавхыг дээшлүүлж, цагдаагийн алба хаагчдыг олон улсын сүлжээний нэг хэсэг болгох боломж олгодог байна.

1.4.4. ХБНГУ-ын Бранденбургийн цагдаагийн академи

ХБНГУ-ын Бранденбургийн цагдаагийн академи нь анхан шатны сургалтаас гадна дадлагажуулах сургалт явуулдаг. Дадлагажуулах сургалт нь бүс нутгийн цагдаагийн дарга нар, цагдаагийн ажилтнуудын шилжилт хөдөлгөөнөөс ихээхэн хамаардаг. Бранденбургийн их сургуулийн бүсийн төвүүд дадлагажуулах сургалт явуулдаг.

Заавал хамрагдах дадлагажуулах сургалтад:

- Кибер гэмт хэрэг;
- Мөрдөн байцаалт;
- Байцаалтын арга техник;
- Замын хөдөлгөөний дүрэм;
- Бие хамгаалах;
- Хээрийн сургалт;
- IT технологи;
- Галт зэвсгийн техник,
- Буудлага
- Манлайлал зэрэг хичээлүүд багтдаг.⁴⁸

Мөн байгууллагын хүсэлтийн дагуу дадлагажуулах сургалт явуулахаас гадна цагдаагийн байгууллагын өдөр тутмын ажилтай холбоотой тогтмол мэргэжил дээшлүүлэх сургалтууд байдаг. Бранденбургийн цагдаагийн эрх зүйн коллеж нь цагдаатай холбоотой судалгаа, холбогдох арга зүйн үйл ажиллагааг FHPol-ийн эрхэм зорилгын нэг гэж тодорхой заажээ.

1.4.5. Америкийн Нэгдсэн Улсын цагдаагийн академи

АНУ-д цагдаагийн академиас дадлагажуулах хөтөлбөрүүд санал болгодог. Сургалтынхуваарь, хичээлийн тодорхойлолт, зардлыг нийтлэх замаар дадлагажуулах хөтөлбөр зарлагддаг. Хэдийгээр дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах нь сайн дурын үндсэн дээр байдаг ч офицеруудыг аль болох олон сургалтанд хамрагдахыг

⁴⁸ Police education and training systems in the osce region, 2018, pp. 105-118, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

зөвлөдөг байна. Заримдаа цагдаагийн хэлтсүүд нь тодорхой үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд тусгай сургалтад хамрагдсан байхыг шаарддаг. Цаашилбал, офицер зарим үүргээ биелүүлээгүй тохиолдолд дадлагажуулах сургалтад хамрагдах үүрэгтэй. Нөгөөтэйгүүр, АНУ-д мөрдөгч, техникийн ослын мөрдөн байцаагч, тусгай хариу арга хэмжээ авах багийн гишүүд зэрэг тусгай боловсон хүчнийг сургахад зориулсан тусгай сургалтын хөтөлбөрүүд мөн байдаг.⁴⁹

1.4.6. Турк Улсын үндэсний цагдаагийн газар

Турк Улсад Үндэсний цагдаагийн газрын Сургалт, боловсролын хэлтсээс гадна бусад хэлтсийнтодорхой нэгжүүд мэргэжил дээшлүүлэх/дадлагажуулах сургалт явуулдаг. Тухайлбал, Нийтийн хэв журам хамгаалах газрын Эрүүгийн мөрдөн байцаах, судалгаа, сургалтын төв (SASEM) болон Туркийн Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын академи (TADOC) нь сургалт, судалгааны тэргүүлэх байгууллагуудын нэг юм. Сургалт, боловсролын хэлтсээс жил бүр сургалтын хөтөлбөрийг гаргадаг. Офицерууд ямар ч сургалтад хамрагдах боломжтой. Сургалт, боловсролын хэлтсийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн цагдаагийн хэлтсүүд мөн хэлтсийн хэрэгцээ шаардлагад үндэслэн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж болно. Гэсэн хэдий ч эрэлт хэрэгцээ их байдаг учир бүх сургалтыг хүн бүрд орох боломжгүй байдаг. Дунджаар нийт цагдаагийн тавны нэг нь Туркийн үндэсний цагдаагийн газарт мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах боломжтой. Тэнхимийн хэрэгцээнд тулгуурлан мэргэшүүлэх сургалтуудыг хүссэн үедээ зохион байгуулж, санал болгож болно. Үүнтэй холбогдуулан Туркийн Үндэсний цагдаагийн газар АНУ-тай маш төстэй төрөлжсөн сургалттай гэж хэлж болно.⁵⁰

Дээрх сонгон судалсан 6 орны 5-д нь цагдаагийн академи анхан шатны мэргэжлийн сургалт, бакалавр, магистрын дээд боловсролын сургалтаас гадна цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн буюу дадлагажуулах сургалт болон мэргэшүүлэх зэрэг бусад сургалтыг хамтад нь орж байна. Харин Турк Улсын Үндэсний цагдаагийн газрын Сургалт, боловсролын хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах газрын Эрүүгийн мөрдөн байцаах, судалгаа, сургалтын төв болон Туркийн Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын академи зэрэг нь Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын холбогдох бусад сургалтын нэгжүүдтэй адил цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн, дадлагажуулах зэрэг сургалтыг орж байна.

Сургалтын агуулгын хувьд шинэ нөхцөл байдал, алба хаагчийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн жил бүр өөр агуулгаар сургалтыг зохион байгуулах боломжтой байна. Нийтлэг байдлаар авч үзвэл кибер гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг сэдвүүд дадлагажуулах сургалтад түгээмэл байгаа бөгөөд Монтенегро улсад хүний эрхийн сургалт ордог нь давуу талтай юм.

49 A_Comparative Study of the Police Training in the United States United Kingdom and Turkey, p.18, Холбоос: https://www.academia.edu/12541123/A_Comparative_Study_of_the_Police_Training_in_the_United_States_United_Kingdom_and_Turkey, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

50 Мөн тэнд.

Явцын дүгнэлт

Улс орнуудын цагдаагийн байгууллагын нийтлэг зорилго нь нийгмийн аюулгүй, амар тайван байдлыг хамгаалах, түүнд үйлчлэх явдал юм. Гэсэн хэдий ч үйл ажиллагаа явуулах арга барил нь тодорхой шалтгааны улмаас өөр байж болно. Цагдаагийн алба хаагчийн сургалт нь цагдаагийн байгууллагын чиг үүрэг хэрхэн хэрэгжихийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг юм.

Монгол Улсад цагдаагийн алба хаагчийг сургах боловсрол, сургалтын тогтолцоог онцгой анхаарч Засгийн газраас үе шаттайгаар, тасралтгүй хөгжүүлэхээр бодлогын баримт бичгүүдэд тусгаж ирсэн ч хэрэгжилт хангалтгүй, сургалтын нэгдсэн тогтолцоог оновчтой тодорхойлоогүй байна.

Холбогдох журмууд хоорондоо зөрчилтэйн улмаас тэдгээрийг дагалдуулж баталсан сургалтын хөтөлбөрүүд оновчгүй бөгөөд Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох журмаар тодорхойлоогүй сургалтын төрлүүдийг нэмж тусгасан, ЦАТХ-д заасан сургалтын төрлийг дагаж мөрдөөгүй зэргийг анхаарах шаардлагатай. Мөн холбогдох журмуудад чадавхжуулах, ур чадварын, мэдлэг, ур чадварын, мэргэшүүлэх, давтан, үргэлжилсэн, ажлын байрны, ажлын байран дахь албаны, ажлын байран дээрх албаны, албаны сургалт зэрэг хоорондоо авцалдаагүй, олон төрлийн сургалтыг тусгасан нь сургалтууд харилцан уялдаагүй байх, давхцах, хийдэл гарах зэрэг асуудлыг үүсгэжээ. Харин энэхүү судалгаанд хамрагдсан гадаад орнуудад цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо харьцангуй тогтсон хандлагатай, бүтэц, нэр томьёо, хөтөлбөр, агуулга тодорхой байгаа бөгөөд мэргэшүүлэх, дадлагажуулах, үргэлжилсэн зэрэг сургалтын тодорхой төрлийг тогтмол хэрэгжүүлж байна.

Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх журам болох 118 дугаар журамд нэлээд их алдаа, дутагдал илэрсэн. Тухайлбал, хүчингүй болсон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг эш татан зохицуулсан байна. Мөн “Цагдаа-мэргэжлийн дээд боловсролын сургалт” гэсэн хуульд заагаагүй нэр томьёо хэрэглэснээс гадна “Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт”-гэсэн ойлголтоос ялгахад хүндрэл үүсгэж байна. Эдгээр журам, хөтөлбөрт заасан сургалтууд болон хөтөлбөр, төлөвлөгөөний нэршлийг мөн Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэх эсхүл зохистой байдлаар шинэчлэн тусгахад анхаарах шаардлагатай юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам болох 118, 239 дүгээр журам зэргийг хангалттай шинэчилж, боловсронгуй болгоогүй байна. Тухайлбал, Сургалтын бодлого, боловсруулж хэрэгжүүлэх 118 дугаар журмыг 2022 онд шинэчлэн баталсан боловч Цагдаагийн ерөнхий газрын нэгжийн өөрчлөлттэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг өнөө хүртэл оруулаагүй байв. Үүний улмаас ЦЕГ-ын аль хэлтэс, нэгж ямар чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгаа нь тодорхой бус болсон.

Мөн цагдаагийн алба хаагчдын ёс зүйн асуудал иргэдээс ирж буй гомдол, мэдээллийн дийлэнх хувийг эзэлж байгаа нь албаны сургалтаар ёс зүйн сургалт орж байгаа хэдий ч үр дүнд хүрээгүй бөгөөд ёс зүйн асуудал чухал хэвээр байгаагийн илрэл юм. Ёс зүйн сургалтыг цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах нь зайлшгүй боловч үүнээс гадна цагдаагийн

мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт мөн тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Цагдаагийн анхан шатны сургалтад ардчиллын үнэт зүйлс, соёлын олон талт байдал, ялгаварлан гадуурхалтгүй харилцаа зэрэг чиглэлийг хөтөлбөрт тусгадаг олон улсын дурдсан сайн туршлагыг харгалзан, хүний эрхийн олон улсын гэрээний зарчим, хэм хэмжээнд тулгуурласан агуулгыг Монгол Улсын цагдаагийн анхан шатны сургалтад багтаах нь зүйтэй.

Монгол Улсын тухайд иргэд 1 сарын сургалтад хамрагдсанаар цагдаагийн албаны үйл ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэх эрхтэй болж байгаа нь сонгон судалсан улс орнуудын цагдаагийн сургалтын байгууллагад хэрэгжиж буй цагдаагийн анхан шатны сургалттай харьцуулахад хэт богино хугацаатай байгааг зайлшгүй анхаарах шаардлагатай.

Харин цагдаагийн алба хаагчийн төгсөлтийн дараах сургалтын тухайд, сонгон судалсан орнуудын дийлэнх нь цагдаагийн боловсролын асуудал хариуцдаг тусгай академид хариуцуулж сургалтуудыг бүхэлд нь зохион байгуулдаг бол Турк Улсын Үндэсний цагдаагийн газрын болон Австри улсын Цагдаагийн байгууллагын тусгай хэлтсүүд зарим төрлийн үргэлжилсэн сургалтыг хариуцдаг нь Монгол Улсын сургалтын тогтолцоотой төсөөтэй байна гэж үзэв.

Санал

Энэхүү бүлгийн дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчийн сургалттай холбоотой 118, 239, А/211, 951 дүгээр журам зэрэг холбогдох журмууд хоорондын нийцлийг хангах, гадаад орнуудын туршлага, жишгийг баримтлан сургалтын төрлүүдийг нэгтгэж боловсронгуй болгох, Сургалтуудыг төлөвлөхдөө холбогдох журамд заасан нэр томьёо, ангилалд нийцүүлэх, холбогдох журмыг Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлж шинэчлэх;
2. Мэргэшүүлэх сургалтыг холбогдох журмууд болон хөтөлбөртөө тусгайлан тусгасан байгаа хэдий ч гадаад орнуудын жишгийг харгалзан дотоодын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн үндсэн сургалтын төрөл болгож хуульчлах;
3. Хууль тогтоомжид заасан сургалтын нэршил болон төрлүүдийг тусгаж сургалтын хөтөлбөр батлах, журамд тусгаагүй сургалтыг хөтөлбөрт тусгахаас зайлсхийх;
4. Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх тухай 118 дугаар журамд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хүчингүй болсон хууль эш татсан байгааг өөрчилж, хүчин төгөлдөр үйлчилж буй “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай” хуулийг үндэслэх;
5. “Цагдаа-мэргэжлийн дээд боловсролын сургалт” гэсэн нэр томьёог Боловсролын ерөнхий хуулийн 3.1.18-д заасны дагуу “Цагдаагийн дээд боловсролын сургалт” гэж томьёолох;
6. Төлөвлөгөө, журмуудад заасан “Цагдаа-мэргэжил олгох сургалт” болон “Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт” зэрэг нэр томьёог нэгтгэж жигдлэх;
7. Журмын 118.9.3.б-д заасан хэл, найруулга зүйн алдаатай бичвэрийг засах, мөн зүйлд тусгасан зөвлөл нь уг зүйлийн д болон з-д заасан чиглэлээр

- хийсэн ажлууд, сургалтын тайланд хийсэн дүн шинжилгээ, аргачлал, зөвлөмж зэргийг олон нийтэд сурталчлан таниулах;
8. Цөөн хүн амтай манай улсад цагдаагийн албаны сургалт явуулах чиг үүрэг бүхий төсөөтэй хэд хэдэн сургалтын байгууллага байгаа нь хүний нөөцийн үр ашиггүй зардал гаргахаас гадна сургалтын нэгдмэл бус, хэврэг тогтолцоог бий болгож байж болзошгүй байгааг анхаарч, харьцуулсан судалгааны хүрээнд авч үзсэн улс орнууд шиг цагдаагийн боловсрол эзэмшүүлдэг их сургууль, академид цагдаагийн сургалтын чиг үүргийг төвлөрүүлж, үр ашиггүй зардлаас зайлсхийх;
 9. ЦБҮАЖ-ын 118.7.3.д-д заасан ёс зүйн сургалт нь зөвхөн зөрчил гаргасан алба хаагчдын хамрагдах сургалт байхаар ойлгогдож байх тул бүх алба хаагчдын ёс зүйн сургалтыг үндсэн төрлийн сургалт болгон журамлах, цагдаагийн анхан шатны боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах;
 10. Монгол Улсын цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт олгох хугацаа, багц цагийг нэмэгдүүлэх;
 11. Гомдол, мэдээлэлд холбогдон шалгагдсан алба хаагчдын дийлэнх хувийг офицерүүд эзэлж байгаа ч ахлагчдын тоо хангалттай буураагүй байна. Иймд офицер, ахлагч бэлтгэх сургалтын хөтөлбөрт ёс зүйн сургалтыг анхан шатнаас нь эхлэн орохоор тусгах;
 12. Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн судалгааны нэгдсэн төв болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн үйл ажиллагааг уялдуулж бүтцийн хувьд нэгтгэх арга хэмжээ авах, ДХИС-ийн сургалтын чиг үүрэгтэй уялдуулж зохион байгуулалт хийх;
 13. Сургалтын агуулгад цагдаагийн алба хаагчийн бие даасан байдал болон монгол хэлний найруулга зүй, бичгийн ур чадварыг дээшлүүлэх хэл зүйн сургалтуудыг багтаах.

II. ЦАГДААГИЙН АЛБАНЫ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Судалгааны энэ бүлэгт Монгол Улсын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын эрх зүйн байдал, бүтэц, иргэдээс ирүүлсэн гомдол болон гадаадын зарим улсын холбогдох байгууллагын бүтцийн талаар судаллаа.

Цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх систем⁵¹

Олон улсад цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх таван төрлийн систем байдаг. Үүнд:

Хүснэгт 4.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх систем

№	Системийн төрөл	Тайлбар
1.	Цагдаагийн байгууллагын дотоод хяналт	Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын систем нь цагдаагийн байгууллагад харьяалагддаг, дотооддоо хяналт шалгалт явуулж шийдвэр гаргадаг. Гэвч энэхүү системийг үр дүн муутай, хүний эрхийн хэм хэмжээнд нийцэхгүй, ардчилсан бус, олон нийтийн итгэлийг төрүүлдэггүй, үр дүнгүй арга гэж шүүмжилдэг.
2.	Яамны харьяа цагдаагийн гомдол шалгах байгууллага	Яамны харьяа байгууллага гомдлыг шийдвэрлэх нь хараат бус байдлыг бий болгож байгаа боловч нэг салбарын шаталсан бүтэц гэдэг утгаараа 1 дэх системийн адил үр дүнгүй арга гэх шүүмжлэлд өртдөг байна.
3.	Улсын прокурорын дэргэдэх хянан шалгах байгууллага	Прокурорын байгууллагын дэргэдэх цагдаагийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг хянан шалгах, яллах бүрэн эрхтэй байгууллага юм. Гэхдээ зөвхөн эрүүгийн гэмт хэрэгт холбогдох гомдлыг шийдвэрлэх эрхтэй.
4.	Омбудсмен	Омбудсмен байгууллага нь төрийн алба хаагчдын эсрэг гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэдэг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, эрх бүхий байгууллага юм. Бие даан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаггүй ба гомдол гаргагч, мөрдөн байцаагч хоёрыг холбож зуучлах үүргийг гүйцэтгэдэг. Гэвч цагдаагийн алба хаагчийн эсрэг гаргасан олон тооны өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзэх нь бий.
5.	Иргэдийн хяналт шалгалт	Цагдаагийн алба хаагчийг цагдаагийн алба хаагч бус хөндлөнгийн этгээд болох иргэдээр шалгуулах маш энгийн шалгууртай, хараат бус систем юм. Гомдолтой холбогдуулан хийсэн цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааг хянах, бие даан мөрдөн шалгах ажиллагаа явуулах зэрэг эрхтэй байдаг.

Монгол Улсын хувьд нэг дэх систем буюу цагдаагийн байгууллагын дотоод хяналтын системийг ашигладаг. Үүнийг дэлгэрүүлж авч үзье.

2.1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын дотоод хяналт-аюулгүй байдлын эрх зүйн үндэс

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг

51 Graham Smith. International police complaints reform, Холбоос: <https://rm.coe.int/16806dbbbd>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.⁵² Мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 14.1.3 болон Долдугаар, Аравдугаар бүлгүүдэд тус тус зааснаар цагдаагийн байгууллагын дотоод хяналтын эрх зүйн үндсийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналт;
- Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга зөвхөн хуульд тусгайлан эрх олгосон асуудлаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Цагдаагийн байгууллагын дотоод хяналтыг цагдаагийн төв байгууллагын дарга хэрэгжүүлэх;
- Цагдаагийн байгууллага, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа, шийдвэрээс хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж иргэн, албан тушаалтан үзвэл дотоод хяналт-аюулгүй байдал хариуцсан нэгж болон прокурор, шүүхэд гомдол гаргах.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хяналтын эрх зүйн үндсийг бусад хуульд тусгасан байдлыг мөн авч үзье⁵³.

Засгийн газрын хяналтын тухай хуулийн 3.1-д “яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан /цаашид «байгууллага, албан тушаалтан» гэх/, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахаар заажээ. Ингэхдээ “...цагдаагийн байгууллагын энэ хуулийн 3.2.3-т⁵⁴ зааснаас бусад үйл ажиллагаанд” энэхүү хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн хуулийн 5.1-д зааснаар тус хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтны дараах үйл ажиллагаанд хяналт тавихаар тодорхойлжээ. Үүнд:

- 5.1.1. хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- 5.1.2. албаны чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- 5.1.3. хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа;
- 5.1.4. дотоод хяналтын үйл ажиллагаа;
- 5.1.5. ил тод, нээлттэй байдлыг хангах үйл ажиллагаа;
- 5.1.6. мэдээлэл авах эрхийг хангах үйл ажиллагаа;

52 Цагдаагийн албаны тухай хууль, 4.1.Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

53 Засгийн газар дахь хяналтын тухай хууль, 1.1.Энэ хуулийн зорилго нь захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсыг сахиулах, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, Засгийн газраас харьяа байгууллага, албан тушаалтанд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэхэд оршино, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532040173281>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

54 Засгийн газар дахь хяналтын тухай хууль, 3.2.3.гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах, шийдвэрлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зэвсэгт хүчин, тагнуул, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон төрийн гадаад бодлогыг шууд хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаанд тавих хяналт.

3.3.Батлан хамгаалах болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаа, тагнуул, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын энэ хуулийн 3.2.3-т зааснаас бусад үйл ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.

5.1.7.байгууллагаас хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

5.1.8.ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа;

5.1.9.ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.

Харин дотоод хяналт шалгалт гэх ойлголтыг бусад эх сурвалжаас судалж үзэхэд Цагдаагийн албаны тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх явцад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, дэвшүүлсэн зорилго, төлөвлөгөө, стандартын дагуу явагдаж байгаа эсэхийг хянаж алдаа, дутагдлыг залруулах процесс⁵⁵ гэж зарим судлаач үзсэн байна.

Монгол Улсад дотоод аудитыг нэвтрүүлэх бодлогын ажлын хүрээнд 2014 онд Цагдаагийн газрын бүтцэд дотоод аудитын нэгжийг шинээр байгуулсан. Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын эрх зүйн байдлыг Цагдаагийн албаны тухай хуулийн 14.1.3-т “Цагдаагийн байгууллагын үүрэгт цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч гэмт хэрэг, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах, мөн тус хуулийн 14.6-д “Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан нь эрх хэмжээнийхээ хүрээнд тухайн байгууллагын алба хаагч, ажилтны өдөр тутмын ажилд хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн ёс зүй, сахилга, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна” гэж тус тус тодорхойлжээ.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн⁵⁶ 4.2.2.5-д Хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, харилцан ажиллагааны уялдаа холбоо, чанар, үр дүнг дээшлүүлэхээр заасан ба ингэхдээ эрсдэлийн болон гүйцэтгэлийн удирдлагыг нэвтрүүлж, үр дүнд суурилсан дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлсэн байх; иргэдийн хяналтын тогтолцооны чанар, үр дүнг дээшлүүлсэн байх зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тусгажээ.


Дээрх чиг үүргийн дагуу “Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар цагдаагийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/141 дүгээр тушаалаар Аюулгүй байдлын хэлтэс, Хяналт, шалгалт, дотоод аудитын хэлтэс, Төрийн нууцын хэлтсийн гүйцэтгэх, чиг үүрэг, бүтэц, орон тоог нэгтгэн Дотоод хяналт-аюулгүй байдлын газрыг байгуулж, Төрийн нууцын тасаг, Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасаг, хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч гэсэн бүтэцтэйгээр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийж, үнэлгээ өгөх, цагдаагийн алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлүүлэх, цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, судалгаа хийх, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авч байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, төрийн болон байгууллагын

55 А.Бат-Амгалан, Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоо, боловсронгуй болгох зарим асуудал, ХСИХ, магистрын зэрэг горилсон судалгааны ажил, (2016).

56 Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211003&showType=1>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

нууцын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, техник, криптографийн арга хэрэгсэл ашиглан шифр харилцааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулан мэдээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.⁵⁷

Схем 4.1. Монгол Улсын ЦЕГ-ын дотоод хяналт-аюулгүй байдлын газрын бүтэц⁵⁸



Хүснэгт 4.3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх өргөдөл, гомдол ба шийдвэрлэлтийн мэдээлэл⁵⁹ (2017-2023 он)

№	Он	Нийт өргөдөл, гомдол	Шийдвэрлэгдсэн	Шийдвэрлэгдээгүй	Албан хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй
1	2017	470	451	19	-
2	2018	495	471	24	303
3	2019	487	466	21	258
4	2020	494	483	11	324
5	2021	361	351	10	242
6	2022	515	486	29	269
7	2023	492	458	34	293

2017 оны байдлаар⁶⁰ нийт 470 гомдол, мэдээлэл ирснээс 95.9%-ийг хуулийн хугацаанд нь шалган шийдвэрлэж 19 өргөдөл, гомдлыг шийдвэрлэгдээгүй үлдсэн байна. Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 115 гомдол, мэдээлэлд албаны шалгалтын дугаар авч шалгасан. Нийт 312 танилцуулга бичсэн байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлын тухайд, цагдаагийн албан хаагчид сахилга, ёс зүйн дүрэм зөрчсөн талаар 202, ажлын хариуцлага алдсан талаар 133, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журам зөрчсөн талаар 109 болон бусад 26 өргөдөл, гомдол ирүүлсэн.

57 Хууль зүйн үндэсний хүрээлэнд ЦЕГ-ын Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвөөс ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний 50/11461 дугаартай албан бичиг.

58 Мөн тэнд.

59 Мөн тэнд.

60 Мөн тэнд.

2018 оны байдлаар⁶¹ нийт 495 өргөдөл, гомдол хүлээн авснаас 471 гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж 24 гомдлыг шийдвэрлээгүй үлдсэн байна. Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын 462 гомдол буюу 97,8%-ийг 30 хоногийн дотор, 9 гомдлыг буюу 2,1%-ийг хугацаа сунгаж шийдвэрлэсэн байна. Сахилгын шийтгэл ноогдуулсан 526 албан хаагчийн 477 албан хаагч буюу 90,3% нь офицер, 49 албан хаагч буюу 9,1% нь ахлагч, 3 албан хаагч буюу 0,6% нь энгийн ажилтан байв.

2019 оны байдлаар⁶² тухайн оны 465, өмнөх оны 22 өргөдөл, гомдол нийлээд нийт 487 өргөдөл, гомдол байсны 466 гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж 21 өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй үлдсэн байна. Өргөдөл, гомдлын 455 буюу 97,5%-ийг гуч хоногийн хугацаанд шийдвэрлэж 11 буюу 2,5%-ийг хугацаа сунгаж шийдвэрлэсэн байна. Нийт 170 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан.

2020 оны байдлаар⁶³ нийт 494 өргөдөл, гомдлыг хүлээн авснаас 483 гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн.

2021 оны байдлаар⁶⁴ нийт 361 өргөдөл, гомдол ирсний 351 өргөдлийг шийдвэрлэж 10 өргөдлийг шийдвэрлэгдээгүй үлдсэн байна. Нийт өргөдөл, гомдлын 99 хувийг гуч хоногийн дотор шийдвэрлэж 1 гомдлын хугацааг сунгаж шалгасан байна. Шалгагдсан өргөдлийн 430 өргөдөл буюу 94%-ийг офицер, 28 өргөдөл буюу 6%-ийг ахлагчид ирсэн.

2022 оны байдлаар⁶⁵ нийт өргөдөл, гомдлын 99,8%-ийг 30 хоногийн дотор шийдвэрлэж 1 гомдлыг хугацаа сунгаж шийдвэрлэсэн байна. Шалгагдсан өргөдөл, гомдолд давхардсан тоогоор нийт 515 албан хаагчийн 451 нь буюу 87,6% нь офицер, 64 нь буюу 12,4% нь ахлагч холбогдсон.

2023 оны 10 дугаар сарын байдлаар⁶⁶ шийдвэрлэсэн нийт 458 өргөдөл, гомдлын 99,3%-ийг 30 хүртэл хоног шалгаж үлдсэн 4 гомдлыг хугацаа сунгаж шийдвэрлэсэн. Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын дагуу давхардсан тоогоор 506 албан хаагч шалгагдсанаас 465 буюу 91,9%-ийг офицер, 39 гомдол буюу 8,1%-ийг ахлагч нар эзэлжээ.

61 Мөн тэнд.

62 Хууль зүйн үндэсний хүрээлэнд ЦЕГ-ын Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвөөс ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний 50/11461 дугаартай албан бичиг.


63 Мөн тэнд.

64 Мөн тэнд.

65 Мөн тэнд.

66 Мөн тэнд.

График 4.1. 2017-2023 оны Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол



2017-2023 онд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга, ёс зүйтэй холбоотой ирсэн нийт өргөдөл, гомдлын 95%-ийг хуулийн хугацаанд багтааж шийдвэрлэсэн байна. Гэхдээ шийдвэрлүүлэхээр ирсэн өргөдөл, гомдлын 60%-ийг алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй гэж шийдвэрлэжээ. Цагдаагийн алба хаагчийн зөрчлийн тоо буураагүй. Цагдаагийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувь нь цагдаагийн алба хаагч буруугүй гэсэн шийдвэр байгаа нь иргэд цагдаагийн байгууллага өөрийн ажилтнаа хамгаалж буй гэх хардалт үүсэх, цагдаагийн байгууллагад итгэх итгэл буурах эрсдэлтэй.

Иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэл нь нийтийн хэв журмыг сахиулах үйл ажиллагааг хэвийн, үр дүнтэй явуулахад маш чухал ач холбогдолтой байдаг. Гэвч А.Бат-Амгалан судлаачийн “Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоо, боловсронгуй болгох зарим асуудал⁶⁷” сэдэвт судалгаанд иргэдийн цагдаагийн албанд итгэх итгэл суларч байгааг онцолсон бөгөөд цагдаагийн алба хаагч хүний эрх чөлөөнд халдсан зөрчил өмнөх жилүүдээс нэмэгдсэн талаар дурдсан. Мөн цагдаагийн байгууллагын хэмжээнд үйл ажиллагааг бүрэн хамарсан хяналтын тогтолцоо хэвшээгүй, зарим газарт дотоод хяналт шалгалт хариуцсан алба хаагчийн орон тоо байхгүйгээс үйл ажиллагааны доголдол байнга давтагддаг тухай дээрх судалгаанд өгүүлсэн байна.

Иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхээр гадаадын зарим улс цагдаагийн байгууллагаас хараат бус байгууллага байгуулж цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх жишиг тогтжээ. Үүнтэй холбогдуулан гадаад зарим орны туршлагыг судалгааны дараах хэсэгт дэлгэрэнгүй авч үзье.

67 А.Бат-Амгалан, Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоо, боловсронгуй болгох зарим асуудал, ХСИХ, магистрын зэрэг горилсон судалгааны ажил, (2016), 58 дахь тал.

2.2. Гадаадын зарим орны цагдаагийн албанд хяналт тавих чиг үүрэг бүхий хараат бус байгууллага

Цагдаагийн алба хаагчид эрх мэдлээ олон нийтийн эрх ашгийн төлөө бус, хувийн ашиг сонирхолдоо ашиглах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хууль, дүрэм зөрчих зэрэг байдлаар гэмт хэрэг, ёс зүй, сахилгын зөрчил, дутагдал гаргах тал бий. Цагдаагийн байгууллага зөрчил гаргасан алба хаагчаа өөрөө шалгах нь шийдвэрт нөлөөлнө хэмээн олон нийтийн зүгээс хардалт үүсэх, шударгаар шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ үүсэх байдал үүсдэг. Үүнтэй холбогдуулан Хүний эрхийн тухай Европын конвенцын 2.3 дугаар зүйлд хамаарах Цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг үр дүнтэй шалгах таван зарчмыг⁶⁸ Европын хүний эрхийн шүүх (the European Court of Human Rights)-ээс гаргасан. Үүнд:

- Бие даасан байдал: Цагдаагийн байгууллагын зөрчил хариуцсан мөрдөн байцаагч, шалгагдаж байгаа цагдаагийн алба хаагч нарын хооронд байгууллагын болон албан тушаалын холбоо хамаарал байхгүй, бодитойгоор бие даасан байдалд байх шаардлагатай;
- Хангалттай байдал: Мөрдөн шалгах ажиллагаа нь цагдаагийн алба хаагчийн гаргасан үйлдлийг ёс зүйн доголдолтой талаар шийдвэрлэх баримт нотолгоо цуглуулж буруутай этгээдийг тодорхойлж шийтгэл хүлээлгэх;
- Шуурхай байдал: Эрх зүйт ёсонд итгэх итгэлийг хадгалахын тулд мөрдөн шалгах ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх;
- Олон нийтийн хяналт: Хариуцлага тооцохын тулд шийдвэр гаргалт, үйл ажиллагааны журам нээлттэй, ил тод байх шаардлагатай;
- Хохирогчийн оролцоо: Гомдол гаргагч нь өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахын тулд гомдол шийдвэрлэх ажиллагаанд оролцох зарчим багтана.

Дээрх зарчмын дагуу гадаадын зарим улс орнууд цагдаагийн албаны тухай хуульд шинэчлэл оруулж цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хараат бус байгууллага байгуулж системийн шинэчлэл хийсэн. Тухайлбал, Алдерийн хэрэг⁶⁹ буюу Их Британи улсын цагдаагийн хамгаалалтад байх үедээ нас барсан ноён Алдерийн хэргийг шүүх нотлох баримтыг устгасан, үхлийн шалтгаан тодорхой бус, хөрш цагдаагийн байгууллагаар шийдвэрлүүлсэн зэрэг шалтгаанаар цагдаагийн байгууллагыг буруутгасан. Энэхүү шүүмжлэлийн дагуу Их Британийн Засгийн газар хууль тогтоомжийн шинэчлэл хийж, цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой хүний амь нас эрсэдсэн, хүнд гэмтсэн талаарх өргөдөл, гомдлыг цагдаагийн хараат бус байгууллагаар шийдвэрлүүлэх шинэ систем бий болгосон байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаар гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэдэг хараат бус байгууллагын эрх зүйн байдлыг хуульчлан зохицуулсан гадаадын зарим орны жишгийг авч үзье.

68 The Danish Institute for Human Rights, Police oversight mechanisms, 2018, Холбоос: https://www.humanrights.dk/files/media/migrated/police_complaint_mechanisms_dih2018.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

69 Мөн тэнд.

2.2.1. Их Британи: Англи, Уэльс улсын Цагдаа судлалын бие даасан байгууллага (Independent Office for Police Conduct)

Тус комисс нь 2002 оны Цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэтгэлийн дүнд 2004 онд Цагдаагийн бие даасан өргөдөл, гомдлын хороо нэртэйгээр анх үүсгэн байгуулагдаж, 2017 оны Цагдаа ба гэмт хэргийн тухай хууль⁷⁰-аар шинэчлэгдэж “Цагдаа судлалын бие даасан байгууллага” нэртэйгээр өргөжин тэлсэн. Төрийн албанаас санхүүждэг яамны харьяа байгууллага юм. Цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагааг удирдан явуулах, хянах, эсвэл бие даан шалгах чиг үүрэг хэрэгжүүлдэг байна.

Бүтэц: Дарга, удирдлагын баг болон гүйцэтгэх бус гишүүд гэсэн бүтэц бүхий хороо ажилладаг. Даргыг хаант засаглалаас, төрөөс тус тус таван жилээр томилдог байна.

Бүрэн эрх: Цагдаагийн байгууллагын талаар өргөдөл, гомдлын системийг бүхэлд нь хянадаг. Тус хороо нь бие даасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

Хараат бус байдал: Цагдаагийн бие даасан өргөдөл, гомдлын хороо нь төрөөс санхүүжилт авдаг ч цагдаа, улс төрийн нам болон ашиг сонирхлын бүлгүүдээс тусдаа бие даасан байгууллага юм. Тухайлбал,

1. Хэргийн шийдвэрлэлтэд төрийн зүгээс ямар нэгэн оролцоо байхгүй.
2. Дарга болон комиссарууд өмнө нь ямар нэгэн байдлаар цагдаагийн байгууллагад ажиллаж байгаагүй байх шаардлага тавигддаг.

Хүснэгт 4.4. Дауу болон сул тал /Их Британи/

Дауу тал	Сул тал
<p>- Цагдаагийн байгууллагын шийдвэрлэсэн хэргүүдэд сэтгэл ханамжгүй бол дээд шатанд нь гомдол гаргах эсхүл Цагдаагийн бие даасан өргөдөл, гомдлын хороонд тус хэргийг мэдээлэх</p> <p>- Цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдлээс шалтгаалан хүний амь нас хохирох, ноцтой гэмтэл учирсан тохиолдолд Цагдаагийн бие даасан өргөдөл, гомдлын хороонд заавал мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>- Ноцтой халдлага, авлига, ялгаварлан гадуурхалтаас шалтгаалан хүндрэл, бэрхшээл учирсан хэргүүдэд хамаарах өргөдөл, гомдлыг тус хороонд мэдэгдэх шаардлагатай.</p> <p>- Тус хороонд мэдэгдээгүй зарим хэргийг шалгах эрхтэй.</p> <p>- Мөрдөн шалгах ажиллагааны үед эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр улсын прокурорт хэргийг шилжүүлэх, эсвэл сахилгын арга хэмжээ авах талаар зөвлөмж өгдөг.</p>	<p>- Цагдаагийн бие даасан өргөдөл, гомдлын хороо цагдаагийн байгууллагын доголдлыг илрүүлж зөвлөмж гаргах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй.</p> <p>- Тус зөвлөмжийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлэхгүй байгаагаас шалтгаалан олон нийтийн шүүмжлэлд өртдөг.</p> <p>- Хүний амь нас хохироох, ноцтой гэмтэл учруулсан тохиолдолд ажлын хариуцлага алдсан гэж шууд зөвлөмж өгөх эрхгүй.</p>

70 Policing and Crime Act 2017, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2017/3/contents/enacted>. Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

2.2.2. Умард Ирланд Улсын Цагдаагийн байгууллагын зөвлөл⁷¹

Умард Ирланд Улсын Цагдаагийн байгууллагыг шинэчлэх зорилгоор Цагдаагийн хараат бус хорооны зөвлөмжөөр Умард Ирланд Улсын Цагдаагийн байгууллагын зөвлөлийг байгуулсан. 2000 онд баталсан Цагдаагийн албаны тухай хуулиар төрийн бус байгууллага байгуулсан.

Бүрэн эрх

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийттэй зөвлөлдөх, цагдаагийн байгууллагатай хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
2. Цагдаагийн байгууллагын жилийн төлөвлөгөөнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг, зорилтыг тусгуулж, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах;
3. Ахлах ахлагч цол, хэргэмээс дээш цолоор алба хаагчдын албан тушаалыг томилох;
4. Зардал хянах, шалгах төсөв тавих;
5. Цагдаагийн байгууллагын талаар гаргасан гомдлын хэв маяг, шинж чанарыг судлах;
6. Цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдолд хяналт тавих;
7. 1998 оны Хүний эрхийн тухай хуульд нийцэж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;
8. Үйл ажиллагааг сайжруулах зохицуулалтыг хангах;
9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлж үнэлгээг сайжруулах тал дээр арга хэмжээ авах;
10. Гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний газрын үйл ажиллагааг хянах, зохион байгуулалттай гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажиллах.

Бүтэц

Нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Д'Хондт (суудал хуваарилах хамгийн дундаж арга ба намын жагсаалтын хувь тэнцүүлэн төлөөлөх нэг төрөл)-ын системийн аргаар сонгогдсон Умард Ирландын Ассамблейн 10 улс төрийн гишүүн байна. Харин үлдсэн 9 хараат бус гишүүнийг тус улсын хууль зүйн сайд томилдог. Зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирал нь төсөв санхүүжилтийг хариуцаж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргад ажлаа шууд тайлагнадаг. Зөвлөлийн дарга нь хараат бус гишүүн хэдий ч зөвлөлийн ихэнх гишүүд улс төрийн харьяалалтай байгаа нь сөрөг үр дагавартай байж болзошгүйд тооцогддог.

Бие даасан байдал

Парламентын сангаас Умард Ирландын их хурлын Тамгын газар санхүүжүүлдэг байна.

Парламентад жил бүр ажлаа тайлагнадаг.

71 Northern Ireland Policing Annual Report, 2017, Холбоос: <https://www.nipolicingboard.org.uk/sites/nipb/files/media-files/northern-ireland-policing-board-annual-report-2016-2017.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

2.2.3. Канад Улсын Онтарио хотын Цагдаагийн байгууллагын хяналт удирдлагын алба⁷²

Онтариагийн хууль тогтоох байгууллага 2007 оны 5 дугаар сард Цагдаагийн хараат бус хяналт шалгалтын тухай хуулийг баталж, Цагдаагийн байгууллагын хяналт удирдлагын алба байгуулсан.

Бүрэн эрх

1. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хууль сахиулах үед гарсан өргөдөл, гомдлыг зохицуулах;
2. Цагдаагийн алба хаагчийн талаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
3. Тухайн эрх, үүргийг гүйцэтгэхдээ хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

Бүтэц

Цагдаагийн байгууллагын хяналт удирдлагын албыг Ерөнхий прокурорын санал болгосны дагуу Зөвлөлийн дэд дарга томилдог. Тус албанд цагдаагийн алба хаагчаар ажилладаг болон ажиллаж байсан хүнийг томилж болохгүй. Нийт 57 ажилтантай ба үүнээс 52 ажилтан нь бүтэн цагаар, 5 ажилтан нь түр томилогдсон байна. Удирдлагын алба, хэргийн менежмент, мөрдөн шалгах ажиллагаа, хууль зүйн үйлчилгээ, үйл ажиллагааны төв гэсэн бүтцээр ажилладаг.

Хүснэгт 4.5. Давуу болон сул тал /Канад/

Давуу тал	Сул тал
<p>-Цагдаагийн үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн талаар бүх хүн өргөдөл, гомдол гаргах боломжтой.</p> <p>- Мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл мөрдөн байцаагч цагдаагийн байгууллага руу нэвтрэн орж нэгжлэг хийж болно.</p> <p>- Мөрдөн байцаагч мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой бүртгэл, мэдээллийг цагдаагийн байгууллагад очиж авах эрхтэй. Хэргийн холбогдох бүртгэл, мэдээллийг хайх, шалгах, хувилж авах боломжтой. Цагдаагийн байгууллагын мэдээлэл хадгалах санг ашиглаж болно.</p> <p>- Цагдаагийн байгууллагын хяналт, удирдлагын алба нь өөрсдийн ажлын эрх, үүрэг эсвэл үйл ажиллагааны талаар дүрэм гаргаж болно.</p> <p>- Хэрэв хэргийн баримт нотолгоо хангалтгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргагч 30 хоногийн дотор дахин хянуулах хүсэлт гаргах боломжтой.</p> <p>- Цагдаагийн байгууллагын хяналт удирдлагын албаны ажилтан мөрдөн байцаагчийн үүрэг гүйцэтгэх явцад цуглуулсан баримт нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвшөөрөгдөхгүй.</p> <p>- Албан үүргээ гүйцэтгэж байх явцад олсон мэдээ мэдээллийн хүрээнд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдүүлэг өгч болохгүй.</p>	<p>- Тухайн гомдол нь илт үндэслэлгүй гэж үзвэл шийдвэрлэхээс татгалзаж болно.</p> <p>- Хэрэг гарснаас хойш 6 сараас дээш хугацаа өнгөрсний дараа гомдол гаргасан тохиолдолд хүлээн авч шийдвэрлэхгүй байж болно.</p> <p>- Тухайн гомдол гаргагч этгээдэд шууд нөлөө үзүүлээгүй тохиолдолд гомдлыг шийдвэрлэхгүй байж болно.</p> <p>-Цагдаагийн байгууллагын хяналт, удирдлагын алба дараагийн шатны гомдол гаргадаггүй.</p>

72 Цагдаагийн хараат бус хяналт шалгалтын тухай хууль, (2007), Холбоос: <https://www.ontario.ca/laws/statute/s07005>. Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

2.2.4. Өмнөд Австралийн (Австралийн төв өмнөд хэсэгт орших муж) Олон нийтийн шударга байдлын алба

2016 оны Цагдаагийн байгууллагын гомдол, хариуцлагын тухай хуулийн дагуу цагдаагийн байгууллагын талаарх бүх өргөдөл гомдолд үнэлэлт, дүгнэлт өгч шалгах ажлыг 2017 оны 4 дүгээр сараас эхлэн Олон нийтийн шударга байдлын алба хамаарах болсон.

Бүрэн эрх, үйл ажиллагаа

- Иргэдээс ирүүлсэн төрийн байгууллагын талаарх гомдлыг хүлээн авч шалгах;
- Төрийн байгууллага, алба хаагчдаас гаргасан төрийн захиргааны авлига, ёс зүй, удирдлагын буруутай үйлдлийн талаарх гомдлыг хүлээн авч шалгах;
- Комиссарын удирдлагын дагуу төрийн байгууллагуудад заавар, зөвлөгөө өгөх;
- Комиссараас даалгасан бусад ажил.

Бүтэц

Тус байгууллагын даргыг Ерөнхий прокуророос санал болгож, УИХ-ын хороо дэмжсэний дагуу Засаг дарга томилдог. Гүйцэтгэх захирлыг Комиссар сонгож томилдог. Үнэлгээний ахлах, ажилтан, гомдол хариуцсан мэргэжилтэн зэрэг 9 ажилтнаас баг бүрддэг.

Хүснэгт 4.6. Давуу болон сул тал /Өмнөд Австрали/

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Комиссарын алба нь хууль сахиулах байгууллага юм; - Комиссар нь шалгалт явуулах, баримт бичгийн бүрдүүлэлт хүсэх, хайх зэрэг чиглэлээр албадлагын эрх мэдэлтэй; - Төрийн албан хаагчдад зориулж зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой боловсролын болон ёс зүйн харилцааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг. 	<ul style="list-style-type: none"> - Комиссар прокурортой адил эрх мэдэлгүй ч прокурорын газарт хандаж болно. - Цагдаагийн байгууллага болон бусад агентлагуудад дэмжлэг үзүүлнэ.

Хараат бус байдал

- Мөрдөн шалгах ажиллагааны үед Комиссар заавар, чиглэл авахгүй;
- Ажлын тайланг шууд Парламентад тайлагнадаг.

Гадаадын орнууд олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх, иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл, нэр хүндийг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаар гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх хараат бус байгууллага байгуулан ажиллаж байна. Зарим улс орны хараат бус байгууллагууд зөвхөн хянан шалгах эрхтэй байсан бол сүүлд мөрдөн шалгах эрхтэй болж эрх мэдлийн хүрээ өргөжсөн. Хэрхэн өөрчлөгдсөн байдлыг дараах хүснэгтэд үзүүлье.

Хүснэгт 4.7. Гадаадын зарим орны цагдаагийн албанд хяналт тавих чиг үүрэг бүхий хараат бус байгууллагын жагсаалт⁷³

№	Он	Улс	Байгууллагын нэр	Эрх мэдэл
1.	1958	АНУ-ын Филадельфи хот	Цагдаагийн байгууллагын зөвлөх зөвлөл	Хяналт шалгалт
2.	1966	АНУ-ын Нью-Йорк хот	Иргэдийн өргөдөл, гомдлын хяналтын зөвлөл	Хяналт шалгалт
3.	1977	Их Британи: Англи, Уэльс улс	Цагдаагийн бие даасан өргөдөл, гомдлын комисс	Хяналт шалгалт
4.	1981	Канад Улсын Онтарио муж	Торонтогийн цагдаагийн байгууллагын өргөдөл, гомдлын комиссар	Хяналт шалгалт
5.	1985	Их Британи: Англи, Уэльс улс	Цагдаагийн байгууллагын гомдол гаргах газар	Хяналт шалгалт
6.	1986	Австрали улсын Викториа муж	Цагдаагийн байгууллагын гомдол гаргах газар	Хяналт шалгалт
7.	1989	Австрали улсын Квинсленд муж	Эрүүгийн хууль зүйн хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
8.	1990	Канад улсын Онтарио муж	Цагдаагийн байгууллагын өргөдөл, гомдлын комиссар Тусгай мөрдөн байцаах алба	Хяналт шалгалт, мөрдөн шалгах ажиллагаа
9.	1991	Бүгд Найрамдах Филиппин улс	Иргэдийн хууль сахиулах зөвлөл	Мөрдөн шалгах ажиллагаа
10.	1993	Бельгийн хаант улс	Цагдаагийн байгууллагын байнгын хяналтын хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
11.	1993	АНУ-ын Нью-Йорк хот	Иргэдийн өргөдөл, гомдлын хяналтын зөвлөл	Мөрдөн шалгах ажиллагаа
12.	1996	Австрали улсын Шинэ Өмнөд Уэльс муж	Цагдаагийн шударга ёсны хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
13.	1997	Өмнөд Африкийн Бүгд найрамдах улс	Хараат бус өргөдөл, гомдлын хэлтэс	Мөрдөн шалгах ажиллагаа
14.	2001	Австрали улсын Квинсленд муж	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
15.	2002	Зимбабве улс	Цагдаагийн байгууллагын олон нийтийн өргөдөл, гомдлын алба	Мөрдөн шалгах ажиллагаа
16.	2004	Их Британи: Англи, Уэльс улс	Хараат бус цагдаагийн байгууллагын өргөдөл, гомдлын хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
17.	2007	Ирланд улс	Гарда Сиочана Омбудсмен хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
18.	2008	Бүгд Найрамдах Унгар Улс	Хараат бус цагдаагийн байгууллагын өргөдөл, гомдлын хороо	Хяналт шалгалт
19.	2009	Канад улсын Онтарио муж	Цагдаагийн байгууллагын хараат бус хяналтын даргын алба	Мөрдөн шалгах ажиллагаа
20.	2010	Ямайка улс	Хараат бус мөрдөн байцаах комисс	Мөрдөн шалгах ажиллагаа
21.	2011	Малайз улс	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шударга байдлын хороо	Мөрдөн шалгах ажиллагаа
22.	2012	Дани улс	Хараат бус цагдаагийн байгууллагын өргөдөл, гомдлын алба	Мөрдөн шалгах ажиллагаа
23.	2013	Шотланд улс	Цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах комиссар	Мөрдөн шалгах ажиллагаа

73 Graham Smith, International police complaints reform, p 2, Холбооц: <https://rm.coe.int/16806dbbbd>. Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

Явцын дүгнэлт

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хандаж буй иргэдийн итгэх итгэл нь цагдаагийн байгууллагын зүгээс нийтийн хэв журмыг сахиулах, эрх мэдлээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Монгол Улсын ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлсэн 2017-2023 оны нийт өргөдөл, гомдлын 95 хувийг хугацаандаа шийдвэрлэсэн нь сайшаалтай хэдий ч 2018-2023 онд иргэдийн зүгээс гаргасан нийт өргөдөл, гомдлын 60 хувь нь албан хаагчийн буруутай үйлдлийг тогтоогоогүй байгаа нь анхаарал татах асуудал юм.

Мөн “Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоо, боловсронгуй болгох зарим асуудал” судалгаанд иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх илтгэл буурсан, хүний эрх чөлөөнд халдсан зөрчил өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн талаар дурдсан зэргийг онцолсон нь тус албаны үйл ажиллагаанд зөрчил, дутагдал байсаар байгааг илэрхийлнэ.

Иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор цагдаагийн алба хаагчдын талаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хараат бус, бие даасан байгууллагаар шийдвэрлүүлдэг олон улсын жишиг тогтсон байна.

Европын хүний эрхийн шүүх (The European Court of Human Rights)-ээс гаргасан, Хүний эрхийн тухай Европын конвенцын 2, 3 дугаар зүйлд зааснаар Цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг үр дүнтэй шалгах таван зарчмыг гадаадын ихэнх улс орон жишиг болгон хэрэгжүүлэх болсон бөгөөд ирсэн өргөдөл, гомдлыг хянан шалгах зорилго бүхий бие даасан байгууллага байгуулжээ. Ийм төрлийн байгууллага байгуулагдсанаар цагдаагийн алба хаагчдын хууль зөрчсөн үйлдэлд холбогдох журмын дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг болсон тохиолдолд тодорхой хэмжээнд иргэдийн итгэл үнэмшил нэмэгдэх талтай юм.

Тус судалгааны хүрээнд сонгон судалсан улс орнуудын жишгээс үзэхэд хууль тогтоомжийн шинэтгэл хийж, цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой хүний амь хохирсон, хүний биед гэмтэл учруулсан талаарх өргөдөл, гомдлыг цагдаагийн хараат бус байгууллагаар шийдвэрлүүлэх шинэ системийг хэрэгжүүлж байна.

Санал

Энэхүү бүлгийн дүгнэлтэд үндэслэн, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга, ёс зүйтэй холбоотой иргэдийн өргөдөл, гомдлыг хараат бус байгууллагаар шалгаж шийдвэрлүүлэх хяналтыг илүү үр дүнтэйд тооцож байгаа олон улсын чиг хандлагыг харгалзан, Хүний эрхийн тухай Европын конвенцын 2, 3 дугаар зүйлд зааснаар Цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг үр дүнтэй шалгах зарчмуудыг тусгаж Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэх саналыг дэвшүүлж байна.

III. МӨРДӨГЧИД ТАВИГДАХ ШАЛГУУР БА СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар «мөрдөгч» гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар хуульд заасан ажиллагаа явуулдаг эрх бүхий албан тушаалтныг хэлдэг. Тус хуулийн 6.2 дугаар зүйлд мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар зохицуулсан.

Мөрдөгч нь эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхдээ зөвхөн хуульд захирагдах, гаднын нөлөө, ашиг сонирхолд автагдахгүй байх, мөрдөн байцаалтын нууцыг чандлан хадгалах үүрэг хүлээхээс гадна сэжигтэн, яллагдагчийг дуудан ирүүлэх, баривчлах, цагдан хорьж мөрдөх үед хүнлэг бусаар харьцах, эрүү шүүлт хэрэглэх, дарамт шахалт үзүүлэх зэргээр хүний халдашгүй эрхийг хөндөх, хязгаарлах үйлдэл гаргахыг хориглодог.⁷⁴

Хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлд “мөрдөгчдийн хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, дур мэдэн баривчлах, саатуулахаас хамгаалуулах эрхийн талаарх мэдлэг дутмаг, хүний нөөц, дотоод зохион байгуулалтаас шалтгаалж хүний эрхийг үл хайхрах хандлага гаргасаар байна.” гэж дүгнэсэн бөгөөд мөрдөгчид хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, хууль бус болон дур зоргын баривчилгааны талаар мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах, ялангуяа баривчлах үед нь баривчилсан шалтгаан, холбогдсон хэргийн талаар тодорхой тайлбарлах, уг ажиллагааг бодитой хийгээгүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврын талаар мэдлэг, хандлага суулгах хэрэгтэй талаар санал дэвшүүлжээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь нэг талаас гэмт хэргийг тал бүрээс нь бодитойгоор, бүрэн дүүрэн илрүүлэх, нотлоход чиглэсэн цогц үйл ажиллагааны илрэл бөгөөд нөгөө талаас тухайн эрүүгийн хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргах хүртэлх бүхий л ажиллагаанууд хийгддэг учраас мөрдөн байцаагчаас мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан онцгой ажиллагаа юм.⁷⁵ Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн ажлын зохион байгуулалтыг оновчтой болгох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг бүрдүүлэх, мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх талаар бодлогын шинжтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь хүн хэргээ аль болох богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг хангах үндэс болно.⁷⁶

Иймээс мөрдөгч нь нийгмийн аюулгүй, амар тайван байдал, хүний эрхийг хамгаалахад чухал нөлөөтэй алба хаагч тул энэхүү судалгаагаар мөрдөгчид тавигдаж буй, шалгуур болон мөрдөгчдийн сонгон шалгаруулалтын талаар харьцуулан судлах болно.

74 Д.Баярсайхан, “Эрүүгийн процессын эрх зүй”, (УБ, 2020), 113 дахь тал.

75 С.Гантулга, Мөрдөн байцаагчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах нь, ХСИХ, Удирдлагын сургуулийн удирдахуйн ухааны магистрын зэрэг горилсон ажил, (2015), 21 дэх тал.

76 ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 66 дахь тал, Холбоос: <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

3.1. Монгол Улс

Монгол Улсын мөрдөгчид тавигдах одоогийн тусгай шалгуурыг⁷⁷ үзвэл:

1. Боловсрол: Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
2. Мэргэжил: Эрх зүйч
3. Мэргэшил: Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх
4. Туршлага: Цагдаагийн байгууллагад 4-өөс доошгүй жил ажилласан байх
5. Ур чадвар: Дүн шинжилгээ хийх
 - Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх
 - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах чадвартай байх
 - Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх
6. Асуудал шийдвэрлэх:
 - Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;
 - Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
7. Багаар ажиллах:
 - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;
 - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
8. Бусад:
 - Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх;
 - Компьютерын Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point програмуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх;
 - Нууц хадгалах гэсэн шалгуур тус тус мөрдөгдөж байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т заасан төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас....” гэж заасны дагуу ажлын байрны орон тооны нөхөн хангалтыг хийдэг байна. Гэхдээ дээрх шалгуур нь ДХИС-аас бусад энгийн их сургууль төгсөгчдөд хамаарах бөгөөд офицер цол авсан тохиолдолд мөрдөгчөөр томилж ажиллуулдаг байна.⁷⁸ Харин, ДХИС төгсөгчдийг мөрдөгчийн албан тушаалд шууд томилдог байна.⁷⁹

Үүнээс үзэхэд мөрдөгч нь мэргэжлийн ур чадварын болон монгол хэл зүйн зэрэг шалгуур хангасан байх ёстой гэсэн шаардлага тавигддаг ч уг шалгуурыг хангаж буйг хэрхэн тогтоодог нь тодорхойгүй юм. Цагдаагийн албан тушаалд шинээр томилогдох сонгон шалгаруулалт буюу тухайлбал, бие бялдрын зэрэг түгээмэл шалгуураас гадна мөрдөгчид тусгайлан зориулсан сонгон шалгаруулалт байхгүй байна.

77 Хууль зүйн үндэсний хүрээлэнд ЦЕГ-ын Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвөөс ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 50/11461 дугаартай албан бичиг.

78 ЦЕГ-ын мөрдөн байцаах албаны мөрдөгчтэй хийсэн ярилцлагын хэсгээс, 2023.12.25.

79 Мөн тэнд.

Цагдаагийн байгууллагад 4-өөс доошгүй жил ажилласан байх буюу мөрдөгч болохын тулд цагдаагийн алба хаагч байх шаардлага тавигддаг учир цагдаагийн алба хаагчдыг шалгаруулахдаа ямар шаардлага тавьдаг талаар авч үзье. Цагдаагийн албаны тухай хуулийн 66.2-т зааснаар цагдаагийн албан тушаалд анх томилохдоо гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, нас, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн болон бусад тусгайлсан шалгуур үзүүлэлтийг хангасан 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг хүсэлтийг нь үндэслэн шалгуур хангасан байдлаар нь эрэмбэлэн шалгаруулж томилдог. Мөн хуулийн 66.5-д зааснаар, цагдаагийн албан тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, цагдаагийн албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ. Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам⁸⁰-д нийтлэг болон тусгай шаардлагыг заасан бөгөөд тусгай шалгуурт насны хязгаар, боловсрол, мэргэжил, туршлага, ур чадварын шалгуур үзүүлэлт, эрүүл мэнд, сэтгэл зүйн шаардлага, бие бялдар, гоо зүйн болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тус тус тусгасан байна.

Уг журмын 3.2.-т боловсрол, мэргэжил, туршлага, ур чадварын шаардлага, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгасан ба үүнийг авч үзвэл:

- 3.2.1. цагдаагийн бага цолны албан тушаалд бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой байх;
- 3.2.2. цагдаагийн дунд ба түүнээс дээш цолны албан тушаалд бакалавр, түүнээс дээш боловсролтой, тухайн ажлын байрны шаардлага хангасан мэргэжил эзэмшсэн байх;
- 3.2.3. албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил эзэмшсэн, түүнийг нотлох баримт бичиг, хүчинтэй хугацаа дуусаагүй эрхийн гэрчилгээтэй байх;
- 3.2.4. өмнө нь цагдаагийн албанд болон бусад байгууллагад мэргэжлийн чиглэлээр ажиллаж байсан туршлага, ур чадвартай, олон нийтийн цагдаагаар 1 буюу түүнээс дээш жил үр дүнтэй ажилласан бол давуу тал болно.

Үүнд холбогдох мэргэжил эзэмшсэн байх, туршлагатай байх, ур чадвартай байх гэдгийг багтаасан байх бөгөөд харин хангалттай ур чадвартай эсэхийг хэрхэн тогтоож, тодорхойлж байгаа нь тусгагдаагүй байна. Монгол хэлний бичгийн болон ярианы чадвар нь цагдаагийн алба хаагчид төдийгүй мөрдөгчид шаардлагатай хамгийн наад захын, зайлшгүй эзэмшсэн байвал зохих чадварын нэг билээ. Гэхдээ цагдаагийн алба хаагч болохыг хүссэн иргэнд энэ шалгуур тавигдаагүй, “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-д ч тусгагдаагүй байна. Судалгааны эхний бүлэг болох цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо бүлэгт дурдсан судалгаанд шинээр томилогдсон цагдаагийн алба хаагчийн бичгийн ур чадвар, тайлагнах ур чадвар хангалтгүй үзүүлэлттэй гарсныг дурдах нь зүйтэй.

Харин сэтгэцийн эрүүл мэнд, бие хүний сэтгэл зүйн шинж чанарууд нь насны онцлогт тохирч байгаа эсэх, буюу тухайн иргэний оюун ухааны хөгжлийн түвшнийг мэргэжлийн сэтгэл зүйч тогтоож, дүгнэлт гаргадаг. Ингэхдээ ярилцлага хийх /тухайн иргэний зан байдал, түүний төлөвшил, хандлага, хүсэл, сонирхлыг тодруулах

80 ЦЕГ-ын даргын А/80 дугаар тушаалын хавсралт, Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам, 2023, Холбоос: <https://police.gov.mn/resource/policenew/File/2023/05/12/29qkfwo2ksbpx3y/%D0%B0-80%D1%81%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BD%20%D1%88%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D1%85.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

зорилгоор урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөө, асуултын дагуу харилцан ярилцах болон сэтгэл судлалын шинжлэх ухааны бусад аргуудыг ашиглах/ аргыг ашигладаг байна. Ярилцлагад тэнцсэн иргэний анхаарал, ой тогтоолт, сэтгэн бодох чадвар зэрэг танин мэдэхүйн үйл явц, бие хүний сэтгэл зүйн онцлог шинж, сэтгэл хөдлөл, мэдрэмж, нийгэм сэтгэл зүй, зан төлөвийн өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор сэтгэл зүйн сорил авдаг. Гэхдээ уг сорил нь ямар хэлбэртэй, хэрхэн авагддаг талаар холбогдох журамд тусгаагүй байна.

3.2. Америкийн Нэгдсэн Улс

“Америкийн Нэгдсэн Улсын Код”⁸¹-д мөрдөгчийг тодорхойлохдоо эзэмшсэн байвал зохих чадвар, шаардлагыг тусгажээ. Мөрдөгч нь:

(A) мөрдөн шалгалтын арга техник, нотлох баримт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм, нотлох баримтыг үнэлэх, нэгжлэг, хураан авах болон холбогдох шүүхийн өмнөх үйл ажиллагааны талаарх мэдлэгтэй байх;

(B) хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд танилцуулах нотлох баримтыг боловсруулж, үнэлж, танилцуулах;

(C) тандалтын арга техникийг ашиглах, гүйцэтгэх ажил хийх, зөвлөгөө өгөх, туслах ур чадвартай байх;

(D) нарийн төвөгтэй, урт хугацааны хэргүүдэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүрэн ашиглах

(E) Эрүүгийн хууль болон Холбооны хуулийн талаар мэдлэгтэй байх, Үүнд:

(i) гэмт хэргийн бүрэлдэхүүний талаарх мэдлэг;

(ii) гэмт хэргийг нотлоход шаардлагатай нотлох баримт;

(iii) баривчлах эрх бүхий байгууллагатай холбоотой шийдвэр;

(iv) мөрдөн шалгах ажиллагааны арга зүй;

(v) илрүүлэх төхөөрөмж;

(F) гэмт хэрэг үйлдэгдсэний дараа мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлэхээс гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чадвартай байх;⁸² гэж дэлгэрэнгүй байдлаар зохицуулсан байна.

АНУ-ын Хьюстон мужид эргүүлийн цагдаагийн алба хаагч аль нэг мэргэжлийн ангид хандахад ямар туршлагатай байх шаардлага нь тухайн салбараас шалтгаалан өөр өөр байна. Жишээлбэл, хүн амины гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст мөрдөн байцаагчаар шинээр орох бол эргүүлийн цагдаагаар дор хаяж гурван жил ажилласан байх шаардлагатай бол хар тамхитай тэмцэх хэлтэст таван жил

81 АНУ-ын Код нь хууль тогтоох үйл явцаар дамжуулан АНУ-ын Конгрессоос баталсан бүх ерөнхий болон байнгын холбооны хуулиудын албан ёсны эмхэтгэл юм. АНУ-ын Кодод хуулиар тогтоосон хууль тогтоомж нь Конгрессоос баталсан хуулийг хэрэгжүүлэхийн тулд холбооны янз бүрийнагентлагууд бий болгосон холбооны дүрэм журмуудтай зөрчилдөх ёсгүй. Холбоос: <https://mn.eferrit.com/%D0%B0%D0%BD%D1%83-%D1%8B%D0%BD-%D1%85%D1%83%D1%83%D0%B%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9/>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

82 5 U.S. Code § 5545a - Availability pay for criminal investigators, Холбоос: https://www.law.cornell.edu/uscode/text/5/5545a#a_2, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

ажилласан байх шаардлагыг тавьжээ.⁸³

АНУ-ын Цагаачлал, гаалийн албаны эрүүгийн мөрдөгчид нь тусгай агент гэгддэг бөгөөд үндэсний аюулгүй байдалд заналхийлэх, терроризм, хар тамхины хууль бус наймаа, хүүхдийн мөлжлөг, хүний наймаа, хууль бус зэвсгийн экспорт, санхүүгийн гэмт хэрэг, хувийн мэдээллийг ашиглан үйлдсэн гэмт хэрэг, тэтгэмжийн луйвар, арилжааны луйвар зэрэгт эрүүгийн болон иргэний мөрдөн байцаалт явуулдаг.⁸⁴ Энэ чиглэлийн мөрдөгч болохын тулд төрийн байгууллагад ажиллаж байсантай холбоотой ICTAP/CTAP, Ажил мэргэжлийн асуулга, ярилцлага, Бие бялдрын шалгалт, Эмнэлгийн магадалгаа, Хар тамхины шинжилгээ, Суурь мэдээлэл/Аюулгүй байдлын судалгаа, Полиграфын үзлэг зэрэгт хамаарах үндсэн шалгуурыг хангах ёстой. Үүнээс гадна гадна эрүүгийн мөрдөгчийг 2 үе шат бүхий шалгаруулалтаар сонгож авдаг байна.

I шатны шалгаруулалт

Бичгийн автоматжуулсан үнэлгээ (AWA): Бичгээр харилцах чадвар нь эрүүгийн мөрдөгчид тавигдах гол шалгуурт орно. Энэхүү шалгалтын хүрээнд, өргөдөл гаргагчид нь богино эсээ бичдэг ба эсээг үнэлэхдээ илэрхийлэл, хэл зүйн дүрэм, хариултын бүрэн бүтэн байдлыг харгалзан үнэлдэг.

Нөхцөл байдлыг үнэлэх шалгалт (SJT): SJT тестээр ажил горилогчид нь ажилтай холбоотой, бодит нөхцөлүүдэд тохирсон арга хэмжээ авах боломжит үйл ажиллагааны чиглэлүүдийг сонгох хэрэгтэй болдог. Өгөгдсөн хариултуудыг хянаж, тус бүр нь хэр үр дүнтэй байж болох талаар үнэлгээ өгөхийг өргөдөл гаргагчдаас хүсдэг. Энэхүү шалгалт нь багаар ажиллах чадвар болон уян хатан байдлыг хэмждэг бөгөөд энэ нь анхан шатны эрүүгийн мөрдөгчид үр дүнтэй ажиллахад шаардагдах чухал хоёр ур чадварт тооцогддог. Төгсгөл хэсэгт I шатанд тэнцсэн буюу хоёр үнэлгээгээр хангалттай оноо авсан өргөдөл гаргагч II шатанд шилжинэ.

II шатны шалгаруулалт

II шатны шалгаруулалтад өргөдөл гаргагч хүссэн хуваарийн дагуу цахим хаягаар ирсэн холбоосоор оролцох боломжтой байдаг.

Энэ шатанд дараах гурван шалгалтыг авдаг. Үүнд:

Бичих ур чадварын шалгалт (WST): WST-ын хүрээнд, өргөдөл гаргагч өгөгдсөн асуултуудад хариулдаг бөгөөд англи хэлний нийтлэг дүрмийн талаарх ойлголттой эсэхийг шалгадаг. (жишээ нь, өгүүлбэр зохиох, үг зөв хэрэглэх г.м).

Логик үндэслэлийн шалгалт (LRA): Эрүүгийн мөрдөн байцаагч нь мэдээллийг тайлбарлах, чухал шийдвэр гаргах чадвартай байх маш чухал. Энэхүү шалгалтаар өгөгдсөн материалыг тайлбарлах, холбогдох бодит нөхцөл байдалд шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах чадварыг үнэлдэг.

Нэр дэвшигчийн туршлагын бүртгэл (CER): Уг шалгалтаар өргөдөл гаргагчийн өнгөрсөн туршлага, ажил, боловсролын сонголт, хувь хүний өөрийн чадварын

83 Police education and training systems in the OSCE region, 2018, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

84 Criminal investigator, Холбоос: <https://www.ice.gov/careers/criminal-investigator>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

талаарх ойлгож буй байдлыг иж бүрэн үнэлдэг бөгөөд өргөдөл гаргагчийн талаарх гол мэдээллийг цуглуулахад ашиглагддаг.

I, II шатны шалгалтад тэнцсэн өргөдөл гаргагчтай ярилцлагын шатны зохицуулагч холбогдож, ярилцлагын цаг товлодог.

Шалгалтын аль нэг үе шатыг давсан өргөдөл гаргагч процесс эсвэл үнэлгээнд томоохон өөрчлөлт гарснаас бусад тохиолдолд тухайн шатны үр дүнг тодорхойгүй хугацаагаар дахин ашиглах боломжтой. Харин шалгалтын аль нэг үе шатанд тэнцээгүй өргөдөл гаргагч шалгалтад тэнцээгүй өдрөөс хойш хоёр жилийн дараа дахин шалгалт өгөх боломжтой.

3.3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын цагдаагийн алба хаагчид их сургуулиа төгсөөд цагдаагийн байгууллагад олон чиглэлээр ажлын гараагаа эхэлдэг. Эрүүгийн мөрдөгчөөр ажиллах эхний үед тусгай мэдлэг шаардагдахгүй. Харин ажиллах салбар, гэмт хэргийн төрлөөс хамааран (жишээлбэл, эдийн засаг, байгаль орчны эсрэг, галдан шатаах, төрийн хамгаалалт, хар тамхины гэмт хэрэг зэрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад тусгай мэдлэг шаардана.) тусгайлсан сургалтад эртнээс хамрагддаг.⁸⁵

Эдгээр сургалтыг ихэвчлэн их сургуулиас зохион байгуулдаг боловч сэдвээс хамаарч Холбооны цагдаа эсвэл муж улсын цагдаагийн газраас зохион байгуулна. Мөрдөгч болохын тулд шалгалт өгөх шаардлагагүй байдаг. Хязгаарлагдмал тооны буюу дунджаар 10-20 цагдаагийн алба хаагч бакалаврын сургалтаа төгссөн даруйдаа эрүүгийн мөрдөн байцаах багт элсдэг.⁸⁶ ХБНГУ-д цагдаагийн алба хаагч мөрдөн байцаах албанд элсэхээсээ өмнө цагдаагийн байгууллагад цагдаа мэргэжлээрээ хэдэн жил “ердийн” алба хаах ёстой байдаг ба хэд хэдэн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдаг тул нэмэлт шалгалт өгөх шаардлагагүй гэж үздэг.

Гэхдээ ХБНГУ-д мөрдөгч болохын тулд мөн ч цагдаа байх шаардлагатай байх бөгөөд цагдаа болохын тулд тусгай шалгалтуудыг өгсөн байдаг. Иймд цагдаад тавигдах шаардлага, сонгон шалгаруулалтын талаар мөн авч үзье. Сэтгэлзүйн оношилгооны тест нь сонгон шалгаруулах үйл явцын эхний хэсэг юм. “The psychodiagnostic test”⁸⁷ буюу сэтгэл зүйн шалгалт нь сонгон шалгаруулалтын хамгийн эхний үе шат болдог. Энэхүү шалгалт нь бичгийн чадамжийн шалгалт бөгөөд бүхэлдээ компьютероор авдаг. Оногдсон даалгаврыг тодорхой хугацаанд гүйцэтгэдэг ба тэнцсэн хүмүүс дараагийн шатны шалгалтуудад хамрагдах эрхтэй. Уг шалгалт нь дедуктив болон аналитик сэтгэлгээг шаарддаг янз бүрийн бүлгийн даалгавруудыг агуулсан байдаг ба танин мэдэхүйн ерөнхий чадвар, хэл зүйн чадваруудыг шалгадаг.

85 Police education and training systems in the OSCE region, 2018, Холбооц: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

86 Мөн тэнд.

87 Psychodiagnostischer Test, Холбооц: https://www.karriere.bka.de/Karriereportal/DE/Bewerbung/Auswahlverfahren/PsychodiagnostischerTest/PsychodiagnostischerTest_node.html, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

Танин мэдэхүйн ерөнхий шалгалт

Уг шалгалт нь дедуктив үндэслэл шаарддаг өөр өөр бүлгийн даалгавруудаас бүтдэг. Ялангуяа танин мэдэхүйн чадвар, логик болон дүрслэн бодох чадварыг шалгана.

Үүнийг ерөнхийдөө гурван ажлын талбарт хувааж болно. Хэл зүйн чадварыг шалгахын тулд утга төгөлдөр өгүүлбэр зохиож, зүйрлэл, ижил төстэй байдлыг тодорхойлдог. Цаашилбал, тоо бодох чадварыг шалгадаг. Үүнд тоонуудын эгнээ нэмэх эсвэл арифметик тэмдэгтүүдийг зөв байрлалд оруулах хэрэгтэй. Сүүлийн талбар бол дүрслэн бодох даалгавар бөгөөд энд жишээ нь шооны даалгавар, матрицыг шийдвэрлэнэ.

Анхаарал төвлөрөлтийн шалгалт

Анхаарал төвлөрөлтийн шалгалт нь анхаарлаа төвлөрүүлэх, анхааралтай ажиллах чадварыг шалгадаг. Даалгаврыг 10 минутын дотор аль болох хурдан, алдаагүй гүйцэтгэх ёстой. Жишээлбэл, энэхүү шалгалт нь арифметикийн хүнд даалгавартай байж болно.

Герман хэлний шалгалт

Герман хэлний шалгалтад герман хэлний зөв бичих дүрэм, хэл зүйн ерөнхий дүрэм, үгийн утгын талаарх даалгавруудыг 15 минутын хугацаанд гүйцэтгэдэг. Зөв бичих дүрмийн эргэлзээтэй үг бүхий даалгаврууд багтана.

Нийгмийн асуудлын үнэлгээ

Нийгмийн асуудлыг үнэлэх шалгалтын үргэлжлэх хугацаа ойролцоогоор 5 минут байна. Үүгээр нийгмийн асуудлуудад хандсан тайлбар, өгүүлэмжийг шалгаж үнэлдэг.

Мөн цагдаагийн албаны тухайн хэлтсээс хамааран өөр өөр сэдвээр ур чадварын шалгалт өгөх шаардлагатай байдаг. Тухайлбал кибер гэмт хэргийн хэлтэст мэдээллийн технологийн ур чадварыг тухайн сэдвийн дагуу өгөгдөл дээр ажиллуулж ур чадварыг шалгадаг.

Явцын дүгнэлт

Мөрдөгчөөр ажиллахад мэргэжил, боловсролоос гадна, ур чадвар, хэл зүй, сэтгэл зүйн зэрэг олон шалгуур хангасан байх шаардлагатай. Монгол Улсад мөрдөгч нь цагдаагийн байгууллагад 4 жил ажилласнаар эсхүл ДХИС-ийг төгссөнөөр томилогдох боломжтой байгаа ч монгол хэл, ур чадварын шалгуурыг хангаж буйг хэрхэн тогтоодог нь тодорхойгүй ба тусгай сонгон шалгаруулалт байхгүй байна. Цагдаагийн алба хаагчид тавигддаг шалгуур үзүүлэлтийг судалж үзэхэд ажлын байрны шаардлага хангасан мэргэжил эзэмшсэн байх, туршлагатай байх, ур чадвартай байх шаардлага тавьсан боловч хангалттай ур чадвартай эсэхийг тогтоох шалгалтын талаар журамд тодорхой тусгаагүй байна.

Харин АНУ-д бичгийн ур чадвар, нөхцөл байдлын үнэлгээ, логикийн зэрэг шалгалтуудыг тухайн мэргэших чиглэлээс хамаарч авдаг бөгөөд бичгийн шалгалтыг голчилж үздэг байна. ХБНГУ-д мөрдөгч болохын тулд тусгай шалгалт өгдөггүй ч цагдаагийн албанд ороходоо танин мэдэхүйн, анхаарал төвлөрөлтийн,

герман хэл, үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг олон чадварыг шалгасан шалгалтыг авдаг. Үүнээс дүгнэхэд дээрх хоёр улсад аль алинд нь хэл зүйн болон бусад тодорхой төрлийн ур чадварыг сайтар шалгадаг байна. Харин Монгол Улсад цагдаагийн алба хаагчийн танин мэдэхүйн үйл явц, зан төлөвийн өөрчлөлтийг тодорхойлох сэтгэл зүйн сорилыг ямар агуулгаар, хэрхэн авч, яаж дүгнэдэг нь тодорхойгүйн дээр иргэний оюун ухааны хөгжлийн түвшнийг сэтгэл зүйч ярилцлагын аргаар дүгнэж буй нь оновчтой бус, бүрэн дүгнэхэд хангалтгүй гэж үзэж байна.

Санал

Энэхүү бүлгийн дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөрдөгчид хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, хууль бус болон дур зоргын баривчилгааны талаарх мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах;
2. Мөрдөгчийн ур чадварыг тухайн ажиллах хэлтэс, нэгжээс хамаарч шалгахаас гадна мөрдөгчөөр ажиллахад шаардагдах тодорхой ур чадварууд тухайлбал, үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээллийг тайлбарлах, шийдвэр гаргах, анхаарал төвлөрөлтийн зэрэг шалгалт авахаар журамлах;
3. Монгол хэлний дүрэм, үгийн сан, бичгээр илтгэх ур чадварыг шалгахын тулд монгол хэлний шалгалтыг бий болгох;
4. Сэтгэл зүйн сорилын агуулга, хэлбэр, хугацаа зэрэг онцлогийг тодорхойлж, дэлгэрэнгүй заах.

IV. ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛЛАГАА БА СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

4.1. Албаны чиг үүрэг гүйцэтгүүлэх ажилд оролцох сонсогчийн эрх зүйн байдал, хүрээг тогтоох хэрэгцээ, шаардлага

Цагдаагийн албан хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллагын суралцагчдыг ЦАТХ-ийн холбогдох хэм хэмжээг үндэслэн зарим тохиолдолд хүч нэмэгдүүлэн цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд дайчлах тухай эрх зүйн зохицуулалт байдаг.⁸⁸ Албан бус мэдээллийн нээлттэй эх сурвалжаас үзэхэд, сонсогчдыг дайчлан ажиллуулах тохиолдол практикт цөөнгүй гардаг⁸⁹ бөгөөд тухайлбал, Ковид-19 цар тахлын үеэр болон нийтээр тэмдэглэх томоохон баярын амралтын өдрүүдэд нэлээд тохиолдсон байна. Ингэхдээ сонсогчдыг гудамж, талбай зэрэг олон нийтийн орчинд хяналт тавих, эргүүл хийх буюу хууль болон журмаар тогтоосон хэм, хэмжээг сахиулах “нийтийн хэв журмыг хамгаалах” албаны чиг үүргийг гүйцэтгэхэд дайчлан оролцуулжээ.

Мөн албан бус эх сурвалжуудын мэдээлснээр, цагдаагийн албаны чиг үүрэгт үл хамаарах ажилд сонсогчдыг дайчлан ажиллуулах тохиолдол ч гардаг⁹⁰ төдийгүй ингэхдээ сонсогчдыг сайн дурын үндсэн дээр хэрэгжих ёстой ажилд практикт дайчилгааны шинж чанартай ажиллуулдаг⁹¹, түүнчлэн ажил үүрэг гүйцэтгэсэн цалин, хөлсийг хангалттай олгодоггүй зэрэг асуудлууд хөндөгддөг байна. Энэ нь сонсогчдын эрх зүйн байдал, тэдгээрийн эрх, үүргийг хууль болон журмаар нарийвчлан зохицуулаагүй буюу уг төрлийн эрх зүйн харилцааны зохицуулалт хангалтгүй, дутмаг байгаатай шууд холбоотой юм.

88 Цагдаагийн албаны тухай хууль 67 дугаар зүйлийн 67.4.Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагч болон 18 насанд хүрсэн суралцагчийг онцгой тохиолдолд нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцуулж болох бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн алба хаагчид хуулиар олгосон баталгаа тэдгээрт нэгэн адил хамаарна.

89 “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Цагдаа, Дотоодын цэрэг, Дотоод хэргийн их сургуулийн сонсогч нийлсэн 6000 орчим алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа билээ.” Хөл хорио ба цагдаа нар нийтлэл, 2020.11.20, Холбоос: <https://news.mn/r/2374739/>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

“Улаанбаатар хотод бүх нийтийн бэлэн байдал зарласан энэ үед өдөрт 3,000 орчим цагдаагийн алба хаагч, 1,000 гаруй сонсогч явган зорчигчийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих чиглэлээр үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа юм.” Гудамж талбайд үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч болон сонсогч нарт халдаг улавч өгчээ, 2021.01.08, Холбоос: <https://ikon.mn/n/23ch>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

“Тийн унжлагат хэмээх шороон нохой жилийн Сар шинийн баярын өдрүүдэд Их сургуулийн захирлын тушаалаар Цагдаагийн сургууль, Ахлагчийн сургуулийн нийт 700 сонсогч 02 дугаар сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд 14 цагдаагийн хэлтэст хуваарилагдан эргүүл, хамгаалалтад хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгэхээр боллоо.” Сар шинийн баярын өдрүүдэд их сургуулийн 700 сонсогч эргүүл, хамгаалалтад үүрэг гүйцэтгэнэ, 2018.02.14, Холбоос: <https://www.facebook.com/775810089179511/posts/1633317106762134/>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

90 Сонсогчдыг дайчлан ажиллуулах, түний практиктэй холбоотой зарим асуудлаар мэдээ, мэдээлэл авах зорилгоор холбогдох эрх бүхий байгууллага, алба хаагчдад хандсан боловч тус сэдвээр мэдээлэл өгөхөд нээлттэй бус байх, дэлгэрэнгүй мэдээлэл, статистик тоо баримт дутмаг байх зэрэг харилцаа, хандлага ажиглагдаж байна.

91 “Ургац хураалтыг технологийн хугацаанд гүйцэтгэх зорилгоор их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн оюутан, сонсогч, цэргийн алба хаагч болон бусад иргэдийг сайн дурын үндсэн дээр ургац хураалтын ажилд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авна.” Ургац хураалтад оюутан, сонсогч, цэргийн алба хаагч болон иргэдийг сайн дураар оролцуулна”, 2020.07.20, Холбоос: <https://ikon.mn/n/2m7m>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

Ийнхүү суралцагчийг дайчлан ажиллуулдаг практик нь эрх зүйн үндэслэл болж буй хэм хэмжээтэйгээ нийцэж буй эсэх, тухайлбал ямар нөхцөл байдал үүссэн үед суралцагчийг дайчлан ажиллуулах, цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэх үеийн суралцагчийн эрх зүйн байдал зэргийг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Учир нь цагдаагийн алба нь төрийн нэрийн өмнөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг⁹², зарим тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэдэг⁹³ төрийн тусгай алба бөгөөд энэ ч утгаараа цагдаа болон бусад хүн, эрх зүйн этгээдийн хооронд үүсэж буй харилцаанд тэдгээрийн эрх хэмжээ, үүргийн хүрээ хязгаарыг хуулиар нарийвчлан тогтоох шаардлагатай. Цаашлаад энэ нь хууль, эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй, дутмаг байдлын улмаас сонсогчдын эрх, эрх чөлөө зөрчигдөж болзошгүй эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг ба цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал

Цагдаагийн алба нь “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дараах үндсэн гурван үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн тусгай алба юм. Үүнд:

1. Гэмт хэрэгт тэмцэх;
2. Нийтийн хэв журам хамгаалах;
3. Олон нийтийн аюулгүй байдлын хангах.

Тус хуулийн цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай Наймдугаар бүлгийн 68 дугаар зүйлийн 2-т цагдаагийн алба хаагч нь дээрх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий эрх зүйн этгээд хэмээн тодорхойлжээ.

Мөн хуулийн “Нэр томьёоны тодорхойлолт” гэсэн 3 дугаар зүйлд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн гурван чиг үүргийг тодорхойлсон байна. Мөн хуулийн 10, 11, 12 дугаар зүйлд дээрх үндсэн чиг үүргүүдийн талаар дэлгэрэнгүй зохицуулалт тусгасан. Цагдаагийн алба хаагчийн чиг үүргээ хэрэгжүүлж байх үеийн эрх зүйн байдлыг тус хуулийн Наймдугаар бүлэгт дэлгэрэнгүй хуульчилсан бөгөөд 83 дугаар зүйлийн 1-т “Цагдаагийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан баталгаагаар хангагдана.” гэж заасан байна.

4.2. Суралцагчийг цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажиллагаанд оролцуулах эрх зүйн орчин

ЦАТХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын...18 насанд хүрсэн суралцагчийг онцгой тохиолдолд нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцуулж болох бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн алба хаагчид хуулиар олгосон баталгаа тэдгээрт нэгэн адил хамаарна.”

92 Цагдаагийн албаны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

93 Мөн тэнд, Тавдугаар бүлэг “Албадлагын арга хэмжээг хэрэглэх”

Дээрх заалтын дагуу нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцож буй 18 насанд хүрсэн суралцагч нь тус үүргийг гүйцэтгэх хугацаандаа эрх зүйн байдлын хувьд ЦАТХ болон Төрийн албаны тухай хуульд заасан баталгаагаар цагдаагийн алба хаагчийн нэгэн адил хангагдахаар байна. Үүнээс гадна уг хэм хэмжээ нь ЦАТХ-ийн цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн Наймдугаар бүлгийн “Цагдаагийн албан тушаалд томилох” гэсэн 67 дугаар зүйлд хуульчлагдсан байгаагаас үзэхэд ийнхүү онцгой тохиолдолд нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцож буй 18 насанд хүрсэн суралцагч нь эрх зүйн байдлын хувьд цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг болон баталгааг нэгэн адил эдлэхээр ойлгогдож байх боловч түүний хүрээ хязгаар, хэрэгжих журам зэргийг нарийвчлан тогтоосон зохицуулалт одоогоор байхгүй байна.

Эрх зүйн үндэслэл

ЦАТХ-ийн 67.4-т “Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын18 насанд хүрсэн суралцагчийг онцгой тохиолдолд нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцуулж болох бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн алба хаагчид хуулиар олгосон баталгаа тэдгээрт нэгэн адил хамаарна.” гэж зааснаас үзэхэд тус хуулийн заалт хэрэгжих нөхцөлийг дараах байдлаар ойлгож болохоор байна. Үүнд:

- Онцгой тохиолдолд байх;
- Нийтийн хэв журам хамгаалах ажил байх;
- 18 насанд хүрсэн суралцагч байх;

Дээрх хуулийн заалт үйлчлэх нөхцөлийг тус хуульд нэмэлтээр тухайлан дэлгэрэнгүй тайлбарласан заалт байхгүй тул бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдээс дараах байдлаар тодруулга хийж болохоор байна.

Хүснэгт 4.8. ЦАТХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх хэсэг хэрэгжих нөхцөлийн дэлгэрэнгүй тодруулга

№	Хэрэгжих нөхцөл	Тайлбар
1	Онцгой тохиолдол байх	Цагдаагийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуулиудад тус нэр томъёог тайлбарласан, дэлгэрэнгүй зохицуулсан хэм хэмжээ одоогоор байхгүй байна.
2	Нийтийн хэв журам хамгаалах ажил	ЦАТХ-ийн 3.1.2. <i>“нийтийн хэв журам хамгаалах” гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг;</i>
3	18 насанд хүрсэн суралцагч байх	<i>Дээд боловсролын тухай хуулийн 4.1.2. «дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч» /цаашид «суралцагч» гэх/ гэж дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагч оюутан, магистрын хөтөлбөрөөр суралцагч магистрант, докторын хөтөлбөрөөр суралцагч докторантыг.</i>

Дээрх хуулийн зохицуулалтын дагуу нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцож буй 18 насанд хүрсэн суралцагч нь тус үүргийг гүйцэтгэх хугацаандаа эрх зүйн байдлын хувьд ЦАТХ болон Төрийн албаны тухай хуульд заасан баталгааг цагдаагийн алба хаагчийн нэгэн адил эдэлнэ гэсэн ерөнхий зохицуулалтаас өөр дэлгэрэнгүй зохицуулалт байхгүй байна. Мөн хуулийн заалт үйлчлэх нөхцөлд тодотгон зохицуулах шаардлага байгаа нь хуулийн заалт дахь “онцгой тохиолдол” гэдэгт ямар нөхцөл байдлыг ойлгох, нөхцөл байдал бүрийг тоочиж эсхүл хүрээ

хязгаарыг нь тогтоож тодотгосон заалт тус хууль болон холбогдох бусад хууль, журамд байхгүй, цагдаагийн албаны ажилд суралцагчийг татан оролцуулахад зөвхөн “нийтийн хэв журам хамгаалах” ажил л хамрахаар зохицуулагдсан мэтээр ойлгогдож байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЦАтХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг эс тооцвол “суралцагч”, “сонсогч” гэсэн илэрцтэй нийт 5 зохицуулалт байх боловч эдгээрээс цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн эрх зүйн байдал, чиг үүргийн талаар дэлгэрэнгүй зохицуулсан хэм хэмжээ хуульд байхгүй байна.

Суралцагчийн үйлдвэрлэлийн дадлага

Цагдаагийн төв байгууллагаас холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргадаг “Цагдаагийн Байгууллагын Үйл Ажиллагааны Журам”-ын (2022) Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх код 118-ын 118.6 дугаар зүйлийн 5-д⁹⁴ заасны дагуу оюутны цагдаагийн байгууллагад хийх танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг зохион байгуулахтай холбогдох харилцааг “Цагдаагийн мэргэжлийн сургуулийн сонсогчийн дадлагын журам” код 945-аар зохицуулна. Уг код 945 дугаар зүйлийн дадлагын ажил гүйцэтгэж буй суралцагчийн эрх, үүргийг заасан 7 дахь хэсгийн 2 а/ -д суралцагч нь цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн албан үүргийг шууд гүйцэтгэхийг хориглоно гэж зааснаас үзэхэд цагдаагийн алба хаагч бэлтгэх дээд боловсролын байгууллагын сонсогч буюу суралцагчийн клиник, танилцах, үйлдвэрлэлийн дадлага нь ЦАтХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “суралцагчийг онцгой тохиолдолд нийтийн хэв журам хамгаалах ажилд оролцуулж” буй тохиолдол биш гэж үзэхээр байна. Гэхдээ дадлагын журмын 945.7.2.б/-д буй “суралцагч нь цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн албан үүргийг шууд гүйцэтгэхийг хориглоно” гэсэн заалтын “шууд бус гүйцэтгэл” гэдэг агуулгыг тодруулах хэрэгцээ, шаардлага мөн урган гарч байна.

4.3. Гадаад улсын жишиг

Олон улсын жишгээс үзэхэд цагдаагийн алба хаагч бэлтгэх дээд боловсролын байгууллагын суралцагч буюу сонсогчийг суралцах хугацаанд нь албаны чиг үүргийг шууд гүйцэтгүүлэхээр цагдаагийн албаны чиг үүрэг, эрх зүйн байдлыг тогтоосон органик хуульдаа хуульчилсан улс орон харьцангуй цөөн байна. Харин албаны чиг үүрэг гүйцэтгэх ажиллагаанд сонсогчийг татан оролцуулах нөхцөлийг цагдаагийн албаны тухай хуульдаа хуульчилсан орнуудаас сонсогчийн албаны чиг, үүргийг гүйцэтгүүлэх нөхцөл, ийнхүү гүйцэтгэх үе дэх эрх зүйн байдлыг нэлээд дэлгэрэнгүй, тодорхой хуульчилсан жишиг болохуйц орнуудын нэг нь Бүгд Найрамдах Эстони улс байна. Манай улстай адил парламентын засаглалтай, харьцангуй цөөн хүн амтай, эрх зүйн тогтолцооны хувьд эх газрын бүлд хамаардаг зэрэг шалтгааныг харгалзан тус улсын цагдаагийн албаны тухай хууль тогтоомжийг харьцуулсан судалсан.

94 118.6.5.Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их, дээд сургууль, академид суралцаж байгаа сонсогч, алба хаагч, бусад энгийн их, дээд сургуулийн оюутныг цагдаагийн байгууллагад хийх танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг зохион байгуулахтай холбогдох харилцааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 945-д зааснаар зохицуулна.

Хүснэгт 4.9. Гадаад орнуудын цагдаагийн албаны тухай хууль дахь сонсогчийн эрх зүйн байдлын зохицуулалт

Бүгд Найрамдах Эстони Улс
Цагдаа, хил хамгаалах албаны тухай хууль ⁹⁵
<p>§ 37. Сонсогч</p> <p>“Сонсогч” гэж дунд боловсролын үндсэн дээр мэргэжлийн сургалтаар боловсрол эзэмшиж буй болон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах цагдаа, хилчин мэргэжлийг эзэмшихээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй цагдаагийн байгууллагад харьяалалгүй оюутан.</p> <p>§ 44. Ажиллах хугацаа</p> <p>(3) Дараах хүмүүсийг тодорхой хугацаагаар албан тушаалд томилж болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. өөр дээд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшсэн боловч мэргэжлийн боловсролгүй цагдаагийн алба хаагч - мэргэжлийн сургалтад хамрагдах хугацаанд; 2. мэргэжлийн болон бусад дээд, мэргэжлийн боловсролгүй цагдаагийн алба хаагчийг мэргэжилтний албан тушаалд - мэргэжлийн дээд, мэргэжлийн боловсрол эзэмших хугацаанд; 3. цагдаагийн ажилтан - түр зуурын үүрэг гүйцэтгэх хугацаанд; мөн сонсогч – практик сургалтын хугацаанд. <p>(4) Ажилласан хугацааг сар, жилээр тооцно.</p> <p>§ 45. Цагдаагийн алба хаагчийн тангарга</p> <p>(6) Сонсогч анхны дадлага хийхээс өмнө тангараг өргөнө.</p> <p>§ 60. Сонсогчийн эрх зүйн байдал</p> <ol style="list-style-type: none"> (1) Практик сургалтын хугацаанд сонсогчийг энэ хуулийн 44 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу орон тооны бус цагдаагийн ажилтны албан тушаалд томилно. Практик сургалтын үеэр Төрийн албаны тухай хуулийн 44, 45, 48–51, 53–60 дугаар хэсэг, энэ хуулийн 2¹ дүгээр бүлэг, Хууль сахиулах тухай хуулийн 5 дугаар бүлэг, түүнчлэн 71, 74, 76–78¹, Энэ хуулийн 83-92 дугаар зүйл сонсогчид хамаарна. (2) Захиргааны акт эсхүл өөрийн санаачилга эсхүл гэмт хэргийн хохирогчийн хүсэлтээр цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэж буй сонсогчид энэ хуулийн 2¹ дүгээр бүлэг болон Хууль сахиулах тухай хуулийн 5 дугаар бүлэг, энэ хуулийн 71, 74, 76–78¹, 83–92 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн баталгаа, эрх, үүрэг хариуцлага цагдаагийн алба хаагчтай адил хамаарна. (3) Үүрэг гүйцэтгэж байсан сонсогчийн эрүүл мэндэд хохирол учирсан, амь хохирсон тохиолдолд төрийн албаны тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 7, 10 дахь хэсэгт заасан тэтгэмжийг тогтоох, тооцох үндэслэл нь хэрэг явдал болох үед мөрдөж байсан цагдаагийн албан хаагчийн цалингийн нэгдүгээр зэрэгт тохирсон цалингийн жишиг байна. (4) Сонсогчийн суралцах болон практик дадлагын хугацаанд сургалтын тэтгэлэг олгоно. Практик дадлагын хугацаанд цалин, хөлс олгохгүй. Сургалтын тэтгэлгийн хэмжээ, түүнийг олгох нөхцөл, журмыг салбар хариуцсан сайд журмаар тогтооно. <p>69¹. Сургалтын зардлыг сонсогч нөхөн төлөх</p> <ol style="list-style-type: none"> (1) Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мэргэжилтэн бэлтгэх дээд боловсролын байгууллагаас хасагдсан хүнээс дараах тохиолдолд төрөөс гаргасан сургалтын зардлыг нөхөн төлүүлэхийг шаардаж болно.

95 The Republic of Estonia, Police and Border Guard Act, Passed 06.05.2009, RT I 2009, 26, 159, Entry into force 01.01.2010, partially 01.01.2012, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/511112019003/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.20.

1. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтын үйл ажиллагаагаа зогсоосон;
2. сурлагын ахиц дэвшил хангалтгүйн улмаас сургуулиас хасагдсан;
3. сахилгын зөрчил үйлдсэний улмаас сургуулиас хасагдсан;
4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагыг төгссөнөөс хойш 3 сарын дотор төрийн албанд ажилд ороогүй;
5. шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц төрийн албанаас чөлөөлөгдсөн;
6. сахилгын зөрчил гаргасан, ажил олгогчийн итгэлийг алдсан үйлдлийн улмаас төрийн албанаас чөлөөлөгдсөн;
7. өөрийн хүсэлтээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төрийн албанаас чөлөөлөгдсөн.

(2) олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах мэргэжилтэн бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагаас хасагдсан хүн дараах тохиолдолд суралцахад төрөөс гаргасан сургалтын зардлыг нөхөн төлөх шаардлагагүй.

1. дээр дурдсан үндэслэлээр хасагдсаны дараа тухайн хүн эрх бүхий байгууллагад ажилд орсон буюу төрийн албанд нэг стандарт суралцах хугацаатай тэнцэх хугацаагаар ажилласан;
2. хөдөлмөрийн чадваргүй, хөгжлийн бэрхшээлтэй, тэтгэврийн насны, хувийн тусламж, хяналт шаардлагатай гэр бүлийн гишүүнээ асран хамгаалах хэрэгцээ шаардлагаас үүдэн ажил, үүргээсээ чөлөөлөгдсөн;
3. тухайн хүн олон нийтийг хамгаалах мэргэжилтэн бэлтгэх дээд боловсролын байгууллагад дотоод аюулгүй байдлын чиглэлээр сургалтын хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж байгаа.

(3) Олон нийтийн аюулгүй байдлыг хангах мэргэжилтэн бэлтгэх дээд боловсролын сургуулиас хасагдсан хүнд сургалтын зардлын тухай мэдэгдэл өгч, үүний үндсэн дээр сургалтын зардлыг нөхөн төлүүлнэ. Хэрэв тухайн хүн зардлаа нөхөн төлөхөөс татгалзвал сургалтын зардлын тухай мэдэгдлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2-р зүйлийн 1-ийн 21-д заасан шийдвэр гүйцэтгэх хэрэгсэл гэж үзнэ.

(4) Боловсролын зардлын мэдэгдлийн дагуу цуглуулсан боловсролын зардлыг албадан хэрэгжүүлэх хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байна. Хөөн хэлэлцэх хугацаа нь боловсролын зардлыг нөхөн төлүүлэх баримт бичгийг хүргүүлснээс хойш эхэлнэ.

(5) Боловсролын зардлыг тооцох нөхцөл, журам, нөхөн төлбөрийн хэмжээг тухайн салбарын сайдын тушаалаар тогтооно.

§ 80. Мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагч офицер болон сонсогчийг олон нийтийг хамгаалах ажилд татан оролцуулах

(1) Цагдаа, хил хамгаалах зөвлөлийн ерөнхий дарга нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах мэргэжилтэн бэлтгэх дээд боловсролын байгууллагын захиралтай зөвшилцсөний үндсэн дээр энэ хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд олон нийтийг хамгаалах ажилд мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагч офицер болон сонсогчийг олон нийтийг хамгаалах ажилд татан оролцуулах эрхтэй.

(2) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагч офицер болон сонсогчийг олон нийтийг хамгаалах ажилд татан оролцуулахыг албан үүргээ гүйцэтгэхээр томилолтод явсанд тооцохгүй.

§ 77. Цагдаагийн алба хаагч илүү цагаар ажиллах

(1) Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд амралтын болон нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд илүү цагаар ажиллах эрх бүхий байгууллагын даргын тушаалыг биелүүлэх үүрэгтэй.

1. үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор;
2. үндэсний батлан хамгаалах зорилгоор;
3. хүний амь насыг аврах, аврах ажиллагаа явуулах, хүмүүсийг эрэн хайх;
4. байгалийн гамшиг, гал түймэр, осол, сүйрлээс урьдчилан сэргийлэх, түүний үр дагаврыг арилгах;
5. онцгой шинж чанараас шалтгаалан түр зогсоох, дуусгах боломжгүй яаралтай чиг үүргийг гүйцэтгэхийн тулд;
6. олон нийтийн эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор;
7. хуульд заасан бусад тохиолдолд.

БНЭУ-ын хувьд “Цагдаа, хил хамгаалах албаны тухай хууль”-даа “Сонсогч” хэмээх нэр томъёог шууд тайлбарласан төдийгүй цагдаагийн мэргэжилтэн бэлтгэх дээд боловсролын байгууллагын сонсогчийг цагдаагийн албанд ажиллуулах үеийн зохицуулалтыг манай улстай адил хийсэн байна. Түүнчлэн сонсогчийн суралцах хугацааны сургалтын зардалтай холбоотой харилцааг нэлээд дэлгэрэнгүй зохицуулжээ. Сонсогчийн эрх зүйн байдлыг дээр дурдсан хууль болон бусад хамаарах хуулиудад нэг бүрчлэн эш татах байдлаар тусгаж, албан үүрэг гүйцэтгэх үед сонсогчийн эдлэх эрх, үүрэг, баталгаа зэргийн хүрээ хязгаарыг нарийвчлан тогтоосон төдийгүй сонсогч сайн дураараа албаны чиг үүрэг гүйцэтгэх ажиллагаанд оролцож болох эрх хэмжээг мөн хуульчилсан. Мөн ямар тохиолдол, нөхцөл байдал үүссэн үед сонсогчийг албаны чиг үүрэгт татан оролцуулах харилцааг нэг бүрчлэн тогтоож, ийнхүү дайчлах шийдвэр гаргах эрх бүхий этгээдүүд, тэдгээрийн эрх хэмжээ зэргийн тодорхой зохицуулсан байна.

Явцын дүгнэлт

Монгол Улсын хувьд цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтоосон органик хууль болох ЦАТХ-д цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын 18 насанд хүрсэн суралцагчийг цагдаагийн албаны чиг үүрэг гүйцэтгүүлэхэд татан оролцуулах, ийнхүү оролцоход суралцагч нь цагдаагийн алба хаагчтай нэгэн адил хуулиар олгосон баталгааг эдлэх эрх зүйн үндсийг тогтоосон байна. Гэвч тусгай албаны чиг үүргийг гүйцэтгүүлэхэд сонсогчийг оролцуулах нөхцөл, журам, түүний эрх, үүргийн хүрээ хязгаарыг хуульчлан журамлаж тодорхой болгох хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. Судалгаанд дурдсан гадаад орны хувьд суралцагчаар албаны чиг үүрэг гүйцэтгүүлэх үндэслэл, тохиолдол, тус төрлийн шийдвэр гаргах журам, суралцагч албаны чиг үүрэг гүйцэтгэх үеийн эрх зүйн байдал төдийгүй төрийн хариуцан гаргаж буй сургалтын төлбөр, албаны чиг үүрэг гүйцэтгэх үеийн цалин хөлс, нөхөн төлбөрийн харилцааг ч нарийвчлан зохицуулсан туршлага байна. Иймд уг асуудлыг зайлшгүй анхаарч хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэл хийх шаардлагатай бөгөөд энэ нь цагдаагийн алба төдийгүй нийгэм, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хүний эрхийг хангах, иргэд, сонсогчдын эрх ашгийг хамгаалах харилцаанд чухал ач холбогдолтой юм.

Санал

1. ЦАТХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх заалт дахь “Онцгой тохиолдол” гэсэн нэр томъёоны агуулгыг тодорхойлох. Уг заалтын агуулгыг нарийвчилж тогтоох;
2. ЦАТХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх заалтад дурдсан чиг үүргийг гүйцэтгэж буй сонсогч нь тус хуулиар тогтоосон цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалтай адил эрх хэмжээтэй байх тухай хуулийн заалтын агуулгыг тодорхой болгох;
3. ЦАТХ-д цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийг дайчлах нөхцөл, тохиолдлуудыг хуульчлах;
4. ЦАТХ эсхүл холбогдох хууль, журамд албаны чиг үүрэг гүйцэтгэх ажиллагаанд оролцож буй сонсогчийн эрх зүйн байдлыг тухайлан тусгах;
5. Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийг цагдаагийн албаны чиг үүрэг

хэрэгжүүлэхэд татан оролцуулах эрх бүхий этгээд болон татан оролцуулах журмыг хуульчлах, эсхүл түүний эрх зүйн үндсийг хуульд бүрдүүлж, түүнд тулгуурлан холбогдох үйл ажиллагааны процессыг журамлах;

6. Цагдаагийн албаны үйл ажиллагааны журмын дадлагын журмын код 945.7.2.б/-д буй “суралцагч нь цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн албан үүргийг шууд гүйцэтгэхийг хориглоно” гэсэн заалтын “шууд бус гүйцэтгэл” гэдэг агуулгыг тодорхойлох;
7. ЦАТХ-ийн 67 дугаар зүйлийн 4 дэх заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийж, цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд сонсогчдыг татан оролцуулж буй практикийг шинжлэн судалсны үндсэн дээр холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, цагдаагийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд сонсогчдын эдлэх эрх, гүйцэтгэх үүргийг тодорхой хуульчлах, зааварчилгаа зэрэг арга зүйн баримт бичиг боловсруулж ашиглах.

V. ЦАГДААГИЙН АЛБА ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЛБАДАН ТАРААХ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

5.1. Цагдаагийн алба жагсаал цуглаан албадан тараах ажиллагааны үед үүсэж буй хүний эрхийн зөрчил

Судалгааны тус бүлэгт ЦАТХ болон ЖЦХЖТХ-аар зохицуулагдсан цагдаагийн албаны жагсаал, цуглаан албадан тараах ажиллагааг хүний эрхийн зөрчилгүйгээр хэрэгжүүлэх боломжийг нарийвчлан зохицуулах хэрэгцээ, шаардлагыг илрүүлэх зорилгоор практикт гардаг хүний эрхийн зөрчлийн талаар албаны тайлан, мэдээ, статистик тоо баримтад тулгуурлаж тоймлон судлав.

Монгол Улсын түүхэнд иргэдийн жагсаал, цуглаанаас эмх замбараагүй байдал бий болж, жагсаал, цуглааныг албадан тараахын тулд цагдаагийн байгууллага хүч хэрэглэснээр иргэд цагдаагийн алба хаагчдын эсрэг мөргөлдөөн, зөрчил үүсэж улмаар хүний амь нас, эрүүл мэнд, их хэмжээний эдийн болон эдийн бус хохирол учирсан гашуун туршлага бий. Тодруулбал, 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр өрнөсөн олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас 5 иргэн амь насаа алдаж, онцгой байдлын албаны 4, цагдаа, дотоодын цэргийн 393 алба хаагч, мөн 401 иргэний биемахбодид гэмтэл учирч, 155 иргэн, 118 аж ахуйн нэгжид 11,291,6 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна.⁹⁶ Иймээс өдгөө эрх баригчдын зүгээс тайван жагсаал, цуглааныг аль болох намжааж, тараахад чиглэсэн хандлага баримталдаг нь үнэн.⁹⁷

1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх тухай хууль 27 жилийн дараа цаг үеэс хоцорсон, хууль хоорондын хэрэглээний зөрчил гаргадаг хууль болсон байна гэж үзэн “ЖЦХЖТХ-ийн 14 дүгээр зүйлд цагдаагийн алба хаагчид засаг даргын шийдвэргүйгээр тараах, мөн ЦАТХ-ийн 44 дүгээр зүйлд заасан цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө энэ шийдвэрийг тухайн оролцогчдод уншиж танилцуулна гэсэн заалтуудыг хэрэгсэхгүй тараагаад байна. Цагдаагийн алба хаагчийн шаардлагууд жагсаал, цуглаан хийх эрхтэй нийцэхгүй байна”⁹⁸ гэж УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр болсон уг хуулийн хэрэгжилтийн талаарх нийтийн сонсгол дээр дүгнэн хэлжээ.

Сүүлийн үеийн жишээ, баримтаас эш татвал Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл”-д голчлон дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үе дэх иргэдийн тайван хуран чуулах эрхийн зөрчлийн талаар дараах тайлан мэдээг гаргасан байна.

96 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн үндэсний комиссын 10 дахь илтгэл, (УБ, 2011), 61-64 дэх тал.

97 Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төсөлд зориулсан харьцуулсан судалгаа” /Судалгааны тайлан/, (УБ, 2022).

98 Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаар нийтийн сонсгол /2021.12.30/, УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг.

Нийт хүн амын, эсхүл хувь иргэний эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлсэн тохиолдолд төрөөс арга хэмжээ авах боломжийг олгохын тулд нийтийн эрүүл мэндийг хамгаалах үндэслэлээр тайван хуран чуулах эрх чөлөөг хязгаарлаж болно. Энэ үндэслэлээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан олон улсын эрүүл мэндийн дүрэм журмыг анхаарч үзнэ. ... энэхүү хязгаарлалтын хууль ёсны байдал хангагдаагүй, нэг хүний суулт, үзэл бодол илэрхийлэх олон хүний оролцоогүй арга хэмжээг таслан зогсоосныг ХЭҮК-оос хүний эрхийн зөрчил гэж үзсэн юм. “Бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах” гэж тайван хуран чуулах эрх чөлөөгөө хэрэгжүүлж байгаа хүмүүсээс бусад нийгмийн гишүүдийн Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гарцаагүй шаардлагын үүднээс тогтоосон хязгаарлалтыг ойлгоно.⁹⁹

Тус илтгэлд дурдсан, ХЭҮК-т ирсэн мэдээллээр баталгаажсан жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөтэй холбоотой зарим зөрчлүүдийг дор тоймлон хүргэв.

Тохиолдол 1.¹⁰⁰

2022 оны 12, 2023 оны 1 дүгээр сард жанжин Д.Сүхбаатарын талбайд өрнөсөн жагсаал, цуглааны үйл явцад ХЭҮК-оос 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хяналт тавьж, баримтжуулав.

...2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан ерөнхий хяналтын сонсголд оролцуулаагүй гэх шалтгаанаар Төрийн ордны баруун талын хаалганы гадаа (-26) хэмийн хүйтэн орчинд 20 гаруй иргэн нүцгэлэн эсэргүүцэл илэрхийлж, амь нас эрүүл мэнддээ бодитой эрсдэл учруулсан үйлдлийг таслан зогсоож, эрүүл мэндийн тусламж үзүүлэх арга хэмжээ авсан нь хүний эрхийн зарчимд нийцнэ. Харин эдгээр иргэдийг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа Эрүүлжүүлэх, саатуулах төвд эмнэлгийн машинаар хүргэж, улмаар зөрчилд холбогдуулан тайлбар авсан, эмнэлэгт хэвтэхийг санал болгосон, өрөө тасалгаа урьдчилан бэлтгэсэн нь жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах үр дагавартай, хүсэл зоригийг мохоох шинжтэй үйлдэл гэж үзлээ.

...Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Бат-Ирээдүйгийн Нийслэлийн цагдаагийн удирдах газар, ажиллагааны удирдах штабын бүрэлдэхүүнд хүргүүлсэн “Дэмжлэг хүсэх” тухай 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01/635 дугаар албан бичгийн дагуу энэ өдрийн 18.00-19.00 цагийн хооронд Жанжин Сүхбаатарын талбайн Чингисийн хөшөөний урд тайван замаар суулт хийж байсан иргэдийг эрүүл мэндийн байгууллагад албадан хүргэх арга хэмжээг цагдаагийн байгууллага хэрэгжүүлсэн нь хүний халдашгүй чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарласан болно. Дээрх албан бичигт эрүүл мэндийн байдалд ноцтой сөрөг үр дагавар үүсэх эрсдэлтэй хүмүүсийн нэрсийг нэг бүрчлэн дурдаагүй, хэт ерөнхий агуулгатай байсан нь нэр бүхий 28 (тухайн үед ийм тооны иргэд байж таарсан) иргэнийг албадан эмнэлэгт хүргэх хэлбэрээр эрх чөлөөг нь хязгаарлах, улмаар тайван цуглааныг албадан тараах үндэслэл болжээ.

Эмнэлгийн үзлэгээр 21 хүнийг 1 цаг ажиглах, 4 хүнийг 30 минут ажиглах дүгнэлт гарсан бөгөөд нэн даруй эмнэлгийн тусламж үзүүлэх эрсдэлтэй хүн тогтоогдоогүй. Харин 3 хүн үзлэгт орохоос татгалзаж, эрүүл мэндийн байгууллагыг орхин явжээ. Цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй эрсдэл үүсэж болох ч 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс суулт зарласан хүмүүст хийсэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд үндэслэн эрсдэлтэй байж болох иргэдийн нэрсийг нэг бүрчлэн гаргаж, тэднийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах боломжтой байсан. Эрүүл мэнд нь эрсдэлд ороогүй хүмүүст эмнэлгийн тусламж албадан үзүүлэх шийдвэр гаргасан нь хүний эрхийн хязгаарлалт тохирсон байх шаардлагад нийцэхгүй. Мөн тайван суулт хийж байсан иргэдийг эрүүл мэндийн байгууллагад албадан хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цагдаагийн байгууллагаас Д.Сүхбаатарын талбайн орчимд зорчиж явсан зарим иргэдийн эрх чөлөөг хууль бусаар хязгаарлаж, жагсаал цуглааныг албадан тараасан байна.

(2022 оны 12 дугаар сар, 2023 оны 1 дүгээр сард явагдсан “Нүүрсний хулгайн эсрэг” гэх уриатай цуглааны үеийн хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх ХЭҮК-ын дүгнэлтээс)

99 Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байлын талаарх 22 дахь илтгэл, (УБ, 2022).

100 Мөн тэнд.

Тохиолдол 2.¹⁰¹

... 2548 дугаартай зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т заасан, зөрчлийн шинжгүй гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзах тухай тогтоолыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр гаргаж, Сүхбаатар дүүргийн хяналтын прокурор хянаж, баталгаажуулжээ.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд ХЭҮК хяналт тавих үед цуглаанд оролцоогүй хүмүүсийг албадан саатуулсан талаарх мэдээлэл өгсөн. Тухайлбал, 24 настай иргэн “М” “Хүмүүнлэгийн сургуулийн хажуу талын интернэт тоглоомын газар шөнийн 2 цаг хүртэл тоглож байгаад харьж явахдаа Германы ЭСЯ-ны дэргэдээс саатуулагдсан”, 33 настай иргэн “Б” “Эхнэр, хүүхэдтэйгээ машинаар явж байхад талбайн хажууд хүмүүс орилолдоод байхаар нь эхнэр, хүүхдээ машиндаа орхиод сонирхоод очсон. Намайг талбай дээр очих үед 3-4 цагдаа 2 хүүхдийг бүчээд авсан байхаар нь “хүүе, яаж байгаа юм бэ” гэсэн, тэгээд намайг саатуулсан, эхнэр, хүүхэд машиндаа үлдсэн”, 24 настай иргэн “Ж” “МУИС-ын 1 дүгээр байрны дэргэд 4 найзтайгаа машинтай явж байхад цагдаа зогсоогоод шууд баривчилсан. Бид Сүхбаатарын талбай ороогүй, 32-ын тойрог уруу явж байсан” гэсэн нь анхаарал татаж байна. Эдгээр хүмүүсийн зарим нь Комисст өгсөн мэдээллээ баталгаажуулах баримтыг гаргаж өгсөн. ...Цуглааныг албадан тарааж, 50 иргэнийг албадан саатуулсан нь үндэслэлгүй, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байна.

... Комисст иргэдээс өгсөн мэдээлэл, гэрэл зураг, цахим орчинд нийтэлсэн гэрэл зураг, дүрс бичлэгээс иргэдийг баривчлах явцдаа цагдаагийн алба хаагчид зүй бус харьцаж, хүч хэрэглэсэн, хүний бие махбодод халдсан үйлдэл гаргажээ.

(2022 оны 4 дүгээр сард явагдсан “Эх орондоо сайхан амьдаръя” гэх уриатай цуглааны үеийн хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх ХЭҮК-ын дүгнэлтээс)

Цагдаагийн Ерөнхий Газраас ирүүлсэн статистик тоо, баримтаар Монгол Улсын хэмжээнд 2023 оны эхний 4 сарын байдлаар 98 удаагийн 995 цаг үргэлжилсэн, 4264 орчим хүн хамрагдсан жагсаал, цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулагдсан байна.¹⁰²

Хүснэгт 4.10. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны мэдээлэл¹⁰³

Он	Сар	Нийт	Хамрагдсан хүний тоо	Бүртгэгдсэн газар		Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Жагсаал, цуглааны төрөл				
				Нийслэл	Орон нутаг			Суулт	Жагсаал, цуглаан	Өлсгөлөн	Ажил хаялт	Бусад эсэргүүцлийн арга хэмжээ
2023	1	16	385	14	2	1	15	2	10	-	-	4
	2	16	283	11	5	2	14	2	12	-	-	2
	3	36	962	28	8	9	27	2	19	1	1	13
	4	30	2634	25	5	6	24	4	9	1	2	14
	Нийт	98	4264	78	20	18	80	10	50	2	3	33

Нийт жагсаал, цуглаан болон эсэргүүцлийн арга хэмжээний 79.6 хувь нь нийслэлд, 20.4 хувь нь орон нутагт зохион байгуулагдаж, 18.4 хувийг бүртгэлтэй, 81.6 хувийг бүртгэлгүй жагсаал, цуглаан эзэлж байна. 2023 оны эхний 4 сард

101 Мөн тэнд.

102 Эрүүгийн цагдаагийн албаны Нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс бэлтгэсэн жагсаал, цуглааны судалгаа, (2023).

103 ЦЕГ-ын Мэдээлэл, мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүн шинжилгээ, судалгааны хэлтэс, Жагсаал, цуглааны нөхцөл байдал, хэтийн төлөвт хийсэн хэсэгчилсэн дүн шинжилгээ (2023)

зохион байгуулагдсан 98 удаагийн жагсаал, цуглаанд хамрагдсан хүний тооноос авч үзэхэд нэг удаагийн жагсаал, цуглаанд дунджаар 43 хүн хамрагдсан байна.¹⁰⁴

Дээр дурдсан ХЭҮК-ын илтгэл, дүгнэлт зэргээс үзвэл, эрх бүхий байгууллагын зүгээс хуульд заасан нөхцөлийг үндэслэн иргэдийн тайван, жагсаал цуглаан хийх эрхэд хязгаарлалт тогтоох арга хэмжээг хэрэгжүүлсэн байх боловч шийдвэр гаргах болон, албадлагын арга хэмжээг цагдаагийн алба хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тохиолдол гарсаар байгаа нь баримтаар нотлогдож байна. Тиймээс албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл болсон хууль тогтоомж болон тэдгээрт үндэслэсэн үйл ажиллагааны дүрэм, журмуудыг боловсруулахдаа хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой хэм хэмжээг тусгах, нарийвчлан зохицуулах шаардлага байгааг илтгэж байна.

Мөн ЦЕГ-аас ирүүлсэн мэдээллээс үзэхэд, 2023 оны эхний хагаст зохион байгуулагдсан жагсаал, цуглааны тоо болон тэдгээрийн 81.6 хувь нь хуульд заасан жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргах үндэслэл болохуйц бүртгэлгүй байгаа зэрэг нь албадан тараах ажиллагааны журмыг цаашид нарийвчлан боловсруулах хэрэгцээ, шаардлагыг илтгэх бас нэг үзүүлэлт юм.

5.2. Цагдаагийн байгууллагын жагсаал цуглааныг албадан тараах ажиллагааны өнөөгийн эрх зүйн зохицуулалт ба тулгамдсан асуудал

Жагсаал, цуглааныг зохион байгуулах явцад олон нийтийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх чухал чиг үүрэг бүхий байгууллага бол цагдаагийн байгууллага юм. Иймд цуглааныг төлөвлөх, бэлтгэх, зохицуулах бүхий л асуудалд хууль сахиулах байгууллагууд хүний эрхэд суурилсан хандлагыг баримтлах ёстой.¹⁰⁵

Монгол Улсын жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж нь Үндсэн хууль, холбогдох Монгол Улсын олон улсын гэрээ, ЖЦХЖТХ, ЦАТХ зэрэг хууль, тэдгээрт нийцүүлсэн баталсан журмуудаас бүрдэнэ. Албадан тараах ажиллагаа нь жагсаал, цуглаан хийх эрхэд тодорхой үндэслэлээр хязгаарлалт тавьсан тохиолдолд хэрэгжүүлдэг үйл ажиллагаа тул юун түрүүнд уг ажиллагааг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргах суурь буюу 1) эрх бүхий байгууллагаас жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах эрх зүйн үндэслэл; 2) жагсаал, цуглааны үе дэх цагдаагийн албаны чиг үүрэг; 3) албадан тараах ажиллагааны үйл ажиллагааны журмын зохицуулалтын талаар тус тус энэ хэсэгт авч үзье.

1. Эрх бүхий байгууллагын зүгээс жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах эрх зүйн үндэслэлийн тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3-т “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж зохицуулсан байдаг. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх

¹⁰⁴ Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүн шинжилгээ, судалгааны хэлтэс, Жагсаал, цуглааны нөхцөл байдал, хэтийн төлөвт хийсэн хэсэгчилсэн дүн шинжилгээ, (2023).

¹⁰⁵ European Commission for Democracy Through Law (Venice Commission), OSCE/ODIHR, Guidelines on Freedom of Peaceful Assembly (3rd EDITION), Warsaw, 2019.

чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасны дагуу, аливаа жагсаал, цуглаан нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулсан тохиолдолд түүнийг хориглох, хязгаарлах нь зүй ёсны хэрэг юм.

Албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэх журмыг ЖЦХЖТХ-ийн “Жагсаал цуглааныг албадан тараах” гэсэн 14 дүгээр зүйлд Засаг дарга тус хуулийн 8 дугаар зүйлд заасан дараах нөхцөлийн аль нэг нь тогтоогдсон тохиолдолд албадан тараах шийдвэрийг гаргана гэж зохицуулсан. Үүнд:

- Дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалсан шинжтэй болсон;
- эсхүл онц болон дайны байдал зарласан буюу гамшиг болон аюул тохиолдсон үед;
- үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болгох.

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээний баримт бичгүүд болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.” гэсэн бол “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 21 дүгээр зүйлд тайван хуран цуглах эрхийг хязгаарлах онцгой нөхцөлүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Нийгмийн дэг журам /Тус нэр томъёоны тодорхой бус байдлыг ашиглан жагсаал, цуглааныг хориглож болохгүй./;
2. Олон нийтийн аюулгүй байдал / Төр нь олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд энэ үүргийг ямар ч тохиолдолд хурал зохион байгуулагчид даалгаж болохгүй./;
3. Эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах;
4. Бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах;
5. Үндэсний аюулгүй байдал;
6. Терроризм, хэт даврагч үзэлтэй тэмцэх;
7. Онц болон дайны байдал зарлах¹⁰⁶ зэрэг нөхцөл багтана.

Дээрх зохицуулалт нь жагсаал, цуглаантай холбоотой олон улсын хүний эрхийн заавал дагаж мөрдөх хэм хэмжээ юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд зааснаар Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Гэтэл энэ хүрээнд дотоодын хууль тогтоомж болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээний зохицуулалт, агуулгын зөрүүтэй байдлын талаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын 22 дахь илтгэл”-д тусгаж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг өгсөн байна. Эдгээрийг тоймлон авч үзье.

106 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 21-р зүйл.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг боловсронгуй болгох санал¹⁰⁷

ЖЦХЖТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс үгсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах”, 8.1.2 дахь заалтад “үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох” зорилгоор жагсаал, цуглаан зохион явуулахыг хориглох, ийм жагсаал, цуглааныг бүртгэхгүй байх, зохион байгуулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцохоор хуульчилсан.¹⁰⁸ Жагсаал, цуглааны агуулгад тогтоосон дээрх хязгаарлалт нь Монгол Улсын олон улсын гэрээний заалтын хүрээг өргөжүүлсэн байна.

ИБУТЭТОУП-ын 20 дугаар зүйлд илэрхийллийн агуулгын хязгаарлалт тогтоосон нь жагсаал, цуглаанд ч хамааралтай тул дайныг болон алагчлал, дайсагнал, хүчирхийлэлд өдөөн турхирдаг үндсэрхэг үзэл, арьс үндэс, шашин шүтлэгтэй нь холбогдуулан бусдыг үзэн ядах агуулгатай жагсаал, цуглаан хийхийг хориглоно.¹⁰⁹ ЖЦХЖТХ-ийн 8 дугаар зүйлд төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг уриалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж, эмх замбараагүй байдал бий болгох зорилготой жагсаал, цуглааныг хориглохоор заасан нь ИБУТЭТОУП-ын 20 дугаар зүйлд зааснаас өргөн хүрээтэй байна.

Үндсэн хуулийн дэглэмийг өөрчлөх, сонгуулийн тогтолцоог өөрчлөх, Засгийн газрыг огцрох тухай жагсаал, цуглааны шаардлага нь үйл явц тайван өрнөж буй нөхцөлд хууль ёсны илэрхийлэл гэж үзэх тул төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг уриалах зэрэг агуулгын өргөн хүрээтэй хязгаарлалт нь хуулийг дур зоргоор тайлбарлах, тайван хуран чуулах эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах эрсдэлийг үүсгэж болно.

ИБУТЭТОУП-ын 21 дүгээр зүйлийн хүрээнд жагсаал, цуглаанаар илэрхийлэх агуулгыг өргөн хүрээтэй хязгаарлахгүй байх, хуулиар хориглоогүй үзэл бодлыг нийгмийн зарим хэсгийн бухимдал, дургүйцлийг төрүүлэх, цочроохуйц арга хэлбэрээр илэрхийлэхийг тайван гэж үзэж хамгаалах,¹¹⁰ Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг шүүмжилсэн, улс төрийн шинжтэй тайван жагсаал, цуглааныг онцгойлон хамгаалахыг НҮБ-ын Хүний эрхийн хороо тодорхойлжээ.¹¹¹ Үл нийлэх үзэл бодлыг хүлцэн ойлгох нийгмийн хандлага хэврэг, жагсаал, цуглаанаар илэрхийлэхийг хориглоогүй үзэл бодол, “тайван” гэж тооцогдох илэрхийллийн арга хэлбэрийн талаарх ЖЦХЖТХ-ийн зохицуулалт тодорхой бишээс зарим хүмүүст этгээд гойд, тааламжгүй санагдаж, бухимдуулж болох буюу олон нийтийг талцуулж мэдэх боловч Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн гэрээний хүрээнд хамгаалагдах тайван цуглааныг албадан тараах, эд хэрэгслийг хураах, хууль сахиулагчид, иргэд зөрчилдөх тохиолдлууд гарч байна.¹¹² Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн эрүүл мэнд, нийтийн ёс суртахуун, бусад хүний эрх, эрх чөлөө гэх тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болох зургаан үндэслэлийг ИБУТЭТОУП-ын 21 дүгээр зүйлээр тогтоожээ. Өөрөөр хэлбэл, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөнд хуулиар тогтоосон хязгаарлалт нь эдгээр эрх ашгийн нэгийг, эсхүл хамтад нь хамгаалахад үйлчлэх бөгөөд тус бүрдээ хууль зүйн тогтсон агуулга илэрхийлэх хууль ёсны үндэслэлүүдийн агуулгыг дур мэдэн тайлбарлаж болохгүй.¹¹³

107 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл (2022).

108 “Жагсаал, хийх журмын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

109 Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх удирдамж. Венецийн комисс, ЕАБХАБ-ын Ардчилсан институци, хүний эрхийн алба (ЕАБХАБ/ АИХЭА), Страсбург/ Варшав хот (2020 оны 7 дугаар сарын 15-ны өдөр CDL AD(2019)017rev 3 дахь хэвлэл), 150 дахь догол мөр.

110 Тайван жагсаал, цуглааныг илэрхийлж буй агуулга зарим хүмүүсийг бухимдал, дургүйцлийг төрүүлж, оролцогчдын эсрэг хүч хэрэглэхэд хүргэсэн нь тухайн арга хэмжээг тараах үндэслэл болохгүй бөгөөд тэр үзэл бодлоо илэрхийлж буй хүмүүсийг хамгаалах үүрэгтэй, НҮБ-ын Хүний эрхийн хорооны 21 дүгээр зүйлийн талаар гаргасан 37 дугаар Ерөнхий тайлбар, (2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр UN Doc CCPR/C/GC/37), 78, 79 дэх догол мөр.

111 Мөн тэнд, 49 дэх догол мөр.

112 Монгол Улсын Хүний Эрхийн Комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, (2022).

113 Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах үндэслэлийн агуулгыг НҮБ-ын Хүний эрхийн хорооны 37 дугаар Ерөнхий тайлбар, ИБУТЭТОУП-аар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, гэрээний үүргээс ухрахад баримтлах Сиракузагийн зарчмуудаар тодорхойлсон юм.

ЖЦХЖТХ-д тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах журмыг нарийвчлан тусгах шаардлагатай. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хууль ёсны үндэслэлээр хязгаарлах шийдвэр гаргасан албан тушаалтан тухайн нөхцөлд тийнхүү шийдвэр гаргах шаардлага үүссэн болон хязгаарлалт, албадлагыг тохирсон хэмжээнд хэрэгжүүлсэн болохыг өөрийн санаачилгаар эсхүл Комиссын гишүүний саналаар ХЭҮК-т тайлбарлах эрх зүйн зохицуулалт бий болгох нь тайван хуран чуулах эрх чөлөөг хууль бус, дур зоргоор хязгаарлахаас сэргийлэхэд ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагаас тайван жагсаал, цуглааныг үндэслэлгүйгээр албадан тараах, цуглаанд оролцогчдыг бөөнөөр нь албадан саатуулах, баривчлах зэргээр хүний эрхийг зөрчиж байгаагийн нэг шалтгаан нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг хуулиар нарийвчлан зохицуулаагүй, хүний эрхийн хязгаарлалт шаардлагатай, тохирсон байх зарчмыг цагдаагийн алба хаагчид мэддэггүйтэй холбоотой. Жагсаал, цуглааны үеэр нэг буюу хэсэг хүмүүс хүч хэрэглэж, бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь жагсаал, цуглааныг бүхэлд нь тайван бус гэж үзэх, албадан тараах үндэслэл болохгүй юм. Ийм үед зөвхөн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд чиглэсэн албандлыг арга хэмжээ авах нь хүний эрхийн хязгаарлалт тохирсон байх шаардлагад нийцнэ.

Дээр дурдсаныг нэгтгэн дүгнэхэд, Монгол Улсын хуулиар хориглох жагсаал, цуглааны агуулгыг олон улсын заавал дагаж мөрдөх хүний эрхийн хэм хэмжээ болох ИБУТЭТОУП-ын 20, 21 дүгээр зүйлд заасантай нийцүүлэх болон тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг хуулиар нарийвчлан зохицуулах хэрэгтэй гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Жагсаал цуглааныг хууль ёсны дагуу хориглох, түүнтэй холбоотой эрхэд хязгаарлалт тавих нөхцөлийг дээрх хэсэгт дэлгэрэнгүй дурдсан олон улсын хүний эрхийн хэм хэмжээ бүхий баримт бичгүүдэд заасан агуулгад нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар тодорхойлох нь эрх баригчид болон хууль сахиулагчид буюу цагдаагийн алба жагсаал, цуглаантай холбоотой эрх, үүргээ хэрэгжүүлэх ажиллагааныхаа процесс журмыг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээ хязгаараа зөв зохистой тогтооход тус дөхөм болно. Энэ нь цаашилбал цагдаагийн алба албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үед хүний эрх, эрх чөлөө хөндөгдөх, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх хамгийн анхдагч, суурь хүчин зүйл болох юм.

2. Жагсаал, цуглааны үе дэх цагдаагийн албаны чиг үүрэг

ЦАТХ-ийн дагуу цагдаагийн албанд тус хуулийн 68.2-т заасныг үндэслэн 3.1.3, 12 дугаар зүйлд заасан “олон нийтийн аюулгүй байдлыг хангах” үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд тус хуулийн 12.1.2-т “эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх” үүргийг ногдуулсан байдаг. Энэ нь уг эрх, үүргийг хууль сахиулагчдад ногдуулдаг олон улсын жишигт нийцэж байгаа юм.

Харин албадан тараах ажиллагааны процессын хувьд албадан тараах шийдвэрийг зохион байгуулагчдад мэдэгдсэнээс хойш 2 цагийн дотор тараахаас татгалзсан буюу татгалзаагүй боловч уг үйл ажиллагааг дурдсан хугацаа өнгөрсний дараа цаашид үргэлжлүүлбэл жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараана.¹¹⁴ Ийнхүү албадан тараахдаа цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө оролцогчдод бүх төрлийн холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглааныг албадан тараах тухай сум, дүүргийн засаг даргын шийдвэрийг мэдэгдэж, биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд авах арга хэмжээг урьдчилан анхааруулна¹¹⁵ гэсэн заалтыг хуульчилсан байна.

114 “Жагсаал цуглаан хийх журмын тухай” хууль, 14 дүгээр зүйлийн 2,3 дахь хэсэг.

115 “Цагдаагийн албаны тухай” хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

Хүснэгт 4.11. Гадаад орнуудын жагсаал, цуглааны үе дэх цагдаагийн албаны оролцоог хуульчилсан байдал¹¹⁶

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
<p>12-р хэсэг [Цагдаагийн оролцоо]</p> <p>1 Цагдаагийн алба хаагчдыг олон нийтийн жагсаал, цуглаан руу явуулсан бол зохион байгуулагчид өөрийгөө таниулах ёстой. 2 Тэдэнд зохих газар өгөх ёстой.</p> <p>Хэсэг 12a [Цагдаагийн газраас авсан зураг, дууны бичлэг]</p> <p>(1) Олон нийтийн аюулгүй байдал, хэв журамд ноцтой аюул учруулахуйц бодит шинж тэмдэг байгаа тохиолдолд цагдаа нар зөвхөн олон нийтийн цугларалт дээр эсвэл түүнтэй холбогдуулан оролцогчдын дүрс бичлэг, аудио бичлэг хийж болно. 2 Гуравдагч этгээд зайлшгүй нөлөөлсөн тохиолдолд арга хэмжээ авч болно.</p> <p>(2) 1 Баримт бичгийг олон нийтийн цуглаан, түүнтэй шууд холбоотой үйл явдал дууссаны дараа цаг хугацаа, мөн чанарын хувьд нэн даруй устгана, хэрэв шаардлагатай бол 1. Оролцогчдын үйлдсэн эрүүгийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх, 2. Нөлөөлөлд өртсөн этгээдийг олон нийтийн цуглаан дээр болон түүнтэй холбогдуулан эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн, бэлтгэсэн, үйлдсэн гэж сэжиглэж байгаа тул цаашид олон нийтийн жагсаал, цуглаанд ноцтой эрсдэл учруулахаас болгоомжилж байгаа тул аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус тусад нь тохиолдлууд. 2. 1-р өгүүлбэрийн 2-р өгүүлбэрт заасан шалтгаанаар устгагдаагүй баримт бичгийг 1-р өгүүлбэрт заасан зориулалтаар ашиглаагүй бол тэдгээрийг үүсгэснээс хойш гурван жилийн дотор ямар ч тохиолдолд устгах ёстой. (3) Эрүүгийн процессын хууль болон Захиргааны зөрчлийн тухай хуулийн дагуу хувийн мэдээллийг цуглуулах эрх мэдэлд нөлөөлсөн хэвээр байна. 18(3), 19 (4) Цагдаа нар дэг журмыг ноцтой зөрчсөн оролцогчдыг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байж болно. Зохицуулах байгууллагаас гадна цагдаагийн байгууллага, ялангуяа гадаад нөхцөл байдлын улмаас дагалдан явах шаардлагатай үед дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрдөг. Энэ нь ихэвчлэн улс төрийн мэдрэмжтэй жагсаал, цуглааны үеэр тохиолддог бөгөөд үүнээс илүү онцлог шинж чанарууд нь: Цуглааны тухай хуулийн 12 р зүйлийн дагуу цагдаа нар өөрсдийгөө оролцогч биш гэдгээ илчлэх ёстой. Цагдаагийн тухай хууль огт хэрэгжихгүй. Цагдаагийн байгууллага цуглааны тухай хуулийн заалтын дагуу ажиллах ёстой.</p> <p>(3) Эрүүгийн процессын хууль болон Захиргааны зөрчлийн тухай хуулийн дагуу хувийн мэдээллийг цуглуулах эрх мэдэлд нөлөөлсөн хэвээр байна. 18(3), 19 (4) Цагдаа нар дэг журмыг ноцтой зөрчсөн оролцогчдыг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байж болно. Зохицуулах байгууллагаас гадна цагдаагийн байгууллага, ялангуяа гадаад нөхцөл байдлын улмаас дагалдан явах шаардлагатай үед дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрдөг. Энэ нь ихэвчлэн улс төрийн мэдрэмжтэй жагсаал, цуглааны үеэр тохиолддог бөгөөд үүнээс илүү онцлог шинж чанарууд нь: Цуглааны тухай хуулийн 12-р зүйлийн дагуу цагдаа нар өөрсдийгөө оролцогч биш гэдгээ илчлэх ёстой. Цагдаагийн тухай хууль огт хэрэгжихгүй. Цагдаагийн байгууллага цуглааны тухай хуулийн заалтын дагуу ажиллах ёстой.</p> <p>Энэ нь цагдаа нарын дагаж мөрдөх ёстой шаардлагуудыг нарийвчлан тодорхойлдог, жишээлбэл. Хэсэг 12, 12a, 13 Цуглааны тухай хууль. Ингэснээр цагдаа нар видео бичлэг хийх эсвэл цуглааныг тараахыг зөвшөөрдөг. Тэд цуглаанд тохиолддог ердийн аюулын эсрэг стандарт арга хэмжээ авахыг зөвшөөрдөг, тухайлбал оролцогчоос хувийн таних мэдээллийг авах. Хувийн мэдээллийг цуглуулах нь Цагдаагийн тухай хуулийн ердийн арга хэрэгсэл бөгөөд ийм тохиолдолд Цагдаагийн тухай хуулийг онцгойлон хэрэглэх эсэх нь маргаантай байдаг. Үндсэн хуулийн цэцийн тойм нь 15-р зүйлийн дагуу юм. Зөвхөн цуглааны өмнө төдийгүй цуглаан эхэлсний дараа хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрдөг. Цуглаан цуглаан хийхийг бүхэлд нь хориглож болох тул Цагдаагийн тухай хуульд заасны дагуу хөндлөнгийн оролцоо багатай үйл ажиллагаа явуулахыг хууль ёсны дагуу урьдчилан зөвшөөрөх ёстой.</p> <p>13-р хэсэг [Цагдаа жагсаал, цуглааныг тараах]</p> <p>(1) Цагдаа зөвхөн дараах нөхцөлд үндэслэлээ дурдсан тохиолдолд тарааж болно:</p> <p>1. Зохион байгуулагч нь 1-р хэсгийн 1-ээс 4-р зүйлийн 2-т заасан заалтад хамаарах бөгөөд 4-р хэсэгт заасан хоригийг эрх бүхий захиргааны байгууллага тогтоосон бол,</p> <p>2. Цуглаан хүчирхийлэл, эсхүл эмх замбараагүйгээр явах, эсхүл оролцогчдын амь нас, эрүүл мэндэд шууд аюул заналхийлсэн,</p>

116 Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төсөлд зориулсан харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны тайлан (2023).

<p>3. Зохион байгуулагч нь 2-р зүйлийн 3-т заасны дагуу зэвсэг болон бусад эд зүйл авч яваа хүмүүсийг нэн даруй хасаагүй эсвэл хасагдсан эсэхийг баталгаажуулаагүй,</p> <p>4. Цуглааны зан байдал нь гэмт хэрэг, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой аливаа эрүүгийн хуулийг зөрчиж байгаа эсвэл цуглаан нь ийм гэмт хэргийг хөхүүлэн дэмжиж, удирдагч үүнийг даруй таслан зогсоогоогүй.</p> <p>2-оос 4-т заасан тохиолдолд цагдаагийн бусад арга хэмжээ, тухайлбал тасалдуулах нь хангалтгүй тохиолдолд л албадан тараахыг зөвшөөрнө.</p> <p>(2) Цуглаан тарсан гэж мэдэгдмэгц бүх оролцогчид шууд орхин явах ёстой.</p>
<p>Бүгд Найрамдах Солонгос Улс</p>
<p>19 дүгээр зүйл (Цагдаагийн ажилтны нэвтрэх эрх)</p> <p>(1) Цуглаан, жагсаал зохион байгуулагчид мэдэгдсэний дараа дүрэмт хувцастай цагдаагийн алба хаагч жагсаал, цуглаан хийх газар руу орох боломжтой: Хэрэв дотор цуглаан зохион байгуулж байгаа газарт нэвтрэх бол зөвхөн үүргээ биелүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдлоор хязгаарлагдана.</p> <p>(2) Жагсаал, цуглаан зохион байгуулагч, зохицуулагч, эсхүл уг жагсаал, цуглаан хийх газрын хамгаалагч нь дэг журам сахиулах үүргээ биелүүлэхэд цагдаагийн алба хаагчидтай хамтран ажиллана.</p>
<p>20 дугаар зүйл (Жагсаал, цуглааныг тараах)</p> <p>(1) Дараах тохиолдолд цуглаан, жагсаалыг цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга зохих хугацаанд сайн дураараа тараахыг шаардаж болох бөгөөд хэрэв шаардлагыг биелүүлээгүй бол албадан тараана:</p> <ol style="list-style-type: none"> 1. 5 дугаар зүйлийн 1, 10 дугаар зүйлийн үндсэн өгүүлбэр, 11 дүгээр зүйлийн заалтыг зөрчсөн аливаа цуглаан, жагсаал; 2. 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заагаагүй, эсхүл 8, 12 дугаар зүйлийн дагуу хориглосон аливаа цуглаан, жагсаал; 3. 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хязгаарлалт болон энэ зүйлийн заалтад заасан нөхцөлийг зөрчиж, хөдөлгөөний жигд урсгал гэх мэт эмх журам сахиулахад илт заналхийлсэн аливаа цуглаан, жагсаал. 10 буюу 12 дугаар зүйл; 4. 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу дүгнэлтээ зарласан аливаа цуглаан, жагсаал; болон 5. 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үйлдлээс болж эмх цэгцтэй болоогүй аливаа цуглаан, жагсаал. <p>(2) (1)-д заасны дагуу жагсаал, цуглааныг тараахыг тушаасан тохиолдолд бүх оролцогчид цаг алдалгүй газрыг орхино.</p> <p>(3) (1)-д заасан сайн дурын үндсэн дээр тараах, албадан тараах тухай мэдэгдлийн шаардлагатай холбоотой асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.</p>
<p>21 дүгээр зүйл (Жагсаал, цуглааны зөвлөлдөх хороо)</p> <p>(1) Жагсаал, цуглаан хийх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг олон нийтийн амгалан тайван байдал, дэг журмыг сахиулах хэрэгцээтэй тэнцвэржүүлэхийн тулд янз бүрийн түвшний цагдаагийн байгууллага бүрд цуглаан, жагсаалын талаар зөвлөлдөх хороо байгуулж болно. Хороо цагдаагийн байгууллагын даргад дараах асуудлаар зөвлөгөө өгнө.</p> <ol style="list-style-type: none"> 1. жагсаал, цуглаан хийхийг хориглох, хязгаарлах тухай мэдэгдэл; 2. гомдлын талаар гаргасан нэхэмжлэл; 3. Жагсаал, цуглаан хийсэн хэргийг шалгах; 4. Жагсаал, цуглаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх. <p>(2) Хороо нь нэг даргатай байх бөгөөд нийт таваас доошгүй, долоогоос илүүгүй гишүүнээс бүрдэнэ.</p> <p>(3) Хорооны дарга, гишүүдийг дараах хүмүүсийн дундаас мэргэшил, шударга байдлыг харгалзан тухайн түвшний цагдаагийн байгууллагын дарга томилно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуульч; 2. Профессор; 3. Иргэний байгууллагаас санал болгосон хүмүүс; 4. Харьяалагдах нутаг дэвсгэр эсвэл бүс нутгийн оршин суугчдын төлөөлөл. <p>(4) Хороог бүрдүүлэх, ажиллуулах гэх мэт шаардлагатай асуудлуудыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.</p>

Судалгаанд хамрагдсан гадаад орнуудын холбогдох хуульд жагсаал, цуглааны үед цагдаа болон цагдаагийн байгууллагын оролцоо, эрх, үүргийг тодорхой, дэлгэрэнгүй зохицуулсан бол манай улсын хувьд цагдаагийн алба хаагчийн эрх зүйн зохицуулалт нь органик хуульд ерөнхий байдлаар туссан, цагдаагийн албаны тухай хуулиараа зохицуулсан нь дутагдалтай байна. Жагсаал, цуглаан албадан тараах үндэслэл, цагдаагийн алба хаагчийн зорилго, шаардлага тавих, хөндлөнгөөс оролцох үндэслэлүүд нь зөвхөн бусдын эрх чөлөөнд халдах, гуравдагч этгээдэд нөлөөлөх зэргээр алба хаагчийн эрх, үүрэг нь энх тайван буюу тайван жагсаал, цуглаан болгох зорилго агуулж эрх зүйн зохицуулалтыг хийсэн байна.

3. Албадан тараах ажиллагааны журмын зохицуулалтын тухайд

ЕАБХАБ-ийн Ардчилсан институт, хүний эрхийн газрын (АИХЭГ) “Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага”-д *“Жагсаал, цуглааныг зохион байгуулах явцад олон нийтийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх чухал чиг үүрэг бүхий байгууллага бол цагдаагийн байгууллага бөгөөд жагсаал, цуглааныг төлөвлөх, бэлтгэх, зохицуулах бүхий л асуудалд хүний эрхэд суурилсан хандлагыг баримтлах ёстой. Хууль сахиулах байгууллагынхан зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд цуглаан дээр хүч хэрэглэж болохгүй. Хязгаарлах, пропорциональ байх, хохирлыг багасгах, хүний амь насыг аврах зарчмуудыг баримтлан зөвхөн шаардлагатай хамгийн бага хэмжээгээр хүч хэрэглэх ёстой. Үхлийн аюултай зэвсэг болох галт зэвсэг нь цуглааныг тараах зэрэгт тохирох тактикийн хэрэгсэл биш тул зайлсхийх хэрэгтэй.”*¹¹⁷ гэж жагсаал, цуглааны үеийн цагдаагийн байгууллагын үүрэг, оролцоо ба баримтлах журмыг тодорхойлсон байна.

Жагсаал цуглааныг албадан тараах хууль, эрх зүйн үндэслэл, журмыг ЦАТХ-ийн 12.1.2, ЖЦХЖТХ-ийн 14 дүгээр зүйлд тус тус зохицуулснаас үзэхэд цагдаагийн албаны оролцоо, эрх үүргийг нэлээд ерөнхий байдлаар хуульчилсан байх тул албадан тараах үеийн процесс ажиллагааг практикт хэрэгжүүлэхдээ цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр дүрэм, журам, заавруудыг баталж, мөрдүүлэх ажлын хүрээнд баталсан “Цагдаагийн үйл ажиллагаанд баримтлах журам”-ын эмхэтгэлийн 503 кодтой 6 зүйл 13 хэсэг бүхий “Жагсаал цуглааныг албадан тараах журам”-ыг баримталдаг байна.

Уг жагсаал цуглааныг албадан тараах процесс ажиллагаанд баримтлах журмын 503.2.2-т “Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэнийг ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарлахыг хориглоно.” хэмээн хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой ганц заалтыг ерөнхий байдлаар тусгасан байна.

Түүнчлэн, уг журмын 503.4.1-д “Дараах тохиолдолд засаг дарга жагсаал цуглааныг албадан тараах тухай...” гээд жагсаал цуглааныг засаг даргын жагсаал, цуглаан албадан тараах тухай захирамж гаргах эрх, цагдаагийн байгууллагын үүргийг дурдаад, тухайн тохиолдлуудыг жагсаасан байх бөгөөд энэ нь хуулийн

117 Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газрын “Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага”, Варшав хот, (2016).

зохицуулалтыг давтсан бөгөөд зарим тохиолдолд хуулиас давсан мэт шинжтэй байгаа эсэх; анхаарах зүйл гэсэн 503.5 дахь хэсэгт хүний эрхийг хангаж ажиллахыг анхааруулсан заалт байхгүй гэх зэрэг асуудлууд байгааг Нээлттэй нийгэм форум, Дотоод хэргийн их сургуулийн хамтарсан “Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх нь” сэдэвт судалгааны тайланд дурджээ.¹¹⁸

Хүснэгт 4.12. Хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжтой зөрчилдсөн журмууд /хэсэгчлэн авав/¹¹⁹

Журмын холбогдох заалт	Асуулт, дүгнэлт	Зөвлөмж
503. ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЛБАДАН ТАРААХ		
503.4.1 Дараах тохиолдолд засаг дарга жагсаал цуглааныг албадан тараах тухай ...	Хуулиас давсан зохицуулалтыг бий болгосон эсэх.	Жагсаал цуглааныг албадан тараах тохиолдлуудыг хичээл зааж байгаа мэт оруулсан байгааг өөрчилж, хуулийн заалтыг эш татах.
503.5 Анхаарах зүйл	Анхаарах зүйлийн хүрээнд хүнийг эрхийг хангаж ажиллахыг анхааруулсан заалт байхгүй.	Нэмж тусгах.

Албадан тараах шийдвэрийг хэрэгжүүлж буй байгууллага нь хуулиар тогтоосон хэм хэмжээг мөрдлөг болгохоос гадна процесс ажиллагааг хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа хэрэгжүүлэх арга техник болон тактикийг хүний эрхийн зөрчилгүйгээр боловсруулахад олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан дэлгэрэнгүй зааварчилгааны шинжтэй гарын авлага, удирдамж зэргийг баримтлах нь зүйтэй юм.

Олон улсын байгууллагуудаас гаргасан хүний эрхийн талаарх дүгнэлт, зөвлөмжүүд болон гарын авлагууд чухал ач холбогдолтой. Тухайлбал, жагсаал, цуглаан хийх эрхийн тухайд дараах олон улсын байгууллагын дүгнэлт, зөвлөмж болон гарын авлага байна. Үүнд:

- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ) -ын “Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага”
- ЕАБХАБ-ын АИХЭГ-ын “Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний удирдамж”
- НҮБ-ын Тусгай илтгэгчид Майна Киай, Кристоф Хэйнс нар, “Жагсаал, цуглааныг зөв зохистой зохицуулах 10 зарчим”
- Эмнести интернэшнл олон улсын байгууллагын жагсаал, цуглаан хийх эрхийн талаарх судалгаанууд, дүгнэлт, зөвлөмжүүд гэх мэт баримт бичгүүдийг дурдаж болно.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас гаргасан “Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага” -д жагсаал, цуглааныг тараах ажиллагаанд:

118 ННФ, ДХИС, “Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх” сэдэвт судалгааны тайлан, (УБ, 2020).

119 Мөн тэнд, 43 дахь тал.

- Хүмүүс аяндаа тарах боломжийг хангах;
- Тарах тухай мэдэгдлийг илэрхийлж хандах;
- Хүчирхийлэл үүссэн жагсаал, цуглааныг тараахаар хүч хэрэглэх шийдвэр гаргах;
- Хүч хэрэглэхээс өмнө анхааруулах арга хэмжээ авах;
- Хүч хэрэглэхээс өмнө зохих хугацаа өгөх, түүнийг баримтжуулах;
- Эмзэг бүлгийн хүмүүст хүч хэрэглэх харилцааг анхаарах;
- Албадан тараах тактик хэрэглэх хэмжээ, хязгаарийг баримтлах зэрэг албадан тараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх техникийн шинжтэй зөвлөмжүүдийг дэлгэрэнгүй байдлаар өгсөн байна.

Харин манай улсад өнөө мөрдөгдөж буй хуульд цагдаа болон цагдаагийн байгууллагын оролцоо, эрх, үүргийг ерөнхий байдлаар зохицуулсны дээр албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэх журмын хамрах хүрээ, зохицуулалт хэт ерөнхий байна. Иймд жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэх журмыг ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газрын “Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага” гэх мэт олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишигт нийцсэн, хүний эрхийн талаас нарийвчлан зөвлөсөн шинжтэй баримт бичгүүдэд заасан зарчимд нийцсэн ажиллагаа, түүнд холбогдох нөхцөлүүдийг тусгах шаардлагатай юм.

Мөн ХЭҮК-ын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл”-д жагсаал, цуглааны үеийн хууль сахиулах ажиллагааг журамлахтай холбоотой дараах зөвлөмжүүдийг нэлээд дэлгэрэнгүй байдлаар тусгасныг хэрэгжүүлж, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй. Үүнд:

- ЖЦХЖТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтад “жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид ...үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол” албадан тараахаар заасан нь тайван хуран чуулах эрх чөлөөг хэтрүүлэн, дур мэдэн хязгаарлах нөхцөлийг бүрдүүлжээ. Тайван жагсаал цуглааны явцад хүчирхийллийн шинжтэй үйлдэл хэсэгчлэн гарсан нь арга хэмжээг бүхэлд нь тайван бус гэж үзэх, албадан тараах үндэслэл болохгүй юм.¹²⁰
- Хүч, албадлагыг бодит шаардлага үүссэн үед, нөхцөл байдалд тохирсон хэмжээнд хэрэглэх, хүчирхийлэл өдөөсөн нэг буюу хэсэг хүмүүсийн үйлдлийг таслан зогсоосон тохиолдолд цааш нь хүч, албадлага хэрэглэхийг хориглох зохицуулалтыг холбогдох хуульд тусгавал зохино.¹²¹
- Түүнчлэн, жагсаал, цуглааны үед албадлагын ямар төрлийн арга хэмжээг авах шийдвэр чиглэлийг, ямар албан тушаалтан өгсөн, чиглэлийг хэрхэн хэрэгжүүлсэн, биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн байдлыг баримтжуулах, тэмдэглэл тодорхой хөтлөх, жагсаал, цуглааны нэг хэсэгт хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд албадлагыг арга хэмжээг хэсэгчилсэн авах журам, жагсаал цуглааны үеийн хууль сахиулах ажиллагаанд дагнан сургаж, дадлагажуулсан алба

120 НҮБ-ын Хүний эрхийн хороо, ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар гаргасан 34 дүгээр ерөнхий зөвлөмж, 74-79 дэх догол мөр, CCPR/C/GC/34

121 Мөн тэнд.

- хаагчийг ажиллуулах, хүч, албадлага хэрэглэсэн тохиолдолд эмнэлгийн тусламж авах боломжийг заавал бүрдүүлэх шаардлагыг холбогдох хуульд тусгах шаардлагатай.
- Жагсаал цуглааныг тараахад галт зэвсэг хэрэглэхийг хориглож, энгийн хувцастай цагдаагийн алба хаагч ажиллах журмыг тодорхой болгох, хэн болохоо далдлан албан үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч хэн болохоо илчлэхгүйгээр албадлага хэрэглэх, жагсаал, цуглааныг албадан тараах нөхцөл үүсгэх зорилготой зөрчил өдөөхийг хориглох зохицуулалтыг хуульд тусгавал зохино. Жагсаал, цуглааны үеэр хууль сахиулж, албадлага хэрэгжүүлж буй цагдаагийн алба хаагч үйлдлийнхээ хариуцлагыг бүрэн хүлээх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дүрэмт хувцас өмсөх, бүрэн эрх, хэн болохыг нь гэрчлэх бичиг баримтыг биедээ авч явах, баривчилсан, албадан саатуулсан хүмүүсийг зөөвөрлөх цагдаагийн албаны тээврийн хэрэгсэл ялгах тэмдэгтэй байх шаардлагыг холбогдох хуульд тусгах нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилсан сэргийлэх юм.
 - Үзэл бодлоо илэрхийлсэн, тайван жагсаал, цуглаан хийсэн иргэдийг албадан саатуулсан цагдаагийн алба хаагчид нь дүрэмт хувцас өмсөөгүй, албан үнэмлэхээ уншигдахуйц байдлаар үзүүлээгүй, албадан саатуулсан хүмүүсийг тээвэрлэсэн авто машин нь таних тэмдэггүй байсан зэрэг зөрчлийг Монголын Эмнести Интернэшнл байгууллага баримтжуулжээ.¹²²
 - Цагдаагийн албаны тухай хуульд заасан жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө оролцогчдод бүх төрлийн холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглааныг албадан тараах тухай сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг мэдэгдэж, биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд авах арга хэмжээг урьдчилан анхааруулах, албадан тараах ажиллагааны явцыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах арга хэмжээ авахгүй байх дутагдал нийтлэг байна. Мөн тайван жагсаал, цуглааныг албадан тараах зайлшгүй шаардлага үүсээгүй, холбогдох Засаг даргын шийдвэр гараагүй байхад Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл буюу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох цагдаагийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн иргэнд албадлага хэрэглэх зохицуулалтыг үндэслэн жагсаал, цуглааныг тараах тохиолдол гарч байна.¹²³ Мөн, тайван жагсаал, цуглаан зохион байгуулсан, идэвхтэй оролцсон иргэдээс тайлбар, мэдүүлэг авахаар цагдаагийн байгууллагад албадан ирүүлж, удаан хугацаагаар саатуулж, жагсаал, цуглааныг тарахад хүргэх тохиолдол мөн цөөнгүй гарч байна.
 - Жагсаал, цуглаанд оролцсон иргэдийн хувийн мэдээллийг хууль сахиулах, тусгай чиг үүргийн байгууллагууд хууль бусаар ашиглах, тэднийг мөрдөн мөшгөх, жагсаал, цуглаан хийх хүсэл зоригийг мохооход ашиглахгүй байх баталгааг бүрдүүлж, хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл явцад хяналт тавих механизм бий болгох хэрэгтэй. Ялангуяа, технологийн хөгжил дэвшлийн эрин үед хүний байршил тогтоох, нүүр царай таних хэрэгслийг ашиглаж байгаа байдал, хүний цахим ур мөрийг мөшгөх, хувийн захидал, харилцааг хянах үйл ажиллагааг хүний эрхийн зарчимд нийцүүлэн журамлах шаардлагатай байна.

122 ННФ, Эмнести интернэшнл “Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа”, (УБ, 2022), 21 дэх тал.

123 Мөн тэнд, 18 дахь тал.

Дээрх зөвлөмжөөс үзэхэд, жагсаал цуглааныг албадан тараах ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний холбогдох баримт бичгүүдэд дэлгэрэнгүй тусгасантай уялдуулан нарийвчлан хуульчлах, ингэхдээ хүний эрхийн дотоодын эрх бүхий байгууллагын албан ёсны баримт, тайлбар, судалгаа болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй уялдуулан гаргасан дүгнэлт, санал, зөвлөмж зэргийг хуулийн төсөл боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахад зайлшгүй харгалзан үзэх, цаашилбал тогтоосон үндэслэл журамтай уялдуулан техникийн шинжтэй буюу албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг шинэчлэн боловсруулах шаардлагатай.

Явцын дүгнэлт

ХЭҮК-ын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл” болон бусад эх сурвалжид дурдсан албан ёсны тоо баримтаас үзэхэд иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх, түүнийг хуульд заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагын зүгээс хязгаарлах, цагдаагийн алба албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэх үед хүний эрхийн зөрчил үүссээр байна. Ийнхүү хууль сахиулах байгууллага болон иргэд хоорондын албадлагын шинжтэй харилцааны үед хүний эрхийн зөрчил үүссээр байгаа гол шалтгаан нь ЖЦХЖТХ болон ЦАТХ-д жагсаал цуглаан хийх эрхийг хориглох, хязгаарлах үндэслэл журмыг нарийвчлан тусгаагүй, зарим улс орнуудын (ХБНГУ, БНСУ зэрэг) жишигт байдаг жагсаал, цуглааны үеийн цагдаагийн байгууллагын оролцоо, эрх, үүргийг дэлгэрэнгүй хуульчлаагүй, ЖЦХЖТХ-ийн зохицуулалт нь хэт хуучирсан шинжтэй бөгөөд энэ нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасан агуулгатай зөрчилддөг, албадан тараах процесс ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах зохицуулалт хуульчлагдаагүй зэрэгтэй холбоотой байна.

Мөн албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэх арга техник, тактик зэргийг боловсруулахад удирдлага болгон ашигладаг, цагдаагийн төв байгууллагаас холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргадаг ЦБҮАЖ-ын албадан тараах ажиллагаанд холбогдох журам нь хэт ерөнхий шинжтэй, зарим талаараа хуулийн зохицуулалтыг давтсан, давсан, техник ажиллагааны удирдамж дутуу, хүний эрхийг харгалзсан заалт дутмаг зэрэг нөхцөл байдлыг холбогдох байгууллагын хийсэн судалгаа, дүгнэлт харуулж байна.

Иймээс дээр дурдсан олон улсын хүний эрхийн хэм хэмжээ (ИБУТЭТОУП зэрэг), олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, удирдамж, гарын авлага зэрэгт тусгасан арга зүй болон үндэсний хэмжээний хүний эрхийн байгууллагын холбогдох баримт, судалгаанд суурилсан зөвлөмж, илтгэл (Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлүүд), олон улсын харьцуулсан болон онолын судалгааны дүнд үндэслэсэн дүгнэлт, санал зэргийг харгалзан үзэж жагсаал, цуглааны үеийн цагдаагийн байгууллагын оролцоо, албадан тараах ажиллагаанд баримтлах зарчим, цагдаагийн алба хаагчийн эрх, үүргийг тодорхой тусгасан дотоодын хууль тогтоомжийг шинэчлэн батлах, түүнд нийцүүлэн журам боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

Санал

Энэхүү бүлгийн Дүгнэлтийг үндэслэн, цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг хүний эрхийг зөрчилгүйгээр хэрэгжүүлэх боломжийг нарийвчлан зохицуулах тухайд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Өнөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу хуулиар хориглох жагсаал, цуглааны агуулгыг олон улсын заавал дагаж мөрдөх хүний эрхийн хэм хэмжээ болох ИБУТЭТОУП-ын 20, 21 дүгээр зүйлд нийцүүлэх;
2. ЖЦХЖТХ-д жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой журмыг нарийвчлан тусгах;
3. Холбогдох хуульд жагсаал, цуглааны үеийн цагдаагийн байгууллагын оролцоо, эрх, үүргийг тодорхой, нарийвчлан зохицуулах;
4. ЦБҮАЖ-ын жагсаал цуглаан албадан тараахад баримтлах журамд хүний эрхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг тусгах, олон улсын хүний эрхийн удирдамж, гарын авлага, зөвлөмжид заасныг баримтлах;
5. Дотоодын хүний эрхийн байгууллагын албан ёсны баримт, тайлбар, судалгаа болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй уялдуулан гаргасан дүгнэлт, санал, зөвлөмж зэргийг хуулийн төсөл боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахад зайлшгүй харгалзан үзэх, үүнд нийцүүлэн техникийн шинжтэй буюу албадан тараах ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг шинэчлэн боловсруулах.

VI. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Цагдаагийн албаны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэрэгцээнд тулгуурлан, дараах 5 асуудлын хүрээнд Монгол Улс болон гадаад орнуудын хууль тогтоомж, туршлагыг харьцуулан судаллаа. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо;
2. Цагдаагийн албаны дотоод хяналт шалгалт, гадаадын зарим орны туршлага;
3. Мөрдөгчид тавигдаж байгаа шалгуур ба сонгон шалгаруулалт;
4. Онцгой тохиолдолд албаны чиг үүрэг гүйцэтгүүлэх ажилд оролцож буй сургалтын байгууллагын суралцагчийн эрх зүйн байдал эрх, үүргийн хүрээ хязгаарыг тогтоох асуудал;
5. Цагдаагийн алба жагсаал цуглааныг албадан тараах ажиллагааг хүний эрхийн зөрчилгүйгээр хэрэгжүүлэх боломж.

Монгол Улсад цагдаагийн алба хаагчийг сургах боловсрол, сургалтын тогтолцоог тодорхойлсон хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, сургалтын нэгдсэн тогтолцоог оновчтой тодорхойлоогүй байна. Холбогдох журмууд хоорондоо зөрчилтэй, шинэчилж батлаагүйн улмаас тэдгээрийг дагалдуулж баталсан сургалтын хөтөлбөрүүд оновчгүй бөгөөд Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох журмаар тодорхойлоогүй сургалтын төрлүүдийг нэмж, олон төрлийн харилцан уялдаагүй сургалтуудыг тусгасан, хүчин төгөлдөр бус хуулийг дагаж мөрдөхөөр заасан, нэр томъёоны хувьд төөрөгдөл үүсгэхүйц тулгамдаж буй олон асуудал үүсжээ. Иймд цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт болон цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтыг олон улсын сайн туршлагыг үндэслэн боловсронгуй болгох шаардлагатай юм.

Иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл нь тус байгууллага үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад гол тулгуур болдог. Гэвч иргэдийн итгэл буурч, хүний эрх чөлөөнд халдсан зөрчил нэмэгдэх асуудал тулгамдсаар байна. Харин гадаад орнууд энэхүү асуудлыг шийдвэрлэхээр хууль тогтоомжийн шинэтгэл хийж, бие даасан байгууллага иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж цагдаагийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг хандлагатай байна. Иймд ЦАТХ-д олон улсын конвенцод заасан зарчмыг тусгаж, шинэчлэл хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Монгол Улсад мөрдөгчийг сонгон шалгаруулах тусгай ажиллагаа явагддаггүй байна. Иймээс цагдаагийн алба хаагчид тавигддаг шалгуур үзүүлэлтийг судалж үзэхэд тодорхой ур чадвартай байх шаардлага тавьсан боловч эдгээрийг тогтоох шалгалтын талаар журамд тодорхой тусгаагүй байна. Харин сонгон судалсан орнуудад хэл зүйн болон анхаарал төвлөрөл зэрэг бусад тодорхой төрлийн ур чадварыг сайтар шалгадаг. Иймээс мөрдөгчийн ур чадварыг тухайн ажиллах хэлтэс, нэгжээс хамаарч шалгахаас гадна мөрдөгчөөр ажиллахад шаардагдах тодорхой ур чадваруудын шалгалт авахаар журамлах нь зүйтэй.

Дөрөвдүгээр бүлгийн хүрээнд, суралцагчаар (сонсогч) албаны чиг үүргийг гүйцэтгүүлэх нөхцөл, журам болон суралцагчийн эдлэх эрх, үүрэг буюу эрх зүйн байдлын талаарх зохицуулалт зарим талаараа хангалтгүй байна. Энэ нь төр, хувь хүн, олон нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх, цаашлаад суралцагчийн эрх,

эрх чөлөө зөрчигдөх сөрөг талтай байна. Харин Эстони улсын жишгээс үзэхэд сонсогчийн эрх зүйн байдал болон албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам, эрх, үүрэг зэргийг нарийвчлан зохицуулсан байна. Иймд одоо мөрдөгдөж буй ЦАТХ-д уг асуудлыг нарийвчлан зохицуулах хэрэгцээтэй байна.

Практикт цагдаагийн албаны хэрэгжүүлж буй (албадан тараах) жагсаал, цуглаантай холбоотой ажиллагааны хүрээнд хүний эрхийн зөрчил үүссээр байна. Иймд эрх бүхий байгууллагын зүгээс жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах эрх зүйн үндэслэлийг Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээний агуулгатай (ИБУТЭТОУП-ын 20, 21 дүгээр зүйл) нийцүүлэх, жагсаал, цуглааны үе дэх цагдаагийн албаны чиг үүргийг ЦАТХ эсхүл ЖЦХЖТХ-д гадаад орнуудын жишгээр дэлгэрэнгүй хуульчлах мөн албадан тараах ажиллагааны журмыг (ЦБҮАЖ) олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан удирдамж зэрэгт нийцүүлэн боловсруулах шаардлагатай нь дээрх судалгаагаар тогтоогдож байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Цагдаагийн Албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2017).
3. Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, (1994).
4. Төрийн албаны тухай хууль, (2017).
5. Галт зэвсгийн тухай хууль, (2015).
6. Дотоодын цэргийн тухай хууль, (2017).
7. Боловсролын ерөнхий хууль, (2023).
8. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, (2023).
9. Засгийн газар дахь хяналтын тухай хууль, (2022).
10. ЦЕГ-ын даргын А/80 дугаар тушаалын хавсралт, Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам, (2023).
11. Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.
12. Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолын хавсралт, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.
13. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 100.
14. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 118.
15. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 239.
16. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 503.
17. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 945.
18. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 951.
19. Цагдаагийн ерөнхий газрын даргын А/211 дүгээр тушаал, 2017.
20. ЦЕГ-ын 2022 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр.
21. ЦЕГ-ын даргын 2023 оны албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 2023.02.06-ны өдрийн А/46 тоот тушаал.

Гадаад хэлээр:

1. Independent Police Review Act, 2007, S.O. 2007, с. 5 - Bill 103, Холбоос: <https://www.ontario.ca/laws/statute/s07005>, U.S. Code Холбоос: <https://mn.eferrit.com/%D0%B0%D0%BD%D1%83-%D1%8B%D0%BD-%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9/>,
2. 5 U.S. Code § 5545a - Availability pay for criminal investigators, Холбоос: https://www.law.cornell.edu/uscode/text/5/5545a#a_2,

3. the Republic of Estonia, Police and Border Guard Act1 Passed 06.05.2009, RT I 2009, 26, 159, Entry into force 01.01.2010, partially 01.01.2012, <https://www.riigiteataja.ee/en/eli/511112019003/consolide>,
4. Policing and Crime Act 2017, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2017/3/contents/enacted>,

Олон улсын баримт бичиг

Монгол хэлээр:

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966.
2. НҮБ-ын Хүний эрхийн хороо, ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар гаргасан 34 дүгээр ерөнхий зөвлөмж.
3. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 21 дүгээр зүйлийн талаар гаргасан 37 дугаар Ерөнхий тайлбар, (2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр UN Doc CCPR/C/GC/37).
4. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний талаарх удирдамж. Венецийн комисс, ЕАБХАБ-ын Ардчилсан институци, хүний эрхийн алба (ЕАБХАБ/АИХЭА), Страсбург/ Варшав хот (2020 оны 7 дугаар сарын 15-ны өдөр CDL AD (2019) 017rev 3 дахь хэвлэл).

Гадаад хэлээр:

1. European Commission for Democracy Through Law (Venice Commission), OSCE/ODIHR, Guidelines on Freedom Of Peaceful Assembly (3rd EDITION), Warsaw, 2019.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Д.Баярсайхан, “Эрүүгийн процессын эрх зүй”, (Уб, 2020).
2. Монгол Улсын Хүний эрхийн комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн үндэсний комиссын 10 дахь илтгэл, (Уб, 2011).
3. Монгол Улсын Хүний Эрхийн Комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, (Уб, 2022).
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төсөлд зориулсан харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны тайлан, (Уб, 2022).
5. Эрүүгийн цагдаагийн албаны Нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс бэлтгэсэн жагсаал, цуглааны судалгаа, (Уб, 2023).
6. Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүн шинжилгээ, судалгааны хэлтэс, Жагсаал, цуглааны нөхцөл байдал, хэтийн төлөвт хийсэн хэсэгчилсэн дүн шинжилгээ, (Уб, 2023).

7. Нээлттэй нийгэм форум, Эмнести интернэшнл “Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа”, (УБ, 2022).
8. Нээлттэй Нийгэм Форум, Дотоод Хэргийн Их Сургууль, “Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх” сэдэвт судалгааны тайлан, (УБ, 2020).
9. С. Гантулга, Мөрдөн байцаагчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах нь, ХСИХ, Удирдлагын сургуулийн удирдахуйн ухааны магистрын зэрэг горилсон ажил, (2015).
10. Б.Баттуяа, Цагдаагийн алба хаагчийн давтан болон мэргэшүүлэх сургалтын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ, ХСИХ-ын Магистрын зэрэг горилсон судалгааны ажил, (2018).
11. А.Бат-Амгалан. Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоо, боловсронгуй болгох зарим асуудал, ХСИХ, магистрын зэрэг горилсон судалгааны ажил, (2016).
12. Law enforcement theoretical and methodological journal, 2014, Б.Одончимэг, “олон улсын хууль сахиулах чиглэлийн боловсролын тогтолцооны хөгжлийн тойм: цагдаагийн боловсролын жишээн дээр”,
13. О. Энххүслэн, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь”, «Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь» сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд оролцсон илтгэлийн хэсгээс, (2022).
14. Нээлттэй нийгэм форум, Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, хэсгийн хэрэгжилт судалгааны тайлан, (УБ, 2022).
15. ХСИХ-ын Цагдаагийн сургуулийн сургалтын хөтөлбөрийн талаарх ажил олгогч, төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, (УБ, 2017).

Гадаад хэл дээр:

1. Good Practices in Basic Police Training – Curricula Aspects by the Senior Police Adviser to the OSCE Secretary General SPMU Publication Series Vol.5, 2009, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/a/2/109933.pdf>.
2. Police education and training systems in the osce region, 2018, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>.
3. A Comparative Study of the Police Training in the United States United Kingdom and Turkey, p.18, Холбоос: https://www.academia.edu/12541123/A_Comparative_Study_of_the_Police_Training_in_the_United_States_United_Kingdom_and_Turkey,
4. The Danish Institute for Human Rights, Police Oversight Mechanisms, 2018, Холбоос: https://www.humanrights.dk/files/media/migrated/police_complaint_mechanisms_dihr2018.pdf.
5. Graham Smith, International Police Complaints Reform, Холбоос: <https://rm.coe.int/16806dbbbd>,
6. Northern Ireland policing board annual report, Холбоос: <https://www.nipolicingboard.org.uk/sites/nipb/files/media-files/northern-ireland-policing-board-annual-report-2016-2017.pdf>.

7. Chappell, A.T. (2008), "Police academy training: comparing across curricula", Policing: An International Journal, Vol. 31 No. 1, pp. 36-56, Холбоос: <https://doi.org/10.1108/13639510810852567>,
8. Blumberg, D. M., Schlosser, M. D., Papazoglou, K., Creighton, S., & Kaye, C. C. (2019). New directions in police academy training: A call to action. International journal of environmental research and public health, 16(24), 4941.
9. Marenin, O. (2004). Police training for democracy. Police practice and Research, 5(2), 107-123.

Цахим эх сурвалж

Гадаад хэлээр:

1. Psychodiagnostischer Test, Холбоос: https://www.karriere.bka.de/Karriereportal/DE/Bewerbung/Auswahlverfahren/PsychodiagnostischerTest/PsychodiagnostischerTest_node.html,
2. Criminal investigator, Холбоос: <https://www.ice.gov/careers/criminal-investigator>,
3. The Estonian Academy of Security Sciences, Холбоос: <https://www.sisekaitse.ee/en/eass-home>,
4. Sicherheitsakademie, Холбоос: <https://www.bmi.gv.at/104/>,
5. Education for police officers, <https://gov.hr/en/education-for-police-officers/1044>,
6. Montenegro, Холбоос: <https://polis.osce.org/country-profiles/montenegro>,

Бусад мэдээлэл

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаар нийтийн сонсгол /2021.12.30/
2. Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага, (2023).
3. Цагдаагийн ерөнхий газрын Цагдаа дотоодын цэргийн сургалтын төвийн судлаачтай хийсэн ярилцлага, (2023).
4. ДХИС-ын сургалт хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага, (2023).
5. Хууль зүйн үндэсний хүрээлэнд Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвөөс ирсэн № 50/11461 тоот албан бичиг.
6. Хөл хорио ба Цагдаа нар нийтлэл, 2020.11.20, Холбоос: <https://news.mn/r/2374739/>,
7. Гудамж талбайд үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч болон сонсогч нарт халдаг улавч өгчээ, 2021.01.08, Холбоос: <https://ikon.mn/n/23ch>,
8. Сар шинийн баярын өдрүүдэд их сургуулийн 700 сонсогч эргүүл, хамгаалалтад үүрэг гүйцэтгэнэ, 2018.02.14, Холбоос: <https://www.facebook.com/775810089179511/posts/1633317106762134/>,
9. Ургац хураалтад оюутан, сонсогч, цэргийн алба хаагч болон иргэдийг сайн дураар оролцуулна, 2020.07.20, Холбоос: <https://ikon.mn/n/2m7m>,
10. Б.Алтантулга, Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэс, (2023), Холбоос: <https://prezi.com/p/hzsshw681kbl/presentation/>,

11. Цагдаагийн мэргэжлийн сургалт, Холбоос: https://police.gov.mn/resource/policegovmn/media/ХНСХ/_docx_

ТАВ. ГҮТГЭХ БОЛОН ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ
ГЭМТ ХЭРГИЙН ЛАВЛАГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
Б.Сүнжидмаа	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам
Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.11.27.

АГУУЛГА

I. ГАДААД ОРНУУД ДАХЬ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ БОЛОН ГҮТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦУУЛАЛТ.	263
II. ГҮТГЭХ ГЭМТ ХЭРЭГ, ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРЭГ, ГҮТГЭХ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ.	269
2.1. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоон мэдээлэл.	269
2.2. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал	270
НОМ ЗҮЙ	271

I. ГАДААД ОРНУУД ДАХЬ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ БОЛОН ГҮТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д/д	Улс	Эрүүгийн/Зөрчлийн хуулийн зүйл, заалт	Субъект	Оногдуулах ял
1	Монгол Улс	<p>Эрүүгийн хууль /2015 он/ 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах 1. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Эрүүгийн хууль /2002 он/ 111 дүгээр зүйл. Гүтгэх 111.1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгжээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 111.2. Гүтгэлийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөргийн хөлсний доод хэмжээг тавин нэгжээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 111.3. Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэн хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгжээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Нийтлэг субъект буюу хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан, гүтгэсэн этгээд байна.</p> <p>Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгжээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>Урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгжээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэн хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгжээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	

<p>2.</p> <p>Холбооны Бүгд Найрамдах Герман Улс</p>	<p>Эрүүгийн хууль 14 дүгээр бүлэг. Доромжлох 186 дугаар зүйл. Худал цуу яриа тараах. Бусдын нэр хүндийг унагааж, тухайн хүний талаарх олон нийтийн үзэл бодолд сөргөөр нөлөөлөхийн тулд түүний талаар нотлогдоогүй баримтыг зарласан эсхүл тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэх бөгөөд хэрэв олон нийтэд, хурал цуглаан дээр мэдээллийг (энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан) түгээх замаар энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэнэ. 187 дугаар зүйл. Гүтэх Бусадтай холбоотой баримтыг худал гэдгийг мэдсээр байж зарласан эсхүл тараасан нь түүнийг доромжилсон, олон нийтийн үзэл бодолд сөргөөр нөлөөлсөн эсхүл зээлийн чадварт нь аюул учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэнэ. Хэрэв уг үйлдлийг олон нийтийн өмнө, хурал цуглаан, эсхүл мэдээллийг (энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан) түгээх замаар үйлдсэн бол таван жилээс илүүгүй хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэнэ.</p>	<p>Нийтлэг субъект буюу бусдын талаар худал цуу тараасан, бусдыг гүтгэсэн этгээд байна.</p>	<p>Худал цуу яриа тараах гэмт хэрэгт нэг жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэнэ. Хэрэв олон нийтэд, хурал цуглаан дээр эсхүл мэдээллийг (энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан) түгээх замаар энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл торгох ял шийтгэнэ.</p>
<p>3.</p> <p>Оросын Холбооны Улс</p>	<p>Эрүүгийн хууль 17 дугаар бүлэг. Хувь хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг 128.1 дүгээр зүйл. Гүтгэх Бусдын нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж, хуурамч мэдээлэл тараасан бол 500,000 хүртэл рубль эсхүл ялтны 6 сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 160 цаг хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ. Олон нийтэд ярьсан, нийтэд бүтээлээр үзүүлсэн, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний нэр төрд халдсан бол 1 сая хүртэл рубль эсхүл ялтны 1 жил хүртэлх хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 240 цаг хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.</p>	<p>Нийтлэг субъект буюу 1.Бусдын нэр төрийг санаатайгаар гутааж буюу нэр хүндэд нь халдаж, хуурамч мэдээлэл тараасан; 2.Олон нийтэд ярьсан, нийтэд бүтээлээр үзүүлсэн, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний нэр төрд халдсан; 3.Албан тушаалын байдлаа ашиглан гүтгэсэн; 4.Бусдад аюул учруулж болзошгүй хүнд өвчтэй гэж гүтгэсэн;</p>	<p>128.1 дүгээр зүйлд заасан гүтгэх гэмт хэрэгт тухайн зүйлчлэлээс хамаараад 500,000-5,000,000 хүртэл рубль эсхүл ялтны 6 сараас 3 жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 160-480 цаг хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 4-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 4-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

		<p>Энэ гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол 2 сая хүртэл рубль, эсхүл ялтны 2 жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 320 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.</p> <p>Бусдад аюул учруулж болзошгүй хүнд өвчтэй гэж гүтгэсэн бол 3 сая хүртэл рубль, эсхүл ялтны 3 жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 400 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Бэлгийн хүчирхийллийн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэсэн бол 5 сая хүртэл рубль, эсхүл ялтны 3 жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 480 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 4-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>5.Бэлгийн хүчирхийллийн хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэсэн бол 3 хүртэл жилийн хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран татсан байвал 3-10 жил хүртэл хугацаатай хорих ялаар шийтгэнэ.</p>	<p>Бусдыг гэмт хэрэг үйлдсэнд гүтгэсэн бол 3 хүртэл жилийн хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран татсан байвал 3-10 жил хүртэл хугацаатай хорих ялаар шийтгэнэ.</p> <p>Төрийн байгууллагын ажилтан өмнөх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн байвал хүндээр шийтгэнэ.</p>
<p>4.</p>	<p>Бүгд Найрамдах Хятад Ард Улс</p>	<p>Эрүүгийн хууль 4 дүгээр бүлэг. Ард иргэний биеийн эрх, ардчилсан эрхэд халдсан ял 243 дугаар зүйл.</p> <p>Бусдыг эрүүгийн хэргээр нэхэмжлүүлэх зорилгоор өргүй хэрэг учрыг зохион гаргаж бусдыг гүтгээд үйл байдал нь хүнд ноцтой байвал 3 хүртэл жилийн хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран хамаарахаар шийтгэнэ; хүнд ноцтой уршиг учруулсан байвал 3-10 жил хүртэл хугацаатай хорих ялаар шийтгэнэ. Төрийн байгууллагын ажилтан өмнөх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн байвал хүндээр шийтгэнэ. Санаатайгаар гүтгээгүй, харин буруу заалдсан буюу илчилсэн нь бодит байдалтай нийцээгүй байвал өмнөх 2 хэсэгт хамаарахгүй.</p>	<p>Бусдыг гэмт хэрэг үйлдсэн нийтлэг субъект болон төрийн албан хаагч байна.</p>	<p>Бусдыг гэмт хэрэг үйлдсэнд гүтгэсэн бол 3 хүртэл жилийн хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран татсан байвал 3-10 жил хүртэл хугацаатай хорих ялаар шийтгэнэ.</p> <p>Төрийн байгууллагын ажилтан өмнөх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн байвал хүндээр шийтгэнэ.</p>

	<p>5. Найрамдах Франц Улс</p>	<p>Францын Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль¹ 32 дугаар зүйл. Гүтгэлэг Хүний нэр төр, алдар хүндийг гутаасан тохиолдолд 12,000 еврогийн торгуулиар торгоно. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, шашин, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, байдалд халдсан тохиолдолд 1 хүртэлх жил хорих ял оногдуулна. 33 дугаар зүйл. Доромжлол Нотлох баримтгүйгээр доромжилсон Үг, үйлдэл гаргасан тохиолдолд 12,000 еврогийн торгуулиар торгоно. Төрийн албаны үүргээ биелүүлж буй албан хаагчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, шашин, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээлээр нь доромжилсон тохиолдолд 3 хүртэл жил хорих болон 75,000 еврогийн торгох ял оногдуулна.</p>	<p>Нийтлэг субъект буюу бусдын талаар худал цуу тараасан, бусдыг гүтгэсэн этгээд байна.</p>	<p>Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн Гүтгэх гэмт хэрэгт хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, шашин, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, байдалд халдсан тохиолдолд 1 хүртэл жил хорих ял болон 12,000 еврогийн торгуулиар торгох ял оногдуулна. Харин төрийн албаны үүргээ биелүүлж буй албан хаагчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, шашин, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээлээр нь доромжилсон тохиолдолд шийтгэлийг 3 хүртэл жил хорих болон 75,000 еврогийн торгууль оногдуулна.</p>
<p>6.</p>	<p>Бүгд Найрамдах Солонгос Улс</p>	<p>Эрүүгийн хууль Нэр төрийн эсрэг гэмт хэрэг² 156 дугаар зүйл. Хуурамчаар буруутгах Бусдад эрүүгийн болон сахилгын шийтгэл оногдуулах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтанд худал мэдээлэл өгсөн этгээдийг 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл 15,000,000 вон хүртэл торгууль оногдуулна. 307 дугаар зүйл. Гүтгэх (1) Баримтыг олон нийтэд мэдээлэх замаар бусдын нэр төрийг гутаасан этгээдийг 2 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 5,000,000 вонноос илүүгүй торгуулиар шийтгэнэ. (2) Бусдыг олон нийтэд худал мэдээлэл тарааж гүтгэсэн бол 5 жилээс дээшгүй хугацаагаар хорих, 10 жилээс дээшгүй хугацаагаар мэргэшлийг түдгэлзүүлэх, 10,000,000 вонноос дээшгүй торгох ял шийтгэнэ.</p>	<p>Нийтлэг субъект байна.</p>	<p>Бусдын нэр төрийг гутаасан эсхүл худал мэдээлэл тарааж гүтгэсэн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 5,000,000 вонноор торгох шийтгэл оногдуулна. Харин худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих, мэргэжлийн үйл ажиллагааг явуулах эрхийг 10 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, 10,000,000 вонноор торгох шийтгэл оногдуулна. Нас барсан хүний нэр хүндэд халдсан тохиолдолд 5 жил хүртэл хугацаагаар хорих, 5,000,000 вон хүртэл торгууль оногдуулна.</p>

1 Францын Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Холбоос: <https://www.legifrance.gouv.fr/loda/id/LEGITEX/T000006070722>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.27.
2 БНСУ-ын Эрүүгийн хууль, Холбоос: <https://www.refworld.org/docid/3f49e3ed4.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.27.

		<p>308 дугаар зүйл. Нас барсан хүний нэр төрийг гутаах</p> <p>Нас барсан хүний нэр төрийг олон нийтэд худал зарласан, гүтгэсэн этгээдийг 2 жилээс дээш хугацаагаар хорих, 5,000,000 воноос дээшгүй торгох ял шийтгэнэ.</p>		
7.	<p>Австрали Улс</p>	<p>Австралид хүнийг гүтгэх тохиолдлыг ихэвчлэн иргэний эрх зүйн зөрчилд тооцдог бөгөөд зарим тохиолдолд Эрүүгийн хуулиар зохицуулдаг байна.</p> <p>Эрүүгийн хууль (1899)</p> <p>365 дугаар хэсэг³</p> <p>(1) Хууль зүйн үндэслэлгүйгээр бусад хүний нэр төрийг гутаасан нийтлэл нийтлэх</p> <p>Тухайн мэдээллийг худал гэдгийг мэдэж байсан эсвэл мэдээллийг үнэн, худал эсэхийг шалгаагүй;</p> <p>Холбогдох этгээдэд санаатайгаар хохирол учруулахыг зорьсон Эдгээр тохиолдолд 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.</p> <p>Яллагдагч тухайн мэдээллийг нийтлүүлэх шаардлагатай гэсэн тодорхой үндэслэлтэй гэж үзвэл яллагдагчийг гүтгэсэн хэргээр иргэний шүүхэд хандаж болно.</p>	<p>Хууль зүйн үндэслэлгүйгээр бусад хүний нэр төрийг гутаасан нийтлэл нийтэлсэн этгээд.</p>	<p>Тухайн мэдээллийг худал гэдгийг мэдэж байсан эсвэл мэдээллийг үнэн, худал эсэхийг шалгаагүй; Холбогдох этгээдэд санаатайгаар хохирол учруулахыг зорьж хууль зүйн үндэслэлгүйгээр бусад хүний нэр төрийг гутаасан нийтлэл нийтэлсэн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
8.	<p>Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс</p>	<p>Эрүүгийн хууль⁴</p> <p>156 дугаар зүйл. Гүтгэлэг</p> <p>1. Дараах гэмт хэргийг үйлдсэн этгээдэд 10,000,000 - 50,000,000 донг, 2 жил хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийх, 3-12 сар хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. Үүнд:</p> <p>Хүний хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан, нэр төрд халдсан худал мэдээлэл тараасан тохиолдолд;</p> <p>Зохиомол хэрэгт буруутгаж эрх бүхий байгууллагад мэдээлэх.</p> <p>2. Дараах тохиолдолд 1-3 жилийн хорих ялаар шийтгэнэ. Үүнд:</p> <p>Зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэх;</p>	<p>Нийтлэг субъект байна.</p>	<p>Хүний хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан, нэр төрд халдсан худал мэдээлэл тараах, зохиомол хэрэгт буруутгасан тохиолдолд 10,000,000-50,000,000 донг, 2 жил хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийх, 3-12 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

3 Австрали улсын Эрүүгийн хууль, Холбоос: http://www5.austlii.edu.au/au/legis/au/consol_act/cc189994/s365.html, Сүүлд үзсэн огноо: 2023.11.27.

4 БНСВУ-ын Эрүүгийн хууль, Холбоос: <https://www.derechos.org/intlaw/doc/vnm1.html>, Сүүлд үзсэн огноо: 2023.11.27.

	<p>Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах; Хоёр болон түүнээс дээш хүний нэр хүндэд халдах; Албан үүргээ гүйцэтгэж буй хууль сахиулагчийн эсрэг гэмт хэрэг үйлдэх; Компьютерын сүлжээ, харилцаа холбоо, электрон төхөөрөмж ашиглан гэмт хэрэг үйлдсэн тохиолдол; Хохирогч гэмт этгээдийн үйлдлээс үүдэн 11-45 хувийн сэтгэц болон зан үйлийн эмгэгт өртсөн; Хүнийг зохиомол онц, хүнд хэрэгт холбогдуулан буруутгах; 3. Дараах тохиолдолд 3-7 жилийн хорих ялаар шийтгэнэ. Үүнд: Хохирогч гэмт этгээдийн үйлдлээс үүдэн 46 хувиас дээш сэтгэц болон зан үйлийн эмгэгт өртсөн; Хохирогчийг амиа хорлоход хүргэсэн.</p>		<p>Зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэх; албан тушаал, эрх мэдлээ урвуулах ашиглах, хоёр болон түүнээс дээш хүний нэр хүндэд халдах, хохирогчийн гэмт этгээдийн үйлдлээс үүдэн 11-45 хувийн сэтгэц болон зан үйлийн эмгэгт өртсөн, зохиомол онц, хүнд хэрэгт холбогдуулан буруутгасан тохиолдолд 1-3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хохирогчийн гэмт этгээдийн үйлдлээс үүдэн 46 хувиас дээш сэтгэц болон зан үйлийн эмгэгт өртсөн, хохирогчийг амиа хорлоход хүргэсэн тохиолдолд 3-7 жилийн хорих ял шийтгэнэ.</p>
--	--	--	--

Дүгнэлт

Гүтгэх болон худал мэдээлэл тараах гэмт хэргийг хуулиар зохицуулсан ОХУ, БНХАУ, БНФУ, ХБНГУ, БНСУ, БНСВУ зэрэг улсыг сонгон авч энэхүү лавлагааг гүйцэтгэлээ. Сонгон судалсан орнуудаас гүтгэх болон худал мэдээлэл тараах гэмт хэргийг БНФУ хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиараа зохицуулж байгаа бол бусад орнууд Эрүүгийн хуульдаа тусгайлан хуульчилсан байх бөгөөд захиргааны зөрчилд тооцсон улс байхгүй байна.

Гэмт хэргийн субъектийн хувьд худал мэдээлэл тараасан, бусдыг гүтгэсэн нийтлэг субъекттэй байгаа бөгөөд БНХАУ төрийн албан хаагч энэхүү гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хүндээр шийтгэхээр тусгайлан зохицуулсан байна.

Мөн сонгон судалсан орнууд гүтгэх болон худал мэдээлэл тараах гэмт хэрэгт торгох болон хорих ял оногдуулахаар хуульчилсан байгаа нь нийтлэг байдлаар ажиглагдсан бол зарим улсад албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг шийтгэлийг оногдуулж байна.

II. ГҮТГЭХ ГЭМТ ХЭРЭГ, ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРЭГ, ГҮТГЭХ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ.

2.1. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоон мэдээлэл

Цагдаагийн байгууллагад 2013-2022, 2023 оны эхний 10 сард бүртгэгдсэн 2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйл, 2015 оны Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн судалгаа:

Хүснэгт 5.1. Бүртгэгдсэн хэргийн тоо /2013-2023 он/

№	Он	Бүртгэгдсэн хэрэг		Холбогдсон хүн
		2002 оны Эрүүгийн хуулийн 111 дугаар зүйл	2015 оны Эрүүгийн хуулийн 13.14 дугаар зүйл	
1	2013	29	-	20
3	2014	19	-	20
4	2015	31	-	31
5	2016	19	-	16
6	2017.06 сар	14	-	8
7	2020	-	127	25
8	2021	-	132	29
9	2022	-	136	21
10	2023.10	-	201	23

2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд заасан Гүтгэх гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2013-2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 112 бүртгэгдсэн ба 2015 онд хамгийн олон буюу 31 хэрэг бүртгэгдсэн байна. Харин худал мэдээлэл тараах гэмт хэрэг 2020-2023 оны 10 сар хүртэл нийт 596 гэмт хэрэг бүртгэгдэж энэ онд эрс өсөлттэй буюу өмнөх онтой харьцуулахад 65-аар нэмэгдэн 201 гэмт хэрэг бүртгэгдсэн. Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо 2013-2023 оны хооронд тогтвортой байгаа бөгөөд дунджаар Гүтгэх гэмт хэрэгт 19 хүн холбогдсон бол Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт 25 хүн тус тус холбогджээ.

2017-2021 оны хооронд Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан зөрчил нь нийт 1246 бүртгэгдэж, 302 иргэнд 618.350.000 төгрөгийн торгууль оногдуулсан байна. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл нь 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс хүчингүй болсон тул 2022-2023 онд бүртгэгдээгүй.

Хүснэгт 5.2. Бүртгэгдсэн зөрчлийн тоо /2017-2021 он/

№	Он	Бүртгэгдсэн зөрчлийн тоо	Холбогдсон хүн	Арга хэмжээ авсан байдал /төг/
1	2017 он	138	27	52.200.000
2	2018 он	490	108	211.200.000
3	2019 он	515	132	272.800.000
4	2020 он	102	34	82.050.000
5	2021 он	1	1	100.000
Нийт		1246	302	618.350.000

2.2. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

2002 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд заасан “Гүтгэх” гэмт хэргийн талаар 2013-2015 оны хооронд шүүхийн шийдвэрийн цахим санд тавигдсан шүүхийн шийдвэр байхгүй байна. Харин 2016 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 5 хэрэг шийдвэрлэсэн байна. Үүнээс 3 гэмт хэрэгт торгох ял оногдуулж, 1 гэмт хэргийг цагаатгаж, 1 гэмт хэрэгт хорих ял тус тус оногдуулжээ. Давж заалдах шатны шүүхээр 4 хэрэг шийдэгдсэний 3 хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаасан ба 1 хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Харин хяналтын журмаар шийдвэрлэсэн 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгажээ.

Харин 2017 онд анхан шатны журмаар шийдвэрлэсэн 5 хэрэг байгаагаас 3 гэмт хэрэгт торгох ял, 2 хэргийг цагаатгаж шийдвэрлэсэн бөгөөд давж заалдсан 4 хэргээс шийдвэрийг хэвээр үлдээсэн 2, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 1, прокурорт буцаасан 1 хэрэг тус тус байна. Харин хяналтын журмаар шийдвэрлэсэн 1 хэргийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

2020 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс “Худал мэдээлэл тараах” нийт 9 гэмт хэрэгт ял оногдуулснаас 7 гэмт хэрэгт торгох ял оногдуулсан бөгөөд 2 гэмт хэргийн шүүхийн шийтгэх тогтоол нууцалсан байх тул үзэх боломжгүй байв. Давж заалдах болон хяналтын журмаар шүүх хянан шийдвэрлэсэн хэрэг байхгүй байна.

2021 онд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” 20 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 17 нь торгох ял, 2 гэмт хэргийн шийтгэх тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, холбогдох хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгосон бол 1 гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ялаар тус тус шийтгэжээ. Үүнээс 6 гэмт хэрэгт давж заалдсан бөгөөд бүх шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Харин хяналтын шатны журмаар шүүх хэргийг хянан шийдвэрлээгүй байна.

2022 оны 1-12 дугаар сарын байдлаар Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” 15 хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэнээс 7 гэмт хэрэгт торгох ял, 3 гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ял, 4 гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ял тус тус оногдуулсан байна. /1 шийтгэл тогтоолыг үзэх боломжгүй байна./ Давж заалдах журмаар нийт 6 хэрэг шийдвэрлэсэнээс 5 шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, 1 хэрэгт анхан шатны шүүхээр шийдвэрлэхээр буцаасан байна. Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байна.

2023 онд анхан шатны шүүхээр нийт 26 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд 15 хэрэгт торгох, 3 хэрэгт нь нийтэд тустай ажил хийлгэх, 1 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бол 6 хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан байна. 1 шийтгэх тогтоол нууцлалтай тул харах боломжгүй байна. Давж заалдах шатны шүүхээр 6 хэрэг шийдэгдсэнээс 1 шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, 1 шийтгэх тогтоолыг гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, 2 давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Мөн 1 хэрэгт шийтгэх тогтоолыг өөрчилж шийдвэрлэсэн ба 1 магадлал нууцалсан тул үзэх боломжгүй байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар хяналтын шатны шүүхээр хэрэг шийдвэрлэгдээгүй байна.

НОМ ЗҮЙ

1. Эрүүгийн хууль, /Монгол Улс/ (2015).
2. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль, (2013).
3. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Эрүүгийн хууль, (2015).
4. Бүгд Найрамдах Франц Улсын Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, (1881).
5. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль, (1997).
6. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль, (1996).
7. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль, (1998).
8. Цагдаагийн Ерөнхий газрын Цагдаа, дотоодын цэргийн сургалтын төвөөс авсан тоон мэдээлэл.
9. <https://shuukh.mn>

ЗУРГАА. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ
БОЛОН ПЕДОФИЛ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСТ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТАЛААРХ ЛАВЛАГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Сүнжидмаа	Эрдэм шинжилгээний ажилтан
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Сэлэнгэ	Эрдэм шинжилгээний ажилтан
О.Түвшинсанаа	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.10.11.

АГУУЛГА

I. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЛАВЛАГАА	275
II. ПЕДОФИЛ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСТ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЛАВЛАГАА	282
ДҮГНЭЛТ	285
НОМ ЗҮЙ	286

I. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЛАВЛАГАА

№	Улс	Гэмт хэрэгт оногдуулах ял	Ял эдэлсний дараах хяналт тавих арга	Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял эдэлсний дараа олон нийтэд ил болгох ажиллагаа
1.	Америкийн Нэгдсэн Улс	<p>Масачусеттсийн мужийн хуулиар 16 нас хүрээгүй хүүхдийг хүчиндсэн тохиолдолд мужийн шоронд бүх насаар нь хорих, статуын эрх зүй дэх хүчиндэх гэмт хэрэгт мужийн шоронд бүх насаар нь хорих, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр статуын эрх зүй дэх хүчиндэх гэмт хэрэгт (наснаас хамаарч) насаар хорих буюу хамгийн багадаа 10 жил хорих ял оноох, 16-аас доош насны хүүхдийг хүчиндэх зорилгоор хүчирхийлсэн бол насаар нь хорих ялаар шийтгэх, 14-өөс доош хүүхдэд хүч хэрэглэн айлтан сүрдүүлсэн тохиолдолд шоронд 10 хүртэлх жил, түр шоронд 2,5 жилээр хорих, 16 нас хүрээгүй хүүхдэд садар самуун үйлдэл хийсэн тохиолдолд шоронд 5 жил, түр шоронд 2,5 жил хорих ялаар шийтгэдэг байна.¹</p>	<p>2006 оны 07 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан The Adam Walsh Child Protection and Safety Act хуулийн Title I буюу Sex Offender Registration and Notification Act (SORNA) бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтний бүртгэлийг хийхээр тусгажээ. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтнийг I зэрэг (tier), II зэрэг, III зэргийн гэж гурав хувааж авч үзсэн. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгээр яллагдсан хэрэгтэн хамгийн ноцтой гэмт хэрэгтэнд тооцож буюу III зэрэгт хамаарагддаг байна.</p> <p>III зэргийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэн нь насан туршдаа 3 сар тутам өөрийн биеэр эрх бүхий байгууллагад бүртгүүлэх шаардлагатай.</p>	<p>SORNA хуульд тусгагдсанаар эрх бүхий байгууллагууд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэнг бүртгэх, хянах, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд SMART office нь SORNA хэрэгжүүлж буй харьяа байгууллагуудад шаардлагатай мэдээллийн сан, төсөв, сургалт, техникийн туслалцаагаар хангадаг. Drn Sjodin National Sex Offender Public Website (NSOPW) үндэсний мэдээллийн цахим хуудсанд харьяа байгууллагууд гэмт хэрэгтнүүдийн дараах мэдээллийг бүртгэх хэрэгтэй байдаг. Үүнд, тухайн хэрэгтний овог, нэр, гэр, ажил, сургуулийн хаяг, машины дугаар, машины марк, утасны дугаар зэрэг орно. Хэрэв хэрэгтэн аяллаар явахаар болбол харьяа байгууллагадаа хаана, хэд хоноогоор явах гэж байгаага мэдэгдэх ёстой бөгөөд эрх бүхий байгууллага нь очих гэж байгаа газрын харьяа байгууллагад хэрэгтний мэдээллийг мэдэгдэнэ. Мөн бэлгийн гэмт хэрэгтэн гарын алганы хээ, хурууны хээ, DNA зэргийг бүртгэж авдаг байна. Гэмт хэрэгтний талаарх мэдээллийн дийлэнх хэсгийг нийтэд ил болгодог. Харин хохирогчийн мэдээлэл, social security number, паспорт, цагаачлалын мэдээллийг ил болгодоггүй байна. Мөн хууль хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага нь SORNA хуулийг хэрэгжүүлж чадаагүй бол төсвийн мөнгөнөөс 10%-ийг багасгахаар тусгаж өгсөн байна.</p>

1 Penalties For Child Sexual Abuse Accused of Sexual Abuse? Fight Your Punishment, Холбоос: <https://www.rsweeneylaw.com/criminal-defense/sex-crimes/penalties-for-child-sexual-abuse/>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

	<p>2. Европын Холбоо</p> <p>Улс бүр харилцан адилгүй байна.</p>	<p>Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн бүртгэлийг хийдэггүй бөгөөд Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн талаарх удирдамж- /EU's directive on child sexual abuse^{2/-д зааснаар гишүүн орнууд "бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүмүүсийг бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн бүртгэлд бүртгэх зэрэг арга хэмжээ авах талаар "харгалзаж болно" гэж заасан байдаг.}</p>	<p>Европын холбоо нь хувийн нууцыг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг цагаатгахыг өрмөлздэг тул бүртгэлийн мэдээллийг олон нийтэд задруулахыг ерөнхийд нь хориглодог. Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тухай удирдамжид "[a] тэдгээр бүртгэлд хандах эрхийг Үндсэн хуулийн зарчим болон холбогдох өгөгдөл хамгаалах стандартын дагуу хязгаарлах ёстой" гэж нэмж оруулсан байна.</p>
<p>3. Англи</p>	<p>Sexual Offences Act³ 2003-ын 1 дүгээр хэсгийн 5-д "13-аас доош насны хүүхдийг хүчиндэх" гэмт хэргийг хуульчилсан байна. Уг гэмт хэрэгт буруутай хүнд яллах дүгнэлт үйлдэж, бүх насаар нь хорих ялаар шийтгэхээр заажээ.</p>	<p>Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргээр ял шийтгүүлсэн хүмүүс хорихоос суллагдсаныхаа дараа орон нутгийн цагдаад хувийн тодорхой мэдээллийг (жишээлбэл төрсөн өдөр, улсын даатгалын дугаар, ашигласан нэр, хаана амьдарч байгаа эсвэл аялахаар төлөвлөж байгаа гэх мэт) өгөх ёстой. Бүртгэлд байх хугацаанд. Бүртүүлэгчид гадаадад аялах эсвэл хүүхэдтэй гэрт байх үедээ мөн мэдээлэл өгөх ёстой бөгөөд ДНХ-ийн дээж, хурууны хээ, одоо байгаа гэрэл зургийг хавсаргадаг байна. Хүчирхийллийн болон бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргтнүүдийн бүртгэл (VISOR) нь хууль сахиулах байгууллагуудад бүртгэлийн мэдээлэлд хандах, харьяаллын дагуу гэмт хэрэгтнүүдийг хянах боломжийг олгодог.</p>	<p>Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн тухай хууль /Sex Offences Act of 2003/-аар гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдийг бүртгэх талаар зохицуулдаг ба АНУ-аас ялгаатай нь Англид бүртгүүлэгчийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байхыг зөвшөөрдөггүй. Англид зөвхөн хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хэргээр шийтгэгдсэн тохиолдолд зарим бүртгүүлэгчдийн тухай мэдээллийг «хяналттай задруулах» заалттай байдаг. Ингэхдээ эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтээр мэдээллийг задруулж болдог. Ил болгох хүсэлтийг үнэлж буй албан тушаалтан нь тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор уг гэмт хэрэг үйлдсэн бүртгэлтэй этгээдийн талаарх мэдээлэл задруулж болох эсэх, бүрэн байгаа эсэх талаарх бүртгэлтэй этгээдээс гаргасан зөвшөөрлийг мөн харгалзан үздэг байна. Мэдээллийг задруулах нь "маш ноцтой" хэрэгт л хязгаарлагддаг.</p> <p>Холбогдох байгууллагаас мэдээллийг задруулахыг зөвшөөрсөн тохиолдолд Дотоод хэргийн яамны удирдамжийн дагуу мэдээлэл хүлээн авч буй бүх хүмүүсээс "мэдээлэл нууц гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа, цаашид энэ мэдээллийг задруулахгүй" гэсэн амлалтад гарын үсэг зурахыг шаарддаг бөгөөд хэрэв энэ нууцлалыг задруулбал шүүхэд хэрэг үүсгэж болзошгүй гэдгийг анхааруулдаг байна.</p>

2 Directive 2011/93/EU of the European Parliament and of the Council of 13 December 2011 on combating the sexual abuse and sexual exploitation of children and child pornography, and replacing Council Framework Decision 2004/68/JHA, provision 43, Холбоос: <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?qid=1574272335934&uri=CELEX:32011L0093>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

3 Sexual Offences Act, 2003, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2003/42/contents>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

				Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр шийтгүүлсэн хүмүүст хувийн хөдөлмөр эрхлэхэд ямар хэлбэр хаалттай байх ёстойг төрийн байгууллагын зүгээс тогтоодог. Англи ажил олгогчид болон сайн дурын байгууллагуудад өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон бусад нийгмийн эмзэг бүлгийн хүмүүстэй ойр харилцах боломжтой албан тушаалд өргөдөл гаргасан хүмүүсийн гэмт хэргийн түүхийг шалгахыг зөвшөөрдөг байна.
				Парламент анхлан «30 сар ба түүнээс дээш хугацаагаар хорих ял эдэлсэн эсхүл цагдан хоригдсон» этгээдүүдийг «тодорхойгүй хугацаагаар» бүртгэхийг үүрэг болгосон ч Их Британийн Дээд шүүх энэ заалтыг хүчингүй болгосон байна. Шүүх үүнийг Европын Хүний эрхийн тухай конвенцод заасан гэмт хэрэгтнүүдийн хувийн нууцад хамаарах эрхэд нь «пропорциональ бус хөндлөнгийн оролцоо» болно гэж үзжээ. Парламент 2012 онд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, насан туршдаа бүртгүүлэх бүртгүүлэгчид уг шаардлагыг харгалзан, зарим тохиолдолд цуцлах механизмыг бий болгосон. 2016-2018 оны хооронд бүртгэлээс хасах хүсэлт гаргасан иргэдийн 72 хувь нь хүсэлтийг нь хангасан байна.
				Бүртгэлтэй мэдээлэл нь нийтэд нээлттэй биш боловч хууль сахиулах байгууллагуудад нээлттэй байдаг. Германы Эрүүгийн хуулийн 68b StGB; Энэ хэсэг нь бэлгийн харьцааны онц хүнд гэмт хэрэг үйлдэж, дахин гэмт хэрэг үйлдэх томоохон эрсдэлтэй гэж үзсэн хүмүүсийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахыг зөвшөөрдөг.
				Эрүүгийн эрх зүйн зарим асуудлыг муж улсын түвшинд зохицуулдаг тул тодорхой журам, дүрэм журам нь муж мужаас (Бундесланд) хамаарч өөр өөр байж болохыг анхаарах нь чухал.
4.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	ХБНГУ-д бэлгийн гэмт хэрэг үйлдсэний улмаас их хэмжээний хорих ял, торгууль оногдуулж, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэгчээр бүртгэнэ.	ХБНГУ-д бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэгчийг бүртгэхтэй холбоотой тусгай хууль байдаггүй. Харин Германы Эрүүгийн хуулийн ⁴ 68f хэсэгт (Strafgesetzbuch эсвэл StGB) зохицуулдаг.	

4 Criminal Code in the version published on 13 November 1998 (Federal Law Gazette I, p. 3322), as last amended by Article 2 of the Act of 22 November 2021 (Federal Law Gazette I, p. 4906), Холбооц: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

5.	Бүгд найрамдах Солонгос Улс	<p>Одоогоор бага насны болон өсвөр насны хүүхдийн эсрэг үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргийг БНСУ-д дараах хуулиудаар зохицуулдаг.</p> <p>Бэлгийн гэмт хэрэгт оногдуулах тусгай хуулийн⁵ 7 дугаар зүйл.</p> <p>① 13 нас хүрээгүй хүний эсрэг Эрүүгийн хуулийн 297 дугаар зүйл (Хүчиндэх)-д заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд бүх насаар нь хорих, эсхүл 10-аас дээш жил хорих ялаар шийтгэнэ.</p> <p>② 13 нас хүрээгүй хүний биед халдаж, айлган сүрдүүлж дор дурдсан үйлдлийн аль нэгийг үйлдсэн бол 7 жилээс доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.</p> <p>1. Ам, анус гэх мэт биеийн дотор (бэлэг эрхтнээс бусад) бэлэг эрхтнээ оруулах</p> <p>2. Биеийн хэсэг (бэлэг эрхтнийг эс тооцвол) эсвэл хуруу, эд зүйлийг бэлэг эрхтэн, анус руу оруулах.</p>	<p>Шагайн цахим төхөөрөмж (Цахим төхөөрөмжийн тухай хууль)</p> <p>Хамгаалалтын арга хэмжээ нь ялын гүйцэтгэл дууссаны дараа хэрэгжинэ. Энэ нь прокуророос шүүхэд хүсэлт гаргаж, батлагдсанаар тогтоогдох бөгөөд дор дурдсан зүйл байвал прокурор цахилгаан төхөөрөмж зүүлдэг.</p> <p>1. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд ял эдэлж, ялаас чөлөөлөгдсөнөөс хойш 10 жилийн дотор бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг дахин үйлдсэн бол.</p> <p>2. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэхийг завдсан тул цахим төхөөрөмж зүүх тушаал авч байсан хүн дахин бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэх үед</p> <p>3. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг хоёроос дээш удаа үйлдсэн (хэрэв гэм буруутай нь тогтоодсон бол) гэмт хэрэг үйлдэж байсан нь хүлээн зөвшөөрөгдсөн.</p>	<p>Гэмт хэрэгтнүүдийн мэдээллийг олон нийтэд ил болгож https://www.sexoffender.go.kr гэх сайтад байрлуулдаг ба энэ талаар "MUGSHOT Ил тод болгох тухай хууль" /mid shot disclosure bill/, "Зарим онц хүнд гэмт хэргийн сэжигтний хувийн мэдээллийг задруулах тухай хууль" /law on the Disclosure of Personal Information of Suspects of Specific Serious Crimes/-аар зохицуулдаг.</p>
----	--------------------------------------	---	--	---

5 Act on Special Cases Concerning The Punishment of Sexual Crimes 2010, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27332&type=part&key=7, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

	<p>Хүүхэд, өсвөр үеийнхний эсрэг бэлгийн хүчирхийллийн тухай хуулийн⁶ 7 дугаар зүйл (Хүүхэд, өсвөр үеийнхнийг хүчиндэх, хүчирхийлэх гэх мэт)</p> <p>① Хүүхэд, өсвөр насны хүүхдийг айлган сүрдүүлж хүчиндсэн этгээдийг бүх насаар нь хорих, эсхүл 5 ба түүнээс дээш жил хорих ялаар шийтгэнэ.</p> <p>② Хүүхэд, өсвөр насныхны эсрэг халдсан, айлган сүрдүүлэх замаар дор дурдсан үйлдлүүдийн аль нэгийг үйлдсэн этгээдийг гурван жил ба түүнээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.</p> <p>Бэлгийн эрхтнийг ам, анус гэх мэт биеийн дотор (бэлэг эрхтнээс бусад) оруулах</p> <p>Биеийн хэсэг (бэлэг эрхтнийг эс тооцвол) эсвэл хуруу зэрэг багажийг бэлэг эрхтэн, анус руу оруулах.</p>	<p>4. 19 нас хүрээгүй хүүхэд, өсвөр насныхны эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд.</p> <p>5. Сэтгэцийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдсэн.</p> <p>Эдгээр төрлийн гэмт хэрэгт ял эдэлж байсан бол шагайн цахим төхөөрөмж зүүх ба хугацааг шүүхээр тогтоож өгнө. Жишээлбэл:</p> <p>Цаазаар авах болон бүх насаар нь хорих ялаар шийтгэсэн тохиолдолд: 10-30 жил</p> <p>3 жилээс дээш хугацаагаар хорих ялтай бол: 3-20 жил.</p> <p>3 жилээс доош хугацаагаар хорих ялтай бол: 1-10 жил.</p> <p>Цахим төхөөрөмж зүүх хугацааг сунгаж болно. Гэмт хэрэгтэн хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр гадаадад зорчих, гадагш гарсан тохиолдолд прокурорын хүсэлтээр түүний хугацааг сунгаж болно.</p>	
--	---	---	--

6 Act on The Protection of Children and Youth Against Sex Offenses, 2009, Холбоос: https://elaw.kfri.re.kr/leng_mobile/viewer.do?hseq=33019&type=part&key=16, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

		<p>Хүүхдийн халамжийн тухай хуулийн⁷ 17 дугаар зүйл (Хорлоотой үйлдэл) Дараах үйлдлүүдийн аль нэгийг хийж болохгүй. Хүүхдийг садар самуун явдалд хүргэх, зуучлах зэрэг бэлгийн хүчирхийллийн үйлдлүүд, эсвэл хүүхдэд бэлгийн дарамт учруулах.</p>		
<p>6. Оросын Холбооны Улс</p>	<p>ОХУ-ын Эрүүгийн хуулийн⁸ 131 дүгээр зүйлээр "Хүчиндэх" гэмт хэргийг хуульчилсан байна. Тус зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар "хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй нөхцөл байдлыг ашиглан, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүч хэрэглэн бэлгийн харилцаанд орсон" бол 3-6 жил хорих ял оногдуулахаар тусгажээ. Уг заалтын 4-т зааснаар бага насны хүүхдийг хүчиндэж бэлгийн дур хүслээ хангасан бол 12-20 жилийн хугацаанд хорих ял эдлүүлж, тодорхой төрлийн албан тушаал эрхлэх эрхийг хасахаар хуульчилжээ.</p>	<p>Эрүүгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173 дугаар зүйлд зааснаар хорих ялаас чөлөөлөгдсөн этгээдэд захиргааны хяналтыг тавьдаг байна. Өөрөөр хэлбэл, засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааны зүгээс ял шийтгэгдсэн этгээдийн сонгосон оршин суух газраар зорчих хөдөлгөөнд оролцох, тогтоосон цаг хугацаанд зорчих зэргийг заасан байх бөгөөд хэрэв тухайн этгээд тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд шүүхээс хорих ялаар солих хуулийн заалттай.</p>		<p>Тухайлсан асуудлаар ОХУ-ын холбогдох хуулиудад зохицуулаагүй байна.</p>

7 Child welfare act, 2011, Холбоос: https://elaw.kiri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=39028&type=sogan&key=10, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

8 The Criminal Code of The Russian Federation No. 63-Fz of June 13, 1996, Холбоос: <https://www.legal-tools.org/doc/8eed35/pdf/>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

<p>7.</p> <p>Канад</p> <p>Улс</p>	<p>Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийн бүртгэл мэдээллийн тухай хууль /Sex Offender Information Registration Act⁹-аар бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг бүртгэж мэдээлдэг. Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 227 дугаар бүлгээр уг харилцааны эрх зүйн харилцааг зохицуулж байна.</p>	<p>Хуулийн дагуу хүчиндэх гэмт хэрэгт гэм буруутгайд тооцогдож, эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээдээс гадна хэрэг хариуцах чадваргүй үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээгээгүй этгээдүүд өөрийн овог нэр, нас хүйс, бүртгэлтэй эсхүл оршин суугаа хаяг, ажлын байр, сургуулийн хаяг, мэдээлэл, холбоо барих утасны дугаар, өндөр, жин, нүд, үсний өнгө, биеийн бусад онцлох өгөгдөл, шаардлагатай бол тэдгээрийн зурган мэдээлэл, эзэмшиж буй автомашины дугаар, арлын дугаар, өнгө, загвар, үйлдвэрлэгдсэн огноо, жолооны үнэмлэхийн дугаар, мэдээлэл, гадаад паспортын мэдээлэл зэргийг өөрийн биеэр Бүртгэлийн төвд (Registration Center) очиж мэдүүлэх үүрэг хүлээдэг. Мэдүүлэг өгсөн этгээдийг гэмт хэрэгтэн биш гэж үзэх үндэслэл байна гэж үзвэл хурууны хээг таниулах боломжтой.</p>	<p>Гэмт этгээдээс гадна цагдаагийн байгууллага ял шийтгэл хүлээсэн дээрх этгээдүүдэд холбогдох шүүхийн шийдвэрийг хүлээн авч түүний дагуу бүртгэл үүсгэдэг бөгөөд ингэхдээ хохирогч бүрийн нас, ямар харилцаатай байсан зэргийг мөн бүртгэдэг. Тус хуульд дээр заасан бүртгэлийг үүсгэх, хөтлөх, хариуцах байгууллагын харьяалал зэргийг тодорхой тусгаснаас гадна мэдээллийн санд нэвтрэх, мэдээлэлтэй танилцах, түүний алдааг засах, мэдээллийг задруулах үндэслэл, журмыг тогтоосон байна.</p> <p>Гэмт хэрэгтэн болон хохирогчийн талаарх мэдээллийг бүртгэсэн, түүнтэй танилцсан этгээд мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээх бөгөөд мэдээлэл өгөгчид түүний өгсөн мэдээллийн хуулбарыг өгөх үүрэг хүлээдэг.</p>
-----------------------------------	---	---	--

9 Sex Offender Information Registration Act (S.C. 2004, с. 10), Холбоос: <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-8.7/>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

II. ПЕДОФИЛ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСТ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЛАВЛАГАА

№	Улс	Педофил өвчтэй хүмүүст авах арга хэмжээний талаар	Нэмэлт арга хэмжээ/ Хорих ялаас бусад төрлийн ял
1.	Америкийн Нэгдсэн Улс	<p>Гэмт хэрэгт оногдуулах ял</p> <p>Педофил гэж насанд хүрээгүй хүүхдээс бэлгийн таашаал авахыг хүссэн сэтгэцийн эмгэг юм. Калифорнийн эрүүгийн төрөлжсөн хуулийн 288-д (California Penal Code^{10§ 288}) 14 нас хүрээгүй хүүхдийг биед болон аль нэг хэсэгт санаатайгаар өөрийн бэлгийн дур хүслийг хангах гэх зэрэг гэмт хэрэгт 3, 6, 8 жилийн хорих ял оноодог байна.</p> <p>Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд хорих ялаа эдэлж дууссаны дараа эрх бүхий байгууллагад заавал бүртгүүлэх шаардлагатай байдаг¹¹ бөгөөд тухайн мэдээлэл нь нийтэд ил байдаг.</p>	<p>Америкийн хэд хэдэн мужуудад химийн кастрация бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэнд хийхээр зөвшөөрдөг байдаг байна. Жишээ нь: Калифорни мужийн Castration law¹² 645 дугаар хэсэгт бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэнд зориулсан Кастрация химийн бодис болох жирэмслэлтийн эсрэг дааврын бэлдмэл, жирэмслэлтээс хамгаалах эм хэрэглэж хэрэгтний тестостероны түвшнийг бууруулж, улмаар бэлгийн дур хүслийг бууруулдаг байна. Энэхүү эмчилгээ нь хэрэгтний өөрөө хянаж чадахгүй байгаа бэлгийн дур хүслийг эмчлэхэд нэн тохиромжтой гэж үздэг байна.</p> <p>Мөн Калифорни мужийн Эрүүгийн хуулийн 645 дугаар хэсэгт 13 нас хүрээгүй хүүхдийг давтан хүчирхийлсэн тохиолдолд заавал медроксипрогестерон ацетат (medroxyprogesterone acetate) дааврын эмчилгээг хийлгэхийг шаарддаг байна. Тухайн хэрэгтэн ял эдэлж дуусахаас нэг долоо хоногийн өмнө эмчилгээгээ эхлэх бөгөөд Засан хүмүүжүүлэх газраас эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эмчилгээг зогсоодог байна. Мөн хэрэгтэн химийн дааврын эмчилгээ хийлгэхгүйгээр сайн дураараа мэс засал хийлгэх боломжтой байдаг байна.</p>

10 California Penal Code, Холбоос: <https://leginfo.ca.gov/faces/codesTOCSelected.xhtml?tocCode=PEN&tocTitle==+Penal+Code+-+PEN>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

11 Pedophilia, Холбоос: <https://www.law.cornell.edu/wex/pedophilia>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

12 California's Castration Law for Sex Offenders (PC Section 645), June 13, 2022 By Stephen Klarich, Холбоос: <https://www.wksexcrimes.com/california-castration-law-sex-offenders/>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

		<p>Ийм сэтгэцийн эмгэгээс шалтгаалан ялын хэмжээнд өөрчлөлт орохгүй. Харин хоёр дахь удаагаа үйлдсэн бол Ялын тухай хуулиар¹³ гэмт хэрэгтнүүдэд автоматаар бүх насаар нь хорих ял оноодог.</p>	<p>Шүүхээс гэмт хэрэгтнүүдэд цэцэрлэгт хүрээлэн, сургууль гэх мэт хүүхдүүд цуглардаг газруудад орохыг хориглох зэрэг нөхцөлүүдийг тавьж болдог.</p> <p>Оношилгоо ба үнэлгээ: Педофил эмгэгтэй хүмүүсийг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн эмнэлзүйн үнэлгээгээр оношлох боломжтой. Энэхүү үнэлгээ нь эмгэгийн шинж чанар, ноцтой байдлыг тодорхойлоход тусална.</p> <p>Эмчилгээ: Педофил эмгэгийн эмчилгээг ихэвчлэн сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь үндсэн асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн сэтгэлзүйн эмчилгээ, зөвлөгөө болон зөвшөөрлийн үндсэн дээр тарилга тарьж бэлгийн дур хүслийг багасгах арга хэмжээг хамарч болно. Эмчилгээ нь ихэвчлэн хүмүүст эмгэгээ даван туулах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад тусалдаг.</p> <p>Эрсдэлийн үнэлгээ ба менежмент: Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн педофил өвчтэй хүмүүс эрсдэлийн үнэлгээнд хамрагдана. Эдгээр үнэлгээг дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг үнэлж, эмчилгээ, хяналт, нийгэмд нийгэмшүүлэх талаар шийдвэр гаргахад ашигладаг.</p> <p>Хяналт: Гэмт хэргийн хүнд байдал, хувь хүний эрсдэлийн түвшнээс хамааран тэнсэн суллах ажилтан/probation or parole officers/, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хяналтад байж болно. Үүнд байнгын үзлэгт хамрагдах, эмчилгээний төлөвлөгөөг дагаж мөрдөх, болзошгүй хохирогчтой холбоо тогтоохыг хязгаарлах зэрэг орно.</p> <p>Гэмт хэрэг үйлдэгчээр бүртгүүлэх: Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хэргээр ял шийтгүүлсэн тохиолдолд тэд ихэвчлэн бэлгийн гэмт хэрэг үйлдэгчээр бүртгүүлэх шаардлагатай болдог. Энэхүү бүртгэлд хууль сахиулах байгууллагад хувийн мэдээлэл өгөх, үе үе шинэчлэлт хийх зэрэг багтана.</p> <p>Нийгэмд дахин нэгтгэх: Педофил өвчтэй зарим хүмүүсийг нийгэмд болзолтойгоор суллах, ихэвчлэн хатуу нөхцөл, байнгын хяналттай байхаар тооцож болно. Эрсдэлийн үнэлгээ, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн суллах шийдвэрийг гаргадаг.</p>
2.	Англи		

	3.	<p>Эрүүгийн хуулийн¹⁴ 197 болон 200 дугаар зүйлүүдэд хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд бага насны хүүхдийг хүчиндэх болон бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох гэмт хэргүүдийг тусад нь хуульчилсан байна. Бага насны хүүхэд буюу 15-аас доош насны хүүхдийг хүчиндсэн бол хамгийн багадаа 3 жил хорих ял оногдуулахаар дээд хязгаарыг тогтоолгүй хуульчилжээ. Харин бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орсон үйлдэлд 2-12 жилийн хорих ялыг тус тус хуульчилсан байна. Түүнчлэн, 2006 дугаар зүйлд Педофилийн зан үйлийг зөвшөөрөх гэсэн гэмт хэрэг байдаг бөгөөд Педофилийн зан үйлийг олон нийтэд сурталчлах эсвэл зөвшөөрсөн хэн бүхэн торгууль, эрх чөлөөг хязгаарлах эсвэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Харин педофил өвчтэй хүмүүст тусад нь ял оноох зохицуулалт байхгүй.</p>	<p>Польш улс нь эмийн эмчилгээг зөвшөөрлийн үндсэн дээр бус гэмт хэргийн санхиад оруулж заавал дагаж мөрдөхөөр хуульчилсан орон юм. Эрүүгийн хуулийн 95а.-д "Хаалттай байгууллага; эм зүйн эмчилгээ"-ний талаар заасан бөгөөд үүнд дараахыг тусгасан.</p> <p>§1. Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг эсхүл бэлгийн гаж дур сонирхолтой холбоотой гэмт хэрэгт шүүх хорих ялыг оногдуулахдаа хорих ялыг эдэлж дууссаны дараа хаалттай хорих ангид хорих ялаар шийтгэх эсхүл дахин ийм төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлгийн дур хүслийг бууруулах замаар түүнийг эмийн эмчилгээ, сэтгэлзүйн эмчилгээнд хамруулна.</p> <p>Гэмт этгээдийн амь нас, эрүүл мэндэд ямар нэгэн аюул учруулж болзошгүй тохиолдолд эмийн эмчилгээг хэрэглэхгүй.</p>
4	Македон	<p>БНМУ-ын Эрүүгийн хуулийн¹⁵ 188 дугаар зүйлд бага насны /14 насанд хүрээгүй/ хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг заасан ба педофил өвчтэй эсэхээс үл харгалзан хамгийн багадаа 12 жилийн ялыг онохоор байна.</p>	<p>188-д заасан гэмт хэрэгт аюулгүй байдлын арга хэмжээ /safety measure/ авдаг.</p> <p>Эрүүгийн хуулийн 62(б)-ын дагуу 14 хүртэлх насны хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтэн хорих ялаар шийтгүүлсэн тохиолдолд эмнэлгийн болон эмийн эмчилгээ хийлгэж болно. Энэ нь заавал биш бөгөөд тухайн этгээдэд оноосон ялын талыг хасах болзлоор энэхүү аюулгүй байдлын арга хэмжээг санал болгодог байна.</p>

14 The Criminal Codez dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. tłum. gb Nr 88, poz. 553), Холбоос: [https://sherloc.unodc.org/cid/uploads/res/unscac/Legallibrary/Poland/Laws/Criminal%20Code%20\(Poland\).pdf](https://sherloc.unodc.org/cid/uploads/res/unscac/Legallibrary/Poland/Laws/Criminal%20Code%20(Poland).pdf), Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

15 Criminal code, 1996, Холбоос: https://www.rightofassembly.info/assets/downloads/1996_Criminal_Code_of_North_Macedonia.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

ДҮГНЭЛТ

АНУ болон БНСУ нь хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийн мэдээллийг олон нийтэд тавьдаг байхад судалсан орнуудын олонх нь олон нийтэд ил тавихаас татгалзах, хязгаартайгаар задруулах зэрэг зохицуулалттай байна. Ялангуяа Европын Холбооны орнуудад хувийн нууцад халддаг гэж үзэн зайлшгүй шаардлагатай тохиолдлуудад мэдээллийг ил болгох журамтай байна. Харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаанд тухайн этгээд өөрсдийн мэдээллийг бүртгүүлэхийг үүрэг болгосон тохиолдлууд нийтлэг ажиглагдлаа.

Дэлхийн улс орнуудад хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтнүүд болон педофил өвчтэй хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлгийн дур хүслийг бууруулах, гормоны ялгаралтыг багасгах арга хэмжээ /кастраци/-г түгээмэл авдаг байна. Энэ аргыг АНУ, Аргентин, Австрали, Эстони, Израиль, Молдав, Шинэ Зеланд, Польш, Орос, Дани, Герман, Унгар, Франц, Норвеги, Финлянд, Исланд, Литва, Их Британи, Бельги, Швед, Македон, Турк, Индонез зэрэг олон улсын эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан байдаг байна. Ингэхдээ мэс заслын болон эм зүйн гэсэн үндсэн 2 аргаар багасгадаг. Хоёр дахь хэсэгт сонгон судалсан орнууд нь бүгд эм зүйн аргаар гормон ялгаралтыг багасгадаг орнууд юм.

Уг арга хэмжээг авдаг орнуудын хуулиудыг ангилахад дараах гурван хувилбар гарч ирдэг байна.¹⁶ Нэгдүгээрт, эм зүйн аргаар явуулах нь «сайн дурын үндсэн дээр» байж болно, учир нь тухайн хүн тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж, ийм эмчилгээ хийлгэхийг зөвшөөрсөн тохиолдолд л эм зүйн кастраци гэж хуулийн дагуу үзнэ. Үүнд Англи, Дани зэрэг хэд хэдэн улс орны эрх зүйн зохицуулалт хамаардаг. Хоёрдугаарт, эм зүйн кастрацитай холбоотой хууль нь «сонголттой» байж болно. Эм зүйн кастраци нь тухайн хүн тодорхой гэмт хэрэг үйлдэж, шүүхээс оногдуулах бусад ялын хамт (хорих гэх мэт) ялын төрөл байж болно. Гэхдээ шүүх тус зохицуулалтыг заавал хэрэглэхээр тусгаагүй. Хэрэв шүүхээс ял оногдуулсан бол ял эдэлж байгаа хүн эмчилгээ хийлгэх шаардлагатай. Гуравдугаарт, хуульд «заавал» авахаар тусгагдсан байж болно. Хэрэв тухайн хүн тодорхой төрлийн гэмт хэрэгт буруутгагдаж байгаа бол шүүх эм зүйн аргаар кастраци хийх түүнчлэн хорих гэх мэт бусад ял оногдуулах ёстой. Ихэвчлэн гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд химийн аргаар кастраци хийх ялыг заавал оногдуулах тухай хууль үйлчилдэг байна.

16 Vedije Ratkoceri, Chemical Castration of Child Molesters – Right or Wrong?! June 2017 European Journal of Social Sciences Education and Research 11(1):70 DOI:10.26417/ejser.v11i1.p70-76, Холбоос: https://www.researchgate.net/publication/320590655_Chemical_Castration_of_Child_Molesters_-_Right_or_Wrong, Сүүлд үзсэн огноо: 2023.10.11.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. Directive 2011/93/EU of the European Parliament and of the Council of 13 December 2011 on combating the sexual abuse and sexual exploitation of children and child pornography, and replacing Council Framework Decision 2004/68/JHA, provision 43, Холбоос:<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?qid=1574272335934&uri=CELEX:32011L0093>
2. Sexual Offences Act, 2003, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2003/42/contents>,
3. Criminal Code in the version published on 13 November 1998 (Federal Law Gazette I, p. 3322), as last amended by Article 2 of the Act of 22 November 2021 (Federal Law Gazette I, p. 4906), Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html
4. Act on Special Cases Concerning The Punishment of Sexual Crimes 2010, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=27332&type=part&key=7,
5. Act on The Protection of Children and Youth Against Sex Offenses, 2009, Холбоос: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=33019&type=part&key=16 ,
6. Child welfare act, 2011, Холбоос:https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=39028&type=sogan&key=10,
7. The Criminal Code of The Russian Federation No. 63-Fz of June 13, 1996, Холбоос: <https://www.legal-tools.org/doc/8eed35/pdf/>,
8. Sex Offender Information Registration Act (S.C. 2004, c. 10), Холбоос: <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-8.7/>
9. California Penal Code, Холбоос:<https://leginfo.ca.gov/faces/codesTOCSelected.xhtml?tocCode=PEN&tocTitle=+Penal+Code+-+PEN>
10. Pedophilia, Холбоос:<https://www.law.cornell.edu/wex/pedophilia>
11. California's Castration Law for Sex Offenders (PC Section 645), June 13, 2022 By Stephen Klarich, Холбоос:<https://www.wksexcrimes.com/california-castration-law-sex-offenders/>,
12. Prosecution of Offences Act 1985, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/1985/23>
13. The Criminal Codez dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. tłum. gb Nr 88, poz. 553), Холбоос:[https://sherloc.unodc.org/cld/uploads/res/uncac/LegalLibrary/Poland/Laws/Criminal%20Code%20\(Poland\).pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/uncac/LegalLibrary/Poland/Laws/Criminal%20Code%20(Poland).pdf)
14. Criminal code, 1996, Холбоос:https://www.rightofassembly.info/assets/downloads/1996_Criminal_Code_of_North_Macedonia.pdf

Цахим эх сурвалж

1. Penalties For Child Sexual Abuse Accused of Sexual Abuse? Fight Your Punishment, Холбоос: <https://www.rsweeneylaw.com/criminal-defense/sex-crimes/penalties-for-child-sexual-abuse/>
2. Vedije Ratkoceri, Chemical Castration of Child Molesters – Right or Wrong?! June 2017 European Journal of Social Sciences Education and Research 11(1):70 DOI:10.26417/ejser.v11i1.p70-76, Холбоос: https://www.researchgate.net/publication/320590655_Chemical_Castration_of_Child_Molesters_-_Right_or_Wrong.

ДОЛОО. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 21.9 ДҮГЭЭР ЗҮЙЛ
“МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХ”
ГЭМТ ХЭРГИЙН ЛАВЛАГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
----------------	---

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
М.Ганди	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Санчир	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.10.15.

АГУУЛГА

I. ГАДААД ОРНУУД ДАХЬ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЛАВЛАГАА	289
II. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ	295
НОМ ЗҮЙ	298

I. ГАДААД ОРНУУД ДАХЬ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЛАВЛАГАА

Д/д	Улс	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	Субъект	Оногдуулах ял
1.	Монгол Улс	<p>Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэрэг гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх журам, хэрэг хянан шийдвэрлэх хэвийн үйл ажиллагаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлд хуульчлан тодорхойлж эрүүгийн харууцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.¹</p> <p>Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах</p> <p>1.Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн, мөрдөн шалгах ажиллагааны талаарх албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олон нийтэд задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>2.Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Эрүүгийн хуульд эрүүгийн харууцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн хэрэг харууцах чадвартай, мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт мэдээллийг олж мэдсэн хүн, эсхүл мөрдөн шалгах үйл ажиллагааны талаарх албаны үүргийн дагуу олж мэдсэн албан хаагч, ажилтан байна.</p>	<p>Ерөнхий: дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>Хүндрүүлэх : нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

1 Эрүүгийн эрх зүйн тусгай анги, Дотоод хэргийн Их сургууль-Цагдаагийн сургууль, (УБ, 2020), 313 дахь тал.

ХБНГУ-ын Эрүүгийн хууль 353б	ХБНГУ-ын Эрүүгийн хууль 353б	ХБНГУ-ын Эрүүгийн хуульд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэрэг нь мөрдөн байцаалтын бүрэн бүтэн байдал, мөрдөн шалгах ажиллагааны явцад олж мэдсэн нууцыг хамгаалах зорилготой заалтуудаар зохицуулагддаг. Энэ асуудлыг зохицуулсан гол зүйл заалт бол Германы Эрүүгийн хуулийн 353б хэсэг (StGB) юм. ХБНГУ-ын Эрүүгийн хууль 353б. Албаны болон тусгай нууцыг хамгаалах үүргээ зөрчих (1)Хэрэв: 1. Төрийн албан хаагч; 2. Төрийн тусгай үүрэг бүхий албан хаагч;	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
(1) ... 5 жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. Гэмт хэрэгтэн болгоомжгүйгээр нийтийн ашиг сонирхолд аюул учруулсан бол 1 жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. (2) ... 3 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.	1. Төрийн албан хаагч, 2.Төрийн тусгай үүрэг бүхий албан хаагч, 3. Ажилчдыг төлөөлөх тухай хуульд заасан чиг үүрэг эсвэл бүрэн эрх хүлээж авсан этгээд	3. ажилчдыг төлөөлөх тухай хуульд заасан чиг үүрэг эсвэл бүрэн эрх хүлээж авсан этгээд итгэмжлэл олж авсан буюу мэдсэн нууцыг зөвшөөрөлгүйгээр задруулсны улмаас нийтийн ашиг сонирхолд аюул учруулсан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. Гэмт хэрэгтэн болгоомжгүйгээр нийтийн ашиг сонирхолд аюул учруулсан бол нэг жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ. (2) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөвшөөрөлгүйгээр: 1. Холбооны улсын болон мужийн хууль тогтоох байгууллага эсвэл түүний хорооноос гаргасан шийдвэр дээр үндэслэн нууц хадгалах үүрэг хүлээж олж авсан; 2. бусад төрийн байгууллагаас нууцыг чандлах хадгалах үүргээ зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээх тухай сануулга авч олж авсан объект эсвэл мэдээллийг бусдад олж авах боломж олгосон, нээлттэй болгосон зэргийн улмаас нийтийн ашиг сонирхолд аюул учруулсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.	2.

3. Оросын Холбооны Улс	310 дугаар зүйл. Урьдчилсан мөрдөн байцаалт /Preliminary Investigation/-ын нууцыг задруулах ² Хуулиар тогтоосон журмын дагуу урьдчилсан мөрдөн байцаалтын мэдээ баримтыг задруулахгүй байх талаар үүрэг хүлээж сануулга авсан этгээд мөрдөгч, хэрэг бүртгэлт явуулж буй этгээд /производящего дознание/-ийн зөвшөөрөлгүйгээр түүнийг задруулсан бол 80,000 хүртэл рубль эсхүл ялтны 6 сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл 480 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.	Хуулиар тогтоосон журмын дагуу урьдчилсан мөрдөн байцаалтын мэдээ баримтыг задруулахгүй байх талаар үүрэг хүлээж сануулга авсан этгээд.	80,000 хүртэл рубль эсхүл ялтны 6 сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл 480 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл 3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
4. Бүгд Найрамдах Эстони Улс	Эрүүгийн хэргийн урьдчилсан шүүхийн ажиллагаа болон гэмт хэргээс проseeeding/ болон хяналт тогтоох ажиллагаа/surveillance proceedings/-тай холбоотой мэдээллийг хууль бусаар задруулах. ³ Эрүүгийн хэргийн урьдчилсан шүүхийн ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор явуулсан хяналт тогтоох ажиллагаатай холбоотой мэдээллийг албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан мэдсэн этгээд хууль бусаар задруулсан бол гэмт хэргийн шинжтэй, ял оногдуулах үйлдэл хийгдсэн эсхүл хийгдээгүй гэдгийг тогтооход, нотлох зүйлийн бусад баримтыг тогтооход эсхүл хяналт тогтоох үйл ажиллагааны зорилгод хүрэхэд боломжгүй болгосон буюу ноцтой хүндрэл учруулсан бол торгууль оногдуулах эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.	Албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан мэдсэн этгээд.	Торгууль оногдуулах эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.
5. Бүгд Найрамдах Латви Улс	Бүгд Найрамдах Латви Улсын Эрүүгийн хуулийн 304 дүгээр зүйл. Шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгалтын явцад гарсан мэдээллийг задруулах Прокурор, мэдээлэлд хамаарах этгээдээс зөвшөөрөл авалгүйгээр шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгалтын ажиллагааны мэдээллийг задруулахгүй байхыг анхааруулсны дараа задруулсан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгоно ⁴ .	Мэдээллийг задруулахгүй байхыг анхааруулсан этгээд.	Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгоно.

2 Уголовный кодекс Российской Федерации от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 12.06.2024) (с изм. и доп., вступ. в силу с 01.07.2024). Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/, Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

3 Penal Code, Холбоос: <https://www.rigitateaja.ee/en/eil/522012015002/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

4 The Criminal Law of Latvia, Tulkõšanas un terminoloõijas centrs, Холбоос: <https://www.wamathgroup.com/wp-content/uploads/2015/03/Latvia-Criminal-Code.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

6.	<p>Бүгд Найрамдах Финланд Улс</p>	<p>Бүлэг 38 - Мэдээлэл, харилцаа холбооны гэмт хэрэг (578/1995) 1-р хэсэг - Нууцлалын гэмт хэрэг (578/1995) Дараах тохиолдолд хууль тогтоомжийн дагуу олж авсан буюу хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас тусгайлан даалгасан нууцын үүргийг зөрчсөн этгээдэд тооцно. Үүнд: (1) албан тушаал, үүрэг даалгаврын дагуу эсвэл үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, нууцлах ёстой мэдээллийг задруулсан, эсхүл (2) 40-р бүлгийн 5-д заасны дагуу /Албаны нууцыг зөрчих гэмт хэрэгт/ шийтгэгдээгүй бол ийм нууцыг өөртөө эсвэл өөр бусдад ашиг сонирхлын үүднээс ашигласан бол нууцын эсрэг гэмт хэрэг үйлдсэнд тооцож торгох, эсхүл хамгийн ихдээ нэг жилийн хугацаагаар хорих ял оногдуулна.</p>	<p>Хууль тогтоомжийн дагуу олж авсан буюу хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас тусгайлан даалгасан нууцын үүргийг хүлээж буй этгээд</p>	<p>Торгох, эсхүл хамгийн ихдээ нэг жилийн хугацаагаар хорих ял оногдуулна.</p>
7.	<p>Бүгд Найрамдах Франц Улс</p>	<p>Францын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль (Code de procédure pénale) болон бусад холбогдох хуулиудад голчлон тусгасан болно. Францын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль 11.⁵ Хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нууц байна. Ийм хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон аливаа этгээдийг Эрүүгийн хуулийн 226-13, 226-14 дүгээр зүйлд заасан нөхцөл, шийтгэлийн дагуу мэргэжлийн нууцад хамруулна. Францын Эрүүгийн хууль /Penal code/ 226-13.⁶</p>	<p>Итгэмжлэгдсэн этгээд албан тушаал, мэргэжлээрээ, эсвэл түр зуурын үүрэг гүйцэтгэсэн этгээд.</p>	<p>1 жилийн хорих ял, 15,000 еврогийн торгууль оногдуулна.</p>

5 France Code of Criminal procedure, Холбоос: https://sherloc.unodc.org/cid/uploads/res/document/fra/2006/code_of_criminal_procedure_en_html/France_Code_of_criminal_procedure_EN.pdf. Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

6 French Penal Code, Холбоос: https://www.equalrightstrust.org/eftrightbank/french_penal_code_33.pdf. Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

8.	Бүгд Найрамдах Солонгос Улс	<p>БНСУ-ын Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйл. Сэжиглэгдэж буй гэмт хэргийн талаар мэдээллийг нийтлэх.</p> <p>Прокурор, цагдаа болон гэмт хэрэг мөрдөн шалгах бусад үйл ажиллагаа явуулах, түүнд хяналт тавих, түүнд туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгэх явцад шүүхээр хэлэлцүүлэх хүсэлт гаргахаас өмнө өөрийн ажил үүргээ гүйцэтгэх үед мэдсэн гэмт хэргийн сэжигтний үйл баримтыг нийтэд мэдээлсэн этгээдийг гурван жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл таван жилээс дээшгүй хугацаагаар мэргэжлийн эрхийг хасах ял шийтгэнэ.⁷</p> <p>Испанийн Хаант Улс Эрүүгийн хуулийн 466 дугаар зүйл.</p> <p>1. Шүүхийн байгууллагаас нууц гэж зарласан мөрдөн шалгах ажиллагааны мэдээллийг задруулсан өмгөөлөгч, хуульчийг арван хоёроос хорин дөрвөн сар хүртэл хугацаагаар торгох, тусгай хязгаарлалтын дагуу ажиллах нэг жилээс дөрвөн жил хүртэл хугацаагаар төрийн албан тушаал эрхлэх, худалдаа хийх эрхийг тусгайлан хасах ялаар шийтгэнэ.</p> <p>2. Шүүгч, шүүхийн гишүүд, улсын яллагчийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн эрх бүхий албан тушаалтан нууцаар гэж зарласан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг задруулсан бол хуулийн 417 дугаар зүйлд заасан хариуцлагын /арван хоёртоос арван найман сар хүртэл торгох, нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар төрийн ажил, албан тушаал эрхлэхийг тусгайлан хориглох/ дээд хэмжээний талыг нь түүнд оногдуулна.</p> <p>3. Нэгдүгээр хэсэгт заасан үйлдлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон бусад этгээд үйлдсэн бол ялыг доод хэмжээний хагасаар нь оногдуулна.⁸</p>	<p>Өөрийн ажил явцад мэдээллийг олж эгтгээд.</p> <p>- Өмгөөлөгч, хуульч</p> <p>- Шүүгч, шүүхийн гишүүд, улсын яллагчийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтан</p> <p>- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон бусад этгээд.</p>	<p>Гурван жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл таван жилээс дээшгүй хугацаагаар мэргэжлийн эрхийг хасах ял шийтгэнэ.</p> <p>- 12-24 сар хүртэл хугацаагаар торгох, тусгай хязгаарлалтын дагуу ажиллах, 1-4 жил хүртэл хугацаагаар төрийн албан тушаал эрхлэх, худалдаа хийх эрхийг тусгайлан хасах ял шийтгэнэ.</p> <p>- Хуулийн 417 дугаар зүйлд заасан хариуцлагын /12-18 сар хүртэл торгох, 1-3 жил хүртэл хугацаагаар төрийн ажил, албан тушаал эрхлэхийг тусгайлан хориглох/ дээд хэмжээний талыг нь түүнд оногдуулна.</p> <p>- Энгийн бүрэлдэхүүний ялын доод хэмжээний хагасаар нь оногдуулна.</p>
9.	Испанийн Хаант Улс			

7 Criminal act of Korean, Act No. 11731, Apr. 5, 2013, 대한민국 영문법령, Холбоос: https://elaw.kiri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG, Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

8 ORGANIC ACT 10/1995, DATED 23RD NOVEMBER, ON THE CRIMINAL CODE OF SPAIN, Холбоос: https://www.mjusticia.gob.es/es/AreaTematica/Documentacion/Publicaciones/Criminal_Code_2016.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

	<p>Украин Улсын Эрүүгийн хуулийн 387 дугаар зүйл. Шүүхийн өмнөх шатны мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн талаарх мэдээллийг задруулах.</p> <p>1. Прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хамаарагдах хүний зөвшөөрөлгүй эсхүл нийтэд мэдээлэхийг зөвшөөрөөгүй мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэйг нь хуульд заасан журмын дагуу мэдэгдсэн этгээд шүүхийн өмнөх шатны мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн талаарх мэдээллийг задруулсан бол албан татвараас чөлөөлөх орлогын доод хэмжээг таваас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар нийгэмшүүлэх ажил хийлтгэх ял шийтгэнэ.</p> <p>2. Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөгч нь шүүхийн өмнөх хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын талаарх мэдээллийг нийтэд задруулснаас тухайн хүний нэр төр гутаан доромжлогдсон, нэр төр, алдар хүнд, хүний эрхэм чанарт хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, албан татвараас чөлөөлөх орлогын доод хэмжээг 100-300 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар нийгэмшүүлэх ажил хийлтгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.⁹</p>	<p>- Тухайн мэдээллийг задруулахгүй байх талаар мэдэгдсэн этгээд;</p> <p>- Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөгч.</p>	<p>-Албан татвараас чөлөөлөх орлогын доод хэмжээг таваас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар нийгэмшүүлэх ажил хийлтгэх ял шийтгэнэ.</p> <p>- Тодорхой албан тушаал эрхлэх эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, албан татвараас чөлөөлөх орлогын доод хэмжээг 100-300 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар нийгэмшүүлэх ажил хийлтгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>
<p>10. Украин Улс</p>			

9 Criminal Code of Ukraine (This Code enters into force on September 1, 2001), Холбоос: https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/ukr/2001/criminal-code-of-the-republic-of-ukraine-en_html/Ukraine_Criminal_Code_as_of_2010_EN.pdf. Сүүлд үзсэн огноо: 2023.10.15.

II. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

№	Он	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	Субъект	Тайлбар
1.	1926 он	157 дугаар зүйл. Шүүх таслах газрын гишүүн харьяат газрын хуралд аливаа хэргийг шүүмжлэн хэлэлцэж таслан шийтгэсэн учир шалтгааныг санаатайгаар бусдад задлаваас 100-600 төгрөг хүртэл торговол зохино.	Шүүх таслах газрын гишүүн	Тусгай субъект үйлдсэн бол гэмт хэрэгт тооцно.
2.	1929 он	161 дугаар зүйл. Шүүх таслах газрын хэсгүүд, харьяат газрын хуралд албан хэргийг шүүмжлэн хэлэлцэж таслан шийтгэсэн учир шалтгааныг санаатайгаар бусдад задруулбаас 100-600 төгрөг хүртэл торговоос зохимой		Тусгай субъект үйлдсэн бол гэмт хэрэгт тооцно.
3.	1940 он	134. Албан тушаалтнаас өөрийн урьдын буюу одоогийн албан тушаалын хувиар мэдсэн бөгөөд задруулж үл болох мэдээ зүйлүүдийг бусдад задруулсан буюу шилжүүлсэн байвал нэгэн жилээс доошгүй хугацаагаар хорьж шийтгэвэл зохино.	Албан тушаалтан	Тусгай субъект үйлдсэн бол гэмт хэрэгт тооцно.
4.	1960 он	151 дүгээр зүйл. Урьдчилан мөрдөн байцаасан ба хэрэг бүртгэсэн материалыг задруулах	Хэргийн оролцогчид	Тусгай субъект үйлдсэн бол гэмт хэрэгт тооцно.
5.	1986 он	209 дүгээр зүйл. Урьдчилсан мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн мэдээ баримтыг задруулах	Хэргийн оролцогчид болон мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцсон, байлцсан бусад этгээд	ЭБШХ-ийн 133 дугаар зүйлд заасны дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг гагцхүү хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зөвшөөрснөөр тэдний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно. Материалыг задруулж болохгүй тухай гэрч, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч, өмгөөлөгч, шинжээч, хэлмэрч, орчуулагч, хөндлөнгийн гэрч, мөрдөн байцаалт явуулахад байлцсан бусад хүмүүст урьдчилан мэдэгдэж, хэрэв зөрчвөл Эрүүгийн хуулийн 209 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулсан байна.

6.	2002 он	<p>257 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулах</p> <p>257.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин намэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгжээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>	<p>Хэргийн оролцогчид болон орчуулагч, хэлмэрч, шинжээч, хөндлөнгийн гэрч зэрэг нуууцын баталгаа гаргасан этгээд</p>	<p>Дээрхтэй адил хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцыг задруулаахгүй байх талаар урьдчилан сануулга авсан, хэрэг хариуцах чадвартай, 16 насанд хүрсэн этгээд байна.</p>
7.	2015 он	<p>21.9 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах</p> <p>1.Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн, мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олон нийтэд задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>2.Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хорих ял шийтгэнэ.</p>	<p>Мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон, байлцсан хүн гэдэгт хэргийн оролцогчид болон орчуулагч, хэлмэрч, шинжээч, хөндлөнгийн гэрч, иргэний нэхэмжлэгч, хариуцагчаар тогтоогдсон хүн зэрэг урьдчилан сануулсан, нууцын баталгаа гаргасан этгээд</p>	<p>Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүлэгт хамаарна.</p> <p>ЭХХШТХ 29.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал</p>

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллах үүрэгтэй. Мөрдөгч төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна.

Мөрдөн шалгах ажиллагаанд оролцох явцдаа мэдсэн, илэрхий болсон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын мэдээ, баримтыг оролцогч этгээд задруулахгүй байх үүрэг хүлээнэ. Баримт, мэдээлэл гэдэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэдүүлэг, хэргийн газрын үзлэг, нэгжлэг, бусад үзлэг, туршилтаар тогтоогдсон зүйл, шинжээчийн дүгнэлт, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах байгууллагад дуудагдсан хүний тухай болон бусад бүхий л байдлуудыг хамааруулан ойлгоно.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцыг хууль бусаар задруулах нь албаны болон иргэний үүргээ гүйцэтгэж байгаа хүмүүсийн эрх ашиг сонирхолд ноцтой хохирол учруулдаг. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулахгүй байх нь хууль зүйн хувьд хэргийн бодит үнэнийг тогтооход ач холбогдолтойн зэрэгцээ хэргийг шалгах явцад төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл хэрэгт авагдсан байдагт мөн чанар нь оршино.

Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь гэмт хэргийг түргэн шуурхай, бүрэн бодитой илрүүлэх талаарх хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын хэвийн үйл ажиллагаа юм.

Субъект нь ЭХХШТХ-д зааснаар мэдээ, баримтыг задруулахгүй байх талаар урьдчилан сануулсан, нууцын баталгаа гаргуулсан этгээд байна.

Тиймээс зөвхөн прокурорын зөвшөөрлөөр, зөвшөөрсөн хэмжээний мэдээллийг нийтэд мэдээлж болно. Ийнхүү нийтэд мэдээлэгдэж болох мэдээлэл, баримт нь хүчирхийлэл, аллага, хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, сэдэлжүүлсэн, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан байж болохгүйгээс гадна төр, байгууллага, хувь хүний болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцыг задруулахгүй байх хэмжээгээр нийтлэгдэнэ гэж УДШ тайлбарласан байдаг.

Мэдээлэл задруулсан гэдэгт прокурорын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мээ, баримтыг мэдэх ёсгүй хүмүүст тараасан, хэвлэлд нийтлүүлсэн гэх мэт идэвхтэй үйлдлийг ойлгоно.

НОМ ЗҮЙ

1. Эрүүгийн хууль, (2002).
2. Эрүүгийн хууль, (2016).
3. Шүүх цаазын бичиг, (1926).
4. Шүүх цаазын бичиг, (1929).
5. Шүүх цаазын бичиг, (1934).
6. Эрүүгийн хууль, (1940).
7. Эрүүгийн хууль, (1960).
8. Эрүүгийн хууль, (1986).
9. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль, (1998).
10. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль, (1996).
11. Бүгд Найрамдах Эстони Улсын Эрүүгийн хууль, (2001).
12. Бүгд Найрамдах Латви Улсын Эрүүгийн хууль, (2000).
13. Бүгд Найрамдах Финланд Улсын Эрүүгийн хууль, (1889).
14. Бүгд Найрамдах Франц Улсын Эрүүгийн хууль, (1810).
15. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль, (2013).
16. Испанийн Хаант Улсын Эрүүгийн хууль, (1995).
17. Украин Улсын Эрүүгийн хууль, (2001).
18. Дотоод хэргийн Их сургууль-Цагдаагийн сургууль, С.Гантулга, Б.Энхболд, “Эрүүгийн эрх зүйн тусгай анги”, (2020).
19. МУИС-ХЗС, “Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль”, (2021).

НАЙМ. СОГТУУРСАН БОЛОН МАНСУУРСАН ҮЕДЭЭ ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ ГЭМТ ХЭРЭГ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
Б.Сүнжидмаа	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.10.09.

АГУУЛГА

I. СОГТУУРСАН БОЛОН МАНСУУРСАН ҮЕДЭЭ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ ГЭМТ ХЭРЭГ	301
II. ДҮГНЭЛТ	310
НОМ ЗҮЙ	311

I. СОГТУУРСАН БОЛОН МАНСУУРСАН ҮЕДЭЭ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ ГЭМТ ХЭРЭГ

Европын холбооны орнуудад согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдлуудад дараах төрлийн шийтгэлийг оногдуулж байна. Үүнд:

- торгох;
- жолоодох эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- торгуулийн оноо өгөх;
- эмчилгээний хөтөлбөр (үнэлгээ, албадан эмчилгээ эсвэл нөхөн сэргээлт);
- тээврийн хэрэгслийн шийтгэл (тээврийн хэрэгслийг саатуулах, хөдөлгөөнийг хязгаарлах, согтууруулах ундаа мэдрэгч төхөөрөмж¹ ашиглан машиныг хөдөлгөөнгүй болгох);
- хорих ял оногдуулах зэрэг болно.

1 'Alcohol interlock devices' түгжигч төхөөрөмж нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг тээврийн хэрэгсэл жолоодохоос урьдчилан сэргийлэх зориулалттай автомат удирдлагын систем юм. Тэд тээврийн хэрэгслийн жолоочоос жолоодлого эхлэхийн өмнө амьсгалын дээжийг машины анализ хийх төхөөрөмжид оруулах эсвэл хуруугаараа мэдрэгчийг ашиглан согтууруулах ундаа хэрэглэсэн түвшинг тогтоодог. Дээж ирүүлээгүй эсвэл урьдчилан тогтоосон босго хэмжээнээс хэтэрсэн согтууруулах ундаа илэрсэн тохиолдолд тээврийн хэрэгслийг ажиллуулахыг богино хугацаанд зогсооно. Түгжих хугацаа нь эхний бүтэлгүйтсэн тестийн хувьд хэдэн минут, дараагийн бүтэлгүйтсэн тестийн хувьд илүү удаан үргэлжилнэ. (TRT Trasporti e Territorio Srl, 2014).

Доорх хүснэгтээр Европын Холбооны зарим гишүүн орнууд болон Япон Улсад согтуурсан болон мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл, хэмжээг тусгахыг зорилоо.

СОГТУУРСАН БОЛОН МАНСУУРСАН ҮЕДЭЭ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ ГЭМТ ХЭРЭГ						
№	Улс	Хууль зүйн үндэслэл	Цусан дахь бодисын хэмжээ нг/мл (ng/ml)	Ял шийтгэл		
				Жолоодох эрхийг хасах	Торгох	Хорих
1.	Австри	Замын хөдөлгөөний тухай хууль (Road Traffic Act) ² , 5, 99-р зүйл Жолоодох эрх олгох тухай хууль (Driving Licence Act) ³ , 26-р зүйл	-	4 долоо хоног ба түүнээс дээш	€800-3700	-
2.	Бельги	Замын хөдөлгөөний тухай хууль (Law on traffic circulation) ⁴ , Arts.35, 37 bis	Arts.35, 37 bis-ийн дагуу 62ter-р зүйл. Шүлснээс илэрсэн бодисын хэмжээ дараахаас их эсхүл тэнцүү бол: Дельта-9-тетрагидро-каннабинол (THC) (≥10 нг/мл)	1 сараас 5 жил эсхүл бүх насаар	€200-2000	

- 2 Federal law consolidated: Complete legal regulation for the Road Traffic Act 1960, version of 01.08.2024, Холбоос: <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=10011336>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.
- 3 Federal law consolidated: Complete legal provision for the Driving License Act, version of 01.08.2024, <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=10012723>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.
- 4 16 MARS 1968. - Loi relative à la police de la circulation routière, Холбоос: https://www.ejustice.just.fgov.be/img_i/pdf/1968/03/16/1968031601_F.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

			Амфетамин (≥ 25 нг/мл) Морфин эсвэл 6-ацетилморфин (≥ 5 нг/мл) Кокаин эсвэл бензоиллегонин (≥ 10 нг/мл) 63 дугаар зүйл. Цусанд илэрсэн бодисын хэмжээ дараахаас их эсхүл тэнцүү бол: Дельта-9-тетрагидро- каннабиол (THC) (≥ 1 нг/ мл) Амфетамин (≥ 25 нг/мл) Метилendioксиме- тиламфетамин (MDMA) (≥ 25 нг/мл) Морфин (≥ 10 нг/мл) Кокаин эсвэл бензоил- легонин (≥ 25 нг/мл)		
3.	Хорват	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (Law on Safety in Road Traffic) (OG 67/08, 48/10, 74/11, 80/13, 158/13, 92/14, 64/15) ⁵ , Art. 199(1), 282. Эрүүгийн хууль Criminal Code (CC) (OG.125/11, 144/12, 56/15, 61/15) ⁶ , Art.226		(ЗХАБТХ) 1 сараас 2 жил (ЭХ) 1-5 жил.	5000- 20.000.00 kn (€680-2.700)
					(ЗХАБТХ) 2 сар хүртэл (ЭХ) 3 жил хүртэл.

5 Zakon o sigurnosti prometa na cestama pročišćeni tekst zakona NN 67/08, 48/10, 74/11, 80/13, 158/13, 92/14, 64/15, 108/17, 70/19, 42/20, 85/22, 114/22, 133/23 na snazi od 15.11.2023. Холбоос: https://www.zakon.hr/z/78/Zakon-o-sigurnosti-prometa-na-cestama#google_vignette. Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

6 Kazneni zakon pročišćeni tekst zakona NN 125/11, 144/12, 56/15, 61/15, 101/17, 118/18, 126/19, 84/21, 114/22, 114/23, 36/24 na snazi od 02.04.2024. Холбоос: <https://www.zakon.hr/z/98/Kazneni-zakon>. Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

4.	Дани	Замын хөдөлгөөний тухай хууль ⁷ (2005.11.14 LBK 1079), ss.54, 55, 117d, 125, 126, 128. 6 дугаар сарын 6-ны 524 дүгээр хууль 2007, 2007.06.19-ний BEK 655	ТНС=1 амфетамин = 20 кокаин = 20 морфин = 10 MDMA=20	6 сараас 10 жил эсхүл насан туршид.	-	1.5 жил хүртэл.
5.	Эстони	Замын хөдөлгөөний тухай хууль ⁸ : §91 (тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн үүсгэгчийн тухай хуульд заасны дагуу мансууруулах бодис хэрэглэсэн тохиолдолд шийтгэл ногдуулна. ⁹ § Эрүүгийн хууль ¹⁰ : §50, §424 Хууль сахиулах тухай хууль ¹¹ : §36, §37, §41.	-	(ЗХТХ) байхгүй (ЭХ) 3 жил хүртэл	(ЗХТХ) € 1200 хүртэл (хар тамхи хэрэглэх гэмт хэрэг) (ЭХ) 30-500 өдрийн дундаж орлого	(ЗХТХ) Торгуулийн оронд 30 хүртэл хоногоор баривчлах (хар тамхи хэрэглэх гэмт хэрэг) (ЭХ) 3 жил хүртэл
6.	Финланд	Эрүүгийн хууль ¹² 23 дугаар бүлэг 3, 4, 8 дугаар зүйл	-	5 жил хүртэл	(23 дугаар бүлэг 3) 120 хүртэл хоног (23 дугаар бүлэг 4) 60-аас доошгүй хоног (ноцтой нөлөөнд байх үедээ жолоодсон)	(23 дугаар бүлэг 3) 6 сар хүртэл (23 дугаар бүлэг 4) 2 жил хүртэл (ноцтой нөлөөнд байх үедээ жолоодсон)

7 The Road Traffic Act. 2007, Холбоос: <https://www.global-regulation.com/translation/denmark/612915/announcement-of-the-road-traffic-act.html> Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

8 Road Traffic Act. 2011, Холбоос: <https://www.rigiteataja.ee/en/ei/ee/Riigikogu/act/523012024001/consolide> Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

9 Act on Narcotic Drugs and Psychotropic Substances and Precursors thereof, 1997, Холбоос: <https://www.rigiteataja.ee/en/ei/530102013024/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

10 Penal Code. 2001, Холбоос: <https://www.rigiteataja.ee/en/ei/501072024002/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

11 Law Enforcement Act. 2011, Холбоос: <https://www.rigiteataja.ee/en/ei/528072023002/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

12 The Penal Code of Finland. 1989, Холбоос: https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1989/en18890039_19951010.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

7.	Франц	2016.1.26-ны өдрийн 2016-41-р хууль ¹³ , 2 дугаар сарын 3-ны өдрийн 2003-87-р хууль ¹⁴ , 99-505-р хууль, (code de la route L. 235-1, 235-2 дугаар зүйл) ¹⁵ , 2016.08.24-ний өдрийн 2016-1152 тогтоол ¹⁶ , 2016.08.27-ны өдрийн 2001-751 тогтоол ¹⁷ (R 235-1 code de la route-ийн дагуу)	-	3 жил хүртэл	€4500	2 жил
8.	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Замын хөдөлгөөний тухай хууль ¹⁸ s.24a(2) Эрүүгийн хууль ¹⁹ (StGB) ss.315c, 316	Хуулиар тодорхойлоогүй. Харин санал болгож буй аналитик хязгаар (ийлдэс дэх): THC=1 амфетамин = 25 кокаин = 10 морфин = 10	(ЗХТХ) 1-3 сар (ЭХ) 1-3 сар эсвэл цуцлах	Хэрвээ жолооч мөн солтууруулах ундааны нөлөөнд байсан бол €9000 (ЗХТХ) € 3000 хүртэл (ЭХ) Бүх гэмт хэрэгт: гэмт хэрэгтний орлогыг харгалзан	Хэрвээ жолооч мөн солтууруулах ундааны нөлөөнд байсан бол 3 жил s.315c ²⁰ , S.316 1 жил хүртэл

13 LOI n° 2016-41 du 26 janvier 2016 de modernisation de notre système de santé. 2016, Холбоос: <https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT0000031912641>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

14 LOI n° 2003-87 du 3 février 2003 relative à la conduite sous l'influence de substances ou plantes classées comme stupéfiants. 2003, Холбоос: <https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT00000235043/>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

15 Code de la route L., Холбоос: https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006074228?init=true&page=1&query=code+de+la+route+L.+235-1&searchField=ALL&tab_selection=all, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

16 Décret no 2016-1152 du 24 août 2016 relatif à la lutte contre la conduite après usage de substances ou plantes classées comme stupéfiants. 2016, Холбоос: https://www.legifrance.gouv.fr/download/pdf?id=DP2-6dWn_-8gt0LL_r2-iJGWR-gJcY3gUgru_D4Gbkz, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

17 Décret no 2001-751 du 27 août 2001 relatif à la recherche de stupéfiants pratiquée sur les conducteurs impliqués dans un accident mortel de circulation routière, modifiant le décret no 2001-251 du 22 mars 2001 relatif à la partie Réglementaire du code de la route. 2001, Холбоос: https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT00000772929?init=true&page=1&query=2001-751&searchField=ALL&tab_selection=all#;:text=modifier%20le%20d%C3%A9cret-no.-2001%2D251%20du, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

18 Straßenverkehrsgesetz (StVG). 1909, Холбоос: <https://www.gesetze-im-internet.de/stvg/BJNR004370909.html>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

19 German Criminal Code. 1998, Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

20 Хүний амь нас, эд эрхтэнд аюул учруулсан, эсхүл тухайн хүнд чухал ач холбогдол бүхий эд хөрөнгөд аюул учруулсан бол 5 жил хүртэл хорих эсхүл торгох, Тээврийн хэрэгслийг аюулгүйгээр жолоодох чадваргүй үедээ жолоо барьж болгоомжгүй үйлдэл хийж, болгоомжгүйгээр аюул учруулсан бол хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл торгох.

9.	Грек	Грекийн хурдны замын тухай хуулийн ²¹ 42 дугаар зүйл Эрүүгийн хууль ²² - N 4619/2019	-	90-180 хоног	>200€	Хамгийн багадаа 2 сар Хэрэв энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол, 10 жилээс доошгүй хугацаагаар. 2 жил хүртэл; Хүндрүүлэх нөхцөл: а) хүний биед хүндэвтэр хохирол учруулбал 3 жил хүртэл; б) насан туршийн хөгжлийн бэрхшээлтэй болгох, эрүүл мэндийг хүнд хохирол учруулсан, эсхүл олныг хамарсан сүйрэлд хүргэсэн бол 1-5 жил хүртэл; в) гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол 2-8 жил хүртэл; г) гэмт хэргийн улмаас 2 ба түүнээс дээш хүний амь нас хохирсон, эсхүл нийтийг хамарсан үхэлд хүргэсэн бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял.
10	Унгар	Эрүүгийн хууль ²³ 236 дугаар зүйл. Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох 237 дугаар зүйл. Мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох	-	-	-	

21 Regulations on transport issues and other provisions, Холбоос: <https://www.global-regulation.com/translation/greece/39880574/transport-issues-and-other-provisions.html>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

22 Мөн тэнд.

23 Act C of 2012 on the Criminal Code, Холбоос: https://thb.kormany.hu/download/a/46/11000/Btk_EN.pdf, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

11	Латви	Захиргааны зөрчлийн тухай хууль ²⁴ , 2012 оны Эрүүгийн хуулийн ²⁵ 262 дугаар зүйл "согтуурсан болон мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох", 260 дугаар зүйл "Замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой заалтыг зөрчих"	-	(33X) 4 жил хүртэл (ЭХ.262) 5 жил хүртэл 260. (3) Замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой заалтыг зөрчиж түүний улмаас хүний эрүүл мэндэд нь хөнгөн гэмтэл, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан эсхүл хүн нас барсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 5 жилээс дээшгүй хугацаагаар хасах /хорих ялтай хамт хэрэглэнэ./	(33X) Аливаа эм - 1200-1400 евро Эм төст бүтээгдэхүүн - 40-280 евро (ЭХ) сарын цалингийн доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр	Захиргааны баривчлах шийтгэл: 10-аас 15 хоног хүртэлх хугацаанд (ЭХ) 2 жил хүртэл Мөн нийтэд тусгай ажил хийлгэх ялыг оногдуулах боломжтой байна. 260. (3) 3-15 жилийн хугацаагаар хорих
12	Польш	Эрүүгийн хууль ²⁶ 178а зүйл	- (5A) THC=2 амфетамин = 10 кокаин = 10 Морфин = 80	1-10 жил 1-ээс дээш жил	360 хүртэл хоног	2 жил хүртэл 6 сар хүртэл Хүн нас барсан бол 14 жил хүртэл
13	Англи болон Вэльс	Замын хөдөлгөөний тухай хууль ²⁷ s.4 & s.5A				

24 Latvian Administrative Violations Code, Холбоос: https://webapps.ilo.org/dym/legosh/en/f?p=14100:503:76304865574::NO:503:REFERENCE_FILE_ID:312392:NO, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

25 The criminal law, Холбоос: <https://www.km.gov.lv/en/media/1409/download>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

26 The Criminal Code of 6 June 1997, Холбоос: [https://sherloc.unodc.org/cid/uploads/res/unscac/LegalLibrary/Poland/Laws/Criminal%20Code%20\(Poland\).pdf](https://sherloc.unodc.org/cid/uploads/res/unscac/LegalLibrary/Poland/Laws/Criminal%20Code%20(Poland).pdf), Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

27 Road Traffic - Drink and Drug Driving, Холбоос: <https://www.cps.gov.uk/legal-guidance/road-traffic-drink-and-drug-driving>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

14	Швед	Замын хөдөлгөөний зарим гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийн тухай хууль (1951:649) ²⁸ , s.4 ба 4а	-	1 сар - 3 жил. Тээврийн хэрэгслийг хураах боломжтой. 90 хоног. Цагдан хорих ялыг хүчингүй болгох боломжтой (түдгэлзүүлсэн эсэхээс үл хамааран)	Өдрийн торгууль 30-400 хоногийн торгууль (өдөрт 10-500 рон)	2 жил хүртэл 1-5 жил (мөн нотлох баримт биологийн өгөхөөс татгалзсан); Хүндэрсэн тохиолдолд 2-7 жил
15	Румын	Эрүүгийн хууль ²⁹ , 336-337 дугаар зүйл Эрүүл мэндийн яамны 2013.12.12/1512 тоот тушаал	-	(103) 117-(2) зүйлийн 1,3-т заасныг зөрчсөн бол 6 сар хүртэл хугацаагаар	117-(2) 65-66 дурдсан дараах үйлдлийг хийсэн бол 1 сая иенээс илүүгүй торгох шийтгэл ногдуулах эсхүл хорих ял онооно.	117-(2) 5 жилээс илүүгүй хугацаагаар хорих. 117.2-т заасан тохиолдлуудад 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих.
16	Япон	Замын хөдөлгөөний тухай хууль ³⁰ 65 дугаар зүйл /Согтууруулах ундааны нөлөөгөөр тээврийн хэрэгсэл жолоодох, түүнтэй холбоотой бусад үйлдэл/ 66 дугаар зүйл /Ачаалал ихтэй ажилласан эсвэл бусад тодорхой нөхцөлд тээврийн хэрэгсэл жолоодох/				

28 Law (1951:649) on punishment for certain traffic offences, Холбоос: https://www.riksdagen.se/iv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1951649-om-straff-for-vissa-trafikbrott_sfs-1951-649/, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

29 European Commission For Democracy Through Law, Холбоос: [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2018\)042-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2018)042-e), Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

30 Road Traffic Law, Холбоос: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2962>, Сүүлд үзсэн огноо: 2023.10.09.

					117-(2) 65-66 дурдсан дараах үйлдлийг хийсэн бол 1 сая иенээс илүүгүй торгох шийтгэл ногдуулах эсхүл хорих ял онооно. 1). 65.1. согтуурсан хүн жолоодсон 2). 65.2. согтуу гэдгийг нь мэдсээр байж тээврийн хэрэгслээр хангасан этгээд / зөвхөн согтуурсан этгээд жолоодсон тохиолдол хамаарна/ Холбогдох бусад зохицуулалт ³¹
--	--	--	--	--	--

31

66. Ачаалал ихтэй ажилласан өвдсөн байгаа, мансуурсан болон бусад нөхцөл байдлын улмаас аюулгүй жолоодох чадваргүй байгаа хүн жолоодсон.
4. 75 дугаар зүйлийг зөрчиж, согтсон болон жолоодох чадваргүй байгаа хүнийг тээврийн хэрэгсэл жолоодохыг тушаасан буюу зөвшөөрсөн этгээд;
117.2.2. Дараах зүйлийн аль нэгэнд дурдсан этгээдэд, эсхүл 500,000 иенээс илүүгүй торгууль оногдуулах эсхүл хорино.
1) 65.3. Тээврийн хэрэгсэл, трамвай жолоодох магадлалтай этгээдэд согтууруулах ундаа өгөх, согтууруулах ундаа хэрэглэхийг дэмжсэн этгээд
2) 65.4. тухайн хүний сууж явсан тээврийн хэрэгслийн жолооч согтуу байгаа гэдгийг мэдсээр байж жолоодохыг хүссэн, шаардсан, найдсан этгээд
3-4) 117-(2)-т хамаарахгүй 65.3 дахь хэсэгт заасан тохиолдол.

ДҮГНЭЛТ

Дээрхээс дүгнэвэл, сонгон судалсан улс бүр тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон хүнд оногдуулж буй хариуцлага, үүнийг зохицуулсан хууль тогтоомж харилцан адилгүй байна. Нийтлэг байдлаар авч үзвэл, Замын хөдөлгөөний тухай хууль, Эрүүгийн хуулиар холбогдох харилцааг зохицуулж байгаа бөгөөд ихэнх улс Монгол Улстай адилаар Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгт тооцож байхад зарим улсад тухайлбал, Унгар улсад согтууруулах ундаа, хар тамхины нөлөөнд байх зэрэг нэршлээр уг гэмт хэргийг хуульчилсан байна.

Тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын тухайд, Япон Улсад зөвхөн согтуурсан эсхүл мансуурсан, өөрийгөө хянах чадваргүй нөхцөл байдалд байхдаа тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдээс гадна согтуурсан, мансуурсан нөхцөл байдалд байгаа жолоочийн машинд хамт суусан этгээд, тээврийн хэрэгслээр хангасан этгээд нь ч эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан нь гэмт хэргийн субъектэд тооцогдох хамгийн нарийвчилсан зохицуулалтыг агуулжээ.

НОМ ЗҮЙ

1. Federal law consolidated: Complete legal regulation for the Road Traffic Act 1960, version of 01.08.2024, Холбоос: <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=10011336>,
2. Federal law consolidated: Complete legal provision for the Driving License Act, version of 01.08.2024, <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=10012723>,
3. 16 MARS 1968. - Loi relative à la police de la circulation routière, Холбоос: https://www.ejustice.just.fgov.be/img_l/pdf/1968/03/16/1968031601_F.pdf,
4. Zakon o sigurnosti prometa na cestama pročišćeni tekst zakona NN 67/08, 48/10, 74/11, 80/13, 158/13, 92/14, 64/15, 108/17, 70/19, 42/20, 85/22, 114/22, 133/23 na snazi od 15.11.2023, Холбоос: https://www.zakon.hr/z/78/Zakon-o-sigurnosti-prometa-na-cestama#google_vignette,
5. Kazneni zakon pročišćeni tekst zakona NN 125/11, 144/12, 56/15, 61/15, 101/17, 118/18, 126/19, 84/21, 114/22, 114/23, 36/24 na snazi od 02.04.2024, Холбоос: <https://www.zakon.hr/z/98/Kazneni-zakon>
6. The Road Traffic Act. 2007, Холбоос: <https://www.global-regulation.com/translation/denmark/612915/announcement-of-the-road-traffic-act.html>
7. Road Traffic Act. 2011, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/Riigikogu/act/523012024001/consolide>
8. Act on Narcotic Drugs and Psychotropic Substances and Precursors thereof, 1997, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/530102013024/consolide>,
9. Penal Code. 2001, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/501072024002/consolide>,
10. Law Enforcement Act. 2011, Холбоос: <https://www.riigiteataja.ee/en/eli/528072023002/consolide>,
11. The Penal Code of Finland. 1989, Холбоос: https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039_19951010.pdf,
12. LOI n° 2016-41 du 26 janvier 2016 de modernisation de notre système de santé. 2016, Холбоос: <https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000031912641>,
13. LOI n° 2003-87 du 3 février 2003 relative à la conduite sous l'influence de substances ou plantes classées comme stupéfiants. 2003, Холбоос: <https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000000235043/>,
14. Code de la route L., Холбоос: https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006074228?init=true&page=1&query=code+de+la+route+L.+235-1&searchField=ALL&tab_selection=all,
15. Décret no 2016-1152 du 24 août 2016 relatif à la lutte contre la conduite après usage de substances ou plantes classées comme stupéfiants. 2016, Холбоос: https://www.legifrance.gouv.fr/download/pdf?id=DP2-6dWn_-8gt0Ll_r2-iJGWR-gJjcV3gUqru_D4Gbk=,

16. Décret no 2016-1152 du 24 août 2016 relatif à la lutte contre la conduite après usage de substances ou plantes classées comme stupéfiants. 2016, Холбоос: https://www.legifrance.gouv.fr/download/pdf?id=DP2-6dWn_-8gt0LI_r2-iJGWR-gJcV3gUqru_D4Gbk=,
17. Décret no 2001-751 du 27 août 2001 relatif à la recherche de stupéfiants pratiquée sur les conducteurs impliqués dans un accident mortel de la circulation routière, modifiant le décret no 2001-251 du 22 mars 2001 relatif à la partie Réglementaire du code de la route. 2001, Холбоос: https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000000772929?init=true&page=1&query=2001-751&searchField=ALL&tab_selection=all#:~:text=modifiant%20le%20d%C3%A9cret,-no,-2001%2D251%20du,
18. Straßenverkehrsgesetz (StVG). 1909, Холбоос: <https://www.gesetze-im-internet.de/stvg/BJNR004370909.html>,
19. German Criminal Code. 1998, Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html,
20. Regulations on transport issues and other provisions, Холбоос: <https://www.global-regulation.com/translation/greece/39880574/transport-issues-and-other-provisions.html>,
21. Regulations on transport issues and other provisions, Холбоос: <https://www.global-regulation.com/translation/greece/39880574/transport-issues-and-other-provisions.html>,
22. Act C of 2012 on the Criminal Code, Холбоос: https://thb.kormany.hu/download/a/46/11000/Btk_EN.pdf,
23. Latvian Administrative Violations Code, Холбоос: https://webapps.ilo.org/dyn/legosh/en/f?p=14100:503:76304865574::NO:503:P503_REFERENCE_FILE_ID:312392:NO, Сүүлд үзсэн: 2023.10.09.
24. The criminal law, Холбоос: <https://www.km.gov.lv/en/media/1409/download>,
25. The Criminal Code of 6 June 1997, Холбоос: [https://sherloc.unodc.org/cld/uploads/res/uncac/LegalLibrary/Poland/Laws/Criminal%20Code%20\(Poland\).pdf](https://sherloc.unodc.org/cld/uploads/res/uncac/LegalLibrary/Poland/Laws/Criminal%20Code%20(Poland).pdf),
26. Road Traffic - Drink and Drug Driving, Холбоос: <https://www.cps.gov.uk/legal-guidance/road-traffic-drink-and-drug-driving>,
27. Law (1951:649) on punishment for certain traffic offences, Холбоос:
28. https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-1951649-om-straff-for-vissa-trafikbrott_sfs-1951-649/,
29. European Commission For Democracy Through Law, Холбоос: [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2018\)042-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2018)042-e),
30. Road Traffic Law, Холбоос: <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2962>,

ЕС. ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ БУСАД УЛС ОРНЫ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)
----------------	---

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Х.Буянбат	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
М.Ганди	Эрдэм шинжилгээний ажилтан
О.Түвшинсанаа	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2023.12.28

АГУУЛГА

УДИРТГАЛ	315
I. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	316
1.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	316
1.2. Оросын Холбооны Улс	317
II. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	320
2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	320
2.2. Оросын Холбооны Улс	321
III. ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ, ТӨРӨЛ, ЗОРИУЛАЛТ	322
3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	322
3.2. Оросын Холбооны Улс	323
IV. ГАЛТ ЗЭВСЭГ ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨВЛӨХ, БЭЛЭГЛЭХ	326
4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	326
4.2. Оросын Холбооны Улс	329
V. ГАЛТ ЗЭВСГИЙН ХУДАЛДАА БА ИМПОРТ	331
5.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	331
5.2. Оросын Холбооны Улс	331
VI. ГАЛТ ЗЭВСГИЙГ ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА	336
6.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	336
6.2. Оросын Холбооны Улс	337
VII. ГАЛТ ЗЭВСГИЙН ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ, БҮРТГЭЛ	343
7.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	343
7.2. Оросын Холбооны Улс	343
VIII ГАЛТ ЗЭВСГИЙН СУРГАЛТ	348
8.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	348
8.2. Оросын Холбооны Улс	349
IX. ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО	351
9.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	351
9.2. Оросын Холбооны Улс	352
X. СУМ БОЛОН СУМЫГ ДАХИН ЦЭНЭГЛЭХТЭЙ ХОЛБОГДОХ ХАРИЛЦАА	358
ДҮГНЭЛТ, САНАЛ	368
НОМ ЗҮЙ	370

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Манай улсын хувьд галт зэвсэгтэй холбоотой харилцааг “Галт зэвсгийн тухай хууль”-аар зохицуулдаг. Тус хуулийг 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулж, 26 зүйлтэй баталсан. Ийнхүү баталснаас хойш 2015, 2017, 2020, 2022, 2023 онд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл энэ хуульд галт зэвсэгтэй холбоотой зарим харилцааг зохицуулаагүй орхигдуулсан хэвээр байна. Тухайлбал, галт зэвсгийг үйлдвэрлэх, сум дахин цэнэглэхэд зөвшөөрөл олгох, түүнд тавигдах стандартыг тодорхой болгох гэх мэт.

Энэхүү судалгааны хүрээнд гадаадын зарим улсад галт зэвсэгтэй холбоотой асуудлыг хэрхэн тодорхойлж, хуульчилсан талаар сайн туршлагыг судлан үзсэн болно.

Судалгаагаар галт зэвсгийн ерөнхий ойлголт, ангилал, төрөл, эрх зүйн зохицуулалт, өмчлөх, эзэмших, худалдаа, импорттой холбоотой харилцаа, галт зэвсэг хадгалах, тээвэрлэхэд тавигдах шаардлага, хяналтын механизм, галт зэвсгийн сургалт, хариуцлагын тогтолцоотой холбогдох харилцааг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон Оросын Холбооны Улсад хэрхэн зохицуулдаг талаар мөн сумны хонгиог дахин цэнэглэхтэй холбоотой харилцааг дээрх хоёр улс болон Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Канад улсын хууль тогтоомжид хэрхэн хуульчилсан талаар тус тус судлан үзэв.

Дээрх улсуудад галт зэвсэгтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулсан байх бөгөөд тухайн хуулиар иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байх, хууль сахиулах байгууллагын албаны зориулалтаар ашиглах, цэрэг, батлан хамгаалах зориулалтын галт зэвсэг байхаас үл хамааран галт зэвсэгтэй холбоотой үндсэн харилцааг хуулиар зохицуулж байна.

Гадаадын зарим улсуудад галт зэвсэгтэй холбоотой харилцааг хэрхэн хуульчилсан талаарх энэхүү судалгаанд үндэслэн галт зэвсэгтэй холбоотой харилцааг зохицуулсан дотоодын хууль тогтоомжыг боловсронгуй болгох, цаашид засаж сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гүйцэтгэсэн болно.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаагаар галт зэвсэгтэй холбоотой зарим улсын (ХБНГУ, ОХУ, АНУ, Бүгд Найрамдах Филиппин Улс, Канад) материаллаг хууль, эрх зүйн зохицуулалтыг судлан үзсэн болно.

Судалгааны арга зүй

Судалгааг баримт бичгийн, харьцуулалтын, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх зэрэг аргыг ашиглан гүйцэтгэв.

I. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д 2012 онд нийт 5.997.040 гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2022 онд нийт 5.628.584 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 6.14%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График 9.1. ХБНГУ-ын нийт гэмт хэргийн тоо¹



2012-2022 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 0.14-0.18 хувийг галт зэвсэг ашиглахаар завдсан, 0.076-0.097 хувийг ашиглаж үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9.1. ХБНГУ-ын нийт гэмт хэргийн тоог галт зэвсэг ашиглахаар завдсан, галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэгтэй харьцуулсан байдал


Он	Нийт гэмт хэргийн тоо (тоо)	Галт зэвсэг ашиглахаар завдсан (тоо)	Галт зэвсэг ашигласан (тоо)	Хувь /Галт зэвсэг ашиглахаар завдсан/	Хувь /Галт зэвсэг ашигласан/
2012	5997040	10828	5800	0.18%	0.097%
2013	5961662	10093	5500	0.17%	0.092%
2014	6082064	9585	5100	0.16%	0.084%
2015	6330649	9000	4800	0.14%	0.076%
2016	6372526	9967	5000	0.16%	0.078%
2017	5761984	8935	4800	0.16%	0.083%
2018	5555520	8343	4000	0.15%	0.072%
2019	5436401	9151	5100	0.17%	0.093%
2020	5310621	8824	5000	0.17%	0.094%
2021	5047860	7955	4000	0.16%	0.079%
2022	5628584	8534	4400	0.15%	0.078%

2012 онд нийт гэмт хэргийн 0.18% нь галт зэвсэг ашиглахаар завдсан, 0.097% нь гэмт хэрэг үйлдэхдээ галт зэвсэг ашигласан² бол 2022 онд нийт гэмт хэргийн 0.15%-ийг галт зэвсэг ашиглахаар завдсан, 0.078% нь галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь ХБНГУ-д сүүлийн 10 жилд галт зэвсэг ашиглахаар завдсан, галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэргийн тоо буурсныг илтгэж байна.

1 ХБНГУ-ын статистик мэдээллийн нэгдсэн сан.

2 Галт зэвсэг ашигласан гэж галт зэвсгээр гал нээсэн, ашигласан байдлыг ойлгоно.

График 9.2. ХБНГУ-д 2012-2022 онд галт зэвсэг ашиглахыг завдсан болон галт зэвсэг ашигласан хэргийн тоон харьцуулалт³



Дээрх графикаас үзвэл, гэмт хэрэг үйлдэхдээ галт зэвсэг ашиглахаар завдсан тохиолдол гэмт хэрэг үйлдэхдээ галт зэвсэг ашигласан тохиолдлоос жил бүр илүү өндөр үзүүлэлттэй байна.

Түүнчлэн, 2022 онд ХБНГУ-д 8534 галт зэвсэг хэрэглэсэн гэмт хэрэг бүртгэгдсэнээс 4100 гэмт хэрэг нь галт зэвсгээр заналхийлсэн, 4400 гаруй хэрэгт галт зэвсэг ашигласан тохиолдол гарсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад галт зэвсэг ашигласан тохиолдол өссөн үзүүлэлт болж байна.

Нөгөөтээгүүр, ХБНГУ галт зэвсгийг хууль ёсоор өмчлөх, эзэмших, ашиглах нь эрх зүйн орчны хувьд хязгаарлагдмал байдаг. Тиймээс ч галт зэвсэг олж авах нь бусад улс орнуудтай (жишээ нь: АНУ) харьцуулахад илүү хэцүү байдаг.

Түүнчлэн, АНУ-д 2023 онд сар бүр хамгийн багадаа нэг сая галт зэвсэг зарагдсан байна. Судалгаагаар 2023 онд АНУ-ын нийт өрхийн 42 орчим хувь нь галт зэвсэгтэй байсан бөгөөд үүнээс шалтгаалан АНУ-д өдөр бүр галт зэвсэгтэй холбоотой гэмт хэрэг ихээр гардаг. 2023 онд гэхэд галт зэвсгийн улмаас 19,000 хүн амиа алдаж, 36,000 хүн шархадсан тохиолдол бүртгэгдсэн байна.

ХБНГУ-д 2022 онд галт зэвсэг ашиглахаар завдсан хэргийн тоо 8534 байсан бөгөөд үүний талаас илүү хувийг галт зэвсгээр буудсан тохиолдол эзэлж байна.

1.2. Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улсад 1995 онд 100,000 хүнд ногдох гэмт хэргийн тоо 1860, 2006 онд 2701, 2021 онд 1371.3 болсон үзүүлэлттэй байна. Энэ нь 2006 онтой харьцуулахад 1330-аар буурсан үзүүлэлттэй байна.

³ ХБНГУ-ын статистик мэдээллийн нэгдсэн сан, ХБНГУ-д 2012-2022 он хүртэл галт зэвсэг ашигласан гэмт хэргийн тоо, Холбоос: <https://de.statista.com/statistik/daten/studie/350846/umfrage/strafataten-mit-schusswaffengebrauch-in-deutschland/#:~:text=lm%20Jahr%202022%20gab%20es.F%C3%A4llen%20mit%20einer%20Schusswaffe%20geschossen>, Нийтлэгдсэн: 2024.01.03, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

График 9.3. ОХУ-ын 100,000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин (1995-2021 он) ⁴




График 9.4. ОХУ-ын Галт зэвсэг, хийн зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэх төхөөрөмж ашиглаж үйлдсэн гэмт хэргийн тоо (2015- 2021 он) ⁵



ОХУ-ын галт зэвсэгтэй холбоотой нөхцөл байдал

ОХУ-ын Дотоод хэргийн яамны мэдээлснээр 2022 оны байдлаар зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, тэсрэх бодис, дуураймал төхөөрөмж ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийн тоо (5000 орчим) 2021 оны мөн үетэй харьцуулахад 30 орчим хувиар өссөн ба 2022 оны 1-10 дугаар сард бүс нутгуудын дунд тус үзүүлэлтээр Курск (+675%), Белгород (+213.3%) мужууд тэргүүлж байна. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг гэмт хэрэгт ашигласан явдал 116 хувиар (283 хэрэг) өссөн байна.⁶ Мөн өсвөр насны хүүхдүүд зэвсэг ашиглан гэмт хэрэг үйлдэх тохиолдол нэмэгдсэн байна.

Энэ өсөлтөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдал суларсан, Украйны нутаг дэвсгэрээр зэвсэг тээвэрлэхэд хүндрэлтэй болсон зэрэг үйл явдлууд нөлөөлсөн байж болох юм.

2021 оны долдугаар сард тус улсын Ерөнхийлөгч Владимир Путин зэвсгийн наймаатай холбоотой хариуцлагыг чангатгасан бөгөөд иргэн ан агнуурын зэвсэг,

4 Crime rate in Russia from 1995 to 2021 (per 100,000 population), Холбоос: <https://www.statista.com/statistics/1045439/russia-crime-rate/>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

5 Number of crimes involving the use of firearms, gas weapons, ammunition, explosives, and explosive devices in Russia from 2015 to 2021, Холбоос: <https://www.statista.com/statistics/1045454/russia-number-of-crimes-involving-use-of-firearms-and-explosives/>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

6 Gun crimes has increased, Холбоос: <https://www.vedomosti.ru/society/articles/2022/11/23/951802-chislo-prestuplenii-viroslo>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

урт сумтай өөрийгөө хамгаалах зэвсэг худалдан авах насыг 18-аас 21 нас болгон нэмэгдүүлсэн байна. Мөн хууль бусаар зэвсэг үйлдвэрлэх, засварлах, өөрчлөх, эргэлтэд оруулахтай холбоотой хэрэг оногдуулах хариуцлагыг нэмэгдүүлсэн.

Ийнхүү 2021 оноос галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэг болон галт зэвсэг эзэмших эрхтэй холбоотой зохицуулалтыг ОХУ-ын хууль тогтоох байгууллагаас шинэчлэх болсон шалтгаануудын нэг нь өсвөр насны хүүхдүүд галт зэвсэг ашиглан гэмт хэрэг үйлдэх тохиолдол ихсэж, сургууль, олон нийтийн газар зэвсэгт халдлага үйлдэх болсонтой холбоотой.

Гэхдээ ОХУ-д энэ төрлийн гэмт хэрэг 2021 оноос өмнө ч үйлдэгдэж байсан. Тухайлбал, 2014 оны 2 дугаар сарын 3-ны өдөр анх удаа иргэний зэвсгээр сургууль руу халдсан⁷ гэмт хэрэг гарсан ба тодруулбал Отрадное дүүргийн 263 дугаар сургуулийн 10а ангийн сурагч газарзүйн хичээлд агнуурын карабин, винтовтой ирж, багш Андрей Кирилловыг буудаж, ангийнхаа хүүхдүүдийг барьцаалж, эхний ээлжид ирсэн цагдаа нарыг бууджээ.

Мөн 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Пермь хотын Мотивилиха дүүргийн 127 дугаар сургуульд өсвөр насны хоёр хүүхэд 46 ангийн багш болон 14 сурагчийг галт зэвсэг ашиглан гэмтээсэн байна. ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны Пермийн нутаг дэвсгэр дэх хэлтэс Эрүүгийн хуулийн 3 дугаар хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн тус хуулийн 30 (гэмт хэрэг үйлдэхийг завдсан), Эрүүгийн хуулийн 105 (хоёр ба түүнээс дээш хүнийг алахыг завдсан) гэж үзээ, тус хэргийг Мөрдөн байцаах хорооны Мөрдөн шалгах ерөнхий газарт шилжүүлжээ.⁸

Сүүлд 2023 оны 12 сарын 7-ны өглөө наймдугаар ангийн сурагч Оросын бүрэлдэхүүнд байдаг Татарстаны нийслэл Казань хотын Брянскийн биеийн тамирын заал руу гал нээж, нэг хүнийг буудан хороож, өөрөө амиа хорложээ. Өмнө нь энэ хотод 2014 оны 12 дугаар сар, 2016 оны 3 дугаар сар, 2017 оны 3 дугаар сар, мөн оны 9 дүгээр сард өсвөр насны хүүхэд сургууль, олон нийтийн газарлуу халдаж байсан. Мөн 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр өсвөр насны хүүхэд сургууль дээрээ тэсрэх бөмбөг дэлбэлсний улмаас 2 хүн нас барж, 11 хүн гэмтсэн хэрэг гарч байсан.⁹

7 Once upon a time in Moscow: how a teenager first committed a school shooting, Холбоос: https://www.rbc.ru/politics/26/12/2014/549a9b939a794710fb26882d?from=article_body, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

8 Stabbing in Perm: what led to the teenagers attacking a school, Холбоос: https://www.rbc.ru/society/15/01/2018/5a5cd2719a7947016e56ca86?from=article_body, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

9 Cases of shootings and attacks in Russian schools, Холбоос: <https://www.rbc.ru/society/07/12/2023/609a5cdc9a7947237982ce4a>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

II. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ нь Монгол Улстай адил эх газрын эрх зүйн тогтолцоотой учир эрх зүйн эх сурвалжид хууль голлох үүрэгтэй байдаг. Иймд ХБНГУ нь олон нийтийн аюулгүй байдал, хэв журмын сахиулах зорилгоор зэвсэг, сум хэрэглэхтэй холбогдсон харилцааг 2002 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Зэвсгийн тухай хууль” (Waffengesetz, WaffG)-аар зохицуулдаг.

Хүснэгт 9.2. ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн бүтэц

ХБНГУ-ЫН ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬ		
Хэсэг	Бүлэг	Зүйл
1-р хэсэг. Ерөнхий заалтууд	-	§1-3
2-р хэсэг. Зэвсэг, сумтай харьцах	I бүлэг. Зэвсэг, сумны тусгай зөвшөөрөлд тавигдах ерөнхий шаардлага	§4-9
	II бүлэг. Зэвсэг, сумны тусгай зөвшөөрөл; чөлөөлөлт	§10-12
	III бүлэг. Тодорхой бүлэг хүмүүст зориулсан тусгай зөвшөөрөл	§13-20
	IV бүлэг. Зэвсэг үйлдвэрлэгчид, зэвсгийн наймаачид, буудлагын талбай, хамгаалалтын фирмүүдэд зориулсан тусгай зөвшөөрөл	§21-28 а, 31(1)
	V бүлэг. Зэвсэг, сум хэрэгслийг хуулиар зохицуулсан нутаг дэвсгэрт, дамжин эсвэл гадагш шилжүүлэх	§29-33
	VI бүлэг. Зохих ёсоор анхаарал халамж тавих үүрэг; тайлан, мэдэгдлийн шаардлага	§34-39
	VII бүлэг. Хориг	§40-42а
3-р хэсэг. Бусад заалтууд	-	§43-50
4-р хэсэг. Хариуцлага ба торгууль	-	§51-54
5-р хэсэг. Хууль хэрэглэхээс чөлөөлөх	-	§55-57
6-р хэсэг. Шилжилтийн ба захиргааны заалтууд	-	§58-59
Хавсралт 1. Тодорхойлолт (1-р зүйлийн (4))		
1-р хэсэг. Зэвсэг, сумны техникийн тодорхойлолт, объектын ангилал	I бүлэг. Буу	
	II бүлэг. Зөөврийн эд зүйлс	
	III бүлэг. Сум ба бусад хэрэгсэл	
2-р хэсэг. Зэвсгийн тухай хууль тогтоомжийн зорилгын тодорхойлолт	-	
3-р хэсэг. Зэвсгийн удирдамжийн дагуу галт зэвсэг, сумыг А-D ангиллын ангилал	-	
Хавсралт 2. Зэвсгийн жагсаалт (2-р зүйлийн (2)-(4) хүртэл)		
1-р хэсэг. Хориотой зэвсэг		
2-р хэсэг. Тусгай зөвшөөрөл шаарддаг зэвсэг	I бүлэг. Тусгай зөвшөөрөлд тавих нөхцөл	
	II бүлэг. Тусгай зөвшөөрөл шаардахгүй харьцах хэлбэр	
	III бүлэг. Тусгай зөвшөөрлийн зөөлөн нөхцөл	
3-р хэсэг. Хуулиас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдсөн зэвсэг	I бүлэг. 2-р зүйлийн (1) ба 41-р зүйлд зааснаас гаднах хуулиас чөлөөлөгдсөн зэвсэг	
	II бүлэг. 42а дахь зүйлийг бусад хуулиас чөлөөлөгдсөн зэвсэг	

2.2. Оросын Холбооны Улс

ОХУ-д галт зэвсэг худалдаж авахыг хуулиар зөвшөөрдөг бөгөөд мэргэжил, хувийн байдлаасаа хамаарч галт зэвсэг эзэмших эрх, хугацаа, галт зэвсгийн төрөл зэрэг нь өөр өөр байдаг. Галт зэвсэг эзэмших насанд хүрсэн ОХУ-ын иргэн галт зэвсэг ашиглах анхан шатны сургалтад сууж, шалгалт өгсний дараагаар галт зэвсэг эзэмших эрхтэй болдог. Энэхүү харилцааг ОХУ-д Холбооны Эрүүгийн хууль, Галт зэвсгийн тухай хуулиар зохицуулдаг.

Хүснэгт 9.3. ОХУ-ын Галт зэвсгийн тухай хуулийн бүтэц

№	Бүлэг	Зүйл
1	Холбооны хуульд ашигласан үндсэн ойлголт	§1
2	Зэвсгийн төрөл	§2-5
3	Зэвсгийн хэрэглээний хязгаарлалт, эмнэлгийн үзлэг	§6-6.1
4	Зэвсэг, түүний суманд тавигдах шаардлага	§7
5	Зэвсэг, сумны улсын бүртгэл	§8
6	Зэвсэг, сум цуглуулах, үйлдвэрлэх, устгах	§9-9.2
7	Зэвсэг худалдан авах	§10
8	Төрийн байгууллагын зэвсэг худалдан авах эрх	§11
9	Хуульд заасан тусгай субъект зэвсэг худалдан авах, түр ашиглах	§12
10	Энгийн иргэд зэвсэг худалдан авах, туршилтын буудлага хийх	§13-13.1
11	Гадаадын иргэн зэвсэг ашиглах, эзэмших	§14
12	Зэвсэг, сум үйлдвэрлэх, засварлах	§16-16.1
13	ОХУ-руу зэвсэг, хэрэгсэл, сум импортлох, ОХУ-аас экспортлох	§17
14	Иргэний болон албаны зэвсэг, сум худалдаалах	§18
15	Цэргийн байгууллага зэвсэг худалдах, шилжүүлэх	§19
16	Зэвсгийг худалдах, бэлэглэх, өвлүүлэх болон шагналын зэвсэг	§20-20.1
17	Иргэний болон албаны зэвсэг хадгалах	§22
18	Зэвсгийн наймаанаас авах хураамж	§23
19	ОХУ-ын иргэн зэвсэг хэрэглэх, ашиглах	§24-24.1
20	Зэвсгийг бүртгэх, тээвэрлэх, цуглуулах, үзүүлэх	§25
21	Зэвсэг ашиглах, эзэмших зөвшөөрлийг хүчингүй болгох	§26
22	Зэвсэг, сум хураан авах	§27
23	Зэвсгийн эргэлтэд хяналт тавих	§28
24	Хууль хүчин төгөлдөр болох Зохицуулах эрх зүйн актуудыг энэ хуульд нийцүүлэх Хуулийн хэрэгжилтийг хангах Хууль батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжийн зарим актыг хүчингүй болсонд тооцох	§29-32

III. ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ, ТӨРӨЛ, ЗОРИУЛАЛТ

3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуульд заасны дагуу “зэвсэг” гэдэгт дараах шинжийг агуулсан буу, эсвэл түүнтэй адилтгах зүйл болон зөөврийн объектыг ойлгоно.¹⁰ Үүнд:

- Аливаа этгээдийг хамгаалах эсвэл түүн рүү халдах, зэвсгийг устгах эсвэл холдуулах зорилгоор ашиглаж буй;
- Шинж чанар, хэрхэн ажилладаг зэргээс шалтгаалан тухайн зорилгод зориулагдаагүй байсан ч аливаа этгээдийн довтолох, хамгаалах чадварыг арилгах буюу багасгах чадвартай;

Тус хуульд зааснаар зэвсгийг хориотой зэвсэг (1), тусгай зөвшөөрөл шаарддаг зэвсэг (2), хуулиас бүхэлд нь болон хэсэгчлэн чөлөөлөгдсөн зэвсэг (3) хэмээн 3 ангилдаг ба галт зэвсэг буюу буу нь эхний ангилалд багтдаг.

ХБНГУ-д галт зэвсгийг ашиглахад тусгай зөвшөөрөл шаарддаг бөгөөд энэ талаар Зэвсгийн тухай хуулийн хавсралт 1-ийн 1 дүгээр хэсгийн эхний бүлэгт зохицуулсан байдаг.

Тусгай зөвшөөрөл шаарддаг хориотой галт зэвсэг нь буу, зөөврийн объект, ашиглах боломжгүй болсон (гоёл чимэглэлийн зориулалттай) буу, хуурамч буу багтдаг бол тусгай зөвшөөрөл шаарддаггүй галт зэвсэгт мэндчилгээний зэвсэг хамаарна.

Зэвсгийн тухай хуульд эдгээрийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- “Буу” гэж довтолгоо, хамгаалалт, дохиолол, ан агнуур, сум харвах, спорт, амралт зугаалгын зориулалттай сумыг торхоор дамжуулан гадагшлуулдаг объектыг ойлгоно.¹¹ Буу нь зөөврийн объектой ижил шинж чанартай. Тодруулбал, галлах, хөдөлгөөний хүчийг булчингийн хүчээр хангадаг зорилтот биеийг буудах зориулалттай, сумны үзүүрийн хамгийн их кинетик энерги нь 0.16 ж/см²-аас ихгүй уян үзүүртэй объектыг “зөөврийн объект” гэж ойлгоно.
- “Ашиглах боломжгүй болсон буу” гэж сум болон түлхэлтийн цэнэгийг ачиж болохгүй, түүний үндсэн эд ангиудыг стандарт багаж ашиглан хэвийн байдалд оруулах боломжгүй буюу бүрмөсөн ашиглах боломжгүй болсон галт зэвсгийг ойлгоно.
- “Мэндчилгээний зэвсэг” гэж театрын тоглолт, гэрэл зураг, кино, телевизийн бичлэг хийх зориулалттай галт зэвсгийг хэлнэ.
- “Хуурамч буу” гэж гаднах байдлаараа буу шиг харагддаг ч галт зэвсгийн шинж чанаргүй, тоглоом гэж хүлээн зөвшөөрөгдөхүйц бууг ойлгоно гэж тодорхойлжээ.

10 Waffengesetz (WaffG) 2002, Sektion 1 (2), Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039, Сүүлд үзсэн огноо: 2024.01.25.

11 Waffengesetz (WaffG) 2002, Annex 1 (to Sektion 1 (4)), Part 1, Chapter 1, §1.1, Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039, Сүүлд үзсэн огноо: 2024.01.25.

3.2. Оросын Холбооны Улс

ОХУ-д галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэдгээртэй холбоотой ойлголтыг Галт зэвсгийн тухай хуульдаа дараах байдлаар заажээ.

Галт зэвсгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан нэр томъёо хэсэгт:

- ✓ **Зэвсэг** – амьд болон бусад биет байг онох, дохио өгөх зориулалттай төхөөрөмж галт зэвсэг - дарь болон бусад цэнэгийн энергийг ашиглан алсын зайн байг механикаар онох зориулалттай зэвсэг;
- ✓ **Галт зэвсгийн үндсэн хэсгүүд** – их бие, затвор, боолт, хүрд, хүрээ, хүлээн авагч;
- ✓ **Иртэй зэвсэг** - байтай шууд харьцах хүний булчингийн хүчийг ашиглан байг онох зориулалттай зэвсэг;
- ✓ **Шидэлтийн зэвсэг** – хүний булчингийн хүчийг ашиглан шидэгдэж байг алсаас онох зориулалттай зэвсэг (шидэх зэвсэг), түүнчлэн механик энерги ашиглан шидсэн сумаар алсын зайд байг онох зориулалттай зэвсэг;
- ✓ **Пневматик зэвсэг** - шахсан, шингэрүүлсэн, хатууруулсан хийн энергийн нөлөөгөөр чиглэсэн хөдөлгөөнийг хүлээн авдаг сумаар алсын зайд байг онох зориулалттай зэвсэг;
- ✓ **Хийн зэвсэг** - нулимс асгаруулагч, цочроох бодис ашиглан амьд байг түр хугацаагаар химийн аргаар устгах зориулалттай зэвсэг;
- ✓ **Сум** - байг онох зориулалттай, тэсэрч дэлбэрэх, хөдөлгөх, пиротехникийн болон хөөргөх цэнэг, эсхүл тэдгээрийн хослол агуулсан зэвсэг, сумны хэрэгсэл;
- ✓ **Сум** - сумны хайрцгийг эхлүүлэх хэрэгсэл, түлшний цэнэг, сумны тоног төхөөрөмжийн тусламжтайгаар нэг хэсэг болгон нэгтгэсэн зэвсгийг галлах зориулалттай төхөөрөмж;
- ✓ **Дохионы зэвсэг** - бүтцийн хувьд зөвхөн гэрэл, утаа, дуут дохио өгөх зориулалттай зэвсэг;
- ✓ **Зэвсгийн эргэлт, галт зэвсгийн үндсэн эд анги** (цаашид - зэвсэг) - зэвсэг үйлдвэрлэх, зэвсгийн худалдаа, худалдах, шилжүүлэх, олж авах, цуглуулах, үзүүлэх, нягтлан бодох бүртгэл, хадгалах, авч явах, тээвэрлэх, тээвэрлэх, ашиглах, хураах, устгах, импортлох. ОХУ-д зэвсэг, ОХУ-аас экспортлох;
- ✓ **Зэвсгийн үйлдвэрлэл** - судалгаа, боловсруулалт, туршилт, үйлдвэрлэл, түүнчлэн зэвсгийн уран сайхны чимэглэл, засвар, сум, сум, түүний эд анги үйлдвэрлэх;
- ✓ **Хязгаарлагдмал устгалын галт зэвсэг** - гэмтлийн цохилтын сумны хэрэгслээр алсын зайд амьд байг механикаар устгах зориулалттай, нунтаг болон бусад цэнэгийн энергийн нөлөөгөөр чиглэсэн хөдөлгөөнийг хүлээн авдаг, хүний амь насыг хохироох зориулалтгүй богино сумтай, сумгүй зэвсэг хүн;
- ✓ **Гэмтлийн сум** - гөлгөр нүхтэй галт зэвсгээс эсвэл хязгаарлагдмал устгалтай галт зэвсгээс буудах зориулалттай, сумны хайрцгийг тусламжтайгаар гэмтлийн үйлдлийг эхлүүлэх хэрэгсэл, түлшний цэнэг, сумны зэвсгийн тусламжтайгаар нэг хэсэг болгон нэгтгэсэн төхөөрөмж. Хүний үхэлд хүргэх зорилготой;

- ✓ **Хийн сум** - хийн зэвсэг эсвэл хязгаарлагдмал устгалтай галт зэвсгээс буудах зориулалттай, сумны хайрцгийн тусламжтайгаар нэг бүтнээр нэгтгэсэн, нулимс асгаруулагч, цочроох бодисоор тоноглогдсон, хүний амь насыг хохироох зориулалтгүй төхөөрөмж. Хүн;
- ✓ **Гэрэл, дууны үйл ажиллагааны сум** - галт зэвсэг, хязгаарлагдмал устгалын галт зэвсэг, хийн буюу дохионы зэвсгээс буудах зориулалттай, зориулалтын бус гэрлийн болон дууны үйлчлэлийг эхлүүлэх хэрэгсэл, хэрэгслийг сумны хайрцгийн тусламжтайгаар нэг хэсэг болгон нэгтгэсэн төхөөрөмж. Амьд эсвэл бусад байг онох;
- ✓ **Дохионы сум** - галт зэвсэг, дохионы зэвсгийг буудах зориулалттай, сумны хайрцгийн тусламжтайгаар нэг хэсэг болгон нэгтгэж, гэрэл, утаа, дуут дохио өгөх зориулалттай төхөөрөмж. Амьд эсвэл бусад зорилтот;
- ✓ **Цохилтын механизмын довтлогч** - сумыг эхлүүлэх хэрэгсэлд цохилт өгөх цохилтын механизмын хэсэг;
- ✓ **Соёлын үнэт зэвсэг** - 1996 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн п 54-fz “ОХУ-ын музейн сан ба ОХУ-ын музейн тухай» холбооны хуулийн дагуу ОХУ-ын музейн санд багтсан зэвсэг, эсвэл ОХУ-ын 1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 4804-1-р «соёлын үнэт зүйлийг экспортлох, импортлох тухай», түүний дотор эртний (эртний) зэвсгийн тухай ОХУ-ын хуулийн дагуу ОХУ-ын холбооны гүйцэтгэх байгууллагын эрх бүхий засгийн газрын шийдвэрээр;
- ✓ **Эртний (эртний) зэвсэг** - 1899 оныг дуустал үйлдвэрлэсэн галт зэвсэг, шидэлтийн болон пневматик зэвсэг (буудах суманд зориулж үйлдвэрлэсэн галт зэвсгээс бусад), түүнчлэн 1945 оныг дуустал үйлдвэрлэсэн иртэй зэвсэг;
- ✓ **Хуучин (эртний) зэвсгийн хуулбар** - хуучин (эртний) зэвсгийн дээжийн эх буюу зургийн дагуу түүний хийц, үзэмж, чимэглэлийг үнэн зөв, эсхүл жинхэнэ эд ангиудыг оруулалгүйгээр том хэмжээтэй хийсэн зэвсэг. Эртний болон бусад төрлийн зэвсэг;
- ✓ **Хуучин (эртний) зэвсгийн хуулбар** - хуучин (эртний) зэвсгийн дээжийн эх хувь, зураг, тайлбарын дагуу хийсэн загвар, үзэмж, уран сайхны өнгөлгөөний хувьд бүтээлч өөрчлөлттэй, жишээ болгон соёлын үнэ цэнтэй зэвсэг уран сайхны бүтээлч байдал, гоёл чимэглэлийн болон хэрэглээний урлаг;
- ✓ **Ашиглалтаас хасагдсан зэвсэг** - үндсэн хэсэг бүрд нь түүнээс буудах, түүний үндсэн хэсгүүдийг сум, түүний дотор сумны төхөөрөмжөөр ашиглах боломжийг үгүйсгэсэн техникийн өөрчлөлт хийгдсэн, соёл, боловсролын үйл ажиллагаанд ашиглах зориулалттай галт зэвсэг. Түүнээс буудсан сумыг гэрэл, дуу авианы сумаар дуурайлган хийх боломж (нүхтэй зэвсэг) эсвэл түүнээс буудаж дуурайх боломжгүй (сургалтын зэвсэг) эсвэл зэвсгийн эд анги, механизмын харилцан үйлчлэлийн үйл явцыг судлах (зэвсэг таслах)
- ✓ **Хөргөсөн сумнууд** - хайрцагт нүхтэй, түлшний цэнэг ашигласан эхлүүлэгчтэй галт зэвсгийн сум;
- ✓ **Зэвсгийн эргэлтийн чиглэлээр эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллага** - ОХУ-ын үндэсний гвардийн цэргүүд, зэвсгийн салбарт төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг холбооны гүйцэтгэх байгууллага. Эргэлт, хувийн

- хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр болон хувийн аюулгүй байдлын чиглэлээр;
- ✓ **Иргэний урт сумтай галт зэвсгийн сумыг өөрөө тоноглох** - агнуурын урт сумтай галт зэвсэг болон (эсвэл) спортын урт сумтай галт зэвсэг эзэмшдэг иргэд хувийн хэрэгцээнд зориулж сумыг өөрөө угсрах;
 - ✓ **Жижиг зэвсэг шидэх** - харимхай элементүүдийн хэв гажилтын энергийг алсын зайд онох сумны чиглэсэн хөдөлгөөн (шидэлт) болгон хувиргах механик төхөөрөмж болох шидэх зэвсэг;
 - ✓ **Сум** - шидэгч, зөөвөрлөх, тогтворжуулах элементүүдээс бүрдэх төхөөрөмж, эсвэл шидэлтийн шинж чанартай объект, шидэлтийн бага оврын зэвсгээс шидэлтийн үр дүнд зайд байрлах байг механикаар устгах зориулалттай;
 - ✓ **Шидэх зэвсэг** - хүний булчингийн хүчийг ашиглан шидэлтийн үр дүнд зайд байрлах байг механикаар ялах зориулалттай шидэх зэвсэг (шиддэг зэвсэг);
 - ✓ **Гөлгөр цооногтой галт зэвсэг** - гол нь дугуй хөндлөн огтлолтой, цилиндр буюу конус хэлбэртэй, бүхэл бүтэн уртаараа гөлгөр (тэгш) дотоод гадаргуутай галт зэвсэг;
 - ✓ **Винтовын галт зэвсэг (винтовт сумтай галт зэвсэг)** - буудах үед сумны төхөөрөмжид тэнхлэгийн эргэн тойронд тэнхлэгийн эргэн тойронд эргэлдэх хөдөлгөөнийг өгдөг цооног нь дотоод гадаргуу дээр хөндлөн огтлол, хэлбэр, ховилтой (цутгасан, хонхорхой) галт зэвсэг;
 - ✓ **Гох механизм** - буудлагын эхлэл ба төгсгөлийг хянах зориулалттай зэвсгийн механизм;

Зэвсгийн аюулыг нэмэгдүүлэх эх үүсвэр, холбогдох субъектүүдийн ашиглах зорилго, үндсэн параметр, шинж чанарыг шалгуур болгон Галт зэвсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлд дараах байдлаар ангилжээ. Үүнд:

1. **Иргэний** - Энэ нь ОХУ-ын иргэд өөрийгөө хамгаалах, спорт, ан агнуур, соёл, боловсролын зориулалтаар ашиглах зориулалттай зэвсэг юм. Иргэний галт зэвсэг нь тэсрэлтээр галладаггүй байх ба 10-аас илүүгүй сумны багтаамжтай байх ёстой. Сумны багтаамжийн хязгаарлалт нь спортын зэвсэгт хамаарахгүй бөгөөд түүнд тавигдах шаардлагыг спортын дүрэм эсхүл ОХУ-ын бүх спортын холбоодоор магадлан итгэмжлэгдсэн спортын тэмцээний тухай дүрмээр тодорхойлдог. Иргэний галт зэвсгээр буудах үед бууны хошууны энерги нь 150Ж-ээс хэтрэхгүй байх ёстой. Иргэний зэвсэг, түүнд зориулсан сум нь холбооны хууль тогтоомжоор тогтоосон шүүх эмнэлгийн шаардлагад нийцсэн байх ёстой.

2. **Албан тушаалтан** - Үйлчилгээний зэвсэг буюу цагдаа, хүчний байгууллагуудын өдөр тутам биедээ авч явдаг зэвсэг багтана.

3. **Гар буудлага болон хүйтэн зэвсэг** - Үүнд хийн буу болон хутга зэрэг багтана.

IV. ГАЛТ ЗЭВСЭГ ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨВЛӨХ, БЭЛЭГЛЭХ

4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс


ХБНГУ-ын галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах, өвлөх, бэлэглэх, бүртгүүлэх, хадгалах тухай зохицуулалтыг “Зэвсгийн тухай хууль”-аар зохицуулсан байдаг. Галт зэвсэг, сум хэрэгслийг олж авах, эзэмшиж, бусдад хүлээлгэн өгөх, зөөвөрлөх, шилжүүлэх, үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, ашиглах, засварлах, худалдаалахыг “зэвсэг, сумтай харьцах” гэнэ.¹²

Зэвсэг худалдан авах, эзэмших, ашиглах тусгай зөвшөөрлийн төрөл

Зэвсгийн тухай хуулийн дагуу галт зэвсэг эзэмших, худалдан авахад зэвсэг эзэмших үнэмлэх (Waffenbesitzkarte), харин галт зэвсгийг ашиглах, биед авч явахад зэвсгийн лиценз (Waffenschein) хэрэгтэй. Тодруулбал, галт зэвсэг цуглуулагчид зөвхөн зэвсэг эзэмших үнэмлэх (Waffenbesitzkarte) л хэрэгтэй гэсэн үг. Анчдад ан агнуурын лиценз (Jagdschein) байгаа л бол зэвсгийн лиценз (Waffenschein) хэрэггүй бөгөөд зөвхөн ан агнуурын зориулалтаар буюгаа ашиглах боломжтой гэсэн үг юм.

Зэвсэг эзэмших үнэмлэх (Waffenbesitzkarte) нь буу эзэмшигчдэд галт зэвсгийг авч явахаас илүүтэйгээр зөвхөн “тээвэрлэх” боломжийг олгодог. Буу биед авч явах тусгай зөвшөөрөл (Waffenschein) нь цөөн тохиолдолд олгогддог. Тухайлбал, өргөдөл гаргагч нь олон нийт аюулд өртсөн үед ашиглах шаардлага тулгарч, буу авч явах нь тэднийг аюулгүй байлгах болно гэдгийг нотлох үед олгодог. Түүнчлэн, ХБНГУ-ын хуульд бууг нуун дарагдуулах эсвэл олон нийтийн газар цэнэглэх эсэх талаар ямар ч заалт байдаггүй байна.¹³

Схем 9.1. Зэвсэг эзэмших, ашиглах тусгай зөвшөөрлийн төрөл



Зэвсэг худалдан авах, эзэмших, ашиглах тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага:

Зэвсгийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 10 дугаар зүйлийн (1)-д зааснаар зэвсэг худалдан авах, эзэмших тусгай зөвшөөрлийг зэвсэг эзэмших үнэмлэх (Waffenbesitzkarte)-ээр олгоно. Зэвсэг худалдан авах тусгай зөвшөөрөл нь 1 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд түүнийг эзэмших тусгай зөвшөөрөл ихэвчлэн хугацаагүй олгогдоно. Тус хуулийн 10 дугаар зүйлийн (4)-т зааснаар зэвсэг авч

12 Waffengesetz (WaffG) 2002, Sektion 1 (3), Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039, Сүүлд үзсэн огноо: 2024.01.25

13 Deutsche Welle (DW), ХБНГУ-ын олон улсын нэвтрүүлэг, ХБНГУ дахь бууны хяналт, галт зэвсэг эзэмших, нийтлэгдсэн: 2020.02.20, шинэчлэгдсэн: 2022.12.12, Холбоос: <https://www.dw.com/en/gun-control-and-firearms-possession-in-germany/a-52450664>, Сүүлд үзсэн огноо: 2024.01.29

явах зөвшөөрлийг зэвсгийн лиценц (Waffenschein)-ээр олгох ба зарим төрлийн галт зэвсгийн хувьд дээд тал нь 3 жилийн хугацаанд хүчинтэй. Энэ хугацааг шаардлагатай бол хоёр удаа дээд тал нь 3 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

Зэвсэг худалдан авах, эзэмших тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр хэсгийн (1) ба 5-9 дүгээр хэсэгт дэлгэрэнгүй заасан байдаг. Тус хуульд зааснаар галт зэвсэг эзэмших тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд дараах шалгуурыг хангаж, баталгааг хавсаргах шаардлагатай. Үүнд:

1. 18 насанд хүрсэн байх (Зэвсгийн тухай хуулийн 2 дүгээр хэсгийн (1) дэх зүйл)
Зөвхөн 18 нас хүрсэн хүн зэвсэг, сумтай харьцахыг зөвшөөрнө.
2. Шаардлагатай найдвартай байдал (Зэвсгийн тухай хуулийн 5 дугаар хэсэг)

Дараах этгээдийг найдвартай гэж үзэхгүй. Үүнд:

- Ямар нэгэн гэмт хэрэг, эсвэл 1 жилээс доошгүй хугацаагаар хорих ялтай гэмт хэрэг, зөрчлийг санаатай үйлдсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй, эсвэл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 жил өнгөрөөгүй байгаа этгээд;
- Галт зэвсэг, сум хэрэгслийг зүй бус ашиглах, хадгалах нөхцөл хангаагүй, эсвэл эдгээр объектод хяналт тавих эрхгүй хүлээлгэн өгөх үндэслэлтэй гэж үзсэн этгээд.

Дараах этгээдийг дүрмээр найдвартай гэж үзэхгүй. Үүнд:

- Санаатай гэмт хэрэг үйлдсэн; зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодистой харьцсантай холбогдуулан санамсаргүйгээр үйлдсэн, эсхүл санамсаргүйгээр олон нийтэд аюул учруулсан гэмт хэрэг үйлдсэн; Зэвсгийн тухай хууль, Дайны зэвсгийг хянах тухай хууль, Тэсрэх бодисын тухай хууль эсвэл Холбооны ан агнуурын тухай хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг үйлдэж хорих ял, эсвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгор ялаар шийтгүүлсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон этгээд;
- Хувийн холбоог удирдах тухай хуулийн дагуу байгууллага болохыг бүрмөсөн хориглосон, эсхүл хувийн холбоог удирдах тухай хуулийн дагуу үйл ажиллагааг нь бүрмөсөн хориглосон холбоо; Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 46 дугаар хэсгийн дагуу Холбооны Үндсэн хуулийн шүүх үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн намд сүүлийн 10 жилийн хугацаанд гишүүн байсан этгээд;
- Дангаар болон холбооны гишүүний хувьд Үндсэн хуулийг эсэргүүцсэн эсвэл; олон улсын харилцан ойлголцол, ялангуяа энх тайвнаар зэрэгцэн орших үзэл санааны эсрэг чиглэсэн эсвэл; хүчирхийлэл, эсвэл хүчирхийлэлд бэлтгэх арга хэмжээ авах замаар ХБНГУ-ын гадаадын ашиг сонирхлыг аюулд учруулах үйл ажиллагаанд сүүлийн 5 жилийн хугацаанд оролцсон, дэмжсэн этгээд;
- Хүчирхийлэл үйлдсэн хэргээр сүүлийн таван жилийн хугацаанд нэгээс олон удаа шүүхийн зөвшөөрлөөр цагдаагийн байгууллагад цагдан хоригдсон этгээд;

- Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 46-р хэсгийн дагуу Холбооны Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн аль нэг заалтыг удаа дараа буюу бүдүүлгээр зөрчсөн этгээд.

Хувийн чадвар (Зэвсгийн тухай хуулийн 6 дугаар хэсэг)

Дараах этгээдийг хувийн чадвартай гэж үзэхгүй. Үүнд:

- Эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай;
- Архи, согтууруулах ундааны хамааралтай, сэтгэцийн өвчтэй;
- Хувийн нөхцөл байдлын улмаас зэвсэг, сумтай болгоомжтой, зөв харьцах чадваргүй, өөрийгөө болон бусдыг гэмтээх онцгой эрсдэлтэй;

Түүнчлэн, өргөдөл гаргагчийн бичиг баримтад эргэлзэх шалтгаан байгаа бол; эсвэл 25-аас доош насны хүн анх удаа буу олж авах, эзэмших тусгай зөвшөөрөл хүссэн тохиолдолд эрх бүхий байгууллага өргөдөл гаргагчийн зардлаар тухайн этгээдээс бие махбодын болон сэтгэцийн ур чадвар, сэтгэл зүйчийн гэрчилгээ авахыг шаардана.

3. Тусгай мэдлэгтэй байх (Зэвсгийн тухай хуулийн 7 дугаар хэсэг)

Томилогдсон байгууллагад шалгалт өгсөн, эсвэл үйл ажиллагаа, сургалтаар тусгай мэдлэгээ харуулсан хүмүүсийг тусгай мэдлэгээ нотолсон гэж үзнэ. Холбооны Дотоод хэргийн яам нь Холбооны зөвлөл (Bundesrat)-ийн зөвшөөрлөөр зэвсгийн шаардлагатай техникийн болон хууль эрх зүйн мэдлэг, шалгалт, шалгалтын журам, түүний дотор шалгалтын хороо байгуулах зэрэг бусад хууль эрх зүйн баримт бичгийг гаргах эрхтэй.

4. Хэрэгцээтэй байх (Зэвсгийн тухай хуулийн 8 дугаар хэсэг)

Дараах зүйлийг нотлох бичиг баримтыг өгсөн тохиолдолд олон нийтийн аюулгүй байдал, дэг журмыг сахиулах байдлаа буюу хэрэгцээтэй байх шаардлагыг нотолж байна гэж үзнэ. Үүнд:

- Анчин, мэргэн бууч, уламжлалт мэргэн бууч, зэвсэг, сум цуглуулагч, зэвсэг, сумны шинжээч, зэвсэг үйлдвэрлэгч, зэвсгийн наймаачин, хамгаалалтын фирмийн хувьд тусгайлан хүлээн зөвшөөрөгдөх хувийн болон эдийн засгийн ашиг сонирхол;
- Зэвсэг буюу сум нь заасан зориулалтад тохирох эсэх.

5. Зэвсгийн лиценз (Waffenschein) авахад биемахбод болон эд хөрөнгөд учирч болзошгүй гэмтэл, хохирлын 1 сая еврогийн хариуцлагын даатгалын баталгаа.

Өв залгамжлалын замаар галт зэвсэг олж авах, эзэмших

Өв залгамжлалын замаар галт зэвсэг олж авах, эзэмших нөхцөлийг ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 3 дугаар бүлэг (Тодорхой бүлэг хүмүүст зориулсан тусгай зөвшөөрөл)-ийн 20 дугаар хэсэгт “Өв залгамжлах замаар буу олж авах, эзэмших” нэртэй зохицуулсан байна. Хуулийн 17 дугаар хэсгийн 1 дүгээр зүйлд заасны дагуу нас барсан этгээдийн галт зэвсэг олж авах, эзэмших тусгай зөвшөөрлийг түүний өв залгамжлагч, эсхүл гэрээслэлээр (өв залгамжлах замаар олж авах) өв залгамжлагчид олгоно. Хуулийн 20 дугаар хэсгийн 1 дүгээр зүйлд заасны дагуу

гэрээслэлийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор өвийг хүлээн авах эсэхээ шийдэж галт зэвсгийн тусгай зөвшөөрөл шинээр авах; эсвэл одоо байгаа зэвсэг эзэмшигчийн үнэмлэхэд оруулах хүсэлт гаргах шаардлагатай.

Хүүхэд, залуучууд зэвсэг, сумтай харьцах

ХБНГУ-ын “Зэвсгийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн (1)-д заасны дагуу хүүхэд, залуучууд зэвсэгтэй харьцах, заавар өгөх эрх бүхий хүний хяналт дор сургалт, хөдөлмөр эрхлэх явцад зэвсэг, сумтай харьцаж болно. Удаах зүйлд заасны дагуу хэрэв нийтийн ашиг сонирхолд харшлахгүй бол эрх бүхий байгууллага тусгай үндэслэлээр хүүхэд, залуучуудыг насны хязгаарлалтаас чөлөөлж болно. Тус хуульд заасан “хүүхэд” гэдэгт 12-14 настай хүүхдийг¹⁴, “залуучууд” гэдэгт 14-18 настай этгээдийг ойлгоно.¹⁵

4.2. Оросын Холбооны Улс

Галт зэвсэг эзэмших эрх

Галт зэвсгийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд буу эзэмшихтэй холбоотой эмнэлгийн эсрэг заалт байгаа эсэхийг тодорхойлохын тулд эмнэлгийн үзлэгт орох ёстой.

Зэвсэг эзэмшихтэй холбоотой эмнэлгийн эсрэг заалт байгаа эсэхийг тогтоох эмнэлгийн үзлэгээ ОХУ-ын иргэд анх удаа зэвсэг худалдан авч байгаа бол улсын болон хотын эрүүл мэндийн байгууллагууд хийлгэнэ. Харин тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зэвсэг эзэмшдэг иргэд (ОХУ-ын иргэдээс бусад, төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагад алба хааж, цэргийн цол, тусгай цол, зэрэгтэй) оршин суугаа газрын эрүүл мэндийн газар үзлэгийг хийлгэнэ.

Буу эзэмшихтэй холбоотой эмнэлгийн эсрэг заалт байгаа эсэхийг шалгах эрүүл мэндийн үзлэгт сэтгэцийн үзлэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн метаболитуудын биед агуулагдах химийн болон хор судлалын судалгаа орно гэж заажээ.

Галт зэвсэг ашиглах

Галт зэвсгийн тухай хуулийн 20 дугаар зүйл: Зэвсэг худалдах, бэлэглэх, өвлүүлэх

ОХУ-ын иргэд хууль ёсны дагуу хувийн өмчид байгаа зэвсгээ иргэний болон албаны зэвсэг худалдаалах, зэвсэг цуглуулах, үзүүлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд, эсхүл холбооны гүйцэтгэх байгууллагад урьдчилан мэдэгдэн төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагад худалдах эрхтэй.

Зэвсэг хадгалах, авч явах, ашиглах зөвшөөрөл олгосон эсхүл орон нутгийн байгууллага, түүнчлэн зэвсэг худалдан авах, цуглуулах, үзэсгэлэн гаргах зөвшөөрөлтэй иргэн;

14 Waffengesetz (WaffG) 2002, Sektion 27 (3) 1, Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039, Сүүлд үзсэн огноо: 2024.02.26.

15 Waffengesetz (WaffG) 2002, Sektion 27 (3) 2, Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039, Сүүлд үзсэн огноо: 2024.02.26.

Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага эсвэл тухайн зэвсгийг бүртгэх газар дахь орон нутгийн байгууллагад зэвсгийг дахин бүртгүүлсний дараа энэхүү Холбооны хуульд заасан зэвсгийг олж авах, худалдан авах эрх үүснэ.

Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагад бүртгэгдсэн иргэний зэвсгийг хандивлах, өвлүүлэх харилцаа нь ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон журмаар явагдана.

Зэвсэг олж авах бусад үндэслэл

Ашиглалтаас хасагдсан зэвсгийг хандивлах, өвлөн авахын тулд хүлээн авагчид ямар нэгэн зөвшөөрөл шаардлагагүй. Иргэний зэвсгийн эзэмшигч нас барсан тохиолдолд өв залгамжлах асуудлыг шийдэж, иргэний зэвсэг худалдан авах зөвшөөрөл авахаас өмнө тухайн зэвсгийг эрх бүхий байгууллага хадгалах зорилгоор хурааж авдаг.


V. ГАЛТ ЗЭВСГИЙН ХУДАЛДАА БА ИМПОРТ

5.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл

Арилжааны зэвсгийн үйлдвэрлэл, худалдааг ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зохицуулсан байдаг. Тус зүйлийн (1)-д зааснаар аж ахуйн нэгжийн хүрээнд арилжааны болон бие даасан үндсэн дээр буу, сум үйлдвэрлэх, засварлах зөвшөөрлийг зэвсэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөөр олгоно; буу, сумны худалдаа эрхлэх зөвшөөрлийг зэвсэг худалдах тусгай зөвшөөрлөөр олгоно. Тусгай зөвшөөрлийг тодорхой төрлийн буу, сумаар хязгаарлаж болно.

Схем 9.2. Галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл



Дээрх 2 тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд олгохоос татгалзана. Үүнд:

- Өргөдөл гаргагч нь шаардлагатай найдвартай байдал (5 дугаар зүйл) эсвэл хувийн чадвартай байдал (6 дугаар зүйл)-ийг хангаагүй;
- Өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрөл шаарддаг Гар урлалын үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй;
- Өргөдөл гаргагч нь зэвсэг худалдах тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан тохиолдолд шаардлагатай тусгай мэдлэгээ харуулаагүй (өргөдөл гаргагч нь бизнес эсвэл хараат, бие даасан салбараа өөрөө удирддаггүй бол энэ нь хамаарахгүй);
- Өргөдөл гаргагч Үндсэн хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу Германы иргэн биш;
- Өргөдөл гаргагч энэ хуулиар зохицуулсан нутаг дэвсгэрт энгийн оршин суугч биш, худалдааны байгууллага ч байхгүй бол.

5.2. Оросын Холбооны Улс

Галт зэвсгийг худалдах, худалдаж авах, импортлох, тээвэрлэх

Галт зэвсгийн тухай хуулийн 13 дугаар зүйл. ОХУ-ын иргэдийн зэвсэг худалдан авах эрх

21 нас хүрсэн зэвсэг эзэмших зөвшөөрөлтэй ОХУ-ын иргэд, зарим тохиолдолд 21 нас хүрээгүй зэвсэг эзэмших эрхтэй. ОХУ-ын иргэд, цэргийн алба хааж байгаа

буюу хаасан, түүнчлэн, төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагад алба хааж байгаа, цэргийн цолтой иргэд, тусгай цол буюу шүүгч нар энэ хуульд заасан зэвсэг эзэмших эрхтэй. ОХУ-ын уугуул, хөдөө аж ахуй, гар урлал эрхэлдэг, түүнчлэн ан агнуурын мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд зориулалтын зэвсэг эзэмших эрхтэй. Хууль сахиулах байгууллагад ажилладаг албан хаагч 18 нас хүрсэн бол зэвсэг авах эрхтэй.

ОХУ-ын иргэд, казакууд үндэсний хувцасны бүрдэл хэсэг болгон иртэй зэвсэг, хийн гар буу, буу, дохионы зэвсэг, худалдаж авах эрхтэй. Тухайн зэвсгийг хоёр долоо хоногийн дотор зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага эсвэл оршин суугаа газрынхаа орон нутгийн байгууллагад бүртгүүлэх ёстой.

ОХУ-ын иргэд гөлгөр цооногтой урт сумтай агнуурын галт зэвсэг худалдаж авах эрх олгох насыг хууль тогтоох (төлөөлөх) төрийн байгууллагын шийдвэрээр хоёр жилээс илүүгүй хугацаагаар бууруулж болно.

Зэвсэг худалдан авах тусгай зөвшөөрлийн дагуу заасан төрлийн зэвсгийн таваас илүүгүй нэгжийг бүртгэхийг зөвшөөрдөг. Тусгай зөвшөөрлийг зэвсгийн наймааны чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллага эсвэл ОХУ-ын иргэний оршин суугаа газрын орон нутгийн байгууллага олгодог. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа таван жил байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссаны дараа энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан журмаар сунгаж болно.

18 нас хүрсэн ОХУ-ын иргэд тусгай зөвшөөрөл авалгүйгээр нулимс асгаруулагч, аэрозол болон бусад төхөөрөмж, цахилгаан бороохой зэрэг зэвсгийг ашиглах, худалдаж авах хэрэгтэй. Тэдгээрийн амны энерги нь 7.5 дж-аас ихгүй, 4.5 мм хүртэл калибр бүхий хийн зэвсэг байна.

Эртний зэвсэг, эртний зэвсгийн хуулбар, соёлын үнэ цэнтэй иртэй зэвсгийг зэвсэг цуглуулах зөвшөөрөлтэй ОХУ-ын иргэд худалдаж авах эрхтэй.

ОХУ-ын иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан гөлгөр цооногтой урт сумтай галт зэвсгийг өөрийгөө хамгаалах зорилгоор олж авах эрхтэй. Энэ зорилгоор хоёроос дээш сумтай гөлгөр голтой, урт сумтай галт зэвсэг, сум худалдан авахыг хориглоно.

Ан агнуурын зөвшөөрөлтэй ОХУ-ын иргэд спортын болон агнуурын гөлгөр цооногтой урт сумтай зэвсэг, ан агнуурын пневматик, агнуурын шидэлтийн буу худалдаж авах эрхтэй.

Ан агнуурын тусгай зөвшөөрөлтэй ОХУ-ын иргэд дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан тохиолдолд винтов, урт сумтай агнуурын галт зэвсгийг худалдан авах зөвшөөрөл авах эрхтэй:

1. Ан агнууртай холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг;
2. Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр таван жилээс доошгүй хугацаанд урт сумтай агнуурын галт зэвсгийг эзэмших;
3. Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагаас олгосон биедээ зэвсэг авч явах зөвшөөрлийн үндсэн дээр винтов, агнуурын урт сумтай галт зэвсгийг эзэмших;

4. Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр таван жилээс доошгүй хугацаанд урт сумтай агнуурын галт зэвсгийг тасралтгүй эзэмшсэн байх, хэрэв заасан зөвшөөрлийн хугацаа дууссан, эсхүл тухайн зөвшөөрлөөс сайн дураараа татгалзсаны үндсэн дээр цуцлагдсан өдрөөс хойш нэг жилээс илүүгүй хугацаа өнгөрсөн бол;
5. Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагаас энэ зүйлд заасны дагуу түүнийг хадгалах, авч явах зөвшөөрлийн үндсэн дээр винтов, агнуурын урт сумтай галт зэвсэг эзэмшдэг.

Хэрэв тухайн зөвшөөрлийн хугацаа дууссанаас хойш нэг жилээс илүүгүй хугацаа өнгөрөөгүй, эсхүл тухайн зөвшөөрлөөс иргэн сайн дураараа татгалзсаны үндсэн дээр цуцалсан;

ОХУ-ын иргэд дараах тодорхой ангиллын, заасан тооноос илүү иргэний зэвсгийг эзэмшихийг хориглоно.

1. гөлгөр цооногтой урт хошуутай таван нэгж зэвсэг;
2. гөлгөр цооногтой урт сумтай агнуурын галт зэвсэг эсхүл винтов сумтай, агнуурын урт сумтай арван нэгж зэвсэг (хэрэв иргэн винтов сумтай урт сумтай агнуурын галт зэвсэг худалдан авах эрхтэй бол);
3. винтов сумтай таван нэгж спортын галт зэвсэг;
4. ан агнуурын таван нэгж жижиг зэвсэг;
5. хязгаарлагдмал устгах зориулалттай галт зэвсгийн хоёр нэгж;
6. энэ хэсгийн 1, 2 дахь хэсэгт заасан зэвсгийн нийт тооноос арван нэгж.

Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагаас агнуурын зэвсгийг хадгалах, авч явах зөвшөөрөл авсан ОХУ-ын иргэд ан агнуурын иртэй зэвсэг, агнах зориулалттай жижиг зэвсгийг худалдан авах эрхтэй. Ан агнуурын иртэй зэвсгийг зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага, орон нутгийн байгууллагаас тогтоосон журмаар худалдахдаа худалдааны байгууллага бүртгэдэг.

17 дугаар зүйл. ОХУ зэвсэг, сум хэрэгслийг импортлох, экспортлох

ОХУ-д зэвсэг импортлох, экспортлох, цэргийн зориулалттай бүтээгдэхүүнтэй холбоотой гадаад худалдааны үйл ажиллагаа нь гадаад улсуудтай цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай хууль тогтоомжийн дагуу явагддаг. Бусад тохиолдолд ОХУ-д зэвсэг импортлох, экспортлох Засгийн газраас тогтоосон журмаар явагддаг.

27 дугаар зүйл Зэвсэг, сумыг хураан авах

Зэвсэг, сум хэрэгслийг хураан авах ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэнэ.

1) Дараах тохиолдолд зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий байгууллага эсвэл орон нутгийн байгууллага нь холбооны хуульд заасан лиценз ба (эсвэл) зөвшөөрлийг тогтоосон журмын дагуу цуцална:

Хуулийн этгээд зэвсэг, сум үйлдвэрлэх, худалдах, хадгалах, бүртгэх, түүнчлэн галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх, олж авах, шилжүүлэх, тээвэрлэх тусгай зөвшөөрлийн ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон журам, шаардлага, нөхцөлийг ноцтойгоор зөрчсөн,

- Согтууруулах ундаа хэрэглэсэн иргэн зэвсэг авч явсан, зэвсэг авч явсан этгээд согтуугаар эрх бүхий албан тушаалтны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, иргэд зэвсэг, сум хэрэгслийг шилжүүлэх, ашиглах, зэвсэг илгээх, хадгалах, үйлдвэрлэх, худалдах журам зөрчсөн,
- Энэ хуулийн 3.6, 6, 11 дэх хэсгийн 20 дугаар зүйлийн 13-т заасан, тусгай зөвшөөрөл, (эсвэл) зөвшөөрөл авах боломжийг хассан нөхцөл байдал үүссэн;
- Иргэний зэвсэг эзэмшигч нас барсан, эсхүл цэргийн болон албаны зэвсэг хууль ёсны дагуу эзэмшиж байсан иргэн нас барсан;
- Зэвсэг эзэмших эрх бүхий хуулийн этгээдийг татан буулгасан;
- Энэ холбооны хуульд заасан бусад үндэслэлээр;

1) Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт заасан тохиолдолд дотоод хэргийн байгууллага (хуулийн этгээд зэвсэг, сум үйлдвэрлэх, худалдах, хадгалах, бүртгэх тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөлийг ноцтой зөрчсөнөөс бусад);

2) ОХУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчлийг таслан зогсоох, ан агнуур, агнуурын нөөцийг хамгаалах, загас агнуур, усны биологийн нөөцийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, түүний дотор байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр зэвсэг, сум хэрэгслийг дотоод хэргийн байгууллагад шилжүүлэх замаар өөрсдийн бүрэн эрхийнхээ хүрээнд;

3) ЕвроАзийн эдийн засгийн нийгэмлэг болон (эсвэл) ОХУ-ын Гаалийн тухай хууль тогтоомжийн хүрээнд Гаалийн холбооны гаалийн хууль тогтоомжид заасан тохиолдолд гаалийн байгууллага;

4) ОХУ-ын хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд

Зэвсэг, сумыг хураах журмыг ОХУ-ын Засгийн газар тогтоодог.

Энэхүү Холбооны хууль болон ОХУ-ын бусад зохицуулалтын эрх зүйн актаар тогтоосон зэвсгийн эргэлтийн талаарх дүрмийг зөрчсөнтэй холбогдуулан хураан авсан зэвсэг, сумыг устгах нь эрүүгийн, захиргааны болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр болон захиргааны зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу явагддаг.

Энэхүү Холбооны хуульд заасан тусгай зөвшөөрөл ба (эсвэл) зөвшөөрлийг тогтоосон журмын дагуу хүчингүй болгосонтой холбогдуулан хураан авсан зэвсэг, сум, түүнчлэн зэвсэг, сум хэрэгслийг эзэмшигч хуулийн этгээдийг татан буулгахтай холбогдуулан төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг холбооны гүйцэтгэх байгууллагын нутаг дэвсгэрийн байгууллагад шилжүүлсэн.

Хурааж авсан буюу хүлээлгэн өгсөн зэвсэг, (эсвэл) сум хэрэгслийг иргэний хуульд заасны дагуу өмчлөгч нь хураан авах, эсхүл энэхүү Холбооны хуульд

заасан шаардлагын дагуу эзэмшигч нь хураан авсан буюу хүлээлгэн өгсөн өдрөөс хойш нэг жилийн дотор хүлээн авах ёстой. Зэвсэг ба (эсвэл) сум эзэмшигч нь нас барсан тохиолдолд тогтоосон хугацааг иргэний хуульд заасны дагуу өвийг хүлээн авсан (худалдан авсан) өдрөөс эхлэн тооцно. Хадгалсан зэвсэг ба (эсвэл) түүнд зориулсан сум нь ОХУ-ын өмч болно. Хураан авсан зэвсэг, тэдгээрийн сумыг зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллагын нутаг дэвсгэрийн байгууллага төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагуудад хадгалахаар шилжүүлж болно.

Мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр сарын дотор эдгээр зэвсэг ба (эсвэл) сум хэрэгслийг хүлээн авах, өмчлөх шаардлагатай байгаа тухай;

Түүнчлэн, зэвсэг, сум хэрэгслийг хадгалах, албадан гаргахтай холбоотой зардлын дундаж тооцоолсон зардлын хамт зэвсэг эсвэл сумны эзэмшигчид мэдэгдэнэ.¹⁶

16 Федеральный закон от 13.12.1996 N 150-ФЗ (ред. от 25.12.2023) «Об оружии» (с изм. и доп., вступ. в силу с 07.01.2024), Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_12679/2215c48a57ea8ed6877ecb5717f7979a53275552/, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

VI. ГАЛТ ЗЭВСГИЙГ ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Галт зэвсэг хадгалах

Зэвсэг, сум эзэмшдэг этгээд гуравдагч этгээдэд зэвсэг, сумаа алдах, хулгайд алдахаас сэргийлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авна. Зэвсгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн (1)-д заасны дагуу галт зэвсгийг хадгалахад Европын эдийн засгийн бүсийн конвенцод заасан улсууд DIN/EN 1143-1 стандарт, эсэргүүцлийн зэрэг 0 эсвэл бусад гэрээт улсын стандартад нийцсэн найдвартай саванд хадгалахаас бусад тохиолдолд бууг сумнаас тусад нь хадгалах ёстой. Мөн зүйлийн (2)-т зааснаар лицензийн шаардлагаас чөлөөлөгдөөгүй буу болон хориотой зэвсгийг дор хаяж DIN/EN 1143-1 стандарт, эсэргүүцлийн 0 зэрэглэл эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний саванд хадгална. Тухайлбал, VDMA-ын дагуу аюулгүй байдлын B зэрэглэлийн чингэлэг нь түүнтэй адилтгах ёстой. Арав хүртэлх урттай галт зэвсгийг VDMA¹⁷ 24992 стандартын дагуу аюулгүй байдлын A зэрэглэлийн саванд эсвэл EЗЗБ¹⁸-ын гишүүн өөр улсын түүнтэй адилтгах стандартын дагуу хадгалсан бол найдвартай хадгалсан гэж үзнэ.

Мөн зүйлийн (3)-т заасны дагуу зөвшөөрөл шаардлагатай зэвсэг, сум, хориотой зэвсэг эзэмшиж байгаа, эсхүл ийм эд зүйлийг эзэмших зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан этгээд тэдгээрийг найдвартай хадгалах талаарх нотлох баримтыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Эрх бүхий байгууллага тус галт зэвсэг хадгалж буй байгууллага руу нэвтрэх эрхтэй ба энэ нь Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх болох орон сууцны халдашгүй байдлыг хязгаарлах үндэслэл болдог.

Галт зэвсгийн тээвэрлэлт

Зэвсэг, сумын шилжүүлэх харилцааг Зэвсгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан байна. Тус хуулиар зохицуулсан нутаг дэвсгэрт зөвхөн лицензээр олж авах буюу эзэмшиж болох зэвсэг, сум хэрэгслийг шилжүүлэх тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд олгож болно. Үүнд:

- Хүлээн авагч нь дээрх зэвсэг, сумыг олж авах, эзэмших эрхтэй;
- Эдгээр зэвсэг, сум хэрэгслийг олж авах, эзэмших эрх бүхий этгээд тэдгээрийг аюулгүй тээвэрлэх баталгаа байгаа тохиолдолд.

Хэрэв Европын Холбооны өөр гишүүн улсаас буу, сумыг энэ хуулиар зохицуулсан нутаг дэвсгэрт шилжүүлэх гэж байгаа бол зэвсэг, сум хэрэгслийг шилжүүлэх тусгай зөвшөөрлийг нөгөө гишүүн улсын хууль тогтоомжийн дагуу олгоно.

Хуулийн 12 дугаар зүйлийн (1)1b-д заасны дагуу зэвсэг эзэмшигчийн үнэмлэх (Waffenbesitzkarte)-тэй этгээдээс зэвсгийг түр хугацаагаар тээвэрлэх, хадгалах зорилгоор авсан этгээд зэвсэг олж авах, эзэмших тусгай зөвшөөрөл шаардахгүй.

17 The German engineering federation VDMA (Verband Deutscher Maschinen- und Anlagenbau e. V.)

18 Европын эдийн засгийн бүс.

6.2. Оросын Холбооны Улс

Галт зэвсгийн тээвэрлэлт

ОХУ-д зэвсэг, сум, тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг хадгалах, тээвэрлэх талаар «ОХУ-ын нутаг дэвсгэрт иргэний болон албаны зэвсэг, тэдгээрийн сумны эргэлтийг зохицуулах арга хэмжээний тухай» тогтоол, «ОХУ-ын нутаг дэвсгэрт иргэний болон албаны зэвсэг, тэдгээрийн сумыг тээвэрлэх журам», «Иргэний болон албаны зэвсэг, тэдгээрийн сум хэрэгслийн улсын кадастрын хөтлөх, хэвлэн нийтлэх журам»-д галт зэвсгийг хадгалах болон тээвэрлэхэд тавигдах шаардлагын талаар дэлгэрэнгүй тусгажээ.

Тухайлбал, «ОХУ-ын нутаг дэвсгэрт иргэний болон албаны зэвсэг, тэдгээрийн сумны эргэлтийг зохицуулах арга хэмжээний тухай» Засгийн газрын баталсан журмын 8 дугаар бүлэг болон 11 дүгээр бүлэгт галт зэвсгийг тээвэрлэх, хадгалах стандарт, үйл ажиллагааны талаар тусгасан¹⁹ байна. Үүнд:

VIII бүлэг. Зэвсэг, сум хэрэгслийг тээвэрлэх

69 дүгээр зүйл. Хуулийн этгээдүүд нь зэвсгийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага болох ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба (Federal National Guard Service) эсвэл түүний нутаг дэвсгэрийн байгууллагаас тогтоосон журмын дагуу олгосон зөвшөөрлийн үндсэн дээр өөрт хамаарах зэвсэг, сум хэрэгслийг тээвэрлэх эрхтэй. Зэвсэг, сум тээвэрлэхдээ хуулийн этгээд дараах зүйлийг хийх шаардлагатай.

а) Зэвсэг, сумыг бүртгэх газар дахь ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба эсвэл түүний нутаг дэвсгэрийн байгууллагатай тээврийн чиглэл, төрлийг зохицуулах;

б) 20 гаруй нэгж галт зэвсэг, 20 мянга гаруй галт зэвсгийн сумыг галт зэвсгээр зэвсэглэсэн дор хаяж нэг харуул маршрутын дагуу дагалдаж байх ёстой.

Галт зэвсгээр зэвсэглэсэн харуул хамгаалалтгүйгээр спортын галт зэвсэг болон (эсвэл) түүнд зориулсан сумыг спорт, биеийн тамир, галт зэвсгийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага, тамирчид, дасгалжуулагчид болон бусад ажилчид тээвэрлэхийг зөвшөөрнө.

в) Зэвсгийг битүүмжилсэн анхны сав баглаа боодол эсхүл тусгай саванд тээвэрлэнэ.

Зэвсэг, сум ашиглахтай холбоотой спортын холбогдох төрлөөр үйл ажиллагаагаа явуулж буй спорт, боловсролын байгууллагууд нь зэвсэг, сумыг хадгалах зөвшөөрлийн хуулбарыг (шаардлагатай бол зэвсгийн бүртгэлийн дугаарын жагсаалтыг хавсаргасан), түүнчлэн бүс нутаг, Орос, олон улсын биеийн тамирын арга хэмжээ, спортын нэгдсэн хуанлийн төлөвлөгөөний хуулбар, ОХУ-ын аж ахуйн нэгжүүдийн биеийн тамирын арга хэмжээ, спортын арга хэмжээний хуанлийн төлөвлөгөө, хотын захиргаа, Оросын болон бүс нутгийн спортын холбоодын хуанлийн төлөвлөгөө, зэвсэг, сум тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай хуулийн этгээдийн даргын тушаал зэргийг зэвсгийн эргэлтийн үед авч явах шаардлагатай.

19 XIII. Transportation and transportation of weapons and ammunition, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_19504/560eecedfbf2c42fd907f741ace48148940b1c3d/, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

Хайрцаг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийг аюултай ачаа тээвэрлэх шаардлагын дагуу тоноглох. Тээвэрлэлтийн явцад зэвсэг нь сумнаас тусдаа, нэмэлт ачаагүй байх ёстой.

Зэвсэг, сумыг тээвэрлэхдээ тээврийн хэрэгсэл техникийн хувьд бүрэн бүтэн байх ёстой бөгөөд ачааг нүдээр харах, зөвшөөрөлгүй хүмүүсийг тээврийн хэрэгсэлд нэвтрэхийг хориглоно.

70 дугаар зүйл. Зэвсэг, сумыг хоёр ба түүнээс дээш тээврийн хэрэгслийн цуваагаар тээвэрлэх тохиолдолд тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, галт зэвсэгтэй, 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй баг хамгаалалтыг хангана.

71 дүгээр зүйл. Зэвсэг, сум тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд онгойх, савыг гэмтээх, лацыг хөндөгдсөн шинж тэмдэг илэрвэл ахлах зэвсэгт харуул энэ тухай дотоод хэргийн байгууллагад нэн даруй мэдээлж, акт гаргаж, хэргийн шалтгааныг тогтоох, хэргийн газрын хамгаалалтыг хангахад шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.

76 дугаар зүйл. Гаалийн бүсэд байгаа зэвсэг, сумыг тусгай чингэлэгт, эсхүл гаалийн байгууллага битүүмжилсэн тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Ийм зэвсэг, сумыг тээвэрлэх журмыг ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба, ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамтай тохиролцсоны дагуу Холбооны гаалийн алба тогтоодог.

77 дугаар зүйл. ОХУ-ын иргэд ОХУ-ын нутаг дэвсгэрээр 5 нэгжээс ихгүй хэмжээтэй, 1000 ширхгээс илүүгүй сумтай зэвсгийг зөвшөөрлийн үндсэн дээр тээвэрлэнэ.

XI бүлэг. Зэвсэг, сум хадгалах

54 дүгээр зүйл. Зэвсэг, сум хадгалахыг ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба, түүний нутаг дэвсгэрийн байгууллагаас зэвсэг хадгалах, ашиглах, авч явах зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүст зөвшөөрнө.

55 дугаар зүйл. Хуулийн этгээд нь ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба, түүний нутаг дэвсгэрийн байгууллагаас тогтоосон журмаар зэвсэг хадгалах, ашиглах зөвшөөрөл авсны дараа зэвсэг, сум хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, аюулгүй хадгалах, зөвшөөрөлгүй хүмүүс хэрэглэхээс сэргийлсэн нөхцөлд хадгалах үүрэгтэй.

Тэдэнд зориулсан зэвсэг, сумыг зэвсэг, сум хадгалах өрөөнд, цоожтой сейф эсвэл металл шүүгээнд (хайрцаг) хадгалах ёстой. Бусад эд хөрөнгийг зэвсэг, сумны хамт хадгалахыг хориглоно.

Зэвсгийг цэнэггүй, гохыг татан, хамгаалалтыг нээн (хэрэв байгаа бол) сумнаас тусад нь хадгална. Тусгай өрөөнд тавиур дээр зориулалтын байранд хадгална.

Зэвсгийн сургуулилт хийх үед буудлагын талбай, буудлагын талбайд зэвсгийг цоожтой сейф, төмөр шүүгээнд (хайрцаг) хийж түр хадгалахыг зөвшөөрнө.

Зэвсэг, сумыг үйлдвэрлэх явцад хадгалах журам, нөхцөлийг ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн албатай тохиролцсоны дагуу ОХУ-ын Үйлдвэр, худалдааны яам тогтоодог.

57 дугаар зүйл. ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба эсвэл түүний нутаг дэвсгэрийн байгууллагаас буудлагын байгууламжид зэвсэг хадгалах, ашиглах зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн шаардлагыг харгалзан тоноглогдсон байранд спортын галт зэвсэг, түүний дотор винтов сумтай, эсвэл 7.5 дж-аас дээш хошууны энергитэй, 4.5 мм-ээс дээш калибрын спорт пневматик зэвсэг, спортын иртэй зэвсэг, шидэлтийн зэвсэг, ан агнуурын зэвсгийг хадгалж болно.

58 дугаар зүйл. Зэвсэг, сум хадгалах байр, зэвсэг, сумыг үзвэрийн зорилгоор ашиглах, худалдаалах байр, буудлагын талбай, буудлагын талбайн доторх байгууламж болон нэвтрэлтэд хяналт тавих журмыг эрх бүхий байгууллагын дарга батална. Баталсан журмын дагуу зэвсэг, сумны хадгалалтын аюулгүй байдлыг хангах, түүнчлэн зөвшөөрөлгүй хүмүүс тэдгээрт нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ёстой.

Зэвсэг, сум хадгалах байр нь тогтоосон журмаар бүртгэгдсэн (дуусаагүй барилгын объектыг эс тооцвол) барилга, байгууламжид байрлана.

Зэвсэг, сум хадгалах байрны гадна ба дотоод хана, шал, тааз (цаашид бүтцийн элемент гэх) нь дараах шаардлагыг хангасан байх ёстой.

- Хамгийн багадаа 360 мм зузаантай чулуу эсвэл тоосго;
- 120 мм-ээс багагүй цул төмөр бетон эсвэл 200 мм-ээс багагүй зузаантай бетонон ханын блок;
- бетон блокууд нь 2 давхаргатай, тус бүр нь дор хаяж 90 миллиметр зузаантай;
- 120 мм-ээс багагүй зузаантай төмөр, бетон хавтан.

Сум, зэвсэг хадгалах байрыг тоосго, цул бетон, хөөсөн блок, төмөр, бетон хавтангаар хийж болох бөгөөд дотор талыг дор хаяж 16мм диаметртэй ган саваагаар 150х150мм хэмжээтэйгээр уулзвар бүрд нь гагнасан тороор доторлоно. Метал тороо суулгасны дараа гипс эсвэл бүрээстэй хавтангаар бүрхэж болно.

Зэвсэг сум хадгалах байр нь хаалганы зохион байгуулалтай байх ба гол болон нөөц (аваарын) хаалгатай (цаашид хаалганы байгууламж гэх) байна. Энэ нь өргөн нь хамгийн багадаа 100х100х5мм хэмжээтэй гадна доторгүй гагнасан ган хайрцагнуудаар хийгдсэн байна. Гаднах цул ган хаалга нь 3мм өргөн байна. Хаалганы гадуур тойруулж болон диагональдаж (хаалганы ирмэгээс 20 мм-ээс ихгүй зайд) хамгийн багадаа 50х50х3мм хэмжээтэй ган бэхэлгээгээр бэхэлнэ. Түүнчлэн, дор хаяж 16мм диаметртэй ган саваагаар 150х150мм хэмжээтэйгээр уулзвар бүрд нь гагнасан торон дотор хаалгатай байна.

Энэ тохиолдолд хаалганы завсар (дээр доороо) нь дотоод түгжих төхөөрөмжтэй байх ёстой. Мөн хаалганы систем суулгасан байж болно. Гаднах хаалга нь 2 далд цоожтой байх бөгөөд тэдгээрийн аль нэгийг эвдэх, түлхүүргүй онгойлгох гэж оролдох үед дохио өгөх “эрт хариу үйлдэл үзүүлэх” функцтэй байх ёстой.

Зэвсэг, сум хадгалах байрны гадна хаалгыг хууль тогтоомжид заасан тусгай үүрэг бүхий хуулийн этгээдийн ажилтнууд өдөр бүр зэвсэглэн хамгаалж байгаа тохиолдолд «эрт хариу үйлдэл үзүүлэх» функцгүй 2 цоожтой цоожоор тоноглохыг зөвшөөрнө.

Хаалганы хоёр талд түгжих төхөөрөмж байгаа тохиолдолд зөвхөн хаалганы бүтцэд суурилуулсан хаалганы байгууламжид цоож суурилуулахыг зөвшөөрнө.

Дотор талын хаалга (дотор талын торон хаалга) нь 1 цоожтой байна.

Түгжээ нь ОХУ-ын ГОСТ Р 52582-2006 «Хамгаалалтын байгууламжийн түгжээ, онгойлгох, хулгайд тэсвэртэй байх техникийн шаардлага, туршилтын арга»-ын үндэсний стандартын дагуу хамгийн багадаа U3 ангиллын хулгайд тэсвэртэй байх ёстой.

Зэвсэг, сум хадгалах өрөөний хананд эсвэл гадна цул ган хаалганд (эсвэл дотоод торон хаалганд) зэвсэг, сумыг хүлээн авах, гаргахын тулд 300x200 мм-ээс ихгүй хэмжээтэй, цоожоор тоногдсон, цонх суурилуулахыг зөвшөөрнө, үүнд хананд суурилуулахдаа 100x100x5мм-ээс багагүй хэмжээтэй хооронд нь гагнасан ган хүрээтэй (дотоод ба гадна) эсвэл дотоод хаалганд суурилуулсан бол 35x35x4мм хэмжээтэй ган хүрээтэй байна. Тус цонхнууд 16мм диаметртэй ган саваагаар 150x150мм хэмжээтэйгээр уулзвар бүрд нь гагнасан тороор буюу метал сараалжаар тоноглогдсон байна.

Агааржуулагч хоолой, яндан, технологийн суваг зэрэг 200 мм-ээс дээш диаметртэй (диагональ), зэвсэг, сум хадгалах байранд нэвтрэх боломжтой хоолойнуудыг техникийн аюулгүй байдлын үүднээс хамгийн багадаа 16 мм өргөнтэй ган саваагаар 50x50мм-ээс ихгүй хэмжээтэй зай гарган уулзвар бүрд гагнасан төмөр сараалжаар тоногдсон байна.

Зэвсэг, сум хадгалах байрыг тоноглоход ашигласан ган хоолой, ган төмрийн хэмжээг нь цувьсан металл үйлдвэрлэхэд тавигдах шаардлагыг харгалзан тодорхойлно.

Зэвсэг, сум хадгалах байрны бэхлэлт нь энэ журмын шаардлагад нийцсэн байх эсвэл энэ журмаар тогтоосон хэмжээнээс давсан техникийн үзүүлэлттэй байх ёстой.

Зэвсэг, сум хадгалах байр нь хамгаалалтын дохиоллоор тоноглогдсон байна. (Дор хаяж 2 ээлж).

Аюулгүй байдлын эхний дохиолол дараах байдлаар ажиллана:

- Цонх болон хаалганы байгууламжийн зөрчил, цонх хагарах зэрэгт
- Зэвсэг сум хадгалах байрны бүтэц, агааржуулалтын нүх, яндан, тус байрнаас гарсан 200мм-ээс дээш диаметртэй технологийн суваг болон бусад нүхийг эвдэх, цохих зэрэгт ажиллана.

Аюулгүй байдлын дохиоллын хоёр дахь дохиолол нь олон төрлийн физик зарчмууд, эзлэхүүн мэдрэгчийн тусламжтайгаар нэвтрэх үйлдэл, хөдөлгөөн дээр ажиллаж зэвсэг, сум хадгалах байрыг хамгаалдаг.

Зэвсэг сум хадгалах өрөөнүүд нь дохиоллыг цааш нь дамжуулахын тулд унтраах боломжгүй байхаар хийгдэх ба гар аргаар дохиоллыг асаах товчлууртай байна.

Хамгаалалт, дохиолол идэвхэжсэн тухай мэдээллийг шуурхай хүлээн авч, байнгын аюулгүй байдлыг хангах үүднээс бүх хамгаалалтын дохиоллын шугам, түүнчлэн зэвсэг, сум хадгалах байрны дохиоллын системийг ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн албаны хувийн хамгаалалтын төвлөрсөн хяналтын төвд холбосон байна. Зэвсгийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу тус байгууллагатай байгуулсан гэрээтэй хувь хүн, хуулийн этгээдийн дохиолол дугарсан үед зэвсэг сум хадгалах газрыг хамгаална.

Зэвсэг, сум хадгалах байрыг зөвхөн зэвсэг, сумны аюулгүй байдал, нягтлан бодох бүртгэлийг хариуцдаг хүмүүс, эсвэл зэвсэг, сум гаргаж, хүлээн авдаг ажилчид байх хугацаанд, эсвэл зэвсэг байхгүй тохиолдолд хамгаалалтаас хасдаг. (ажилчид санаандгүй дохиолол дуугаргасан)

Аюулгүй байдлын байгууллага (ОХУ-ын Үндэсний харуулын албаны хувийн хамгаалалтын ангиас бусад) дохиоллын системээс хүлээн авсан мэдээллийг «112» дугаарт дуудлага өгөн яаралтай тусламжийн системд хандана.

Хамгаалалтын дохиолол, дохиоллын систем нь үндсэн эх үүсвэрийн тэжээл унтарсан үед нөөц эх үүсвэрээс цахилгаан тэжээлд автоматаар шилжих, сэргээгдэх үед үндсэн эх үүсвэрээс цахилгаан тэжээлд автоматаар буцах шаардлагатай. Аюулгүй байдлын дохиолол ба дохиоллын систем нь нөөц эх үүсвэрээс 24 цагийн турш зогсолтын горимд, сэрүүлгийн горимд 2-оос доошгүй цагийн турш тасралтгүй ажиллах ёстой.

Зэвсэг, сум ашиглаж байгаа хуулийн этгээд хадгалах байрнаас гадна зэвсэг, сум ачих, буулгах газрыг давхар тоноглох ёстой.

Зэвсэг, сум хадгалах байр нь эдгээр дүрмийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлохдоо хот төлөвлөлтийн үйл ажиллагааны тухай ОХУ-ын хууль тогтоомжийн шаардлага хангасан тухайн үл хөдлөх хөрөнгийн техникийн баримт бичиг (техникийн төлөвлөгөө, техникийн бичиг баримтын (хэрэв байгаа бол) мэдээллийг харгалзан үзнэ.

Зэвсэг, сум хадгалах байрыг их засвар, сэргээн босгох, техникийн дахин тоноглох (хамгаалалтын дохиолол ба (эсвэл) дохиоллын системийг дахин тоноглохоос бусад) ажил эхлэхээс хуанлийн 10-аас доошгүй хоногийн өмнө ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба эсвэл түүний нутаг дэвсгэрийн байгууллагад төлөвлөсөн ажлынхаа талаар бичгээр мэдэгдэнэ.

59 дүгээр зүйл. ОХУ-ын иргэд зэвсэг, сум, түүнчлэн сумыг өөрөө цэнэглэх зориулалттай шатамхай бодис, материал (дарь, праймер) зэргийг цоожтой сейф, зэвсгийг хадгалах төмөр шүүгээ, өндөр бат бэх материалаар хийсэн хайрцаг, төмөр доторлогоотой модон хайрцаг зэрэгт тэдгээрийн аюулгүй байдал, хадгалалтын аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөлгүй хүн нэвтрэхийг хориглох нөхцөлийн дагуу оршин суугаа газартаа хадгална.

ОХУ-ын Үндэсний харуулын алба, түүний нутаг дэвсгэрийн байгууллага, зээмшигчийн оршин суугаа газар дахь дотоод хэргийн байгууллагууд бүртгэгдсэн зэвсгийн хадгалалтын нөхцөлийг шалгах эрхтэй.

Спортын буудлагын нийгэмлэг, клубийн гишүүн ОХУ-ын иргэд буудлагын бэлтгэл, тэмцээн болох газар дахь спортын буудлагын байгууламжид зэвсэг, сумаа хадгалж болно.

60 дугаар зүйл. Төрийн байгууллагын албан тушаалтан, төрийн хамгаалалтад байгаа хүмүүс, цэргийн албан хаагчид болон цэргийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагчид, түүнчлэн зэвсэглэлээр шагнагдсан хүмүүс энэ хуулийн 59 дүгээр зүйлд заасан журмаар зэвсэг, сумаа оршин суугаа газартаа хадгална.

Зэвсгээр шагнагдсан цэргийн албан хаагчид, цэргийн алба хаах, авч явахыг зөвшөөрсөн төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагын албан хаагчид шагналын зэвсэг, сумыг цэргийн алба хаасан газарт тогтоосон журмаар хадгалж болно.

61 дүгээр зүйл. Гадаадын иргэн ОХУ-д худалдаж авсан зэвсгийг ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн албанаас гаргасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 10 хоног хадгалахыг зөвшөөрнө.

Гадаадын иргэдийн ОХУ-д ан агнах, спортын арга хэмжээ, үзэсгэлэн, түүх, соёлын арга хэмжээнд оролцох зорилгоор импортолсон зэвсэг, сумыг түр хадгалахыг эдгээр иргэд аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд зөвшөөрнө.

VII. ГАЛТ ЗЭВСГИЙН ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ, БҮРТГЭЛ

7.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д галт зэвсгийг бүртгүүлэх замаар хяналт тавьдаг байна. Энэ талаар Зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйл (Зэвсэг олж авах, эзэмших, авч явах, буудах тусгай зөвшөөрөл), 23 дугаар зүйл (Зэвсгийн бүртгэл), 34 дүгээр зүйл (Зэвсэг, сумыг хүлээлгэн өгөх; олж авах эрхийг шалгах; тайлагнах шаардлага) зэрэгт тусгасан байна.

ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1(а) болон 2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зэвсэг олж авсан хүмүүс хоёр долоо хоногийн хугацаанд өөрийн овог нэр, хаяг, зэвсэг эзэмшигчийн үнэмлэхийг бичгээр мэдэгдэж, эрх бүхий байгууллагад танилцуулж, зэвсэг худалдан авсан тухайгаа бүртгүүлнэ. Бууг нэгээс олон хүн эзэмшиж байвал тэдгээрт зэвсэг эзэмших тусгай зөвшөөрөл олгоно. Зэвсэг эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн үнэмлэхийг мөн буудлагын клуб, ан агнуурын нийгэмлэг зэрэг хуулийн этгээд олгож болно. Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 7 (b)-д заасны дагуу буудлагын клубуудын бүс нутгийн холбоо нь харьяалагдах буудлагын клубуудыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч клубийн гишүүн тус бүрд галт зэвсэг эзэмших зөвшөөрөл анх олгосон өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хэр олон удаа буудсан тухай бүртгэл хөтлөх үүрэгтэй байна.

ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 23 дугаар зүйлд “зэвсгийн бүртгэл”-ийн талаар зохицуулсан байна. Тус зүйлд заасны дагуу арилжааны зорилгоор буу үйлдвэрлэдэг газрууд бууны төрөл, тоо хэмжээ, хаана байгааг тэмдэглэсэн зэвсгийн бүртгэл хөтөлнө. Мөн арилжааны зорилгоор буу олж авсан, бусдад худалдсан, хүлээлгэн өгсөн хэн бүхэн эдгээр бууны төрөл, тоо хэмжээ, гарал үүсэл, хаана байгааг тэмдэглэсэн зэвсгийн бүртгэл хөтөлнө.

ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Зэвсэг, сумыг хүлээлгэн өгөх; олж авах эрхийг шалгах; тайлагнах шаардлага”-ийн талаар зохицуулсан байна. Тус зүйлд заасны дагуу зэвсэг худалдаалах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь (Зэвсгийн тухай хуулийн 21(1) дүгээр зүйлд заасан) зэвсэг эзэмших тусгай зөвшөөрөл (Зэвсгийн тухай хуулийн 10(1) дүгээр зүйлд заасан)-ийн үндсэн дээр галт зэвсгийг бусдад хүлээлгэн өгсөн бол зэвсэг эзэмшигчийн лиценз дээр үйлдвэрлэгчийн тэмдэг, эсхүл барааны тэмдэг, зэвсгийн серийн дугаар, түүнчлэн хүлээлгэн өгсөн огноо, компанийн нэр, хаягийг тэмдэглэх ба хүлээлгэн өгсөн тухайгаа хоёр долоо хоногийн дотор эрх бүхий байгууллагад бичгээр мэдээлнэ.

ХБНГУ-ын статистик мэдээллийн нэгдсэн сангийн мэдээгээр ХБНГУ-д Хувийн эзэмшлийн галт зэвсэг, эд ангиудыг NWR²⁰-ийн дагуу 2023 оны байдлаар 5.48 сая галт зэвсэг бүртгэлтэй байна.

7.2. Оросын Холбооны Улс

ОХУ нь галт зэвсгийн хяналт, татвар болон хураамж, зэвсгийн бүртгэлийн талаар ОХУ-ын Зэвсгийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 25 дугаар зүйл, 28 дугаар зүйлд тусгасан ба зэвсгийн бүртгэлийн талаар дэлгэрэнгүй “ОХУ-ын нутаг дэвсгэрт

20 National Weapons Register буюу Үндэсний зэвсгийн бүртгэл.

иргэний болон албаны зэвсэг, тэдгээрийн сумыг эргэлтэд оруулах журам”-аар зохицуулжээ.

Галт зэвсгийн эргэлтэд тавих хяналт

ОХУ-ын Зэвсгийн тухай хуулийн 28 дугаар зүйлд²¹ зааснаар үйлчилгээний зэвсгийн эргэлтийг хянах ажлыг ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмаар гүйцэтгэдэг.

Зэвсгийн эргэлтэд холбооны улсын хяналтыг хэрэгжүүлэх журмыг зэвсгийн эргэлтийн чиглэлээр эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллага тогтоодог.

Иргэний болон албаны зэвсгийн эргэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллагын албан тушаалтан дараах эрхтэй. Үүнд:

1. Зэвсгийг үйлдвэрлэх, худалдаалах, хадгалах, устгах, авч явах, ашиглах, турших газар, түүнчлэн түүний эргэлтийг хянах эрх бүхий байгууллагын албан тасалгааны байранд шалгах;
2. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олж авсан, эзэмшигчийн хууль ёсны эзэмшилд байгаа зэвсгээс бусад ОХУ-ын нутаг дэвсгэрт эргэлтэд оруулахыг хориглосон зэвсгийг тогтоосон журмын дагуу хурааж, устгах;
3. Хуулийн этгээд, иргэнээс хяналтын чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай зэвсэг, баримт бичиг үзүүлэхийг шаардах;
4. Тогтоосон журмын зөрчил илэрсэн тохиолдолд эдгээр зөрчлийг арилгах талаар ОХУ-ын иргэд, албан тушаалтнуудад заавал биелүүлэх тушаал гаргах;
5. Энэ хуульд заасны дагуу олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, зэвсэг, сум хэрэгслийг албадан хураах, зөвшөөрөл, зэвсэг, сумыг хураах талаар шүүхэд өргөдөл гаргах. Түүнчлэн, ОХУ-ын хууль тогтоомжид заасан бусад арга хэмжээг авах.

Зэвсэг, түүнд зориулсан сум хураах, зэвсэг олж авах, хадгалах, хадгалах, авч явах, хадгалах, ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болсон нөхцөл байдлын талаар мэдээлэлтэй хуулийн этгээд, иргэн. Зэвсэг, сумны тухайд эдгээр мэдээллийг зэвсгийн эргэлтэд холбооны улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тэдний хүсэлтээр өгөх үүрэгтэй.

Зэвсгийн эргэлтэд хяналт тавьдаг байгууллагын албан тушаалтнуудын хууль ёсны шаардлагыг ийм шаардлага авсан хуулийн этгээд, хувь хүмүүс заавал биелүүлэх ёстой.

Зэвсгийн эргэлтэд хяналт тавьдаг байгууллагын албан тушаалтнуудын хууль ёсны шаардлагыг дагаж мөрдөхгүй байх, эдгээр хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой тэдний хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах нь зэрэг үйлдэлд

21 Статъя 28. Контроль за оборотом оружия, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_12679/a6f2aa09cb1e2cec0485a71553633dd5c879b9aa/, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

ОХУ-ын захиргааны зөрчлийн тухай хуулийн 19.4 дүгээр зүйлд²² заасан хариуцлага хүлээлгэнэ.

Зэвсгийн эргэлтэд тавих хяналтын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэдэг.

1. Тэдэнд зэвсэг эзэмших эрх олгох, эрхийг нь хасах үндэслэлийг тогтоох зорилгоор хүмүүсийг шалгах;
2. Зэвсэг эзэмшигчдийн зэвсгийн наймааны чиглэлээр ОХУ-ын хууль тогтоомжийг дагаж мөрдөж буй байдлын үнэлгээ;
3. Зэвсэг эзэмшигчдэд зэвсэг эзэмших эрхийг олгосон баримт бичгийн хүчинтэй байдал, эдгээр баримт бичиг нь зэвсгийн талаарх бодит мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхийг шалгаж, тэдэнд олгосон эзэмших эрхийг баталгаажуулах;
4. Зэвсгийн эргэлтийн чиглэлээр ОХУ-ын хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд зэвсэг, сум хэрэгслийг шалгах;
5. Зэвсгийн эргэлтийг явуулж байгаа эсвэл зэвсгийн эргэлт хийхээр төлөвлөж буй газрууд нь зэвсгийн наймааны чиглэлээр ОХУ-ын хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах;
6. Зэвсэг эзэмших эрх олгосон хүмүүс, түүнчлэн ийм эрх авахаар хүсэлт гаргасан хүмүүсийг мэдээллийн систем ашиглан бүртгэх;
7. Зэвсэг, тэдгээрийн сум хэрэгслийг бүртгэх;
8. Зэвсгийн наймааны чиглэлээр ОХУ-ын хууль тогтоомжид заасан тохиолдолд зэвсэг, тэдгээрийн сум, түүнчлэн зэвсэг эзэмших эрхийг олгосон баримт бичгийг хураах ;
9. Зэвсэг эзэмших эрхийг олгосон баримт бичгийг хүчингүй болгох;
10. Зэвсгийн наймаатай холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;
11. Эрх мэдлийн хүрээнд зэвсгийн наймааны чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг олгосон баримт бичиг (энэ хуульд заасан төрийн үйлчилгээ үзүүлэх хүрээнд олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлөөс бусад) олгох.

Зэвсгийн эргэлтэд тавих хяналтын арга хэмжээг албан тушаалтан ийм хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад харьяалагддаг болохыг баталгаажуулсан албан ёсны баримт бичгийг танилцуулсны үндсэн дээр гүйцэтгэдэг.

Зэвсгийн эргэлтэд тавих хяналтын хүрээнд шалгалт хийх төлөвлөгөө боловсруулагдаагүй, бүртгэлийг хөтөлдөггүй. Зэвсгийн эргэлтэд тавих хяналт арга хэмжээ авахын тулд зэвсгийн эргэлтэд хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын захиргааны баримт бичгийг нийтлэх шаардлагагүй.

Зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байгууллага, дотоод хэргийн байгууллагуудын зэвсгийн

22 ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хууль 19.4 дүгээр зүйл. Төрийн хяналт (хяналт) эрхэлдэг байгууллагын албан тушаалтан, холбооны хууль тогтоомжийн дагуу төрийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, хотын хяналтыг хэрэгжүүлдэг байгууллагын албан тушаалтны хууль ёсны тушаалыг дагаж мөрдөхгүй байх, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/0dd0f5ea5fc103d05b56af9b614e8387081cba79/#dst9617, Сүүлд үзсэн огноо: 2023.12.19.

наймааны чиглэлээр тэдний эрх мэдэлд хамаарах асуудлаар хамтран ажиллах журмыг тогтоодог ба дотоод хэргийн салбарт төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх.

Галт зэвсгийн татвар, хураамж

ОХУ-д галт зэвсэг эзэмших, ашиглах, худалдан авах зэрэгт тодорхой төрлийн татвар ногдуулдаг. Тухайлбал, галт зэвсэг, суманд онцгой албан татвар ногдуулдаг бөгөөд түүнийг үйлдвэрлэх, импортлох цэгт нь ногдуулдаг. Энэ татварыг ихэвчлэн галт зэвсэг, сумны төрөл, түүний шинж чанарт үндэслэн тооцдог. ОХУ-ын ихэнх бараа, үйлчилгээний нэгэн адил галт зэвсэг болон дагалдах хэрэгсэлд НӨАТ ногдуулдаг. НӨАТ нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, түгээлтийн үе шат бүрд үнэд нэмдэг хэрэглээний татвар юм. Хэрэв ОХУ-д галт зэвсэг, эд ангиудыг импортлох бол импортын татвар ногдуулдаг. Эдгээр татварыг импортын барааны үнэд үндэслэн тооцдог бөгөөд дотоодын үйлдвэрүүдийг хамгаалах, төрд орлого бүрдүүлэх зорилготой. Мөн татвараас гадна галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах, түгээх ажилд оролцож буй хувь хүн, аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Эдгээр лицензүүд нь ихэвчлэн хураамж эсвэл захиргааны төлбөртэй байдаг. Эдгээр татвартай холбоотой тодорхой хувь хэмжээ, зохицуулалт нь галт зэвсгийн төрөл, калибрын хэмжээ, зориулалт зэрэг хүчин зүйлээс хамаарч өөр өөр байж болно.

ОХУ-ын Зэвсгийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зэвсгийн наймааны чиглэлээр эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллага нь ОХУ-ын татвар, хураамжийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмаар зэвсгийн наймааны чиглэлээр хууль ёсны ач холбогдолтой үйл ажиллагаа явуулахад улсын татвар авдаг.²³ Мөн зөвшөөрөл (зэвсэг эзэмших), тусгай зөвшөөрөл (зэвсэг худалдаалах) авах үед иргэн дараах байдлаар хураамж төлнө:

- Тусгай зөвшөөрлийг өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор олгоно (2 хоногийн дотор бүртгүүлэх), хураамж нь 2000 рубль байна.
- Зөвшөөрлийг өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дараа олгоно (2 хоногийн дотор бүртгүүлэх), хураамж нь 500 рубль байна²⁴.

Галт зэвсгийг бүртгэх

“ОХУ-ын нутаг дэвсгэрт иргэний болон албаны зэвсэг, тэдгээрийн сумыг эргэлтэд оруулах журам”-ын 10 дугаар бүлэгт галт зэвсгийг бүртгэх талаар тусгажээ.

Зэвсэг, сумны бүртгэл²⁵

49 дүгээр зүйл. Улсын цэрэгжүүлсэн байгууллага (State paramilitary organizations) нь иргэний болон албаны зэвсэг, сумны бүртгэлийг холбогдох төрийн цэрэгжүүлсэн байгууллагын тогтоосон жагсаалт, хэлбэр, хөтлөх журмыг үндэслэн хөтлөх үүрэгтэй.

23 23 дугаар зүйл. Зэвсгийн наймааны чиглэлээр хууль зүйн ач холбогдол бүхий үйлдлээс авах улсын хураамж, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_12679/4b70c00e85160308fd5a9d5580f07c5e8b6b88d3/, Сүүлд үзсэн огноо: 2023.12.19.

24 Сроки оформления разрешения и госпошлина, Холбоос: <https://custom-guns.ru/blog/post/76-kak-poluchit-razreshenie-na-oruzhie-v-2023-godu.html#Yakor3>, Сүүлд үзсэн огноо: 2023.12.19.

25 Accounting for weapons and ammunition, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_19504/897bef29e5d26a6211716c4285980d2232549746/?fbclid=IwAR3Fb1GpQ2aFNIWqM_Pb1ark-Kyu8Bsl6lqcgQ9eK8Tted3icH1MufShyk, Сүүлд үзсэн огноо: 2023.12.19.

50 дугаар зүйл. Хуулийн этгээд, хувь хүмүүсийн эзэмшиж буй зэвсэг, сумыг төрөл, загвар, авсан эх сурвалжаас үл ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба, түүний нутаг дэвсгэрийн байгууллагад бүртгүүлэх ёстой.

51 нэгдүгээр зүйл. ОХУ-ын Зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-7 дугаар зүйлд заасан зэвсэг худалдан авах эрхтэй субъектүүд, тэдгээрийн зэвсэг, сумыг судлах, боловсруулах, турших, үйлдвэрлэх, уран сайхны аргаар боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүд хууль тогтоомжид заасан даалгавруудыг биелүүлэх, энэ журам, эрх бүхий байгууллагуудын эрх зүйн актуудын үндсэн дээр сум эсэргүүцэх чадварыг турших, зэвсэг, сумны бүртгэл тооцоо хийх, тэдгээрийн аюулгүй байдал, аюулгүй хадгалалт, ашиглалтыг хянана.

Үүний зэрэгцээ зэвсэг үйлдвэрлэгчид үйлдвэрлэсэн иргэний болон үйлчилгээний зэвсгийн талаарх мэдээллийг улсын үйлдвэрлэлийн мэдээллийн системд оруулж баталгаажуулах ёстой.

52 дугаар зүйл. Бүртгэлд хамрагдаагүй зэвсгээс бусад ОХУ-ын хуулийн этгээд, иргэдийн худалдаж авсан зэвсэг, сум болон тэтгэвэрт гарсан цэргийн албан хаагчид, төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагын ажилтнуудад тогтоосон журмаар шилжүүлсэн, төрийн байгууллагын албан тушаалтан, хүмүүст олгосон зэвсэг, сумыг төрийн хамгаалалтад хамрагдах, хандивлах, өв залгамжлалын үр дүнд хүлээн авсан зэрэг зэвсгүүдийг 2 долоо хоногийн дотор ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн алба, түүний нутаг дэвсгэрийн байгууллагад бүртгүүлэх ёстой.

53. Зэвсэг, сумны бүртгэлийг хөтлөхдөө ОХУ-ын Үндэсний харуулын цэргийн албаны тогтоосон шаардлагын дагуу автоматжуулсан нягтлан бодох бүртгэлийн цахим хэрэгслийг ашиглаж болно.

Үүнээс үзэхэд, ОХУ-ын иргэн хууль ёсоор олж авсан зэвсэг, сум, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг эрх бүхий байгууллагад мэдэгдэж, 14 хоногийн дотор бүртгүүлэх ёстой. Хугацаа хэтэрвэл хууль бусаар зэвсэг эзэмшсэн гэж үзэж зэвсгийг хураах зэрэг арга хэмжээ авах боломжтой.

VIII. ГАЛТ ЗЭВСГИЙН СУРГАЛТ

8.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д галт зэвсэг эзэмших, ашиглахын тулд Зэвсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан “тусгай мэдлэг”-ийг эзэмших шаардлагатай байдаг. Тус зүйл заалтад заасны дагуу томилогдсон байгууллагад мэргэжлийн шалгалт өгсөн, эсвэл буудлагын сургалт (клуб)-д хамрагдсан хүмүүсийг тусгай мэдлэгээ нотолсон гэж үзнэ.

Схем 9.3. Тусгай мэдлэгээ нотлох шаардлага



Буудлагын сургалт (клуб): Буудлагын сургалтын талаар ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд зохицуулсан байдаг. Буудлагын клубийн бүс нутгийн хороо нь 1000 доошгүй буюгаар бууддаг буудлагын гишүүнчлэлтэй, хүүхэд, залуучуудын насны онцлогт тохируулан буудлагын спортоор хичээллэх зохих бэлтгэлийг хангасан, бүс хоорондын тэмцээн тогтмол зохион байгуулахаас гадна батлагдсан буудлагын журмын үндсэн дээр клубүүдийн спортын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй байна. Мөн зэвсэг эзэмших үнэмлэх авсан этгээд буудлагын клубээс гармагц түүнийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Мэргэжлийн шалгалт: Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн буудлагын холбоод тус шалгалтыг²⁶ болон мэргэжлийн сургалтыг хийх боломжтой. Мэргэжлийн сургалт нь онол, практик гэсэн 2 хэсгээс бүрдэх ба дунджаар 4 хоног, өдрийн 8 цаг үргэлжилнэ. Төлбөрийн хувьд 320 €²⁷ (2024 оны 2 дугаар сарын байдлаар) байна. Зэвсэг эзэмших болон ашиглахад шаардлагатай техникийн болон хууль эрх зүйн мэдлэг, шалгалт, шалгалтын журам, түүний дотор шалгалтын хороо байгуулах зэрэг бусад хууль эрх зүйн баримт бичгийг Холбооны Дотоод хэргийн яам нь Холбооны зөвлөл (Bundesrat)-ийн зөвшөөрлөөр гаргах эрхтэй.²⁸ ХБНГУ-ын Зэвсгийн тухай хуулийн 22 (2)-т заасны дагуу дараах хууль зүйн баримт бичгийг Холбооны Дотоод хэргийн яам нь Холбооны зөвлөл (Bundesrat)-ийн зөвшөөрлөөр гаргах эрхтэй байна. Үүнд:

1. Зэвсгийн талаар шаардлагатай техникийн болон хууль эрх зүйн мэдлэг, түүний дотор тодорхой төрлийн зэвсэг, сум хэрэгслийн талаарх мэдлэг (тусгай мэдлэг);

26 Deutsche Welle (DW), ХБНГУ-ын олон улсын нэвтрүүлэг, ХБНГУ дахь бууны хяналт, галт зэвсэг эзэмших, нийтлэгдсэн: 2020.02.20, шинэчлэгдсэн: 2022.12.12, Холбоос: <https://www.dw.com/en/gun-control-and-firearms-possession-in-germany/a-52450664>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.23.

27 ХБНГУ-д үйл ажиллагаа явуулдаг сургалтын академи, Холбоос: <https://pond-academy.com/en/kursangebot/kurzaffenkurs-basic/>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.23.

28 Waffengesetz (WaffG) 2002, Sektion 7 (2), Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039, Сүүлд үзсэн огноо: 2024.02.22.

2. Шалгалт, шалгалтын журам, үүнд шалгалтын комисс байгуулах,
3. Мэргэжлийн үйл ажиллагаа (арилжааны) эрхлэх этгээдийн төрөл, цар хүрээ, шаардлага.

8.2. Оросын Холбооны Улс

21 нас хүрсэн ОХУ-ын иргэн ан агнуурын болон спортын галт зэвсэг, өөрийгөө хамгаалах зэвсэг худалдан авч эзэмшихийн тулд заавал анхан шатны сургалтад сууж гэрчилгээ авсан байх ёстой. Галт зэвсгийн аюулгүй байдлын сургалтад иргэний галт зэвсэг, хийн гар буу, буу, ан агнуурын буу зэргийг анх удаа авах гэж буй 21 нас хүрсэн ОХУ-ын иргэн хамрагдана.

21 нас хүрээгүй буюу 18 нас хүрсэн ОХУ-ын цэргийн албан хаагч, цэргийн алба хаасан этгээд, бусад хууль сахиулах байгууллагад ажилладаг этгээд зэвсэг эзэмших зөвшөөрөл авч болно.²⁹

Зэвсгийн зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна³⁰. Үүнд:

- ROHA - зэвсэг хадгалах, авч явах зөвшөөрөл;
- RSOa - биеийг хамгаалах зорилгоор урт хошуутай гөлгөр нүхтэй галт зэвсгийг биедээ авч явах эрхгүйгээр хадгалах зөвшөөрөл;
- RKСа - богино хошуутай гэмтлийн галт зэвсгийг хадгалах, авч явах зөвшөөрөл

Зэвсэг эзэмших зөвшөөрлийг авахад заавал биелүүлэх шаардлага.

- Зөвхөн ОХУ-ын иргэдэд дараах байдлаар олгоно. Үүнд:³¹
- Байнгын оршин суух газартай;
- 21 насанд хүрсэн;
- Санаатай гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдоогүй;
- Санаатай хүнд, онц хүнд гэмт хэрэг, түүнчлэн зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэрч дэлбэрэх хэрэгсэл, хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодис, хүчтэй, хортой, цацраг идэвхт бодис хэрэглэсэн, дунд хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон, ялгүй байх;
- Хууль бус зэвсгийн наймаанд оролцоогүй;
- Терроризм, экстремизм, түүний дотор суртал ухуулга дэмжсэн хэргээр эрүүгийн хэрэг үүсгээгүй;
- Насанд хүрээгүй хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдээгүй;
- Хоёр ба түүнээс дээш хүнд хэлбэрийн ялгүй байх;
- Захиргааны хариуцлага хүлээлгээгүй;
- Нийтийн хэв журам зөрчсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг

29 Кто обучается безопасному обращению с оружием, Холбоос: https://www.gosuslugi.ru/help/faq/rifled_weapon_license/3101210, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

30 Виды разрешений на оружие, Холбоос: https://www.gosuslugi.ru/help/faq/weapon_permit/101559, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

31 Обязательные требования для лицензии на огнестрельное оружие ограниченного поражения, Холбоос: https://www.gosuslugi.ru/help/faq/license_for_weapons_of_limited_destruction/200130, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

хууль бусаар ашигласан, тээвэрлэсэн хэргээр нэг жилийн дотор удаа дараа эрүүгийн хэрэг үүсгээгүй;

- Сэтгэцийн эмгэг, архидалт, мансууруулах бодисын донтолтын улмаас эмнэлгийн байгууллагад бүртгэгдээгүй;
- Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгсөн.

Галт зэвсгийн аюулгүй байдлын сургалт

Хэрэв анх удаа галт зэвсэг эзэмших зөвшөөрөл авах гэж байгаа бол галт зэвсгийн аюулгүй байдлын сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй сургалтын төвд хандан ОХУ-ын Зэвсгийн тухай хууль, боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй мэргэшсэн багш нараар зэвсэгтэй харьцах дүрмийг сурах ба сургалтад бүрэн хамрагдсанаар зэвсэгтэй хэрхэн зөв, аюулгүй харьцах талаар анхан шатны мэдлэг олох боломжтой.

Уг сургалтад лекц, практик хосолсон нийт 6 кредит цаг цуглуулах ёстой ба үүний дараа сургалтад амжилттай оролцсон этгээдэд гэрчилгээ олгогдоно.³² Ингэснээр ОХУ-ын иргэн галт зэвсэг эзэмших зөвшөөрөл хүсэх эрхтэй болно.

32 Обучение граждан обращению с оружием, Холбоос: <https://mgssk.ru/obuchenie-grazhdan-rf/>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

IX. ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

9.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын зэвсэг ашиглахтай холбоотой хариуцлагын тогтолцоог “Зэвсгийн тухай хууль”-ийн 4 дүгээр бүлэг (Шийтгэл, торгууль) буюу 51-54 дүгээр зүйлд зохицуулсан байна. Үүнээс үзвэл, хариуцлагын тогтолцоо нь хорих ял, торгууль, зэвсгийг буцаан хураан авах гэсэн хэлбэртэй байна.

Хүснэгт 9.4. Торгуулийн хүснэгт: Хууль бус зэвсэг эзэмшсэн тохиолдолд оногдуулах шийтгэл³³

Зөрчил	Санкц
1. Зөвшөөрөл шаарддаггүй бага оврын галт зэвсгийг зөвшөөрөлгүйгээр авч явсан (жишээ нь хийн буу)	10,000 евро хүртэл торгууль ногдуулна.
2. Зэвсгийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 1 дүгээр хэсгийн 1.3.6-т заасан хориотой зэвсэг, төхөөрөмж биед авч явсан	10,000 евро хүртэл торгууль ногдуулна.
3. Галт зэвсэг, хориглосон зэвсгийг зөвшөөрөлгүйгээр <u>байнга/ хүндэвтэр тохиолдолд/ онц хүнд тохиолдол олж/ хайхрамжгүй үйлдлээс болж</u> авсан, эзэмшсэн, хүлээлгэн өгсөн, авч явсан, зарцуулсан, авч явсан, үйлдвэрлэсэн, засварласан, боловсруулсан, худалдаалсан бол дараах санкцтай байна.	
- байнга	1-5 жил хүртэлх хорих ял ногдуулна.
- хүндэвтэр тохиолдол	Торгууль, эсвэл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулна.
- онц хүнд тохиолдол	1-5 жил хүртэлх хорих ял ногдуулна.
- санаатайгаар эсвэл хайхрамжгүй хандсан	Захиргааны зөрчил гаргасанд тооцож 10,000 евро хүртэл торгууль ногдуулна.
4. Дээр заасан хорих ялаар шийтгүүлсэн гэмт хэрэг үйлдсэн бол гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд бэлдсэн, төлөвлөсөн	бол холбогдох зэвсгийг хураан авна.
5. Захиргааны зөрчил гаргасан бол	бол холбогдох зэвсгийг хураан авна.

Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсгийг хураан авах хариуцлагын хэлбэрийг ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 74а дугаар зүйлд мөн заасан байдаг. Тус хуульд заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оролцогчоос гэмт хэргийн улмаас бий болсон зүйл, гэмт хэргийн хэрэгсэл болон гэмт хэргийн объектыг бусад этгээдээс хураан авах ба шийдвэр гарах үед эд зүйлд бусад этгээдийн эзэмшилд буюу бусад этгээдийн эзэмших эрхтэй байгаа тохиолдолд дараах зүйлийг тус хуульд зааснаар хураан авч болно. Үүнд:

- Болгоомжгүй байдлын улмаас тухайн эд зүйл нь гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдсан эсвэл гэмт хэргийн объект болсон, эсвэл
- Хураан авах тухай мэдэж байсан ч тухайн эд зүйлийг зүй бусаар олж авсан.³⁴

ХБНГУ-д “Зэвсгийн тухай хууль”-д зэвсэг эзэмших, ашиглахад хатуу хязгаарлалт тавьдаг. Ялангуяа галт зэвсэг эзэмшигчдэд тавих шаардлага маш өндөр байдаг. Тиймээс хууль бусаар зэвсэг эзэмших нь хүнд гэмт хэрэгт тооцогддог.

33 ХБНГУ-ын Зэвсгийн тухай хууль.

34 ХБНГУ-ын Эрүүгийн хууль §74а.

9.2. Оросын Холбооны Улс

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 222 дугаар зүйл. Зэвсэг, галт зэвсгийн үндсэн хэсэг, сум, эд ангийг хууль бусаар олж авах, шилжүүлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх. (2021 оны 7 дугаар сард өөрчлөлт орсон)

Галт зэвсэг, түүний бүрдэл хэсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис буюу дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, хадгалсан, тээвэрлэсэн буюу авч явсан бол гурвал жил хүртэл эрх чөлөөг хязгаарлах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох буюу торгохгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Галт зэвсэг, түүний үндсэн эд анги, сум (том калибрын галт зэвсэг, түүний үндсэн эд анги, сум, иргэний гөлгөр голтой урт хошуут зэвсэг, тэдгээрийн үндсэн хэсэг, сум, алах хязгаарлагдмал галт зэвсгээс бусад) хууль бусаар худалдсан бол нэг зуун мянга хүртэл рубль, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хэрэгтний цалин, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг:

- а) бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож;
- б) албан тушаалын байдлаа ашигласан этгээд;
- в) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт ашигласан бол нэг зуун мянгаас хоёр зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол гурван зуун мянгаас таван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл нэг жилээс арван найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг:

- а) бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож;
- б) албан тушаалын байдлаа ашигласан этгээд;
- в) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт ашигласан бол гурван зуун мянгаас таван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл нэг жилээс арван найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

6.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таван зуун мянгаас найман зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

7. Иргэний гөлгөр голтой урт сумтай галт зэвсэг, тэдгээрийн үндсэн эд анги, сум, алах хязгаарлагдмал зориулалттай галт зэвсэг, тэдгээрийн үндсэн эд анги, сум, хийн зэвсэг, 7.5 дж-аас дээш хошууны энергитэй пневматик зэвсэг, иртэй зэвсэг буюу шидэлтийн зэвсэг (механик шүршигч, аэрозоль болон нулимс болон цочроох бодис агуулсан бусад төхөөрөмжөөс бусад)-ыг хууль бусаар худалдсан бол дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг

жилээс хоёр жил хүртэл хугацаагаар засаж залруулах ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах ял шийтгэнэ.

Тайлбар:

1. Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураар хүлээлгэн өгсөн этгээд энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө. Хүнийг цагдан хорих, түүнчлэн шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах явцад хураан авсан нь энэ зүйл, түүнчлэн энэ хуулийн 222.1, 222.2, 223, 223.1-д заасан зүйлийг сайн дураар хүлээлгэн өгсөн гэж үзэхгүй.

2. Энэ зүйл болон энэ хуулийн бусад зүйлд зааснаар нунтаг болон бусад цэнэгийн энергийн нөлөөгөөр шидэгдсэн хэрэглүүр чиглүүлэн хөдөлж байгаа байг алсаас механикаар устгах зориулалттай зэвсгийг галт зэвсэг гэж ойлгоно.

3. Энэ зүйл болон энэ хуулийн бусад зүйлд заасны дагуу сум гэж үйлдвэрийн аргаар эсвэл гар хийцийн аргаар үйлдвэрлэдэг, байг онох зориулалттай, калибрын харгалзахгүй тэсрэх, хөдөлгөх, пиротехникийн болон хөөргөх цэнэг, эсхүл тэдгээрийн хослолыг агуулсан зэвсэг, сум, сумны хэрэгслийг ойлгоно.

222.1 дүгээр зүйл. Тэсрэх бодис, тэсрэх төхөөрөмжийг хууль бусаар олж авах, шилжүүлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх буюу авч явах.

1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хууль бусаар олж авах, шилжүүлэх, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, тээвэрлэсэн бол нэг зуун мянган рубль хүртэлх хэмжээгээр торгож, зургаан жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих эсхүл хэрэгтний зургаан сар хүртэл хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгох.

2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хууль бусаар худалдсан бол нэг зуун мянгаас хоёр зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, найман жилээс арван нэгэн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл хэрэгтний зургаан сараас нэг жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасныг:

а) бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож;

б) албан тушаалын байдлаа ашигласан этгээд;

в) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт ашиглаж үйлдсэн бол гурван зуун мянгаас таван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож, найман жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл эсхүл хэрэгтний нэг жилээс арван найман сар хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таван зуун мянгаас найман зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, арван жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хэрэгтний хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгоно.

5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг:

а) бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож;

б) албан тушаалын байдлаа ашигласан этгээд;

в) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт ашиглаж үйлдсэн бол таван зуун мянгаас найман зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, арваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хэрэгтний хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгоно.

6.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таван зуун мянгаас нэг сая рубль хүртэл хэмжээгээр торгож, арван таваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл ял шийтгүүлсэн этгээдийн хоёр жилээс дөрвөн жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

Тайлбар:

1. Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураар хүлээлгэн өгсөн этгээд энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

2. Энэ зүйл болон энэ хуулийн бусад зүйлд тэсрэх бодис гэж гаднын нөлөөн дор хурдан химийн урвал (дэлбэрэлт) үүсэх чадвартай химийн нэгдлүүд буюу бодисын хольцыг ойлгоно.

3. Энэ зүйл болон энэ хуулийн бусад зүйлд тэсрэх бодис гэж тэсрэх бодис агуулсан, үйл ажиллагааны хувьд тэсрэх зориулалттай, тэсрэх чадвартай үйлдвэрийн болон гар аргаар хийсэн бүтээгдэхүүнийг ойлгоно.

222.2 дугаар зүйл “Том калибрын галт зэвсэг, түүний үндсэн эд анги, сумыг хууль бусаар олж авах, шилжүүлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх, илгээх, авч явах”

1.Их калибрын галт зэвсэг, түүний үндсэн эд анги, сумыг хууль бусаар олж авах, шилжүүлэх, хадгалах, тээвэрлэх, илгээх, авч явсан бол таван жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ эсхүл гурван жилээс зургаан жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэж, хоёр зуун мянган рубль хүртэл торгоно эсхүл хэрэгтний нэг жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

2. Том калибрын галт зэвсэг, түүний үндсэн эд анги, сумыг хууль бусаар худалдсан бол хоёр зуун мянгаас гурван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож долоогоос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл хэрэгтний зургаан сараас нэг жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг:

а) бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож;

б) албан тушаалын байдлаа ашигласан этгээд;

в) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт ашиглаж үйлдсэн бол гурван зуун мянгаас таван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож найман жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл хэрэгтний нэг жилээс арван найман сар хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таван зуун мянгаас найман зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож арваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн хүний хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгоно.

5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг:

а) бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож;

б) албан тушаалын байдлаа ашигласан этгээд;

в) мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт ашиглаж үйлдсэн бол таван зуун мянгаас найман зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож арваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн хүний хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгоно.

6.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таван зуун мянгаас нэг сая рубль хүртэл хэмжээгээр торгож арван хоёр жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл хэрэгтний хоёр жилээс дөрвөн жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

Тайлбар.

1.Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураар хүлээлгэн өгсөн этгээд энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

2.Энэ зүйл болон энэ хуулийн бусад зүйлд 20 мм ба түүнээс дээш калибрын галт зэвсгийг (иргэний болон албаны галт зэвсгээс бусад) том калибрын галт зэвсэг гэж ойлгоно.

223 дугаар зүйл. Хууль бусаар зэвсэг үйлдвэрлэх

1.Галт зэвсэг, түүний үндсэн эд анги (хязгаарлагдмал устгах зориулалттай галт зэвсгээс бусад) хууль бусаар үйлдвэрлэх, өөрчлөх, засварлах, түүнчлэн галт зэвсгийн сумыг хууль бусаар үйлдсэн бол нэг зуун мянгаас хоёр зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож дөрвөөс зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл хэрэгтний зургаан сараас нэг жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

2.Бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож үйлдсэн бол хоёр зуун мянгаас гурван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, зургаан жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл нэг жилээс хоёр жил хүртэлх хугацаанд хэрэгтний цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол гурван зуун мянгаас таван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, найман жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ эсхүл хэрэгтний хоёр жилээс гурван жил хүртэлх хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

4. Хязгаарлагдмал устгах зориулалттай галт зэвсгийг хууль бусаар үйлдвэрлэх, өөрчлөх, засварлах, эсхүл хийн зэвсгийг хууль бусаар үйлдвэрлэх, 7.5 Дж-ээс дээш хошууны энергитэй пневматик зэвсэг, иртэй зэвсэг, шидэлтийн зэвсэг, устгах хязгаарлагдмал буюу хийн зэвсгийн сумыг хууль бусаар үйлдсэн бол дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар засаж залруулах ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тавин мянгаас наян мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгож хоёр жил хүртэл хугацаагаар хорих эсхүл ял шийтгүүлсэн этгээдийн зургаан сар хүртэл хугацааны цалин, бусад орлогын хэмжээгээр торгоно.

Тайлбар: Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураар хүлээлгэн өгсөн этгээд энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

224 дүгээр зүйл. “Галт зэвсэг хайхрамжгүй хадгалах”

1.Галт зэвсгийг өөр этгээд ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн, болгоомжгүй хадгалсан нь хүний амь нас хохирсон, бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол нэг зуун мянган рубль хүртэл хэмжээгээр торгох эсхүл эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хэрэгтний хөдөлмөрийн хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсвэл нэг жил хүртэл хугацаагаар засаж залруулах ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ялаар шийтгэнэ.

2.Энэ үйлдлээр хоёр ба түүнээс дээш хүний амь нас хохирсон бол дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засаж залруулах ажил, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

223 дугаар зүйл. Хууль бусаар зэвсэг үйлдвэрлэх (2021 оны 7 дугаар сард өөрчлөлт орсон)

1. Галт зэвсэг, түүний үндсэн эд анги (биологи, химийн, цөмийн зэвсгээс бусад) хууль бусаар үйлдвэрлэх, өөрчлөх, засварлах, түүнчлэн галт зэвсгийн сумыг хууль бусаар үйлдвэрлэсэн бол нэг зуун мянгаас хоёр зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ үйлдлийг бүлэг хүмүүс урьдчилан тохиролцож үйлдсэн бол хоёр зуун мянгаас гурван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол гурван зуун мянгаас таван зуун мянган рубльтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Биологи, химийн, цөмийн зэвсгийг хууль бусаар үйлдвэрлэх, өөрчлөх, засварлах, эсхүл хийн зэвсгийг хууль бусаар үйлдвэрлэх, 7.5 Дж-ээс дээш хошууны энергитэй пневматик зэвсэг, иртэй зэвсэг, шидэх зориулалттай зэвсэг, биологи, химийн, цөмийн зэвсгийн сумыг хууль бусаар үйлдвэрлэх - дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар албадан сургалтад хамруулах, хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрх хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураар хүлээлгэн өгсөн этгээд энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.³⁵

35 “Уголовный кодекс Российской Федерации” от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 25.12.2023) (с изм. и доп., вступ. в силу с 30.12.2023), УК РФ Статья 223. Незаконное изготовление оружия, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/b1e2aa2e039d85c60875b500d5060719fc78efcc/, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

Х. СУМ БОЛОН СУМЫГ ДАХИН ЦЭНЭГЛЭХТЭЙ ХОЛБОГДОХ ХАРИЛЦАА

Сумны хонгиог дахин цэнэглэхийг гар аргаар цэнэглэх, дахин цэнэглэх гэж нэрлэдэг ба үйлдвэрийн сумыг бөөнөөр нь худалдаж авахын оронд бие даасан эд ангиудыг (хонгио, бялт, дарь, хошуу) угсарч галт зэвсгийн сум хийх үйл ажиллагаа юм.

Гар аргаар цэнэглэх гэдэг нэр томьёо нь илүү ерөнхий нэр томьёо бөгөөд ерөнхийдөө сумыг гар аргаар угсрах үйлдлийг хэлдэг. Харин дахин цэнэглэх гэдэг нь өмнө нь шатаасан хонгио, бүрхүүлийг ашиглан гараар цэнэглэхийг хэлнэ. Цэнэглэх үйл явц нь шинэ эсвэл дахин боловсруулсан бүрэлдэхүүн хэсгүүдийг ашиглаж байгаа эсэхээс үл хамааран ихэвчлэн ижил байдаг. Гол ялгаа нь хонгио, бүрхүүлийг бэлтгэх үйл явцад байдаг. Шинэ бүрэлдэхүүн хэсгүүд нь ерөнхийдөө цэнэглэхэд бэлэн байдаг бол өмнө нь шатаасан эд ангиудын хувьд түүнийг цэвэрлэх, ашиглагдсан бялтыг авч хаях, гуулин хонгионы хэлбэр, хэмжээг өөрчлөх зэрэг нэмэлт процедур шаардлагатай байдаг.³⁶

Үйлдвэрийн сум нь хүчирхэг, найдвартай, нарийвчлал сайтай байдаг хэдий ч дараах шалтгаануудын улмаас сумны хонгиог дахин цэнэглэж хэрэглэх шаардлагатай болдог.

Хүснэгт 9.5. Сумны хонгиог дахин цэнэглэх

Зардлыг хэмнэх	Ашигласан материалын чанараас хамааран дахин цэнэглэх нь үйлдвэрийн шинэ сумны зардлын үнэнээс гуравны нэгээс хоёрны нэг хүртэл хямд байдаг. Таны ашигладаг дахин цэнэглэх машинуудын төрлөөс хамааран та цагт нэгээс таван хайрцаг гаргаж болно.
Үзүүлэлтийг сайжруулах	Үйлдвэрийн сум нь “нэг хэмжээтэй” байх ёстой. Энэ нь орчин үеийн бууны даралт, хурд, гүйцэтгэлийг тэсвэрлэх чадваргүй хуучин винтов гэх мэт буунд тохирдоггүй. Ийм тохируулга нь нарийвчлалыг ихээхэн сайжруулж, заримдаа хоёр дахин нэмэгдүүлдэг. Мөн үүний дагуу сумны даралт болон хурдыг тааруулах боломжтой.
Хуучирсан болон ховор хонгиог ашиглах	Зарим сумнууд нь хэт хуучирсан эсвэл олдохоо байсан, ховордсон байдаг учраас дахин цэнэглэх шаардлагатай болдог.
Хэмнэлттэй материал ашиглах	Нэмэлт хөнгөн, хямд сум, тэр ч байтугай цутгамал хар тугалга хэрэглэснээр гар цэнэглэгч нь шатаадаг эрчим хүчний ачааллыг бууруулж чадна. Эдгээр нь сургалт, дадлага хийх, жижиг ан агнуур хийхэд тохиромжтой. Ийм бага даралт нь гуулин хонгиог элэгдүүлдэггүй. Иймд энэ аргаар хэдэн арван удаа ачаалж болно.
Их буудах боломж	Дахин цэнэглэх нь зардал багатай тул үйлдвэрийн сумаар буудсанаас илүү их буудах боломжтой ³⁷ .

Сумны хонгиог дахин цэнэглэх арга

1. Хонгионоос бялтыг салгах. Тохиромжтой хэрэгслээр бялтын голд байрлах нүхээр бялтыг салгана. Хонгиог цэвэрлэх хамгийн хялбар арга бол дахин цэнэглэх машин ашиглах явдал юм. Хэмжээг тохируулахдаа мөн бялтыг салгаж болно.

36 Bigfoot Gun Belts (25 March 2016). “Difference Between Handloading vs Reloading”

37 Reloading Your Own Ammunition By Ron Spomer, Холбоос: <https://www.ronspomeroutdoors.com/blog/reload-your-own>. Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

2. Хонгионы хүзүүний хэмжээг өөрчлөх. Хэрэв ижил галт зэвсэгтэй сумыг дахин ашиглахаар төлөвлөж байгаа бол зөвхөн хонгионы хүзүүний хэмжээг өөрчлөхөд нь хангалттай. Энэ нь хонгионы хэмжээг бүхэлд нь өөрчлөхөөс амар байдаг.

3. Бялтын ховилыг цэвэрлэх. Бялтын ховилыг өмнөх буудлагын ул мөрөөс цэвэрлэнэ. Үүний зэрэгцээ даралтын улмаас бялтын ховил тэлэхгүй байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.

4. Хонгионы амыг тэлэх. Хонгионы амыг цэвэрлэж тэлнэ.

5. Бялтыг суурилуулах. Бялтыг гар багаж эсвэл ширээтэй багажаар хийж болно. Гараар хийдэг бялтын гол давуу тал нь угсрахад бялтыг илүү тогтвортой, жигд байрлуулах боломжтой. Бялтыг суурилуулахдаа хамгаалалтын нүдний шил зүүх ёстой.

6. Хонгиог цэнэглэх. Нунтаг дарийг юүлүүрээр хонгионд хийнэ. Дарийг хэмжиж шаардлагатай хэмжээнд байгаа эсэхийг шалгах нь чухал юм.

7. Хошууг байрлуулах. Төгсгөлд нь хошууг хонгионы хүзүүнд дарагч ашиглан хийнэ.

8. Эцсийн шалгалт. Дахин цэнэглэсэн сумыг шалгаж, хонгионы тосолгооны үлдэгдлийг арчина. Бүх зүйл хэвийн байгаа эсэхийг шалгахын тулд дахин цэнэглэсэн сумаа дахин шалгана.³⁸

Хонгиог дахин цэнэглэх нь аюулгүй хэдий ч зарим тохиолдолд хүний үйл ажиллагаанаас хамааран аюул тулгардаг. Иймд дараах аюулгүйн дүрмүүдийг мөн сахих хэрэгтэй. Үүнд:

- Зөвхөн анхаарал хандуулж чадах үедээ л дахин цэнэглэх ёстой. Ядарсан эсвэл өвчтэй үед дахин цэнэглэж болохгүй;
- Тохиромжтой нүдний хамгаалалтыг үргэлж зүүх хэрэгтэй;
- Дарь болон бялтыг хүүхдээс хол газар хадгалахаас гадна галаас мөн хол байлгах шаардлагатай;
- Дахин цэнэглэсний дараа илүү гарсан дарийг зориулалтын саванд хадгалах;
- Бялтыг бөөнөөр нь болон ихээр нь хадгалж болохгүй. Мөн бялтын шинж чанар алдагдсан тохиолдолд ашиглах хорiotой;
- Дарийн хэмжээг ихэссэн эсэхийг сайн шалгах шаардлагатай ба ингээгүй тохиолдолд гэмтэх, цаашлаад үхэлд хүрэх аюултай;
- Сумны хэмжээнд үндэслэсэн дахин цэнэглэх дүрэм, журмыг зайлшгүй дагах шаардлагатай;
- Хонгиог дахин цэнэглэх хэрэглэгдэхүүн солигдсон тохиолдолд шинээр эхлэх шаардлагатай;

38 The reloading process – how to reload “i want to reload my own ammo – where do i start?”, Холбоос: <https://www.vihtavuori.com/reloading-data-tool-rifle-handgun-cowboy-action-shooting/how-to-reload/>. Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

- Хонгиог дахин цэнэглэх тоног төхөөрөмжийг эмх цэгцтэй байлгаж, байнгын бүрэн бүтэн байдлыг шалгах;
- Бялт болон суманд хар тугалга ихээр агуулагддаг тул хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх ёстой.³⁹

Сумны хонгиог дахин цэнэглэх этгээд

Улс орон бүрд сумны хонгиог дахин цэнэглэх этгээдийг дотоодын эрх зүйн зохицуулалтаас хамаарч өөр өөрөөр зохицуулдаг. Гэхдээ дараах байдлаар нийтлэгээр тодорхойлдог.

Зөвшөөрөлтэй галт зэвсэг эзэмшигч: Галт зэвсгийг хууль ёсны дагуу эзэмшихийг зөвшөөрсөн, хүчинтэй галт зэвсгийн зөвшөөрөлтэй хүмүүс хувийн хэрэгцээнд зориулж сумны хонгиог дахин цэнэглэх эрхтэй байж болно. Эдгээр зөвшөөрлийг сайтар шалгаж, холбогдох байгууллагаас тогтоосон бусад шаардлагыг хангасан тохиолдолд өгдөг.

Сум дахин цэнэглэх бизнес: Сумны хонгиог дахин цэнэглэх, үйлдвэрлэх чиглэлээр мэргэшсэн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд арилжааны зорилгоор сумыг дахин цэнэглэхийг зөвшөөрч болно. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөхийн тулд тусгай дүрэм журам, зөвшөөрлийн шаардлага, хяналт шалгалтад хамрагддаг.

Бүртгэлтэй сум үйлдвэрлэгчид: Зарим улс орнуудад сум үйлдвэрлэгчийн тусгай зөвшөөрөл авсан хувь хүмүүс эсвэл компаниуд өөрсдийн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн үйл явцын нэг хэсэг болгон сумны хонгиог дахин цэнэглэдэг.

Шаардлага хангасан эсэхийг үнэлэх этгээд

Дахин цэнэглэсэн сумыг зорилго, нөхцөлөөс хамаарч хэд хэдэн этгээдүүд шалгадаг. Нийтлэг байдлаар дараах этгээдүүд шалгалтыг хийх үүргийг хүлээдэг.

Дахин цэнэглэсэн хүн: Сумыг дахин цэнэглэсэн хүн өөрийн цэнэглэсэн сумыг шалгах үүрэгтэй. Үүнд зөв угсралт, хонгионы бүрэн бүтэн байдал, дарь, сумны суултын гүнийг шалгах, чанарын ерөнхий хяналт зэрэг багтана. Дахин цэнэглэсэн этгээд нь тогтоосон аюулгүй ажиллагааны зааварчилгааг дагаж, сумаа хэрэглэхээсээ өмнө хүссэн техникийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах ёстой.

Буусонирхогч/буудагч хүн: Дахин цэнэглэсэн сумыг хэрэглэгчид буудахаасаа өмнө шалгаж болно. Тэд хонгионы аюулгүй байдал, гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй аливаа илэрхий согог, бүрэн бус байдал, гэмтлийн шинж тэмдгийг нүдээр шалгаж болно. Тэд мөн хонгиог хэмжиж, жинлэх боломжтой бөгөөд шаардагдах үзүүлэлтүүдийг хангаж, зорилгодоо нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах боломжтой.

Практик буудлагын ажилтан/багш: Практик буудлагын талбайд буудах үед, ялангуяа зохион байгуулалттай буудлагын тэмцээн, уралдааны үеэр талбайн хамгаалалтын офицерууд эсвэл талбайн мастерууд аюулгүйн дүрэмд нийцэж

39 Vihtavuori reloading safety rules, Холбоос: <https://www.vihtavuori.com/reloading-data-tool-rifle-handgun-cowboy-action-shooting/reloading-safety/>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

байгаа эсэхийг баталгаажуулахын тулд дахин цэнэглэсэн суманд шалгалт хийж болно. Тэд дахин цэнэглэсэн сумыг аюулгүй угсарч, зөв тэмдэглэгээтэй, хүлээн зөвшөөрөгдсөн гүйцэтгэлийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг шалгана.

Хууль сахиулах байгууллага/захиргааны байгууллага: Зарим улсад харьяаллын дагуу хууль сахиулах байгууллага, захиргааны байгууллага дахин цэнэглэсэн сумыг хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгана. Үүнд тогтоосон аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөж байгаа эсэх, тэмдэглэгээний дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсвэл гүйцэтгэлийн тодорхой шалгуурыг хангаж байгаа эсэх хамаардаг.

Монгол Улсын хувьд одоогийн байдлаар хонгиог дахин цэнэглэх, түүнийг ашиглахтай холбогдсон харилцааг 2015 оны Галт зэвсгийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн зохицуулалтад тусгаагүй.

Мөн Монгол Улсын хэмжээнд дотоодын сумны нөөц хүрэлцээгүй байгаа нөхцөл байдал ажиглагддаг. Тухайлбал, Дотоод хэргийн их сургуулийн нэг хичээлийн жилийн хэрэгцээнд АКМ, РПК бууны хээрийн буудлагад 7,62 мм-ийн ПС (ердийн) маркын сум 224.000 ширхэг, СВД, ПК бууны хээрийн буудлагад 7,62 мм-ийн ЛПС (ердийн) маркын сум 168.000 ширхэг, ПМ, АПС бууны буудлагад 9 мм-ийн ПС (ердийн) маркын сум 118.400 ширхэг, нийт 510.400 ширхэг сумны хэрэгцээ бий.

Түүнчлэн, Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “хууль сахиулах албаны зориулалттай галт зэвсгийг тодорхойлсон байх ба сумны хошуу нь зүрхэвчгүй байхаар” заасан. Монгол Улсад ашиглаж байгаа байлдааны зориулалттай бүх сум ган зүрхэвчтэй бөгөөд хатуу биетэд налуу өнцгөөр туссан тохиолдолд аюултай ойлт үүсгэдэг, мөн дүүрэн дарин цэнэгтэй тул нисэлтийн зай хол, нэвтлэх чадвар өндөр байдаг. Хууль сахиулах үйл ажиллагаа нь ихэвчлэн хот, суурин газарт явагддаг учир хэрэглэх сум нь оршин суугчдад бага аюул учруулах шаардлага үүснэ. Аюултай ойлтыг багасгахын тулд сум ган зүрхэвчгүй, дарин цэнэг бага байх ёстой. Иймд хууль сахиулах зорилгоор ашиглах сумны хүчин чадлыг тодорхойлж гаргах, хонгиог хууль сахиулах зорилгоор дахин цэнэглэх, сургалт дадлагад ашиглах хэрэгцээ байгааг харуулж байна.

Өмнө нь хийгдсэн судалгааны ажлын хүрээнд хууль сахиулах салбарын инновацын дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрт /2015-2020/ тусгагдсан “дотооддоо сум, галт хэрэгсэл, дохионы пуужин, тусгай хэрэгсэл үйлдвэрлэх галт зэвсгийн туршилт, судалгааны лаборатори байгуулах” ажлын хүрээнд хэрэглэсэн хонгиог дахин ашиглах боломжийг эрэлхийлсэн судалгааг 5 жилийн өмнөөс хийсэн. Гар бууны сумны хонгиог 25 удаа, АКМ бууны сумны хонгиог таван удаа ашиглаж болдог. Энэ судалгааны явцад Lee Precision компанийн сум дахин цэнэглэх төхөөрөмж ашиглаж, хонгиог дахин цэнэглэх туршилт-үйлдвэрлэлийн ажил гүйцэтгэхээр судалгааг ДХИС-д хийж байсан.

Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ш.Паламдорж, цэргийн ухааны доктор (Ph.D), профессор А.Хүү-Ухна нар Батлан хамгаалах яамны захиалгаар “Цэргийн зориулалт бүхий тэсрэх бодисыг дотооддоо үйлдвэрлэх технологи, техник эдийн засгийн үндэслэл” сэдэвт нууцын зэрэглэлтэй шинжлэх ухаан, технологийн төслийн ажлыг хийж гүйцэтгэжээ. Тус судалгааны ажил нь Батлан хамгаалах яамны нууцад байгаа бөгөөд судалгааны ажлын үр дүнгээр Монгол Улсад байгаа

дарь, тэсрэх бодис хийх түүхий эдийн нөөцүүдийг тогтоосон. Монгол Улсад цэргийн зориулалттай, сайн чанарын, бүх төрлийн дарь, тэсрэх бодис хийх боломжтой болохыг судлан дүгнэлт гаргасан байна. Судалгааны ажлаар цэргийн зориулалттай дарь, тэсрэх бодис хийх арга зүйг боловсруулжээ.

А.Хүү-Ухна докторын санаачлан хэрэгжүүлж, удирдан гүйцэтгэсэн “9 мм-ийн буудлагын сум, сургалтын гранат үйлдвэрлэх арга зам” сэдэвт судалгааны төслийн ажлаар Монгол Улсад 9 мм-ийн буудлагын сумыг дахин цэнэглэх арга зүйг боловсруулжээ. Тус төслийг Батлан хамгаалах яамны удирдлагаас дэмжиж, 2015 онд Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид сумыг дахин цэнэглэх үйлдвэрлэл явуулж эхэлсэн байна. Гэвч 2016 онд Турк улстай хамтарсан сумны үйлдвэр байгуулах асуудал яригдаж, дээрх судалгааны төслийн хэрэгжилтийг зогсоожээ.⁴⁰

2021 оны байдлаар цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын ашиглаж байгаа сумны нөөцийг бага зардлаар бүрдүүлэх зорилгоор Америкийн Нэгдсэн Улсын “Mark 7R reloading” LLC байгууллагатай галт зэвсгийн хонгиог дахин цэнэглэх “Mark 7 Evolution” сум угсрагч загварын бүрэн автомат төхөөрөмж, “Hornady ammo plant”, “The evolution” загварын 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс санхүүжүүлсэн хөрөнгөөр худалдан авч, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Сум дахин цэнэглэх цехийн үйл ажиллагаа явуулах, тоног төхөөрөмж байрлуулах өрөөг тусгай зориулалтын дагуу тохижуулан засвар хийсэн⁴¹.

Түүнчлэн, хонгиог дахин цэнэглэхтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгдэх болсон бөгөөд хонгиог дахин цэнэглэх нь Эрүүгийн хуулийн 20.5 дугаар зүйлд заасан “Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх” гэмт хэрэгт тооцогдож байна.

Иймд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад хонгиог дахин цэнэглэхтэй холбоотой харилцааг хуульчлах шаардлагатай байна. Гадаад улс, орнуудын хувьд дээрх харилцааг зохицуулсаар ирсэн ба өөр, өөрийн гэсэн сайн туршлагыг бий болгосон байна. Тус судалгааны хүрээнд Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Канад Улсыг сонгон эрх зүйн зохицуулалтыг судалсан бөгөөд хонгиог дахин цэнэглэхтэй холбоотой процесс, дахин цэнэглэсэн сумыг шалгах зэргийг нарийвчлан авч үзсэн.

Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улсын хувьд сумны хонгиог дахин цэнэглэх нь хуулиар хориглоогүй үйлдэл бөгөөд ямар нэг зөвшөөрөл авдаггүй төдийгүй нэлээд түгээмэл үйлдэл байдаг. Мэргэжилтнүүд дахин цэнэглэсэн сум ашиглах нь “ердийн сум” гэсэн сэтгэгдэл төрүүлж болзошгүй тул үүнтэй холбоотой хуулийн хариуцлагын талаар авч үздэг.⁴²

Америкийн Нэгдсэн Улсад сумны хонгиог дахин цэнэглэх нь ерөнхийдөө хууль ёсны бөгөөд холбооны түвшинд зохицуулагддаг. Гэсэн хэдий ч зарим зохицуулалт нь муж улсаас хамаарч өөр байдаг. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсын Колумбийн

40 Б.Зулбадрах, “Сумны хонгиог дахин цэнэглэж, буудлагын сургалтад ашиглах” Инновацийн баримт бичиг.

41 “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилт.

42 Massad Ayoob (April 2005). “Handloads are for sport and training: not defense: after a shooting, certain concerns contraindicate handloads”. Guns Magazine. Archived from the original on 2009-02-03.

тойргийн кодексийн 7–2504.01-ийн е-ийн 2-т “Бүртгэлийн гэрчилгээтэй этгээд нь бүртгэлтэй галт зэвсгийг дахин цэнэглэх, захиалгаар цэнэглүүлэх үйл ажиллагаа эрхэлж болно. Түүнээс бусад тохиолдолд тухайн хүн бусдын сумыг дахин цэнэглэж болохгүй”⁴³ гэж хуульчилсан байдаг.

Холбооны түвшинд Архи, тамхи, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодистой тэмцэх товчоо (ATF) нь сум үйлдвэрлэх, түүний дотор хонгиог дахин цэнэглэхтэй холбоотой зохицуулалтыг хянадаг. Арилжааны зорилгогүйгээр хувийн хэрэгцээнд хонгиог дахин цэнэглэх нь ерөнхийдөө хууль ёсны галт зэвсэгтэй холбоотой үйл ажиллагааны ангилалд багтдаг.

Америкийн Нэгдсэн Улсад сумны хонгиог дахин цэнэглэх талаар дараах зохицуулалтууд байдаг.

Хувийн хэрэглээ. Хувийн хэрэгцээнд зориулж сумыг худалдах, түгээх зорилгогүйгээр сумны хонгиог дахин цэнэглэх нь ихэвчлэн хууль ёсны гэж тооцогддог.

Тусгай зөвшөөрөл. Хувийн хэрэгцээнд зориулж сумны хонгиог дахин цэнэглэж байгаа тохиолдолд ерөнхийдөө тусгай зөвшөөрөл шаарддаггүй. Харин арилжааны зориулалттай сум үйлдвэрлэх эсвэл дахин цэнэглэсэн сум зарахаар төлөвлөж байгаа бол нэмэлт лиценз, зохицуулалт хэрэгжиж болно.

Бүрэлдэхүүн хэсгүүд. Холбооны түвшинд бялт, дарь, хошуу гэх мэт бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар тодорхой дүрэм журамтай байж болох ч эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг хувийн хэрэгцээнд зориулж худалдан авахад тодорхой хязгаарлалт байдаггүй.

Аюулгүй байдал. Сумны хонгиог дахин цэнэглэх үед аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих нь чухал. Тогтсон аюулгүй ажиллагааны удирдамжийг дагаж мөрдөх, зохих тоног төхөөрөмж ашиглах, эд анги, сумыг зохих ёсоор хадгалах нь сумны хонгиог дахин цэнэглэх үйл явцын чухал хэсэг юм.⁴⁴

Америкийн Нэгдсэн Улсад дахин цэнэглэгдсэн сумыг шалгаж үзэхэд хууль, эрх зүйн түвшинд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тус үйл ажиллагааг Архи, тамхи, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодистой тэмцэх товчоо (ATF) болон холбооны, мужийн хууль сахиулах байгууллага, галт зэвсэг үйлдвэрлэгч байгууллагууд хяналт тавьдаг.

- Хараагаар шалгах (Дахин цэнэглэсэн сумыг харж шалгана. Хонгио, сум, бялт дээрх хагарал, товойлт, гэмтлийн шинж тэмдэг зэрэг харагдахуйц ямар нэгэн согогийг хайж олох ба бүрэлдэхүүн хэсгүүдийг зөв угсарсан эсэхийг шалгана.)

- Хэмжээг шалгах (Сумны хэмжээг шалгахын тулд диаметр хэмжигч эсвэл бусад хэмжих хэрэгслийг ашиглана. Сумны үйлдвэрийн стандарт болон бусад стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээнд багтаж байгаа эсэхийг шалгахын тулд хонгионы урт, нийт урт, сумны диаметрийг хэмжинэ.)

43 Code of the District of Columbia, Холбоо: <https://code.dccouncil.gov/us/dc/council/code/sections/7-2504.01>, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

44 Bureau of Alcohol, Tobacco, Firearms, and Explosives (ATF), Холбоо: www.atf.gov, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

- Дарийн баталгаажуулалт (Дарь нь тохирох бөгөөд нягт байгаа эсэхийг баталгаажуулна. Дарийг дахин цэнэглэх өгөгдлийн жагсаалттай харьцуулж үзнэ.)

- Бялтын үзлэг (Бялтыг зөв суулгаж, гэмтэл, гажилтын шинж тэмдэг буй эсэхийг шалгана. Бялтууд нь хонгионы толгойтой ижилхэн, хэт цухуйсан эсвэл хонхойгоогүй байх ёстой.)

- Сумны суулгалт ба хавчилт (Сумны суултын гүнийг шалгаж, тэдгээр нь тогтвортой, санал болгож буй техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг шалгана.)

- Чанарын хяналт ба тогтвортой байдал (Дахин цэнэглэлтийн ерөнхий чанар, тогтвортой байдлыг шалгана. Найдвартай байдал, нарийвчлал, аюулгүй байдалд нөлөөлж болохуйц хоорондын зөрчил, өөрчлөлтийг хайж олно.)

- Хууль тогтоомжийг дагаж мөрдөх (Дахин цэнэглэлт нь холбооны, мужийн, орон нутгийн холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгана. Сумны төрөл, материал, нийт урт болон холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон бусад тусгай шаардлагын хязгаарлалтыг анхаарч үзнэ.)

- Туршилтаар галлах (заавал биш) (Хэрэв үүнийг хийх нь аюулгүй бөгөөд хууль ёсны бол гүйцэтгэлийг үнэлэхийн тулд дахин цэнэглэсэн сумны дээжийг туршина. Галын үед хэт даралт, хэт тийрэлт болон бусад хэвийн бус үйлдлүүдийн шинж тэмдгийг ажиглана.)⁴⁵

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улсын 1996 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Галт зэвсгийн тухай хуульд сумны хонгиог дахин цэнэглэх талаар зохицуулсан. Тус зохицуулалт нь зэвсэг, түүнд зориулсан сум үйлдвэрлэх, урт хошуут зэвсэг бүхий иргэний галт зэвсгийн сумыг өөрөө цэнэглэх талаар агуулгатай.

Зэвсэг, сум үйлдвэрлэх ажлыг Оросын Холбооны Улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэдэг. Зэвсэг, сум үйлдвэрлэдэг хуулийн этгээд нь үйлдвэрлэлийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн хяналт, бүтээгдэхүүний зохих чанар, аюулгүй байдлыг хангах ёстой. Байлдааны жижиг зэвсгийн загвараас бусад нь зөвхөн төрийн хагас цэрэгжүүлсэн байгууллагуудад хүргэх, түүнчлэн Оросын Холбооны Улсын гадаад улсуудтай хийх цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай хууль тогтоомжийн дагуу гадаад улсад хүргэх зорилгоор үйлдвэрлэгддэг.

Урт хошуутай иргэний галт зэвсэг эзэмшигч Оросын Холбооны Улсын иргэд энэ зэвсгийг хадгалах, авч явах зөвшөөрөлтэй бол тухайн зэвсгийн сумыг хувийн хэрэгцээнд зориулж бие даан цэнэглэх эрхтэй. Мөн галт зэвсгийн үндсэн хэсгийг эс тооцвол галт зэвсгийн эд ангиудыг засварлах, солих ажлыг энэ зэвсгийн эзэмшигч бие даан гүйцэтгэж болно.

Зэвсэг, сум үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын галт зэвсгийн үндсэн эд анги болох зэвсэг, сумыг үйлдвэрлэх, бүртгэлжүүлэх, хадгалах,

45 Hornady Manufacturing Company, Hornady Handbook of Cartridge Reloading. Grand Island, NE: Hornady Manufacturing Company

худалдахтай холбогдсон албан тушаалд гэмт хэрэгт шийтгүүлж байсан хүнийг оруулахгүй.

Хязгаарлагдмал устгах зориулалттай галт зэвсэг, хийн зэвсэг, дохионы зэвсэг, бүтцийн хувьд зэвсэгтэй ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд байлдааны гар галт зэвсэг, албаны галт зэвсгийн үндсэн эд анги, тэр дундаа улсын цэрэгжүүлсэн цэргийн байгууллагын бүртгэлээс хасагдсан зэвсгийг ашиглахыг хориглоно.

Иргэний болон албаны зэвсгийн засвар, түүний дотор галт зэвсгийн үндсэн хэсгийг засварлах, солих ажлыг иргэний болон албаны зэвсэг, галт зэвсгийн үндсэн эд ангиудыг засварлах, эсвэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэж болно. Иргэний болон албаны зэвсгийг эзэмшигчид энэ зүйлд заасан хуулийн этгээдэд засварлахаар шилжүүлэх нь зэвсгийн эргэлтийн чиглэлээр эрх бүхий холбооны гүйцэтгэх байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн үндсэн дээр хийгддэг. Иргэний болон албаны зэвсэг, галт зэвсгийн үндсэн эд ангиудыг засварлах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь тухайн зэвсэг, түүний үндсэн эд ангиудыг зохих загварын галт зэвсгийн үйлдвэрлэгчид засварлахаар шилжүүлэх эрхтэй.⁴⁶

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Европын улсуудаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс нь хонгиог дахин цэнэглэхийг хуулиар зөвшөөрдөг улсуудын нэг юм. Ингэхдээ сумны хонгиог дахин цэнэглэх болон дэлбэрэх бодис болох дарьтай харьцах сургалтад сууж, шалгалтыг өгсөн байх шаардлагатай. Тус улсын Дотоод хэргийн яам тус шалгалтыг явуулдаг. Тус сургалтад сууж шалгалтад тэнцсэний дараа хонгио дахин цэнэглэх талаар хүсэлтээ («Bedürfnisprüfung») гаргах ба таван жилийн турш дарь авах зөвшөөрөл авах хүсэлтийг мөн гаргаж болно. Дарь бүрийг зөвшөөрөл дээр тэмдэглэсэн байдаг. Бялт, хонгио, сум болон дахин цэнэглэх төхөөрөмжийг зөвшөөрөлгүй авах боломжтой.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 2002 оны Зэвсгийн тухай хуульд сумны хонгиог дахин цэнэглэх талаар тусгасан байдаг.

Бууны сумыг зэвсэг эзэмшигчийн үнэмлэх дээр оруулснаар сум олж авах, эзэмших зөвшөөрлийг олгоно. Хэрэв тийм биш бол тодорхой төрлийн сум авах тусгай зөвшөөрөл олгох замаар зөвшөөрөл олгоно. Сум худалдан авах тусгай зөвшөөрөл нь зургаан жилийн хугацаатай байх ба сум эзэмших хугацаа дуусаагүй байна. Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуулийн хүрээнд арилжааны бус зорилгоор сумны хонгиог дахин цэнэглэх зөвшөөрөл нь мөн ийм сум олж авах, эзэмших зөвшөөрөл мөн байна. Ийм сум эзэмших зөвшөөрөл нь зөвшөөрлийн бичиг баримтын хугацаа дууссанаас хойш зургаан сарын хугацаанд үргэлжилнэ.

Сумыг арилжааны зориулалтаар үйлдвэрлэж, шилжүүлж байгаа бол сумны үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийн сериал (үйлдвэрлэлийн код), зөвшөөрлийн дугаар, тэмдэглэгээг агуулсан хамгийн жижиг савлагааны нэгжийг нэн даруй тэмдэглэнэ. Үйлдвэрийн код, сумны тэмдэглэгээг мөн бүрхүүл дээр тэмдэглэнэ. Дахин

46 Статья 16. Производство оружия и патронов к нему. Самостоятельное снаряжение патронов к гражданскому огнестрельному длинноствольному оружию, Федеральный закон от 13.12.1996 N 150-ФЗ (ред. от 06.02.2023) «Об оружии», Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_12679/a1b5b7acb1dbdcd793cde6fec7c01e9d0876a32/, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

цэнэглэсэн сум нь мөн тусгай тэмдэгтэй байна. Сум сумыг өөрийн нэр, худалдааны нэр, барааны тэмдгийн дор бусдад худалдсан, хүлээлгэн өгсөн этгээдийг мөн энэ хуулийн заалтад нийцэж байгаа этгээдийг үйлдвэрлэгч гэж үзнэ. Арилжааны зорилгоор буу, сум, сум үйлдвэрлэх, сумыг дахин цэнэглэх, худалдаа эрхэлдэг, эдгээр объектод барааны тэмдэг ашиглахыг хүссэн хэн бүхэн энэ тухай Үндэсний хэмжил зүйн хүрээлэнд бичгээр мэдэгдэнэ.⁴⁷

Дээрх хуулиас гадна Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 1991 оны Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуульд зохицуулжээ.

Арилжааны бус зориулалтаар сумыг дахин цэнэглэх дарийг анхны савлагаанд эсвэл импортлогчийн сав баглаа боодолд хадгална.

Тэсрэх бодистой харьцах, тээвэрлэх чиглэлээр сургалт явуулахыг эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрнө. Эдгээр курсууд нь үндсэн, тусгай эсвэл давтан сургалтууд гэж ангилагддаг. Энэхүү сургалтад сумны хонгиог дахин цэнэглэх сургалт мөн хамаардаг байна.⁴⁸

Канад Улс

Канад Улсад хонгиог дахин цэнэглэхийг хуулиар зөвшөөрдөг. Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуульд барилгад хадгалж болох дарь(утаагүй эсвэл хар)-ны хэмжээ, түүнийг хадгалах арга, хэдийд ч ашиглах боломжтой дарийн хэмжээ зэргийг хязгаарласан байдаг.⁴⁹

Канадын үндэсний галт зэвсгийн холбооны дүгнэлтээр нэг хүн 75 кг хүртэл дарь хадгалах боломжтой. Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуулийн XII хэсэгт заасны дагуу хадгалсан бол орон сууцанд дарь («хар нунтаг» ба «утаагүй нунтаг» хоёуланг нь багтаасан)-ийг хадгалж болно. Хэрэв нунтаг тусдаа дэлгүүрт хадгалагддаг бол 75 кг-ыг хамт хадгалж болно. Хэрэв тохиромжтой саванд хадгалсан бол тохиромжтой сав бүр 10 кг-аас ихгүй байх ёстой, гэхдээ зөвшөөрөгдөх хэмжээ нь 75 кг хэвээр байна. Дарийг хадгалахад зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь сумыг дахин цэнэглэхтэй холбогддог.

Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуулийн I хэсгийн 13-т хонгиог шотган, буу, винтов, гар буу, револьвер, үйлдвэрийн бууны сумыг буудсаны дараа гаргаж авах боломжтой, нэг сум дахь дэлбэрэлтийг нөгөө суманд дамжуулахаас хамгаалсан хамгаалалтыг хэлэхээр тодорхойлжээ.

Тэсэрч дэлбэрэх бодисын тухай хуулийн IV хэсгийн 35-ын “s” хэсэгт сумны хонгиог дахин цэнэглэх талаар тусгайлан авч үзсэн. Үүнд сумны хонгиог дахин цэнэглэхдээ тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрээс гадна дараах байдлаар цэнэглэж болохоор хуульчилжээ.

а) Хонгиог дахин цэнэглэсэн нь худалдаанд эсвэл арилжааны, үйлдвэрлэлийн болон бизнесийн зориулалтаар ашиглагдаагүй байх;

47 Weapons Act of 11 October 2002 (Federal Law Gazette I, p. 3970, 4592; 2003 I p. 1957), most recently amended by Article 2 of the Act of 4 March 2013 (Federal Law Gazette I, p. 362)

48 First Regulation of the Explosives Act, as amended by the Notice of 31 January 1991 (BGBl. 169), as last amended by Article 20 of the Law of 25 July 2013 (BGBl. 2749)

49 Legal Info for Reloaders Archived 2012-04-25 at the Wayback Machine at Canadian Shooting Sports Association. Retrieved 2011-11-16.

б) Хонгиог дахин цэнэглэхэд ашигласан тэсрэх бодисыг XIII хэсгийн заалтын дагуу хадгалах буюу хадгалах;

с) Хонгионоос гадна 2 кг-аас дээш дарийг хадгалахгүй байх.

Бүгд Найрамдах Филиппин Улс

Бүгд Найрамдах Филиппин Улсад сумны хонгиог дахин цэнэглэхийг зөвшөөрдөг хэдий ч Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодисын алба (FEO)-аар дамжуулан Филиппиний үндэсний цагдаагийн газар (PNP) зөвшөөрлийг заавал авах ёстой.

Бүгд Найрамдах Филиппин Улсын 2013 онд батлагдсан “Галт зэвсэг, сум болон түүнд хамаарах хариуцлагын тухай хууль”-д сумны хонгиог дахин цэнэглэх талаар дараах байдлаар зохицуулсан байдаг.

Тус хуулийн 3 дугаар зүйлийн (b) хэсэгт “сум” гэдгийг ямар ч галт зэвсэгт ашиглах зориулалттай сум, дарь, хонгио, бялтаас бүрдсэн эсвэл хонгиог дахин цэнэглэсэн бүрэн бэхлэгдээгүй хэсгийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Тус хуулийн 14 дүгээр зүйлд галт зэвсэг, сум үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хамрах хүрээг зохицуулсан ба үүний (a) хэсэгт хамаарах талбай, нутаг дэвсгэр, үйлдвэрүүдийн хүрээнд галт зэвсэг, сум, сэлбэг хэрэгсэл, дагалдах хэрэгсэл, сумны эд анги, сумыг дахин цэнэглэх, үйлдвэрлэх, угсрах тусгай зөвшөөрлийг Орон нутгийн засаг захиргаа (DILG)-ийн нарийн бичгийн дарга өгөхөөр тусгагджээ.

Харин тус хуулийн 16 дугаар зүйлд үүнийг худалдахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Үүнд зааснаар галт зэвсэг, сум, галт зэвсгийн үндсэн болон жижиг эд анги, дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, эд анги, дахин цэнэглэх төхөөрөмжийг худалдах худалдан авах тусгай зөвшөөрлийг Бүгд Найрамдах Филиппин Улсын Үндэсний Цагдаагийн газар (PNP)-аас авахаар хуульчилжээ.

Мөн тус хуулийн 28 дугаар зүйлд галт зэвсэг хууль бусаар эзэмших тохиолдолд сумны хонгиог дахин цэнэглэсэн байвал илүү өндөр торгууль оногдуулахаар зохицуулжээ.⁵⁰

50 Republic act no. 10591 an act providing for a comprehensive law on firearms and ammunition and providing penalties for violations thereof, Холбоос: https://lawphil.net/statutes/repacts/ra2013/ra_10591_2013.html, Сүүлд үзсэн огноо: 2024.02.19.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Эрх зүйн зохицуулалтын тухайд

Сонгон судалсан улсуудын хувьд галт зэвсэгтэй холбогдох бүхий л харилцааг бие даасан хуулиар зохицуулсан байна. Тухайн хуулиар иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байх, хууль сахиулах байгууллагын албаны зориулалтаар ашиглах, цэрэг, батлан хамгаалах зориулалтын галт зэвсэг байхаас үл хамааран холбогдох гол харилцааг уг хуулиар зохицуулж байна. Энэ нь тухайн харилцааг бүрэн гүйцэт зохицуулах ихээхэн ач холбогдолтой байна.

Мөн тус улсуудын Галт зэвсгийн тухай хуульд холбогдох харилцааг аль болох бүхэлд нь зохицуулахыг зорьжээ. Үүний нэг илрэл нь зайлшгүй шаардлагатай жагсаалтыг хуулийн хавсралт байдлаар баталсан явдал юм. Тухайлбал, ХБНГУ-ын “Зэвсгийн тухай хууль” (Waffengesetz, WaffG)-ын хавсралтад Зэвсэг, сумны техникийн тодорхойлолт, объектын ангилал, Хориотой зэвсгийн жагсаалт гэх мэтийг зохицуулсан байна. Манай улсад дээрхтэй адил жагсаалтыг батлахдаа захиргааны хэм хэмжээний акт батлах байдлаар зохицуулдаг нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үр дагаврыг бий болгож байгаа билээ. Иймд энэхүү сайн жишгийг анхаарч үзэх нь зүйтэй.

2. Галт зэвсгийн ерөнхий ойлголт, ангилал, төрөл, зориулалтын тухайд

Сонгон судалсан улсуудад галт зэвсгийн ерөнхий ойлголт, ангиллыг тодорхойлохдоо техникийн үзүүлэлтийг зориулалтын хамт шалгуур болгон хуульчилсан байна. Ингэснээр эрх зүйн хийдэл үүсэх, үүнээс үүдэн практикт үүсэж болох олон асуудлаас зайлсхийж чадсан байна. Манай улсын хувьд галт зэвсгийг зөвхөн зориулалтаар нь ангилсан байдгаас үүдэн техникийн үзүүлэлтийг тодорхойлсон захиргааны хэм хэмжээний актыг өөрчлөхөд хуулийн зохицуулалтыг агуулгын хувьд өөрчлөх боломж бүрдсэн байдаг.

3. Галт зэвсгийн худалдаа ба импортын тухайд

ХБНГУ болон ОХУ нь галт зэвсэг үйлдвэрлэгч, дэлхийн зах зээлд экспортлогч улсууд билээ. Тиймээс ч галт зэвсгийн худалдаа ба импортын тухайд зах зээлийг хязгаарлах гэхээсээ хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарч, тус чиглэлээр үйл ажиллагаа явуулахад тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагааны тайланд хяналт тавих зэрэг нийтлэг байдлаар хяналтыг хэрэгжүүлж байна. Харин тодорхой төрлийн буу, сумыг худалдах буюу импортлохыг хязгаарлаж байна.

4. Галт зэвсгийг хадгалах болон тээвэрлэхэд тавигдах шаардлагын тухайд

ХБНГУ-д галт зэвсгийг хадгалах болон тээвэрлэхэд тавигдах шаардлага нь Европын холбооноос батлагдан мөрдөгдөж буй стандартаар зохицуулагдаж байна. Харин ОХУ-ын хувьд галт зэвсгийг хадгалах болон тээвэрлэхэд тавигдах шаардлага тун нарийн бөгөөд хатуу процесс бүхий зохицуулалттай байна. Галт зэвсгийг хадгалах болон тээвэрлэхэд нарийн хяналт, хамгаалалтыг хослуулан чанд мөрдүүлэх нь олон нийтийн аюулгүй байдлыг хангахаас гадна улсын дотоод аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна.

5. Галт зэвсгийн хяналтын механизм, бүртгэлийн тухайд

Сонгон судалсан улсуудад галт зэвсгийн хяналтыг галт зэвсгийн бүртгэлээр хэрэгжүүлдэг нь нийтлэг байна. Мөн тус бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэх үүргийг төрийн байгууллагуудаас гадна дэлгүүр, спорт холбоод зэрэг байгууллагуудад хүлээлгэж, бүртгэлийн үйл ажиллагаанд төрийн байгууллагаас шалгалт хийдэг байна. Ингэснээр хяналтын механизмыг илүү өргөн бөгөөд үр дүнтэй ажиллуулах нөхцөл болж байна.

ОХУ-ын хувьд галт зэвсгийн тооллого болон шалгалтыг өргөн хэмжээнд зохион байгуулдаг ба тэр дундаа шалгалтыг тогтмол явуулдгаараа онцлогтой байна.

6. Галт зэвсгийн сургалтын тухайд

Сонгон судалсан улсуудад галт зэвсэг эзэмших, ашиглах, өмчлөхийн тулд зайлшгүй тусгай сургалтад хамрагдсан байхыг шаардаж байна. Энэхүү сургалт нь хууль зүйн асуудал эрхэлсэн яамнаас баталсан тусгай хөтөлбөр бүхий, кредит цагийн тогтолцоотойгоос гадна эрх олгох тусгай шалгалтаар давхар баталгааждаг онцлогтой байна.

7. Хариуцлагын тогтолцооны тухайд

Галт зэвсгийг хууль бусаар эзэмших нь сонгон судалсан улсуудад гэмт хэрэгт тооцогдож байна. ОХУ-д галт зэвсгийг хадгалах, тээвэрлэх нөхцөлийг зөрчсөн буюу хадгалалтад хайхрамжгүй хандсан үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэж буйг анхаарах нь зүйтэй.

8. Сум болон сумыг дахин цэнэглэхтэй холбогдох харилцааны тухайд

Монгол Улсын хувьд одоогийн байдлаар хонгиог дахин цэнэглэх, түүнийг ашиглахтай холбогдсон харилцааг 2015 оны Галт зэвсгийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн зохицуулалтад тусгаагүй. Монгол Улсын хэмжээнд дотоодын сумны нөөц хүрэлцээгүй байдаг. Үүнээс үүдэн хууль бус сумны худалдаа нэмэгдсээр байгаа билээ. Иймд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад хонгиог дахин цэнэглэхтэй холбоотой харилцааг хуульчлах хэрэгтэй байна. Дэлхийн бусад улс, орнуудын хувьд дээрх харилцааг зохицуулсаар ирсэн ба өөр, өөрийн гэсэн сайн туршлагыг хэдийн бий болгосон байгааг Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Канад Улсын жишээнээс харж болно.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Эрүүгийн хууль (2015)
2. Эрүүгийн хэрэг хянан шийлвэрлэх тухай хууль, (2017).
3. “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилт.

Гадаад хэлээр:

1. Waffengesetz (WaffG) 2002, Холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_waffg/englisch_waffg.html#p0039,
2. ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хууль. Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/0dd0f5ea5fc103d05b56af9b614e8387081cba79/#dst9617,
3. Code of the District of Columbia, <https://code.dccouncil.gov/us/dc/council/code/sections/7-2504.01>
4. First Regulation of the Explosives Act, as amended by the Notice of 31 January 1991 (BGBl. 169), as last amended by Article 20 of the Law of 25 July 2013 (BGBl. 2749)
5. Republic act no. 10591 an act providing for a comprehensive law on firearms and ammunition and providing penalties for violations thereof, https://lawphil.net/statutes/repacts/ra2013/ra_10591_2013.html,

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Б.Зулбадрах, “Сумны хонгиог дахин цэнэглэж, буудлагын сургалтад ашиглах” Инновацийн баримт бичиг.

Гадаад хэлээр:

1. Massad Ayoob (April 2005). “Handloads are for sport and training: not defense: after a shooting, certain concerns contraindicate handloads”. Guns Magazine. Archived from the original on 2009-02-03.
2. Weapons Act of 11 October 2002 (Federal Law Gazette I, p. 3970, 4592; 2003 I p. 1957), most recently amended by Article 2 of the Act of 4 March 2013 (Federal Law Gazette I, p. 362)

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт (2021), Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530439064421&showType=1>,

Гадаад хэлээр:

1. Deutsche Welle (DW), ХБНГУ-ын олон улсын нэвтрүүлэг, ХБНГУ дахь бууны хяналт, галт зэвсэг эзэмших, нийтлэгдсэн: 2020.02.20, шинэчлэгдсэн: 2022.12.12, Холбоос: <https://www.dw.com/en/gun-control-and-firearms-possession-in-germany/a-52450664>,
2. ХБНГУ-ын статистик мэдээллийн нэгдсэн сан, Холбоос: <https://de.statista.com/>,
3. ХБНГУ-д үйл ажиллагаа явуулдаг сургалтын академи, Холбоос: <https://pond-academy.com/en/kursangebot/kurzwaffenkurs-basic/>,
4. Crime rate in Russia from 1995 to 2021 (per 100,000 population), Холбоос: <https://www.statista.com/statistics/1045439/russia-crime-rate/>,
5. Number of crimes involving the use of firearms, gas weapons, ammunition, explosives, and explosive devices in Russia from 2015 to 2021, Холбоос: <https://www.statista.com/statistics/1045454/russia-number-of-crimes-involving-use-of-firearms-and-explosives/>,
6. Gun crimes has increased, Холбоос: <https://www.vedomosti.ru/society/articles/2022/11/23/951802-chislo-prestuplenii-viroslo>,
7. Once upon a time in Moscow: how a teenager first committed a school shooting, Холбоос: https://www.rbc.ru/politics/26/12/2014/549a9b939a794710fb26882d?from=article_body,
8. Stabbing in Perm: what led to the teenagers attacking a school, Холбоос: https://www.rbc.ru/society/15/01/2018/5a5cd2719a7947016e56ca86?from=article_body,
9. Cases of shootings and attacks in Russian schools, Холбоос: <https://www.rbc.ru/society/07/12/2023/609a5cdc9a7947237982ce4a>,
10. Федеральный закон от 13.12.1996 N 150-ФЗ (ред. от 25.12.2023) «Об оружии» (с изм. и доп., вступ. в силу с 07.01.2024), Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_12679/2215c48a57ea8ed6877ecb5717f7979a53275552/,
11. XIII. Transportation and transportation of weapons and ammunition, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_19504/560eecedfbf2c42fd907f741ace48148940b1c3d/,
12. Статья 28. Контроль за оборотом оружия, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_12679/a6f2aa09cb1e2cec0485a71553633dd5c879b9aa/,
13. Сроки оформления разрешения и госпошлина, Холбоос: <https://custom-guns.ru/blog/post/76-kak-poluchit-razreshenie-na-oruzhie-v-2023-godu.html#Yakor3>,

14. Кто обучается безопасному обращению с оружием, Холбоос: https://www.gosuslugi.ru/help/faq/rifled_weapon_license/3101210.
15. Виды разрешений на оружие, Холбоос: https://www.gosuslugi.ru/help/faq/weapon_permit/101559.
16. Обязательные требования для лицензии на огнестрельное оружие ограниченного поражения, Холбоос: https://www.gosuslugi.ru/help/faq/license_for_weapons_of_limited_destruction/200130.
17. “Уголовный кодекс Российской Федерации” от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 25.12.2023) (с изм. и доп., вступ. в силу с 30.12.2023), УК РФ Статья 223. Незаконное изготовление оружия, Холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/b1e2aa2e039d85c60875b500d5060719fc78efcc/.
18. Bigfoot Gun Belts (25 March 2016). “Difference Between Handloading vs Reloading”
19. Reloading Your Own Ammunition By Ron Spomer, Холбоос: <https://www.ronspomeroutdoors.com/blog/reload-your-own>.
20. THE RELOADING PROCESS – HOW TO RELOAD “I WANT TO RELOAD MY OWN AMMO – WHERE DO I START?”, Холбоос: <https://www.vihtavuori.com/reloading-data-tool-rifle-handgun-cowboy-action-shooting/how-to-reload/>.
21. VIHTAVUORI RELOADING SAFETY RULES, Холбоос: <https://www.vihtavuori.com/reloading-data-tool-rifle-handgun-cowboy-action-shooting/reloading-safety/>.
22. Bureau of Alcohol, Tobacco, Firearms, and Explosives (ATF), Холбоос: www.atf.gov.